



**СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН  
2019 ОНЫ ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙН  
НЭГДСЭН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН**

УЛААНБААТАР ХОТ  
2019

## А.НИЙТ АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ

### НЭГ. “ СОЁЛЫН ӨВИЙН БҮРТГЭЛ СУДАЛГАА ”-НЫ СТРАТЕГИЙН ЗОРИЛТЫГ ХАНГАХ АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ

#### 1.1. Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн 2018-2019 оны улсын тооллогын дүн мэдээллийг нэгтгэх.

#### I.2018-2019 ОНЫ ТҮҮХ, СОЁЛЫН ХӨДЛӨХ ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙН УЛСЫН ТООЛЛОГЫН БЭЛТГЭЛ ХАНГАСАН ТУХАЙ

##### Эрх зүйн баримт бичгийн шинэчлэлт:

2014 онд шинэчилсэн найруулгаар батлагдсан Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн соёлын өвийн үзлэг, тооллого хийх тухай хуулийн заалтад нийцүүлэн “Соёлын өвийн тооллого хийх журам”-ыг боловсруулсан бөгөөд Засгийн газрын 2018 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 184 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар “Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийх журам” батлагдсан.

Уг журамд төрийн болон орон нутгийн өмчийн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн эх төрх, бүрэн бүтэн байдал, бүтэц, шинж чанар, тоо хэмжээг нягтлан шалгаж хадгалалт хамгаалалтын нөхцөл, аюулгүй байдал хяналт тавих үйл ажиллагааг зохицуулахаар заасан юм. Олон нийтийн, шашны, хувийн өмчийн хөдлөх дурсгалт зүйлийг зөвшилцлийн үндсэн дээр тоолох эрх зүйн зохицуулалтыг мөн тусгасан байна.

Журамд тооллогын комиссын эрх үүрэг хийгээд ажлын бэлтгэл хангах, зохион байгуулах, тооллогын бүртгэл хөтлөх, дүн мэдээг тайлагнах зэрэг тооллогын үйл ажиллагааны зүйл заалтыг нарийвчлан тусгасны дагуу 2018-2019 оны улсын тооллогыг зохион байгуулан ажиллалаа.

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 14<sup>1.1.2</sup> дугаарт “...соёлын өвийн улсын үзлэг, тооллогыг хуулиар тогтоосон хугацаанд явуулж, дүнг Засгийн газарт тайлагнах;” тухай заасны дагуу Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газраас түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн улсын тооллогыг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангаж, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Соёлын өвийн үндэсний төв зэрэг холбогдох газруудтай хамтран дараах ажлуудыг хийж гүйцэтгэжээ. Үүнд:

- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас улс, аймаг, орон нутгийн 36 музей, 5 соёлын байгууллагад дурсгалт зүйлийн бүртгэл баримтжуулалтын ажлыг сайжруулах зориулалтаар 44 ширхэг компьютер, 40 ширхэг гэрэл зургийн хагас мэргэжлийн аппарат хэрэгсэл тараан, хангасан.
- Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллогын бүртгэлийн “Register” программд 25 төрлийн нэмэлт хөгжүүлэлт хийсэн.
- Улсын тооллогын явцын дүн мэдээг мэдээлэх веб хуудас [toollogo.monheritage.mn](http://toollogo.monheritage.mn) боловсруулан интернэтийн орчинд олон нийтэд ил тод мэдээлсэн.
- “Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллогын бүртгэл” дэвтрийг хэвлүүлэн, баталгаажуулж тараасан.

- “Тоолов (2018)”, “Тоолов (2019)” тэмдгийг хийлгүүлэн, Салбар комиссуудад хүлээлгэн өгсөн.
- Аймаг, орон нутгийн улсын тооллогын салбар комиссыг байгуулах чиглэл өгч ажилласан.
- Бүртгэл, тооллогын арга зүйн хичээлийн агуулгыг боловсруулан гарын авлага бэлтгэн хэвлүүлсэн.
- Тооллогын ажлыг нэгдсэн арга зүйгээр хангаж, нийслэл, аймаг орон нутагт бүсчилсэн сургалт зохион байгуулсан.
- Улсын тооллого явуулахад шаардлагатай 120,000,000 орчим төгрөгийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлсэн.

Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллогын бүртгэлийн “Register” программд хийгдсэн нэмэлт, хөгжүүлэлт:

2012 онд музейн ерөнхий бүртгэлийг цахимд шилжүүлэн “Register” бүртгэлийн программыг ашиглаж эхэлсэн ба 2017 онд уг программ хангамжид нэмэлт хөгжүүлэлтийг хийж ажиллалаа.

Соёлын өвийн үндэсний төв “Register” бүртгэлийн программыг зохиогч “Сайбер-Андромеда ХХК-тай 2017 оны 11 дүгээр сарын 24-нд гэрээ (Монгол Улсын Иргэний хуулийн 343-358 дугаар зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн) байгуулж, музей-хэрэглэгчээс ирүүлсэн саналуудыг тусган бодлогын даалгавар боловсруулан ажиллаж, программын ажиллагааг боловсронгуй болгоход дараах 2 чиглэлээр 25 төрлийн шинэчлэлт сайжруулалтыг хийсэн юм.

Хүснэгт №1

№	1-рт: “Register” программын ажиллагааг боловсронгуй болгох сайжруулалт:
	Дурсгалын жагсаалт дээр
1	Бүртгэлийн талбарт үзмэрийн гэрэл зураг
2	Grid нь Developer Express-ийнх байна. Sum нь гардаг. Filter-ийг custom-оор хийдэг.
3	Хайлтын үр дүнд олон дурсгалуудыг нэг дор хайх, үзэхэд боловсронгуй болгосон.
4	Сонгосон дурсгалыг edit цонхруу орохгүйгээр View хийдэг боломжтой болсон
5	Хайлтын үр дүн лист дээр хадгалагддаг болсон.
6	Бүртгэлийн нүүр талбарт сан хөмрөгийн байршил харагддаг болсон.
7	Төрөл зүйл, Он цагийн ангилал, сонголтыг шинэчилсэн.
8	Гэрэл зураг excel рүү хөрвөх боломжтой болсон.
9	Дурсгал музейн сан хөмрөгт орсон арга зам сонголттой болсон.
	Дурсгал бүртгэх хэсэг
10	Дутагдсан, Солигдсон, Алдагдсан үзмэр, эд өлгийн зүйлийн бүртгэлийн тусдаа талбарыг бий болгосон.
11	Гэрэл зургийн хэмжээ
12	6. Тодорхойлолт” Иж бүрдэл үзмэрийн бүрэлдэхүүний хэсгийн нийт тоо ширхэг нь excel-рүү хөрвөж гарах төлөв байдлыг цэгцэлсэн.
	Хэвлэх
13	Холбогдох нэр, газар, онцлогийг бүртгэх А. Бүтээсэн, Б. Хэрэглэж байсан, В. Цуглуулсан гэх хүснэгтүүд EXCEL-рүү хөрвөхөд Б-хэсэгт бичигдсэн текст хоёр дахин хуулагдан гарч байсныг зассан.
14	Хайлтын үр дүнг гэрэл зурагтай жагсаалтаар хэвлэх (Хэвлэх форматыг бэлтгэж өгнө)
15	Тайлан хэсэгт нэмэлт өөрчлөлт хийгдсэн. “Төрөл зүйлийн тоон дүн” гаргасны дараа давхар “он цагийн тоон дүн” гаргахад өмнөх нь лист дээр давхар хадгалагдана.

16	Хэвлэх командыг илүү өргөн боломжтой болгосон. Хуудасны тоог гараас өгөх сонголттой, мөн үр дүн байхгүй утга аваагүй хэсгүүдийг хасаж хэвлэдэг г.м
	Хэрэглэгч
17	Хэрэглэгч бүртгэхдээ и-мэйл оруулах ба нууц үгээ мартсан бол имэйл-ээр сэргээж авах боломжтой байх.
18	Admin нь хэрэглэгчийн нууц үгийг RESET хийдэг болсон. Харж, засаж болохгүй.
	2-рт: Музейн сан хөмрөгийн улсын тооллогын ажлын автоматжуулалт, цахим бүртгэлийн сайжруулалт:
19	Соёлын өвийг нэг бүрчлэн бүртгэлтэй тулган, гэрэл зургийг программд оруулсны дараа баталгаажуулах “Тоолов” товч бий болгосон. Тоологдсон огноо болон бусад мэдээлэл автоматаар хадгалагдана.
	Тайлагнах процесс
20	Тооллогын явцын талаарх тоон дүн мэдээ гарч байх боломжтой.
21	Тооллогын явцын мэдээллүүд сервер дээр нэгтгэн хадгална
22	Соёлын өвийн үндэсний төв дээр нэгтгэгдсэний дараа сүлжээнд ажиллах боломжтой.
23	Бүх музейнүүдийн бүртгэлийн бааз нь автоматаар нэгтгэгдэнэ.
24	Тооллогын явцын тайланг чарт хэлбэрээр тоон үзүүлэлтээр live /бодит цаг хугацаанд/ гаргана.
25	Музей тус бүрээр, мөн улсын хэмжээний тооллогын ажлын явцын мэдээллийг авах боломжтой болсон.

Программын шинэчлэлт сайжруулалтаар Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2012 оны №А/355 дугаартай тушаалаар батлагдсан “Музейн сан хөмрөгийг бүртгэх баримтжуулах заавар”-ын ББЗМаягт №46 “Дутагдсан үзмэр, эд өлгийн зүйлийн жагсаалт”, ББЗМаягт №49 “Солигдсон үзмэр, эд өлгийн зүйлийн жагсаалт”-ыг тус, тус уг программд нэмэлт талбар болгон оруулсны үр дүнд:

- Тухайн музейгээс алдагдсан, дутагдсан үзмэрийн талаарх тодорхойлолт мэдээлэл болон олдсон эсэх нь бүртгэгдэх,
- Алдагдсан, дутагдсан, солигдсон тухай мэдээллийг музейн ерөнхий бүртгэлд байнга хадгалах, нэгтгэх,
- “Register” бүртгэлийн программ нэмэлт хөгжүүлэлтийг хийснээр соёлын өвийн бүртгэл мэдээллийн сангийн “Монгол Улсын Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл буюу RCH (Registration of Cultural Heritage) бүртгэлийн программтай холбох, үндсэн мэдээллийн баазыг холбох, нэгтгэх зэрэг боломжууд бий болж, соёлын өвийн бүртгэл мэдээллийн ажилд томоохон ахиц гарсан юм.

toollogo.monheritage.mn веб хуудас боловсруулан, тооллогын явцын дүнг ил тод мэдээлсэн тухай:

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газар, Соёлын өвийн үндэсний төв хамтран улсын тооллогын үеэр тооллогын явцын дүн мэдээг олон нийтэд ил тод мэдээлэх зорилгоор анх удаа toollogo.monheritage.mn мэдээллийн веб сайт ажиллууллаа.

Соёл, урлагийн газрын даргын 2018 оны А/42 тоот тушаалыг үндэслэн “Сайбер-Андромеда” ХХК- тай (Register цахим бүртгэлийн ‘программ хангамжийг хийсэн) “Ажил гүйцэтгэх гэрээ” байгуулж, уг toollogo.monheritage.mn мэдээллийн цахим хуудсыг Соёл, урлагийн газрын вэб сайтад байршуулсан.

Тооллогын статистик тоон мэдээллийг чарт хэлбэрээр харуулах toollogo.monheritage.mn хуудсыг ажиллуулснаар:

- Тооллогын явцын дүн мэдээг интернэтийн орчинд сүлжээгээр ил тод олон нийтэд мэдээлэх,

- Улсын тооллогод хамрагдсан төрийн болон орон нутгийн өмчийн байгууллага, дүүрэг, сумдын Орон нутаг судлах танхим (цаашид ОНСТ гэх) тус бүрийн тооллогын явцыг тоологдвол зохих тоон дүнгээс хэд нь тоологдсон, улсын хэмжээнд тооллого хэдэн хувьтай явагдаж байгааг шууд харах,
- Улс, аймгийн музей, байгууллага, сум бүрээр сар, өдөр, цаг минутаар тооллогын дүн мэдээг мэдээлэх,
- Төрийн байгууллагуудыг тооллогын явцын мэдээллээр хангах,
- Тооллогын үйл ажиллагаанд хяналт тавих, улсын тооллогыг заасан цаг хугацаанд, чанартай хийж гүйцэтгэх зэрэг мэдээлэл, хяналтын ажилд үр дүнгээ өгсөн.



## Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн улсын тооллого (2018-2019)

Сүүлд 2019.07.05 -ны 14:14 -д шинэчлэгдсэн.

Тооллогын явц (Нэгдсэн дүнгээр Дэс: 126,811, Тоо ширхэг: 272,218)

Тооллого эхэлсэн: 2018.12 сар, 2019.01 сар

Тооллого дуусах: 2019.03.31



Тооллогын явц (Төрөлжсөн дүнгээр)

	Дэс	Тоо ширхэг	%
Төрийн өмчийн музей, бусад байгууллага	63,441	140,207	99.80%
Орон нутгийн өмчийн музей	43,318	97,429	99.65%
Шашны өмчийн сүм хийд	732	394	8.06%
Хувийн музей	0	0	0.00%
Сумдын орон нутаг судлах танхим	18,747	33,145	101.00%

### “Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллогын бүртгэл” дэвтрийг хэвлүүлэн, баталгаажуулан тараасан талаар:

Засгийн газрын 2018 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 184 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийх журам”-ын 3.1 дүгээр зүйлд “...Тооллогын ажилд соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд бүртгэлтэй дурсгалт зүйлийн жагсаалтыг аж ахуйн нэгж, байгууллага тус бүрээр хэвлэж, дэвтэрлэсэн тооллогын дэвтрийг ашиглана. Тооллогын дэвтэр нь дурсгалт зүйлийн хувийн дугаар, нэр, тодорхойлолт, тоо ширхэг, материал, хэмжээ жин, хадгалалтын байдал, тайлбар гэсэн асуулга бүхий баганатай байна.” гэж заасны дагуу соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд бүртгэгдсэн хөдлөх дурсгалт зүйлийн жагсаалтыг улс, аймаг орон нутгийн музей, сумдын орон нутаг сурталчлах танхим, эрдэм шинжилгээний

хүрээлэн, номын сан зэрэг байгууллага тус бүрээр нь бэлтгэн, “Түүх соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллогын бүртгэл” нийт 365 дэвтэр хэвлүүлсэн.

Өмнөх 2012-2013 оны музейн сан хөмрөгийн улсын тооллогоор үйлдсэн үндсэн 21 асуулга бүхий “Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэл”-ийн цахим хэлбэр “Register” программаас дээрх журмын 3.1, 3.2 дахь заалтын дагуу “дэс”, “дурсгалт зүйлийн хувийн дугаар”, “нэр”, “төрөл зүйл”, “тодорхойлолт”, “тоо ширхэг”, “материал”, “хэмжээ жин”, “хадгалалтын байдал”, “тайлбар” гэсэн үндсэн 10 асуулгыг сонгон, А4 хуудасны нэг талд, 250 хүртэл хуудастай хэвлүүлсэн бүртгэл юм.

Тооллогын журмын 3.5 дугаар зүйлд заасны дагуу байгууллагуудад тараагдсан бүртгэлийн дэвтэр нэг бүрийн нүүр хуудсанд улсын тооллогын Улсын комиссын дарга буюу Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газрын дарга гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулсан ба мөн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангаас дугаар өгч дугаарласан.

Улсын комисс тооллогын ажлын явцад тооллогын журмын 2.7.5 дугаар заасны дагуу бүртгэлийн дэвтэр хөтлөлтөд хяналт тавьж ажилласан ба улсын тооллого дууссаны дараа улс, аймгийн музей, байгууллагуудаас тайлангийн хамт бүртгэлийн дэвтрийг улсын комисс хүлээн авч, соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хадгалах ажлыг зохион байгуулж байна.

“Тоолов (2018)”, “Тоолов (2019)” тэмдгийг хийлгүүлэн, Салбар комисст хүлээлгэн өгсөн:

Дурсгалт зүйлийг тооллогод хамруулсныг гэрчлэх “Тоолов...он” гэсэн бичвэр бүхий тэмдгийг захиалан хийлгэж, “тоолов 2018 он”, “тоолов 2019 он” тэмдгийг тооллогод хамрагдсан 45 Салбар комисст хүлээлгэн өглөө.

Тэмдгийн ашиглалтын байдалд хяналт тавьж ажилласан бөгөөд тэмдгийн бичвэрийг засварласан, гэмтээсэн тохиолдол гараагүй болно.

Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийх журам”-ын 6.7-д заасны дагуу Улсын комиссын даргын шийдвэрээр томилсон 3 гишүүнтэй баг “Тоолов 2018 он”, “Тоолов 2019 он” тэмдэг 91 ширхгийг устгалд оруулав.

Бүртгэл, тооллогын арга зүйн хичээлийн агуулгыг боловсруулан, гарын авлага бэлтгэн хэвлүүлсэн тухай:

Улсын комисс нь тооллогын журмын 2.7.1 дүгээр зүйлд заасан тооллогын ажлыг нэгдсэн арга зүйгээр хангах хүрээнд шинэчлэн батлагдсан тооллогын журамд нийцүүлэн тооллого, бүртгэлийн арга зүйг боловсруулан, дараах агуулгаар бэлтгэсэн. Үүнд:

- Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн улсын тооллогын бүртгэл (Д.Нарантуяа. Соёлын өвийн үндэсний төвийн Соёлын өвийн бүртгэл, судалгааны газрын түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл хариуцсан шинжээч)
- Биологийн цуглуулгын зүйлийн нэр ба төрлийн асуудалд (Т.Тодгэрэл Ph.D. Байгалийн түүхийн музейн Эрдэм шинжилгээ аргагүй сан хөмрөгийн тасгийн дарга)
- Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллогод хяналт шалгалт хийх чиглэл (Д.Отгонбаяр. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Соёлын хяналтын улсын байцаагч)

- Үзмэр, эд өлгийн зүйлийг хасах, устгах тухай (Ч.Нацагням. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газрын Соёл, соёлын өвийн хэлтсийн музей, үл хөдлөх дурсгалын бодлогын хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн)
- Үзмэрийн гэрэл зураг авах тухай
- Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн улсын тооллогын ажлыг тайлагнах тухай (Г.Энхбат Ph.D. Соёлын өвийн үндэсний төвийн захирал)
- “Register” цахим бүртгэлийн программыг ашиглах зөвлөмж (Э.Баттулга. Сайбер-Андромеда ХХК-ийн захирал)

Улсын комиссын 2018 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 2 дугаар хуралдаанаар тооллогын арга зүйн сургалт хичээлийн агуулгыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

Улсын комиссын шийдвэрийн дагуу соёлын өвийн тооллогод мөрдөх хууль, дүрэм журам, тушаал шийдвэр зэрэг хууль эрх зүйн баримт бичиг, арга зүйн хичээл зэргийг нэгтгэсэн “Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн улсын тооллого (2018-2019 он)” гарын авлагыг бэлтгэн, 150 ширхгийг хэвлүүлэн улсын тооллогод хамрагдсан байгууллагуудын албан хэрэгцээнд үнэгүйгээр тарааж, арга зүйгээр хангах ажлыг зохион байгуулсан.

Бүсчилсэн сургалт зохион байгуулсан талаар:

Улсын комисс нь тооллогын журмын 2.7.1; 4.4 дүгээрт заасан тооллогын ажлыг нэгдсэн арга зүйгээр хангах, сургалт зохион байгуулах чиг үүргийнхээ хүрээнд улсын тооллогын арга зүйн сургалтыг 2018 оны 12 дугаар сарын 1-ээс 16-ны өдрүүдэд бүсчилсэн байдлаар зохион байгуулсан. Сургалтад улсын тооллого хамрагдаж буй байгууллагуудын Салбар комиссын гишүүд, аймаг, орон нутгийн Боловсрол соёлын газрын соёл хариуцсан мэргэжилтнүүд, Мэргэжлийн хяналтын байцаагчдыг хамруулсан. Бүсчилсэн байдлаар зохион байгуулагдсан 6 удаагийн сургалтад нийт 44 музей, бусад байгууллагын 235 ажилтан, албан хаагчид оролцжээ.

Хүснэгт №2

№	Бүс	Хамрагдсан музей, байгууллага	Зохион байгуулагдсан газар, огноо	Оролцогчдын тоо
1	Улаанбаатар хот	1. Монголын үндэсний музей	Улаанбаатар 2018.11.30	6
		2. Байгалийн түүхийн музей		5
		3. Богд хааны ордон музей		2
		4. Дүрслэх урлагийн музей		6
		5. Чойжин ламын сүм музей		4
		6. Монголын Театрын музей		5
		7. Монголын Уран зургийн галерей		3
		8. Үлэг гүрвэлийн төв музей		3
		9. Улаанбаатар хотын музей, Налайх дүүрэг		4
		10. Монгол Цэргийн музей		6
		11. Төрийн түүхийн музей		4
		12. Монголын Үндэсний номын сангийн үнэт ховор номын фонд		6
		13. Төв аймгийн музей		6
		14. Мэргэжлийн хяналтын ерөнхий газар		1

		15. ШУА-ийн Палеонтологи, геологийн хүрээлэн	Улаанбаатар 2019.02.28	6
		16. ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн		2
		17. МУИС-ийн Нийгмийн шинжлэх ухааны сургууль		3
		18. ШУТИС-ийн Бизнесийн удирдлага хүмүүнлэгийн сургууль		1
		19. Улаанбаатар их сургууль		2
		20. Эрдэнэсийн сан		3
2	Төвийн бүс	21. Хархорум музей	Хархорин сум 2018.12.04	8
		22. ЭрдэнэЗуу музей		6
		23. Хөшөө Цайдам музей		6
		24. Архангай аймаг		6
		25. Өвөрхангай аймаг		10
		26. Баянхонгор аймаг		8
3	Баруун бүс	27. Завхан аймаг	Улиастай 2018.12.06	5
		28. Баян-Өлгий аймаг		6
		29. Ховд аймаг		3
		30. Увс аймаг		6
		31. Говь-Алтай аймаг		5
4	Хойд бүс	32. Орхон аймаг	Орхон аймаг 2018.12.09	8
		33. Дархан-Уул аймаг		5
		34. Сэлэнгэ аймаг		5
		35. Хөвсгөл аймаг		6
		36. Булган аймаг		7
5	Говийн бүс	37. Дундговь аймаг	Мандалговь 2018.12.14	12
		38. Өмнөговь аймаг		7
		39. Дорноговь аймаг		6
		40. Говьсүмбэр аймаг		8
6	Зүүн бүс	41. Дорнод аймаг	Чойбалсан 2018.12.16	12
		42. Ялалт музей		3
		43. Хэнтий аймаг		5
		44. Сүхбаатар аймаг		4
	Нийт	44 музей, байгууллага		235

Тооллогын Улсын комиссын даргын баталсан хөтөлбөрийн дагуу сургалтыг зохион байгуулж, бүртгэл тооллоготой холбоотой гарч буй асуудлуудад арга зүйн зөвлөгөө өгч зохион байгуулсан.

Арга зүйн сургалтын үеэр багийн гишүүд, Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газрын соёлын улсын ахлах байцаагч нар Хархорум музей, Завхан, Орхон зэрэг аймгийн музейн барилгын нөхцөл байдалд тандалт хяналт хийж, музейн аюулгүй байдлыг хангах, болзошгүй эрсдэлээс хамгаалах шаардлагатай дохиолол хамгаалалтыг сайжруулах, үзмэрийн эрсдэлийг хянах, мэдээллийн сан бүрдүүлэх талаар тодорхой санал дүгнэлт гарган, төсөв хөрөнгийг шийдэж ажиллалаа.

Сургалтыг бүсчилсэн байдлаар зохион байгуулсан нь тооллогын салбар комиссын гишүүдийг бүрэн сургалтад хамруулан, нэгдсэн арга зүйгээр хангаж шинэчилсэн журмын дагуу тооллого явуулахад ач холбогдолтой боллоо.

Тооллогын бэлтгэл хангаж, цахим бүртгэлийн программ сайжруулсан, бүртгэлийн дэвтэр хэвлүүлэн баталгаажуулж тараасан, бүсчилсэн сургалт зохион байгуулсан, тооллогын явцыг ил тод мэдээлэх веб сайтыг ажиллуулсан зэрэг арга



хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн нь улсын тооллогыг богино хугацаанд үр дүнтэй зохион байгуулахад чухал түлхэц болсон гэж үзэж байна.

## II. УЛСЫН ТООЛЛОГЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, АЖЛЫН ЯВЦ

### Салбар комиссын ажлын зохион байгуулалт

“Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийх журам”-ын 2.2-т “Тооллогын ажлыг аж ахуйн нэгж, байгууллага, нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах үүргийг салбар комисс хэрэгжүүлнэ. Засгийн газрын гишүүн өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төрийн өмчийн музей, номын сан, эрдэм шинжилгээний байгууллага болон бусад аж ахуйн нэгж, байгууллагад хадгалагдаж байгаа дурсгалт зүйлд тооллого хийх салбар комиссын бүрэлдэхүүнийг, аймаг нийслэлийн Засаг дарга орон нутгийн өмчийн музей, номын сан, орон нутаг судлах танхим болон бусад аж ахуйн нэгж, байгууллагад хадгалагдаж байгаа дурсгалт зүйлд тооллого хийх салбар комиссын бүрэлдэхүүнийг тус тус батална.” гэж заасны дагуу:

- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын тушаалаар тооллогын ажлыг нэгдсэн арга зүйгээр хангах үүрэг бүхий Улсын комисс; улсын 10 музей, Үндэсний номын сан 1, эрдэм шинжилгээний хүрээлэн 2, их дээд сургууль 3, сүм хийд 2 зэрэг 18 байгууллагын<sup>1</sup>;
- аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар аймаг, орон нутаг, нийслэлийн 24 музей, 261 сум, дүүргийн ОНСТанхимын;
- харьяа удирдах дээд байгууллагын шийдвэрээр 3 байгууллагын (Эрдэнэсийн сан, Төрийн түүхийн музей, Монгол цэргийн музей) нийт 45 салбар комисс байгуулагдан, улсын тооллогыг зохион байгуулан ажилласан.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/648 дугаартай “Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийх тухай” тушаалын нэгдүгээр хавсралт “Тооллогын ажлын удирдамж” дахь “Тооллогод хамрагдах байгууллага”-ын жагсаалтад орсон:

- Шашны өмчийн- МБШТөв Гандантэгчэнлин хийд,
- Хувийн музей-1 (Данзанравжаагийн музей),
- Өвөрхангай аймгийн Өлзийт сум, Сүхбаатар аймгийн Онгон сум ОНСТанхимгүй шалтгаанаар тус, тус улсын тооллогод оролцоогүй.

Тус удирдамжийн “Тооллогод хамрагдах байгууллага”-ын жагсаалтад ороогүй:

- Булган аймгийн Тэшиг сумын ОНСТ, Дорнод аймгийн Дашбалбар сумын ОНСТ тус тус нэмэгдэн улсын тооллогод хамрагдсан байна.
- Аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар аймаг, нийслэлийн нутаг дэвсгэр дэх музей-27, сум, дүүргийн ОНСТанхим-261, сүм хийд-1 тооллогын салбар комиссыг тус тус байгуулан, харьяалах нутаг дэвсгэрийн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн улсын тооллогыг зохион байгууллаа. Аймаг, орон нутгийн салбар комисс аймгийн музей болон сумдын ОНСТанхимуудын улсын тооллогыг хариуцан гүйцэтгэлээ.

<sup>1</sup> Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн “Салбар комисс байгуулах тухай” А/756 тоот тушаал

- Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллогын Улсын комисс нь аймаг, орон нутгийн салбар комиссын үйл ажиллагаатай танилцаж, арга зүйн заавар зөвлөгөө өгөх, салбар комиссоос тооллогын дэвтэрт тусгахаар ирүүлсэн саналыг тухай бүр хянаж шийдвэрлэх, шаардлагатай аймаг, орон нутагт нарийн мэргэжлийн эрдэмтэн судлаачдыг оролцуулсан ажлын хэсгийг томилон ажиллуулах зэргээр тооллогын ажлыг нэгдсэн арга зүйгээр хангах үүргээ зохих журмын дагуу хэрэгжүүлж ажилласан.

Улсын комиссын шийдвэрлэсэн асуудал, хэрэгжүүлсэн арга хэмжээ

Улсын тооллогоор түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн эх төрх, бүрэн бүтэн байдалд хяналт тавихын зэрэгцээ Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20.8 дугаарт: - “Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санг цаасан болон цахим хэлбэрээр бүрдүүлэх бөгөөд түүнд агуулагдах мэдээлэл үнэн зөв, бүрэн гүйцэд, зөрүүгүй байна.” гэж заасанчлан тооллогын бүртгэл хөтлөлтийг хангаж ажилласан.

2018-2019 оны улсын тооллогоор гар бичмэл бүртгэл үйлдээгүй ба тооллогын журмын 3.1, 3.2 дугаар зүйлийг баримтлан “дэс, дурсгалт зүйлийн хувийн дугаар, нэр, төрөл зүйл, тодорхойлолт, тоо ширхэг, материал, хэмжээ, жин, хадгалалтын байдал” үзүүлэлтээр бүртгэлийн дэвтэр болон цахим “Register”-тэй тулгах, нягтлан шалгах ажиллагаа хийгдлээ.

Музейн ерөнхий бүртгэлийг өмнөх 2012-2013 оны улсын тооллогоор цахим “Register” бүртгэлд шилжүүлэх ажиллагаа анх удаа хийгдсэн юм.

Музейн сан хөмрөгийн үзмэр, эд өлгийн зүйлийн (цаасан болон цахим) ерөнхий бүртгэлд:

- Үг, үсгийн зөв бичгийн дүрмийн алдаа,
- Найруулга зүйн алдаа,
- Дурсгалын шинж чанарыг илэрхийлэх мэдээллийг бүртгэлд дутуу, бүрэн бус тусгасан,
- Цаасан болон цахим бүртгэлд мэдээллийг зөрүүтэй оруулсан зэрэг бүртгэл хөтлөлтийн явцад үүссэн алдаанууд нийтлэг байна.

Засгийн газрын 2018 оны 184 дүгээр тогтоолоор батлагдсан “Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийх журам”-ын 2.8.4-т: “тооллогын дэвтэрт бичигдсэн дурсгалт зүйлийн хувийн дугаар, нэр, тодорхойлолт, тоо ширхэг, материал, хэмжээ, жин, хадгалалтын байдлыг илэрхийлсэн бичвэрт нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулан Улсын комисст хүргүүлж, шийдвэрлүүлэх;”-ээр заасан. Улсын комиссын 2018 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 2 дугаар хуралдаанаар Улсын болон Салбар комиссын бүртгэлийн алдааг засах эрх, засварын цар хүрээг хэлэлцэн шийдвэрлэсэн.

Хүснэгт №3

Улсын комиссын хүрээнд шийдвэрлэх:	Салбар комиссын хүрээнд шийдвэрлэх:
<ul style="list-style-type: none"> <li>➢ дурсгалын нэр өөрчлөгдөх,</li> <li>➢ дурсгалын физик шинж чанарыг илэрхийлэх хэлбэр төрх, өнгө дүрс зэрэг бичвэрийн утга агуулга өөрчлөгдөх,</li> <li>➢ хэмжээ, жин 3 ба түүнээс дээш %-иар зөрсөн тохиолдолд тус тус улсын комисс шийдвэрлэнэ. /Жишээ нь: жин 1550 гр гэж бүртгээгдсэн үзмэрийн жин тооллогоор 3%-буюу 46.5 гр-аар зөрсөн, хэмжээ урт</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>➢ үг, үсгийн зөв бичгийн дүрмийн алдаа засах,</li> <li>➢ дурсгалын физик шинж чанарыг илэрхийлсэн утга агуулгыг өөрчлөхгүйгээр бичвэрийн найруулга зүйг сайжруулах,</li> <li>➢ “хэмжээ, жин”, “материал, арга техник”, “хадгалалтын байдал”-д нэмэлт мэдээлэл оруулах,</li> <li>➢ бүртгэл хөтлөлтийн явцад үүссэн алдааг залруулах /дэс алгассан, үзмэр давхар</li> </ul>

<p>105 см үзмэрийн урт 3% буюу 3.15 см-ээр зөрсөн, өндөр 20 см үзмэрийн өндөр 3% буюу 0.6 см-ээр зөрсөн тохиолдолд тус тус улсын комисс шийдвэрлэнэ./</p>	<p>бүртгэсэн г.м/ ажиллагааг “Музейн сан хөмрөгийг бүртгэн баримтжуулах заавар”-ын 2.2.27-д заасны дагуу гүйцэтгэх,          ➤ хэмжээ, жин 3 ба түүнээс доош %-иар зөрсөн тохиолдолд тус тус салбар комисс шийдвэрлэнэ.</p>
---	---

Тооллогын үеэр:

- Засгийн газрын шийдвэрээр түүх, соёлын хосгүй үнэт зэрэглэлд хамрагдсан үзмэр, эд өлгийн зүйлийн бүртгэлд нэмэлт, өөрчлөлт хийхгүй ба зөвхөн нэмэлт, өөрчлөлт оруулах тухай саналаа Тайланд тусгахаар,

- Үзмэр нэг бүрт хийгдэж байгаа “Төрөл зүйл”-ийн сонголт нэмэлт, өөрчлөлтөд орохгүй байх зэрэг арга зүйн заавар өгч ажилласан.

Тооллогын журмын 2.8.4 дүгээрт заасанчлан Улсын комисс хуралдаануудаар “дурсгалын нэр өөрчлөгдөх”, “дурсгалын физик шинж чанарыг илэрхийлэх хэлбэр төрх, өнгө дүрс зэрэг бичвэрийн утга агуулга өөрчлөгдөх”, “хэмжээ, жин 3 ба түүнээс дээш %-иар зөрсөн” тохиолдол тус бүрээр музей, байгууллага, сумын ОНСТ-уудаас ирүүлсэн саналуудыг авч хэлэлцэн зохих шийдвэрүүдийг гарган ажилласан.

Бүртгэлийн бичвэрт нэмэлт, өөрчлөлт оруулахаар дараах нэр бүхий 25 музей, байгууллагын Салбар комиссоос 1144 санал, 5 аймгийн 22 сумын ОНСТанхим, 1 сүм хийдээс 50 санал (нийт 1194 санал) ирүүлснийг Улсын комисс хуралдаануудаараа хэлэлцэн шийдвэрлэжээ.

#### Хүснэгт №4

№	Санал ирүүлсэн байгууллага	Бүртгэлд нэмэлт, өөрчлөлт оруулах санал ирүүлсэн дурсгалт зүйлийн тоо	дурсгалын нэр өөрчлөх саналыг		дурсгалын физик шинж чанарыг илэрхийлэх хэлбэр төрх, өнгө дүрс зэрэг бичвэрийн утга агуулга өөрчлөх саналыг		хэмжээ, жин (3 ба түүнээс дээш %-иар зөрсөн тохиолдолд) өөрчлөх саналыг		Улсын комисс-оор хэлэлцэх шаардлагагүй
			Дэмж -сэн	Дэмж ээгүй	Дэмж -сэн	Дэмжэ эгүй	Дэмж -сэн	Дэмжэ эгүй	
1	Монголын Үндэсний музей	51	19	9	1		22		
2	Байгалийн түүхийн музей	203		203					
3	Богд хааны ордон музей	1		1					
4	Чойжин ламын сүм музей	188					188		
5	Үлэг гүрвэлийн музей	3	1		2				
6	Монголын Театрын музей	1	1						
7	Төрийн түүхийн музей	4							4
8	Монгол Уран зургийн галерей	234			70		164		
9	Монгол Цэргийн музей	14		3		6	4	1	
10	Хархорум музей	27	3				24		
11	Хөшөө цайдам музей	1		1					
12	ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн	3					3		
13	Булган аймгийн музей	235							235
14	Говьсүмбэр аймгийн музей	22	2	16			4		
15	Дорноговь аймгийн музей	24	1	1		6	5	5	6
16	Дорнод аймгийн музей	39	1				38		

17	Дорнод аймаг. Ялалт музей	17	1		7		9		
18	Завхан аймгийн музей	7	6				1		
19	Орхон аймгийн музей	1							1
20	Өвөрхангай аймгийн музей	3		3					
21	Эрдэнэ Зуу музей	22	8	3	6	4		1	
22	Өмнөговь аймгийн музей	10		10					
23	Сүхбаатар аймгийн музей	5	1	4					
24	Сэлэнгэ аймгийн музей	28		2	20				6
25	Увс аймгийн музей	1		1					
	Нийт	1144	44	257	106	16	462	7	252


Улсын комисст санал ирүүлсэн Сумын ОНСТ, Сүм хийд

Хүснэгт №5

№	Санал ирүүлсэн Сумын ОНСТ, Сүм хийд	Бүртгэлд нэмэлт, өөрчлөлт оруулах санал ирүүлсэн дурсгалт азиймийн тоо	дурсгалын нэр өөрчлөх саналыг		дурсгалын физик шинж чанарыг илэрхийлэх хэлбэр төрх, өнгө дүрс зэрэг бичвэрийн утга агуулга өөрчлөх саналыг		хэмжээ, жин (3 ба түүнээс дээш %-иар зөрсөн тохиолдолд) өөрчлөх саналыг		Улсын комиссоор хэлэлцэх шаардлагагүй
			Дэмжсэн	Дэмжээгүй	Дэмжсэн	Дэмжээгүй	Дэмжсэн	Дэмжээгүй	
1	Дорноговь. Алтанширээ сумын ОНСТ	1							1
2	Дорноговь. Айраг сумын ОНСТ	3		2				1	
3	Дорноговь. Дэлгэрэх сумын ОНСТ	1				1			
4	Дорноговь. Мандах сумын ОНСТ	1					1		
5	Дорноговь. Өргөн сумын ОНСТ	1		1					
6	Дорноговь. Сайхандулаан сумын ОНСТ	1						1	
7	Дорноговь. Улаанбадрах сумын ОНСТ	1	1						
8	Дорноговь. Хатанбулаг сумын ОНСТ	1	1						
9	Дорноговь. Хөвсгөл сумын ОНСТ	1							1
10	Дорноговь. Эрдэнэ сумын ОНСТ	1	1						
11	Дорнод. Баяндун сумын ОНСТ	2					2		
12	Дорнод. Дашбалбар сумын ОНСТ	1							1
13	Дорнод. Сэргэлэн сумын ОНСТ	1					1		
14	Дорнод. Цагаан-Овоо сумын ОНСТ	4					4		
15	Сүхбаатар. Сүхбаатар сумын ОНСТ	2		2					
16	Сэлэнгэ. Баруунбүрэн сумын ОНСТ	9		9					
17	Сэлэнгэ. Бугант сумын ОНСТ	3					3		
18	Сэлэнгэ. Ерөө сумын ОНСТ	1			1				
19	Сэлэнгэ. Жавхлант сумын ОНСТ	2		2			2		
20	Увс. Зүүнхангай сумын ОНСТ	1	1						
21	Увс. Өндөрхангай сумын ОНСТ	1	1						
22	Увс. Ховд сумын ОНСТ	1	1						

23	Өвөрхангай. Шанхын Баруун хүрээ хийд	10				10			
	Нийт	50	6	16	1	11	13	2	3
		санал ирүүлсэн дурсгалт зүйлийн тоо	Дэмжсэн	Дэмжээгүй	Дэмжсэн	Дэмжээгүй	Дэмжсэн	Дэмжээгүй	Улсын комиссоор хэлэлцэх шаардлагагүй
			дурсгалын нэр өөрчлөх саналыг	дурсгалын физик шинж чанарыг илэрхийлэх хэлбэр төрх, өнгө дүрс зэрэг бичвэрийн утга агуулга өөрчлөх саналыг		хэмжээ, жин (3 ба түүнээс дээш %-иар зөрсөн тохиолдолд) өөрчлөх саналыг			

Салбар комиссуудаас ирүүлсэн нийт 1194 саналын 632 буюу 53%-ийг зөвшөөрөн дэмжсэн; 309 буюу 26 %-ийг үндэслэл шалтгаан хангалтгүй, судалгаа шинжилгээ хийгдэж байж нэмэлт, өөрчлөлт оруулах тул улсын тооллогоор бүртгэлийн бичвэрийг хэвээр үлдээхээр; 255 буюу 21%-ийн саналыг Улсын комиссоор хэлэлцэх шаардлагагүйг буцааж тус тус шийдвэрлэсэн.



Судалгаа шинжилгээ хийгдэж судлаачийн үнэлэлт дүгнэлт гаргасан Монголын Театрын музей, Монголын Үндэсний музей, Үлэг гүрвэлийн музей, Хархорум зэрэг музей, Завхан, ЭрдэнэЗуу, Говьсүмбэр зэрэг музейн илт ташаарсан угсаатны зүйн болон бурхны шашны холбогдолтой үзмэр, эд зүйлийн нэр өөрчлөх тухай Салбар комиссын саналуудыг зөвшөөрөн дэмжсэн байна.

Улсын комиссоос музейд судалгааны ажлыг хөгжүүлэх, хөхиүлэн дэмжих, сайжруулах шаардлагатайг дурдаад “дурсгалын нэр”-энд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг судалгаа шинжилгээний ажлын үндсэн дээр шийдвэрлэх нь зүйтэй гэж дурсгалын нэр өөрчлөх асуудлыг улсын тооллогоор хэвээр үлдээхээр шийдвэрлэсэн.

Улсын комиссын гишүүд салбар комиссоос ирүүлсэн дурсгалын бичвэр тодорхойлолтод нэмэлт өөрчлөлт оруулах тухай саналуудтай нэг бүрчлэн үзэж танилцаж ажилласан ба нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэл шалтгаан хангалтгүй, тодорхойгүй саналуудыг буцаан бичвэрийг хэвээр үлдээхээр шийдвэрлэн ажилласан.

Дээрх № 4, 5 дугаар хүснэгтийн дүнгээс үзэхэд бүртгэлийн бичвэрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 25 музейн салбар комиссоос ирүүлсэн:

- хэмжээ жингийн бичвэрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай санал- 40,9 %,
- дурсгалын нэр өөрчлөх тухай санал- 26,3%,
- дурсгалын физик шинж чанарыг илэрхийлэх хэлбэр төрх, өнгө дүрс зэрэг бичвэрийн утга агуулга өөрчлөх тухай санал- 10,6 %ийг эзэлж байна.

-салбар комиссын хүрээнд шийдвэрлэгдэх болон хууль хяналтын байгууллагын (дутсан, солигдсон дурсгалт зүйлс г.м) шийдэх асуудлаар улсын комисст хандсан нь- 22.2 %-ийг тус тус эзэлж байна.

Улсын тооллогоор дурсгалт зүйлийн физик шинж чанарыг илэрхийлэх хэлбэр төрх, өнгө дүрс, хэмжээ, жингийн бичвэр тодорхойлолт зөрж байгааг илрүүлэн гаргаж байгаа нь сайн талтай ч цаашид хяналт тавих, зөрсөн учир шалтгааныг олж тогтоох, үнэн зөв, мэдээллийн зөрүүгүй бүртгэлд тусгах шаардлагатай байна.

#### Ажлын хэсэг томилон ажиллуулсан тухай

Улсын Комисс дурсгалт зүйлийн бичвэрт нэмэлт, өөрчлөлт оруулахаар санал ирүүлсэн салбар комиссын саналуудыг хэлэлцэж, газар дээр нь биечлэн үзэж танилцах шаардлагатай газруудад 8 Ажлын хэсэг томилон ажиллуулсан. Үүнд:

Эрдэнэ Зуу музей, Завхан, Сүхбаатар, Дорноговь, Говьсүмбэр, Сэлэнгэ зэрэг аймгийн музей, Монголын Уран зургийн галерей, Монгол Цэргийн музей, МУИС, ШУТИС, Улаанбаатар Их сургууль зэрэг улсын тооллогын 11 Салбар комиссын тооллогын явцтай биечлэн очиж, зохих зөвлөмж өгч, дүгнэлт гарган ажилласан.

Ажлын хэсэг Засгийн газрын 2018 оны 184 дүгээр тогтоолоор батлагдсан “Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийх журам”-ын 2.8.2; 2.8.4 дүгээр зүйлд заасны дагуу дээрх нэр бүхий музейн улсын тооллогын бүртгэлд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг шийдвэрлэхэд зохих дүгнэлтийг гарган ажилласан байна.

Тооллогын үеэр Улсын комисс бүрэн бүрэлдэхүүнээрээ Чойжин ламын сүм музей дээр биечлэн очиж, тооллогын ажлын явц, улирлын байдлаас шалтгаалан үүссэн нөхцөл байдалтай танилцан, арга зүйн зөвлөмж, хугацаатай албан даалгаврыг албан бичгээр өгөх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан.

### III. ТҮҮХ, СОЁЛЫН ХӨДЛӨХ ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙН 2018-2019 УЛСЫН ТООЛЛОГЫН НЭГДСЭН ДҮН МЭДЭЭ

#### Тооллогын хугацаа, хамрагдсан байгууллага, нэгдсэн тоон дүн мэдээ

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн соёлын өвийн үзлэг, тооллого тухай 26.1 дүгээр заалт, Засгийн газрын 2018 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 184 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийх журам”, Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын сайдын 2018 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн А/648 дугаартай “Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийх тухай” тушаалд тус, тус заасны дагуу түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн улсын тооллого 21 аймаг, нийслэлийн хэмжээнд 2018 оны 11 дүгээр сарын 1-ээс 2019 оны 3 дугаар сарын 31-нийг хүртэлх хугацаанд зохион байгуулагдаж, төрийн өмчийн-19, орон нутгийн өмчийн-285, шашны өмчийн-3, нийт 307 байгууллага, аж ахуйн нэгж хамрагдлаа.

## Хүснэгт №6

№	Байгууллага	Улсын тооллогод хамрагдсан байгууллагуудын тоо	Өмчийн хэлбэрээр
1	Улсын музей	10	Төрийн өмчийн (19)
2	Эрдэм шинжилгээний хүрээлэн	2	
3	Их, дээд сургуулийн дэргэдэх музей	3	
4	Байгууллагын дэргэдэх музей	2	
5	Үндэсний номын сангийн ховор номын фонд	1	
6	Монголбанкны Эрдэнэсийн сангийн музей	1	
7	Аймаг, орон нутаг, нийслэлийн музей	24	Орон нутгийн өмчийн (285)
8	Сум, дүүргийн Орон нутаг сурталчлах танхим	261	
10	Бурханы шашны сүм хийд	3	Шашны өмчит (3)
	Нийт	307	

- Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн 2018-2019 оны улсын тооллогоор 127264 дэсийн 277019 ширхэг түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл тоологдохоос 126810 дэсийн 276077 ширхэг 105.659. 865,196 төгрөгийн үнэ бүхий түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл тоологдсон байна.

## Хүснэгт №7


№	Улсын тооллогод хамрагдсан байгууллага- (307)	Тоологдох хөдлөх дурсгалт зүйл		Дутсан		Хулгайд алдсан		Солигдсон		Гадаадад үзэсгэлэнд		Тоологдсон хөдлөх дурсгалт зүйл	
		дэс	тоо/ш	дэс	тоо/ш	дэс	тоо/ш	дэс	тоо/ш	дэс	тоо/ш	дэс	тоо/ш
1	Улсын музей-10, э/ш хүрээлэн-2, номын сан-1, их сургууль-3, сүм хийд-2	59331	132270	9	9			1	1	19	67	59302	132193
2	Аймаг, орон нутаг, нийслэлийн музей-24, байгууллагын музей-3	48205	109622	68	86	2	2	21	23			48114	109511
3	Сум, дүүргийн ОНСТ-261, сүм хийд-1	19728	35127	285	672	41	72	8	10			19394	34373
<b>НИЙТ ДҮН</b>		<b>127264</b>	<b>277019</b>	<b>362</b>	<b>767</b>	<b>43</b>	<b>74</b>	<b>30</b>	<b>34</b>	<b>19</b>	<b>67</b>	<b>126810</b>	<b>276077</b>

(Хавсралт №1, 2, 3, 4. Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн 2018-2019 оны улсын тооллогын дүн мэдээний дэлгэрэнгүй үзүүлэлт)

Тоологдсон хөдлөх дурсгалт зүйлийн төрөл зүйлийн үзүүлэлт

## Хүснэгт №8

№	Улсын тооллогод хамрагдсан байгууллага- (307)	Байгалийн түүхийн цуглуулга		Археологийн олдвор		Түүхийн цуглуулга		Угсаатны зүйн цуглуулга		Шашин шүтлэг		Урлаг, уран сайхан	
		дэс	тоо/ш	дэс	тоо/ш	дэс	тоо/ш	дэс	тоо/ш	дэс	тоо/ш	дэс	тоо/ш
1	Улсын музей-10, э/ш хүрээлэн-2, номын сан-1, их сургууль-3, сүм хийд-2	10431	12576	5093	22785	14971	43767	6544	10395	13375	31265	8820	11337
2	Аймаг, орон нутаг, нийслэлийн музей-24 байгууллагын музей-3	3842	6639	2193	4476	16444	52160	10147	13529	10739	27147	4744	5561
<b>НИЙТ ТӨРӨЛ ЗҮЙЛ</b>		<b>14273</b>	<b>19215</b>	<b>7286</b>	<b>27261</b>	<b>31415</b>	<b>95927</b>	<b>16691</b>	<b>23924</b>	<b>24114</b>	<b>58412</b>	<b>13564</b>	<b>16898</b>



- Түүхийн холбогдолтой цуглуулга -29%
- Шашин шүтлэгийн холбогдолтой зүйл -22%
- Угсаатны зүйн цуглуулга-16%
- Байгалийн түүхийн холбогдолтой -13%
- Урлаг, уран сайхны холбогдолтой-13 %
- Археологийн олдвор7%-ийг тус тус эзэлж байна.

Улсын тооллогоор “дутсан”, “хулгайд алдсан”, “солигдсон” болон “гадаадад үзэсгэлэнд оролцсон” хөдлөх дурсгалт зүйлийн талаар:

2018-2019 оны улсын тооллогоор:

- 15 аймгийн 87 сумын Орон нутаг сурталчлах танхим,
- Аймаг, орон нутгийн 6 музей,
- Улсын 4 музей,
- байгууллагын харьяа 1 музей,
- 1 сүм хийд зэрэг нийт 99 байгууллагын 146,529,941 төгрөгийн үнэ бүхий 435 дэсийн 875 ширхэг хөдлөх дурсгалт зүйл "дутсан", "хулгайд алдсан", "солигдсон" шалтгаанаар тоологдоогүй байна. Үүнд:
- 362 дэсийн 767 ширхэг нь дутсан,



- 43 дэсийн 74 ширхэг нь хулгайд алдсан,
- 30 дэсийн 34 ширхэг дурсгалт зүйлс солигдсон байна.

Тоологдоогүй дурсгалт зүйлсийн:

- Түүхийн холбогдолтой дурсгалт зүйл- 522 ш буюу 61%,
- Угсаатны зүйн дурсгалт зүйл- 178 ш буюу 19%,
- Шашин шүтлэгийн холбогдолтой- 74 буюу 8%,
- Байгалийн түүхийн дурсгалт зүйл 52 ш буюу 6%,
- Урлаг, уран сайхны холбогдолтой- 43 ш буюу 5%,
- Археологийн олдвор- 6 ш буюу 1%-ийг тус тус эзэлж байна.



Дутсан, хулгайд алдсан, солигдсон дурсгалт зүйлийнхээ мэдээллийг 17 салбар комисс буюу 15% нь хуулийн байгууллагад хандсан, 74 буюу 76% нь хууль хяналтын байгууллагад хандаагүй, 8 газар буюу 7% нь хуулийн байгууллагад хандсан эсэх нь тодорхойгүй байгаа нь тооллогын журмын 2.8.6 дугаарт заасан: “дутсан солигдсон дурсгалт зүйлийн талаарх мэдээллийг бэлтгэж аймаг, нийслэлийн Засаг дарга, цагдаагийн байгууллагад хүргүүлэх” тухай заалтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Ялангуяа сумдын ОНСТанхимуудын хадгалалт хамгаалалт, хараа хяналт сулаас их хэмжээний (285 дэсийн 672 ширхэг) дурсгалт зүйлс дутсан бөгөөд дутагдаж, үрэгдүүлсэн дурсгалт зүйлсийн талаар хуулийн дагуу зохих арга хэмжээ авдаггүй, зарим газар дутаасан зүйлсээ хасах актлах үзмэрийн саналд оруулан тайланд тусгасан зэрэг зохисгүй явдлууд гарсан байна. ОНСТанхимын үнэ цэнэтэй үзмэрийг тухайн сумын Засаг дарга дур мэдэн өрөө тасалгаандаа хадгалах, язгуур байдлаар нь ашиглах явдал байсаар байна. Тухайлбал: Дорнод аймгийн Булганы сумын ОНСТ-ын үнэ цэнэтэй үзмэр “Хэт хутга”-ыг сумын Засаг дарга нь цагаан сараар авч хэрэглэдэг байсан ба 2013 онд авч хэрэглэх үедээ дутаасан (тухайн үедээ 15 сая төгрөгөөр үнэлсэн) ба өдий хүртэл хуулийн дагуу арга хэмжээ аваагүй байна.

Мөн Дорнод аймгийн Баяндун сумын ОНСТ 2018 онд 16 дэсийн 51 ширхэг дурсгалт зүйлс бурхны танка зураг, бөөгийн толь, цөгц зэрэг үнэт цэнэтэй ур хийц сайтай үзмэрүүд дутаасныг аймгийн музейгээс тус сумын цагдаагийн хэсэгт хандсан боловч сумын цагдаагийн хэсэг хэрэг үүсгэн шалгахаас татгалзсан зэрэг хууль бус үйлдлүүд гарсан байна.

Дутсан, солигдсон дурсгалт зүйлийн байдлаас үзэхэд тухайн дурсгал бүхэл бүтнээрээ дутагдаж, солигдсон байхаас гадна тухайн дурсгалаас хэсэгчлэн дутсан явдал цөөнгүй байна. Тухайлбал: Ховд аймгийн музейн үнэ цэнэтэй үзмэрүүдийн нэг “Халх эхнэрийн толгойн боолт”-ноос 1 ширхэг том хэмжээний шүрэн шигтгээ дутсан байна.

Иймээс дутсан солигдсон, тоологдоогүй үзмэрүүдийн “дэс” болон “тоо ширхэг”-ийн тоог гаргахаас гадна хэсэгчлэн дутсаныг зөвхөн “тоо ширхэг”-ээр нь тоолж гаргасан болно.

Дутсан хөдлөх дурсгалт зүйлийн талаар:

Хүснэгт №9

Байгууллагаар	Дутсан 362 дэсийн 767 ширхэг хөдлөх дурсгалт зүйлийн:			
	дэс	хувь	тоо/ш	хувь
Сумын ОНСТ	285	78%	672	87%
Аймаг, орон нутаг, байгууллагын харьяа музей,	68	19%	86	11%
Улсын музей, сүм хийд	9	2%	9	1,17 %



Сумдын Орон нутаг сурталчлах танхим (ОНСТ)-аас:

- Булган аймгийн Гурванбулаг сумын ОНСТ 21 дэсийн 49 ширхэг,
- Булган аймгийн Дашинчилэн сумын ОНСТ 19 дэсийн 240 ширхэг,
- Баянхонгор аймгийн Богд сумын ОНСТ 19 дэсийн 19 ширхэг,
- Дорнод аймгийн Баяндун сумын ОНСТ 18 дэсийн 68 ширхэг,
- Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын ОНСТ 11 дэсийн 30 ширхэг,
- Увс аймгийн Өлгий сумын ОНСТ 11 дэсийн 13 ширхэг

- Хэнтий аймгийн Дархан сумын ОНСТ 9 дэсийн 29 ширхэг,
- Төв аймгийн Баянжаргалан сум ОНСТ 9 дэсийн 13 ширхэг,
- Увс аймгийн Бөхмөрөн сумын ОНСТ 8 дэсийн 27 ширхэг,
- Өвөрхангай аймгийн Төгрөг сумын ОНСТ 8 дэсийн 12 ширхэг зэрэг хамгийн их дутжээ.

Аймаг, орон нутаг, нийслэлийн музейгээс:

- Сэлэнгэ аймгийн нэгдсэн музей 61 дэсийн 78 ширхэг,
- Монгол Цэргийн музей 3 дэсийн 3 ширхэг,
- Төв аймгийн музей 2 дэсийн 2 ширхэг зэрэг.

Улсын музейгээс:

- Байгалийн түүхийн музей 3 дэсийн 3 ширхэг,
- Өвөрхангай аймгийн Төвхөн хийд 3 дэсийн 3 ширхэг
- Богд хааны ордон музей 2 дэсийн 2 ширхэг,
- Хархорум музей 1 дэсийн 1 ширхэг тус тус дутсан байна.

Улсын тооллогоор нийт “дутсан” дурсгалт зүйлийн дотор тухайн музейн сан хөмрөгт өөрийн сайн дураар өгч хандивласан эд өлгийн зүйлсээ өгсөн эзэн нь эгүүлэн авсны улмаас дутсан дурсгалт зүйл цөөнгүй байна. Үүнд: Улсын 1 музей, 9 аймгийн 17 сумын ОНСТанхимд нийтдээ 30 дэсийн 38 ширхэг дурсгалт зүйл дээрх шалтгаанаар дутсан байна.

Хүснэгт №10

№	Музей, ОНСТ	Дэс, тоо/ш
1	Богд хааны ордон музей	2 дэсийн 2 ширхэг
2	Архангай аймгийн Өлзийт сумын ОНСТ	2 дэсийн 2 ширхэг
3	Говь-Алтай аймгийн Халиун сумын ОНСТ	2 дэсийн 2 ширхэг
4	Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын ОНСТ	1 дэсийн 2 ширхэг
5	Завхан аймгийн Алдархаан сумын ОНСТ	1 дэсийн 1 ширхэг
6	Завхан аймгийн Асгат сумын ОНСТ	4 дэсийн 4 ширхэг
7	Завхан аймгийн Баянтэс сумын ОНСТ	3 дэсийн 3 ширхэг
8	Завхан аймгийн Тэлмэн сумын ОНСТ	1 дэсийн 1 ширхэг
9	Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын ОНСТ	1 дэсийн 1 ширхэг
10	Төв аймгийн Баянжаргалан сумын ОНСТ	2 дэсийн 2 ширхэг
11	Төв аймгийн Эрдэнэсант сумын ОНСТ	2 дэсийн 2 ширхэг
12	Увс аймгийн Өлгий сумын ОНСТ	1 дэсийн 1 ширхэг
13	Увс аймгийн Тариалан ОНСТ	1 дэсийн 8 ширхэг
14	Увс аймгийн Хяргас сум	1 дэсийн 1 ширхэг
15	Ховд аймгийн Дуут сумын ОНСТ	2 дэсийн 2 ширхэг
16	Ховд аймгийн Мөнххайрхан сумын ОНСТ	1 дэсийн 1 ширхэг
17	Ховд аймгийн Цэцэг сумын ОНСТ	1 дэсийн 1 ширхэг
18	Хэнтий аймгийн Баянхутаг сумын ОНСТ	2 дэсийн 2 ширхэг
	Улсын 1 музей, 9 аймгийн 17 сумын ОНСТанхимын	30 дэсийн 38 ширхэг

Тайланд бичсэнээс үзэхэд: музейн сан хөмрөгт өөрийн сайн дураар өгснөө буцаан авсан эсхүл хувь иргэнээс түр зээлсэн эд зүйлсийг эзнийхэн зөвшөөрөлгүй ерөнхий бүртгэлд бүртгэсэн зэрэг шалтгаанууд байна. Музейн сан хөмрөгөөс буцаан авсан асуудал байгууллага, иргэдийн дунд маргаантай байх тул асуудлыг зохих хуулийн дагуу шийдвэрлэх шаардлагатай байна.

Хулгайд алдсан хөдлөх дурсгалт зүйлийн талаар:

Хүснэгт №11

Байгууллагаар	Хулгайд алдсан 43 дэсийн 74 ширхэг хөдлөх дурсгалт зүйлийн:			
	дэс	хувь	тоо/ш	хувь
сумын ОНСТ	41	95%	72	97%
аймаг, байгууллагын харьяа музей	2	4.6%	2	2.7%

Сумдын ОНСТ-аас:

- Булган аймгийн Бүрэгхангай 23 дэсийн 36 ширхэг,
- Ховд аймгийн Мөнххайрхан сум 10 дэсийн 13 ширхэг хамгийн их дурсгалт зүйл хулгайд алдсан.

Аймаг, орон нутаг, байгууллагын харьяа музейгээс:

- Өмнөговь аймгийн музей (2004 онд) 1 дэсийн 1 ширхэг,
- Монгол Цэргийн музей 1 дэсийн 1 ширхэг дурсгалт зүйл хулгайд алдсан байна.

Солигдсон хөдлөх дурсгалт зүйлийн талаар:

Хүснэгт №12

Байгууллага	Нийт солигдсон 30 дэсийн 34 ширхэг хөдлөх дурсгалт зүйлийн:			
	дэс	хувь	тоо/ш	хувь
аймгийн музей	21	70%	23	67%
сумын ОНСТ	8	26%	10	29%
улсын музей	1	3%	1	2,9%

Аймаг, орон нутаг, нийслэлийн музейгээс:

- Сэлэнгэ аймгийн музей 21 дэсийн 23 ширхэг,

Сумдын ОНСТ-аас:

- Завхан аймгийн Цагаанчулуут сумын ОНСТ 1 дэсийн 1 ширхэг,
- Завхан аймгийн Яруу сумын ОНСТ 1 дэсийн 1 ширхэг,
- Төв аймгийн Сүмбэр сумын ОНСТ 1 дэсийн 1 ширхэг,
- Ховд аймгийн Дарви сумын ОНСТ 1 дэсийн 1 ширхэг,
- Ховд аймгийн Үенч сумын ОНСТ 2 дэсийн 3 ширхэг,
- Ховд аймгийн Арбулаг сумын ОНСТ 1 дэсийн 1 ширхэг,

Улсын музей, бусад байгууллагаас:

- Монголын Үндэсний музейн харьяа Хэлмэгдлийн музейн 1 дэсийн 1 ширхэг дурсгал тус тус солигдсон байна.



Улсын тооллогын дутсан, солигдсон, хулгайд алдсан зэрэг шалтгааны улмаас тоологдоогүй дурсгалт зүйлийн тоон дүнгээс үзэхэд хадгалалт, хамгаалалтын нөхцөл байдал, хариуцсан албан тушаалтны ажлын хариуцлага, сахилга бат, хяналт сулаас дурсгалт зүйл дутах, солигдох, хулгайлагдах зэрэг гэмт хэргийн нөлөөнд өртөж, соёлын өвийн бүрэн бүтэн байдал алдагдсан байна.

Өмнөх улсын тооллогуудын үр дүнгийн мөрөөр хэрэгжүүлсэн эрх бүхий байгууллагын шийдвэр гарч актлах устгах ажиллагаа хийгдсэн боловч ерөнхий бүртгэлээс хасаж, бүртгэлээ цэгцлэх ажил хийгдээгүй улмаас энэ тооллогоор тухайн хасаж актлагдсан зүйлс “дутсан” мэт бүртгэлд харагдаж тооллогын тоон дүн мэдээг нэгтгэхэд хүндрэл учруулж байлаа. Иймд зохих дүрэм журмын дагуу актлагдсан, шилжүүлсэн үзмэр нэг бүрийг бүртгэлүүдтэй тулган шалгаж дутсан талаарх дүн мэдээг гаргалаа.

2018-2019 оны улсын тооллогын үр дүнгийн мөрөөр хэрэгжүүлэх ажлын хүрээнд тухайн музей, байгууллагууд өмнөх (2008, 2012 оны) улсын тооллогуудаар илэрч, эрх бүхий байгууллагын шийдвэр гарч шийдвэрлэгдсэн:

- дутсан, хулгайд алдсан, солигдсон,
- хасаж актлагдсан,
- шилжүүлсэн эсхүл дэс алгасан бүртгэсэн,
- давхар бүртгэсэн зэргийг нотлох баримтыг үндэслэн цахим “Register” бүртгэлээс хасаж, бүртгэлийг цэгцлэх ажлыг хийх шаардлагатай байна.

Гадаадад үзэсгэлэнд оролцсон хөдлөх дурсгалт зүйлийн талаар:

Монголын Үндэсний музейгээс Дани Улсад 2018 оны 6 дугаар сараас 2019 оны 10 дугаар сарыг хүртэлх хугацаанд зохион байгуулагдаж буй “Чингис хааны тал нутагт-Монголын нүүдэлчид” үзэсгэлэнд байгаа 19 дэсийн 67 дурсгалт зүйл улсын тооллогод хамрагдаагүй болно. Эдгээр дурсгалт зүйлс 2019 оны 10 дугаар сард бүрэн бүтэн эргэж ирээд байна.

Бүртгэл хөтлөлт сайжруулалтын хүрээнд хийгдсэн нэмэлт, өөрчлөлт:

Өмнөх 2012-2013 оны улсын тооллогоор музейн ерөнхий бүртгэлийг цахимжуулах ажил анх удаа хийгдсэн ба цахимд шилжүүлэх явцад:

-дурсгалыг давхардуулан бүртгэсэн,  
 -дэс алгасаж бүртгэсэн,  
 -тоо ширхгийг гар бичмэл дэвтрээс алдаатай оруулсан зэрэг бүртгэл хөтлөлттэй холбоотой дутагдлууд байсныг энэ удаагийн улсын тооллогоор засаж залруулах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Түүнчлэн 2013 оноос хойш сумдын ОНСТанхимууд, зарим аймаг орон нутгийн музейн ерөнхий бүртгэлд бүртгэгдээгүй байсан хөдлөх дурсгалт зүйлийг шинээр нэмж бүртгэх ажил хийгдсэн байна.

#### Хүснэгт №13

№	Улсын тооллогод хамрагдсан байгууллага- (307)	Бүртгэл хөтлөлт сайжруулалтын хүрээнд хийгдсэн:					
		Дэс давхардсан эсхүл алгассан		Тоо /ш задалж эсхүл нэгтгэсэн		Шинээр нэмж бүртгэсэн	
		дэс	тоо/ш	зад+	нэгт-	дэс	тоо/ш
1	Улсын музей-10, э/ш хүрээлэн-2, номын сан-1, их сургууль-3, сүм хийд-2	67	68	464	20		
2	Аймаг, орон нутаг, нийслэлийн музей-24 байгууллагын музей-3	13	12	38	305	5	7
3	Сум, дүүргийн ОНСТ-261, сүм хийд-1	19	5	599	40	538	865
НИЙТ ДҮН		99	85	1101	365	543	872

#### *Дэс давхардсан, алгассан бүртгэлийн талаар:*

Цахим бүртгэлд үзмэр, дурсгалт зүйлийг давхардуулан бүртгэсэн, эсвэл дэс алгасаж бүртгэсэн нь тухайн музей, байгууллагын сан хөмрөг дэх дурсгалт зүйлийн тоон дүн буруу ташаа гарахад нөлөөлж байна. Энэ удаагийн улсын тооллогыг цахим бүртгэлд тулгуурлан явуулснаар бүртгэл хөтлөлтийн явцад гарсан алдаа мэдгийг илрүүлэн, засаж залруулах боломжтой болсон.

Улсын 7 музей, аймаг орон нутгийн 7 музей, 12 сумын (давхардсан) ОНСТ-ын цахим бүртгэлд 100 дэсийн 86 ширхэг дурсгал зүйлийг давхар бүртгэсэн эсхүл дэс алгасаж бүртгэсэн зэрэг асуудлыг илрүүлсэн ба цахим бүртгэлээс хасаж цэгцлэх шаардлагатай байна.

#### Хүснэгт №14

№	Байгууллага	Дэс давхардсан эсхүл алгассан	
		дэс	тоо/ш
1	Монголын үндэсний музей	35	63
2	Байгалийн түүхийн музей	6	
3	Монголын Театрын музей	1	1
4	Монголын Уран зургийн галерей	3	3
5	Чойжин ламын сүм музей	1	1
6	ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн	20	
7	Өвөрхангай аймаг. Шанхын Баруун хүрээ хийд	1	
8	Архангай аймгийн музей	1	
9	Баянхонгор аймгийн түүх, угсаатны зүйн музей	1	
10	Дорноговь аймгийн музей, сургалт сурталчилгааны төв	2	2
11	Орхон аймгийн музей	1	1

12	Төв аймгийн музей	1	1
13	Монгол цэргийн музей	6	6
14	Эрдэнэсийн сан	1	2
15	Архангай аймгийн Булган сумын ОНСТ	1	
16	Архангай аймгийн Ихтамир сумын ОНСТ		
17	Архангай аймгийн Өлзийт сумын ОНСТ	1	1
18	Баянхонгор аймгийн Баацагаан сумын ОНСТ	2	
19	Баянхонгор аймгийн Баянбулаг сумын ОНСТ	2	
20	Баянхонгор аймгийн Бууцагаан сумын ОНСТ	1	
21	Баянхонгор аймгийн Хүрээмарал сумын ОНСТ	6	
22	Завхан аймгийн Их-Уул сумын ОНСТ	1	1
23	Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын ОНСТ	1	1
24	Төв аймгийн Бүрэн сумын ОНСТ	2	2
25	Төв аймгийн Угтаалцайдам сумын ОНСТ	1	
26	Ховд аймгийн Манхан сумын ОНСТ	1	1
27	Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын ОНСТ	1	

*Тоо ширхэг залруулан бүртгэсэн талаар:*

Язгуур хэрэглээ хийц байдал, онцлог шинж чанараас хамаарч музейн үзмэр нь ганц нэг ширхгээр байхаас гадна хэд хэдэн хэсэг, ширхгээс бүрдэж байдаг. Музейн ерөнхий бүртгэлд салангид хэрнээ тухайн үзмэрийн салшгүй нэг бүрдэл болсон хэсэг бүрийг нэг бүрчлэн тоолж бүртгэдэг.

Тухайлбал: “Хэт хутга”-ыг бүртгэхдээ дэс-1, тоо ширхэг-1 гэнэ. Хэт хутганы иж бүрдэл бүрэлдэхүүн хэсгийн тоо ширхгийг: савх-1хос буюу 2ш, хутга-1ш, хуй-1ш, бэл-1хос буюу 2ш, тээг-1ш, хэт-1ш, мөнгөн оосор 2ш, иж бүрдлийн тоо ширхэг нийт 9ш гэх мэтээр доторх зүйлсийг нарийвчлан задалж бүртгэдэг.

Тооллогоор улсын 9 музей, аймаг орон нутгийн 7 музей, 31 сумын ОНСТ бүртгэл хөтлөлтийг цэгцлэн сайжруулахад нийт 1101 дэсийн 365 ширхэг дурсгалт зүйлийн иж бүрдлийн тоо ширхэг бүрэлдэхүүнийг задалж эсхүл нэгтгэн бүртгэсэн байна. Иж бүрдлийн тоо ширхгийг задалж үндсэн “тоо ширхэг”-т нэмж оруулан тоолсон. Үүнд:

**Сумдын ОНСТ-аас:**

- Булган аймгийн Дашинчилэн сумын ОНСТ 304 ширхгээр,
- Булган аймгийн Баяннуур сумын ОНСТ 110 ширхгээр,
- Булган аймгийн Сайхан сумын ОНСТ 76 ширхгээр,
- Ховд аймгийн Булган сумын ОНСТ 17 ширхгээр,
- Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын ОНСТ 14 ширхгээр
- Булган аймгийн Гурванбулаг сумын ОНСТ 13 ширхгээ тус тус нэмсэн.

**Улсын музей, бусад байгууллагаас:**

- Өвөрхангай аймгийн Төвхөн хийд 195 ширхэг,
- ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн 168 ширхэг,
- Монголын Үндэсний музей 98 ширхгээр тус тус нэмж оруулсан.

**Аймаг, орон нутаг, нийслэлийн музейгээс:**

- Эрдэнэсийн сан 24 ширхгээр нэмжээ.

**Иж бүрдлийн тоо ширхгийг нэгтгэсэн бүртгэсэн:**

**Аймаг, орон нутаг, нийслэлийн музейгээс:**

- Баянхонгор аймгийн түүх, угсаатны зүйн музей хамгийн их 218 ширхгийг
- Дорноговь аймгийн музей, сургалт судалгааны төв 77 ширхгийг,
- Эрдэнэсийн сан 10 ширхгийг тус тус нэгтгэн тоолж бүртгэсэн байна.

Сумдын ОНСТ-аас:

- Завхан аймгийн Отгон сум 22 ширхгийг,

Улсын музей, бусад байгууллагаас:

- МУИС-ийн Нийгмийн шинжлэх ухааны сургууль 18 ширхгийг тус тус нэгтгэн тоолж бүртгэсэн байна.

*Сан хөмрөгт шинээр нэмж бүртгэсэн талаар:*

Улсын тооллогоор сумдын ОНСТ, зарим аймаг, орон нутгийн музей тоологдвол зохих дурсгалт зүйлээс гадна 2013 оноос хойш сан хөмрөгт үзмэр баяжуулалтаар авсан үзмэр, дурсгалт зүйлийг ерөнхий бүртгэлд нэмж бүртгэх ажлыг гүйцэтгэсэн байна. Аймаг орон нутгийн 2 музей, 32 сумын ОНСТ ерөнхий бүртгэлд бүртгэгдээгүй байсан 543 дэсийн 872 ширхэг дурсгалт зүйлийг тооллогын үеэр нэмж бүртгэжээ. Үүнд: Сумдын ОНСТ-аас:

- Дорноговь аймгийн 12 сумын ОНСТ нийт 126 дэсийн 222 ширхгийг,
- Дундговь аймгийн 10 сумын ОНСТ нийт 209 дэсийн 320 ширхгийг,
- Увс аймгийн Тариалан сум ОНСТ 14 дэсийн 14 ширхэг,
- Ховд аймгийн 11 сумын ОНСТ нийт 189 дэсийн 309 ширхгийг,

Аймаг, орон нутаг, нийслэлийн музейгээс:

- Дорноговь аймгийн музей, сургалт судалгааны төв 4 дэсийн 6 ширхэг,
- Увс аймгийн музей 1 дэсийн 1 ширхэг дурсгалт зүйлийг тус тус ерөнхий

бүртгэлд шинээр нэмж бүртгэн тоолсон байна.

Ерөнхий бүртгэлээс хасах, ангилал солих саналтай түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тоон дүн

*Хасах, актлах саналын талаар:*

- Улсын 3 музей, аймаг орон нутгийн 17 музей, сумдын 59 ОНСТ-аас 606 дэсийн 1001 ширхэг үзмэрийг соёлын өвийн шаардлага хангахгүй хэмээн ерөнхий бүртгэлээс хасаж, актлах тухай санал,

- Улсын 5 музей, аймаг орон нутгийн 14 (давхардсан тоогоор) музей, сумдын 25 (давхардсан тоогоор) ОНСТ 717 дэсийн 1590 ширхэг дурсгалт зүйлийг үндсэн хөрөнгөөс эргэлтийн хөрөнгөд шилжүүлэх тухай тус, тус санал ирүүлсэн байна.

Мөн өмнөх (2012-2013 оны) улсын тооллогоор хасаж актлах тухай саналыг гаргаж байсан боловч шийдэгдээгүй байгаа асуудлууд байсаар байна. Тухайлбал: Монголын Уран зургийн галерейн 2008 онд гал түймэрт шатсан 113 ширхэг уран зургийн асуудал өдий хүртэл шийдэгдээгүй, тооллогоос тооллогын хооронд шатсан үнс нурам тоолсоор байгааг шийдвэрлэх шаардлагатай байна.



## Хүснэгт №15

№	Улсын тооллогод хамрагдсан байгууллага- (307)	Хасах, актлах саналтай		Бүртгэлийн ангилал солих								Өмчлөл, эзэмшил шилжүүлэх саналтай		Дэс давхардсан, алгассаныг бүртгэлээс хасуулах саналтай	
				Туслах хэрэглэгдэхүүний бүртгэлд шилжүүлэх саналтай		Сурталчилгааны бүртгэлд шилжүүлэх саналтай		Эргэлтийн хөрөнгөд шилжүүлэх саналтай		Түүх, соёлын үл хөдлөх дурсгалд шилжүүлэх					
		дэс	тоо/ш	дэс	тоо/ш	дэс	тоо/ш	дэс	тоо/ш	дэс	тоо/ш	дэс	тоо/ш	дэс	тоо/ш
1	Улсын музей-10, э/ш хүрээлэн-2, номын сан-1, их сургууль-3, сүм хийд-2	118	144	255	80	13	13	14	26					67	68
2	Аймаг, орон нутаг, нийслэлийн музей-24 байгууллагын музей-3	224	423	34	479	119	304	148	327	2	13	6	16	13	12
3	Сүм, дүүргийн ОНСТ-261, сүм хийд-1	264	434	47	198	12	11	64	120	3	3			19	5
<b>НИЙТ ДҮН</b>		<b>606</b>	<b>1001</b>	<b>336</b>	<b>757</b>	<b>144</b>	<b>328</b>	<b>226</b>	<b>473</b>	<b>5</b>	<b>16</b>	<b>6</b>	<b>16</b>	<b>99</b>	<b>85</b>

Улсын тооллогын Салбар комиссууд тооллого дууссаны дараа дурсгалт зүйлийн хадгалалт хамгаалалтын нөхцөл, аюулгүй байдлын талаар танилцуулга бэлтгэн Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлд танилцуулж, санал дүгнэлтээ гаргасан байна.

Хасах, актлах санал ирүүлсэн үзмэрүүдийн ихэнх хувийг он удаан жил болж хадгалалтын нөхцөл даахгүй болсон ургамлын хатаамал, амьтдын чихмэл, хорхойд идэгдэж устсан эсгий даавуу эдлэл, бүрэн бүтэн байдлаа алдсан, дахин сэргээн засварлах боломжгүй үзмэрүүд эзэлж байна.

Тайланд “Хасах, актлах санал”-д дараах шалтгаан, нөхцөлтэй дурсгалт зүйлсийг оруулсан байна. Үүнд:

- өмнөх улсын тооллогуудаар эрх бүхий байгууллагуудын хасах актлах тухай шийдвэр гарсан боловч шийдвэрийг биелүүлээгүй, 2018-2019 оны улсын тооллогоор дахин тоолж бүртгэн хасах, актлах саналтай хэмээн тайланд тусгасан байна.

- эрх бүхий байгууллагуудын шийдвэрийн дагуу хасаж акталсан үзмэр, дурсгалт зүйлсээ ерөнхий бүртгэлээс хасаж, бүртгэл дансаа цэгцлээгүйн улмаас тоологдоогүй, мөн дутсан дурсгалт зүйлийн тоон дүнд оруулан бүртгэсэн байна.

- хасаж актлах тухай саналыг албан ёсоор гаргасан боловч шийдэгдээгүй асуудлууд байна.

Ерөнхий бүртгэлээс хөдлөх дурсгал зүйл буюу үзмэрийг хасах актлах ажлыг улсын тооллогын үр дүнгийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын дагуу хэрэгжүүлэхээр тусгагдсан.

Бүртгэлийн ангилал солих талаар:

Улсын 5 музей, аймаг, орон нутаг, нийслэлийн 14 музей, сүм хийд 1, Завхан аймгийн 9, Өвөрхангай аймгийн 1, Төв аймгийн 3, Ховд аймгийн 9 сумын, Улаанбаатар хотын 1 дүүргийн ОНСТ зэрэг нийт 41 газраас 717 дэсийн 1590 ширхэг дурсгалт зүйлийг “Туслах хэрэглэгдэхүүний бүртгэл”, “Судалгаа сурталчилгааны бүртгэл”, “Эргэлтийн хөрөнгө”-д шилжүүлэх тухай саналуудыг үзэхэд:

- Соёлын өвд хамаарахгүй, макет, хуулбар зэрэг туслах хэрэглэгдэхүүний зүйлс, шилэн хорго, тавиур, сав зэргийг үзмэрийн ерөнхий бүртгэлд бүртгэсэн;

- үл хөдлөх дурсгалыг хөдлөх дурсгалын ерөнхий бүртгэлд бүртгэсэн тохиолдол байна. Тухайлбал: Төв аймгийн Манзушир хийдийн хадан дээр зурсан бурхны зургийг хөдлөх болон үл хөдлөх дурсгалын бүртгэлд давхар бүртгэсэн тул үл хөдлөх дурсгалд шилжүүлэхээр тус тус санал ирүүлжээ.

Өмчлөл, эзэмшил шилжүүлэх саналын талаар:

Ерөнхий бүртгэлийн ангилал солих саналаас гадна өмчлөл, эзэмшил шилжүүлэх тухай Монгол Цэргийн музей 3 дэсийн 5 ширхэг, Завхан аймгийн музейгээс 3 дэсийн 11 ширхэг дурсгалт зүйлийн санал тайланд тусгажээ.

Тухайлбал: Завхан аймгийн Улиастай хотод сүүлийн үед баригдсан соёлын өвд хамаарахгүй, орчин цагийн хөшөө дурсгалын төрөл зүйлд хамаарах Суваргануудыг музейн үзмэрийн бүртгэлд бүртгэснийг хасуулж Улиастай хотын нийтийн эзэмшилд шилжүүлэх саналыг ирүүлсэн байна.

Нэн яаралтай сэргээн засварлах шаардлагатай дурсгалт зүйлсийн талаар:

Хүснэгт №16

№	Улсын тооллогод хамрагдсан байгууллага- (307)	Нэн яаралтай сэргээн засварлах шаардлагатай дурсгалт зүйлс	
		дэс	тоо/ш
1	Улсын музей-10, э/ш хүрээлэн-2, номын сан-1, их сургууль-3, сүм хийд-2	435	450
2	Аймаг, орон нутаг, нийслэлийн музей-24 байгууллагын музей-3	147	178
3	Сум, дүүргийн ОНСТ-261, сүм хийд-1	32	40
<b>НИЙТ ДҮН</b>		<b>614</b>	<b>668</b>

Улсын тооллогоор улсын 5 музей, аймаг, орон нутгийн 13 музей, 1 эшхүрээлэн, 15 сумын ОНСТ зэрэг нийт 34 газраас нийт 614 дэсийн 668 ширхэг үзмэрийг нэн яаралтай сэргээн засварлуулах санал ирүүлсэн байна.

Үүнээс Дүрслэх урлагийн музей 113 дэсийн 113 ширхэг дурсгалт зүйл, Монголын Уран зургийн галерей 2008 оны гал түймэрт өртсөн 260 дэсийн 260 ширхэг уран зураг зэрэг нь сэргээн засварлуулах саналын 63 %-ийг эзэлж байна.

Ерөнхий бүртгэлд нэмж бүртгэх хөдлөх дурсгалт зүйлсийн талаар:

Хүснэгт №17

№	Улсын тооллогод хамрагдсан байгууллага- (307)	Дэс давхардсан, алгассан бүртгэлийг хасаж залруулах		Бие даасан үзмэр болгон салгаж бүртгэх		Нэгтгэж бүртгэх		Сан хөмрөгөөс илэрч олдсоныг Ерөнхий бүртгэлд бүртгэх		2012 оноос хойшхи Ерөнхий бүртгэлд бүртгээгүйг бүртгэх	
		дэс	тоо/ш	дэс	тоо/ш	дэс	тоо/ш	дэс	тоо/ш	дэс	тоо/ш
1	Улсын музей-10, э/ш хүрээлэн-2, номын сан-1, их сургууль-3, сүм хийд-2	67	68			5	78	27	31	31	47
2	Аймаг, орон нутаг, нийслэлийн музей-24 байгууллагын музей-3	13	12	17	124	26	34	203	351	271	392
3	Сум, дүүргийн ОНСТ-261, сүм хийд-1	19	5	2	2	0	1	253	331	1081	1910
<b>НИЙТ ДҮН</b>		<b>99</b>	<b>85</b>	<b>19</b>	<b>126</b>	<b>31</b>	<b>113</b>	<b>483</b>	<b>713</b>	<b>1383</b>	<b>2349</b>

- Улсын тооллогоор бүртгэл хөтлөлтийн явцад илрүүлсэн дэс давхардуулан эсвэл алгасаж бүртгэснийг залруулах цэгцлэх,

- Дурсгалт зүйлийн түүхэн үнэ цэнэ, ач холбогдол, язгуур хэрэглээ хийц, шинж байдлаас шалтгаалан бие даасан үзмэр болох дурсгалт зүйлсэд тусад нь хувийн дугаар өгч салган бүртгэх, эсвэл нэгтгэн бүртгэхээр тус тус тайланд тусгасан байна.

- Сан хөмрөгт хадгалагдаж байгаа ч ерөнхий бүртгэлд бүртгэгдээгүй үзмэрүүд байна. Тухайлбал:

Говь-Алтай аймгийн 5 сум, Дорнод аймгийн 6 сум, Увс аймгийн 6 сумын ОНСТ 253 дэсийн 331 ширхэг,

Аймаг, орон нутгийн музей 203 дэсийн 271 ширхэг дурсгалт зүйл буюу Дорнод, Дундговь, Орхон, Сүхбаатар, Сэлэнгэ аймгийн музей, Эрдэнэ Зуу музей, Дорнод аймгийн Ялалт музейгээс тус тус хамгийн их санал ирүүлсэн байна.

2012 оноос хойших Ерөнхий бүртгэлд бүртгээгүй үзмэрүүдийн тухай:

БСШУ-ны сайдын 2012 оны А/355 дугаартай тушаалаар батлагдсан “Музейн сан хөмрөгийг бүртгэн баримтжуулах заавар”-ын 2.2.2-т эд өлгийн зүйлийг музейн сан хөмрөгт авах тухай шийдвэр гарснаас хойш Ерөнхий бүртгэлд 20 хоногийн дотор бүртгэхээр заасан ч ялангуяа сумдын ОНСТ, Аймаг орон нутгийн музейнууд 2012-2013 оны улсын тооллогоос хойш сан хөмрөг баяжилтаар авсан үзмэр эд өлгийн зүйлсээ ерөнхий бүртгэлд бүртгээгүй дутагдлууд тооллогоор илэрлээ. Үүнд:

- Өвөрхангай аймгийн 14 сум, Өмнөговь аймгийн 13 сум, Дорноговь аймгийн 12 сум, Дундговь аймгийн 9 сум, Архангай, Баян-Өлгий, Баянхонгор аймгийн тус бүр 1 сумын ОНСТ 1081 дэсийн 1910 ширхэг,

- Дорнод, Дархан-Уул, Өмнөговь, Төв, Говьсүмбэр аймгийн музей 271 дэсийн 392 ширхэг нийтдээ 1352 дэсийн 2302 ширхэг дурсгалт зүйлсийг улсын тооллогын дараа Ерөнхий бүртгэлдээ бүртгэхээр тайланд тусгасан байна.

Улсын тооллогын үеэр ОНСТанхимууд шинээр 543 дэсийн 872 ширхэг ерөнхий бүртгэлд нэмж бүртгэх ажлыг гүйцэтгэж, дүн мэдээнд оруулсан байна.

Цаашид музейн үзмэр, дурсгалт зүйлийг холбогдох дүрэм журмын дагуу хугацаанд нь бүртгэн баримтжуулах ажилд музейн захиргаа онцгой анхааран хяналт тавьж хэрэгжүүлэх шаардлагатай байна.

#### Тайланд музейнүүдээс ирүүлсэн цаашид хэрэгжүүлэх саналын талаар:

Салбар комиссоос ерөнхий бүртгэлийг цэгцлэх сайжруулах, бүртгэлийн чиглэлээр ажилтнуудыг чадавхжуулах, мэргэшүүлэх, шаардлагатай орон тоог бий болгох, сан хөмрөгийн хадгалалт хамгаалалтын нөхцөлийг сайжруулахад шаардлагатай мэргэжлийн тоног төхөөрөмж, барилгаар хангах, хөрөнгө санхүүгийн асуудлыг шийдвэрлүүлэх тухай саналуудыг улсын тооллогын тайланд тусган ирүүлснийг нэгтгэв.

#### Тайлан бичвэрийн талаар:

Салбар комиссуудын тайлан бичвэрийн байдлаас үзэхэд улсын тооллогоор тоологдсон дурсгалт зүйлийн талаарх тоон дүнг мэдээг нэгтгэж, цэгцлээгүй, цахим бүртгэлийн нэгдсэн дүн, хэвлэмэл дэвтрийн арын баталгаажилтын хуудсан дээрх тоологдсон үзмэрийн тоо ширхгийг тухай тэмдэглэл, тооллогын ажлын тайлан бичвэр зэргийн дурсгалт зүйлийн тоон дүн мэдээ өөр хоорондоо зөрүүтэй тайланд тусгасан нь улсын нэгдсэн дүн мэдээг нэгтгэхэд бэрхшээлтэй байлаа.

Ялангуяа аймаг, орон нутгийн Салбар комиссын тайланд тусгагдсан дүн мэдээ цахим болон дэвтрийн бүртгэлтэй зөрөх явдал их гарлаа. Баянхонгор, Булган, Дорноговь, Өвөрхангай, Сэлэнгэ, Хэнтий зэрэг аймгуудын музей, сумдын

ОНСТанхимуудын тайланд бичигдсэн дүн мэдээ буруу ташаа бичигдсэн, цахим бүртгэлийн тоон дүн, бодит байдалтай нийцэхгүй байсан.

Тухайлбал: Баянхонгор аймгийн музей үзмэрийн тоо ширхгээс 218 хассан боловч энэ тухайгаа тайланд тодорхой тайлбарлаагүй, актлагдсан үзмэр хэмээн бүрхэг тусгажээ. Гэтэл актлагдсан үзмэрийн тоо баримт нь актлах тухай шийдвэрт тусгагдсан тоо баримттайгаа зөрж байна.

Булган аймгийн Дашинчилэн сумын ОНСТ үзмэрийн иж бүрдлийн тоо ширхгийг үндсэн тоо ширхэг болгон задалж тоолж бичсэн боловч тайланд: “*Нийт дэсийн 1 ширхэг үзмэр эд өлгийн зүйл бүрэн тоологдов*” гэж бичсэн байна. Гэтэл цахим бүртгэлд нийт 16 дэсэд 304 ширхэг нэмэгдэж, 341 ширхэг программд орсон байна. Үүнээс 18 дэсийн 101 ширхэг үзмэр тоолсон байна. 19 дэсийн 240 ширхэг үзмэрт “Тоолов” дараагүй. /Бусад шалтгаанаар тоологдоогүйд оруулсан./ гэх мэт тайланг бичихдээ хариуцлагагүй, хайхрамжгүй хандсан байна.

- Тайланд тоологдсон дурсгалт зүйлсийн тоон дүн мэдээг 2 өөр бичсэн,
- дутсан, солигдсон зэрэг үзмэр, дурсгалт зүйлийн дүн мэдээг тайланд зөрүүтэй бичсэнээ тайлбарлаж чадахгүй,

- хассан, актлагдсан гэх боловч эрх бүхий байгууллагуудын шийдвэр баримт актлагдсан үзмэртэйгээ зөрсөн, эсвэл шийдвэр баримт байхгүй, тайланд хавсаргаагүй,

- тооллогын журмын заалтуудыг зөрчсөн, Тухайлбал Дорноговь аймгийн музей 2 дэсийн 2 үзмэрийг дур мэдэн акталсан, Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 12 сарын 04-ний 59-р тогтоолоор Хатгал тосгоны Соёлын төвийн 31 нэрийн 37 ширхэг үзмэр, эд өлгийн зүйлийг акталж, устгасан нь Тооллогын журмын 5.14.1-ийг тус тус зөрчсөн, энэ тухай мэргэжлийн хяналтын байцаагчийн дүгнэлтэд тусгагдаагүй байна.

- Булган аймгийн музейн Салбар комисс эрх мэдлээ хэтрүүлэн 14 дэсийн 14 ширхэг дурсгалт зүйлийн нэрийг дур мэдэн өөрчилсөн зэрэг алдаа, дутагдлууд гарсан байна.

Салбар комисс, музейн захирлуудын удирдлага зохион байгуулалт, хяналт сулаас дурсгалт зүйлийн тоон дүн мэдээг нэгтгээгүй, задгай, зөрүү ташаа тоо баримт гаргасан явдлууд их байгаа нь аймаг, сумын Салбар комиссуудын тайлангийн бичвэрийн байдлаас харагдаж байна.

Музей, сумдын ОНСТ хариуцсан ажилтнуудын мэдлэг, бичиг үсгийн боловсрол чадавхыг дээшлүүлэх, соёлын өвийн холбогдох хууль эрх зүйн баримт бичгүүдийг бүрэн судлах, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлэхэд музейн захиргаа, удирдлага хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.

#### IV. ДҮН ШИНЖИЛГЭЭ, ҮР ДҮН, ДҮГНЭЛТ, ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТ

##### ДҮН ШИНЖИЛГЭЭ

Дүн шинжилгээний зорилго: Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 26.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Журам батлах тухай” 184 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/648 тоот тушаалын дагуу түүх, соёлын хөдлөх дурсгалт

зүйлийн тооллогын үед цуглагдсан мэдээ баримт, “Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн 2018-2019 оны улсын тооллогын нэгдсэн тайлан”-нд үндэслэн дүн шинжилгээ хийж, гарсан үр дүнд цаашид тооллогын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөлт хийхэд шаардлагатай мэдээллийг олж илрүүлэх, тооллогод хамрагдсан музей, байгууллагуудыг төрийн өмчийн музей, бусад байгууллага (16), Их дээд сургууль (3) Орон нутгийн өмчийн музей (24), Шашны өмчит (3) гэсэн өмчийн хэлбэрээр ангилан, Сумдын Орон нутаг сурталчлах 262 танхимын үзүүлэлтийг харьяалах аймгаар нь дундажлан үзүүлэлт тус бүрээр дүгнэхэд оршино.

Зорилт:

- Тооллогын үеэр хийгдсэн ажил, үйл ажиллагаатай танилцах,
- Тооллогын нэгдсэн дүн мэдээ, тайлантай танилцах,
- Тооллогын явцад болон тооллогын нэгдсэн тайланд дурдагдсан тооллого явуулахад хүндрэл бэрхшээлтэй хүчин зүйлсийг (ажил, үйл ажиллагаа) олж илрүүлэх,
- Тооллогын мөрөөр цаашид авах арга хэмжээг төлөвлөх,
- Үзүүлэлт тус бүрээр тооллогод хамрагдсан музей, байгууллагыг дүгнэх.

Шалгуур:

1. Бэлтгэл ажил хангагдсан байдал,
2. Тооллого төлөвлөсөн цаг хугацаанд багтаж хэрэгжсэн байдал,
3. Салбар комиссын дарга, музейн захирал, албан тушаалтны чадавх, манлайлал, эрх үүрэг, оролцоо,
4. Бүртгэл, тооллогын үнэн зөв хөтлөлт, бүртгэл бүрдүүлэлтийн байдал
5. Музейн ажилтан, албан хаагчдын чадавх,
6. Тайлан бичилтийн байдал,
7. Мэргэжлийн хяналтын байгууллагын хяналт тавих, дүгнэх чадавх.

Үзүүлэлт:

Дээр дурдсан шалгуур бүрийг Маш хангалттай /Маш хангалттай нь 21-28 хүртэл онооны шалгуур бөгөөд 24-28 оноо авсан бол Маш хангалттай, 21-23 оноо авсан бол Хангалттай дунд хэмээн 2 хувааж дүгнэнэ./, Хангалттай 20-15 оноо, Хангалтгүй 14-7 оноо, Маш хангалтгүй 6-1 оноо гэсэн үзүүлэлтээр дүгнэлээ.

### Төрийн өмчийн -16 музей, байгууллага

Хүснэгт №18

№	Төрийн өмчит байгууллага	Шалгуур үзүүлэлт Маш хангалттай-4, Хангалттай-3, Хангалтгүй-2, Маш хангалтгүй-1						Нийт оноо	Үзүүлэлт
		Бэлтгэл ажил хангасан байдал	Тооллого төлөвлөсөн хугацаанд багтаж хэрэгжсэн байдал	Салбар комиссын дарга, музейн захирал албан тушаалтны чадавх, манлайлал, эрх үүрэг,	Бүртгэл, тооллогын үнэн зөв хөтлөлт, бүртгэл бүрдүүлэлтийн байдал	Музейн ажилтан, албан хаагчдын чадавх	Тайлан бичилтийн байдал		

1	Чойжин ламын сүм музей	4	4	4	4	4	4	3	27	Маш хангалттай
2	Монголын үндэсний музей	4	4	4	4	4	4	3	27	Маш хангалттай
3	ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн	4	4	4	4	4	4	3	27	Маш хангалттай
4	Монголын Үндэсний номын сангийн үнэт ховор номын фонд	4	4	4	3	4	4	3	26	Хангалттай дунд
5	Хархорум музей	4	4	4	4	4	3	3	26	Хангалттай дунд
6	Монголын Театрын музей	4	4	3	4	4	4	3	26	Хангалттай дунд
7	Эрдэнэсийн сан	4	4	4	4	3	4	3	26	Хангалттай дунд
8	Дүрслэх урлагийн музей	4	4	4	3	4	3	3	25	Хангалттай дунд
9	Монголын Уран зургийн галерей	4	4	4	3	3	3	3	24	Хангалттай дунд
10	Үлэг гүрвэлийн төв музей	4	4	4	3	3	3	3	24	Хангалттай дунд
11	ШУА-ийн Палеонтологи, геологийн хүрээлэн	4	4	4	3	3	3	3	24	Хангалттай дунд
12	Байгалийн түүхийн музей	4	4	3	3	3	3	3	23	Хангалттай дунд
13	Хөшөө цайдам музей	4	3	3	3	3	3	3	22	Хангалттай дунд
14	Төрийн түүхийн музей	4	3	3	3	3	3	3	22	Хангалттай дунд
15	Монгол цэргийн музей	4	3	2	3	3	2	3	20	Хангалттай
16	Богд хааны ордон музей	4	4	2	3	2	1	3	19	Хангалттай
	Оноо	64	61	56	53	51	48	48		

Төрийн өмчийн байгууллагуудаас Маш хангалттай үзүүлэлттэй 3, Хангалттай дунд 11, Хангалттай үзүүлэлтээр 2 байгууллага байна. Шалгуур үзүүлэлтээс үзэхэд:

- Бэлтгэл ажил хангасан байдал - 64 оноо,
- Тооллого төлөвлөсөн хугацаанд багтаж хэрэгжсэн байдал – 61 оноо,
- Салбар комиссын дарга, музейн захирал албан тушаалтны чадавх, манлайлал, эрх үүрэг, оролцоо - 56 оноо,
- Бүртгэл, тооллогын үнэн зөв хөтлөлт, бүртгэл бүрдүүлэлтийн байдал – 53 оноо,
- Музейн ажилтан, албан хаагчдын чадавх - 51 оноо,
- Тайлан бичилтийн байдал -48 оноо,
- Мэргэжлийн хяналтын байгууллагын хяналт тавих, дүгнэх чадавх- 48 оноотой байна.

Төрийн өмчийн их, дээд сургууль-3

Хүснэгт №19

№	Их, дээд сургууль	Шалгуур үзүүлэлт Маш хангалттай-4, Хангалттай-3, Хангалтгүй-2, Маш хангалтгүй-1							Нийт оноо	Үзүүлэлт
		Бэлтгэл ажил хангасан байдал	Тооллого төлөвлөсөн хугацаанд багтаж хэрэгжсэн байдал	Салбар комиссын дарга, музейн захирал албан тушаалтны чадавх, манлайлал, эрх үүрэг, оролцоо	Бүртгэл, тооллогын үнэн зөв хөтлөлт, бүртгэл бүрдүүлэлтийн байдал	Музейн ажилтан, албан хаагчдын чадавх	Тайлан бичилтийн байдал	Мэргэжлийн хяналтын байгууллагын хяналт тавих, дүгнэх чадавх		
1	МУИС-ийн Нийгмийн шинжлэх ухааны сургууль	3	4	3	3	2	3	3	21	Хангалттай дунд
2	ШУТИС-ийн Бизнесийн удирдлага хүмүүнлэгийн сургууль	3	4	3	3	2	3	3	21	Хангалттай дунд
3	Улаанбаатар их сургууль	3	4	3	3	2	3	3	21	Хангалттай дунд
	Оноо	9	12	9	9	6	9	9		

Төрийн өмчийн 3 их, дээд сургууль Хангалттай дунд үзүүлэлтээр дүгнэгдсэн. Шалгуур үзүүлэлтээс үзэхэд:

- Тооллого төлөвлөсөн хугацаанд багтаж хэрэгжсэн байдал – 12 оноо,
- Бэлтгэл ажил хангасан байдал- 9 оноо
- Салбар комиссын дарга, музейн захирал албан тушаалтны чадавх, манлайлал, эрх үүрэг, оролцоо- 9 оноо,
- Бүртгэл, тооллогын үнэн зөв хөтлөлт, бүртгэл бүрдүүлэлтийн байдал -9 оноо
- Тайлан бичилтийн байдал - 9 оноо
- Мэргэжлийн хяналтын байгууллагын хяналт тавих, дүгнэх чадавх- 9 оноо
- Музейн ажилтан, албан хаагчдын чадавх -6 оноотой байна.
- Орон нутгийн өмчийн -24 байгууллага

№	Аймаг, орон нутаг, нийслэлийн музей	Шалгуур үзүүлэлтийн оноо: Маш хангалттай-4, Хангалттай-3, Хангалтгүй-2, Маш хангалтгүй-1							Нийт оноо	Үзүүлэлт
		Бэлтгэл ажил хангасан байдал	Тооллого төлөвлөсөн цаг хугацаанд хэрэгжсэн байдал	Салбар комиссын дарга, музейн захирал, албан тушаалтны чадавх, манлайлал, эрх үүрэг, оролцоо	Бүртгэл тооллогын үнэн зөв хөтлөлт, бүртгэл бүрдүүлэлтийн	Музейн ажилтан, албан хаагчдын чадавх	Тайлан бичиглтийн байдал	Мэргэжлийн хяналтын байгууллагын хяналт тавих, дүгнэх		
1	Ховд аймгийн музей	4	4	3	3	4	3	3	24	Маш Хангалттай
2	Дархан-Уул аймгийн музей	4	4	3	3	3	3	4	24	Маш Хангалттай
3	Өвөрхангай. ЭрдэнэЗуу музей	4	4	3	3	3	4	3	24	Маш Хангалттай
4	Дорнод аймгийн музей	3	4	3	3	3	3	4	22	Хангалттай- дунд
5	Баян-Өлгий аймгийн музей	3	3	3	3	3	3	3	21	Хангалттай- дунд
6	Архангай аймгийн музей	3	3	3	3	3	3	3	21	Хангалттай- дунд
7	Улаанбаатар хотын музей	4	2	3	3	3	3	3	21	Хангалттай дунд
8	Увс аймгийн музей	3	3	2	3	3	3	3	20	Хангалттай
9	Дорнод. Ялалт музей	3	3	2	3	2	3	4	20	Хангалттай
10	Орхон аймгийн музей	3	3	2	3	3	3	3	20	Хангалттай
11	Төв аймгийн музей	3	3	2	3	3	3	2	19	Хангалттай
12	Завхан аймгийн музей	3	3	2	3	3	3	2	19	Хангалттай
13	Өмнөговь аймгийн музей	3	3	2	3	3	3	2	19	Хангалттай
14	Дундговь аймгийн музей	3	3	3	2	2	2	3	18	Хангалттай
15	Сүхбаатар аймгийн түүх, угсаатны зүйн музей	3	3	3	2	2	2	3	18	Хангалттай
16	Говь-Алтай аймгийн музей	2	3	2	2	3	2	3	17	Хангалттай
17	Хэнтий аймгийн музей	3	3	2	2	2	2	3	17	Хангалттай
18	Говьсүмбэр аймгийн музей	3	3	2	2	2	2	3	17	Хангалттай
19	Хөвсгөл аймгийн Орон нутаг судлах музей	3	3	2	2	2	3	2	17	Хангалттай
20	Баянхонгор аймгийн түүх, угсаатны зүйн музей	2	3	2	2	2	2	3	16	Хангалттай
21	Өвөрхангай аймгийн музей	3	2	2	2	2	2	3	16	Хангалттай
22	Булган аймгийн музей	3	3	2	2	2	2	2	16	Хангалттай
23	Сэлэнгэ аймгийн нэгдсэн музей	3	3	2	2	2	2	1	15	Хангалттай
24	Дорноговь аймгийн музей, сургалт сурталчилгааны төв	3	3	1	1	1	2	2	13	Хангалтгүй
	Оноо	71	70	53	60	61	62	66		



Орон нутгийн өмчийн 24 байгууллагаас Маш хангалттай 3, Хангалттай- дунд 4, Хангалттай 16, Хангалтгүй 1 байгууллага байна. Шалгуур үзүүлэлтээс үзэхэд:

- Бэлтгэл ажил хангасан байдал – 71 оноо,
- Тооллого төлөвлөсөн хугацаанд багтаж хэрэгжсэн байдал - 70 оноо,
- Мэргэжлийн хяналтын байгууллагын хяналт тавих, дүгнэх - 66 оноо,
- Бүртгэл, тооллогын үнэн зөв хөтлөлт, бүртгэл бүрдүүлэлтийн байдал - 60 оноо,
- Тайлан бичилтийн байдал - 62 оноо,
- Музейн ажилтан, албан хаагчдын чадавх – 61 оноо,
- Салбар комиссын дарга, музейн захирал албан тушаалтны чадавх, манлайлал, эрх үүрэг, оролцоо - 53 оноотой байна.

### Орон нутгийн өмчийн сумдын ОНСТ-261

### Хүснэгт №21

№	Аймаг, орон нутаг, нийслэлийн музей	Шалгуур үзүүлэлтийн оноо: Маш хангалттай-4, Хангалттай-3, Хангалтгүй-2, Маш хангалтгүй-1							Нийт оноо	Үзүүлэлт
		Бэлтгэл ажил хангасан байдал	Тооллого төлөвлөсөн цаг хугацаанд хэрэгжсэн байдал	Салбар комиссын дарга, музейн захирал, албан тушаалтны чадавх, манлайлал, эрх үүрэг, оролцоо	Бүртгэл тооллогын үнэн зөв хөтлөлт, бүртгэл бүрдүүлэлтийн байдал	Музейн ажилтан, албан хаагчдын чадавх	Тайлан бичилтийн байдал	Мэргэжлийн хяналтын байгууллагын хяналт тавих.		
1	Дархан-Уул аймаг- 1 сум	3	3	3	3	3		4	22	Хангалттай дунд
2	Дундговь аймаг- 10 сум	3	3	3	3	3		3	21	Хангалттай дунд
3	Өмнөговь аймаг- 13 сум	3	3	3	3	3		3	21	Хангалттай дунд
4	Сүхбаатар аймаг- 3 сум	3	3	3	3	3		3	21	Хангалттай дунд
5	Төв аймаг- 28 сум	3	3	3	3	3		2	20	Хангалттай
6	Нийслэлийн дүүрэг -2	3	3	2	3	3		3	20	Хангалттай
7	Завхан аймаг- 21 сум	3	3	3	3	2		2	19	Хангалттай
8	Баян-Өлгий аймаг- 9 сум	3	3	2	2	2		3	18	Хангалттай
9	Архангай аймаг- 11 сум	3	4	2	2	2		2	18	Хангалттай
10	Дорнод аймаг- 6 сум	2	3	2	2	2		4	18	Хангалттай
11	Ховд аймаг- 13 сум	2	3	3	2	2		3	17	Хангалттай
12	Хэнтий аймаг- 12 сум	3	3	2	2	2		3	17	Хангалттай
13	Говь-Алтай аймаг- 18 сум	2	3	2	3	2		3	17	Хангалттай
14	Говьсүмбэр аймаг- 1 сум	3	3	2	2	2		3	17	Хангалттай
15	Увс аймаг- 17 сум	3	3	2	2	2		2	17	Хангалттай
16	Баянхонгор аймаг- 18 сум	2	3	2	2	2		3	16	Хангалттай
17	Дорноговь аймаг- 12 сум	3	3	2	2	2		2	16	Хангалттай
18	Хөвсгөл аймаг- 15 сум	3	3	1	2	2		2	16	Хангалттай
19	Өвөрхангай аймаг-17 сум	3	2	2	2	2		3	16	Хангалттай
20	Булган аймаг -16 сум	3	3	2	2	2		1	15	Хангалттай
21	Сэлэнгэ аймаг-18 сум	3	3	2	2	2		1	15	Хангалттай

22	Орхон аймаг сум ОНСТ байхгүй									
	Оноо	59	63	48	50	48		55		

Аймаг, нийслэлийн сум, дүүргийн ОНСТанхимын байгууллагаас Хангалттай дунд үзүүлэлттэй 4, хангалттай 18 аймаг байна. Шалгуур үзүүлэлтээс үзэхэд:

- Тооллого төлөвлөсөн хугацаанд багтаж хэрэгжсэн байдал - 63 оноо,
- Бэлтгэл ажил хангасан байдал - 59 оноо,
- Мэргэжлийн хяналтын байгууллагын хяналт тавих, дүгнэх - 55 оноо,
- Бүртгэл, тооллогын үнэн зөв хөтлөлт, бүртгэл бүрдүүлэлтийн байдал -50 оноо,
- Салбар комиссын дарга, музейн захирал албан тушаалтны чадавх, манлайлал, эрх үүрэг, оролцоо - 48 оноо,
- Музейн ажилтан, албан хаагчдын чадавх - 48 оноотой байна.
- Сумдын ОНСТ-ын улсын тооллогын тайланг аймгийн музейн тайланд нэгдсэн байдлаар орсон сумдын ОНСТ-ын “Тайлан бичилтийн байдал”-ыг дүгнээгүй болно.

### Шашны өмчийн-3 сүм хийд

Хүснэгт №22

№	Сүм хийд /шашны өмчит-3 хийд/	Шалгуур үзүүлэлт Маш хангалттай-4, Хангалттай-3, Хангалтгүй-2, Маш хангалтгүй-1							Нийт оноо	Үзүүлэлт
		Бэлтгэл ажил хангасан байдал	Тооллого төлөвлөсөн хугацаанд багтаж хэрэгжсэн байдал	Салбар комиссын дарга, музейн захирал албан тушаалтны чадавх, манлайлал, эрх үүрэг, оролцоо	Бүртгэл, тооллогын үнэн зөв хөтлөлт, бүртгэл бүрдүүлэлтийн байдал	Музейн ажилтан, албан хаагчдын чадавх	Тайлан бичилтийн байдал	Мэргэжлийн хяналтын байгууллагын хяналт тавих, дүгнэх чадавх		
1	Ховд. Ганданпунцаглин хийд	3	3	2	2	1	2	3	16	Хангалттай
2	Өвөрхангай Төвхөн хийд	3	3	1	2	1	2	3	15	Хангалттай
3	Өвөрхангай. Шанхын Баруун хүрээ хийд	3	3	1	2	1	1	2	13	Хангалтгүй
	Оноо	9	9	4	6	3	5	8		

Шашны өмчит 3 сүм хийдээс Хангалттай 2, Хангалтгүй үзүүлэлтээр дүгнэгдсэн 1 байна.

Шалгуур үзүүлэлтээс үзэхэд:

- Бэлтгэл ажил хангасан байдал- 9 оноо,
- Тооллого төлөвлөсөн хугацаанд багтаж хэрэгжсэн байдал- 9 оноо,
- Мэргэжлийн хяналтын байгууллагын хяналт тавих, дүгнэх- 8 оноо,
- Бүртгэл, тооллогын үнэн зөв хөтлөлт, бүртгэл бүрдүүлэлтийн байдал-6 оноо,
- Тайлан бичилтийн байдал- 5 оноо,

- Салбар комиссын дарга, музейн захирал албан тушаалтны чадавх, манлайлал, эрх үүрэг, оролцоо- 4 оноо,
- Музейн ажилтан, албан хаагчдын чадавх- 3 оноотой байна.

### Шалгуур үзүүлэлтийн нэгдсэн дүн

Хүснэгт №23

№	Улсын тооллогод хамрагдсан нийт 307 байгууллага	Шалгуур үзүүлэлт Маш хангалттай-4, Хангалттай-3, Хангалтгүй-2, Маш хангалтгүй-1							Нийт оноо	Үзүүлэлт
		Бэлтгэл ажил хангасан байдал	Тооллого төлөвлөсөн хугацаанд багтаж хэрэгжсэн байдал	Салбар комиссын дарга, музейн захирал албан тушаалтны чадавх, манлайлал, эрх үүрэг	Бүртгэл, тооллогын үнэн зөв хөтлөлт, бүртгэл бүрдүүлэлтийн байдал	Музейн ажилтан, албан хаагчдын чадавх	Тайлан бичилтийн байдал	Мэргэжлийн хяналтын байгууллагын хяналт тавих, дүгнэх чадавх		
1	Төрийн өмчийн 16 байгууллага	64	61	56	53	51	48	48		
2	Төрийн өмчийн 3 их, дээд сургууль	9	12	9	9	6	9	9		
3	Орон нутгийн өмчийн 25 байгууллага	71	70	53	60	61	62	66		
4	Орон нутгийн өмчийн 261 сумдын ОНСТ	59	63	48	50	48	-	55		
5	Шашны өмчит 3 сүм хийд	9	9	4	6	3	5	8		
	Нийт оноо	212	215	170	178	169	124	186		

Нийт улс, орон нутгийн музей, байгууллага, сумдын ОНСТ, сүм хийд зэрэг нийт байгууллага (307)-ын шалгуур үзүүлэлтээс үзэхэд:

- Тооллого төлөвлөсөн хугацаанд багтаж хэрэгжсэн байдал – 215 оноо,
- Бэлтгэл ажил хангасан байдал – 212 оноо,
- Мэргэжлийн хяналтын байгууллагын хяналт тавих, дүгнэх – 186 оноо,
- Бүртгэл, тооллогын үнэн зөв хөтлөлт, бүртгэл бүрдүүлэлтийн байдал-178 оноо,
- Салбар комиссын дарга, музейн захирал албан тушаалтны чадавх, манлайлал, эрх үүрэг, оролцоо – 170 оноо,
- Музейн ажилтан, албан хаагчдын чадавх – 169 оноо
- Тайлан бичилтийн байдал – 124 оноотой байна.

Тооллогын нэгдсэн дүн, шалгуур үзүүлэлтээр гарсан дүн шинжилгээнд үндэслэн гарч буй асуудлуудаар цаашид авах арга хэмжээний хүрээнд:

1. Салбар комиссуудын тайлан бичилт хангалтгүй, нийт тоологдсон дурсгалт зүйлийн тоон дүнг нэгтгээгүй задгай бичилттэй, дутсан, алдагдсан үзмэрийн дэс, тоо ширхгийг хасаж нэгтгээгүй, төрөл зүйлийн үзүүлэлтийн тоон дүн гаргаагүй зэрэг нийтлэг алдаа дутагдал байна. Тооллогын дэвтрийн баталгаажилтад гарын үсэг зурагдаагүй, тооллогын бүртгэлийн дэвтэр, цахим

- регистр бүртгэл, тайлан тус бүрийн тоон дүн зөрүүтэй, тайлан бичилтээ нягтлан шалгаагүй, бичвэр найруулга сул тайлан ирүүлсэн байна.
2. Аймаг, орон нутгийн музей, сумдын ОНСТ-ын ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулах, мэдлэг чадварыг дээшлүүлэх, чадавхжуулах арга хэмжээг байнга тогтмол авах.

Угсаатны зүй, шашин, байгалийн холбогдолтой үзмэрийн нэр, нэршил зэргийг үнэн зөв нэрлэж, тогтоох ажилд судалгаа шинжилгээ хийх, мэргэжлийн байгууллага, иргэнийг татан оролцуулж хамтран хийх.
  3. Улсын комисст бүртгэлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудалд хайнга хандсан, бүртгэл, тооллогын ажилд удирдлага, манлайлал хангалтгүй, дутсан, солигдсон дурсгалт зүйлийн талаар дүрэм журмын дагуу арга хэмжээ хангалтгүй авсан зэрэг нь Салбар комиссын дарга, музейн удирдлага музейн үзмэрийн бүртгэл хөтлөлт, бүрдүүлэлтэд удирдлагаар хангах, хяналт тавих тал дээр сул байгааг цаашид анхаарах.

Аймаг, орон нутгийн Салбар комисс ялангуяа сумдын ОНСТ-ыг тооллогын удирдлага, арга зүйгээр хангах, холбогдох хууль, дүрэм, журмын хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах.
  4. Музейн сан хөмрөгт шинээр авсан үзмэрүүдээ ерөнхий бүртгэлд зохих журамд заасан хугацаанд бүртгэгдэггүй, соёлын өвд хамаарахгүй үзмэр, эд өлгийн зүйл бүртгэгдсэн, үзмэр давхардуулж бүртгэгдсэн, өмнөх улсын тооллогоор эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу хасаж устгасан үзмэрийн бүртгэлийг цэгцлээгүй зэрэг бүртгэл бүрдүүлэлттэй холбоотой асуудлыг цаашид зохих журмын дагуу хэрэгжүүлж байх.

Дараагийн тооллогоос өмнө тооллогын дэвтэрт бичигдсэн дурсгалт зүйлийн нэр, тодорхойлолтын байдлыг хянан, нэмэлт, өөрчлөлт орох тохиолдолд эрдэм шинжилгээний байгууллага, ажилтны судалгаа, баримт үндэслэн хийж байх.
  5. 21 аймгийн мэргэжлийн хяналтын байцаагчид дүгнэлтээ бүрэн гаргасан байна. Тооллогын тайлан, дүн нэгтгэлд дүгнэлт гаргахдаа тооллого холбогдох хууль, тооллогын журам зөрчсөн, тооллогын хугацаанд үзмэр акталсан зэрэг байдлаас журмын дагуу явагдсан эсэхэд хяналт тавиагүй, тооллогод хамрагдсан дурсгалт зүйлийн тоо болон дутсан, солигдсон, хулгайд алдагдсан, зэрэг тоон дүнг нягтлан шалгахад анхаарах, цаашид хууль, хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэхэд хяналт тавих.
  6. Салбар комиссууд удирдлага, зохион байгуулалт, нөөц бололцоогоо дайчлан ажиллаж, түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн 2018-2019 оны улсын тооллогыг заасан хугацаанд явагдаж дууссан. Улсын тооллогыг дулааны улиралд явуулж байх, үзмэрийн тооноос хамаарч тооллогын хугацааг тогтоож байх зэрэг саналууд Салбар комиссуудаас ирснийг цаашид анхаарах.
  7. Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн 2018-2019 оны улсын тооллогын бэлтгэл улсын хэмжээнд сайн хангагдсан хэдий ч музей, байгууллагын удирдлагын зүгээс бүртгэл тооллогыг удирдлагаар хангах, хяналт тавих, ажилтнуудын ажлын ур чадавх, тайлан бичилт зэрэгт анхаарах асуудлууд байгааг дүн шинжилгээний үзүүлэлт харуулж байна.

## ҮР ДҮН

- Энэ удаагийн тооллогоор удирдлага, арга зүй, үйл ажиллагааны шинэ дэвшлүүдийг нэвтрүүлээ. Тооллогын үйл ажиллагааг хурдасгах, аргачлалыг сайжруулах зорилгоор анх удаа тооллогыг Цахим бүртгэлд үндэслэн зохион байгууллаа. Цахим мэдээллийн нэгдсэн санг төгөлдөржүүлснээр үндэсний соёлын өвийн мэдээллийг дамжуулах, солилцох, олон нийтийн хүртээл болгох, мэдээллийн ач холбогдол хүртээмжийг нэмэгдүүлэх боломж нөхцөлийг бүрдүүлж, түүх соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл, тодорхойлолт, гэрэл зураг, дүрс бүхий Цахим бүтцийг үүсгэж, тогтвортой хөгжлийн соёлын өвийн тоон дүнг тооцон гаргаж, улс, бүс нутгийн хөгжлийн чиг хандлага, аялал жуулчлалын нөөцийг тодорхойлох боломжийг бүрдүүлэхэд зохих хувь нэмэр оруулсан.
- Тооллогын дүнд соёлын өвийн чиглэлээр 4 жилд гарсан өөрчлөлт, түүний шалтгаан нөхцөлийг судалсан, салбарын хөгжлийг төлөвлөх, хэрэгжүүлэх, төрийн бодлогын баримт бичиг боловсруулах болон эрдэм шинжилгээ судалгаанд хэрэгцээтэй тулгуур мэдээллийг баяжуулав.
- Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хуримтлагдсан хөдлөх дурсгалт зүйлийн талаарх мэдээллийг Үндэсний онцлог бүхий соёлын инноваци, бүтээлч үйлдвэрлэл (дижитал технологид суурилсан контент соёлын үйлчилгээ, ухаалаг технологид суурилсан төрийн болон бизнесийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хөгжүүлэлт)-ийг хөгжүүлэхэд ашиглах боломж бүрдээд байна.

## ДҮГНЭЛТ

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн соёлын өвийн үзлэг, тооллогын тухай 26.1 дүгээр заалт, Засгийн газрын 2018 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 184 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийх журам”, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн А/648 дугаартай “Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийх тухай” тушаалд тус тус заасны дагуу 21 аймаг, нийслэлийн хэмжээнд 2018 оны 11 дүгээр сарын 1-ээс 2019 оны 3 дугаар сарын 31-нийг хүртэлх хугацаанд зохион байгуулагдсан түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн улсын тооллогын ажлын дүн мэдээг нэгтгэж ДҮГНЭХ НЬ:

Засгийн газрын 2018 оны 184 дүгээр тогтоолоор батлагдсан “Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийх журам”-ын Тооллогын ажлыг зохион байгуулах тухай 5 дугаар зүйл, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн А/648 дугаартай “Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийх тухай” тушаалын хоёрдугаар хавсралт Тооллогын ажлын удирдамжийг бүрэн хангаж ажилласан.

Улсын комисс Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн 2018-2019 оны улсын тооллого тогтоосон цаг хугацаанд чанартай, үр дүнтэй зохион байгуулагдлаа гэж дүгнэж байна.

Улсын тооллогод төрийн өмчийн-19, орон нутгийн өмчийн-285, шашны өмчийн-3, нийт 307 байгууллага, аж ахуйн нэгж хамрагдлаа.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/648 дугаартай “Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийх тухай” тушаалын Удирдамжийн хавсралт “Тооллогод хамрагдах байгууллага”-ын жагсаалтад орсон шашны өмчит байгууллагаас МБШТөв Гандантэгчэнлин хийд, Хувийн музей-1 (Данзанравжаагийн музей), ОНСТанхимгүй шалтгаанаар 2 сум (Өвөрхангай аймгийн Өлзийт сум, Сүхбаатар аймгийн Онгон сум) улсын тооллогод тус тус оролцоогүй.

“Тооллогод хамрагдах байгууллага”-ын жагсаалтад ороогүй 2 сумын ОНСТанхим (Булган аймгийн Тэшиг сумын ОНСТ, Дорнод аймгийн Дашбалбар сумын ОНСТ) улсын тооллогод нэмж хамрагдсан байна.

Тооллогын ажлын бэлтгэлийг хангаж, цахим бүртгэлийн сайжруулсан, бүртгэлийн дэвтэр хэвлүүлэн баталгаажуулж тараасан, бүсчилсэн сургалт зохион байгуулсан, тооллогын явцыг ил тод мэдээлэх веб сайтыг ажиллуулсан зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн нь улсын тооллогыг богино хугацаанд үр дүнтэй зохион байгуулахад чухал түлхэц болсон.

Энэ удаагийн улсын тооллогоор гар бичмэл үйлдээгүй цахим бүртгэлийн хангамжид тулгуурлан хийгдлээ. Өмнөх 2012-2013 оны улсын тооллогоор Ерөнхий бүртгэлийг цахимд шилжүүлэх ажил анх удаа хийгдсэн ба шилжүүлэхдээ үг, үсгийн алдаатай шивсэн мэдээллийг холбогдох бусад баримтуудтай тулган нягтлах замаар засаж залруулан цахим бүртгэлийг сайжрууллаа.

Өнгөрсөн тооллогоос эхлэлтэй түүх, соёлын хөдлөх тооллогыг тоолох нэгдсэн арга аргачлалтай, бүртгэлийн цахимжсан программ ашиглах болсон, түүнийгээ улам сайжруулсан зэрэг ахицтай олон ажлууд хийгдсэн нь ихэнх байгууллагуудад явуулсан тооллогын ажил явуулахад дэвшилттэй байсан боловч энэ нь жигд биш байв.

Өмнөх 2012-2013 оны улсын тооллогын комиссоос гаргасан дүгнэлт, дутагдлыг засаж, залруулах, хууль хяналтын байгууллагаар шийдүүлэх талаар улс, аймаг музейнүүд, ОНСТанхим дорвитой ажил хийгээгүй дараагийн тооллогод хамрагдсан байна.

Тоологдсон хөдлөх дурсгалт зүйлийн нэгдсэн дүн мэдээ, үүнээс дутсан, солигдсон, хулгайд алдсан түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн талаарх тоо баримтыг бүрэн гаргасан.

Тооллогын дүн мэдээнээс үзэхэд ялангуяа сумдын ОНСТанхимын хадгалалт хамгаалалт, хараа хяналт сулаас дурсгалт зүйлс ихээр үрэгдэж, дутсан бөгөөд энэ талаар зохих хуулийн дагуу арга хэмжээ авч хэрэгжүүлдэггүй, зарим газар дутаасан зүйлсээ хасах актлах үзмэрийн саналд оруулан тайланд тусгасан зэрэг зохисгүй явдлууд гарсан байна. Иймээс:

Дутсан, солигдсон, хулгайд алдсан хөдлөх дурсгалт зүйлсийг эрэн сурвалжлах, илрүүлэх ажлыг нэн даруй эхлүүлэх, гэм буруутай этгээдэд хариуцлага тооцох, холбогдох хууль хяналтын байгууллагатай хамтран ажиллах;

Сумдын ОНСТанхимд дутсан, солигдсон, хулгайд алдсан зэрэг хууль бус асуудал их гарч байгааг анхаарч, ОНСТанхимуудын хадгалалт хамгаалалтын нөхцөл, тэнд ажиллагсдын ажлын хариуцлага, сахилга батыг дээшлүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

Улсын тооллогоор нийт “дутсан” дурсгалт зүйлийн тоонд орсон тухайн музейн сан хөмрөгт өөрийн сайн дураар өгч хандивласан эд өлгийн зүйлсээ өгсөн эзэн нь эгүүлэн авсны улмаас дутсан Улсын 1 музей, 9 аймгийн 17 сумын ОНСТанхимд нийтдээ 30 дэсийн 38 ширхэг (Хүснэгт №10 дахь) дурсгалт зүйлийн өмчлөл, эзэмшлийн асуудлыг шийдвэрлэх;

Сумын Соёлын төвд соёлын өв хариуцсан ажилтны орон тоо, цалингийн санг төсөвт суулгах, ОНСТанхим хариуцсан орон тооны ажилтантай болгох;

ОНСТанхимын ажилтнуудыг соёлын өвийн бүртгэн баримтжуулалтын чиглэлээр мэргэшүүлэн сургах, бэлтгэх;

Музейн ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулах, мэргэжил, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх;

Бүх шатны музейнүүдэд түүх, соёлын хөдлөх дурсгалууд дээр нарийн судалгаа шинжилгээ, кураторын ажил хийгддэггүй, музейнүүд нарийн мэргэжлийн хүний нөөцөөр хангагдаагүй зэргээс үүдэлтэй олон тооны олдвор цуглуулга, үзмэр эд өлгийн зүйлсийн нэр буруу өгөгдсөн, түүх, соёлын дурсгалд хамруулах үндэслэлгүй зүйлсийг хамруулсан, судалгааны шатандаа явж байгаа, таньж тодорхойлж баталгаажаагүй цуглуулгыг түүх, соёлын хөдлөх дурсгалд бүртгүүлсэн зэрэг нийтлэг дутагдал байсаар байгаа нь тооллогын ажлыг хүндрүүлж байна.

Улсын тооллого хооронд түүх, соёлын дурсгал хадгалагдаж байгаа бүх байгууллагуудад чиглэл, чиглэлийн эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтэн судлаачдаас бүрдсэн баг ажиллуулж, мэргэжил арга зүйгээр хангаж, анхдагч мэдээллийг сайжруулах, эрчимжүүлэх ажлыг хойшлуулалгүй зохион байгуулах шаардлагатай байна.

Засгийн газрын 2013 оны 227 дугаар тогтоолоор “Монгол Улсын түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалт”-ын 769, 770, 771 дүгээрт тус тус бүртгэгдсэн Дорноговь аймгийн музейн сан хөмрөгт дэх XIII зууны үеийн Илгэн дээл (эмэгтэй), Даавуун дээл (эмэгтэй), Торгон дээл (эмэгтэй) зэрэг 3 ширхэг дээл эрсдэлтэй нөхцөл байдалд хадгалагдаж байх тул нэн даруй хадгалалт хамгаалалтын нөхцөлийг сайжруулах арга хэмжээг авах;

Засгийн газрын 2004 оны 108 дугаар тогтоолын хавсралт “Монгол Улсын түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалт”-ын 228 дугаарт Монголын Үндэсний музейд хадгалагдаж байгаагаар бүртгэгдсэн боловч Өвөрхангай аймгийн Шанхын Баруун хүрээ хийдэд хадгалагдаж байгаа “Богд хаант Монгол Улсын үеийн төрийн далбаа”-ны өмчлөгч, эзэмшигчийн асуудлыг шийдвэрлэх, хадгалалт хамгаалалтын нөхцөлийг сайжруулах;

Монголын Уран зургийн галерейн сан хөмрөгт бүртгэлтэй боловч Их тэнгэрийн аманд байрлаж байгаа уран зургуудыг эгүүлэн татах ажлыг зохион байгуулан хэрэгжүүлэх;

Хөдлөх дурсгалт зүйлийн хадгалалт хамгаалалтын нөхцөлийг сайжруулах талаар Салбар комиссуудын ирүүлсэн саналд тусгагдсан мэргэжлийн тоног төхөөрөмжөөр музейг хангах;

Тооллогын мөрөөр цаашид хийгдэх ажлыг Монгол Улсын Засгийн газраас цаг алдалгүй хийж эхлүүлэх нь зүйтэй байна.

**ТҮҮХ, СОЁЛЫН ХӨДЛӨХ ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙН УЛСЫН ТООЛЛОГЫН  
МӨРӨӨР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хийгдэх ажил	Хугацаа	Төсөв	Хариуцах
<b>1</b>	<b>Засгийн Газраас хэрэгжүүлэх арга хэмжээ:</b>			
1.1	Монгол Улсын Түүх, соёлын хосгүй үнэт 778 дурсгалт зүйлс, үзмэрт /биет дээр/ нэг бүрчлэн хөдөлгөөн мэдрэгч, байрлал заагч бүхий тусгайлсан бичил мэдрэгч суурилуулах	2019-2020	Нийт: 407 000 000	Засгийн Газар
1.2	Дорноговь аймгийн музейн сан хөмрөгт дэх хосгүй үнэт XIII зууны үеийн Илгэн дээл (эмэгтэй), Даавуун дээл (эмэгтэй), Торгон дээл (эмэгтэй) зэрэг 3 ширхэг дээлний хадгалалт хамгаалалтын нөхцөлийг сайжруулан Монголын Үндэсний музейд татан байршуулах арга хэмжээг авах.	2019-2020		
1.3	Өвөрхангай аймгийн Шанхын Баруун хүрээ хийдэд хадгалагдаж байгаа хосгүй үнэт “Богд хаант Монгол Улсын үеийн төрийн далбаа”-ны өмчлөгч, эзэмшигчийн асуудлыг шийдвэрлэх, хадгалалт хамгаалалтын нөхцөлийг сайжруулах арга хэмжээг авах.	2020-2021		
1.4	Монголын Уран зургийн галерейн сан хөмрөгт бүртгэлтэй боловч одоо Их тэнгэрийн аманд байрлаж байгаа уран зургуудыг эргүүлэн татах	2020-2021		
1.5	Модон бүтээц бүхий барилгатай музейнүүдэд гал гарах эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг нэн даруй зохион байгуулах, галын аюулын үед ашиглах тоног төхөөрөмж, FM-200 хийн хэрэгслийг музейн орчинд байрлуулах	2020-2021		
1.6	Хасах, актлах болон шилжүүлэх саналтай хөдлөх дурсгалт зүйлийн асуудлыг зохих хуулийн дагуу шийдвэрлэх	2020	-	БСШУСЯ СУГ ТӨБЗГ Орон нутгийн ИТХ МХЕГ Музей
1.7	Дутсан, солигдсон, хулгайд алдсан хөдлөх дурсгалт зүйлийг эрэн сурвалжлах, илрүүлэх, гэм буруутай этгээдэд хариуцлага тооцоход хууль	2020-2021	-	БСШУСЯ СУГ ЦЕГ



	тогтоомжийн хүрээнд арга хэмжээ хэрэгжүүлэх			Аймаг, орон нутгийн Засаг дарга, Музей
2	Салбарын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ:			
2.1	Улс, аймгийн музейг дохиолол, хамгаалалтын нэгдсэн удирдлагын төвтэй болгох	2020-2024		БСШУСЯ
2.2	Нэн яаралтай сэргээн засварлах шаардлагатай дурсгалт зүйлсийн сэргээн засварлахад зарцуулах төсвийг батлуулах, хуваарилах	2020-2024		
2.3	Музей, сумдын ОНСТ-ын ажилтнуудын мэдлэг, чадавхыг дээшлүүлэх урт, богино хугацааны сургалтад хамруулах, арга хэмжээг авч хэрэгжүүлэх	2020-2023		
2.4	- Булган, Сэлэнгэ, Хөвсгөл, Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай, Дорноговь, Говьсүмбэр аймгийн музей болон сумдын ОНСТанхимын бүртгэл бүрдүүлэлтийг сайжруулахад мэргэжлийн судалгааны баг газар дээр нь томилон ажиллуулах	2020-2021		БСШУСЯ, СУГ, СӨҮТ, Эрдэм шинжилгээний хүрээлэн, Монголын Үндэсний музей, Аймгийн БСУГазар, Аймаг, орон нутгийн музей Сумдын ОНСТ
2.5	- Ховд, Баян-Өлгий, Увс, Дархан-Уул, Орхон, Төв, Дорнод, Сүхбаатар аймгийн музей болон сумдын ОНСТанхимын бүртгэл бүрдүүлэлтийг сайжруулахад мэргэжлийн судалгааны баг газар дээр нь томилон ажиллуулах.	2021-2022		
2.6	- ЭрдэнэЗуу, Хархорум, Хөшөө цайдам болон Дундговь, Өмнөговь, Хэнтий, Дорнод, Завхан аймгийн музей, сумдын ОНСТанхимын бүртгэл бүрдүүлэлтийг сайжруулахад мэргэжлийн судалгааны баг газар дээр нь томилон ажиллуулах.	2023-2024		
2.7	Музейг үзмэр, эд өлгийн зүйлийн хадгалалт хамгаалалтын горимыг хангасан дулаан чийглэг, гэрэлтүүлгийн зохистой орчин бүрдсэн шилэн хорго /шил, зузаан тунгалаг, хэт ягаан туяа саармагжуулдаг, дулаан чийглэгийн тохируулагчтай/ тоног төхөөрөмжөөр хангах ажлыг зохион байгуулах	2020-2023		

2.8	Музейн үзмэрийн судалгаа шинжилгээний ажлыг хөхиүлэн дэмжих	-		БСШУСЯ СУГ
3.	Орон нутгийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ:			
3.1	- Аймаг, нийслэлийн музей, сумдын Орон нутаг сурталчлах танхимыг орон тооны ажилтантай болгох,	2020-2023		Аймаг, нийслэлийн Засаг дарга нар
3.2	- Аймаг, нийслэлийн музей, сумдын Орон нутаг сурталчлах танхимыг бүртгэл баримтжуулалт, хадгалалт хамгаалалт, орчны дүн шинжилгээ хийх төхөөрөмжөөр хангах	2020-2023		
4.	Байгууллагын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ:			
4.1	Улсын тооллогоор Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн Ерөнхий бүртгэл (Register цахим)-д санал оруулсан: - давхардсан, алгассан дэсийг залруулах ажлыг гүйцэтгэх	2020-2021	-	СӨҮТ Улс, аймгийн музей
4.2	Улсын тооллогоор Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн Ерөнхий бүртгэл (Register цахим)-д нэмэлт өөрчлөлт хийхээр санал оруулсан: - бие даасан үзмэр болгон салгаж эсвэл нэгтгэж бүртгэх, - 2012 оноос хойш Ерөнхий бүртгэлд бүртгэгдээгүй дурсгалт зүйлийг бүртгэх ажлыг тус, тус зохион байгуулах.	2020-2021	-	Улс, аймгийн Музей Сумын ОНСТ
4.3	Улсын тооллогоор бүртгэлийн бичвэрт нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргасан: -дурсгалын нэр өөрчлөх, -тодорхойлолт бичвэрт нэмэлт, өөрчлөлт оруулахыг судалгаа шинжилгээний үндсэн дээр гүйцэтгэх.	2020-2021	-	Улс, аймгийн Музей

ХАВСРАЛТУУД

Хавсралт №1

ТҮҮХ, СОЁЛЫН ХӨДЛӨХ ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙН 2018-2019 ОНЫ  
УЛСЫН ТООЛЛОГЫН НЭГДСЭН ДҮН

№	Улсын тооллогод хамрагдсан байгууллага- (307)	Тоологдох хөдлөх дурсгалт зүйл		Дутсан		Хулгайд алдсан		Солигдсон		Гадаадад үзэсгэлэнд		Тоологдсон хөдлөх дурсгалт зүйл	
		дэс	тоо/ш	дэс	тоо/ш	дэс	тоо/ш	дэс	тоо/ш	дэс	тоо/ш	дэс	тоо/ш
1	Улсын музей-10, э/ш хүрээлэн-2, номын сан-1, их сургууль-3, сүм хийд-2	59331	132270	9	9			1	1	19	67	59302	132193
2	Аймаг, орон нутаг, нийслэлийн музей-24, байгууллагын музей-3	48205	109622	68	86	2	2	21	23			48114	109511
3	Сум, дүүргийн ОНСТ-261, сүм хийд-1	19728	35127	285	672	41	72	8	10			19394	34373
<b>НИЙТ ДҮН</b>		<b>127264</b>	<b>277019</b>	<b>362</b>	<b>767</b>	<b>43</b>	<b>74</b>	<b>30</b>	<b>34</b>	<b>19</b>	<b>67</b>	<b>126810</b>	<b>276077</b>

ТҮҮХ, СОЁЛЫН ХӨДЛӨХ ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙН  
2018-2019 ОНЫ УЛСЫН ТООЛЛОГЫН ДҮН  
(УЛСЫН МУЗЕЙ, БУСАД БАЙГУУЛЛАГА-18)

№	Байгууллага	Тоологдох хөдлөх дурсгалт зүйл		Гадаадад үзэсгэлэн		Дутсан		Солигдсон		Хулгайд алдсан		Нийт тоологдоогүй		Тоологдсон хөдлөх дурсгалт зүйл	
		дэс	тоош	дэс	тоош	дэс	тоош	дэс	тоош	дэс	тоош	дэс	тоош	дэс	тоош
1	Монголын үндэсний музей	20287	59913	19	67			1	1			<b>20</b>	<b>68</b>	20267	59845
2	Байгалийн түүхийн музей	9950	11997			3	3					<b>3</b>	<b>3</b>	9947	11994
3	Богд хааны ордон музей	4209	8643			2	2					<b>2</b>	<b>2</b>	4207	8641
4	Дүрслэх урлагийн музей	10008	16808											10008	16808
5	Монголын Театрын музей	6587	9516											6587	9516
6	Монголын Уран зургийн галерей	3408	3657											3408	3657
7	Үлэг гүрээлийн төв музей	43	43											43	43
8	Хархорум музей	698	1324			1	1					<b>1</b>	<b>1</b>	697	1323
9	Хөшөө цайдам музей	145	175											145	175
10	Чойжин ламын сүм музей	1002	6385											1002	6385
11	Монголын Үндэсний номын сангийн үнэт ховор номын фонд	516	516											516	516
12	ШУА-ийн Палеонтологи, геологийн хүрээлэн	176	204											176	204
13	ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн	1440	8572											1440	8572

14	МУИС-ийн Нийгмийн шинжлэх ухааны сургууль	25	35											25	35
15	ШУТИС-ийн Бизнесийн удирдлага хүмүүнлэгийн сургууль	52	101											52	101
16	Улаанбаатар их сургууль	52	207											52	207
17	Өвөрхангай аймаг. Төвхөн хийд	62	394			3	3					3	3	59	391
18	Өвөрхангай аймаг. Шанхын Баруун хүрээ хийд	671	3780											671	3780
	<b>НИЙТ ДҮН</b>	<b>59331</b>	<b>132270</b>	<b>19</b>	<b>67</b>	<b>9</b>	<b>9</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>29</b>	<b>77</b>	<b>59302</b>	<b>132193</b>
		дэс	тоо/ш	дэс	тоо/ш	дэс	тоо/ш	дэс	тоо/ш	дэс	тоо/ш	дэс	тоо/ш	дэс	тоо/ш
		Тоологдох хөдлөх дурсгалт зүйл		Гадаадад үзэсгэлэнд		Дутсан		Солигдсон		Хулгайд алдсан		Нийт тоологдоогүй		Тоологдсон хөдлөх дурсгалт зүйл	

Хавсралт №3

ТҮҮХ, СОЁЛЫН ХӨДЛӨХ ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙН  
2018-2019 ОНЫ УЛСЫН ТООЛЛОГЫН ДҮН  
(АЙМАГ, ОРОН НУТАГ, НИЙСЛЭЛ, БАЙГУУЛЛАГЫН МУЗЕЙ -27)

№	Байгууллага	Тоологдох хөдлөх дурсгалт зүйл		Гадаадад үзэсгэлэнд		Дутсан		Хулгайд алдсан		Солигдсон		Нийт тоологдоогүй		Тоологдсон хөдлөх дурсгалт зүйл	
		дэс	тоо/ш	дэс	тоо/ш	дэс	тоо/ш	дэс	тоо/ш	дэс	тоо/ш	дэс	тоо/ш	дэс	тоо/ш
1	Архангай аймгийн музей	1725	3930											1725	3930
2	Баян-Өлгийн аймгийн музей	1359	5314											1359	5314
3	Баянхонгор аймгийн түүх, угсаатны зүйн музей	4240	10419											4240	10419
4	Булган аймгийн музей	2592	4942											2592	4942
5	Говь-Алтай аймгийн музей	2501	2504											2501	2504
6	Говьсүмбэр аймгийн музей	683	948											683	948
7	Дархан-Уул аймгийн музей	911	1300											911	1300

8	Хархорум музей	698	1324			1	1					1	1	697	1323
9	Хөшөө цайдам музей	145	175											145	175
10	Чойжин ламын сүм музей	1002	6385											1002	6385
11	Монголын Үндэсний номын сангийн үнэт ховор номын фонд	516	516											516	516
12	ШУА-ийн Палеонтологи, геологийн хүрээлэн	176	204											176	204
13	ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн	1440	8572											1440	8572
14	МУИС-ийн Нийгмийн шинжлэх ухааны сургууль	25	35											25	35
15	ШУТИС-ийн Бизнесийн удирдлага хүмүүнлэгийн сургууль	52	101											52	101
16	Улаанбаатар их сургууль	52	207											52	207
17	Өвөрхангай аймаг. Төвхөн хийд	62	394			3	3					3	3	59	391
18	Өвөрхангай аймаг. Шанхын Баруун хүрээ хийд	671	3780											671	3780
	<b>НИЙТ ДҮН</b>	<b>59331</b>	<b>132270</b>	<b>19</b>	<b>67</b>	<b>9</b>	<b>9</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>29</b>	<b>77</b>	<b>59302</b>	<b>132193</b>
		дэс	тоо/ш	дэс	тоо/ш	дэс	тоо/ш	дэс	тоо/ш	дэс	тоо/ш	дэс	тоо/ш	дэс	тоо/ш
		Тоологдох хөдлөх дүрсгалт зүйл		Гадаадад үзэсгэлэнд		Дутсан		Солигдсон		Хулгайд алдсан		Нийт тоологдоогүй		Тоологдсон хөдлөх дүрсгалт зүйл	

**ТҮҮХ, СОЁЛЫН ХӨДЛӨХ ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙН  
2018-2019 ОНЫ УЛСЫН ТООЛЛОГЫН ДҮН  
(СУМДЫН ОРОН НУТАГ СУРТАЛЧЛАХ ТАНХИМ-259, ДҮҮРЭГ-2, СУМ ХИЙД-1)**

№	Сумдын нэрс	Тоологдох хөдлөх дурсгалт зүйл		Гадаадад үзэсгэлэнд		Дутсан		Хулгайд алдсан		Солигдсон		Нийт тоологдоо гүй		Тоологдсон хөдлөх дурсгалт зүйл	
		дэс	тоо/ш	дэс	тоо/ш	дэс	тоо/ш	дэс	тоо/ш	дэс	тоо/ш	дэс	тоо/ш	дэс	тоо/ш
1	1.Архангай аймаг- 11 сум	454	692			2	2					2	2	452	690
2	2. Баян-Өлгий аймаг- 9 сум	478	641			2	4			1	1	3	5	475	636
3	3. Баянхонгор аймаг- 18 сум	2379	3116			31	31					31	31	2348	3085
4	4. Булган аймаг -16 сум	837	1899			46	297	23	36			69	333	768	1566
5	5. Говь-Алтай аймаг- 18 сум	1380	1395					3	3			3	3	1377	1392
6	6. Говьсүмбэр аймаг- 1 сум	22	58											22	58
7	7. Дархан-Уул аймаг- 1 сум	91	95											91	95
8	8. Дорноговь аймаг- 12 сум	1005	2024			5	5					5	5	1000	2019
9	9. Дорнод аймаг- 6 сум	763	1542			29	72	2	17			31	89	732	1453
10	10. Дундговь аймаг- 10 сум	827	1324											827	1324
11	11. Завхан аймаг- 21 сум	1817	4382			9	9			2	3	11	12	1806	4370
12	12. Орхон аймаг														
14	14. Өмнөговь аймаг- 13 сум	786	1739											786	1739
15	15. Сүхбаатар аймаг- 3 сум	776	876											776	876
16	16. Сэлэнгэ аймаг-18 сум	856	1240			15	16					15	16	841	1224
17	17. Төв аймаг- 28 сум	1279	2978			30	70	2	2	2	2	34	74	1245	2904
18	18. Увс аймаг- 17 сум	1574	3358			34	56					34	56	1540	3302
19	Ховд аймаг- 13 сум, 1 сум хийд	923	1690			19	18	11	14	2	3	32	35	891	1655
20	20. Хөвсгөл аймаг- 15 сум	1527	2596			35	40			1	1	36	41	1491	2555
21	21. Хэнтий аймаг- 12 сум	896	1527			19	39					19	39	877	1488
22	22. Нийслэлийн дүүрэг -2	444	546											444	546
23	Сүм хийд, Ховд аймаг, Ганданпунцаглин хийд	50	271											50	271
<b>Нийт</b>		<b>19728</b>	<b>35127</b>			<b>285</b>	<b>672</b>	<b>41</b>	<b>72</b>	<b>8</b>	<b>10</b>	<b>334</b>	<b>754</b>	<b>19394</b>	<b>34373</b>

ТАЙЛАГНАСАН:

УЛСЫН КОМИССЫН ДАРГА:

Г.ЭРДЭНЭБАТ (ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ СОЁЛ,  
УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГА)

ГИШҮҮД:

Н.МӨНХЗУЛ (СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН СОЁЛ, СОЁЛЫН ӨВИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА)

Б.ДАВААЦЭРЭН (БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН  
ЯАМНЫ СОЁЛ, УРЛАГИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН  
МЭРГЭЖИЛТЭН)

Г.ЭНХБАТ (СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРАЛ)

Д.СҮХБААТАР (МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ МУЗЕЙН ЗАХИРАЛ)

Ш.ЖАВЗМАА (ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ХҮН АМ,  
НИЙГМИЙН СТАТИСТИКИЙН ГАЗРЫН ШИНЖЭЭЧ)

Э.ГАНЧИМЭГ (ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН  
ГАЗРЫН ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ, ХЯНАЛТЫН  
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН)

Х.ЦОГТБААТАР (ШУА-ИЙН ПАЛЕОНТОЛОГИ, ГЕОЛОГИЙН  
ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ)

С.ЧУЛУУН (ШУА-ИЙН ТҮҮХ, АРХЕОЛОГИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ)

Т.БАЯРЛАХ (ҮНДЭСНИЙ НОМЫН САНГИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА)

Г.ЭРЭГЗЭН (ШУА-ИЙН ТҮҮХ, АРХЕОЛОГИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН ЭРДЭМ  
ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛТАН)

Д.ОТГОНБАЯР (МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
СОЁЛЫН ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ)

Б.ТӨМӨРБААТАР (МОНГОЛЫН УРЧУУДЫН ЭВЛЭЛИЙН ХОРООН  
ДАРГА)

Т.ТОДГЭРЭЛ (БАЙГАЛИЙН ТҮҮХИЙН МУЗЕЙН ЭРДЭМ  
ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛТАН)

Д.ТУЛГА (ШАШНЫ ДЭЭД СУРГУУЛИЙН УРЛАХУЙН УХААНЫ  
ТЭНХИМИЙН БАГШ)

КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:

Ч.НАЦАГНЯМ (СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН СОЁЛ, СОЁЛЫН ӨВИЙН  
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН)

Д.НАРАНТУЯА (СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН СОЁЛЫН  
ӨВИЙН БҮРТГЭЛ, СУДАЛГААНЫ ГАЗРЫН ДАРГЫН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ)



## 1.1. “Чулуун соёлын өв” хөтөлбөрийн хэрэгжилт 2019 бүртгэн баримтжуулалт

### “ЧУЛУУН СОЁЛЫН ӨВ” ХӨТӨЛБӨРИЙН 2019 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

1. Удиртгал
2. Чулуун соёлын өвийг бүртгэх арга зүйг боловсронгуй болгох ажлын тайлан
3. Чулуун соёлын өвийн бүртгэлийн маягтыг “RICH” програмд нэвтрүүлнэ.
4. Чулуун соёлын өвийн мэдээллийг “RICH” програм руу шилжүүлж хадгална.

#### УДИРТГАЛ

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 69 дүгээр тогтоолоор "Чулуун соёлын өв" үндэсний хөтөлбөр, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/368 дугаар тушаалаар “Чулуун соёлын өв үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г тус тус баталсан.

Үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2019 онд 3 төрлийн 7 нэр бүхий ажлыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл урлагийн газар, Соёлын өвийн үндэсний төв хамтран зохион байгуулж, гүйцэтгэлээ. Энэхүү ажлыг зохион байгуулахад Архангай, Увс, Хөвсгөл, Дундговь, Сүхбаатар аймгийн ЗДТГ, музейд дэмжлэг үзүүлэв.

1.1.Бүртгэн баримтжуулах, мэдээлэл цуглуулах арга зүйг боловсронгуй болгоно.

1.1.1.Чулуун соёлын өвийг бүртгэх арга зүйг шинээр боловсруулна.

1.1.2.Чулуун соёлын өвийн бүртгэлийн маягтыг “RICH” программд нэвтрүүлнэ.

Чулуун дурсгалыг бүртгэн баримтжуулах, мэдээллийн арга зүйг боловсронгуй болгох ажлын хүрээнд:

- Чулуун дурсгалын бүртгэлийн арга зүйг боловсруулан, бүртгэх маягтыг шинээр зохиов.
- Бүртгэлийн RICH 2, RICH 3.0 программ хангамжийг шинчлэн сайжруулж, RICH 4.0 программ хангамжийг нэвтрүүллээ.
- Гэрэл зургийг ашиглаж дурсгалын эвдрэл гэмтэл, хадгалалтын талаарх мэдээллийг боловсруулах модуль үүсгэж, сэргээн засварлах, судлах, хамгаалах төлөвлөлтөд ашиглах боломжийг бүрдүүлэв.

1.3.Зарим томоохон цогцолбор дурсгалын оршин буй газрыг кадастрын улсын бүртгэлд бүртгүүлэх.

1.3.1. Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын нутагт орших Уушигийн өвөрийн буган чулуун хөшөө бүхий цогцолбор,

1.3.10. Архангай аймгийн Өндөр-Улаан сумын нутагт орших Их Жаргалантын буган чулуун хөшөө бүхий цогцолбор,

1.3.11. Архангай аймгийн Ихтамир сумын нутагт орших Тайхар чулуу.

- Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын улсын хамгаалалтын зэрэглэлд ангилагдсан Уушигийн өвөр, Их Жаргалантын буган чулуун хөшөөний цогцолборуудыг Дэлхийн өвийн жагсаалтад бүртгүүлэх, дурсгалын бүрэн бүтэн байдлыг хангах, хадгалалт хамгаалалтыг сайжруулах

үүднээс кадастрын хэмжилт хийж, Уушигийн өвөрийн кадастрын зураглалыг 7 цэг, 23.1 га, Их жаргалантын кадастрын зураглалыг 13 цэг, 86.8 га-аар тогтоож, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлэв.

- Архангай аймгийн Ихтамир сумын нутагт орших Тайхар чулуунаа түүхийн олон үед холбогдох тамга тэмдэг, амьтдын сийлмэл зураг, зосон зураг болон руни, согд, уйгур, монгол, дөрвөлжин, төвд, ланз, манж, тод, нангиад зэрэг арав гаруй зүйл бичиг үсгийн 150 гаруй бичээс бий. Дээрх дурсгалт газар нь бэхээр бичиж үлдээсэн бичээс арвинтай, Монголын түүхийн сурвалжид дурдагддаг бие хүмүүсийн нэр бичигдсэн, домог билэгдэл зүйтэй холбогддог соёлын биет бус өвийн илэрхийллийг агуулсан цөөн дурсгалуудын нэг гэдгээрээ онцлогтой. Тайхар чулуу орчимд хамгаалалтын бүс тогтоох кадастрын хэмжилтийг хийх ажлыг 2019 оны 8 сард хийж гүйцэтгэсэн.

2.1.Хэв, дардасыг авах, хуулбарыг хийж хадгалах;

2.1.1.Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын нутагт орших Баруун элгэний бичээсийн хэвийг авч, хуулбар хийн хадгалах,

2.1.3. Дундговь аймгийн Өлзийт сумын нутагт орших Дэл уулын хадны зургийн дардасыг авч хадгалах,

2.1.12. Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутагт орших Жаргалантын ширээний хадны зургийн дардасыг авч хадгалах,

- Монгол Улсын төдийгүй олон улсын хэмжээнд түүх, соёл, шинжлэх ухаан, урлагийн өндөр ач холбогдол бүхий Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутагт орших хүний нүүр (баг) болон амьтдыг дүрсэлсэн, эртний хэв шинжийг агуулсан Жаргалантын ширээний хадны зураг, Дундговь аймгийн Өлзийт сумын “Дэл уулын 32 хүнт”-ийн булшны хавтан чулуун дээрх хүрэл зэвсгийн үеийн хүмүүсийн оршуулгын зан үйлийг харуулсан зураг, Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын нутагт байх Умард Хүннү, Хан улсуудын харилцааг өгүүлсэн бичгийн томоохон дурсгал Баруун элгэний хятад бичээсийн хэв, дардасыг авч хуулбарыг хийж баримтжуулав.
- Дурсгалын хэв авах баримтжуулалтын үр дүнд цаашдын судалгаанд ашиглах 400 орчим гэрэл зургийн 2GB цахим файлыг СӨУНБМСанд хадгалаад байна.

## НЭГ. БҮРТГЭН БАРИМТЖУУЛАХ, МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ АРГА ЗҮЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АЖЛЫН ТАЙЛАН

1. Хэрэглэгчийн шаардлага тодорхойлох ажил
2. Нэмэлт ажил
3. Програмчлалын ажил
4. Дүгнэлт
5. Хавсралт

### 1.1. Хэрэглэгчийн шаардлага тодорхойлох ажил

“Соёлын өвийн төв” (Захиалагч), “Сайбер-Андромеда” ХХК (Гүйцэтгэгч) нарын 2019 оны 10-р сарын 03-ны өдөр байгуулсан Түүх, соёлын үл хөдлөх

дурсгалын бүртгэлийн RICH програм хангамжийг сайжруулах тухай №29 тоот гэрээний хавсралт №1-д заасан хэрэглэгчийн шаардлага тодорхойлох ажлын хүрээнд доорх 4 төрлийн ажлыг хийж гүйцэтгэхээр заасан. Үүнд:

1. RICH 2.0 болон RICH 3.0 програм дээр бүртгэгдсэн бүртгэлүүдийг харьцуулсан анализ хийх
2. Чулуун дурсгалын бүртгэлийн маягтыг эцэслэн тогтох
3. ТСҮХД-ын нэгдсэн бүртгэлийн маягтыг эцэслэн тогтох
4. Програмын функциональ шаардлагыг тодорхойлох (Хайлт, тайлан ...г.м)

Хэрэглэгчийн шаардлага тодорхойлох ажлын хэсгийн бүрэлдэхүүнд захиалагч талаас Г.Энхбат (СӨҮТ-ийн захирал), Г.Анхсанаа (СӨҮТ-ийн Соёлын өвийг авран хамгаалах газрын дарга), П.Чинбат (СӨҮТ-ийн Систем хөгжүүлэлтийн инженер), Г.Бүрэнтөгс (СӨҮТ-ийн ТСҮХД хариуцсан бүртгэл, мэдээллийн санч), гүйцэтгэгч талаас Б.Алтансүх (Програмист) нар тус тус орж ажиллав.

Энэ ажлын хүрээнд 10-р сарын 3, 7, 16, 30-нд, 11-р сарын 5, 13, 14, 20, 21-нд нийт 9 удаагийн уулзалт хийж хэрэглэгчийн шаардлагыг нарийвчлан тодорхойлох ажлыг хийж гүйцэтгэлээ. Хэрэглэгчийн шаардлага тодорхойлох ажлын явцад гэрээнд тусгагдаагүй нэмэлт ажил гарч ирсэн нь “Бүртгэлийн програмыг онлайн болгох” ажил байв. Энэ удаагийн сайжруулалтын ажлын хүрээнд бүртгэлийг онлайн болгох ажлыг бүрэн хэмжээнд хийж гүйцэтгэх боломжгүй ч, энэхүү ажлыг тодорхой хэмжээнд эхлүүлэхээр хоёр тал харилцан тохиролцов.

1. RICH 2.0 болон RICH 3.0 програм дээр бүртгэгдсэн бүртгэлүүдийг харьцуулсан анализ хийх

2. RICH 2.0 болон RICH 3.0 бүртгэлийн програмд оруулсан бүртгэлүүдийг харьцуулан үзэж бүртгэлийн маягтыг нэгтгэх, засаж сайжруулах ажлыг хийж гүйцэтгэлээ.

“RICH 2.0” програм хангамж: 2004 онд батлагдсан Монгол улсын Соёлын өвийг хамгаалах хуульд түүх соёлын Үл хөдлөх дурсгалыг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр 11 хэсэгт ангилан авч үзэх бөгөөд Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 541-р тушаалаар батлагдсан бүртгэлийн магт дээр үндэслэн 2010 оноос боловсруулсан. “RICH 2.0” програм хангамж нь Монгол улсын нутаг дэвсгэр дээрх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэлийн мэдээллийг УНБМСанд нэгтгэн сан үүсгэх, цугларсан мэдээлэлд боловсруулалт хийх боломжтой.

“RICH 2.0” програм нь үндсэн 5 хэсэг 27 асуултын дагуу бүртгэдэг. Үүнд: Дурсгалын төрөл, оршиж байгаа засаг захиргааны нэгжийн нэр, хамгаалалтын ангилал, холбогдох он цаг, гэмтэл, дурсгалт зүйлийн бүрдэл, анх нээж илрүүлсэн, судлагдсан байдал гэх мэт дэлгэрэнгүй мэдээллийг агуулахыг зориулагдсан юм.

Тус програм хангамжид орсон нийт дурсгал бүрд УНБМСангийн нэгдсэн дугаар өгөх бөгөөд Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын талаарх мэдээллийг цуглуулж бичихийн зэрэгцээ мэдээллийг дотор нь нэгтгэх, хайх, боловсруулах системийн үйлдэл хийнэ.

Мөн дурсгалын гэрэл зургийг оруулан газар зүйн солбицлыг газрын зурагт тэмдэглэх, УНБМСанд байгаа Монгол улсын нутаг дэвсгэр дахь түүх соёлын үл хөдлөх дурсгалын талаар хайлт хийх, статистик дүн мэдээ гаргах боломжийг олгохоор зохиосон.

Гэвч “RICH 2.0” Програм хангамжийн зарим сул тал нь Зөвхөн Соёлын өвийн төвийн цуглуулсан мэдээллээр хязгаарлагдах бөгөөд цаасан суурьтай баримтын тодорхой хэсэг хамрагдаж байгаа ба мэргэжлийн судалгааны байгууллагууд хамрагдаж чадаагүй зэрэг болно. Тус програм хангамжид одоогоор 2029 дурсгалт газрын 23288 дурсгалын бүртгэлийг оруулаад байна.

“RICH 3.0” програм хангамж: Соёл, спорт, аялал жуулчлалын сайдын 2014 оны 02 дугаар сарын 28- ны өдрийн А/63 дугаар тушаалаар “Улс, орон даяар 2015 онд зохион байгуулах түүх, соёлын үл хөдлөх дурсгалын үзлэг тооллогын бэлтгэл ажлыг хангах” ажлын хэсгийг байгуулсан билээ. Ажлын хэсэг үзлэг тооллогын бүртгэлийн програм хангамжид ашиглагдах дурсгалын төрөл зүйлийн ангилал болон үзлэг, тооллогын бүртгэлийн маягтыг боловсруулж, Соёлын өвийн төвөөс үзлэг тооллогод зориулагдсан RICH 3.0 бүртгэлийн програм хангамжийг боловсруулсан. Энэ програм хангамжийн гол зорилго нь түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэлийг газар дээр нь цахимаар хийж, дурсгалын төрөл зүйлийг сонгон дурсгалт газар болон дурсгал тус бүр дээр хувийн дугаар өгөх явдал байв. “RICH 3.0” програм хангамж нь 23 асуултаас 9 асуултыг нөхөж бичиж, 14 асуултад сонголт хийхээр хялбарчилсан.

Програм хангамжийн төрөл зүйлийн ангиллыг Үзлэг, тооллогын ажлын хэсэгт орсон ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн, Палеонтологийн хүрээлэн, Монголын Үндэсний музей, ШУТИС- БуХС-ХУС зэрэг археологи, палеонтологийн чиглэлийн 4 байгууллагын судлаачид боловсруулсан бөгөөд нийт 8 ерөнхий, 99 дэд зүйлсээс сонголт хийдэг.

“RICH 3.0” програм хангамж Бүртгэлийн дугаар 12 цифрээс бүрдэх бөгөөд 1-2-р цифр нь аймгийн код, 3-4-р цифр нь сумын код, 5-8-р цифр нь сумын нутаг дэвсгэр дэх дурсгалт газрын дэс дугаар, 9-р цифр нь төрөл зүйл, 10-12-р цифр нь тухайн дурсгалт газар дахь дурсгалын дэс дугаарыг илэрхийлнэ.

Одоо “RICH 3.0” програм хангамж нийт 9537 дурсгалт газрын 86157 дурсгалын бүртгэлийг (газар хувийн дугаар, газар зүйн солбицол, гэрэл зураг, товч тодорхойлолт г.м) оруулсан.

Улс, аймгийн чанартай ямар нэгэн хамгаалалтанд аваагүй ТСҮХД-ын бүртгэлийг “Урьдчилсан бүртгэл” хэмээн нэрлэж RICH 4.0 онлайн бүртгэлийн програмд оруулах, цаашид энэ нэрийг хэрэглэж хэвшихээр болсон нь ТСҮХД-ын бүртгэлийн ажилд гарч буй дэвшил юм.

## 2. Чулуун дурсгалын бүртгэлийн маягтыг эцэслэн тогтох

Чулуун дурсгалын бүртгэлийн маягт боловсруулах ажлын хүрээнд С.Нямдорж (СӨҮТ-ийн Соёлын өвийг сэргээн засварлах газрын дарга), М.Оюунтулга (СӨҮТ-ийн Соёлын өвийг сэргээн засварлах газрын ерөнхий технологич), С.Саран (ШУА-н Физик, технологийн хүрээлэнгийн Технологийн салбарын эрхлэгч), Ш.Чадраабал (ШУА-н Физик, технологийн хүрээлэнгийн ЭША) нартай уулзалт хийж маягтын асуулгыг боловсрууллаа. (Хавсралт №1) “Чулуун соёлын өв” хөтөлбөрийн хүрээнд хийгдэх бүртгэл, судалгааны үеэр дурсгалаас бага хэмжээний дээж авч чулуулгийн төрлийг нарийвчлан тогтоох ажлыг хийхээр болсон бөгөөд энэхүү мэдээллийг цуглуулах, нэгтгэн боловсруулахад шаардлагатай талбарыг бүртгэлийн програмд тусгалаа.

### 3. ТСҮХД-ын нэгдсэн бүртгэлийн маягтыг эцэслэн тогтох

RICH 2.0 болон RICH 3.0 бүртгэлийн програмд оруулсан бүртгэлүүдийг харьцуулан үзэж анализ хийсний үндсэн дээр ТСҮХД-ын нэгдсэн бүртгэлийн маягтыг боловсруулж, уг маягтын дагуу онлайн бүртгэлийн програмыг хийхээр тогтсон. Энэхүү бүртгэлийн маягтыг доорх гурван төрлийн бүртгэлийн агуулгыг аль алиныг агуулсан байхаар бодолцож боловсруулсан болно. Үүнд:

1. ТСҮХД-ын урьдчилсан бүртгэл
2. Чулуун соёлын өвийн бүртгэл
3. Соёлын өвд бүртгэгдсэн буюу улс, аймаг, нийслэл, сум юмуу дүүргийн хамгаалалтын аль нэг ангилалд албан ёсоор орсон ТСҮХД

Энэхүү ажлын хүрээнд боловсруулсан ТСҮХД-ын бүртгэлийн маягтыг Хавсралт №2-ээс үзнэ үү.

### 4. Програмын функциональ шаардлагыг тодорхойлох (Хайлт, тайлан...)

RICH бүртгэлийн програмыг онлайн болгох болсонтой холбоотойгоор програмын функциональ шаардлагыг веб-д суурилсан онлайн програмын онцлогт нийцүүлэн тодорхойлон гаргасан болно. Онцгойлон гэрэл зурагтай ажиллах хэсгийг анх төлөвлөж байснаас илүү өргөн хүрээнд ашиглах боломжтой байхаар тодорхойлов. Тодруулбал гэрэл зурагт метадаг шошго (label) хэлбэрээр хавсарган хадгалах, түүнийг ашиглах нэмэлт функцийг онлайн програмд оруулж өгөхөөр боллоо.

#### 1.2. Нэмэлт ажил

Хэрэглэгчийн шаардлагыг нарийвчлан тодорхойлох ажлын явцад RICH 3.0 офлайн програмын ашиглалтын байдалд дүгнэлт хийхэд дараах дутагдалтай талууд ажиглагдлаа. Үүнд:

1. Програмын хэвийн үйл ажиллагааг хангахад СӨҮТ-д хэт их ачаалалтай байдаг.
2. Мэдээллийн нэгдмэл байдлыг хангахад төвөгтэй байдаг.
3. ТСҮХД-ын бүртгэлийн бүрдүүлэлт, ашиглалтанд түүх, археологийн чиглэлийн судлаачдын оролцоо бага байдаг.

RICH 3.0 програмын дээрх дутагдалтай талуудыг арилгах хамгийн боломжит шийдэл бол програмыг веб-д суурилсан онлайн хувилбарт шилжүүлэх явдал болно. Ингээд захиалагч болон гүйцэтгэгч тал харилцан тохиролцсоны үндсэн дээр “Бүртгэлийг онлайн болгох” ажлын бэлтгэлийг энэхүү гэрээт ажлын хүрээнд хийхээр тохиролцсон. Энхүү веб-д суурилсан бүртгэлийн платформын ажиллах ерөнхий зарчим болоод талуудын оролцоог тодорхойлон схемд буулгах ажлыг хийж гүйцэтгэлээ. Онлайн програмын ажиллах зарчмыг буулгасан схемийг Хавсралт №3-оос үзнэ үү.

Онлайн бүртгэлийн орчинд ажиллах хэрэглэгчдийн ангилал, тэдгээрийн програм дээр хийж болох зөвшөөрөгдсөн үйлдлүүдийг нэг бүрчлэн томъёолж, бүртгэлийн програмрамтай уялдуулах ажлыг хийж гүйцэтгэв. (Хавсралт №4)

Бүртгэлийн програмыг онлайн хувилбарт шилжүүлэхэд гарах давуу болон сул талуудыг дурьдвал:

	<b>Давуу тал</b>	<b>Сул тал</b>
--	------------------	----------------

1	Мэдээллийн нэгдмэл байдал бий болно	Мэдээллийн аюулгүй байдал илүү их анхаарал хандуулах шаардлагатай
2	Програмын хэвийн ажиллагааг хангахад бага цага зарцуулна	Интернэтгүй үед ажиллахгүй
3	Судлаачдын оролцоог хангах боломж бүрдэнэ	
4	Шат шатны БМСанд мэдээлэл дамжуулах хурд нэмэгдэнэ	

### 1.3. Програмчлалын ажил

Гэрээний хавсралтанд заасан програмчлалын 8 төрлийн ажлыг хуваарийн дагуу бүрэн хийж гүйцэтгэлээ. Програмыг онлайн болгох нэмэлт ажлын хүрээнд 2.8-д заасан Системийн тест ба жигдрүүлэлтийн ажлыг гэрээний 1.5-д заасан баталгаат хугацааны туршид буюу 2020 оны 12-р сарын 11-нийг хүртэл хугацаанд үнэ төлбөргүй хийж гүйцэтгэх болно.

Гэрээний 2.3-д заасан Гэрэл зургийг он оноор ангилан харуулах модуль боловсруулах ажлыг өргөтгөн гэрэл зурагтай ажиллах бүрэн хэмжээний модуль болгох ажлыг хийлээ. Энэхүү гэрэл зурагтай ажиллах модулийн гол онцлог нь гэрэл зураг тус бүрд метадата мэдээллийг шошго (label) хэлбэрээр хавсарган хадгалах боломжийг бүрдүүлсэн явдал юм. Гэрэл зурагт хавсаргах жишиг шошгон мэдээллийн жагсаалтыг боловсруулсан (Хавсралт №5) бөгөөд цаашид энэхүү асуулгыг програмын ашиглалтын түвшинд шинэчлэн сайжруулах бүрэн боломжтой байхаар зохион байгуулсан.

Онлайн бүртгэлийн RICH 4.0 програмыг Соёлын өвийн үндэсний төвийн эзэмшлийн rich.ncsch.gov.mn домэйн дээр байрлуулан ашиглахад бэлэн болголоо. (Хавсралт №6)

**ПРОГРАМЧЛАЛЫН АЖИЛД АШИГЛАСАН ТЕХНОЛОГИ:**

Програм хангамж: Microsoft Visual Studio 2017, Adobe XD, Adobe Photoshop

Мэдээллийн бааз: MSSQL 2012

Веб технологи: ASP.NET MVC

Веб хостинг: Windows server 2008 (Соёлын өвийн үндэсний төв)

### 1.4. Дүгнэлт

RICH програмын сайжруулалтын ажлын хүрээнд гэрээнд заагдсан ажлуудаас гадна хэрэглэгчийн шаардлага нарийвчлан тодорхойлох ажлын явцад гарч ирсэн бусад нэмэлт ажлуудыг бүрэн хийж гүйцэтгэн хүлээлгэн өгч байна.

Аливаа програм хангамжийн төслийн үр дүн “Хэрэглэгчийн шаардлага тодорхойлох” ажлыг ямар түвшинд хийснээс шууд шалтгаалдаг. Тийм ч учраас энэхүү гэрээт ажлын хүрээнд хэрэглэгчийн шаардлага тодорхойлох шатнаас програм хангамж бэлэн болох хүртэлх бүх шатны ажлыг төлөвлөх, гүйцэтгэлийг оновчтой удирдах зорилгоор төслийн менежментийн TRELLO програмын онлайн хувилбарыг үр дүнтэй ашигласан болно. (Хавсралт №7) Цаашид програм хангамж хөгжүүлэлтийн төсөл болон бусад ажилд TRELLO програмыг ашиглах нь цаг

хугацаа хэмнэх, ажлын бүтээмж дээшлүүлэх чухал ач холбогдолтой болох нь харагдсаныг онцолж байна.

RICH програмыг онлайн хувилбарт шилжүүлж байгаатай холбоотойгоор цаашид анхаарах зүйлс:

1. Мэдээллийн баазын нөөц хувилбарыг 14 хоног тутамд архивлан хадгалах
2. Гэрэл зургийн нөөц хувилбарыг 2 догч эх үүсвэрт хувиран хадгалах (Хугацааг нарийвчлан тогтох)
3. Серверийн хүчин чадал (RAM, HDD)-г нэмэгдүүлэх, аюулгүй ажиллагаа, нөөц хуулбарыг тогтмол хуваарийн дагуу хийх
4. СӨҮТ-ийн интернэтийн хурдыг сайжруулах

### ХАВСРАЛТ

Хавсралт 1



Хавсралт 2

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын урьдчилсан бүртгэлийн маягт

№	1. ТСҮХД-ийн үндсэн мэдээлэл
1	Дурсгалын бүртгэлийн дугаар:
2	Аймаг, Нийслэл:
3	Сум, дүүрэг:
4	Дурсгалын нэр:
5	Төрөл зүйл: <b>Олон сонголттой</b>
9	Ерөнхий тоо ширхэг:
10	Солбилцол:
11	Хамгаалалтын ангилал: 1. Дэлхийн өвд бүртгэгдсэн эсэх?

	2. Улсын хамгаалалтанд 3. Аймаг (нийслэл)-ийн хамгаалалтанд 4. Сум (дүүрэг)-ийн хамгаалалтанд 5. Хамгаалалтанд аваагүй (ТСҮХД-ын урьдчилсан жагсаалт)
12	Хэмжээ: (Урт, өргөн, өндөр, диаметр зэргийг тоон утгаар, бусад дэлгэрэнгүй хэмжээсийг текстээр бичиж болно.)
13	Тоо ширхэг:
14	Холбогдох он цаг: <b>Олон сонголттой</b>
15	Хамгаалалтад авсан шийдвэр:
16	Бүртгэлд хавсаргах бусад мэдээлэл:
17	Гэрэл зураг:
18	Бусад тэмдэглэл:
19	Бүртгэсэн:
<b>2. Судлагдсан байдал</b>	
2.1	Товч тодорхойлолт:
2.2	Товч түүх:
2.3	Судлагдсан байдал:
2.4	Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тайлан, бусад баримт
2.5	Архив, ном, хэвлэлийн баримт (Хэмжилт судалгааны үр дүн гэх мэт)


<b>3. Хадгалалт хамгаалалтын байдал</b>					
	Хадны зураг, бичгийн дурсгал	Хөшөө дурсгал	Барилга, архитектурын дурсгал	Булш оршуулгын дурсгал	Чулуун зэвсгийн дурсгалт газар, Үйлдвэрлэлийн ул мөр хадгалсан дурсгалт газар
3.1	Хадгалалт хамгаалалтын байдал (Бичвэр бичих)				
3.2	Сэргээн засварласан эсэх (Тийм, үгүй)				
3.3	Сэргээн засварласан байдал (Сэргээн засварлалтын ажлын товч тайлан, он, арга зүй, технологи, үйл ажиллагааг бичнэ. Дэлгэрэнгүй тайланг PDF форматаар хавсаргаж болно.)				
3.4	Хэв хуулбар, дардас авсан эсэх?				
3.5	Хэв хуулбар, дардас авсан байдал (Хэв хуулбар, дардас авах ажлын товч тайлан, он, арга зүй, технологи, үйл ажиллагааг бичнэ. Дэлгэрэнгүй тайланг PDF форматаар хавсаргаж болно.)				
3.6	3D баримтжуулалт хийсэн эсэх?				
3.7	3D баримтжуулалтын байдал? (3D баримтжуулалтын ажлын товч тайлан, он, арга зүй, технологи, үйл ажиллагааг бичнэ. Дэлгэрэнгүй тайланг PDF форматаар хавсаргаж болно. Мөн 3D моделийг тал бүрээс харуулсан зургийг хавсаргаж болно.)				
3.8				Малтаж судалсан эсэх?	
3.9				Малтаж судалсан байдал	
3.10				Ухагдаж тоногдсон эсэх?	
3.11				Ухагдаж тоногдсон байдал (Хэдэн онд аль хэсэг нь ухагдаж тоногдсон, баримт, гэрэл зураг)	
3.13	Хашаа хайстай эсэх?				
3.14	Хашаа хайсны талаар (Хэний санхүүжилтээр, хэн, хэзээ хийсэн. Шийдвэр байгаа бол шийдвэрийн дугаар)				
3.15	Эвдрэл гэмтэл байгаа эсэх?				
3.16	Эвдрэл гэмтлийн талаар				



4. Орон зайн мэдээлэл	
4.1	Солбилцол
4.2	Хамрах хүрээ (3-аас дээш, хэдэн ч солбилцол оруулж болно. Дарааллын дагуу оруулах шаардлагатай /share must be polygon/)
5. Хавсралт материал	
5.1	Дүрс бичлэг (СӨУНБМСан)
5.2	Дүрс бичлэг (Аймаг, нийслэлийн БМСан)
5.3	Дүрс бичлэг (Сум, дүүргийн БМСан)
5.4	Гэрэл зураг, негатив хальс (СӨУНБМСан)
5.5	Гэрэл зураг, негатив хальс (Аймаг, нийслэлийн БМСан)
5.6	Гэрэл зураг, негатив хальс (Сум, дүүргийн БМСан)
6. Чулуун соёлын өв	
6.1	Чулуулгын төрөл
6.2	Өгөршил (1-3 балаар хэмжинэ)
6.3	Биологийн бохирдол (1-3 балаар хэмжинэ)
6.4	Бүтцийн эвдрэл, гэмтэл (1-3 балаар хэмжинэ)
7. Тахилга шүтлэгт газар	
7.1	Тахилга шүтлэгтэй эсэх
7.2	Тахилгат газрын бүртгэлийн дугаар

Хавсралт 3

RICH 4.0 веб програмын ажиллах ерөнхий зарчим



RICH онлайн бүртгэлийн програмын “хэрэглэгч”-ийн  
ангилал ба зөвшөөрөгдсөн үйлдлүүд

№	Үйлдлүүд	СӨҮТ хэрэглэгч	Аймаг, нийслэлийн БМСанч	Сум, дүүргийн БМСанч	Судлаач
<b>1. Бүртгэл нэмэх, засах, устгах</b>					
1.1	Шинээр бүртгэл нэмэх				
1.2	Үндсэн мэдээлэлд засвар хийх				
1.3	“Судлагдсан байдал” хэсгийн мэдээлэлд засвар хийх				
1.4	Хадгалалт хамгаалалтын байдал				
<b>2. Жагсаалттай ажиллах</b>					
2.1	Дурсгалын жагсаалтыг цагаан толгойн үсгийн дараалалаар, солбицолтой нь гаргах				
2.2	Дурсгалын тоо, хэмжээ				
2.3	Тухайн аймаг, сумын нутаг дахь дурсгалын төрөл зүйл, тоон мэдээ гаргах				
Тайлбар: Аймаг, нийслэлийн холбогдолдох албан тушаалтанд тухайн засаг захиргааны харьяалал дахь ТСҮХД-ын бүртгэл, тайланг харах боломжтой байх.					
<b>3. Гэрэл зурагтай ажиллах</b>					
3.1	Гэрэл зураг оруулах				
3.2	Гэрэл зураг устгах			Зөвхөн өөрийн оруулсан зургийг устгах боломжтой	
3.3	Гэрэл зурагт шошго нэмэх, хасах				

3.4	Гэрэл зурагт солбилцол оруулах, засах				
4. Орон зайн мэдээлэл					
4.1	Солбилцол				
5. Хавсралт материал					
5.1	Дүрс бичлэг (СӨУНБМСан)				
5.2	Дүрс бичлэг (Аймаг, нийслэлийн БМСан)				
5.3	Дүрс бичлэг (Сум, дүүргийн БМСан)				
5.4	Гэрэл зураг, негатив хальс (СӨУНБМСан)				
5.5	Гэрэл зураг, негатив хальс (Аймаг, нийслэлийн БМСан)				
5.6	Гэрэл зураг, негатив хальс (Сум, дүүргийн БМСан)				

## Хавсралт 5

### 1. Гэрэл зурагтай ажиллах хэсэг

#### 1.1 Шошго (label)

- Үндсэн мэдээлэл
  - Аймаг (нийслэл)
  - Сум (дүүрэг)
  - Хадны зураг, бичгийн дурсгал
  - Хөшөө дурсгал
  - Барилга, архитектурын дурсгал
  - Булш оршуулгын дурсгал
  - Чулуун зэвсэг, үйлдвэрийн ул мөр хадгалсан дурсгалт газар
- Хамгаалалтын байдал
  - Дэлхийн өвд бүртгэгдсэн
  - Улсын хамгаалалтанд
  - Аймгийн хамгаалалтанд
  - Сумын хамгаалалтанд
- Хадгалалт хамгаалалт
  - Хашаа хайс
  - Хадаг яндар
  - Тоногдсон

- Хугарсан
  - Цуурсан
  - Сангас
  - Өөх тос
  - Унасан
  - Сэргээн засварлалт
  - Хэв хуулбар, дардас
  - 3D баримтжуулалт
  - Эвдрэл гэмтэл
- Баримтжуулалтын мэдээлэл
- Дрон
  - Ерөнхий байдал
  - Деталь зураг
  - Гэрэл зурагчин
  - Гар зураг
  - Дэвсгэр зураг

## Хавсралт 6



ХЯНАХ САМБАР
БҮРТГЭЛ
ХЭРЭГЛЭГЧ
ТУСЛАМЖ

## 1. ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛ

**ТСУХД-ын харьяалал**

1.2 Аймаг, нийслэл

Архангай

1.3 Сум, дүүрэг

Батцэнгэл

1.4 Дурсгалын нэр \*

**4. Орон зайн мэдээлэл (Солбилцол)**

Өргөрөг (N)  \*  \*  \* "

Уртраг (E)  \*  \*  \* "

Өндөршил (ДТД)  метр

**Тусламж!**

• [Гууглийн газрын зураг дээр дурсгалт газрын байршил шалгах тухай видео зааварчилгаа үзэх](#)

www.rich.ncch.gov.mn

### Хавсралт 7

RICH програмын сайжруулалтын ажилд төслийн менежментийн Trello програмыг ашигласан байдал.



## ХОЁР. ТОМООХОН ЗАРИМ ЦОГЦОЛБОР ДУРСГАЛЫН ОРШИН БУЙ ГАЗРЫГ КАДАСТРЫН УЛСЫН БҮРТГЭЛД БҮРТГҮҮЛСЭН АЖЛЫН ТАЙЛАН

1. Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын нутагт орших Уушигийн өврийн буган чулуун хөшөө бүхий цогцолборын кадастрын хэмжилт хийж, улсын бүртгэлд бүртгүүлсэн тухай тайлан
2. Архангай аймгийн Өндөрүлаан сумын Их жаргалантын амны буган чулуун хөшөөний цогцолбор, Ихтамир сумын нутагт орших Тайхар чулууны кадастрын хэмжилт хийж, улсын бүртгэлд бүртгүүлсэн тухай тайлан

### 2.1. Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын нутагт орших Уушигийн өврийн буган чулуун хөшөө бүхий цогцолборын кадастрын хэмжилт хийж, улсын бүртгэлд бүртгүүлсэн тухай тайлан

Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын нутаг Уушигийн өврийн буган чулуун хөшөөний цогцолборт хамгаалалтын бүсийг тогтоож, кадастр улсын бүртгэлд бүртгүүлэх ажлыг 2019 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс 22-ны хооронд газар дээр нь зохион байгуулан ажиллаа.

Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын нутагт орших Уушигийн өврийн буган чулуун хөшөөний цогцолборт Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэсийн мэргэжилтэн Г.Нарангэрэл, Хөвсгөл аймгийн ГХБХБГ –ын мэргэжилтэн Ц.Бямбатөр, Хөвсгөл аймгийн Музейн эрдэм шинжилгээний ажилтан М.Одмаа, Бүрэнтогтох сумын Туяа багийн Засаг дарга Б.Пүрэвдорж, нутгийн иргэн малчин А.Надмид болон Хувилгаан газар ХХК –ны захирал Ж.Цээпилмаа, инженер Ж.Жаргалсайхан нар оролцов (Зураг 9).

Дурсгалт газар дээрээс орчны байдалтай танилцаж ажлын хэсгийн өмнө нь тогтоосон соёлын өвийн хамгаалалтын бүсийн цэгүүдийн байрлалын талаар



Зураг 9. Ажлын хэсэг

зөвлөлдөж хамгаалалтын бүсийн эргэлтийн цэгүүдийг 2 долгионы GPS –ээр газар дээр нь тогтоон, хамгаалалтын бүсийн эргэлтийн цэг газарт бэхлэх ба кадастрын зураглалыг 7 цэгээр хийж, 2303955.0 квадрат метр тогтоов.

“Хувилгаан газар” ХХК нь Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сум нутаг дахь Уушиг уулын өврийн буган чулуун хөшөөний цогцолбор газрын хамгаалалтын бүсийн кадастрын зураглал хийхээр Соёлын Өвийн Үндэсний төвтэй

гэрээ байгуулж, энэ гэрээний дагуу 2019 оны 09 сарын 15 –ны өдөр ажил гүйцэтгэв.

Манайд өмнө нь өгсөн мэдээллээр тус газрын хамгаалалтын бүсийн кадастрын зураглал хийнэ гэсэн бол газар дээр очиход хамгаалалтын бүсийн эргэлтийн цэг газарт бэхлэх ба кадастрын зураглал хийгдэх ажлууд байв (Зураг 10, 11).




Зураг 10. Хиргисүүр булшны харагдах байдал

Ажлын хэсэг:

Дурсгалт газар дээрээс орчны байдалтай танилцаж ажлын хэсгийн өмнө нь тогтоосон соёлын өвийн хамгаалалтын бүсийн цэгүүдийн байрлалын талаар зөвлөлдөж хамгаалалтын бүсийн

эргэлтийн цэгүүдийг 2 долгионы GPS –ээр газар дээр нь тогтоов. Ажлын хэсэг орчны байдлыг нягталсны үндсэн дээр №7 цэгийн байрлалыг шинэчилж цогцолборын баруун хойт талын толгойн шилд болгож өөрчлөв. Үүний дараа “Хувилгаан газар” ХХК нь эргэлтийн цэгүүдийг газарт бэхэлж цэгүүд дээр 2 долгионы GPS –ээр /GPS SOKKIA GSR2700 IS, Serial no.NZH 06260042 NSH06260024 NZH 06260006/ хэмжилтийг хийв.

Эргэлтийг цэгүүдийг газарт бэхлэхдээ 1 урттай төмөр хоолойн дээш гарах хэсэгт 25x30 см харьцаатай хавтгай төмөр пайз бэхэлж /гагнаж/ төмөр хоолойн 70 см – ийг газарт суулгаад хоолойн тойронд 30x30x15 см харьцаатай нүхэнд цемент цутгаж бэхэлсэн болно. Газраас дээш гарсан хэсэгт гагнасан төмөр пайз дээр “ СӨ хам.бүс 1” гэсэн бичгийг цоолборлож цагаан өнгийн будгаар бичсэн болно. Ийнхүү нийт 7 цэг газарт суулгаж бэхлэв. Тайлбар:



Зураг 11. Буган чулуу цогцолборын тойм зураг

- СӨ – Соёлын өв
- хам.бүс – Хамгаалалтын бүс
- 1 –тоо нь цэгийн дугаар болно



Зураг 12. 1-р цэг ойроос, холоос

1 цэг: Цогцолборын хашаанаас хойш 1,2 км орчимд уулын шил дээр байрлана (Зураг 12). Цэгийн координат

X	Y
5501632.408	567034.567
49° 39' 48".60	99° 55' 44".04



Зураг 13. 2- цэг ойроос, холоос

2 цэг: Цогцолборын хашаанаас чанх хойш 800 м орчимд толгойн шилд байрлана (Зураг 13 ). Цэгийн координат

X	Y
5501892.391	566475.630
49° 39' 57".24	99° 55' 16".32



Зураг 14. 3-р цэг ойроос, холоос

3 цэг: Цогцолборын хашаанаас зүүн хойш 650 м орчимд байрлана ( Зураг 14 ). Цэгийн координат



X	Y
5501391.755	567355.128
49° 39' 40".68	99° 55' 59".88



Зураг 15. 4-р цэг ойроос, холоос

4 цэг: Цогцолборын хашаанаас зүүн урагш 230 м автозамын хойно байрлана ( Зураг 15). Цэгийн координат

X	Y
5500545.746	567279.004
49° 39' 13".32	99° 55' 55".56



Зураг16. 5-р цэг ойроос, холоос

5 цэг: Цогцолбороос зүүн урагш 615 м авто замын хойно байрлана ( Зураг 16). Цэгийн координат

X	Y
5500290.577	566423.068
49° 39' 05.40"	99° 55' 12.72"



Зураг 17. 6-р цэг ойроос холоос

6 цэг: Цогцолбороос зүүн зүгт 1.8 км орчимд байрлана ( Зураг 17). Цэгийн координат

X	Y
5500215.958	565774.236
49° 39' 03.24"	99° 54' 40.32"



Зураг 18. 7-р цэг ойроос, холоос

7 цэг: Цогцолбороос зүүн хойш толгойн ар шилд 1,6 км орчимд байрлана ( Зураг 18). Цэгийн координат

X	Y
5501225.303	565372.434
49° 39' 36.08"	99° 54' 20.89"



Зураг 19. 2 долгионы GPS багажаар эргэлтийн цэгийг тогтоох хэмжилт хийж байна

Энэхүү тайланд соёлын өвийн цогцолборын газрын хамгаалалтын бүсийн кадастрын зураг, эргэлтийн цэг газарт бэхэлсэн акт, Хувилгаан газар ХХК – ны улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбарыг хавсаргав.


Хавсралт 5  
Уушигийн өврийн буган чулуун хөшөөний цогцолборын кадастрын зураг

УУШИГ УУЛЫН ӨВРИЙН БУГАН ЧУЛУУН ХӨШӨӨНИЙ ЦОГЦОЛБОРЫН ХАМГААЛАЛТЫН ЗУРВАС  
ЭЗЭМШИЖ БАЙГАА ГАЗРЫН БАЙРШЛЫН КАДАСТРЫН ЗУРАГ

Хаяг: Хөвсгөл аймаг, Бүрэнгогтох сум, Туяа баг, Уушиг уулын өвөр

Огноо: 2019-10-16  
Хашааны координат: Талбайн хэмжээ: 2303954.9 квадрат метр

Дугаар	X	Y	Өндөр	Урт	Цэвүүд
1	5501892.391	566475.630	0.000	616.44	1-2
2	5501632.408	567034.567	0.000	400.84	2-3
3	5501391.755	567355.128	0.000	849.43	3-4
4	5500545.746	567279.004	0.000	893.16	4-5
5	5500290.577	566423.068	0.000	653.11	5-6
6	5500215.958	565774.238	0.000	1086.38	6-7
7	5501225.303	565372.434	0.000	1289.20	7-1



Зураг үйлдсэн:  
ГХБХБГ-ын геодезийн мэргэжилтэн  
Ц.Бямбагэр  
3 Нямбайр

Хянасан: ГУХ-ын дарга

2.2.Архангай аймгийн Өндөрүлаан сумын Их жаргалантын амны буган чулуун хөшөөний цогцолбор, Ихтамир сумын нутагт орших Тайхар чулууны кадастрын хэмжилт хийж, улсын бүртгэлд бүртгүүлсэн тухай тайлан

Архангай аймгийн Өндөрүлаан сумын Их Жаргалантын амны буган чулуун хөшөөний цогцолбор, Ихтамир сумын Тайхар чулууны хамгаалалтын бүсийг тогтоож, кадастр улсын бүртгэлд бүртгүүлэх ажлыг 2019 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс 22-ны хооронд газар дээр нь зохион байгуулан ажиллаа.

Зохион байгуулах бүрэлдэхүүнд СӨҮТ-ийн Соёлын өвийг авран хамгаалах газрын дарга Г.Анхсанаа, Газарзүйн мэдээллийн ажилтан С.Баасандорж Мэдээллийн технолои, аюулгүй байдалын газрын систем хөгжүүлэгч П.Чинбат, нар ажиллав.

Эхний дурсгалт газар болох Архангай аймгийн Өндөр-Улаан сумын нутагт орших Их Жаргалантын буган чулуун хөшөөний цогцолбор, Ихтамир сумын нутагт орших Тайхар чулуунд Архангай аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн Б.Билэгт, аймгийн ГХБХБГ –ын газрын удирдлагын хэлтсийн дарга Г.Рэнцэндорж, аймгийн захирал Т.Мөнхбүрэн, сан хөмрөгч Б.Баатархүү, Өндөр-Улаан сумын засаг дарга Б.Эрдэнэхүү, Их-Тамир сумын ЗДТГ-ын дарга н.Нямжаргал болон “Агдам” ХХК –ны инженер Б.Отгонцэрэг, Д.Гансүх нар оролцов (Зураг 1).

Бид Их Жаргалантын буган чулуун хөшөөний цогцолбор дээрээс орчны байдалтай танилцаж ажлын хэсгийн өмнө нь тогтоосон соёлын өвийн хамгаалалтын бүсийн цэгүүдийн байрлалын талаар зөвлөлдөж хамгаалалтын бүсийн эргэлтийн



Зураг 1 Ажил эхлэх үе

цэгүүдийг 2 долгионы GPS –ээр газар дээр нь тогтоон, хамгаалалтын бүсийн эргэлтийн цэг газарт бэхлэх ба кадастрын зураглалыг 13 цэгээр хийж, 87 га-аар тогтоов. Ихтамир сумын нутагт орших Тайхар чулуунд хамгаалалтын хил татах ажилын явцад тухайн дурсгалт газарт байрлаж буй аж ахуй нэгж газартай харилцан тохиролцож хамгаалалтын бүс татах тал дээр сумын удирдалгуудтай хэлэлцэж байна.

“Соёлын өвийн үндэсний төвийн” захиалгаар Архангай аймаг Өндөрүлаан сумын Хануй баг Их жаргалантын ам буган чулууны цогцолборт хамгаалалтын бүсийг тогтоох кадастрын зураглалыг “Агдам” ХХК нь 2019 оны 09 сарын 17-ний өдөр хийж гүйцэтгэлээ. Энэ ажлыг “Агдам” ХХК-ны захирал Л.Баасансүрэн, инженер Г.Гансүх нарын бүрэлдэхүүнтэй 1 авто машинтай гүйцэтгэсэн болно (Хүснэгт 1).

Гүйцэтгэсэн ажлын тоо хэмжээ

Хүсэгт №1

№	Ажлын төрөл	Хэмжих нэгж	Ажлын хэмжээ
1	Хуучин цэгийн судалгаа	цэг	2
2	Кадастрын зураглалын талбай	га	86.8
4	Зургийн боловсруулалт	га	86.8

Дээрх нэр төрлийн ажлуудыг Монгол улсад мөрдөж буй Геодези, газрын зураглалын ажлын норм дүрэм зааврын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Геодези, байр зүйн зураглалын ажилд дараах багаж тоног төхөөрөмжүүдийг ашиглав. Үүнд:

- Trimble R7 маркын 2 долгионы GPS-ийн хүлээн авагч 1 ком
- Dell фирмийн notebook 1 ш
- GARMEN маркын гар GPS 1 ш
- Epson stylus Photo 1390 өнгөт принтер 1 ш
- Forester маркын авто машин 1 ш

Уг ажлыг доорхи техникийн шаардлага, заавар, стандартыг баримтлан

гүйцэтгэсэн. Үүнд:

- Геодези, зураг зүйн тухай Монгол Улсын Хууль (1997 он)
- ХИЙМЭЛ ДАГУУЛ (GPS/Глонасс)-ын технологиор Монгол Улсын геодезийн сүлжээг байгуулах үндсэн дүрэм (ГХГЗЗГ, 2008 он)
- 1:5000, 1:2000, 1:1000, 1:500-ны масштабтай байр зүйн зураглалын ажлын заавар (ГХГЗЗГ, 2008 он)
- 1:5000, 1:2000, 1:1000, 1:500-ны масштабтай байр зүйн зургийн томъёолсон тэмдэг (УГЗЗГ, 2001 он)
- Геодезийн цэг тэмдэгт байгуулах ажлын заавар 1984 он
- Геодезийн ажлын аюулгүйн техникийн дүрэм (УГЗЗГ, 1976 он)
- TX mapper программын объектийн сангийн лавлах (Гантөгс, 2005)

Хуучин цэгийн судалгаа: Зураглалын ажлыг Өндөрүлаан сум Хануй баг ПЦ 062 тоот геодезийн сүлжээний цэгт тулгуурлан гүйцэтгэсэн ( Хүснэгт 2). Тус цэг нь 2009 онд Улсын төсвийн захиалагт ажлын хүрээнд Геокад ХХК-ны суулгаж цэг тэмдэгтийн хувийн хэргийг үйлдэн улсын нэгдсэн санд хүлээлгэн өгсөн байна Уг цэгийг гар GPS-ийн тусламжтай хайж олсон.

Хуучин цэгийн солбицол, өндрийн жагсаалт

Хүсэгт №2

Д/д	Цэгийн дугаар	Солбицол				Цэгийн өндөр
		UTM47N		Geodetic		
		X	Y	B (N)	L (E)	
1	Өндөр-улаан сум ПЦ-062	5333961.370	652529.400			1636.534

Хэмжилт зураглал: Хэмжилт зураглалын ажлыг Кадастрын зураглалын ажил БНБД 11-11-16 норм дүрмийн дагуу хийж гүйцэтгэлээ. эргэлийн цэгүүдийн UTM координат /Хүснэгт 3/, кадастрын зураглал /Хавсралт 1/, тус тус хавсаргав. Зураглалыг Trimble R4 маркын GPS-ийг ашиглан гүйцэтгэсэн. Зураглалд Монгол улсад баримтлаж буй “UTM” тэгш өнцгийн солбицолын системийг тулгуур болгон ашигласан ба тусгагийн өгөгдлүүдийг доор үзүүлэв.

Суурь эллипсоид WGS-84  
Тусгаг UTM Zone47

Зураглалд Trimble R4 маркын ком GPS-ээр хэмжилтийг хийсэн.

*Trimble R4 GPS-ийн техникийн үзүүлэлт*

- Хиймэл дагуулаас хүлээн авах долгион 24 суваг, долгион L1, L2
- Байршил тодорхойлох нарийвчлал:
  - Статик горимд Байршил  $\pm 5\text{mm} + 0.5\text{ppm}$ 
    - o Өндөр  $5\text{mm} + 1\text{ppm}$
  - Хөдөлгөөнт горимд Байршил  $10\text{mm} + 1\text{ppm}$ 
    - o Өндөр  $20\text{mm} + 1\text{ppm}$
  - RTK горимд Байршил  $10\text{mm} + 1\text{ppm}$ 
    - o Өндөр  $20\text{mm} + 1\text{ppm}$
  - Ажиллах температур  $-40^{\circ}\text{C} - +65^{\circ}\text{C}$

Суурин боловсруулалт: Бид талбайн хэмжилтэндээ тулгуурлан суурин боловсруулалтын ажилд Кадастрын зураглалын ажил БНБД 11-11-16 норм дүрмийн дагуу хийж хээрийн хэмжилтийн объектуудыг кодлон тохирох Layer-үүдэд хийж өгсөн. Зургийн суурин боловсруулалтанд дараахь төрлийн программ хангамжуудыг ашиглан гүйцэтгэсэн.

- GPS боловсруулалтын “TRIMBLE GEOMATICS OFFICE”
- 3 хэмжээст гадаргуу үүсгэх “SDR mapping & design”
- Байр зүйн элементүүдийг таних
- тэмдгээр зурах “TX mapper” ба “ AutoCAD 2007”
- Тайлан бичих, нэгтэх Microsoft Word, PDF merger
- Солбицол хөрвүүлэх Geocalc v3.09

Захиалагчид хүлээлгэн өгсөн материал:

1. Техникийн тайлан хэвлэмэлээр 1%
2. Кадастрын зураглал хэвлэмэлээр 1%
3. Байршлын тойм зураг хэвлэмэлээр 1%

Дурсгалт газар дээрээс орчны байдалтай танилцаж Ажлын хэсгийн өмнө нь тогтоосон соёлын өвийн хамгаалалтын бүсийн цэгүүдийн байрлалын талаар зөвлөлдөж хамгаалалтын бүсийн эргэлтийн цэгүүдийг 2 долгионы GPS –ээр газар дээр нь 13 цэг тогтоов ( Цэгийн координат Хүснэгт 3 ).

Хүсэгт №3

	X	Y
1	5337188.676	655108.448
2	5337362.302	654947.519
3	5337497.246	655003.383
4	5337597.007	655124.012

5	5337791.874	655203.688
6	5337936.510	655207.443
7	5338220.867	655437.494
8	5337935.966	656003.207
9	5337815.351	656065.993
10	5337582.549	656094.703
11	5337106.407	655765.413
12	5336990.237	655582.587
13	5337116.729	655326.170

Их жаргалатын ам буган чулуу цогцолбор бүхий дурсгал: Өндөрүлаан сумын Хануй баг Их жаргалантын ам буган чулууны цогцолборын ерөнхий зураг (зураг 5, 6) болон хамгаалалтын цэг суулгаж байгаа байдал. Цэг суулгалтыг Өндөрүлаан сумын ард иргэд болон сумын соёлын төвийн ажилчид газар дээр GPS-ээр байрлалыг тогтоож өгсөн дагуу суулгав ( Зураг 3).



Зураг 2. Цэг суулгаж буй байдал



Зураг 3. Цэг суулгасны дараа



Зураг 4. Буган чулуу цогцолборын ерөнхий харагдах байдал



Зураг 5. Буган чулуу цогцолборын дээрээс харагдах

Тайхар чулуу: Тус дурсгалт газрын соёлын орон зайг тооцон, кадастрын хэмжилтийг хийхэд, сумаас урьд нь дурсгалын өмнө хэсэгт хэд хэдэн аж ахуй нэгжид газар олгосон нь давхардаж байв. Дээрх аж ахуй нэгжүүд нь Тайхар чулууны өмнө янз бүрийн зориулалт бүхий байгууламж барьсан нь дурсгалыг эх төрхийг алдагдуулж, соёлын орон зайг халхалж байсан тул бид энэ асуудлыг Ихтамир сумын удирдлагуудад танилцуулж, тэдгээр барилга, байгууламжуудыг




холдуулахаар Архангай аймгийн Соёл, урлагийн газар (Б.Билэгт), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Г.Рэнцэндорж)-нартай тохиролцон, албан бичгээр хандахаар боллоо (Хавсралт 4).




Зураг 6. Тайхар чулуу хамгаалалтын цэг тавив




Зураг 7. Тайхар чулуу хамгаалалтын цэг тогтоов



Зураг 8. Тайхар чулуу



Архангай аймгийн Өндөрүлаан сумын Хануй баг Их жаргалантын ам буган чулууны цогцолборын хамгаалалтын кадастрын зураг



Архангай аймгийн Ихтамир сумын нутаг Тайхар чулуу хамгаалалтын  
хил татах бүдүүвч зураг



ТАЙЛАН БИЧСЭН:  
Г.АНХСАНАА.СОЁЛЫН ӨВИЙГ АВРАН ХАМГААЛАХ  
ГАЗРЫН ДАРГА

### 1.3. Соёлын өвийг хамгаалах арга зүй, мэдлэг олгох, сурталчлах ажил

#### “СОЁЛЫН ӨВИЙН МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ” СЭТГҮҮЛИЙГ ХЭВЛЭН НИЙТЛҮҮЛСЭН ТАЛААР

Үр дүнгийн гэрээнд тусгагдсаны дагуу соёлын өвийг хамгаалах, мэдлэг олгох, сурталчлах хүрээнд 2019 оны II ба III дугаар улиралд “Соёлын өвийн мэдээ, мэдээлэл” сэтгүүлийн эхийг бэлтгэх ажлыг хийж гүйцэтгэлээ. Байгууллагын хөрөнгө, санхүүгийн асудлаас шалтгаалан 2014 оноос хойшхи хугацаанд сэтгүүлийг хэвлэх асуудал хэсэг засвсардсаны эцэст 2019 онд хэвлүүлэн нийтлүүлэв.

“Соёлын өвийн мэдээ, мэдээлэл” сэтгүүлээрээ дамжуулан соёлын биет болон биет бус өвийн бүртгэн баримтжуулалт, хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалтын хүрээнд хийгдсэн ажлууд, мэргэжил, арга зүй, танин мэдэхүйн мэдээ, мэдээллийг хэвлэн нийтэлж олон нийтэд хүргэдэг билээ.



2019 оны дугаарт 2014 оноос хойш тус үндэсний төвийн үйл ажиллагааны хүрээнд 21 аймаг, нийслэлийн хэмжээнд хийж гүйцэтгэсэн соёлын өвийг хадгалж хамгаалах олон арван томоохон ажлуудыг тоймлон хэвлэн нийтэлсэн болно. Тухайлбал: 2015 онд улсын хэмжээнд анх

удаа явагдсан түүх, соёлын үл хөдлөх дурсгалын үзлэг, тооллогын дүн мэдээ, Дорнод аймгийн нутаг дэвсгэр дэх “Хэрлэн барс”-ын цамхаг, “Их бурхант” цогцолбор зэрэг дурсгалын сэргээн засварлалтын ажлууд, ЮНЕСКО-гийн Дэлхийн өвийн Жагсаалтад бүртгэгдсэн Монгол Улсаас соёлын ангиллаар Бурхан Халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутгийн талаар, 2018 онд зохион байгуулагдсан “Нүүдэлчин Монгол” Соёлын биет бус өвийн улсын анхдугаар их наадам зэрэг улс орны хэмжээнд зохион байгуулсан, хэрэгжүүлсэн үйл ажиллагаанууд болон соёлын биет өвийн сэргээн засварлалт, соёлын өвийн бүртгэл, баримтжуулалтын холбогдолтой мэргэжил арга зүй, танин мэдэхүйн талаар мэдээ өгүүлэл зэрэг орсон байна.

Соёлын өвийг хамгаалах үйл ажиллагааны талаар 13 өгүүлэл, сэргээн засварлалтын талаар 6 өгүүлэл, мэргэжил арга зүйн 5 өгүүлэл тус тус энэ удаагийн дугаарт хэвлэгдсэн байна. Үүнд:

- Мэндчилгээ. *Г.Энхбат*
- Соёлын өвийн үндэсний төвийн тухай

Соёлын өвийг хамгаалах талаар хийгдсэн ажлуудын тухай:

- Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын үзлэг, тооллого-2015. *Г.Анхсанаа*
- Дэлхийн өв-Бурхан халдун уул, түүний хүрээлсэн тахилгат газар нутгийн хадгалалт, хамгаалалтын асуудал. *Г.Бүрэнтөгс*
- “Чулуун соёлын өв” үндэсний хөтөлбөрийн танилцуулга. *Г.Анхсанаа*
- Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын эрсдэлийн судалгаа. *Г.Энхбат*
- “Монгол Алтайн нурууны хадны зургийн хадгалалт, хамгаалалт” хээрийн бүртгэл, судалгаа. *Г.Анхсанаа*
- Соёлын өвийн хамтын ажиллагаа- Дурсгалт уран барилгын гурван хэмжээст зураглал, бүртгэл баримтжуулалт. *Г.Бүрэнтөгс*
- Соёлын биет өв - 3D бүртгэл баримтжуулалт. *П.Чинбат*
- Виртуал музей. *Н.Энхбаяр*
- Дэлхийн өвд бүртгэгдсэн Соёлын биет бус өвүүд. *Ц.Жаргалсайхан*
- Нүүдэлчин монгол, Соёлын биет бус өвийн Их Наадам-2018. *Ж.Насанжаргал*
- Соёлын биет бус өвийн үндэсний хөтөлбөр батлагдлаа. *Ж.Насанжаргал*
- Зүүн бүсийн Соёлын биет бус өвийн өвлөгдөл ба гээгдлийн судалгаа (Хэнтий, Дорнод аймаг). *Ж.Насанжаргал*
- Соёлын биет бус өвийн эрсдэлийн судалгаа. *А.Саруул*

Соёлын өвийг сэргээн засварлалтын тухай:

- “Хэрлэн барс”-ын Цамхагийн бэхжүүлэлт, сэргээн засварлалт. *С.Чинзориг*
- Шороон бумбагарын бунхант булшны ханын зургийг хувилав. *Г.Нямдорж, А.Мөнгөнцоож*
- Үзүүр гялангийн хадны оршуулгын олдворын сэргээн засварлалт. *Б.Мягмарсүрэн*
- Шүдэн уулын олдворын сэргээн засварлалт. *О.Оюунчимэг*
- Археологийн органик эдлэлд терхалос сахарын ашиглах нь. *Д.Даваадарь*
- “Их бурхант”-ын сэргээн засварлалт. *Н.Жамбал*

Мэргэжил, арга зүй

- Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл ба мэдээллийн сан бүрдүүлэлт (Соёлын төвийн ажилтнуудад зөвлөмж) *Д.Нарантуяа*
- Баримтат өвийн тухай. *Ш.Энхтуяа*
- Соёлын өвийн хадгалалт, хамгаалалт- мэргэжил, арга зүйн сургалт (2014-2018 он). *Ц.Цолмон*
- “Монгол цоожны гайхамшиг” төслийг амжилттай хэрэгжүүллээ. *Б.Алтансүх*

Танин мэдэхүй, мэдээллийн булан

Мартагдаж буй өв - Цахиур буу. *Ц.Жаргалсайхан*

Сэтнүүлийн арын хуудсанд дээрх өгүүлүүдийн англи хэлний хураангуй болон Соёлын өвийн үндэсний төвөөс эрхлэн гаргасан номын тухай мэдээллийг хавсаргалаа.

2019 оны сэтгүүлийн дугаарыг тус үндэсний төвийн Соёлын өвийн бүртгэл, судалгааны газрын даргын үүргийг орлон гүйцэтгэгч Д.Нарантуяа, Мэдээлэл, технологийн газрын систем хөгжүүлэгч П. Чинбат нар эрхлэн, хэвлэх ажлыг зохион байгуулан ажилласан. Англи хэлний хураангуйг Соёлын өвийн бүртгэл, судалгааны газрын дарга М.Цэцэнбилэг орчуулан гүйцэтгэв.



чулууд, Үзүүр цохионы хадны зураг, Хажуу нуурын буган чулуун хөшөөд, Өглөгчийн хэрэм, Баянголын амны хүн чулуун хөшөө, Дуган хадны өврийн чулуун зам зэрэг дурсгалуудыг хамрууллаа.

Хоёрдугаар бүлэгт Биндэр уулын чухал хэсэг болох Рашаан хадны зураг, тамга тэмдэг, бичээс бүхий хэсгүүдийг нарийвчлан шинжлэж, бүртгэн баримтжуулалт хийсэн үр дүнг оруулав.

Гуравдугаар бүлэгт Биндэр уул орчмын түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалтын талаар хийсэн зарим ажлын үр дүнг оруулав. Үүнд, Биндэр уул орчимд хамгааллын бүс тогтоосон тухай, Рашаан хаданд хийсэн багажит дүн шинжилгээний судалгааны тойм, болон 3D баримтжуулалтын талаар өгүүлсэн болно.

ТАЙЛАН БИЧСЭН:

Г.АНХСАНАА.СОЁЛЫН ӨВИЙГ АВРАН

ХАМГААЛАХ ГАЗРЫН ДАРГА

-----oOo-----

**1.4. Улс, аймгийн музейн гадаад, дотоод орчны хадгалалт хамгаалалт ба соёлын өвийн БМСангийн бүрдүүлэлтэд арга зүйн зөвлөлгөө өгөх.**

**ТӨВ, ДОРНОД, СҮХБААТАР АЙМАГТ СОЁЛЫН  
ӨВИЙН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН САН БҮРДҮҮЛЭЛТ  
БОЛОН ОРЧНЫ ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТЫН НӨХЦӨЛ БАЙДАЛД  
ҮЗЛЭГ ХИЙЖ, АРГА ЗҮЙГЭЭР ХАНГАН АЖИЛЛАСАН ТУХАЙ ТАЙЛАН**

2019.10.29

Улаанбаатар хот

Соёлын өвийн үндэсний төвийн 2019 оны бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээний 1.4-т заасны дагуу 2019 оны 10 дугаар сарын 23-наас-27-ны өдрүүдэд Төв, Дорнод, Сүхбаатар аймаг болон музейн бүртгэл, мэдээллийн сангийн бүрдүүлэлт болон музейн орчны хадгалалт, хамгаалалтын нөхцөл байдалд үзлэг хийх ажлыг Д. Нарантуяа /Соёлын өвийн бүртгэл, судалгааны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч/, П. Чинбат /Мэдээлэл, технологийн газрын систем хөгжүүлэгч/, Ж. Насанжаргал /Соёлын өвийн бүртгэл, судалгааны газрын соёлын биет бус өв хариуцсан бүртгэл, мэдээллийн санч/, Г. Ууганчимэг /Соёлын биет өвийг сэргээн засварлах газрын сэргээн засварлагч/, Т. Даваа-Очир /Мэдээлэл, технологийн газрын зураглаач/ нар гүйцэтгэлээ.

№	Ажилласан хугацаа	Байгууллага
1	2019.10.23	Төв аймгийн музейд
2	2018.10.23-25	Дорнод аймгийн музейд
3	2018.10.25-27	Сүхбаатар аймгийн музейд

“Соёлын өвийг хамгаалах тухай хууль”, “Музейн үйл ажиллагаанд тавих шаардлага Монгол Улсын стандарт /MNS5634:2006/”, “Монгол Улсын музейн сан хөмрөгийн дүрэм”, “Музейн үзмэрийг хадгалж хамгаалах заавар”, “Соёлын өвийн улсын бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх, уг санд бүртгэх журам”, “Музейн сан хөмрөгийг бүртгэн баримтжуулах заавар”-ын холбогдох заалтуудыг мөрдлөг болгон Соёлын өвийн үндэсний төвийн захирлын баталсан удирдамжийн дагуу үзлэг хийж, мэргэжил арга зүйн зөвлөмж өгч хангахад ажиллав.

**I. СОЁЛЫН ӨВИЙН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН САН БҮРДҮҮЛЭЛТИЙН ТАЛААР:**

**I.1. Төв аймгийн болон музейн соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэлтийн байдал:**

Тус музейд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20.1.1, 20.1.3-т заасан тогтолцооны дагуу соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэлтийг ханган, үзмэр, эд өлгийн зүйл, аймгийн нутаг дэвсгэр дэх үл хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл, соёлын биет бус өвлөгчдийн бүртгэл, гэрэл зураг, дүрс бичлэг зэрэг мэдээллийг цаасан болон цахим хэлбэрээр бүрдүүлэн ажиллаж байна. /Хавсралт №1/

Бүртгэл, мэдээллийн сан тусдаа өрөөтэй, соёлын биет ба биет бус өвийн бүртгэлүүдийг төрөлжүүлэн сейф шүүгээнд хадгалж байгаа нь цуглагдсан соёлын



биет ба биет бус бүртгэл, мэдээллийг архивлан хадгалах боломж нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Бүртгэл, мэдээллийн санчийн ажлын компьютерийг зөвхөн соёлын өвийн бүртгэл, баримтжуулалтын зориулалтаар албан хэрэгцээнд ашигладаг. Бүртгэл, мэдээллийн сангийн компьютерийг 1 сарын өмнө форматласнаас RCH бүртгэлийн програм ажиллахаа больсон гэв. Цахилгааны эрсдлээс сэргийлсэн тог баригч байхгүй.

Үзмэр, эд өлгийн зүйлийн бүртгэл, баримтжуулалтад “Музейн сан хөмрөгийг бүртгэн баримтжуулах заавар”-ын ББЗМ1-ББЗМ8 хүртэлх маягтуудыг хангалтгүй үйлдсэн, цахим хэлбэрээрээ байгаа зэрэг учир дутагдалтай байна.

Аймгийн БМСанд соёлын биет ба биет бус өвийн цахим мэдээлэл харьцангуй ихээр цуглагдсаныг найдвартай хадгалах хэрэгцээ, шаардлага үүсч байна. Соёлын биет ба биет бус өвийн бүртгэл, мэдээллийг компьютер дээр эсхүл CD, DVD зэрэг тусгай тээгч дээр голдуу 1 хувь хадгалж байна. Музейн төсөвт бүртгэн баримтжуулалтын зардал гэж байхгүй, бусад зардлаасаа зохицуулдаг тухай тайлбарыг өгч байсан.

CD, DVD-ны гэр хайрцагны дээр хаягжуулаад дотор нь байгаа CD, DVD дээрээ бичигдээгүй байгаа зэрэг нь учир дутагдалтай байна нь цаашид CD, DVD сольж холигдох, андуурах байдал үүсгэх тул:

- Архивын дүрэм журмын дагуу CD, DVD-ны нүүрэн хэсэг болон түүнийг хадгалж байгаа гэр хайрцагт нэгэн ижил хаягжуулах, товъёогжуулах,
- Соёлын биет ба биет бус өвийн бүртгэл, мэдээллийг хадгалж буй цахим тээгчдийг ажлын хэрэгцээний болон мастер хувь гэж 2 % хувилан хадгалах шаардлагатайг,
- Цахим файлаа найдвартай байнга хадгалах зориулалтаар музей болон аймгийн БМСангийн хэмжээнд “SATA”, “NAS storage” зэрэг тоног төхөөрөмжтэй болохыг,
- 2012 оноос хойшхи музейн сан хөмрөгт шинээр авсан үзмэрүүдэд ББЗМ1-ББЗМ7 дагуу бүртгэлээ нөхөн бүрдүүлэн хийхийг тус, тус зөвлөсөн.

БМСангийн цаасан суурьтай болон цахим хэлбэрийн бүртгэлүүдэд архивын дүрэм, журмын дагуу товъёогжуулалт бүрэн бус хийгдсэн байх тул Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20.8; 21.2 дахь заалтууд; Музейн сан хөмрөгийг бүртгэн баримтжуулах зааврын 4.1-д заасны дагуу мэдээллийн сан бүрдүүлэх, уг санд цуглагдсан бүртгэл, мэдээллийн бүрэн бүтэн байдлыг хангаж, эмх цэгцтэй хадгалахад бүртгэлийн товъёог хийх шаардлагатайг тус тус зөвлөсөн.

#### 1.2. Дорнод аймгийн болон музейн соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэлтийн байдал:

- Тус музейд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20.1.1, 20.1.3-т заасан тогтолцооны дагуу соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэлтийг ханган ажиллаж байна. /Хавсралт №2/
- Зохиж журмын дагуу үзмэр, эд өлгийн зүйл, аймгийн нутаг дэвсгэр дэх үл хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл, соёлын биет бус өвлөгчдийн бүртгэл, гэрэл

зураг, дүрс бичлэг зэрэг мэдээллийг цаасан болон цахим хэлбээрээр бүрдүүлж байна.

- БМСангийн бүртгэл, мэдээллүүдийг тусгайлсан өрөө байхгүй өрөө тасалгааны багтаамжаас хамааран нарийн бичгийн өрөөнд, төмөр шүүгээ сейфэнд хадгалдаг. Сейфний түлхүүрийг тусад нь шүүгээнд хадгалдаг.

- Тус музей нь Бүртгэл, мэдээллийн санч нь музейн болон аймгийн бүртгэл, мэдээллийн хариуцахын зэрэгцээ музейнхээ бичиг хэрэг, нарийн бичгийн дарны үүргийг хавсарган гүйцэтгэдэг байна.

- “Монгол Улсын түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл” буюу RCH програмын бүртгэл бүрдүүлэлтэд сэргээн засварлагдсан, хуулбарласан, үзэсгэлэнд оролцсон зэрэг шилжилт хөдөлгөөнтэй холбоотой нэмэлт баяжуулалт мэдээллүүдийг бүртгэлд цаг тухай бүрд нь нэмж оруулж байхыг;

- БМСангийн цаасан суурьтай болон цахим хэлбэрийн соёлын биет ба биет бус өвүүдийн бүртгэлийг сум сумдаар нь хавтасжуулан архивын дүрэм, журмын дагуу товъёогжуулалт хийгдсэн, улам сайжруулах шаардлагатай нь харагдаж байв.

- Цахим файлуудыг тусгай тээгчид хадгалах тусгай тоног төхөөрөмж хүртээмж муутай, бүртгэн баримтжуулалтад зориулсан төсөв байдаггүй тул бичиг хэргийн зардлаасаа зохицуулан хэрэгжүүлж байгаагаа тайлбарлан хэлж байв.

-2019 онд тус аймагт музейн шинэ барилгын шав тавигдаж барилгын ажил хийгдэж эхлэсэн ба музейн шинэ барилгадаа БМСанг тусад нь өрөө тасалгаатай байхаар төлөвлөснөө танилцуулав.

### I.3. Сүхбаатар аймгийн болон музейн соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэлтийн байдал:

- Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэлтийг ханган ажиллаж байна.

- “Монгол Улсын түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл” буюу RCH програмын бүртгэл бүрдүүлэлтэд сэргээн засварлагдсан, хуулбарласан, үзэсгэлэнд оролцсон зэрэг шилжилт хөдөлгөөнтэй холбоотой нэмэлт баяжуулалт мэдээллүүдийг бүртгэлд цаг тухай бүрд нь нэмж оруулж байхыг;

- Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 21.2.5 дахь заалт “дотоод, гадаадад гаргасан үзэсгэлэнтэй холбоотой баримт”; Музейн сан хөмрөгийг бүртгэн баримтжуулах зааврын 6.3.9 дэх заалт “Музейгээс гадаад, дотоодод гаргасан үзэсгэлэн” хавтасыг музейн БМСанд бүрдүүлэхийг;

- БМСангийн цаасан суурьтай болон цахим хэлбэрийн бүртгэлүүдэд архивын дүрэм, журмын дагуу товъёогжуулалт бүрэн бус хийгдсэн байх тул Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20.8; 21.2 дахь заалтууд; Музейн сан хөмрөгийг бүртгэн баримтжуулах зааврын 4.1-д заасны дагуу мэдээллийн сан бүрдүүлэх, уг санд цуглагдсан бүртгэл, мэдээллийн бүрэн бүтэн байдлыг

хангаж, эмх цэгцтэй хадгалахад бүртгэлийн товъёог хийх шаардлагатайг тус тус хэлж зөвлөсөн.

- Тус аймаг Аймгийн засаг даргын захирамжаар “Аймгийн бүртгэл, мэдээллийн санч” албан тушаалыг музейд бий болгож орон тоо цалингийн асуудлыг шийдвэрлэн томилон ажиллуулж байна. Мэдээллийн сангийн ажлыг сайжруулахад томоохон дэвшил гарсан байна.

- Бүртгэл, мэдээллийн сангийн бие даасан өрөө тасалгаатай, соёлын биет ба биет бус өвийн холбогдох бүртгэл, мэдээллүүдийг цоожтой лацтай, төмөр сейф шүүгээ нь төрөлжүүлэн хадгалагдаж байна.

#### I.4. Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлсийг дүрс бичлэгээр баримтжуулсан тухай:

Бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэлтэд үзлэг хийх, мэргэжил арга зүйгээр хангах ажлын хүрээнд Засгийн газрын тогтоолоор 2013 оны 227 дугаар тогтоолоор “Монгол Улсын түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалт”-д бүртгэгдсэн Төв аймгийн музейн 1 ширхэг хосгүй үнэт, Сүхбаатар аймгийн музейн 2 ширхэг хосгүй үнэт дурсгалуудыг нийт 01:47:02 минутын 10,63 gb хэмжээ бүхий дүрс бичлэгээр баримтжуулан бүртгэх ажлыг гүйцэтгэн, тухай байгууллагуудын болон СӨУНБМСанд архивлан хадгалах ажлыг гүйцэтгэлээ.

#### Төв ба Сүхбаатар аймгийн музейн хосгүй үнэт үзмэрийн баримтжуулалт

№	Үйл ажиллагаа	Музей	Дүрс бичлэг хийсэн огноо	Хосгүй үнэт үзмэрийн нэр	Бичлэгийн хугацаа	Бичлэгийн хэмжээ
1	Түүх, соёлын хосгүй үнэт хөдлөх	Төв аймгийн музей	2019.10.23	Өндөр гэгээний жирав	00:01:32	2,65 gb
2	дурсгалт зүйлийн дүрс бичлэг	Сүхбаатар аймгийн музей	2019.10.25	Дарьганга эхнэрийн толгойн гоёл	00:21:31	3,68 gb
3	баримтжуулалтын ажил		2019.10.25	Үзмчин толгойн гоёл	00:24:59	4,30 gb
				Нийт	01:47:02	10,63 gb

## 2. МУЗЕЙН ОРЧНЫ ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТЫН ХҮРЭЭНД:

Төв аймгийн музейн барилга нь 1950 оны үед баригдсан учир өнөө цагт хана туурга цуурч хагарсан, 2015 онд гадна, дотор засвар хийсэн байна. Барилгын сууринд өвс ургамал, мод ургасан нь иймд барлагийн сууринд өөрчлөлт, гэмтэл гарах магадлал өндөр байдаг.

Барилгын гадна талаас цан цохиж сууринд чийг тогтсон байна энэ нь яваандаа доод суурьнаасаа мөөгөнцөр үүсгэх аюултай байна.

#### Анхаарах зүйлс:

Үзмэрийн витрин дотор хүчтэй гэрэл байрлуулсан учир үзмэрт фото химийн урвал явагдаж, өнгө алдах механик гэмтэл үүсэх эх үүсвэр болжээ.

Тус музей бусад аймгуудын адил аймгийн музей дээр тухайн аймгийн Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан болон музейн соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санг төвлөрүүлж байна. Сангийн хадгалалтын байдал:

Нэг. Сангийн баримт материалууд музейн хоёр тусдаа өрөөнд байрлах 2 сейфэнд байршуулсан. Ингэхдээ баримтуудыг аймаг, музейн бүртгэл, мэдээллийн сан гэсэн ерөнхий төрөлд ангилаагүй, биет болон биет бус өв, эзэмшигчээр, тусгай тээгчээр нь ялган төрөлжүүлээгүй байрлуулжээ. Нэг өрөөнд нь хүндрүүлэгчтэй 2 сейф байгаа боловч хүндрүүлэгчгүй 1 сейфэнд музейн бүртгэлүүдийг хадгалжээ.



Зураг. 1 Бүртгэл, мэдээллийн сангийн баримтын хадгалалт

Хоёр. Сангийн баримт материалын бүрдлийн хувьд: Орон нутаг судлах танхимын 2008, 2012 оны тооллогын бүртгэлийн зарим нь эх хувиараа, зарим нь хуулбар хувиараа, тооллогын илтгэх хуудсын зарим нь байхгүй. Үзмэрийн гэрэл зураг 2008 оных CD дээр, 2012 оных компьютер, 2018 оных DVD дээр нэг хувь хадгалагдсан. Үл хөдлөх дурсгалын 2015 оны тооллогын бүртгэлийн цаасан нооргоор байгаа ба маягтын дагуу хийгдсэн бүртгэл байхгүй. Дурсгалын гэрэл зураг, тайлан мэдээ БМСангийн компьютерт 1% байна. Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчийн бүртгэл бүрэн бус байдаг. Дуу, дүрс бичлэг мөн компьютерт 1% байна.

Мзейн БМС, ЭША нар соёлын биет бус өв болон үл хөдлөх дурсгалын хувьд бүртгэлийн арга зүй дутагдалтай байдаг тухай хэлж байсан.

Бас нэг асуудал бол сумдын Соёлын төв, ОНСТ музейд бүртгэл, тайлан, мэдээгээ өгөх асуудалд хойрго, тоомжиргүй хандсаар байгаа аж. Үүнийг лавшруулж харвал, төрийн ажилтны зэрэглэл алдагдсан тогтолцооны гажуудал байна. ОНСТ буюу сумдын соёлын төвөөс аймгийн БМСанч тайлан нэхдэг, шаарддаг. Гэтэл Сумын соёлын төвийн эрхлэгч ТҮСУ-5 зэрэглэлд, аймгийн БМСанч ТҮСУ-3 зэрэглэлд хамрагддаг байна.

Музейн бүртгэл, мэдээллийн сангийн баримт байгаа боловч маш эмх цэгцгүй байдалтай. Туайлбал, 1976 оны “Түүх дурсгалын болон урлагийн үнэт ховор зүйлийг бүртгэх дэлгэрэнгүй карт” маягтаар 1970, 1980 оны үед хийсэн 400 ширхэг орчим үзмэрийн бүртгэл задгай эрдэм шинжилгээний ажилтан дээр хадгалагдаж байх жишээтэй.



Зураг 2. Бүртгэл, мэдээллийн сангийн ажилтай танилцаж буй байдал

Анхаарал татсан бас нэг асуудал бол 2019 онд маршил Ю.Цэдэнбалын амьдрал замналаар бүтээж буй “Түүх мартахагүй” киноны зураг авалтад тус музейгээс 61 дэсийн 77 ширхэг нэмж 13 дэсийн 13 ширхэг үзмэр язгуур зориулалтаар нь ашигласан байна. Үүнийг аймгийн удирдлагаас шийдвэрлэсэн учир музейхэн хүчин мөхөсдөж үзмэрийг ашиглуулахаар өөр аргагүйд хүрсэн байна.

#### Музейн үзмэрийн гадаад болон дотоод орчин



Зураг 3. Музейн барилгын гадаад байдал



Зураг 4. Музейн хажууд орших Монгол бичигт хөшөө

Увс аймгийн музей 1948 онд анх байгуулагдаж Харлагбэйсийн өргөөнөө нээгдэж байжээ. 1990 онд баригдсан Номын сангийн байрны 2 давхарт 1995 онд орж үйл ажиллагаагаа явуулж иржээ. 2006 онд Цэдэнбалын мэндэлсний 90 жилийн ойгоор УИХ-ийн гишүүн Ч.Авдай, Ч.Эрдэнэсүрэн нарын санаачлагаар ард түмний хандиваар “Цэдэнбалын музей” байгуулж номын сангийн байртай холбожээ. Уг байр анхнаасаа халаалтгүй баригдсан бөгөөд 2016 онд дулааны шугам тавьсан байдаг ч дулааны алдагдал ихтэй тулд хүйтэн байдаг аж.

Аймгийн музейн нь номын сангийн байрны 2 давхарын бүх цонхыг хааж үзмэрийн танхимыг байгуулсан учир ямарч агааржуулалт байхгүй, Цэдэнбалын музейн хувьд цонхоо онгоолгож агаар сэлгэлт хийдэгч зориулалтыг агааржуулалт байхгүй. Хоёр музейн дулааны шугамнууд ил. Цахилгааны монтажны шинэчлэлийг 2018 онд боломжоороо шийдвэрлэсэн ч ил монтажтай.



Музей нийтдээ дохиолол байхгүй. Бүх үзүүлэгийн танхим, сан хөмрөгтөө камертай боловч сарнилт ихтэй шаардлага хангадашгүй бага тухай музейн ажилтнууд тайлбарлаж байсан. Музейн нэг болон хоёр давхрын бүр цонхнууд хамгаалалт, бэхэлгээ хийгдээгүй, дан вакум цонхтой. Нэг цонх байсныг тоосго өрж битүүлсэн байна.



Зураг 5. Музейн цонхонд хамгаалалт хийгдээгүй



Зураг 6. Сан хөмрөгийн өрөө дан хаалга, цоожтой



Зураг 7. Дулаан, цахилгааны шугмын монтож ил

Энэхүү дулааны алдагдал ихтэй стандарт бус орчноос шалтгаалж музейн дотор орчин дулаан стандартын дагуу 15-18<sup>0</sup>С байхаас дунджаар 26<sup>0</sup>С байгаа нь 10<sup>0</sup>С орчмоор илүү, чийгшил 50-55% байхаас дунджаар 37% байгаа нь 13%-иар бага байна.

№	Музейн орчин	Гэрэлтүүлэг стандарт 50-200 люкс, /Зааварт цаас, даавуу 50, арьс шир, яс, мод 150, шил, металл 500 люкс/	Дулаан стандарт 15-18 <sup>0</sup> С, /Зааварт үзмэрийн танхим 20 <sup>0</sup> С/	Чийгшилт стандартад 50-55% /холимог материал зааварт 35-65%/
1	Сан хөмрөгийн өрөө	104.3	28.3 <sup>0</sup> С	39.5 %
2	Цэдэнбалын танхим	71.5	23.6 <sup>0</sup> С	43.3 %
3	Угсаатны зүйн танхим	164.5	25 <sup>0</sup> С	40.8 %
4	Ургамлын хэсэг	136	26 <sup>0</sup> С	39.4 %
5	Амьтны хэсэг	104.1	26.8 <sup>0</sup> С	39.4 %
6	Шашны танхим	163.7	27.1 <sup>0</sup> С	36.8 %
7	Орчин үеийн танхим	94.2	28.6 <sup>0</sup> С	35.3 %

Стандартад музейн сан хөмрөг барилгын хамгийн аюугүй орчинд байрлах ёстой тухай заасан боловч тус музейн сан хөмрөг шатны харалдаа 2 давхартаа ил задгай орчинд байрласан, агааржуулалт байхгүй, дан модон хаалгатай нь эрсдлийн түвшин өндөр байна.



Зураг 8. Музейн сан хөмрөгийн өрөө

Тус музей Соёлын өвийн үндэсний төвд 2012 онд 4 дэсийн 5 ширхэг үзмэр сэргээн засварлуулахаар явуулж 2013 онд сэргээн засварлуулж авсан. 2017 онд онд 4 дэсийн 6 ширхэг үзмэр сэргээн засварлуулахаар явуулж тус ондоо 3 дэсийн 4 ширхэг үзмэр засварлагдаж, 1 дэсийн 2 ширхэг үзмэр одоогоор ирээгүй байна. Засварласан үзмэрийн ихэнх нь сан хөмрөгтөө байсан бөгөөд 2017 онд сэргээн засварлуулсан “Баяд дээл”-ийг музейн угсаатны зүйн танхимд үзүүлэлт тавьжээ. Гэтэл сэргээн засварлаад 2 жил болоогүй байгаа дээл хажуу хэсгээрээ ханзарч урагдсан байна.



Зураг 9. 2017 онд сэргээн засварлуулсан “Баяд дээл” хажуу хэсгээрээ ханзарч урагдсан

Энэ нь шууд хүндийн шингээр нь өлгүүрт сул байршуулсан, зөөж тээвэрлэх явцаас, сэргээн засварлалтын чанараас алин болохыг тогтоогоогүй ч цаашдаа хэрхэн хадгалах, байруулах талаар заавар зөвлөмж зайлшгүй шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Тус музейн барилгын хувьд номын сантайгаа нэг байранд байрласан, өөрийн гэсэн байргүй. 2006 онд “Цэдэнбалын музей”-н барилга баригдсан ч музейн шаардлага хангахгүй баригджээ.

**ХАВСРАЛТУУД**  
**УВС АЙМГИЙН МУЗЕЙ**

Аймгийн бүртгэл, мэдээллийн сангийн цаасан суурьтай баримтын бүрдэл

Судалгаа хийсэн: Ерөнхий бүртгэл, мэдээллийн санч Ш.Энхтуяа

№	Асуулга	Байгаа эсэх / +, - /	Тайлбар																																																																																
<b>Хөдлөх дурсгалын бүртгэл.</b> “Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хууль” 20.1.3, 20.2, 20.7, 21.2.1, 21.2.4, 31.2.3, 31.2.6, 31.2.7, “Соёлын өвийн Улсын бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэх, уг санд бүртгэх журам” 3.3																																																																																			
1	Орон нутаг судлах танхимын бүртгэл, тодорхойлолт	Үзлэг, тооллогын бүртгэл, баримт	<table style="width: 100%; border-collapse: collapse;"> <thead> <tr> <th style="width: 10%;"></th> <th style="width: 15%;">2008</th> <th style="width: 15%;">2012</th> <th style="width: 15%;">2018</th> </tr> </thead> <tbody> <tr><td>1.Баруунтуруун</td><td>байна</td><td>байна</td><td>байна</td></tr> <tr><td>2.Зүүнхангай</td><td>байна</td><td>байна</td><td>байна</td></tr> <tr><td>3.Өндөрхангай</td><td>байна</td><td>байна</td><td>байна</td></tr> <tr><td>4.Хяргас</td><td>байна</td><td>байна</td><td>байна</td></tr> <tr><td>5.Малчин</td><td>байна</td><td>байна</td><td>байна</td></tr> <tr><td>6.Зүүнговь</td><td>байна</td><td>байна</td><td>байна</td></tr> <tr><td>7.Наранбулаг</td><td>байна</td><td>байна</td><td>байна</td></tr> <tr><td>8.Завхан</td><td>байна</td><td>байна</td><td>байна</td></tr> <tr><td>9.Өлгий</td><td>байна</td><td>байна</td><td>байна</td></tr> <tr><td>10.Өмнөговь</td><td>байна</td><td>байна</td><td>байна</td></tr> <tr><td>11.Ховд</td><td>байна</td><td>байна</td><td>байна</td></tr> <tr><td>12.Сагил</td><td>байна</td><td>байна</td><td>байна</td></tr> <tr><td>13.Давст</td><td>байна</td><td>байна</td><td>байна</td></tr> <tr><td>14.Түргэн</td><td>байна</td><td>байна</td><td>байна</td></tr> <tr><td>15.Улаангом</td><td>ОНСТ</td><td>байхгүй</td><td></td></tr> <tr><td>16.Тариалан</td><td>байна</td><td>байна</td><td>байна</td></tr> <tr><td>17.Тэс</td><td>байна</td><td>байна</td><td>байна</td></tr> <tr><td>18.Цагаанхайрхан</td><td>ОНСТ</td><td>байхгүй</td><td></td></tr> <tr><td>19.Бөхмөрөн</td><td>байна</td><td>байна</td><td>байна</td></tr> </tbody> </table> <p>2008 оны улсын тооллогын бүртгэл, илтгэх хуудас бусад материал байсан. “тоолов” тэмдэг зарим дээр дарагдаагүй, зарим дээр 2008, 2012 дарагдсан. ЕБД-ийн эх хувь ОНСТ дээр байх ёстой боловч зарим нь эх хувиараа музей дээр байна. Зарим сумдын илтгэх хуудас байхгүй.</p> <p>2012 оны ОНСТ-ын илтгэх хуудсыг хадгаламж үүсгэн хадгалсан.</p> <p>2018 оны ОНСТ-ын илтгэх хуудсыг бор хавтсаар хавтасласан боловч баталгааны хуудас байхгүй.</p>		2008	2012	2018	1.Баруунтуруун	байна	байна	байна	2.Зүүнхангай	байна	байна	байна	3.Өндөрхангай	байна	байна	байна	4.Хяргас	байна	байна	байна	5.Малчин	байна	байна	байна	6.Зүүнговь	байна	байна	байна	7.Наранбулаг	байна	байна	байна	8.Завхан	байна	байна	байна	9.Өлгий	байна	байна	байна	10.Өмнөговь	байна	байна	байна	11.Ховд	байна	байна	байна	12.Сагил	байна	байна	байна	13.Давст	байна	байна	байна	14.Түргэн	байна	байна	байна	15.Улаангом	ОНСТ	байхгүй		16.Тариалан	байна	байна	байна	17.Тэс	байна	байна	байна	18.Цагаанхайрхан	ОНСТ	байхгүй		19.Бөхмөрөн	байна	байна	байна
	2008	2012	2018																																																																																
1.Баруунтуруун	байна	байна	байна																																																																																
2.Зүүнхангай	байна	байна	байна																																																																																
3.Өндөрхангай	байна	байна	байна																																																																																
4.Хяргас	байна	байна	байна																																																																																
5.Малчин	байна	байна	байна																																																																																
6.Зүүнговь	байна	байна	байна																																																																																
7.Наранбулаг	байна	байна	байна																																																																																
8.Завхан	байна	байна	байна																																																																																
9.Өлгий	байна	байна	байна																																																																																
10.Өмнөговь	байна	байна	байна																																																																																
11.Ховд	байна	байна	байна																																																																																
12.Сагил	байна	байна	байна																																																																																
13.Давст	байна	байна	байна																																																																																
14.Түргэн	байна	байна	байна																																																																																
15.Улаангом	ОНСТ	байхгүй																																																																																	
16.Тариалан	байна	байна	байна																																																																																
17.Тэс	байна	байна	байна																																																																																
18.Цагаанхайрхан	ОНСТ	байхгүй																																																																																	
19.Бөхмөрөн	байна	байна	байна																																																																																
		“Монгол Улсын түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл” Гэрэл зураг	<p>ОНСТ үзмэрийн бүртгэл</p> <p>2018 онд сумдын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэлийг маягтын дагуу хийлгэж авахын тулд аймгийн МХГазартай хамтарсан албан тоот сумдын ОНСТанхимд явуулсны дүнд 13 сум бүртгэлээ файлаар явуулсан.</p>																																																																																

				Энэ бүртгэл шаардлага хангахгүй тул хэвлээгүй компьютерт байна. -ОНСТ үзмэрийн гэрэл зураг - 2008 оны улсын тооллогын гэрэл зураг 8 сумынх CD дээр 1 хувь, - 2012 оны улсын тооллогын гэрэл зураг бүх 17 сумынх БМС-ийн компьютер дээр байна. - 2018 оны улсын тооллогын гэрэл зураг бүх 17 сумынх БМС-ийн компьютер, DVD дээр хадгалагдаж байна.
2	Шашны байгууллагын бүртгэл, тодорхойлолт	Үзлэг, тооллогын бүртгэл, баримт	-	Аймгийн төвд Дэчинравжаалан хийд /Олон нийтийн өмчлөл/, Наранбуянт хийд, Их амгалант номын хүрдэн хийд гэсэн 3 хийд байдаг. Бүртгэл хийгдээгүй.
		“Монгол Улсын түүх, соёлын хөдлөх дурсалт зүйлийн бүртгэл” Гэрэл зураг	-	“Монгол Улсын түүх, соёлын хөдлөх дурсалт зүйлийн бүртгэл” байхгүй
3	Иргэний өмчлөлд байгаа дурсгалын бүртгэл, тодорхойлолт	“Монгол Улсын түүх, соёлын хөдлөх дурсалт зүйлийн бүртгэл” Гэрэл зураг	-	2017 онд Тэс сумын 3 хүний 4 хөөрөг, 1 хэт хутга, 1 эмээлийг бүртгэлийг хийх ажлыг хийсэн. Уг ажлыг бүрэн дуусгаагүй, батлагдсан маягтын дагуу цаасан бүртгэл хийгээгүй. Тодорхойлсон гар бичмэл болон гэрэл зураг файлаар байна.
4	Эрдэм шинжилгээ байгууллага, хуулийн этгээдийн өмчлөл, эзэмшилд байгаа дурсгалын бүртгэл, тодорхойлолт	Үзлэг, тооллогын бүртгэл, баримт	-	Бүртгэл байхгүй
		“Монгол Улсын түүх, соёлын хөдлөх дурсалт зүйлийн бүртгэл” Гэрэл зураг	-	“Монгол Улсын түүх, соёлын хөдлөх дурсалт зүйлийн бүртгэл”, гэрэл зураг байхгүй
<b>Үл хөдлөх дурсгалын бүртгэл.</b> “Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хууль” 21.2.1, 21.2.2, 21.2.4, 21.2.6, 21.2.7, 21.2.8, 21.2.9, 21.2.11, “Соёлын өвийн Улсын бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэх, уг санд бүртгэх журам” 3.3,				
5	Үл хөдлөх дурсгалын бүртгэл, тодорхойлолт	Үзлэг, тооллогын бүртгэл, баримт	-	2015 оны тооллого 2015, 2016 онд явагдсан. Сумдын дурсгалын бүртгэл /хялбаршуулсан маягтаар/ RICH дээр байгаа, хэвлээгүй. Сумын тайлангууд байхгүй.  2015-2016 тооллогын нэгдсэн тайлан, 2015 оны тайланг тус бүр 2% хийж СӨҮТ-д явуулсан боловч зөвхөн 2015 оны тайлан нь буцаж ирсэн. Нэгдсэн тайлан одоогоор ирээгүй тул байхгүй.

		“Монгол Улсын түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэл” Гэрэл зураг	-	<p>2018 онд сумдын үл хөдлөх дурсгалын бүртгэлийг маягтын дагуу хийлгэж авахын тулд аймгийн МХГазартай хамтарсан албан тоот сумдын ОНСТанхимд явуулсны дүнд 15 сум бүртгэлээ файлаар явуулсан. Уг бүртгэлүүд шаардлага хангахгүй, дутуу хийгдсэн тул 2015 оны тооллогын бүртгэлээс авч баяжуулах ажил хийгдэж байна. Иймээс хэвлэж гаргаагүй байна.</p> <p>Улаангом сумаас зөвхөн “Монгол Улсын түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэл”-ээ хавтаслан ирүүлсэн нь байна.</p> <p>2015-2016 оны улсын тооллогын гэрэл зураг 19 сумаараа БМС-ийн notbook, компьютер, DVD /жигжиг хэмжээтэй/ байна.</p>
6	Үл хөдлөх дурсгалын судалгаа, шинжилгээний ажлын тайлан		+	<p>ШУА-ын Түүх, археологийн хүрээлэн, Соёлын өвийн үндэсний төв. “Увс аймгийн Давст сумын нутгаас илэрсэн хатмал шарил” 2018 оны 1 сар.</p> <p>Монголын үндэсний музей, АНУ-ын Кинтакигийн Их сургууль. Монгол-Америкийн хамтарсан “Баруун монгол” археологийн төслийн 2018 оны хээрийн судалгааны ажлын тайлан. 2018 он.</p>
7	Үл хөдлөх дурсгалын сэргээн засварлалт, хэв хуулбарын ажлын тайлан		-	<p>2019 онд СӨҮТ-тэй хамтарч Сагил суманд оршин улсын хамгаалалтад орсон Цагаан голын эхийн “Можоогийн хадны зураг”-ийн хуулбар, хэв, “Их сар”-ийн хадны зургийн хуулбарыг авсан. Тайлан ирээгүй, ажлын илтгэх хуудас бичигдсэн, хуулбарыг хувилж өгөхөөр тохирсон байна.</p>
<p><u>Соёлын биет бус өвийн бүртгэл. “Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хууль” 21.2.6, 21.2.7, 21.2.9, 21.2.11, “Соёлын өвийн Улсын бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэх, уг санд бүртгэх журам” 3.3</u></p>				
8	Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчийн бүртгэл	Дуу, дүрс бичлэг	+	<p>-2017 онд музейгээс өвлөн уламжлагчийн бүртгэлийг газар дээр нь хийх ажлыг зохион байгуулж Тэс сумын 10 хүний дүрс бичлэгийг хийсэн. /баядын найр эхэлдэг Баянцагаан гэдэг дууг 2 хөгшин дуулсан г.м/</p> <p>-2018 онд музейн БМС-аас Улаангом сумын ерөөлч, магтаалч Б.Жимсийн дүрс бичлэгийг хийсэн.</p> <p>-2018 онд сумдын өвлөн уламжлагчийн бүртгэлийг маягтын дагуу хийлгэж авахын тулд аймгийн МХГазартай хамтарсан албан тоот сумдад явуулж 14 сумдын 240</p>

				орчим өвлөн уламжлагчийн бүртгэл файлаар ирүүлсэн, хэвлээгүй. -Цагаанхайрхан сумын 2 /уртын дууч/ өвлөн уламжлагчийн дүрс бичлэг
		“Монгол Улсын соёлын биет бус өв, түүнийг өвлөн уламжлагчийн бүртгэл” Гэрэл зураг	+	2017 онд музейгээс өвлөн уламжлагчийн бүртгэлийг газар дээр нь хийх ажлыг зохион байгуулсан. Энэ ажлын хүрээнд: -Тэс сумын 10 өвлөн уламжлагчийн бүртгэл, -Малчин сумын 22 өвлөн уламжлагчийн бүртгэл, -Түргэн сумын 11 өвлөн уламжлагчийн бүртгэл, -Хяргас сумын 26 өвлөн уламжлагчийн бүртгэл, -Завхан сумын 4 өвлөн уламжлагчийн бүртгэл, -Цагаанхайрхан сумын 68 өвлөн уламжлагчийн бүртгэл -2018 онд яамнаас ирүүлсэн албан бичгийн дагуу Улаангом сумын 8 дархчуудын бүртгэл хийгдсэн. -Ур чадварын өндөр түвшинд өвлөсөн өвлөн уламжлагч 6 хүн байдаг. Бүртгэл цаасаар байхгүй байгааг анхаарах.
9	Соёлын биет бус өвийн бүртгэл	Дуу, дүрс бичлэг	-	Байхгүй
		“Монгол Улсын соёлын биет бус өв, түүнийг өвлөн уламжлагчийн бүртгэл” Гэрэл зураг	-	Байхгүй

Судалгаа №2

**УВС АЙМГИЙН МУЗЕЙ**  
Музейн бүртгэл, мэдээллийн сангийн цаасан  
суурьтай баримтын бүрдэл

Судалгаа хийсэн: Ерөнхий бүртгэл, мэдээллийн санч Ш.Энхтуяа

№	Асуулга	Байгаа эсэх / +,- /	Тайлбар
			“Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хууль” 21.2.1, 21.2.2, 21.2.4, 21.2.5, 21.2.6, 21.2.7, 31.2.3, 31.2.6, 31.2.7, “Соёлын өвийн Улсын бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэх, уг санд бүртгэх журам” 3.3, “Музейн сан хөмрөгийг бүртгэх, баримтжуулах заавар” 6.1.1, 6.1.2, 6.1.7, 6.1.8, 6.1.9, “Музейн үйл ажиллагаанд тавигдах шаардлага” стандарт 9.3, 12.8.3

1	Соёлын өвийн бүртгэл, тодорхойлолтын бүрдэл	Үзмэрийн карт, паспорт /1997 оноос өмнөх/	+	1976 оны “Түүх дурсгалын болон урлагийн үнэт ховор зүйлийг бүртгэх дэлгэрэнгүй карт” маягтаар 1970, 1980 оны үед хийсэн 400 ширхэг орчим үзмэрийн бүртгэл задгай хадгалагдаж байна. Үүнийг хадгаламж болгох ажлыг дариу хамгийн түрүүнд хийх.
		“Монгол Улсын түүх, соёлын хөдлөх дурсалт зүйлийн бүртгэл” Гэрэл зураг	+	- 1998-2008 онд ЭША асан Д.Тунгалагийн хийсэн 126 орчим “Монгол Улсын түүх, соёлын хөдлөх дурсалт зүйлийн бүртгэл”  - 2003 оны СӨТ-ийн Д.Нарантуяагийн хийсэн 150 орчим “Монгол Улсын түүх, соёлын хөдлөх дурсалт зүйлийн бүртгэл”  - 2010-2014 онд ЭША байсан Б.Цэнд-Аюуш, Б.Должинсүрэн /БМС/ нарын хийсэн 2000 орчим “Монгол Улсын түүх, соёлын хөдлөх дурсалт зүйлийн бүртгэл”-ийг /гэрэл зурагтай/ 13 хавтастай.  - 2012-2019 онд ЭША Н.Гэрэлмаа, У.Мянганбуу /БМС/ нарын хийсэн /RCH программаас гаргасан/ 320 орчим дурсгалын бүртгэл хэвлэгдсэн 4 хавтас /зураггүй/
2	Үзлэг, тооллого хийхэд хөтөлсөн баримт	Улсын тооллогын бүртгэл, баримт	+	Музейн тооллогын бүртгэл  Увс аймгийн орон нутаг судлах музейн үзмэр, сан хөмрөгийн тооллогын бүртгэл 1980 он Төрөөгөөс Эрдэнэбаатарт хүлээлгэн өгсөн сан хөмрөгийн тооллогын дүн 1985 он Түүх дурсгалын болон урлагийн үнэт ховор зүйлсийн тооллогын бүртгэл 1982 он Увс аймгийн орон нутаг судлах музейн үзмэр, сан хөмрөгийн тооллогын бүртгэл 1985 он /угсаатан/ Увс аймгийн орон нутаг судлах музейн үзмэр, сан хөмрөгийн тооллогын бүртгэл 1985 он /археологи/ Увс аймгийн орон нутаг судлах музейн үзмэр, сан хөмрөгийн тооллогын бүртгэл 1985 он Увс аймгийн музейн 1992 оны улсын тооллогын акт ЭШ фонд үндсэн фондын тооллогын бүртгэл 1992 он Тооллогын акт 2005 он Хогшлын ерөнхий бүртгэл 1995 он орчим Музейн үзмэр эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэл 2008 – 3 ширхэг

				Музейн үзмэр эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэл 2012 – 4 ширхэг Музейн үзмэр эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэл 2018 – 2 ширхэг /бүртгэлийн эх хувийг СУГазар явуулсан/ Нийт 19 ширхэг бүртгэл  2007-2008 оны улсын тооллогын тайлан 2012-2013 оны улсын тооллогын тайлан 2018-2019 оны улсын тооллогын тайлан
		Байгууллагын тооллогын бүртгэл, баримт	-	2014 оны музейн сан хөмрөгийн хяналтын болон ажил хүлээлцэх тайлан
3	Сэргээн засварласан үзмэрийн тайлан		+	- 2012 онд СӨҮТөвд 4 дэсийн 5 ширхэг үзмэр сэргээн засварлуулаад 2013 онд ирсэн. Тайлан байгаа. 2013 онд ирсэн. Тайлан байгаа. - 2017 онд СӨҮТөвд 4 дэсийн 6 ширхэг үзмэр сэргээн засварлуулахаар явуулж 3 дэсийн 4 ширхэг ирсэн. 1 дэсийн 2 ширхэг ирээгүй байгаа. Тайлан одоогоор ирээгүй байгаа.
4	Үзмэр шинээр бүртгэлд авсан баримтууд		+	2019 онд 8 дэсийн 31 ширхэг 112 иж бүрдэл ховор үзмэр, эд өлгийн зүйлийг хандиваар авсан. /Үүний 3 дэсийн 3 ширхэг үзмэр нь сан хөмрөгт бүртгэлгүй байсан/ Хавтас үүсгэсэн боловч 2001 оноос 2019 оны баримтууд хольж задгай хийсэн.
5	Үзмэрийн хөдөлгөөний актууд		+	2019 онд маршил Ю.Цэдэнбалын амьдрал замналаар бүтээж буй “Түүх мартаггүй” киноны зураг авалтад 61 дэсийн 77 ширхэг нэмж 13 дэсийн 13 ширхэг үзмэр язгуур зориулалтаар нь ашигласан ба баримт, хүлээлцсэн акт байна.
6	Музейн хуучин, шинэ ерөнхий бүртгэлийн хувийг СӨУНБМСанд хадгалуулсан эсэх /С-12.8.3/		+	2007 оны улсын тооллогоор хойшхи бүртгэлийг явуулсан, өмнөх бүртгэлийг явуулсан эсэх нь тодорхойгүй.
<b>Бүртгэл, мэдээллийн сангийн хадгалалтын байдал.</b> “Соёлын өвийн Улсын бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэх, уг санд бүртгэх журам” 3.7, “Музейн үйл ажиллагаанд тавигдах шаардлага” стандарт 12.4.11, 12.4.17				
7	Архивын зориулалтын шүүгээ, тавиур бүхий өрөөнд тасалгааны горимын дагуу хавтас, хайрцаг, саванд хадгаламж үүсгэн хадгалсан эсэх.	Цаасан Бүртгэл	-	БМСангийн тусгай өрөө тасалгаа байхгүй, БМСанчийн мэдэлд 2 төмөр сейф байгаа. Түүнд аймгийн болон музейн бүртгэл, мэдээллийн сангийн материалыг хадгаламж үүсгээгүй, төрөлжүүлээгүй
		Цахим бүртгэл, тусгай тээгчид хадгалагдаж байгаа баримт	-	Тодорхой хэмжээгээр тусгай, тээгч, компьютерт хадгалж байгаа боловч данс, товъёг хийгдээгүй, “мастер” хувь үүсгээгүй учир алдагдах устах эрсдэл байна.



		Хосгүй үнэт дурсгал		Байхгүй
8	Бүртгэлүүдийн товъёог хөтөлсөн байдал.	Цаасан Бүртгэл	-	Музейн 2008 оны тооллогын тайлан, 2012 оны тооллогын тайлан, 2018 оны тайлан товъёг, баталгааны хуудас хийсэн бусад материалуудыг хадгаламж үүсгээгүй задгай, хавтастай хадгалсан.
		Цахим Бүртгэл		2016 оны 11 сард Баримтад өвийн үндэсний хөтөлбөрийн хүрээнд Тод номын гэрэл төв ТББ хамтарч музейн сан хөмрөгт хадгалагдаж байгаа 471 ширхэг тод үсгийн судрыг сканердан цахимжуулах ажлыг хийсэн байна. Баримт ЭШАжилтанд хадгалагдаж байна.
9	БМСангийн бүртгэлийг галаас хамгаалсан байранд, цоож бэхэлгээ бүхий шүүгээнд хадгалдаг эсэх		-	Байхгүй
<b>Хулгайд алдагдсан үзмэрийн тухай.</b> “Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хууль” 32.2.5, “Музейн үйл ажиллагаанд тавигдах шаардлага” стандарт 12.4.23, 12.4.17				
10	Хулгайд алдагдсан, солигдсон үзмэрийн баримт материалын бүрдэл		+	<p>2005 онд музейд хулгай орж 4 ширхэг үзмэр /мөнгөн хэрэглэлтэй тамхины уут, сэргүүр, мөнгөн аяга/ алдагдсан. Шүүхийн шийдвэр гарч нөхөн төлбөр хийгдсэн.</p> <p>2007 онд үзэсгэлэнд оролцуулах зорилгоор дээл гараад эргэж ирээгүй. Шүүхээр орж нөхөн төлбөрийг барагдуулсан.</p> <p>2008 оны улсын тооллогоор илэрсэн 22 ширхэг цутгамал бурханы шүүхийн тогтоол, шийдвэр гүйцэтгэл 2019 онд гарсан. Нөхөн төлбөрт 51528000 гарснаас одоогийн байдлаар 2751852.79 төг төлөгдөж 47459763.21 төгрөг дутуу байна.</p> <p>Эдгээр баримтууд БМСанд бус сан хөмрөгчид хадгалагдаж байгаагааг БМСанд явуулах</p>

**УВС АЙМГИЙН МУЗЕЙ**  
Бүртгэл, мэдээллийн сангийн цахим мэдээллийн судалгаа

Судалгаа хийсэн: Ерөнхий бүртгэл, мэдээллийн санч Ш.Энхтуяа

№	Асуулга	Байгаа эсэх /+, - /	Тайлбар
“Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хууль” 20.8, “Соёлын өвийн Улсын бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэх, уг санд бүртгэх журам” 3.4,			
1	Хөдлөх дурсгалын бүртгэлийн програмын мэдээллийн бүрэн бүтэн байдал <b>/RCH 2.0/</b>	+	2018 оны тооллогоор 2180дэсийн 5533 ширхэг үзмэр тоологдсон. RCH-д 2164 дэсийн үзмэр /зарим нь зурагтай/ оруулсан байна.
2	Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэлийн программын мэдээллийн бүрэн бүтэн байдал <b>/Register/</b>	+	Аймгийн музей болон ОНСТ нийт 13 register, Равжаа музейн 2012 оны register. /2012 оны тооллогын зурагтайгаа байгаа, 2018 оны гэрэл зураг ороогүй байгаа үүнийг асуух/ Равжаа музейн программыг өөрт нь суулгах талаар хэлэлцэх.
3	Үл хөдлөх дурсгалын бүртгэлийн программын мэдээллийн бүрэн бүтэн байдал <b>/RICH 3.0/</b>	+	2015-2016 оны тооллогын бүртгэл байгаа, хэвлэгсэн.
4	Музейн компьютер, дагалдах хэрэгслийн бүрэн бүтэн байдал, хэвийн ажиллагааг шалгах	+	Тог баригчтай, үнэгүй вирусны программтай, БМСанч RCH, register программтай 2 суурийн PC-тай, 1 нотбуук-тай
5	Гэрэл зургийн аппараттай танилцаж хэвийн үйл ажиллагааг шалгах	+	CANON 700D, яамны өгсөн CANON 200D камертай, үйл ажиллагаа хэвийн
6	Цахим файлын хадгалалт, цэгцтэй байдал	+	2008, 2012, 2018 оны музейн тооллогын гэрэл зураг, дата болон 2015 оны үл хөдлөх дурсгалын гэрэл зураг, дата БМСанчийн компьютерт байгаа нь устах эрсдэлтэй. Үүнийг “мастер” хувь үүсгэж хадгалах талаар зөвлөлгөө өглөө
7	Тусгай тээгчид	-	
8	Бүртгэл, мэдээллийн санчаас түвшин тогтоох товч судалгаа авах	+	БМСанч Л.Отгонжаргал хүүхэд асрах амралттай байгаа тул ЭША А.Уранжаргал 2018-12-01-нээс давхар хариуцан гүйцэтгэж байна.

УВС АЙМГИЙН МУЗЕЙ  
Музейн орчны судалгаа

Судалгаа хийсэн: Ерөнхий бүртгэл, мэдээллийн санч Ш.Энхтуяа

№	Асуулга	Хадгалалт хамгаалалтын байдал / +, - /	Тайлбар														
<p>“Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хууль” 32.1.4, “Музейн үзмэрийг хадгалж хамгаалах заавар” 1.4, 2.7з, ж, и, 2.4, 2.3, 2.5, 2.6, 2.7в,г,д, 4.1, 4.2, 4.4, 5.2b, 4.1, 4.2, 4.4, 5.2b</p> <p>“Монгол Улсын музейн сан хөмрөгийн дүрэм” 15.а,б, 17, “Музейн үйл ажиллагаанд тавигдах шаардлага” стандарт 17.1, 17.7, 3.2, 9.3, 12.8.3, 12.9.3, 12.9.6, 12.9.10, 12.9.12,</p>																	
1	Музейн стандартын шаардлага хангасан байртай эсэх		Увс аймгийн музей нь 1948 онд байгуулагдсан. 1990 онд баригдсан Номын сангийн байрны 2 давхарт 1995 ондүзмэрээ дэглэсэн. /номын сантай цуг/ 2006 онд Цэдэнбалын мэндэлсний 90 жилийн ойгоор УИХ-ийн Ч.Авдай, Ч.Эрдэнэсүрэн нарын санаачлагаар ард түмний хандиваар “Цэдэнбалын музей” байгуулагдсан. /Номын сангийн байртай залгаа/ 2016 онд дулааны шугам тавигдсан. Гэвч дулаан алдагдал ихтэй тулд хүйтэн.														
2	Музейн үзмэр дохиолол бүхий танхим, хоргонд, гэрэл чийг дулаан хангагдсан орчим байрлаж байгаа эсэх		Музей нийтдээ дохиолол байхгүй. Бүх үзүүлэгийн танхим, сан хөмрөгтөө камертай боловч сарнилт ихтэй шаардлага хангагдахгүй. Үзмэрийн хорго дохиололгүй														
3	Гэрэлтүүлэг /стандарт 50-200 люкс/  /Зааварт цаас, даавуу 50, арьс шир, яс, мод 150, шил, металл 500 люкс/		<table> <tr> <td>Сан хөмрөгийн өрөө</td> <td>104.3 L</td> </tr> <tr> <td>Цэдэнбалын танхим</td> <td>71.5 L</td> </tr> <tr> <td>Угсаатны зүйн танхим</td> <td>164.5 L</td> </tr> <tr> <td>Ургамлын хэсэг</td> <td>136 L</td> </tr> <tr> <td>Амьтны хэсэг</td> <td>104.1 L</td> </tr> <tr> <td>Шашны танхим</td> <td>163.7 L</td> </tr> <tr> <td>Орчин үеийн танхим</td> <td>94.2 L</td> </tr> </table>	Сан хөмрөгийн өрөө	104.3 L	Цэдэнбалын танхим	71.5 L	Угсаатны зүйн танхим	164.5 L	Ургамлын хэсэг	136 L	Амьтны хэсэг	104.1 L	Шашны танхим	163.7 L	Орчин үеийн танхим	94.2 L
Сан хөмрөгийн өрөө	104.3 L																
Цэдэнбалын танхим	71.5 L																
Угсаатны зүйн танхим	164.5 L																
Ургамлын хэсэг	136 L																
Амьтны хэсэг	104.1 L																
Шашны танхим	163.7 L																
Орчин үеийн танхим	94.2 L																

4	Дулаан /стандарт 15-18°C, зааварт үзмэрийн танхим 20°C/		Сан хөмрөгийн өрөө 28.3°C Цэдэнбалын танхим 23.6°C Угсаатны зүйн танхим 25°C Ургамлын хэсэг 26°C Амьтны хэсэг 26.8°C Шашны танхим 27.1°C Орчин үеийн танхим 28.6°C
5	Чийгшилт /стандартад 50-55%/ холимог материал зааварт 35-65%		Сан хөмрөгийн өрөө 39.5 % Цэдэнбалын танхим 43.3 % Угсаатны зүйн танхим 40.8 % Ургамлын хэсэг 39.4 % Амьтны хэсэг 39.4 % Шашны танхим 36.8 % Орчин үеийн танхим 35.3 %
6	Сан хөмрөгийн өрөө давхар хаалга, цоожтой эсэх		Сан хөмрөгийн өрөө 2 давхартаа байрласан. Дан модон хаалгатай. Ил болон далд 2 цоожтой.
7	Сан хөмрөгийн өрөө ашиглалтгүй илүү хаалга, цонхгүй байна.		Нэг цонх байсныг тоосго өрж битүүлсэн.
8	Сан хөмрөгийн өрөө салхивч, агааржуулагчтай эсэх,		Агааржуулагч байхгүй
9	Үзмэрийн танхимын өрөө салхивч, агааржуулагчтай эсэх,		Цэдэнбалын танхимд 2 цонх байгаа, бусад /номын санд байгаа/ танхимууд агааржуулагч байхгүй
10	Сан хөмрөгийн өрөө зориулалтын тавиур шүүгээтэй эсэх,		Тавиуртай
11	Сан хөмрөгийн өрөө хүндрүүлэгч бүхий сейфтэй эсэх,		2 төрлийн хүндрүүлэгчтэй сейфтэй
12	Үзүүлэгийн танхимд дулаан, чийгшилт, гэрэлтүүлэг хэмжилтийн төхөөрөмжтэй эсэх,		Байхгүй
13	Сан хөмрөнд дулаан ба чийгшилт, гэрэлтүүлэг хэмжилтийн төхөөрөмжтэй эсэх,		Байгаа
14	Музейн барилга, байгууламж нь гал усны гэнэтийн аюул, хулгайн		Музейн бүх цонхонд хаалт /решотка/ хийгдээгүй, Цэдэнбалын музейн 7 цонхны 5 цонхыг бүтүүлэхдээ зөвхөн

	гэмт халдлагаас хамгаалагдсан эсэх,		дотор талд нь нимгэн панераар хаасан.  Музейн гэрэлтүүлэг, цахилгааны монтажны асуудлыг жил бүр урсгал засварын мөнгөөр шийдвэрлэж ирсэн байна.  Сан хөмрөг, үзмэрийн танхим бүрд галын хор, үүдэнд гал унтраах хэрэгслүүд байрлуулсан.
15	Музей гал усны гэнэтийн аюул, хулгайн гэмт халдлагаас хамгаалагдсан телекамер, дохиололтой эсэх,		Музей нийтдээ галын утаа мэдрэгч болон хөдөлгөөн мэдрэгч байхгүй. Бүх үзүүлэгийн танхим, сан хөмрөгтөө камертай боловч сарнилт ихтэй шаардлага хангагдахгүй.
16	Сэргээн засварласан үзмэрийн хадгалалтын байдал,		2017 онд СӨҮТ-д сэргээн засварлуулсан үзмэрт тавигдсан “Баяд дээл” сэргээн засварласан хэсгээрээ буцаж ханзарсан.
17	Музейн гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй танилцах,		2017 онд батласан “Увс аймгийн музейн гамшгаас хамгаалах төлөвлөгөө” батлагдсан. Гэхдээ ажилтан бүрийн үүргийг тодорхой тусгаагүй.

### ЗӨВЛӨМЖ ХҮРГҮҮЛСЭН ТУХАЙ

Увс аймгийн музейн үзмэрийн хадгалалтын орчин, бүртгэл, мэдээллийн сангийн бүрдэл, хадгалалтын байдлын шинжилгээ судалгаанд үндэслэн тус музейн үйл ажиллагаанд дүгнэлт хийж, 2019 оны 09 сарын 04-ны өдөр дараах “Зөвлөмж”-ийг хүргүүлсэн болно.

#### ЗӨВЛӨМЖ

“Монгол Улсын Үндсэн хууль”, “Төрөөс соёлын талаар баримтлах бодлого”, “Монгол Улсын Соёлын тухай хууль”, “Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хууль”, “Соёлын өвийн Улсын бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэх, уг санд бүртгэх журам”, “Музейн үйл ажиллагаанд тавигдах шаардлага” стандарт MNS 5634:2006, “Монгол Улсын музейн сан хөмрөгийн дүрэм”, “Музейн үзмэрийг хадгалж хамгаалах заавар”, “Музейн сан хөмрөгийг бүртгэх, баримтжуулах заавар” бусад холбогдох эрх зүйн хүрээнд Увс аймгийн музейн гадаад, дотоод орчин, соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн бүрдэл, хадгалалтын байдалд дүн шинжилгээ хийж дараах дүгнэлт, зөвлөмжийг гаргалаа.

Нэг. Музейн үзмэрийн гадаад, дотоод орчин, түүнийг сайжруулах хүрээнд хийх ажил:

Увс аймгийн музей 1990 онд баригдсан Номын сангийн байранд 1995 онд шилжин орж үйл ажиллагаагаа явуулж ирсэн. 2006 онд Ю.Цэдэнбалын мэндэлсний 90 жилийн ойгоор “Ю.Цэдэнбалын музей”-н байрыг ашиглалтад оруулж уг байрыг мөн номын сангийн байртай холбосон ба тус аймгийн музей нь өөрийн байргүй болно.

Эдгээр байрнууд музейн барилгын стандартын наад захын шаардлагыг хангаагүй ил дулаан, цахилгааны шугамтай, агааржуулалтын систем шийдвэрлэгдээгүй, дулааны алдагдал ихтэй нь дээр музейн аюулгүй байдлыг хангах дохиоллын систем байхгүй, хулгайн эрсдэлээс хамгаалсан цонхны хамгаалалтгүй зэрэг олон асуудал байна. Үүнээс үүдэн музейн стандартад заасан орчны дулаан 15-18<sup>0</sup>С байхаас дунджаар 26<sup>0</sup>С буюу 10<sup>0</sup>С орчмоор илүү, чийгшил 50-55% байхаас дунджаар 37% буюу 13%-иар бага байгаа зэрэг нь музейн үзмэр гал ус, хулгайн аюулд өргөх, цаг бусаар хэврэгших, муудах нөхцөл бүрдсэн байна хэмээн үзлээ. Иймээс дараах үндсэн асуудлыг шийдвэрлэх:

1. Монгол Улс тэр дундаа Увс нутгийнхний түүх, соёлын дурсгалт зүйлийг хадгалах, хамгаалах, сурталчлах улмаар хойч үедээ өвлүүлэн уламжлуулах гол объект аймгийн музейн үзмэр, эд өлгийн зүйлийн хадгалалтын орчныг сайжруулах, ажилтнуудын болон үзэгчийн ая тухтай ажиллах, үзэж сонирхох нөхцөл боломж бүхий байр саваар хангуулах талаар холбогдох эрх бүхий албан тушаалтнуудад мэдэгдэх,
2. Музейн агааржуулалтын системийг шийдвэрлэж, харьцангуй чийг дулаан хангасан орчныг бүрдүүлэх,
3. Музейн аюулгүй байдлын үүднээс стандартын дагуу дохиоллын систем, утааны мэдрэгч, галын автомат гидрант, аваарын шат, цонхны хамгаалалт зэргийг шийдвэрлэх,
4. Музейн сан хөмрөгийн өрөөний үзмэрийн тоо хэт их, нэг үзмэрт ноогдох орон зай байхгүй байгаа зэргийг харгалзан зай талбайг нэмэгдүүлж, музейн хамгийн аюулгүй байрлалд давхар цоож, түгжээ бүхий төмөр хаалгатай байх,
5. Чийг, дулаан, гэрэл хэмжих төхөөрөмжийг сан хөмрөгийн өрөө болон үзмэрийн танхим бүрд суурилуулах,

Хоёр. Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн бүрдэл, хадгалалтын байдал, түүний хүрээнд хийх ажил:

“Соёлын өвийг хамгаалах тухай” хуулийн дагуу музей дээр Аймгийн соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан болон Музейн соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санг төвлөрүүлж, уг санд:

- Увс аймгийн хэмжээний түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг бүртгэх, баримтжуулах. Үүнд, Орон нутаг судлах танхим, аймгийн музейн үзмэр болон соёлын өвийг хадгалж байгаа номын сан, архив, театр, их сургууль, сүм хийдэд цаашлаад хувь хүний гар дээр хадгалагдаж байгаа түүх, соёлын дурсгал, эд өлгийн зүйлийг хамруулах,
- Увс аймгийн хэмжээний түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг бүртгэн баримтжуулах. Үүнд, Увс аймгийн нутаг дэвсгэрт орших булш хиргисүүр, хадны зураг, буган чулуу, хүн чулуун хөшөө, архитектурын дурсгал зэрэг үл хөдлөх дурсгалын бүх төрлийг хамруулах,

- Увс аймгийн хэмжээний соёлын биет бус өв болон өвлөн уламжлагчийг бүртгэн баримтжуулах.

Эдгээр баримт материалыг цаасан болон цахим, тусгай тээгчид төрөлжүүлэн ангилан хадгалах шаардлагатай билээ. Энэхүү ажил музейн байр, талбай, ажилтнуудын ур чадвар зэрэг шалтгаануудын улмаас хангалтгүй байгаан дээр түүх, соёлын хөдлөх, үл хөдлөх, биет бус өвийн тооллого бүртгэл зэрэг 2008 оноос хойших чухал баримт, материал, программ хангамж цахим байдлаар хэвлэгдээгүй /тог тохируулагч, вирусны программгүй/ шаардлага хангахгүй компьютерт 1 хувь хадгалагдаж байгаа нь баримт устах эрсдэл үүссэн байна. Иймээс дараах үндсэн асуудлуудыг шийдвэрлэх:

Аймгийн соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан болон Аймгийн музейн соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санг тус тусд нь архивын шаардлага хангасан тусгай өрөө тасалгаа гаргаж, баримт материалыг журам, стандартын дагуу зориулалтын шүүгээ тавиурт, хайрцаг саванд “хадгаламжийн нэгж” бүрдүүлэн хадгалах.

1. Аймгийн соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх ялангуяа биет бус өв, үл хөдлөх дурсгалын бүртгэн баримтжуулах нь зөвхөн музейн ажил биш тул энэхүү ажилд зориулсан тодорхой төсөв санхүүгийн дэмжлэх авах, мэргэжлийн хүмүүсийг дайчлах тал дээр аймгийн удирдлагуудаас байнгын дэмжлэг туслалцаа авах нь зүйтэй болно.
2. Соёлын өвийн бүртгэлийн “Register”, “RICH”, “RCH” зэрэг программ хангамж, цахим баримтыг тусгай компьютер /бусад ашиглалтад хамаардаггүй/ гаргаж байршуулах, тог тохируулагч болон вирусны программ суурилуулах.
3. Нэг хувь тусгай тээгчид болон цахим байдлаар хадгалагдаж байгаа баримтуудын нөөц хувь буюу “мастер” хувийг үүсгэх. Үүнд шаардлагатай зөөврийн болон суурин хард, сервер, тусгай тээгчийн бэлтгэх асуудлуудыг цаг алдалгүй шийдвэрлэж эхлэх шаардлагатай байна.

ТАЙЛАН БИЧСЭН:

Ш.ЭНХТУЯА. СОЁЛЫН ӨВИЙН БҮРТГЭЛ,  
СУДАЛГААНЫ ГАЗАР, ЕРӨНХИЙ БҮРТГЭЛ,  
МЭДЭЭЛЛИЙН САНЧ

-----oOo-----

## ДОРНОГОВЬ АЙМГИЙН СОЁЛЫН ӨВИЙН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН БҮРДЭЛ, ХАДГАЛАЛТ, МУЗЕЙН ОРЧНЫ БАЙДАЛД СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ ТАЙЛАН

2019 оны 12 дугаар сарын 20

Улаанбаатар хот

Соёлын өвийн үндэсний төвийн 2019 оны үр дүнгийн гэрээний 1.4-д заасны дагуу СӨҮТ-ийн захирлын 2019 оны А/113 дугаар тушаал гарч удирдамж батлуулан Дорноговь аймгийн музейн гадаад, дотоод орчин, үзмэрийн хадгалалт хамгаалалт, бүртгэл, мэдээллийн сангийн бүрдүүлэлтийн байдалд судалгаа, шинжилгээ хийж, мэргэжил арга зүйгээр хангах ажлыг 2019 оны 12 дугаар сарын 11, 12-ны өдрүүдэд газар дээр нь Соёлын өвийн үндэсний төвийн Ерөнхий бүртгэл, мэдээллийн санч Ш.Энхтуяа, Ерөнхий технологич М.Оюунтулга /Ph D/ нар гүйцэтгэв. Музейн талаас Бүртгэл, мэдээллийн санч А.Уранжаргал, Сан хөмрөгч Г.Сарангэрэл, Боловсролын ажилтан Б.Болорчимэг нар хамтран ажиллаа.

Дорноговь аймгийн сургалт, судалгааны төв дээр музейн болон аймгийн бүртгэл, мэдээллийн сан бусад аймгийн адил төвлөрч байна. Бүртгэл, мэдээллийн санч хүүхэд асрах чөлөөтэй байгаагаас БМСангийн ажлыг 2019 оны 3 сараас Эрдэм шинжилгээний ажилтан А.Уранжаргал давхар хариуцсан гүйцэтгэж иржээ.

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн дагуу Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санг байгууллага (музей), сум дүүрэг, аймаг, нийслэл хэмээн ангилан, архивын журмын дагуу тусгай хадгаламжийн сан бүрдүүлэн хадгалах ёстой ч бүртгэл, мэдээллийн сангийн суудаг өрөөнд 1 ширхэг хүндрүүлэгчтэй том сейф, 1 ширхэг бичгийн шкафанд баримтуудыг байршуулахдаа аймаг, музейн БМС гэж ялгаагүй хадгалжээ.



Зураг 1. Бүртгэл, мэдээллийн сангийн баримтын хадгалалт

### АЙМГИЙН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН БҮРДЛИЙН БАЙДАЛ

Түүх, соёлын хөдлөх дурсгалын бүрдэл:



Сумдын орон нутаг судлах танхимын 2012-2014 оны улсын тооллогын бүртгэлийн дэвтрийн хуулбар хувиуд, 2018-2019 оны тооллогын бүртгэл, материалууд байна.

Аймгийн музей бүртгэл баримтуудын талаар доор музейн бүртгэл, мэдээллийн сангийн бүрдэлд хэсэгт орууллаа.

Түүнчлэн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хадгалж буй тус аймагт орших эрдэм шинжилгээний байгууллага, шашны байгууллага, бусад хуулийн этгээдийн бүртгэл бараг хийгдээгүй. Зөвхөн Хамарын хийдэд хадгалагдаж буй 14 бурханы ... онд хийгдсэн бүртгэл байсан. Нийт 5 газрын бүртгэл, баримт бүрдэхээс сумын орон нутаг судлах танхимын тооллогын бүртгэлийн хуулбар, Хамарын хийдын 14 шашин шүтлэгийн дурсгалыг бүртгэсэн ба өөр бүртгэлгүй болно.

*Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэл:* 2005-2015 он хүртэлх үл хөдлөх дурсгалын жагсаалт, судалгаа хийсэн баримт материал, түүх, соёлын үл хөдлөх дурсгалын 2015 оны тооллогын 13 сумдын нийт 431 дурсгалын бүртгэл болон нэгдсэн тайланг 14 хавтаст хэрэг болгон хадгаламжийн нэгж үүсгэн хадгалсан. Археологийн хүрээлэн, Соёл урлаг судлалын хүрээлэн, аймгийн музей хамтарсан экспедици "Хатны булагийн нууц-1" 2016 онд, "Хатны булагийн нууц-2" 2017 онд Хатанбулаг суманд хийсэн малтлага судалгааны ажилд музейн ЭША Уранжаргал оролцсон ба тайлангаа бичиж БМСандаа авсан, гэхдээ нэгдсэн дэлгэрэгүй тайлан гараагүйн улмаас байхгүй. Аймгийн музей, Даланжаргалан сум хамтран Чойроос зүүн хойш 20 гаруй км-т орших "Буган хөшөө", мөн сумаас баруун зүг 23 км-т Өлзийт ухаа хэмээх газар орших "Хүн чулуун хөшөө"- тус тус баримтжуулсан ажлын тайлан тус тус байна.

Сайхандулаан суманд булш тоногдсон дуудлагаар Мэргэжлийн хяналтын газартай хамт 13 булш үзэхэд 5 булш тоногдсон, уул уурхайн компаний ашиглалтын талбайд орсон байсан ба үүнийг баримтжуулах ажил 2016 онд хийсэн тухай нийт 4 тайланг задгай (хадгаламжийн нэгж болгоогүй) хадгалсан.

*Соёлын биет бус өв, өвлөн уламжлагчийн бүртгэл:* "Монгол Улсын соёлын биет бус өв, түүнийг өвлөн уламжлагчийн бүртгэл" маягтаар хийгдсэн 2010 оны 15 ширхэг өвлөн уламжлагчийн зураггүй, дутуу бүрдэл бүхий бүртгэл, Хатанбулаг сумын өвлөн тээгчийн жагсаалт 2010 он, Өвлөн тээгчийн намтар /гар бичмэл/ баримтууд 2010-2011 он, Дорноговь аймгийн өвлөн уламчлагч 314 хүний бүртгэл, өвлөн уламжлагчийн нэгдсэн жагсаалт 2016 он, биет бус өвийн 56 бүртгэл болон 5 айл саваар хийсэн нэгдсэн жагсаалт 2016 он байна.

Цахим хэлбэрээр УЧӨТ өвлөн уламжлагчийн дууны бичлэг, өвлөн уламжлагчдаас авсан яриа, 2015 онд хийгдсэн 33 өвлөн тээгчийн тоглолтын бүрэн бичлэг, Хутагтийн тухай мартагдсан 4 дууны Н.Лантуун дууны бичлэг зэрэг хадгалагдаж байгаа ч бүртгэлийн чанар хангалтгүй, дуу, дүрс бичлэгийн эх файлууд нэг хувь БМСангийн РС-д хадгалагдсан байна.

#### Музейн бүртгэл, мэдээллийн сан:

Музейн бүртгэл, мэдээллийн санд тус музей байгуулагдсан үеэс эхлээд үзмэртэй холбоотой бүх баримтыг он дараалаар бүрдүүлэх ёстой ба эдгээрийг одоогийн мөрдөж байгаа "Музейн сан хөмрөгийг бүртгэх, баримтжуулах заавар"-ын дагуу ангилан бүрдүүлнэ.

Тус музейн 1975 оны үзмэрийн гар картууд байх бөгөөд үүнийг Мөнгөн тэмдэгт, Угсаатны эд өлөг, Шашин, Гуашь усан будаг, үрэлтийн бүтээлүүд, Амьтан, Тэмдэг, Баримт бичиг үнэмлэх баярын бичиг, Ном зургийн цомог, Бар, Эртний олдвор, Палкат хайчилбар, хатгамал, зөөлөн урлал, Сийлбэр, Тосон зургийн бүтээл, Эрдэс баялаг, Баримал, хөөмөл, бар, Ургамал, Солилцоо хэмээн төрөлжүүлсэн ... ширхэг гар карт бүхий 36 хавтас байна. Мөн “Намтар дурдатгал” хавтас. Гар картад байгаа үзмэрүүдийн зарим нь манайд байдаггүй хэмээн БМС Уранжаргал ярьж байсан.

2007 онд хийгдсэн “Монгол Улсын Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл” /2010 онд шинэчлэгдсэн/ маягтаар хийгдсэн 43 үзмэрийн бүртгэл. Эртний судлалын олдвор А4 төрөлжсөн бүртгэл 176 дэсийн үзмэртэй, 2007 он. Мөн 2007-2008, 2012-2013 оны тооллогын баримтууд байсан.

Ерөнхий бүртгэлийн дэвтрүүдийг хүндлүүлэгчтэй сейфэнд бүртгэлийн товъёг хийж хадгалсан. Гэхдээ бүртгэлийн хамгийн эртний 1973, 1979, 1988, 1989 он дэвтэр байсан жагсаалтад оруулаагүй байгааг сануулж ерөнхий бүртгэлийн дэврийн товъёгыг шинэчлэн хийх зөвлөлгөө өгсөн.

Музейн зааврын дагуу үзмэр авах, шилжилт хөдөлгөөн зэрэг үйл ажиллагааны чиглэлээр ББЗ Маягт № 1, 2, 3, 5, 7, 30, 31, 33, 35 маягтууд хөтлөгдсөн боловч холилдон хавтаслагдсан.

*Хосгүй үнэт үзмэрийн бүртгэл.* Тус музей түүх, соёлын хосгүй үнэт 3 ширхэг үзмэртэй. Эдгээрийн РСН-ийн бүртгэл хэвлэгдээгүй, харин 2009-2013 онд АНУ-д гарсан үзэсгэлэнд гарсан Condition report-ийн хуулбар зэрэг баримтууд нь сан хөмрөгчид байсан ба үүнийг БМСандаа шилжүүлэн хадгалахыг зөвлөлөө.

#### Цахим баримтыг бүрдэл, хадгалалт:

Register программд 2018 оны тооллогоор аймгийн музей 2180 дэсийн 5533 ширхэг үзмэр, 13 сумын бүртгэл, 2012 оны тооллогын Равжаа музейн үзмэрийн бүртгэл бүрэн орсон. РСН программд 2164 дэсийн үзмэр (зарим нь зурагтай) оруулсан. RICH.2, RICH.3 программд 2015 оны тооллогын бүртгэл бүрэн орсон. Программууд нь тусгай суурин PC-д, БМСанч нь мөн тусгай PC-д байх бөгөөд эдгээр нь тог баригч, үнэгүй вирусны программтай. Нийт 2 суурийн PC, 1 нотбуук, тог баригчтай харьцангуй сайн хангалттай байна.

Мөн CANON 700D, яамны өгсөн CANON 200 D камертай, үйл ажиллагаа хэвийн.

#### Музейн орчны хадгалалт, хамгаалалт:

Тус музейн орчны судалгааг Соёлын өвийн үндэсний төвийн СБӨХГ-ийн Ерөнхий технологич Доктор М.Оюунтулга хийлээ.

Музейн барилга 1979 онд Дорноговь аймгийн түүхийн музейн зориулалтаар байгуулагдсан ба сүүлийн жилүүдэд барилгын хананд цууралт өгсөөр байна. Хамгийн сүүлд аймгийн Мэргэжлийн хяналтын газраас 2012 онд “Барилгын тухай хууль”-ийн заалт хангагдахгүй тухай дүгнэлт гарсан байна. Ерөнхий технологич Доктор М.Оюунтулгын үзэж байгаагаар “Уг барилга мөнх цэвдэг хөрсөн дээр баригдсантай холбоотой хөрсний гэсэлт, хөлдөлтөөс шалтгаалах суулт нь хананд цууралт өгснөөр нурах эрсдлийг бүрдүүлэх гол шалтгаан болж байна. Нурах эрсдэл өндөртэй байгууламжинд соёлын өвийг хадгалж хамгаалах нь музейн үйл ажиллагаанд тавих шаардлагыг хангахгүй болно” хэмээн үзсэн. Мөн үзмэрийн

зарим танхимд цахилгааны ил холболтууд хийсэн, ил утаснууд нь гал авалцах материал бүхий даавуу эдлэлүүдтэй ойр байсан.

Гэрэлтүүлэг, чийгшил, дулаан хэмжигч багаж байгаа хэдий ч тогтвортой орчин бүрдүүлэх агааржуулах, чийгшүүлэх тоног төхөөрөмж үзмэрийн танхимд байхгүй зэрэг асуудал байсан ба тухай бүрд нь зөвлөгөө өгч боломжтой зарим асуудлыг газар дээр нь шийдвэрлэсэн. Үүнд, үзмэрийн танхимийн зарим хэсэгт гэрэлтүүлэг нь стандарт хэмжээг хэтрүүлсэн байсныг гэрэлтүүлгийг бууруулах арга зүйг боловсруулж шийдвэрлүүлсэн.

Музейн зүгээс чийг дулаан гэрэлтүүлгийн хэмжилтийг сэргээн засварлагдсан үзмэрүүдэд сардаа нэг удаа шалгаж хэвшсэн нааштай тал байна.

Хосгүй үнэт дурсгалт зүйлийн хадгалалтын байдал:


Дорноговь аймгийн Даланжаргалант сумын нутаг Их нартын бургастайн ам дахь хадны оршуулгаас 2005 онд олдсон 3 ширхэг дээлийг 2013 онд ЗГ-ын тогтоолоор Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалаар баталсан. Тус үзмэрийг сэргээн засварлаж, 2009-2013 онд АНУ-д үзэсгэлэнд хамрагдсаны дараа 2014 оноос музей дээрээ татан байршуулсан байдаг.

Уг үзмэрийг хадгалалтын орчин “Хангалтгүй” байгаа тухай улсын тооллогын комиссын ажлын хэсэг үзэж байж.

Бид энэ удаагийн үзлэгээрээ тухайн үзмэр хадгалагдаж байгаа хоргонд TR72-Wf хэмжилтийн багаж тавьж, дулаан чийгшлийг 25 цагийн турш 10 минутын давтамжтай 150 удаагийн хэмжилт хийж, нарийвчилсан хэлбэлзлийг гаргаж, хүрээлэн буй орчны дулаан чийгшлийн эрсдлийг тодорхойлох судалгааг хийсэн. Гэтэл музейгээр тодорхой их хичээл зүтгэл гаргаагүй ч чийг, дулаан харьцангуй хэлбэлзэл багатай байсан нь үзмэрийн материалд харгалзахгүй орчны нөлөөлөл бага байх ба энэ нь олдворт хамгийн таатай орчин бүрдүүлдэг. Өөрөөр хэлбэл, маш тогтвортой сайн үзүүлэлт гаргасан. (Графикаас харна уу) Энэ нь тус музейн хувьд халаалт бүрэн ажиллаагүй, сэрүүн нөхцөл зонхилсон, салхины урсгал бага, хүйтны улирал ихэлсэн, зузаан тоосгон хана, үзэгч бага зэрэг шалтгаанаас үзмэрийн танхимд харьцангуй тогтвортой орчин бүрдсэн байх магадлалтай хэмээн Доктор Оюунтулга үзсэн.

Дорноговь аймгийн сургалт, судалгааны  
Төвийн дулаан чийгшил хэмжилт

График 1



Хосгүй үнэт дурсгал хадгалагдаж буй хоргоны байдал



Зураг 2. Зүүн хана



Зураг 3. Голын хана



Зураг 4. Баруун хана

	TR-72wf Ch.2 чийгшил %	TR-72wf Ch.1 °C дулаан
<u>2019-12-12 12:58:15</u>		20.1
	<u>27.9</u>	
<u>2019-12-12 13:08:15</u>		20.5
	<u>17.8</u>	
<u>2019-12-12 13:18:15</u>		20.8
	<u>17.4</u>	
<u>2019-12-12 13:28:15</u>		21.0
	<u>17.1</u>	
<u>2019-12-12 13:38:15</u>		21.1
	<u>17.1</u>	
<u>2019-12-12 13:48:15</u>		21.2
	<u>17.0</u>	
<u>2019-12-12 13:58:15</u>		21.3
	<u>17.1</u>	
<u>2019-12-12 14:08:15</u>		21.4
	<u>17.1</u>	
<u>2019-12-12 14:18:15</u>		21.5
	<u>17.1</u>	
<u>2019-12-12 14:28:15</u>		21.6
	<u>17.0</u>	
<u>2019-12-12 14:38:15</u>		21.6
	<u>17.0</u>	
<u>2019-12-12 14:48:15</u>		21.7
	<u>17.0</u>	
<u>2019-12-12 14:58:15</u>		21.8
	<u>17.0</u>	
<u>2019-12-12 15:08:15</u>		21.9
	<u>16.9</u>	
<u>2019-12-12 15:18:15</u>		21.9
	<u>17.0</u>	
<u>2019-12-12 15:28:15</u>		21.9
	<u>17.1</u>	
<u>2019-12-12 15:38:15</u>		22.0
	<u>17.0</u>	
<u>2019-12-12 15:48:15</u>		22.0
	<u>17.0</u>	
<u>2019-12-12 15:58:15</u>		22.0
	<u>17.0</u>	
<u>2019-12-12 16:08:15</u>		22.0
	<u>17.0</u>	

2019-12-12 16:28:15		22.1
	16.9	
2019-12-12 16:38:15		22.1
	17.0	
2019-12-12 16:48:15		22.1
	17.0	
2019-12-12 16:58:15		22.2
	17.0	
2019-12-12 17:08:15		22.2
	16.9	
2019-12-12 17:18:15		22.2
	16.9	
2019-12-12 17:28:15		22.1
	16.8	
2019-12-12 17:38:15		21.8
	16.8	
2019-12-12 17:38:15		21.8
	16.8	
2019-12-12 17:48:15		21.3
	16.8	
2019-12-12 17:58:15		20.9
	16.9	
2019-12-12 18:08:15		20.6
	16.9	
2019-12-12 18:18:15		20.3
	16.9	
2019-12-12 18:28:15		20.1
	17.0	
2019-12-12 18:38:15		19.9
	17.1	
2019-12-12 18:48:15		19.7
	17.1	
2019-12-12 18:58:15		15.4
	24.1	
2019-12-12 19:08:15		19.1
	32.1	
2019-12-12 19:18:15		21.1
	34.2	
2019-12-12 19:28:15		21.0
	29.8	

Данзанравжаа музейн түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн хэмжилт

Манай баг Данзанравжаагийн музейд орчны судалгаа хийгээгүй ч тус музейн хүсэлтээр түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйл хадгалагдаж буй хоргод TR72-Wf багажаар дулаан, чийгшлийг 7 цагийн турш 10 минутын давтамжтай 40 удаагийн хэмжилт хийж, нарийвчилсан хэлбэлзлийг тогтоож хүрээлэн буй орчны дулаан чийгшлийн эрсдлийг тодорхойлох судалгааг хийв. Музейд хадгалагдаж буй хосгүй үнэт олдворын хувьд органик эдлэл харьцангуй ихтэй байгаа хэдийч хоргонд хийсэн хэмжилтээр чийгшил харьцангуй бага байгаа нь ажиглагдсан. Энэ хэмжээний чийгшил дулаан нь металл эдлэлийн хувьд таатай орчин бөгөөд органик эдлэлийн хувьд улирлын чанартай хэлбэлздэг орчин бол харьцангуй эрсдэлтэй чийгшлийн хэмжээ хэмээн доктор Оюунтулга үзсэн.



Хүснэгт 2: Данданравжаа музей дулаан чийгшил хэмжилтийн график



Зураг 5. Хоргоны байдал

### Сургалт зөвлөлгөөн өгсөн тухай

Аймгийн музей бүх ажилтан болон Данзанравжаа музейн ажилтнуудыг хамруулан сургалт зохион байгуулж зөвлөмж зөвлөгөө өгсөн. Соёлын өвийн үндэсний төвийн Ерөнхий технологич М.Оюунтулга Ph.D “Хүрээлэн буй орчны суурь судалгаа, органик хүчлийн тухай” сэдвээр РР дээр хичээл заасан, Ерөнхий бүртгэл, мэдээллийн санч Ш.Энхтуяа тус музейн Бүртгэл, мэдээллийн сангийн бүрдэл, хадгалалтын байдалтай танилцаж Бүртгэл, мэдээллийн сангийн баримтыг цэгцлэх хадгалах зарчмын талаар зөвлөлгөө өглөө.



Зураг 6. Сургалт зохион байгуулж байгаа байдал

### ДҮГНЭЛТ

- Дорноговь аймгийн сургалт судалгааны төв дээр төвлөрч байгаа Аймгийн бүртгэл, мэдээллийн сан, Музейн бүртгэл, мэдээллийн сангийн баримт бичиг тодорхой зааг ангилалгүй, хадгаламжийн нэгж болгоогүй хадгалж байгаан дээр цахим баримтууд нэг хувь PC дээр байгаа эрсдэлтэй байна. Сан бүрдүүлэх ажилд музейн удирдлага төдийгүй аймгийн Засаг дарга эрх, үүргийнхээ хүрээнд анхаарал хандуулахад музейн санаачлага ихээхэн чухал юм.
- Музейн үйл ажилгааны зорилгын хамгийн чухал асуудлын нэг нь соёлын биет өвийг тогтвортой орчинд хадгалж хамгаалах, гэмтээж муутгах эрсдлээс урьдчилан сэргийлж, багасгах, судалгааны арга зүй боловсруулж суурь судалгаа явуулж цаг хугацааны болон материалын онцлогийг харьцуулан эрсдэлийн нөлөөллийг гаргаж байх судалгааны ажилбар юм. Тус музей нь энэ талын суурь судалгааг бүрэн хангаж ажиллах орчин, анхан шатны тоног төхөөрөмж, судалгааны аргазүй байхгүй байгаа нь цаашид энэ талын судалгааны чиглэлээр хамтран ажиллаж, музейн хүрээлэн буй орчны суурь судалгааны чиглэлээр тус музейн мэргэжилтэнг дадлагажуулж, судалгаа болон хэмжилтийн үр дүнг хэрхэн судалгааны хэрэглэгдэхүүн болгох аргазүйг иж бүрнээр нь эзэмшүүлэх шаардлагатай байна.
- Энэ удаагийн гэрэл, дулаан чийгшил хэмжилтийн үр дүнд Дорноговь аймгийн музейн сургалт судалгааны төвийн хувьд харьцангуй хэлбэлзэл багатай байсан. Материал харгалзахгүй орчны нөлөөлөл бага байх нь олдворт хамгийн таатай орчин бүрдүүлдэг. Гэвч тус музейн хувьд халаалт бүрэн ажиллаагүй, сэрүүн нөхцөл зонхилсон, салхины урсгал бага, хүйтны улирал ихэлсэн, зузаан тоосгон хана, үзэгч бага зэрэг шалтгаанаас үзмэрийн танхимд харьцангуй тогтвортой орчин бүрдсэн байх магадлал өндөртөй байна. Тиймээс цаашид улирлаар болон 12 сараар нарийвчилсан чийгшил, дулаан, органик хүчил, хорхой шавьжны судалгаа хийж бүтэн жилийн харьцуулсан судалгаагаар орчны эрсдэлийг зөв тодорхойлж гаргах шаардлагатай байна.



## ӨГСӨН ЗӨВЛӨГӨӨ

- Музейн бүртгэл, мэдээллийн сангийн баримтыг “Музейн сан хөмрөгийг бүртгэх, баримтжуулах заавар”-ын дагуу 10 төрлийн хавтаст хийж цэгцлэх ажлыг эхлүүлэх,
- Музейн 2008, 2012, 2018 оны тооллогын гэрэл зураг, дата болон 2015 оны үл хөдлөх дурсгалын гэрэл зураг, дата зэрэг баримтууд БМСанчийн компьютерт нэг хувь хадгалагдаж байгаа нь эрсдэлтэй хэмээн үзээд “мастер” хувь, ашиглалтын хувь үүсгэн хадгалах. Үүний тулд цахим баримтуудаа цэгцлэх, багтаамжаасаа хамааран суурин хард, зөөврийн хард авч шийдвэрлэх,
- Байгууллагын тооллогын бүртгэлийн товъёгийг шинэчлэн 1973, 1979, 1988 оны бүртгэлийг нэмж оруулах. Музейн сан хөмрөч дээр байгаа Хосгүй үнэт үзмэрийн баримт, сэргээн засварласан үзмэрийн баримтыг Бүртгэл, мэдээллийн санд шилжүүлэх,
- Бүртгэл, мэдээллийн сангийн баримтуудыг хадгаламжийн нэгж болгох, данслах тусгай өргөө тасалгаа буюу “Хадгаламжийн сан”-гийн өрөөтэй болох асуудлыг боломжоороо шийдвэрлэх.

## ХАВСРАЛТУУД

Судалгааны маягт №1

### АЙМГИЙН СОЁЛЫН ӨВИЙН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН БҮРДЭЛ, ХАДГАЛАЛТ

Огноо 2019-12-11

Судалгааг хийсэн

Ш.Энхтуяа Ерөнхий бүртгэл, мэдээллийн санч

№	Асуулга	Байгаа эсэх / +,- /	Тайлбар
<b>Хөдлөх дурсгалын бүртгэл.</b> “Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хууль” 20.1.3, 20.2, 20.7, 21.2.1, 21.2.4, 31.2.3, 31.2.6, 31.2.7, “Соёлын өвийн Улсын бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэх, уг санд бүртгэх журам” 3.3			
1	Орон нутагт судлах танхимын бүртгэл, тодорхойлолт		
2	Эрдэм шинжилгээний байгууллагын бүртгэл, тодорхойлолт	Үзлэг, тооллогын бүртгэл, баримт	-
		“Монгол Улсын түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл” Гэрэл зураг	-
3	Шашны байгууллагын бүртгэл, тодорхойлолт	Үзлэг, тооллогын бүртгэл, баримт	-
		“Монгол Улсын түүх, соёлын	+ Хамрын хийдэд байгаа эд өлгийн зүйлийн бүртгэл 14 ширхэг

		хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл” Гэрэл зураг		
4	Иргэний өмчлөлд байгаа дурсгалын бүртгэл, тодорхойлолт	“Монгол Улсын түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл” Гэрэл зураг	-	
5	Хуулийн этгээдийн өмчлөл, эзэмшилд байгаа дурсгалын бүртгэл, тодорхойлолт	Үзлэг, тооллогын бүртгэл, баримт	-	
		“Монгол Улсын түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл” Гэрэл зураг	-	
<b>Үл хөдлөх дурсгалын бүртгэл. “Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хууль” 21.2.1, 21.2.2, 21.2.4, 21.2.6, 21.2.7, 21.2.8, 21.2.9, 21.2.11, “Соёлын өвийн Улсын бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэх, уг санд бүртгэх журам” 3.3,</b>				
5	Үл хөдлөх дурсгалын бүртгэл, тодорхойлолт	Үзлэг, тооллогын бүртгэл, баримт	+	2015 оны үл хөдлөх дурсгалын тооллогын нэгдсэн тайлан  13 сумдын бүртгэл нийт 14 хавтаст хэрэг хадгаламжийн нэгж үүсгэсэн
		“Монгол Улсын түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэл” Гэрэл зураг	+	2015 оны үл хөдлөх дурсгалын тооллогоор хийгдсэн 13 сумдын нийт 431 дурсгалын бүртгэл хийгдэж хадгаламжийн нэгж үүсгэсэн хадгалсан.
6	Үл хөдлөх дурсгалын судалгаа, шинжилгээний ажлын тайлан		+	-2005 оноос хийгдсэн үл хөдлөх дурсгалын жагсаалт, судалгаа /2015 он хүртэл хийгдсэн.  - Археологийн хүрээлэн,Соёл урлаг судлалын хүрээлэн, аймгийн музей хамтарсан Хатанбулаг суманд “Хатны булагийн нууц” экспедицийн тайлан. Нэгдсэн тайлан гараагүй, уг малтлагад ЭША Уранжаргал оролцсон ажлынхаа тайланг бичсэн. 2016 он

				<p>- Аймгийн музей, Даланжаргалан сум хамтран Чойроос зүүн хойш 20 гаруй км-т орших “Буган хөшөө” 2016 он сумаасбаруун зүг 23 км Өлзийт ухаа “Хүн чулуун хөшөө”- баримтжуулсан ажлын тайлан. 2016 он,</p> <p>- Сайхандулаан суманд булш тоногдсон дуудлагаар Мэргэжлийн хяналтын газартай хамт 13 булш үзэж баримтжуулсан ажлынтайлан. Үүний 5 тоногдсон. Эдгээр нь уул уурхайн компаний ашиглалтын талбайд орсон байсан. 2016 он,</p> <p>- Археологийн хүрээлэн,Соёл урлаг судлалын хүрээлэн, аймгийн музей хамтарсан Хатанбулаг суманд “Хатны булагийн нууц-2” экспедицийн тайлан. Нэгдсэн тайлан гараагүй, уг малтлагад ЭША Уранжаргал оролцсон ажлынхаа тайланг бичсэн.</p> <p>2017 он</p> <p>Нийт 4 тайлан</p>
7	Үл хөдлөх дурсгалын сэргээн засварласан ажлын тайлан			Хийгдээгүй
<b>Соёлын биет бус өвийн бүртгэл. “Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хууль” 21.2.6, 21.2.7, 21.2.9, 21.2.11, “Соёлын өвийн Улсын бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэх, уг санд бүртгэх журам” 3.3,</b>				
8	Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчийн бүртгэл	Дуу, дүрс бичлэг	+	Цахим хэлбэрээр PC- байгаа
		“Монгол Улсын соёлын биет бус өв, түүнийг өвлөн уламжлагчийн бүртгэл” Гэрэл зураг	+	-Өвлөн тээгчийн /зураггүй, мэдээлэл муутай/ бүртгэл 15 ш, 2010 он -Хатанбулаг сумын өвлөн тээгчийн жагсаалт 2010 он -Өвлөн тээгчийн намтар /гар бичмэл/ баримтууд 2010-2011 он -Дорноговь аймгийн өвлөн уламжлагчийн нэгдсэн жагсаалт. 2016 он, -Өвлөн уламчлагч 314 хүний бүртгэл 2016 он
9	Соёлын биет бус өвийн бүртгэл	Дуу, дүрс бичлэг	+	Цахим хэлбэрээр УЧӨТ өвлөгчийн дууны бичлэг, өвлөн уламжлагчдаас авсан яриа, 2015 онд хийгдсэн 33 өвлөн тээгчийн тоглолтын бүрэн бичлэг, Хутагтийн тухай мартагдсан 4 дууны Н.Лантуун дууны бичлэг

		“Монгол Улсын соёлын биет бус өв, түүнийг өвлөн уламжлагчийн бүртгэл”  Гэрэл зураг	+	- Дорноговь аймгийн өвийн 5 айл саваар хийсэн нэгдсэн жагсаалт 2016 он  Соёлын биет бус өвийн 5 айл савын 56 бүртгэл.  - музейгээс уртын дууны дугуйланг 2014 оноос эхлэн явуулж ирсэн байна. Тогтмол хичээлэлдэг 80 гаруй шавьтай
<b>Бүртгэл, мэдээллийн сангийн хадгалалтын байдал.</b> “Соёлын өвийн Улсын бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэх, уг санд бүртгэх журам” 3.7, “Музейн үйл ажиллагаанд тавигдах шаардлага” стандарт 12.4.11, 12.4.17,				
10	-Архивын зориулалтын шүүгээ, тавиур бүхий өрөө тасалгааны горимын дагуу -Хавтас, хайрцаг, саванд хадгаламж үүсгэн хадгалсан эсэх	Цаасан суурьтай бүртгэл		
		Цахим бүртгэл		
		Хөсгүй үнэт дурсгал		
11	БМСангийн бүртгэлийг галаас хамгаалсан байранд, цоож бэхэлгээ бүхий шүүгээнд хадгалдаг эсэх			

Судалгааны маягт №2

## МУЗЕЙН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН БҮРДЭЛ, ХАДГАЛАЛТ

Огноо 2019-12-11

Судалгааг хийсэн

Ерөнхий бүртгэл, мэдээллийн санч Ш.Энхтуяа

№	Асуулга	Байгаа эсэх / +, - /	Тайлбар	
“Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хууль” 21.2.1, 21.2.2, 21.2.4, 21.2.5, 21.2.6, 21.2.7, 31.2.3, 31.2.6, 31.2.7, “Соёлын өвийн Улсын бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэх, уг санд бүртгэх журам” 3.3, “Музейн сан хөмрөгийг бүртгэх, баримтжуулах заавар” 6.1.1, 6.1.2, 6.1.7, 6.1.8, 6.1.9, “Музейн үйл ажиллагаанд тавигдах шаардлага” стандарт 9.3, 12.8.3				
1	Соёлын өвийн бүртгэл, тодорхойлолтын бүрдэл	Үзмэрийн карт, паспорт /1997 оноос өмнөх/	+	Орон нутаг судлах музейн 1975 оны гар карт: Гэрэл зураг 3 хавтас Мөнгөн тэмдэгт Угсаатны эд өлөг 5 хавтас Шашны эд өлөг 4 хавтас Гуашь усан будаг, үрэлтийн бүтээлүүд Амьтан Тэмдэг

				<p>Баримт бичиг үнэмлэх баярын бичиг 2хавтас Ном зургийн цомог Бар Эртний олдвор Палкат хайчилбар, хатгамал, зөөлөн урлал Сийлбэр Тосон зургийн бүтээл Эрдэс баялаг 2 хавтас Баримал, хөөмөл, бар Ургамал <b>Намтар дурдатгал</b> Солилцоо Нэр өгөгдөөгүй 6 хавтас Нийт 36 хавтас доторх картны тоо .... ширхэг. Эдгээр картад байгаа зарим үзмэр байдаггүй. <b>Намтар түүх хавтас доторх баримтууд байгаа эсэх</b></p>
		“Монгол Улсын түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл”, Гэрэл зураг	+	2007 оны 43 үзмэрийн бүртгэл, гэрэл зурагтай /хангалтгүй/
		“Монгол Улсын түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл” Хосгүй үнэт дурсгал, Гэрэл зураг	-	
2	Үзлэг, тооллого хийхэд хөтөлсөн баримт	Улсын тооллогын бүртгэл, баримт		<p>/Тус музей 1945 онд байгуулагдсан/ -1979, 1988, 1992, 1996, 1998, 2001, 2008, 2012 оны аймгийн музей, Говийн ноён хутагтын музей, 12 сумын ОНСТ бүртгэлийн дэвтэр ний 31 ширхэг /жагсаалтаар гаргасан/ -2013 оны тооллогын ехел-ээс гаргасан А4 бүртгэл-3 дэвтэр /аймгийн музей, сумд, Равжаа музей/ -2019 оны тооллогын бүртгэл /2ш/-А4 -2019 оны Ерөнхий бүртгэлийн дэвтэр /нэмж авсан/ А3 -2019 оны сумдын тооллогын дэвтэр А4 /сору/ 12 ш -Төрөлжсөн бүртгэл: 8 ширхэг А4, 2013 он, -2018 оны 2 ширхэг дэвтэр</p>

				-2019 оны 6 дэвтэр /register-ийн ангилалын дагуу/ “Сумдын ОНМК-уудын үзмэр, соёл түүхийн дурсгалт газрын бүртгэл. 1973-1989 он” энэ дэвтэр бүртгэлдээ бичигдээгүй асуудал байна. Ерөнхий бүртгэлийн дэврийн товъёгыг шинэчлэн хийх зөвлөлгөө өгсөн. Тайлан 2008 оны тооллогын тайлан /copy/ 2012 оны тооллогын тайлан, протокол 2018-2019 оны тооллогын тайлан
		Байгууллагын тооллогын бүртгэл, баримт	-	Байгууллагын тооллогын баримт материал музейн бичиг хэрэгт
3	Сэргээн засварласан үзмэрийн тайлан		+	2005 онд 12 ширхэг Нартын хадны үзмэрийн засварлуулсан жагсаалт байна, бүртгэл байхгүй.  2010 онд Ногоон дара засварлуулсан, хүлээлцсэн бүртгэл байна, бүртгэл байхгүй. АНУ-д гарсан үзэсгэлэнд гарсан 9 үзмэрийн Кондишин репортын хуулбар, бусад материал 2009-2013 он Сан хөмрөгчид байна.
4	Үзмэр шинээр бүртгэлд авсан баримтууд			ББЗ маягт№1, 2, 3, 5, 7, 33 маягтууд хөтлөгдсөн боловч хольж нэг хавтасд хийсэн.  /Он оноор нь/
5	Үзмэрийн хөдөлгөөний актууд			ББЗ маягтаар акт үйлдээгүй, ББЗ маягт 35 маягтаар жагсаалт хийгдсэн
6	Үзмэрийн карт			-ББЗМаягт №31 байршлын карт /бүртгэл хэлбэрээр хийсэн/ 370 үзмэр бүртгэсэн -Төрөлжсөн бүртгэл: Эртний судлалын олдвор А4 176 дэсийн үзмэр 2007 он, -Түүх, угсаатны зүйн үзмэрийн тодорхойлолт А4 /батлагдаагүй маягтаар/ 2007, 2008 -ББЗ маягт 30 Үзмэр эд өлгийн карт А5-ийн 4 хавтас хэрэг 2012 он,
7	Музейн хуучин, шинэ ерөнхий бүртгэлийн хувийг СӨУНБМСанд хадгалуулсан эсэх /С-12.8.3/			1973, 1979, 1988 зэрэг бүртгэл СӨУНБМСанд байгаа эсэхийг үзээд хувиан авах талаар санал солилцох-Захирал

Бүртгэл, мэдээллийн сангийн хадгалалтын байдал.“ Соёлын өвийн Улсын бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэх, уг санд бүртгэх журам” 3.7, “Музейн үйл ажиллагаанд тавигдах шаардлага” стандарт 12.4.11, 12.4.17				
8	Архивын зориулалтын шүүгээ, тавиур бүхий өрөөнд тасалгааны горимын дагуу хавтас, хайрцаг, саванд хадгаламж үүсгэн хадгалсан эсэх.	Цаасан суурьтай бүртгэл	+	
		Цахим бүртгэл	+	
		Хосгүй үнэт дурсгал	+	
9	БМСангийн бүртгэлийг галаас хамгаалсан байранд, цоож бэхэлгээ бүхий шүүгээнд хадгалдаг эсэх		+	
Нэмэлт тэмдэглэл:				

Судалгааны маягт №3

**БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН  
ЦАХИМ БАРИМТЫН БҮРДЭЛ, ХАДГАЛАЛТ**

Огноо 2019-12-11

Судалгааг хийсэн

Ерөнхий бүртгэл, мэдээллийн санч Ш.Энхтуяа

№	Асуулга	Байгаа эсэх / +, - /	Тайлбар
“Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хууль” 20.8, “Соёлын өвийн Улсын бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэх, уг санд бүртгэх журам” 3.4,			
1	Хөдлөх дурсгалын бүртгэлийн програмын мэдээллийн бүрэн бүтэн байдал <b>/RCH 2.0/</b>	+	2018 оны тооллогоор 2180дэсийн 5533 ширхэг үзмэр тоологдсон. RCH-д 2164 дэсийн үзмэр /зарим нь зурагтай/ оруулсан байна.
2	Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэлийн программын мэдээллийн бүрэн бүтэн байдал <b>/Register/</b>	+	Аймгийн музей болон ОНСТ нийт 13 register, Равжаа музейн 2012 оны register. /2012 оны тооллогын зурагтайгаа байгаа, 2018 оны гэрэл зураг ороогүй байгаа үүнийг асуух/ Равжаа музейн программыг өөрт нь суулгах талаар хэлэлцэх.

3	Үл хөдлөх дурсгалын бүртгэлийн программын мэдээллийн бүрэн бүтэн байдал <b>/RICH 3.0/</b>	+	2015-2016 оны тооллогын бүртгэл байгаа, хэвлэгсэн.
4	Музейн компьютер, дагалдах хэрэгслийн бүрэн бүтэн байдал, хэвийн ажиллагааг шалгах	+	Тог баригчтай, үнэгүй вирусны программтай, БМСанч RCH, register программтай 2 суурийн PC-тай, 1 нотбуук-тай
5	Гэрэл зургийн аппараттай танилцаж хэвийн үйл ажиллагааг шалгах	+	CANON 700D, яамны өгсөн CANON 200D камертай, үйл ажиллагаа хэвийн
6	Цахим файлын хадгалалт, цэгцтэй байдал	+	2008, 2012, 2018 оны музейн тооллогын гэрэл зураг, дата болон 2015 оны үл хөдлөх дурсгалын гэрэл зураг, дата БМСанчийн компьютерт байгаа нь устах эрсдэлтэй. Үүнийг "мастер" хувь үүсгэж хадгалах талаар зөвлөлгөө өглөө
7	Тусгай тээгчид	-	
8	Бүртгэл, мэдээллийн санчаас түвшин тогтоох товч судалгаа авах	+	БМСанч Л.Отгонжаргал хүүхэд асрах амралттай байгаа тул ЭША А.Уранжаргал 2018-12-01-нээс давхар хариуцан гүйцэтгэж байна.

Судалгааны маягт №4

МУЗЕЙН ОРЧНЫ ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТ  
ДОРНОГОВЬ АЙМГИЙН МУЗЕЙН СУРГАЛТ СУДАЛГААНЫ ТӨВ

СӨҮТ-СБӨСЗГ

Огноо: 2019-12-11

Ерөнхий технологич М.Оюунтулга. Ph.D

№	Асуулга	Хангасан +/	Хан-гаагүй -/	Тайлбар
<b>1</b>	<b>Музейн барилга ба аюулгүй байдлын шаардлага</b>			
1.1	Музей барилга байгууламж нь барилгын норм, дүрэм, соёлын өвийг хадгалах нийтэд үйлчлэх шаардлага хангасан байна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавих шаардлага)7.1.1.		-	Музейн барилга нь мөнх цэвдэг хөрсөн дээр баригдсантай холбоотой хөрсний гэсэлт, хөлдөлтөөс шалтгаалах суулт нь хананд цууралт өгснөөр нурах эрсдлийг бүрдүүлэх гол шалтгаан болж байна. Нурах эрсдэл өндөртэй байгууламжинд соёлын өвийг хадгалж хамгаалах нь музейн үйл ажиллагаанд тавих шаардлагыг хангахгүй байна.



				
1.2	Түүх, соёлын дурсгалт барилгад байрлаж байгаа музейн захирал удирдах байгууллагатай барилга эзэмших, хамгаалах талаар гэрээ байгуулна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавих шаардлага)7.1.2	+		1979 онд Дорноговь аймгийн түүхийн музейн зориулалтаар байгуулагдсан. Одоо өөрийн үндсэн зориулалтаар ашиглагдаж байна.
1.3	Сан хөмрөг, үзүүлэлт тохирсон байр, төхөөрөмжтэй, аюулгүй байдлыг хангасан байна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавих шаардлага) 10.3		-	Музейн үндсэн барилга нь байнгын суулт өгөх эрсдэл өндөр байдагтай холбоотой соёлын үнэт өвийг хадгалах баталгаатай орчин нөхцөл байдал бүрдэхгүй байна. Үзмэрийн танхим тус бүрт аюулгүй ажиллагааны тоног төхөөрөмж дутуу байсан.
1.4	Цахилгааны сүлжээний бүрэн бүтэн байдалыг 2 жил тутамд шалгадаг эсэх МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавих шаардлага)17.1		-	Үзмэрийн зарим танхимд цахилгааны ил холболтууд хийсэн, ил утаснууд нь гал авалцах материал бүхий даавуу эдлэлүүдтэй ойр байсан 
1.5	Музей нь: Галын хор Утааны мэдрэгч Аврах шат, хаалга, байршлын тойм зураглал Яаралтай мэдээ дамжуулах цахилгаан холбоотой эсэх. 2 жил тутамд аюулгүй байдлын үзлэг хийдэг эсэх. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавих шаардлага) 17.4; 17.5		-	Тус музей нь гамшиг тохиолдсон үед аврах шат, аврах хаалганы байршлыг тодорхойлсон тойм зураглал байхгүй хэдий ч бусад шаардлагатай анхан шатны урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн авч хэрэгжүүлсэн байсан.
1.6	Музейн барилга агааржуулалтын системтэй байна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавих шаардлага) 17.6,		-	Музейн агааржуулах систем үзвэрийн 6 танхимын 2 танхимд нь агаар шүүгчгүй энгийн сэнсэн агааржуулагчтай байсан.

1.7	Музейн барилга байгууламж нь гал, усны гэнэтийн аюул, хулгайн гэмт хадлагаас хамгаалагдсан эсэх, МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавих шаардлага) 17.7,	-	Музейн гадна талыг ажиглах камер бүрэн байхгүй. Музей дотор талын хяналтын камер ажилдаг хэдийч дохиоллын систем нь гадна хаалганы хэсэгт ажиллахгүй байсан.
1.7	Музейн барилга байгууламж нь гал, усны гэнэтийн аюул, хулгайн гэмт хадлагаас хамгаалах зориулалтын телекамер бүхий дохиоллын хэрэгсэлтэй байна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавих шаардлага) 17.7,	-	Музейн гадна талыг ажиглах камер бүрэн байхгүй. Музей дотор талын хяналтын камер ажиллагаатай, гал усны аюулын үед мэдрэгч дохиолол ажиллахгүй байсан.
1.8	Дохиоллын хэрэгслийг байнга шалгаж байна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавих шаардлага) 17.7,	+	Музейн нярав, харуул С.Нармандах дохиоллын хэрэгслийг байнга шалгаж тэмдэглэл хөтөлдөг.
2	Үзүүлэлт ба сан хөмрөгийн нийтлэг шаардлага		
2.1	Сан хөмрөгийн өрөө нь барилгын хулгай дээрэм, үер, гамшигт өртөхөөргүй хэсэгт байрлана. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавих шаардлага) 12.9.2,	+	Музейн сан хөмрөг 2 давхарт байрладаг учраас гадны халдлага болон үер усны гамшигт шууд өртөх боломжгүй.
2.2	МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)12.9.3: -Сан хөмрөгийн өрөө давхар хаалга, цоожтой эсэх,	+	Сан хөмрөгийн өрөө нь 3 давхар хаалгатай, хаалга тус бүр цоожтой байсан.
	-Сан хөмрөгийн өрөө ашиглалтгүй илүү хаалга, цонхгүй байна,	+	Илүү хаалга цонхгүй.
	-Сан хөмрөгийн өрөө бэхэлгээтэй цонхтой эсэх,	+	Цонхгүй.
	-Сан хөмрөгийн өрөө салхивч, агааржуулагчтай эсэх,	-	Агааржуулагчгүй.
	-Сан хөмрөгийн өрөө нь зориулалтын тавиур шүүгээтэй эсэх,	+	Зориулалтын тавиур шүүгээтэй.
2.3	Сан хөмрөгийн өрөөнд үнэт зүйл хадгалах хүндрүүлэгч бүхий сейфтэй байна,	+	Зориулалтын сейфтэй.
	Музейн үзмэр дохиолол бүхий танхим, хоргонд, гэрэл чийг дулаан хангагдсан орчинд байрлаж байгаа эсэх,	-	Нийт үзмэрийн танхимд дохиолол бүрэн хангагдсан хэдий ч хоргон дахь гэрэл, чийг, дулааны хэмжээ стандартаас хэт давсан хэсгүүд байсан.
3.1	Музейн үзүүлэлт ба сан хөмрөгийн арчилгаа, сэлбэлт,	+	Музейн дотоод журмын дагуу 7 хоногт нэг удаагийн цэвэрлэгээ хийдэг.

	цэвэрлэгээний дэг журамтай эсэх, МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавих шаардлага) 12.9.4,			
3.2	Үзүүлэгийн танхим, сан хөмрөгийн өрөө дулаан, чийгшилт, гэрэлтүүлэг хэмжилтийн хэрэгсэл, агааржуулах, чийгшүүлэх тоног төхөөрөмжөөр тоноглогдсон эсэх, МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавих шаардлага) 12.9.6,		-	Гэрэлтүүлэг, чийгшил, дулаан хэмжигч багаж байгаа хэдий ч тогтвортой орчин бүрдүүлэх агааржуулах, чийгшүүлэх тоног төхөөрөмж үзмэрийн танхимд байхгүй байсан.
3.3	МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавих шаардлага) 12.9.7: Үзүүлэгийн танхим, сан хөмрөгийн өрөө бүрийн дулаан ба чийгшилтийн хэмжилтийг сар бүр, Үзүүлэгийн танхимын гэрэлтүүлгийн хэмжилтийг жилд 2-4 удаа шалгаж тэмдэглэл хөтөлнө. Хэмжигч хэрэгслийн заалтын тэмдэглэлийг үндэслэн хадгалалтын тохирсон орчныг бүрдүүлэх арга хэмжээ авдаг эсэх,	+		Музейн дотоод журмын дагуу музейн танхим болон сан хөмрөгийг сардаа нэг удаа дулаан, чийгшил гэрэлтүүлгийн мэдээллийг шалгаж тэмдэглэл тогтмол хөтөлдөг.
3.4	Дулаан, чийг хэмжигч хэрэгслийг мэргэжлийн байгууллагаар баталгаажуулсан байна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавих шаардлага) 12.9.9,		-	Баталгаажуулсан багаж одоогоор ашиглах боломжгүй байна.
3.5	Агаарын бохирдолтоос хамгаалж байгаа эсэх /Музейн үзмэрийг хадгалж хамгаалах заавар 3.2/		-	Агаарын бохирдлын нарийвчилсан судалгаа одоогоор хийгээгүй байна.
3.6	Хортон шавьжнаас хамгаалж байгаа эсэх /Музейн үзмэрийг хадгалж хамгаалах заавар 4.1,4.2,4.3,4.4,5.2/	+		Мэргэжлийн байгууллагаар жилд 2 удаа хортон шавьжны эсрэг ариутгалыг хийдэг.
3.7	Сэргээн засварлагдсан үзмэрийн хадгалалтын байдал	+		Одоогоор асуудалгүй хадгалагдаж байна. Музейн зүгээс чийг дулаан гэрэлтүүлгийн хэмжилтийг сэргээн засварлагдсан үзмэрүүдэд сардаа нэг удаа шалгаж хэвшсэн байна.
	Музейн гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй танилцах	+		Мэргэжлийн байгууллагын зааврын дагуу музейн дотоод журамд тааруулан гамшигаас хамгаалах төлөвлөгөө гаргасан байсан.

Дорноговь аймгийн музейн сургалт судалгааны төвийн үзүүлэгийн танхим,  
сан хөмрөгийн өрөөний гэрэлтүүлэг, дулаан, чийгшлийн хэмжээ

Огноо: 2019.12.11

№	Үзмэр, эд өлгийн зүйлийн материал	Гэрэлтүүлэг /Люкс/	Дулаан /°C/	Чийгшил /%/
1	Даавуу, усан будгийн зураг, цаас, будсан арьс, хуучирсан эд зүйлс	50 люкс хэтрэхгүй	15-18 °C	50-55 %
2	Тосон болон темпр зураг, арьс, лак, ноос, яс, төмөр	200 люкс хэтрэхгүй	15-18 °C	50-55 %

/MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавих шаардлага. 12.9.11; 12.9.12/

№	Үзүүлэгийн танхим, сан хөмрөгийн өрөө болон үзмэр	Дулаан /°C/	Чийгшил /%/	Гэрэлтүүлэг /lux/	Тайлбар
1	Палеонтологийн танхим	19,4	41,9	193	
2	Амьтны танхим	19	42,6	81	
3	Эртний түүхийн танхим	17	44,9	100	
4	Сүлд шүтээний танхим	17,5	45,4	Дунд-60 дээд-30 Арьс-250	
5	Угсаатаны танхим	15,3	47,9	Дээд-400 Дунд-150 Доод-60	Үзмэрийн танхмийн зарим хэсэгт гэрэлтүүлэг нь стандарт хэмжээг хэтрүүлсэн хэдийч гэрэлтүүлгийг бууруулах арга хэмжээг газар дээр нь арга зүй боловсруулж хамт шийдэлд хүрсэн.
6	Орчин үеийн танхим	14,4	48	Дээд-261 Морь-236/арьс/ Цаас-167	
7	Сан хөмрөгийн өрөө	13,5	48,6	Тавиур дотор-11 Тавиурын гадна ил-60 Өрөөний гэрэлтүүлэг-46	

ТАЙЛАН БИЧСЭН:  
Ш.ЭНХТУЯА.СОЁЛЫН ӨВИЙН БҮРТГЭЛ,  
СУДАЛГААНЫ ГАЗАР, ЕРӨНХИЙ  
БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН САНЧ  
М.ОЮУНТУЛГА. СОЁЛЫН БИЕТ ӨВИЙГ  
СЭРГЭЭН ЗАСВАРЛАХ ГАЗРЫН  
ЕРӨНХИЙ ТЕХНОЛОГИЧ

-----oO-----

## **1.5. “Соёлын биет бус өвийг хамгаалах Үндэсий хөтөлбөр-2019” Соёлын биет бус өвийн үзлэг зохион байгуулах бэлтгэл ажил**

### **“СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙГ ХАМГААЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР” 2019-СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙН ҮЗЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ БЭЛТГЭЛ АЖЛЫГ ХАНГАСАН ТУХАЙ ТАЙЛАН**

*Үзлэг хийх арга зүй, удирдамжийг боловсруулна.* Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 26.1. /Соёлын биет бус өвийн үзлэгийг гурван жил тутамд ... соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага аймаг, нийслэлийн Засаг даргатай хамтран зохион байгуулна/, “Соёлын биет бус өвийг хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийг 2019-2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.1.3.-т хуулинд заасны дагуу Соёлын биет бус өвийн үзлэг, тооллогыг зохион байгуулна гэж тусгагдсан.

Үзлэг, тооллогын бэлтгэл ажлын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

Засгийн газрын 2018 оны 184 дүгээр тогтоолоор батлагдсан “Соёлын биет бус өвийн үзлэг хийх журам”-ын хэрэгжилтийг хангах, Монгол улсын үндэсний төлөөллийн болон яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгэгдсэн өвийн хадгалалт, хамгаалалтын байдлыг нягтлан үзэж дүгнэх, цаашид авах арга хэмжээний санал боловсруулах зорилгоор “Соёлын биет бус өвийн үзлэг хийх ажлын удирдамж”-ыг боловсруулж эхний хувилбарыг 2019 оны 01 дүгээр сарын 11-ны өдөр БСШУСЯ-ны дэргэдэх Соёлын биет бус өвийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар танилцуулсан. /Удирдамжийг хавсаргав/

Удирдамжид үйл ажиллагаатай холбоотой арга зүйг дараах байдлаар тодорхой зааж өгсөн. Үүнд:

- Салбар комиссыг байгуулах, /Соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга салбар комиссын даргаар ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга эсхүл Боловсрол, соёл урлагийн газрын даргыг томилж ажиллуулна гэх мэт байдлаар тодорхой зааж өгсөн/
- Үзлэгийг зохион байгуулах үйл ажиллагаа, /Соёлын биет бус өвийг бүртгэх програм хангамжийг бий болгох, Үзлэг хийх бэлтгэл ажлыг хангах, сургалт зохион байгуулах, соёлын биет бус өвийн хадгалалт, хамгаалалтын нөхцөл байдалд эерэг болон сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлсийг тандан судлах, олж тогтоох хээрийн судалгаа, Аймаг, нийслэлийн бүртгэл, мэдээллийн сан, өвлөн уламжлагч, ард иргэдтэй уулзаж мэдээлэл цуглуулах хээрийн судалгаа, Үзлэгээр цуглагдсан мэдээллийг нэгтгэн тайлагнах, дүн шинжилгээ хийх, цаашид авах арга хэмжээний саналыг боловсруулах/
- Үзлэгт мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх байгууллагуудын оролцоо,
- Үзлэг зохион байгуулах ажлын календарчилсан төлөвлөгөө,
- Үзлэгт мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх байгууллагуудын ажиллах хуваарь, /Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын 4.3-т заасан бүсчлэлийн дагуу Аймаг, нийслэлийн салбар комисст мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх төрийн болон төрийн бус байгууллага, Их дээд

сургууль, Судалгааны хүрээлэн, эрдэмтэн судлаач нарыг томилон ажиллуулахаар тусгасан/

- Соёлын биет бус өвийн нийтлэг өвийн төрөл зүйлс, /6 ай савын хүрээнд нийтлэг өвийн нэр томъёог оруулсан/
- Соёлын биет бус өвийн онцлог өвийн төрөл зүйлс, /Тухайн аймагт хамаарах өвийн онцлог төрөл зүйлс/
- Үзлэгийн ажлыг тайлагнах зэрэг болно.

Тайлбар:

1. Тухайн бүс нутагт шилжилт хөдөлгөөнөөс хамааран тухайн орон нутаг суурьшсан угсаатны бүлгүүдийг соёлын биет бус өвийг үзлэгт хамруулна.
2. Үзлэгийг хийхдээ тухайн өвийн онцлогоос хамаарч ёс, заншил зан үйл, өвийг үйлдэхэд хамаарах улирал, цаг хугацааг хүндэтгэн үзэх зарчим баримтална.
3. Нийслэлийн дүүргүүдийн угсаатны бүлэг, онцлог өвийн төрөл зүйлсийг нарийвчлан гаргах боломжгүй тул шилжилт хөдөлгөөнөөс хамааран хавсралт 1, 2-т заасан өвийн төрөл зүйлсийг бүгдийг хамруулж авч үзнэ.

Үзлэгт зориулан СББӨ-ийн ICH бүртгэлийн программд нэмэлт оруулах бодлогын даалгавар боловсруулж, программ хангамжтай болно.

#### ICH.MONHERITAGE.MN ВЕБ программын бодлогын даалгавар боловсруулсан тухай ажлын тайлан

Монгол улсын хэмжээнд байгаа Соёлын биет бус өв болон өвлөн уламжлагч, өвлөн суралцагчийн нэгдсэн бүртгэлийг тоон системд оруулах, өгөгдлийн дагуу мэдээлэл цуглуулах, цуглагдсан мэдээллийг богино хугацаанд нэгтгэн боловсруулах зорилгоор “Монгол улсын соёлын биет бус өв, өвлөн уламжлагчийн бүртгэлийн програм”-ийн бодлогын даалгаврыг Соёлын өвийн бүртгэл судалгааны газрын дарга М.Цэцэнбилэг, бүртгэл мэдээллийн санч Ж.Насанжаргал, Мэдээллийн технологи, аюулгүй байдлын газрын систем хөгжүүлэгч П.Чинбат нар боловсруулсан байна.

/"ich.monheritage.mn веб програмын бодлогын даалгавар"-ыг хавсралтаас дэлгэрэнгүй үзнэ үү/

Монгол улсын хэмжээнд байгаа Соёлын биет бус өв болон өвлөн уламжлагч, өвлөн суралцагчийн нэгдсэн бүртгэлийг тоон системд оруулах, өгөгдлийн дагуу мэдээлэл цуглуулах, цуглагдсан мэдээллийг богино хугацаанд нэгтгэн боловсруулахад энэхүү веб праграмын зорилго оршино.

#### Веб праграм нь:


- Монгол Улсын соёлын биет биет бус өвийн бүртгэл
- СББӨ-ийн өвлөн уламжлагчийн болон өвлөн уралцагчийн бүртгэл
- Арга зүй гэсэн 3 үндсэн цэсээс бүрдэнэ.

#### Веб програмын ерөнхий зарчим нь:

- Бүртгэлийн програм нь ich.monheritage.mn хаяг бүхий веб-сайт (веб-програм) хэлбэртэй, Online горимд ажиллана.
- Энэхүү програм нь Аймаг, нийслэл, сум дүүрэгт орших СББӨ, өвлөн уламжлагч, өвлөн суралцагчийн мэдээллийг тусгайлан бэлдсэн өгөгдлийн дагуу авч хадгалах, цуглагдсан мэдээллийг нэгтгэн боловсруулах, тоон

дүнг богино хугцаанд гаргах, тархалтыг газрын зурагт буулгах, тоон дүнг график, хүснэгт, хувь хэмжээгээр гаргахад зориулагдсан.


- Энэхүү програмыг СББӨ болон өвлөн уламжлагч, өвлөн суралцагчыг бүртгэх, баримтжуулах, хадгалж хамгаалах үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллага /аймгуудын БСУГ, музей, соёлын төв, нийслэлийн СУГ, дүүргүүдийн соёлын төв/ ашиглаж бүртгэлийг хийнэ.



Програмын давуу тал нь:

- СББӨ-ийн болон өвлөн уламжлагчийн бүртгэлийн мэдээллийг нэгдсэн тоон системд оруулах
- Улсын хэмжээнд СББӨ-ийн мэдээллийг өгөгдөл (ай сав, төрөл, зүйл, тархалт)-ийн дагуу цуглуулах
- Өвлөн уламжлагч болон өвлөн суралцагчийн мэдээллийг өгөгдөл (тоон дүн, ай сав, төрөл, зүйл, нас, хүйс, тархалт)-ийн дагуу цуглуулах
- 21 аймаг, 9 дүүргийн өвлөгчдийн болон өвийн тархалтын газрын зургийг боловсруулах, гаргах
- Веб програмд бүртгэгдсэн СББӨ, өвлөн уламжлагч, өвлөн суралцагчийн тоон дүн, тархалт зэрэг өгөгдлийг богино хугцаанд гаргах, боловсруулах





Үзлэгт хамруулах СББӨ-ийн олон төрөл зүйлийн жагсаалт батлагдана:

Соёлын биет бус өвийн үзлэг хийх ажлын удирдамжийн хавсралтад Соёлын биет бус өвийн нийтлэг өвийн төрөл зүйлсийг 6 ай савын хүрээнд нийт 167 өвийн зүйлийн нэр томъёог тусган оруулсан. Үүнд:

1. Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд ай савд 24
2. Ардын язгуур урлаг ай савд 13
3. Үндэсний уламжлалт зан үйл, ёслол, баяр наадам ай савд 36
4. Мал, маллах арга ухаан 16
5. Байгалийн болон сав ертөнцийн тухай мэдлэг, заншил, уламжлалт арга технологи/ухаан 44
6. Зургаа. Уламжлалт гар урлал 34

Тухайн аймагт хамаарах Соёлын биет бус өвийн онцлог өвийн төрөл зүйлсийг 21 аймгийн угсаатны бүлэгт тулгуурлан гаргаж удирламжид хавсралтаар оруулж өгсөн.

Нийт 6 ай савын хүрээнд 21 аймгийн давхардсан тоогоор 240 өвийн зүйлийг тусгаж өгсөн.

## Соёлын биет бус өвийн онцлог өвийн төрөл зүйлс

Хүснэгт №1

№	Аймгуудын нэрс	Тухайн аймагт хамаарах өвийн онцлог төрөл зүйлсийн тоо /ай саваар/						
		Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд	Ардын язгуур урлаг	Үндэсний уламжлалт зан үйл, ёслол, баяр наадам	Мал, маллах арга ухаан	Байгалийн болон сав ертөнцийн тухай мэдлэг, заншил, уламжлалт арга технологи/ухаан	Уламжлалт гар урлал	Дүн
1	Архангай	1	2	4	1	1	3	12
2	Баян-Өлгий	2	2	7		2	2	15
3	Баянхонгор	2	3	2			2	9
4	Булган	1	2	3		1	2	9
5	Говь-Алтай	1	1	1			1	4
6	Говьсүмбэр	1	1	1			1	4
7	Дархан-Уул	1	1	1			1	4
8	Дорноговь	1	2	1			2	6
9	Дорнод	5	4	6			8	23
10	Дундговь	1	2	3		1	4	11
11	Завхан	1	1	1			2	5
12	Орхон	1	1	1			1	4
13	Өвөрхангай	1	2	3		1	2	9
14	Өмнөговь	1	2	3		1	3	10
15	Сүхбаатар	1	1	1			2	5
16	Сэлэнгэ	1	1	1			1	4
17	Төв	1	1	1			4	7
18	Увс	4	5	3	1		4	17
19	Ховд	8	12	15	1	2	10	48
20	Хөвсгөл	4	4	4	1		5	18
21	Хэнтий	4	3	5			4	16
	<b>Нийт дүн</b>	<b>43</b>	<b>53</b>	<b>67</b>	<b>4</b>	<b>9</b>	<b>64</b>	<b>240</b>

## СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙН ҮЗЛЭГ ХИЙХ АЖЛЫН УДИРДАМЖ

### Нэг. Зорилго

Засгийн газрын 2018 оны 184 дүгээр тогтоолоор батлагдсан “Соёлын биет бус өвийн үзлэг хийх журам”-ын хэрэгжилтийг хангах, Монгол улсын үндэсний төлөөллийн болон яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгэгдсэн өвийн хадгалалт, хамгаалалтын байдлыг нягтлан үзэж дүгнэх, цаашид авах арга хэмжээний санал боловсруулахад оршино.

Соёлын биет бус өвийн үзлэгийг бүлэг хамт олон, өвлөн уламжлагч хувь хүнтэй уялдуулан тухайн өвийн оршин байгаа газар, ахуй орчинд нь үзлэгийг хийх

Монгол улс дахь үндэстэн, угсаатны нийтлэг хэв шинжтэй соёлын биет бус өвийн төрөл, зүйл, угсаатны бүлгийн онцлог өвүүдийг заавал хамруулах зарчим баримтална. /Хавсралт 1, 2-т нийтлэг болон бүс нутгийн, угсаатны онцлог өвийн жагсаалтыг тусгав, Нийслэлийн дүүргүүдийн угсаатны бүлэг, онцлог өвийн төрөл зүйлсийг нарийвчлан гаргах боломжгүй тул шилжилт хөдөлгөөнөөс хамааран хавсралт 1, 2-т заасан өвийн төрөл зүйлсийг бүгдийг хамруулж авч үзнэ./

#### Хоёр. Зохион байгуулагч

Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын яам

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, Урлагийн газар

Дэмжигч байгууллага:

Соёлын өвийн үндэсний төв

Нийслэлийн соёл, урлагийн газар

21 аймаг, 9 дүүргийн ЗДТГ

#### Үзлэг хийх хугацаа:

2019 оны 5 дугаар сарын 15-аас 2020 оны 5 дугаар сарын 15 хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэнэ.

#### Хамрах хүрээ:

Нийслэлийн 9 дүүргийн 152 хороо, 21 аймгийн 328 сум.

### Гурав. Салбар комиссыг байгуулах

4.1. Соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга салбар комиссын даргаар ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга эсхүл Боловсрол, соёл урлагийн газрын даргыг томилж ажиллуулна.

4.2. Салбар комиссын бүрэлдэхүүнд үзлэгт хамрагдаж буй байгууллагын дарга, захирлыг заавал оролцуулна.

4.3. Салбар комиссын нарийн бичгийн дарга нь аймаг, нийслэлийн соёлын биет бус өв хариуцсан ажилтан /мэргэжилтэн/ байна.

4.4. Үзлэгийн явцад хүндэтгэн үзэх шалтгаангүй салбар комиссын дарга, гишүүдийг чөлөөлж өөрчлөхгүй.

4.5. Салбар комиссын дарга хүндэтгэн үзэх шалтгааны улмаас комиссын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах боломжгүй болсон бол нарийн бичгийн дарга түр хугацаанд үйл ажиллагааг удирдан зохион байгуулж болно.

#### Дөрөв. Үзлэгийг зохион байгуулах үйл ажиллагаа

2.1. Соёлын биет бус өвийг бүртгэх програм хангамжийг бий болгох:

- 2.2. Үзлэг хийх бэлтгэл ажлыг хангах, сургалт зохион байгуулах:
- 2.3. соёлын биет бус өвийн хадгалалт, хамгаалалтын нөхцөл байдалд эерэг болон сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлсийг тандан судлах, олж тогтоох хээрийн судалгаа:
- 2.4. Аймаг, нийслэлийн бүртгэл, мэдээллийн сан, өвлөн уламжлагч, ард иргэдтэй уулзаж мэдээлэл цуглуулах хээрийн судалгаа:
- 2.5. Үзлэгээр цуглагдсан мэдээллийг нэгтгэн тайлагнах, дүн шинжилгээ хийх, цаашид авах арга хэмжээний саналыг боловсруулах.

Тав. Үзлэгт мэргэжил, арга зүйн  
дэмжлэг үзүүлэх байгууллагуудын оролцоо

5.1. Аймаг, нийслэлийн салбар комисст мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх төрийн болон төрийн бус байгууллага, Их дээд сургууль, Судалгааны хүрээлэн, эрдэмтэн судлаач нарыг Соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга томилон ажиллуулна.

5.2. Аймаг, нийслэлд томилолтоор ажиллах эрдэмтэн судлаачдын томилолт, ажлын хөлсийг тухайн салбар комисс хариуцна.

Зургаа. Үзлэгийн ажлыг тайлагнах

5.1. Салбар комисс үзлэгийн ажлын тайланг тогтсон хугацаанд Төв комиссд ирүүлнэ.

5.2. Салбар комисс тайландаа холбогдох байгууллагын зохион байгуулалт, хэвийн үйл ажиллагааны талаарх санал дүгнэлтийг тусгана.

Төсөл  
Соёл, урлагийн газрын даргын  
2019 оны .. дугаар сарын .. өдрийн  
.. тоот тушаалын хавсралт

**ҮЗЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН КАЛЕНДАРЧИЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн
1. Бэлтгэж ажлын хүрээнд:			
1.1.	Үзлэгийн ажлын удирдамж, төлөвлөгөөг холбогдох байгууллагад хүргүүлэх	2019.05.15	ЗГХА, Соёл, урлагийн газар Улсын комисс
1.2.	Үзлэг хийхэд ашиглах гарын авлага боловсруулж, хэвлүүлэх,	2019.6.10	ЗГХА, Соёл, урлагийн газар Улсын комисс Соёлын өвийн үндэсний төв
1.3.	Соёлын биет бус өвийг бүртгэх програм хангамжийг бий болгох	2019.6.20	ЗГХА, Соёл, урлагийн газар Соёлын өвийн үндэсний төв
1.4.	Мэргэжил, аргы зүйгээр хангах нэгдсэн сургалт зохион байгуулах	2019.6.25	ЗГХА, Соёл, урлагийн газар Улсын комисс
2. Үзлэгийн ажлыг зохион байгуулах хүрээнд:			

2.1.	Салбар комиссыг байгуулах	2019.6.30	ЗГХА, Соёл, урлагийн газар Улсын комисс
2.2.	Үзлэгийн ажлыг эхлүүлэх	2019.8.01	Улсын комисс Салбар комисс
2.3.	Үзлэгийн ажлыг зохион байгуулж дуусгах	2020.5.15	Улсын комисс Салбар комисс
3. Үзлэгийн ажлын дүнг тайлагнах:			
3.1.	Салбар комиссоос үзлэгийн тайланг төв комисст хүргүүлэх	2020.6.15	Улсын комисс Салбар комисс
3.2.	Үзлэгийн ажлыг тайлагнах	2020.6.30	Улсын комисс

Соёл, урлагийн газрын даргын  
2019 оны .. дугаар сарын .. өдрийн  
.. тоот тушаалын хавсралт

Үзлэгт мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх  
байгууллагуудын ажиллах хуваарь

№	Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын 4.3-т заасан бүсчлэл	СББӨ-ийн үзлэгт хамрагдах бүс нутгийн дэд бүсчлэл	Хариуцах байгууллагын нэрс
1.	Баруун бүсэд: Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд	1.1. Баян-Өлгий, Увс, Ховд	- Ховд их сургууль - Соёл, урлаг судлалын хүрээлэн - “Монгол тууль” ТББ - “Хүннү цуурчдын холбоо” ТББ
		1.2. Говь-Алтай, Завхан,	ШУА-ийн Түүх, архелогийн хүрээлэн - Завхан аймгийн Хөгжим бүжгийн коллеж - “Баруун монголын урлаг соёлын төв” - “Монгол бүжиг” төв
2.	Хангайн бүсэд: Архангай, Баянхонгор, Булган, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл	2.1. Архангай, Булган, Өвөрхангай	- ШУА-ийн Түүх, архелогийн хүрээлэн - Дэлхийн өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргаа - “Айрагны Нутгаар” ТББ - “Уран хатгамалчдыг дэмжих Эгнэшгүй санаа” ТББ

		2.2. Баянхонгор, Орхон, Хөвсгөл	- ШУА-ийн Түүх, архелогийн хүрээлэн - ШУА-ын Хэл зохионын хүрээлэн - Соёл урлагийн их сургууль - “Монгол тулгатны өв” ТББ
3.	Төвийн бүсэд: Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв	Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь,	- Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэн - “Тахилгат газрын судалгаа, мэдээллийн төв” - Монгол тулгатны өв
		Дархан-Уул, Сэлэнгэ, Төв	- Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэн - “Уртын дууны холбоо” - Монголын ардын уламжлалт урлагийг хөгжүүлэх “Икэл сан” - “Монгол Шувуучлахуйн холбоо”
4.	Зүүн бүсэд: Дорнод, Сүхбаатар, Хэнтий	- Соёл, урлагийн их сургууль - “Буриад судлалын академи” - “Буриадын соёл спортын холбоо” - “Монгол шагайн харваа” ТББ	
5.	Улаанбаатарын бүсэд: Нийслэл хот, түүний дүүргүүдийн нутаг дэвсгэр, хот орчмын бүсийн дагуул хотууд тус тус орно.	5.1. Баянгол, Сонгинохайрхан, Хан-Уул дүүрэг	- Нийслэлийн соёл, урлагийн газар - ШУА-ийн Түүх, архелогийн хүрээлэн - “Монгол костюмс” - “Монгол дархан”-ы холбоо
		5.2. Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх дүүрэг	- Нийслэлийн соёл, урлагийн газар - ШУА-ийн Түүх, архелогийн хүрээлэн - “Монголын Үндэсний сурын холбоо” - “Монгол үндэсний хөлөгт тоглоом хөгжүүлэх төв”
		5.3. Налайх, Багануур, Багахангай дүүрэг	- Нийслэлийн соёл, урлагийн газар - Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэн - Алтайн өв соёлыг хамгаалах төв - Монголын Үндэсний Урлагийн Зөвлөл

## СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙН НИЙТЛЭГ ӨВИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛС

Нэг. Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд

1. Бэлэг дэмбэрлийн үг
2. Дом шившлэгтэй холбоотой аман илэрхийлэл
3. Сацал мялаалгын үг
4. Ертөнцийн гурав
5. Зүйр цэцэн үг
6. Мэргэн үг
7. Оньсого, таавар
8. Сургаал үг
9. Хөдөлмөр, зан үйлтэй холбоотой уриа дуудлага
10. Гийнгоо, марзай
11. Ерөөл
12. Магтаал
13. Цол дуудах
14. Үлгэр
15. Хууч яриа
16. Зугаа үг
17. Хошин шог
18. Ёгт яриа<sup>2</sup>
19. Дайралцаа үг
20. Жороо үг
21. Түргэн хэллэг
22. Домог
23. Тоглоом наадгайн үг
24. Аман үг хүргэх ёс (Мэндэнд мордогчдын үг)

Хоёр. Ардын язгуур урлаг

1. Харилцаа дуу
2. Бүүвэйн дуу
3. Шог дуу
4. Морин хуур хөгжмөөр тоглох урлаг
5. Аман хуур /Хэл хуур, төмөр хуур, хулсан хуур/ тоглох урлаг
6. Чавхдаст цохилуур хөгжим тоглох урлаг
7. Ардын үлээвэр хөгжим тоглох урлаг
8. Цохилуур хөгжим тоглох урлаг
9. Исгэрэх урлаг
10. Ташилдах урлаг
11. Нуман хуур тоглох урлаг
12. Лимбэ бишгүүрийн битүү амьсгаа

Гурав. Үндэсний уламжлалт зан үйл, ёслол, баяр наадам

1. Эрийн гурван наадам
2. Монгол бөхийн барилдаан
3. Хурдан морины уралдаан
4. Жороо морины уралдаан
5. Халх харваа /Үндэсний сурын харваа/
6. Морьт харваа
7. Цагаан сарын уламжлалт ёслол
8. Шинэ гэрийн найр
9. Хүүхэд угаалга үйлдэх ёс
10. Хүүхдийн даахь үргээх
11. найр
12. Монгол бөмбөг наадуулах наадгай /поло/
13. Аман аялгуут тоглоом /32 цагаан лонх тоолох, 25 хул тоолох г.м/
14. Хуруун тоглоом
15. Цаасан тоглоом
16. Чулуун тоглоом
17. Ээдрээ тайлах тоглоом
18. Онъсон тоглоом
19. Хөлөгт тоглоом
20. Гал голомтоо эрхэмлэх ёс
21. Мал сэтэрлэх зан үйл
22. Мах эрхэмлэх ёс
23. Зочныг угтах, үдэхтэй холбогдсон цээрлэх ёс
24. Идэх, уух, зочлолтой холбогдох цээрлэх ёс
25. Хувцас хэрэглэлтэй холбогдох цээрлэх ёс
26. Хүүхэд хүмүүжүүлэхтэй холбогдсон цээрлэх ёс
27. Байгаль хамгаалахтай холбогдсон цээрлэх ёс
28. Хүмүүсийн харилцаатай холбогдсон цээрлэх ёс
29. Ахуй амьдралтай холбогдолтой нийтлэг цээрлэх ёс
30. Мод ургамал шүтэх зан үйл
31. Нар, сар, од шүтэх зан үйл
32. Овоо тахиx уламжлалт зан үйл
33. Монгол нүүдлийн зан үйл
34. Оршуулгын зан үйл
35. Ан амьтан хамгаалах зан үйл
36. Хад чулуу шүтэх ёс
37. Хөөрөг зөрүүлэх ёс



## Дөрөв. Мал, маллах арга ухаан

1. Адуун сүргийн маллагаа
2. Тэмээн сүргийн маллагаа
3. Үхэр сүргийн маллагаа
4. Сарлаг сүргийн маллагаа
5. Бог малын маллагаа
6. Хурдан морины уяа сойлго
7. Хурдан тэмээний уяа сойлго
8. Мал оторлох ухаан
9. Мал нийлүүлэг /Ардын селекцийн ухаан/
10. Мал хөнгөлөх арга ухаан
11. Мал зүслэх, шүдлэх, нэрлэх, таних ухаан
12. Мал төхөөрөх арга ухаан
13. Малын идэш, тэжээл бэлтгэх арга ухаан
14. Хадлан тэжээл бэлтгэх ухаан
15. Малын эдэлгээ /Ердийн хөсөг ашиглах/
16. Жин тээх ардын мэдлэг, зан үйл

Тав. Байгалийн болон сав ертөнцийн тухай мэдлэг, заншил, уламжлалт арга технологи/ ухаан

1. Цагаан идээ боловсруулах уламжлалт мэдлэг
2. Улаан идээ боловсруулах уламжлалт мэдлэг
3. Ёслол хүндэтгэлийн зоог, шүүс
4. Хөх идээ боловсруулах уламжлалт мэдлэг
5. Шимийн архи нэрэх уламжлалт арга ухаан
6. Ааруул хийх уламжлалт арга технологи
7. Эзгий хийх уламжлалт арга технологи
8. Бяслаг хийх уламжлалт арга технологи
9. Борц хийх уламжлалт арга технологи
10. Хорхог хийх уламжлалт арга
11. Туламлах аргаар хоол хийх арга
12. Хэвийн боов хийх уламжлалт арга технологи
13. Монгол цай чанах уламжлалт арга технологи
14. Дом заслын уламжлалт ухаан
15. Эм барих арга ухаан
16. Хүн эмчлэх ардын уламжлалт мэдлэг, арга ухаан
17. Ардын уламжлалт цаг тоолол, одон орон, зурхайн ухааны мэдлэг
18. Малын ашиг шим авах уламжлалт мэдлэг
19. Эсгий хийх уламжлалт арга технологи
20. Ургийн бичиг хөтлөх монгол арга
21. Хурдан морь шинжих, сойх, уралдуулах монгол эрдэм ухаан
22. Монгол нохой тэжээх, сургах уламжлалт арга
23. Далны мэргэ
24. Чулуу татах мэргэ
25. Ан агнууртай холбоотой уриа дуудлага, хэл, дуу авиа

26. Мал аж ахуйн холбогдолтой уриа дуудлага
27. Яс, эрхтэний бэлгэдэл
28. Мал эмчлэх ардын уламжлалт мэдлэг, арга ухаан
29. Цаг агаар шинжих ухаан
30. Газар шинжих ухаан
31. Тэнгэр шинжих ухаан
32. Хүн шинжих ухаан
33. Мал шинжих ухаан
34. Уул, ус хамгаалах уламжлалт мэдлэг
35. Ургамал, мод хамгаалах уламжлалт мэдлэг
36. Амьтан хамгаалах уламжлалт мэдлэг
37. Ардын сурган хүмүүжүүлэх ухааны арга
38. Арьс шир боловсруулах арга
39. Үс, ноос, ноолуур боловсруулах арга
40. Аялгуу эгшгийг бичгээр тэмдэглэх монгол арга
41. Монголчуудын хэмжилзүйн мэдлэг
42. Ардын тоозүйн уламжлалт мэдлэг
43. Газар тариалан эрхлэх арга ухаан
44. Мөр шинжих мэдлэг, арга ухаан

#### Зургаа. Уламжлалт гар урлал

1. Монгол угсаатнуудын малгай урлал
2. Монгол үндэстний гутал урлал /Монгол гутал, Буриад гутал, Урианхай мааг гутал гэх мэт/
3. Ламын хувцас урлал
4. Бөөгийн хувцас урлал
5. Цамын хувцас урлал
6. Монгол гэрийн уламжлалт урлал
7. Сархинаган тоонотой гэрийн урлал
8. Монголын уламжлалт хээ угалз урлал
9. Уламжлалт эсгий урлал
10. Эсгий ширмэл урлал
11. Эсгий зээглэх урлал
12. Уламжлалт арьс ширэн урлал
13. Уламжлалт модон урлал
14. Уламжлалт малын тоног хэрэглэл урлал
15. Нум сум хийх уламжлалт урлал
16. Мөнгөн аяга урлал
17. Эмээл урлал
18. Хөөрөг урлал
19. Ган сийлбэр
20. Ясан сийлбэр
21. Модон сийлбэр
22. Чулуун сийлбэр
23. Уран хайчилбар
24. Уламжлалт уран хатгамал, оёдлын урлал

25. Зоос ширээний сүлжмэлийн урлал
26. Уламжлалт нэхэх урлал
27. Уламжлалт сүлжих урлал
28. Уяа зангилаа хийх арга ухаан
29. Монгол зургийн урлал
30. Монгол уран бичлэг
31. Зүмбэрийн урлал
32. Шуумалын урлал
33. Уламжлалт наамлын урлал
34. Үндэсний хөгжмийн зэмсгийн уламжлалт урлал
35. Монгол эр хүний зүүсгэл урлал
36. Монгол эмэгтэй хүний зүүсгэл урлал
37. Үхэр тэрэг хийх уламжлалт арга
38. Цахиур буу хийх арга
39. Монгол дархны хөөмөлдөх арга
40. Монгол дархны цутгуурын арга
41. Дархан мужааны багаж хэрэгсэл урлал
42. Ном бүтээх уламжлалт урлал

Удирдамжийн хавсралт 2

СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙН ОНЦЛОГ ӨВИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛС

№	Аймгуудын нэрс	Тухайн аймагт хамаарах өвийн онцлог төрөл зүйлс					
		Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд	Ардын язгуур урлаг	Үндэсний уламжлалт зан үйл, ёслол, баяр наадам	Мал, маллах арга ухаан	Байгалийн болон сав ертөнцийн тухай мэдлэг, заншил, уламжлалт арга технологи/ ухаан	Уламжлалт гар урлал
1	Архангай	Халх аман аялгуу	Дэмбээдэх ая дуу, Төв халх бүжиг	Халх хуримын ёс, зан үйл Гүү барих, гүүний үрс гаргах ёс Унага барих ёс	Сарлаг сүргийн маллагаа	Гүүний айраг исгэх уламжлалт арга технологи	Халх угсаатны хувцас урлал, Айрагны хөхүүр хийх уламжлалт урлал Далай чойнхор хийц

2	Баян-Өлгий	Казах хэл Айтыс	Домбор хөгжмөөр тоглох урлаг, Казак бүжиг	Наурызын баярын ёслол, Казак хуримын ёс, зан үйл, Казак оршуулгын зан үйл, Тогыз кумалак, Тулам булаалдах, Гүү барих, гүүний үрс гаргах ёс Унага барих ёс		Каз хийх уламжлалт арга технологи Гүүний айраг исгэх уламжлалт арга технологи	Казах угсаатны хувцас урлал Айрагны хөхүүр хийх уламжлалт урлал
3	Баянхонгор	Халх аман аялгуу, Халх тууль	Чулуун царгил хөгжим тоглох урлаг, Төв халх бүжиг, Гүр дуу	Халх хуримын ёс, зан үйл, Дуутай хуруу тоглоом			Халх угсаатны хувцас урлал, Далай чойнхор хийц,
4	Булган	Халх аман аялгуу	Дэмбээдэх ая дуу, Төв халх бүжиг	Халх хуримын ёс, зан үйл, Гүү барих, гүүний үрс гаргах ёс, Унага барих ёс		Гүүний айраг исгэх уламжлалт арга технологи	Халх угсаатны хувцас урлал, Айрагны хөхүүр хийх уламжлалт урлал
5	Говь-Алтай	Халх аман аялгуу	Төв халх бүжиг	Халх хуримын ёс, зан үйл			Халх угсаатны хувцас урлал,
6	Говьсүмбэр	Халх аман аялгуу	Төв халх бүжиг	Халх хуримын ёс, зан үйл			Халх угсаатны хувцас урлал,
7	Дархан-Уул	Халх аман аялгуу	Төв халх бүжиг	Халх хуримын ёс, зан үйл			Халх угсаатны хувцас урлал,
8	Дорноговь	Халх аман аялгуу	Төв халх бүжиг Халх тууль	Халх хуримын ёс, зан үйл			Халх угсаатны хувцас урлал, Боржигин хийц

9	Дорнод	Буриад аман аялгуу, Үзэмчин аман аялгуу, Барга тууль, Буриад тууль, Бөө мөргөлийн аман зохиол	Буриад бүжиг, наадаан, Үзэмчин бүжиг, Барга бүжиг, Суух хуур тоглох урлаг	Үзэмчин бөхийн барилдаан, Буриад оршуулгын зан үйл, Буриад харваа, Түнх харваа, Буриад хуримын ёс, зан үйл, Бөөгийн оршуулгын зан үйл			Буриад угсаатны хувцас урлал, Барга угсаатны хувцас урлал, Үзэмчин угсаатны хувцас урлал, Хамниган угсаатны хувцас урлал, Ходак тэрэг хийх уламжлалт арга, Үзэмчин мухлаг тэрэг хийх уламжлалт арга, Буриад байшингийн урлал, Баргын Авдарбаян хийц
10	Дундговь	Халх аман аялгуу	Дэмбээдэх ая дуу, Төв халх бүжиг	Халх хуримын ёс, зан үйл, Гүү барих, гүүний үрс гаргах ёс, Унага барих ёс		Гүүний айраг исгэх уламжлалт арга технологи	Халх угсаатны хувцас урлал, Төв халхын Баянбараат хийц, Боржигин хийц Айрагны хөхүүр хийх уламжлалт урлал
11	Завхан	Халх аман аялгуу	Төв халх бүжиг	Халх хуримын ёс, зан үйл			Халх угсаатны хувцас урлал, Далай чойнхор хийц
12	Орхон	Халх аман аялгуу	Төв халх бүжиг	Халх хуримын ёс, зан үйл			Халх угсаатны хувцас урлал,
13	Өвөрхангай	Халх аман аялгуу	Дэмбээдэх ая дуу, Төв халх бүжиг	Халх хуримын ёс, зан үйл, Гүү барих, гүүний үрс гаргах ёс, Унага барих ёс		Гүүний айраг исгэх уламжлалт арга технологи	Халх угсаатны хувцас урлал, Айрагны хөхүүр хийх уламжлалт урлал
14	Өмнөговь	Халх аман аялгуу	Дэмбээдэх ая дуу, Төв халх бүжиг	Халх хуримын ёс, зан үйл, Гүү барих, гүүний үрс гаргах ёс, Унага барих ёс		Гүүний айраг исгэх уламжлалт арга технологи	Халх угсаатны хувцас урлал, Ноён-Сэврэй хийц, Айрагны хөхүүр хийх уламжлалт урлал

15	Сүхбаатар	Халх аман аялгуу	Төв халх бүжиг	Халх хуримын ёс, зан үйл,			Халх угсаатны хувцас урлал, Дарьганга хийц,
16	Сэлэнгэ	Халх аман аялгуу	Төв халх бүжиг	Халх хуримын ёс, зан үйл,			Халх угсаатны хувцас урлал,
17	Төв	Халх аман аялгуу	Төв халх бүжиг	Халх хуримын ёс, зан үйл,			Халх угсаатны хувцас урлал, Боржигин хийц Төв халхын Баянбараат хийц, Баргын Авдарбаян хийц
18	Увс	Ойрад аман аялгуу, Халх аман аялгуу, Баяд тууль, Дөрвөд тууль	Экил хөгжмөөр тоглох урлаг, Товшуур хөгжмөөр тоглох урлаг, Баяд биелгээ (бүжиг), Дөрвөд биелгээ (бүжиг), Хотон бий биелгээ (бүжиг)	Баяд хуримын ёс, зан үйл, Дөрвөд хуримын ёс, зан үйл, Хотон хуримын ёс, зан үйл	Сарлаг сүргийн маллагаа		Баяд угсаатны хувцас урлал, Дөрвөд угсаатны хувцас урлал, Хотон угсаатны хувцас урлал Хан Хөхий хийц

19	Ховд	Ойрад аман аялгуу, Халх аман аялгуу, Казах хэл, Дөрвөд тууль Захчин тууль Урианхай тууль Торгууд тууль Жангар тууль хайлах	Экил хөгжмөөр тоглох урлаг, Товшуур хөгжмөөр тоглох урлаг, Дөрвөд биелгээ (бүжиг), Захчин бий биелгээ (бүжиг) Мянгад бий биелгээ (бүжиг) Өөлд бий биелгээ (бүжиг) Торгууд бий биелгээ (бүжиг) Урианхай бий биелгээ (бүжиг) Казак бүжиг Тува бий биелгээ (бүжиг) Уран нугаралт Монгол хөөмийн урлаг	Урианхай харваа, Наурызын баярын ёслол, Урианхай хуримын ёс, зан үйл, Дөрвөд хуримын ёс, зан үйл, Захчин хуримын ёс, зан үйл, Казак хуримын ёс, зан үйл, Мянгад хуримын ёс, зан үйл, Өөлд хуримын ёс, зан үйл, Торгууд хуримын ёс, зан үйл, Халх хуримын ёс, зан үйл, Тува хуримын ёс, зан үйл, Бух ноололдоон /ойрад монголчууд/ , Бух авалдаан /торгууд/, Казак оршуулгын зан үйл, Тогыз кумалак, Тулам булаалдах	Сарлаг сүргийн маллагаа	Каз хийх уламжлалт арга технологи, Гүрмэл боов хийх уламжлалт арга технологи	Халх угсаатны хувцас урлал, Дөрвөд угсаатны хувцас урлал, Захчин угсаатны хувцас урлал, Казах угсаатны хувцас урлал, Мянгад угсаатны хувцас урлал, Өөлд угсаатны хувцас урлал, Торгууд угсаатны хувцас урлал, Тува угсаатны хувцас урлал, Урианхай угсаатны хувцас урлал, Хошууд угсаатны хувцас урлал
20	Хөвсгөл	Халх аман аялгуу, Дархад аман аялгуу, Хотгойд аман аялгуу, Бөө мөргөлийн аман зохиол	Төв халх бүжиг Дархад бүжиг, Хотгойд бүжиг, Тува бий биелгээ (бүжиг)	Дархад хуримын ёс, зан үйл, Хотгойд хуримын ёс, Тува хуримын ёс, зан үйл, Бөөгийн оршуулгын зан үйл	Цаан сүргийн маллагаа		Дархад угсаатны хувцас урлал, Хотгойд угсаатны хувцас урлал, Тува угсаатны хувцас урлал, Цаатан угсаатны хувцас урлал Далай чойнхор хийц

21	Хэнтий	Халх аман аялгуу, Буриад аман аялгуу, Бөө мөргөлийн аман зохиол, Буриад тууль	Буриад бүжиг, наадаан, Төв халх бүжиг, Суух хуур тоглох урлаг	Буриад оршуулгын зан үйл, Буриад харваа, Түнх харваа, Буриад хуримын ёс, зан үйл, Бөөгийн оршуулгын зан үйл			Буриад угсаатны хувцас урлал, Ходак тэрэг хийх уламжлалт арга, Буриад байшингийн урлал, Батноров хийц
----	--------	---	---	---	--	--	---

Тайлбар:

4. Тухайн бүс нутагт шилжилт хөдөлгөөнөөс хамааран тухайн орон нутагт суурьшсан угсаатны бүлгүүдийг соёлын биет бус өвийг үзлэгт хамруулна.
5. Үзлэгийг хийхдээ тухайн өвийн онцлогоос хамаарч ёс, заншил зан үйл, өвийг үйлдэхэд хамаарах улирал, цаг хугацааг хүндэтгэн үзэх зарчим баримтална.
6. Нийслэлийн дүүргүүдийн угсаатны бүлэг, онцлог өвийн төрөл зүйлсийг нарийвчлан гаргах боломжгүй тул шилжилт хөдөлгөөнөөс хамааран хавсралт 1, 2-т заасан өвийн төрөл зүйлсийг бүгдийг хамруулж авч үзнэ.

Хавсралт №2

ICH.MONHERITAGE.MN ВЕБ ПРОГРАМЫН БОДЛОГЫН ДААЛГАВАР

МОНГОЛ УЛСЫН СОЁЛЫН БИЕТ БУС ӨВ,  
ӨВЛӨН УЛАМЖЛАГЧИЙН БҮРТГЭЛИЙН ПРОГРАМ

Зорилго:

Монгол улсын хэмжээнд байгаа Соёлын биет бус өв болон өвлөн уламжлагч, өвлөн суралцагчийн нэгдсэн бүртгэлийг тоон системд оруулах, өгөгдлийн дагуу мэдээлэл цуглуулах, цуглагдсан мэдээллийг богино хугацаанд нэгтгэн боловсруулахад энэхүү веб праграмын зорилго оршино.

Зорилтууд:

- СББӨ-ийн болон өвлөн уламжлагчийн бүртгэлийн мэдээллийг нэгдсэн тоон системд оруулах
- Улсын хэмжээнд СББӨ-ийн мэдээллийг өгөгдөл (5 ай сав, төрөл, зүйл, тархалт)-ийн дагуу цуглуулах
- Өвлөн уламжлагч болон өвлөн суралцагчийн мэдээллийг өгөгдөл (тоон дүн, 5 ай сав, төрөл, зүйл, нас, хүйс, тархалт)-ийн дагуу цуглуулах
- 21 аймаг, 9 дүүргийн өвлөгчдийн болон өвийн тархалтын газрын зургийг гаргах
- СББӨ-ийн болон өвлөн уламжлагчийн бүртгэлээр дамжуулан гэрэл зураг, дүрс бичлэгийн санг баяжуулах



- Веб програмд бүртгэгдсэн СББӨ, өвлөн уламжлагч, өвлөн суралцагчийн тоон дүн, тархалт зэрэг өгөгдлийг богино хугцаанд гаргах, боловсруулах
- СББӨ-ийн болон өвлөн уламжлагчдын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэх, баяжуулах.

#### Веб програмын ерөнхий зарчим

- Бүртгэлийн програм нь ich.monheritage.mn хаяг бүхий веб-сайт (веб-програм) хэлбэртэй байна.
- Интернет орчинд ажиллана.
- Энэхүү програм нь Аймаг, нийслэл, сум дүүрэгт орших СББӨ, өвлөн уламжлагч, өвлөн суралцагчийн мэдээллийг тусгайлан бэлдсэн өгөгдлийн дагуу авч хадгалах, цуглагдсан мэдээллийг нэгтгэн боловсруулах, тоон дүнг богино хугцаанд гаргах, тархалтыг газрын зурагт буулгах, тоон дүнг график, хүснэгт, хувь хэмжээгээр гаргахад зориулагдсан.
- Энэхүү програмыг СББӨ болон өвлөн уламжлагч, өвлөн суралцагчыг бүртгэх, баримтжуулах, хадгалж хамгаалах үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллага /аймгуудын БСУГ, музей, соёлын төв, нийслэлийн СУГ, дүүргүүдийн соёлын төв/ ашиглаж бүртгэлийг хийнэ.
- Веб програм нь гэрэл зураг, дүрс бичлэгийн өгөгдөл оруулах боломжтой.
- Бүртгэл хийх техникийн үзүүлэлт: Фонт: Arial, үсэг, тооны хэмжээ: 12, гэрэл зураг: татаж оруулахаар, дүрс бичлэг: татаж оруулахаар байна.
- Веб програм нь ирээдүйд нэмэлт, өөрчлөлт хийгдэх боломжтой байхаар хийгдэнэ.
- Аймаг, нийслэл тус бүр өөрсдийн нэвтрэх нэр, нууц үгтэй байна. Нэвтрэх нэр, нууц үгийг Соёлын өвийн үндэсний төвөөс олгоно. Тухайн хэрэглэгч зөвхөн өөрийн харьяаллын /21 аймаг, 9 дүүрэг/ өвлөн уламжлагчийн бүртгэлийг оруулах ба гадны хэрэглэгч нэвтрэх боломжгүй байхаар хийгдэнэ.

Нэвтрэх нэр: Тоо үсэг холилдсон 8 орон байна.	Нууц үг: Тоо үсэг холилдсон 8 орон байна.
---	---


#### Нүүр хуудас:

- I. Монгол Улсын соёлын биет биет бус өвийн бүртгэл
- II. СББӨ-ийн өвлөн уламжлагчийн болон өвлөн суралцагчийн бүртгэл
- III. Арга зүй гэсэн 3 үндсэн цэсээс бүрдэнэ.

#### Нүүр хуудсанд харагдах мэдээлэл:

I цэс буюу “Монгол Улсын соёлын биет биет бус өвийн бүртгэл”-ийн тоон дүн нь II цэс буюу “СББӨ-ийн өвлөн уламжлагчийн болон өвлөн суралцагчийн бүртгэл”-ийн мэдээлэлтэй уялдан засаг захиргааны нэгжээр, 5 ай саваар, өвийн төрөл, зүйлээр, тухайн өвийг өвлөн уламжлагчийн болон өвлөн суралцагчийн насны үзүүлэлт, хүйсээр тус бүр график, диаграм байдлаар нүүр хуудсанд 3-5 секунд тутам солигдон мэдээлэгдэж байхаар хийгдэнэ.


II цэс буюу “СББӨ-ийн өвлөн уламжлагчийн болон өвлөн суралцагчийн бүртгэл”-ийн тоон дүн нь засаг захиргааны нэгжээр, насны үзүүлэлт, хүйсээр тус бүр график, диаграм байдлаар нүүр хуудсанд 3-5 секунд тутам солигдон мэдээлэгдэж байхаар хийгдэнэ. /эсвэл шүүлт, хайлтын аргаар шууд харж болох уу?/




Энэхүү графикийн мэдээлэлүүд нь I, II цэс дэх мэдээлэлтэй уялдан автоматаар шинэчлэгдэж байхаар хийгдэнэ.

ЮНЕСКО-гийн СББӨ-ийн Төлөөллийн болон Яаралтай хамгаалах шаардлагатай СББӨ-ийн жагсаалтад бүртгэгдсэн 14 өвийн төрлөөр II цэсний СББӨ-ийн өвлөн уламжлагчийн болон өвлөн суралцагчийн бүртгэлийн тоон дүнгээс автоматаар шүүлт хийгдэж диаграм, хувь, хэмжээ харагдаж байхаар хийгдэнэ.

Монгол Улсын Соёлын биет бус өвийн бүртгэлийн тархалтыг газрын зурагт засаг захиргааны нэгжээр шүүлт хийхэд автоматаар өнгөөр ялгагдан харагдах байдлаар хийгдэнэ. Тархалтын тоон дүн, өгөгдөл нь “Монгол Улсын соёлын биет биет бус өвийн бүртгэл”, “СББӨ-ийн өвлөн уламжлагчийн болон өвлөн суралцагчийн бүртгэл”-тэй шууд уялдан автоматаар 3 төрлөөр (Өвийн, өвлөн уламжлагчийн, өвлөн суралцагчийн) гаргадаг байхаар хийгдэнэ.





I. Монгол Улсын соёлын биет биет бус өвийн бүртгэл цэс:

Соёлын биет бус өвийн бүртгэл талбар:

Засгийн газрын 541 тоот Бүртгэл батлах тухай тогтоолын гуравдугаар хавсралтаар баталсан “Монгол Улсын Соёлын биет бус өв, түүнийг өвлөн уламжлагчийн бүртгэл” маягттай уялдуулан энэхүү бүртгэлийг хийнэ.

Бодлогын даалгаварт:

МОНГОЛ УЛСЫН СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙН БҮРТГЭЛ

УНБМС-ийн дугаар           /УНБМС-аас автоматаар олгогдоно/          

*Соёлын өвийн үндэсний төвийн захирлын 2018 оны ... сарын ... өдрийн ... тоот веб програмд Соёлын биет бус өвийн бүртгэлийн дугаар өгөх тухай тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан өгөгдлийн код буюу дугаарыг УНБМС-аас өгнө. Өгөгдлийн код буюу дугаарыг УНБМС-д бүртгэлийг хүлээн авч баталгаажуулсны дараа засаг захиргааны нэгжийн кодоор автоматаар олгогддог байхаар хийгдэнэ.*

Угсаатны бүлэг           /Сонгогддог байхаар хийгдэнэ/          

Өвийн ай, төрөл, зүйл           /Сонгогддог байхаар хийгдэнэ/          

*Соёлын өвийн үндэсний төвөөс баталсан СББӨ-ийн ерөнхий 5 айгаар ангилсан өгөгдөлдлийг сонгох байдлаар оруулна. Дээрх 5 ангиллын алинд нь тухайн СББӨ-ийн төрөл зүйл хамрагдахыг сонгосны дараа ангиллын дотор хуваагдсан төрөл зүйлүүдийн аль нь болохыг мөн сонгоно. Тухайн өвийн төрөл байхгүй тохиолдолд бусад гэсэн хэсгийг сонгоно. Төрөл, зүйл тус бүрд “БУСАД” гэсэн хэсэг байна. СББӨ-ийн ангилал доторх төрөл зүйлүүд мөн адил өгөгдлөөр бүртгэлийн програмд суугдсан байна.*

<u>Аймаг, Нийслэл:</u> Тухайн аймаг, дүүргийн нэрийг автоматаар сонгогддог байхаар оруулна.
<u>Сум, Дүүрэг:</u> Тухайн сумын нэр, хорооны тоог автоматаар сонгогддог байхаар оруулна. Жишээ: /Батноров сум, 5-р хороо, хэдэнч сум, хороог сонгодог байхаар оруулна./
<u>Өвийн тодорхойлолт:</u> 300-аас доошгүй тэмдэгтийн зай

<u>Өвийн холбогдолтой домог, хууч яриа, түүх:</u> 300-аас доошгүй тэмдэгтийн зай
<u>Хэдэн хүн өвлөж байгаа, хэдэн өвлөн суралцагч байгаа мэдээлэл</u> 300-аас доошгүй тэмдэгтийн зай
<u>Холбогдох зан үйл (ямар байдал, ёс журмаар гүйцэтгэдэг)</u> 300-аас доошгүй тэмдэгтийн зай
<u>Холбогдох өвийн зүйл:</u> 300-аас доошгүй тэмдэгтийн зай
<u>Урын сан:</u> Хичнээн дуу, домог, үлгэр гэх мэт өвийн зүйлийн гол төлөөлөл болсон өвийн зүйл, өвлөн уламжлагчийн нэрсийг дурдаж оруулна. 300-аас доошгүй тэмдэгтийн зай
<u>Өвийн онцлог шинж:</u> 300-аас доошгүй тэмдэгтийн зай
<u>Бусад</u> /бүртгэл хэсэгт ороогүй мэдээлэл, санал хүсэлт бичнэ./
<u>Хавсралт материалын тэмдэглэл:</u> Энэ хэсэгт хэдэн өвлөн уламжлагч, өвлөн суралцагч бүртгэлтэй байгаа, гэрэл зураг, хэдэн минутын дүрс бичлэг, хэдэн дуу, домог, үлгэр гэх мэт материал бүртгэлд оруулсан тухай тэмдэглэлийг бичнэ. 500-1000 хүртэлх тэмдэгтийн зай

Өвийн холбогдох гэрэл зураг /Тухайн өвийг төлөөлөх гол өвлөн уламжлагч хэд хэдэн хүний гэрэл зураг байж болно/

2 өвлөгчийн болон өвийн холбогдох зураг байна. Dpi – 72 Pixel – 3000x2000-аас багагүй байна.	Татаж оруулахаар	Татаж оруулахаар	Татаж оруулахаар
--	------------------	------------------	------------------

Өвийн холбогдох дүрс бичлэг

2 минутын өвийн холбогдох дүрс бичлэг байна. Формат - HD1080-аас доошгүй	Татаж оруулахаар
---	------------------

Бүртгэл хийсэн:  
50 хүртэл тэмдэгтийн зай

50 хүртэл тэмдэгтийн зай

/Овог, нэр/

/Албан газар, албан тушаал/

/20.... оны ..... сарын ..... -ны өдөр/

Байгууллага (музей), сум, дүүрэг, аймаг, нийслэл, улсын (сонгохоор) нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хадгалагдаж байгаа:

Д/д	Нэр төрөл	Тоо ширхэг, хэмжээ /gb/	Хадгалагдаж байгаа хэлбэр		Хадгаламжийн дугаар
			цахим	цаас	
1.	Гэрэл зураг	26 ш, 28gb			AP00000005-02
2.	Негатив хальс				
3.	Дүрс бичлэг				
4	Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тайлан, бусад баримт				
5	Архив, ном, хэвлэлийн баримт				
6	Бусад				

I. СББӨ-ийн өвлөн уламжлагчийн болон өвлөн суралцагчийн бүртгэл цэс

СББӨ-ийн өвлөн уламжлагчийн болон өвлөн суралцагчийг бүртгэх талбар

Засгийн газрын 541 тоот Бүртгэл батлах тухай тогтоолын гуравдугаар хавсралтаар баталсан “Монгол Улсын Соёлын биет бус өв, түүнийг өвлөн уламжлагчийн бүртгэл” маягттай уялдуулан энэхүү бүртгэлийг хийнэ.

УНБМС-ийн дугаар өгөх талбар:

- Соёлын өвийн үндэсний төвийн захирлын 2018 оны ... сарын ... өдрийн ... тоот Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн бүртгэлийн дугаар өгөх тухай тушаалын дагуу УНБМС-аас өгнө. Энэхүү дугаар нь засаг захиргааны нэгжийн дагуу автоматаар олгогдож байхаар хийгдэнэ. УНБМС-ийн дугаар нь УНБМС бүртгэлийг хүлээн авч баталгаажуулсны дараа олгогдоно.

Улсын нэгдсэн Бүртгэл, мэдээллийн сангийн дугаар /УНБМСангийн дугаар/ өгөх зарчим.

Өвлөн уламжлагч хувь хүнийг бүртгэхэд УНБМСангийн дугаар дараах зарчмаар өгөгдөнө. /жагсаалтыг бэлдэж өгнө/

Үүнд:

- УБМС-ийн дугаар: AP00000000
- Өвлөн уламжлагч хүнийг бүртгэх Бүртгэлийн дугаар нь: AP00000000 бүтэцтэй, 10 тэмдэгтийн зай байна. Үүнд:
- “AP” буюу Архангай аймаг – Засаг захиргааны нэгжийн товчлол
- “00”- эхний 2 орон тухайн сум, хорооны код автоматаар дугаарлагдана /жагсаалтыг бэлдэж өгнө/
- “00” дараагийн 2 орон 5 ай савын хамаарагдах код автоматаар дугаарлагдана.
- “0001” – Өвлөн уламжлагчийн дугаар байх ба автоматаар дугаарлагдана.

- СӨУНБМСанд 21 аймаг, нийслэлийн БМСангуудаас ирүүлсэн өвлөн уламжлагчийн бүртгэлийг баталгаажуулснаар СӨҮТ-өөс УНБМСанд бүртгэгдсэн тухай “Батламж”-ыг өвлөн уламжлагчид олгоно.
- СӨУНБМСанд эцэслэн бүртгэгдэх УНБМСангийн дугаар нь: AP000000000 /AP-аймгийн код, 00-сумын код, 00-5 ай савын код, 0000-бүртгэгдсэн өвлөн уламжлагчийн дугаарыг илэрхийлнэ/ бүтэцтэй, 10 тэмдэгтийн зай байна.

Өвлөн уламжлагчийн өвлөсөн өв, 5 ай сав, төрөл, зүйлийг сонгох талбар:

Соёлын өвийн үндэсний төвөөс баталсан СББӨ-ийн ерөнхий 5 ай саваар ангилсан өгөгдөлдлийг сонгох байдлаар оруулна. Дээрх 5 ай савын алинд нь тухайн СББӨ-ийн төрөл зүйл хамрагдахыг сонгон бөглөсний дараа ангиллын дотор хуваагдсан төрөл зүйлүүдийн аль нь болохыг мөн сонгоно. СББӨ-ийн ангилал доторх төрөл зүйлүүд мөн адил өгөгдлөөр бүртгэлийн програмд суугдсан байна.

Хэрэв тухайн өвийн нэр буюу төрөл, зүйл байхгүй бол бусад гэсэн хэсэгт оруулдаг байхаар хийгдэнэ. Энэ хэсэгт 5 ай сав хамаарахгүй.

Өвлөн уламжлагчийн мэдээлэл талбар:

Бодлогын даалгаварт:

МОНГОЛ УЛСЫН СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙГ

ӨВЛӨН УЛАМЖЛАГЧИЙН БҮРТГЭЛ

УНБМС-ийн дугаар \_\_\_\_\_

<u>Аймаг, Нийслэл Дүүрэг:</u> Тухайн аймаг, дүүргийн нэрийг автоматаар сонгогддог байхаар оруулах
<u>Сум, Хороо:</u> Тухайн сумын нэр, хорооны дугаарыг автоматаар сонгогддог байхаар оруулах

Соёлын биет бус өвийн тухайн илэрхийллийн нэр: 5 ай сав болон өвийн төрөл зүйлийн нэр автоматаар сонгогддог байхаар оруулах

Өвлөн уламжлагчийн мэдээлэл

Ургийн овог	50 хүртэлх тэмдэгт бичих зай	<p><b>Гэрэл зураг</b> Татаж оруулсан зургийн хамгийн эхний зураг автоматаар ордог байх</p>
Эцэг(эх)-ийн нэр	50 хүртэлх тэмдэгт бичих зай	
Өөрийн нэр	50 хүртэлх тэмдэгт бичих зай	
Хүйс	Сонгогддог байхаар	
Яс үндэс	Сонгогддог байхаар	
Төрсөн он сар өдөр	Сонгогддог байхаар	
Регистрийн дугаар	Сонгогддог байхаар	
Үндсэн захиргаа	Сонгогддог байхаар	
Оршин суугаа хаяг	Засаг захиргааны нэгж нь сонгогддог байхаар, бусад буюу хороолол, байрны дугаар, тоот нь бичигддэг байхаар /сум, хороо хэсэгт сонгогдсон бол шууд ордог байж болох уу/	

Мэргэжил	50 хүртэлх тэмдэгт бичих зай	
Боловсрол	Сонгогддог байхаар	
Эрхэлж буй ажил	100 хүртэлх тэмдэгт бичих зай	

Алдар цол, гавъяа шагнал	500 хүртэл тэмдэгтийн зай
Холбоо барих гар утас, гэрийн болон ажлын утас	50 хүртэлх тэмдэгт бичих зай

Тухайн хүний өвлөсөн биет бүс өвийн мэдээлэл

<u>Өвийн холбогдолтой домог, хууч яриа, түүх</u> 300-аас доошгүй тэмдэгтийн зай
<u>Хэзээ, хэнээс сурсан (хэд дэх үеийн өвлөн уламжлагч)</u> 300-аас доошгүй тэмдэгтийн зай
<u>Холбогдох зан үйл (ямар байдал, ёс журмаар гүйцэтгэдэг)</u> 300-аас доошгүй тэмдэгтийн зай
<u>Урын сан:</u> Хэдэн дуу, домог, үлгэр гэх мэт өвийн зүйлийн нэрсийг оруулна. 300-аас доошгүй тэмдэгтийн зай
<u>Өвийн онцлог шинж:</u> 300-аас доошгүй тэмдэгтийн зай
<u>Бусад</u> /бүртгэл хэсэгт ороогүй мэдээлэл, санал хүсэлт бичнэ./ 300-аас доошгүй тэмдэгтийн зай
<u>Хавсралт материалын тэмдэглэл:</u> Энэ хэсэгт хэдэн гэрэл зураг, хэдэн минутын дүрс бичлэг, хэдэн дуу, домог, үлгэр гэх мэт материал оруулсан тухай тэмдэглэлийг бичнэ. 300-аас доошгүй тэмдэгтийн зай
<u>Хавсралт:</u> Урын санд бичигдсэн өвийн зүйлсийн үг, нот, хэрхэн хийдэг талаарх тайлбар, тодорхойлолт зэргийн бичнэ. Татаж оруулдаг байхаар хийгдэнэ.

Өвлөн уламжлагч болон холбогдох гэрэл зураг

2 ширхэг өвлөгчийн болон өвийн холбогдох зураг байна. Dpi – 72 Pixel – 3000x2000-аас багагүй байна.	Татаж оруулахаар	Татаж оруулахаар
---	------------------	------------------

Бүртгэл хийсэн:

50 хүртэл тэмдэгтийн зай

50 хүртэл тэмдэгтийн зай

/ Овог, нэр/

/Албан газар, албан тушаал/

/20.... оны ..... сарын ..... -ны өдөр/

Байгууллага (музей), сум, дүүрэг, аймаг, нийслэл, улсын (сонгогддог) нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хадгалагдаж байгаа:

Д/д	Нэр төрөл	Тоо ширхэг, хэмжээ /gb/	Хадгалагдаж байгаа хэлбэр		Хадгаламжийн дугаар
			цахим	цаас	
1	Гэрэл зураг	26 хуудас, 28 gb			AP00000005-02
2	<del>Негатив хэлье</del>				
3	Дүрс бичлэг				
4	Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тайлан, бусад баримт				
5	Архив, ном, хэвлэлийн баримт				
6	Бусад				

Бүртгэл хийж дуусгаад баталгаажуулахад өвлөн уламжлагчийн эсвэл өвлөн суралцагчийн хэсэгт оруулах сонголт хийж байхаар байна.

Хэвлэх ажиллагааны тухай:

А-4 цаасны форматаар мэдээллээ хэвлэнэ. Хэвлэхдээ Word програмын зарчмаар хэвлэнэ. Үндсэн цонхоор хэвлэхээс гадна Хавсралтад орсон олон хуудас мэдээлэл бичигдсэн хэсгүүдийг тусад нь хэвлэж болно.

Хайлтын үр дүнд бий болсон хүснэгт, диаграм, график, тархалтын газрын зураг зэрэг мэдээллийг цаасан дээр босоо болон хэвтээ аль ч байдлаар хэвлэх боломжтой.

Веб програмд бичигдсэн бүртгэл нь тухайн байгууллагын БМС-д цаасан болон цахим хэлбэрээр тус бүр 1 хувь хадгалагдана.

Бүртгэл хайх, нэгтгэх, боловсруулах тухай

Бүртгэл хайх, нэгтгэх, боловсруулах систем нь 2 төрлийн байна.

1-рт Нэгж байгууллагад (музей) ажиллах буюу бүртгэл хийх програмд бүртгэл мэдээлэл дотроо ажилладаг хайлт, нэгтгэх, боловсруулах систем байна.

2-рт СӨҮТ-ийн УНБМС-нд 21 аймаг, 9 дүүргийн СББӨ-ийн УНБМС-нд цуглагдсан бүртгэл дээр хайлт, шүүлт хийх, мэдээлэх систем байна.

Хайлтын систем нь бэлэн өгөгдсөн өгөгдлөөр болон дурын хүссэн сонголтоор ажиллах зарчимтай.

Хайлтын систем нь засаг захиргааны нэгжийн бүртгэгдсэн болон бүртгэгдээгүй бүх СББӨ болон өвлөн уламжлагч, өвлөн суралцагчийн сүлжээнд ажиллах ба дор дурдсан бэлэн өгөгдлөөр хайлт хийх, мэдээлэл боловсруулах үйлдлийг хийнэ.

Энэ хайлтанд:

- УНБМС-ийн дугаар
- СББӨ-ийн 5 ай саваар
- СББӨ-ийг өвлөн уламжлагчийн нэр, байршил, хүйс, нас, регистрийн дугаараар



- -СББӨ-ийн бүртгэлийн ангилал, төрөл зүйл гэсэн өгөгдөл багтана.

Аймаг, нийслэлийн хувьд зөвхөн өөрсдийн харьяаллын хүрээнд дээрх мэдээллийг боловсруулах үйлдлийг хийнэ.

Програм хангамжинд тусгайлан бэлдсэн хайлтнаас гадна дурын сонирхсон нэр, зүйлээр хайх хайлт байна. Энэ хайлтын үр дүнд эхний байдлаар зөвхөн нэрс, УНБМС-ийн дугаар жагсагдан гарч ирэх ба цааш үргэлжлүүлэн нэрс, хайж буй бүртгэлийг нээж үзэх боломжтой болно.

#### Бусад

- Програм нь интернет сүлжээ ашиглан мэдээлэл дамжуулах тул тодорхой нууцлалтай байна.
- Мэргэжлийн дижитал гэрэл зургийн аппаратаар авсан зургийн нягтаршил автоматаар бүртгэлийн програмд нэг хэмжээнд шилжиж ордог байж болох уу.
- Програмын текст бичилтэнд урьд өмнө Microsoft WORD програм дээр бичигдсэн файлыг шууд зөөж хуулж болохоор ашиглах боломжтой ба англи монгол хэлээр солигдоно. (ARIAL үсгийн шрифтийг ашиглана.)
- Бичигдсэн бүртгэл мэдээллийг бүхий л төрлөөр хэвлэнэ. Үүнд хүссэн мэдээлэл, хайлт хийсэн нөхцлөөрөө хэрэглэгч мэдээллээ хэвлэж гаргах боломжтой.

#### III Арга зүй цэс:

Энэхүү цэсэнд орсон мэдээлэл нь шууд ороод үзэж болохоор мөн бүгд татаж авахаар байна.

1. Веб програмаар бүртгэл хийх заавар, арга зүйг татаж авахаар оруулах,
2. Соёлын биет бус өвийн бүртгэлийн дугаар өгөх тухай
3. Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн бүртгэлийн дугаар өгөх
4. Хууль, эрх зүйн болон холбогдох байгууллагуудын холбогдох линкүүдийг оруулах гэх мэт. /СӨҮТ-с бэлтгэж өгнө.

Жишээ нь: [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn), [www.monheritage.mn](http://www.monheritage.mn), [www.mecss.gov.mn](http://www.mecss.gov.mn), [www.culture.gov.mn](http://www.culture.gov.mn) гэх мэт.

#### Програмын ач холбогдол:

- Энэхүү програм нь монгол улсын хэмжээнд СББӨ, өвлөн уламжлагч, өвлөн суралцагчийг бүртгэх бүртгэлийн нэгдсэн тоон систем бий болно.
- Энэхүү програм нь Аймаг, нийслэл, сум дүүрэгт орших СББӨ, өвлөн уламжлагч, өвлөн суралцагчийн мэдээллийг тусгайлан бэлдсэн өгөгдлийн дагуу авч хадгалах, цуглагдсан мэдээллийг нэгтгэн боловсруулах, тоон дүнг богино хугцаанд гаргах, тархалтыг газрын зурагт буулгах, тоон дүнг график, хүснэгт, хувь хэмжээг гаргах
- СББӨ утсан тохиолдолд түүнийг сэргээхэд шаардлагатай бүхий л баримт мэдээлэл, онцлог шинжийг бодитой авсан гэрэл зураг, дүрс бичлэг нь бүртгэлийн програмд хадгалагдан үлдэх ач холбогдолтой.

ГҮЙЦЭТГЭСЭН:

М.ЦЭЦЭНБИЛЭГ. СОЁЛЫН ӨВИЙН БҮРТГЭЛ, СУДАЛГААНЫ  
ГАЗРЫН ДАРГА

Ж.НАСАНЖАРГАЛ. СОЁЛЫН ӨВИЙН БҮРТГЭЛ, СУДАЛГААНЫ  
ГАЗРЫН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН САНЧ  
ШИНЖЭЭЧ

ХЯНАСАН:

Г.ЭНХБАТ. СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРАЛ

-----oOo-----

**1.6. ЮНЕСКО-ийн Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өв-Лимбэний битүү амьсгааг хамгаалах ажлын I үе шат (ЮНЕСКО-ийн СББӨ-ийг хамгаалах конвенцийн 11 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх)**

**ЛИМБЭЧДИЙН УРТЫН ДУУНЫ УРЫН САНГ СУРВАЛЖЛАН ОЛОХ,  
БАРИМТЖУУЛАХ, ЦУГЛУУЛАХ, СУДАЛГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН**

“Монгол уртын дуу лимбэдэх уламжлалт арга битүү амьсгааг өвлүүлэн уламжлуулах, тогтворжуулах нь” төслийн ерөнхий мэдээлэл

ЮНЕСКО болон Соёлын өвийн үндэсний төв хооронд 2019 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр байгуулсан № 4500386779 тоот гэрээний дагуу Соёлын өвийн үндэсний төв, ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комисс, “Монголын Лимбэчдийн Холбоо” ТББ хамтран “Монгол уртын дуу лимбэдэх уламжлалт арга битүү амьсгааг өвлүүлэн уламжлуулж, тогтворжуулах нь” төслийг ЮНЕСКО-гийн Соёлын биет бус өвийн сангийн дэмжлэгтэйгээр 2019 онд эхний үе шатийг хэрэгжүүлж дуусгаад байна. Тус төсөл нь 2019-2021 оны хугацаанд 3 үе шаттай хэрэгжинэ.

Төслийн гол зорилго нь ЮНЕСКО-гийн Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн жагсаалтад 2011 онд бүртгэгдсэн “Монгол Лимбэчдийн уртын дуу хөгжимдөх уламжлалт арга барил-битүү амьсгаа” өвийг хамгаалахад Монгол Улсын Засгийн Газар, БСШУСЯ, Соёлын өвийн үндэсний төв болон шат шатны төрийн болон төрийн бус байгууллагуудын гаргасан хүчин чармайлтыг бэхжүүлэх, судалгааны ажлыг эрчимжүүлэх, өвлөн уламжлагчдыг алдаршуулах, залуу хойч үед өвлүүлэн уламжлуулах, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх замаар энэхүү өвийн тогтвортой байдлыг хангахад оршино.

Төслийн хүрээнд Монгол уртын дуу лимбэдэх уламжлалт арга битүү амьсгаа” өвийг өвлөн уламжлагчийг бүртгэн, баримтжуулах хээрийн судалгааны ажлыг зохион байгуулж, Соёлын өвийн үндэсний төв, Соёл Урлагийн Их Сургууль, Монгол улсын Консерватори, Ховд, Завхан, Өмнөговь аймагт лимбэний шавь сургалтын танхим байгуулагдана. Мөн DVD бүхий гарын авлага хэвлэж, баруун, зүүн, төвийн бүсийн хэмжээнд шавь сургалтыг зохион байгуулан ажиллана. Түүнчлэн лимбэ урлалын уламжлалт мэдлэгийг өвлүүлэх сургалт, “Тогтвортой хөгжил ба Монгол уртын дуу лимбэдэх уламжлалт арга битүү амьсгаа” эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж, “Монгол лимбэчдийн бүтээлийн дээжис” CD, лимбэчдийн намтар, танилцуулга бүхий ном хэвлүүлнэ. Мөн Монгол уртын дуу лимбэдэх уламжлалт арга битүү амьсгаа өвийн уламжлал, шавь сургалтын явцыг харуулсан баримтат кино бүтээж, өвлөн уламжлагчдын дунд уралдаант наадам зохион байгуулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан.

Төсөл хэрэгжснээр “Монгол уртын дуу лимбэдэх уламжлалт арга битүү амьсгаа” өвийг өвлөн суралцагчийн тоо 40 хүнээр нэмэгдэж, энэхүү өвийн оршин тогтнох чадвар бэхжих юм. Мөн “Монгол уртын дуу лимбэдэх уламжлалт арга битүү амьсгаа” өвийн талаарх олон нийтийн мэдлэг ойлголт нэмэгдэх болно.

### Төслийн нээлтийн үйл ажиллагаа

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны харьяа Соёлын өвийн үндэсний төв, ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комисс, “Монголын Лимбэчдийн холбоо” ТББ хамтран хэрэгжүүлэх “Монгол уртын дуу лимбэдэх уламжлалт арга битүү амьсгааг өвлүүлэн уламжлуулах, тогтворжуулах нь” төслийн нээлтийг 2019 оны 5 дугаар сарын 21-ны өдөр Монголын Театрын музейд зохион байгуулсан.

Нээлтийн үйл ажиллагаанд БСШУСЯ, Соёлын өвийн үндэсний төв, ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комисс, “Монголын Лимбэчдийн холбоо” ТББ, холбогдох байгууллага, эрдэмтэн судлаач, өвлөн уламжлагч, суралцагч зэрэг нийт 150 орчим хүн оролцсон.

БСШУСЯ-ны Соёл урлагийн бодлогын газрын дарга Б.Сэргэлэн нээлтийн үйл ажиллагааг нээж үг хэлэв.

Төслийн танилцуулгыг Соёлын өвийн үндэсний төвийн захирал Г.Энхбат хийж, Лимбэчдийн төлөөлөл Монголын хүүхдийн ордны лимбэ хөгжмийн багш Ч.Даваажавын сурагчид мэндчилгээ дэвшүүлэв.

Мөн Театрын музейд лимбэний үзэсгэлэнг дэглэн олон нийтэд сонирхуулсан.



ЮНЕСКО, Соёлын өвийн үндэсний төв, ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комисс, "Монголын лимбэчдийн холбоо" ТББ хамтран хэрэгжүүлж байгаа "Монгол лимбэчдийн уртын дуу лимбэдэх уламжлалт арга битүү амьсгааг өвлүүлэн, уламжлуулж, тогтворжуулах" нь төслийн хүрээнд лимбэчдийн уртын дууны урын санг сурвалжлан олох, дуу, дүрс бичлэгээр баримтжуулах, цуглуулах, өнөөгийн нөхцөл байдлын судалгааг хийх, судалгааны ажлаас цуглагдсан материал хэрэглэгдэхүүнээр Соёлын өвийн Улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санг баяжуулах зорилгоор 2019 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс 2019 оны 08 дугаар сарын 20-ны хооронд нийт 30 хоногийн хугацаанд Өмнөговь аймаг Дорноговь, Өвөрхангай, Говь-Алтай, Ховд, Завхан, Архангай, Дархан-Уул, Сэлэнгэ, Орхон, Булган, Хөвсгөл, Төв, Сүхбаатар гэсэн 14 аймгийн 24 сумдын нутгийг хамруулан хийлээ.

Судалгаанд хамрагдсан өвлөгчдийн ярилцлагыг бичвэр болгон буулгаж, гэрэл зургийн хамт тайланд хавсралтаар оруулав.

Судалгааны багийн бүрэлдэхүүнд:

- Багийн ахлагч: Ц.Цэвэгсүрэн /СУИС-ийн Хөгжмийн урлагийн сургуулийн Хөгжимдөх урлагийн тэнхимийн эрхлэгч, лимбэчин, “Монголын Лимбэчдийн Холбоо” ТББ-ын тэргүүн/  
 Багийн гишүүн: Ж. Насанжаргал /СӨҮТ-ийн Соёлын өвийн бүртгэл, судалгааны газрын соёлын биет бус өв хариуцсан бүртгэл мэдээллийн санч  
 Ц.Цолмон (Соёлын өвийн үндэсний төвийн Соёлын өвийг авран хамгаалах газар, Дэлхийн өвийн дурсгал хариуцсан мэргэжилтэн, судлаач)  
 Т.Даваа-Очир (СӨҮТ-ийн Мэдээллийн технологийн газрын зураглаач)  
 Ч.Хишигбат (Жолооч) нарын 5 хүний бүрэлдэхүүнтэй ажиллав.

“Монголын лимбэчдийн холбоо” ТББ, 21 аймгийн боловсрол соёл, урлагийн газартай хамтран 2019 оны 5-р сард Лимбэчдийн тандалт судалгааг урьдчилан хийсний үр дүнд Соёлын өвийн үндэсний төвийн Соёлын өвийн УНБМСанд лимбэний өвлөн уламжлагчдын 168 хүний мэдээлэл цуглагдсан байна. Хүснэгт 1

- Өвлөн уламжлагч – нийслэл-16 – орон нутагт-24
- Өвлөн суралцагч – 128
  - Албан сургалтаар орон нутагт 12 (Завхан аймгийн ХБК), нийслэлд – 55 (СУИС, Багш урлагийн боловсрол хөтөлбөр, СУИС-ийн Бадмаараг ЕБС, Монгол улсын консерватори, Шинэ монгол, Глобал ЕБС)
  - Албан бус сургалтаар орон нутагт – 45 (40 суралцагч төслийн хүрээнд), нийслэлд -16 (Монголын хүүхдийн ордон)
- Лимбэ урлаач - 15 хүн (дээрх өвлөн уламжлагч нараас давхардсан тоогоор 15 нь лимбэ урлаач нар байна.)

Хүснэгт №1

Лимбэний битүү амьсгаа			
№		Аймаг	нийслэл
1	Өвлөн уламжлагч	24	16
2	Өвлөн суралцагч	Албан	12
		Албан бус	45
3	Лимбэ урлаач хүн (дээрх өвлөн уламжлагч нараас 15 нь лимбэ урлаач нар байна)	/давхардсан тоогоор/	
Нийт		168	

Төслийн хүрээнд хийгдсэн хээрийн судалгаагаар Баруун, Говийн, Төвийн бүсийн 14 аймгийн 28 өвлөн уламжлагч болон анхлан суралцагч нарыг сонгон судалгаанд

хамруулан урын сан, лимбэ тоглох арга барил, намтар түүхийг дуу, дүрс бичлэгээр баримтжуулан УНБМСанд авч архивлав.



Судалгаанд хамрагдсан лимбэч өвлөн уламжлагч,  
суралцагчдын судалгаа

Хүснэгт №2

№	Овог, нэр	Харьяалал	Төрсөн он	Хүйс	Ажил, мэргэжил
<i>Лимбэний уламжлалт битүү амьсгааг өвлөн уламжлагч</i>					
1	Ө.Батжаргал	Өмнөговь аймаг, Даланзадгад сум	1949	эрэгтэй	Өвлөн уламжлагч
2	С.Туяахүү	Өмнөговь аймаг, Ханхонгор сум	1961	эрэгтэй	Соёлын төвийн эрхлэгч
3	Б.Отгондүү	Дорноговь аймаг	1960	эрэгтэй	Саран хөхөө театрын хөгжмийн багш
4	Т.Мөнхдалай	Дорноговь аймаг, Иххэт сум	1968	эрэгтэй	Өвлөн уламжлагч
5	Л.Жамбалдорж	Говь-Алтай аймаг Есөнбулаг сум	1956	эрэгтэй	Говь-Алтай аймгийн Алтай чуулгын хөгжимчин
6	Ц.Болдбаатар	Говь-Алтай аймаг	1977	эрэгтэй	Говь-Алтай аймгийн Алтай чуулгын хөгжимчин
7	У.Жанчивдорж	Говь-Алтай аймаг Есөнбулаг сум	1979	эрэгтэй	Говь-Алтай аймгийн Алтай чуулгын хөгжимчин
8	Н.Баярцэнгэл	Өвөрхангай аймаг, Арвайхээр хот	1980	Эрэгтэй	Өвөрхангай аймгийн БСУГ-ын мэргэжилтэн
9	Ч.Ваша	Ховд аймаг	1955	Эрэгтэй	Өвлөн уламжлагч
<i>Лимбэ хөгжмийг өвлөн суралцагч</i>					

10	М.Ундармаа	Ховд аймаг, Манхан сум	1992	Эмэгтэй	Өвлөн уламжлагч
11	Н.Цэрэнпил	Орхон аймаг	1985	эрэгтэй	“Уурхайчин” соёлын ордны гэрээт хөгжимчин,
12	Б.Ганзориг	Хөвсгөл аймаг, Бүрэн сум	1984	эрэгтэй	Авьяас сургуулийн Лимбэ, хөөмэйн багш
13	.Өлзийдүүрэн	Хөвсгөл аймаг, Цэцэрлэг сум	19	эрэгтэй	Хөгжимт драмын театрт хөгжимчин
14	Б.Энхжин	Өмнөговь аймаг, Цогт-Овоо сум	2004	эмэгтэй	Өмнөговь аймгийн ЕБ-ын 2-р сургуулийн 106 ангийн сурагч
15	А.Уранжаргал	Дорноговь аймаг, Сайншанд сум	1992	эмэгтэй	Музей сургалт судалгааны төвийн ЭША
16	Ч.Эрдэнэбаатар	Дорноговь аймаг, Сайншанд сум	1989	эрэгтэй	Сайншанд өртөөнд Туслах жижүүр
17	Б.Баттайван	Дорноговь аймаг, Сайншанд сум	1988	эрэгтэй	Дорноговь аймгийн 5 дугаар сургуулийн дуу хөгжмийн багш
18	Р.Түмэнбаатар	Говь-Алтай аймаг, Баян-Уул сум	1976	эрэгтэй	Өвлөн уламжлагч
19	Б.Батцогт	Хөвсгөл аймаг, Улаан-Уул сум	1966	Эрэгтэй	Соёлын төвийн Дархад дууны багш
20	Ш.Жамьяанмядаг	Завхан аймаг, Улиастай хот	1942	9905927 5	Өндөр настан 99003908
21	Н.Батмөнх	Завхан аймаг, Шилүүстэй сум	/1970- 2019/	эрэгтэй	Шилүүстэй сумын ЕБС-ын хөгжмийн багш
22	Б.Батжаргал	Завхан аймаг, Идэр сум	1983	эрэгтэй	Идэр сум, Хаан банкны ажилтан
23	М.Гантөмөр	Завхан аймаг, Идэр сум	2003	эрэгтэй	Завханы ХБК-ын 11-р ангийн сурагч
24	С.Ганболд	Дархан-Уул	1957	эрэгтэй	Өвлөн уламжлагч
25	З.Ган-Эрдэнэ	Дархан-Уул	1977	эрэгтэй	“Залуучууд театр”-ын лимбэчин
26	Т.Отгонгэрэл	Дархан-Уул	1978	эрэгтэй	Өвлөн уламжлагч

27	С.Дугар	Сэлэнгэ аймаг, Сайхан сум Номгон тосгон	1960	эрэгтэй	Соёлын төвийн эрхлэгч
28	М.Наранбат	Сүхбаатар аймаг	1983	Эрэгтэй	3-р сургуулийн багш

## ӨМНӨГОВЬ АЙМАГТ ТОМИЛОЛТООР АЖИЛЛАСАН ТУХАЙ ТАЙЛАН

2019 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс 3 хоногийн хугацаагаар Өмнөговь аймгийн Даланзадгад, Ханхонгор сумдад ажиллав.

Судалгааны баг 06 дугаар сарын 02-ны өдөр Улаанбаатар хотоос 13:00 цагт гарч Өмнөговь аймгийн төв Даланзадгад хотод оройн 22:00 цагийн орчим очиж Өмнөговь аймгийн Боловсрол, Соёл урлагийн газрын мэргэжилтэн Б.Сайнгэрэлтэй уулзан удирдамжаа танилцуулж маргааш өдрийн хийх ажлаа төлөвлөв. Аймгийн Нийгмийн бодлогын газрын дарга, Боловсрол, Соёл урлагийн газрын дарга, мэргэжилтэн, Лимбэч МУГЖ Б.Батжаргал нарын хамт тус аймгийн 1-р сургуулийн “Хүүхэд хөгжлийн төв”-д Соёлын өвийн үндэсний төвөөс хэргэжүүлж буй “Монгол уртын дуу лимбэдэх уламжлалт арга битүү амьсгаа” төслийн хүрээнд жишиг танхимын загвараар Лимбэний танхим байгуулж нээлтийн ажиллагааг хийсэн. Тус танхимыг Лимбэч, өвлөн уламжлагч МУГЖ Б.Батжаргал хариуцан шавь сургалт явуулах багшаар сонгогдож гэрээ байгуулж ажиллахаар тохиролцов.



Лимбэч Ө.Батжаргал нь эдүгээ 70 насыг гарч яваа ба 1978 оны үндэсний хөгжимчдийн улсын анхдугаар уралдаанд хөдөө орон нутгаас оролцсон цөөн тооны хөгжимчний нэг байсан төдийгүй амжилттай оролцож лимбэний төрөлд 3-р байрын шагналыг хүртсэн чадварлаг лимбэчин билээ.



2019 оны 6 дугаар сарын 03-ны өдөр Өмнөговь аймгийн төвөөс 18 км зайд орших “Мухар шивэрт” нэртэй байгалийн өвөрмөц тогтоцтой газар Лимбэч, өвлөн уламжлагч МУГЖ Ө.Батжаргал, “Дөрвөн цаг” дууг лимбэдэж, өөрийн намтар, түүх, анх лимбэ заалгаж байсан багш нар, лимбэний битүү



амьсгаа өвийг хэрхэн өвлөн суралцаж байгаа, энэхүү өвд хэрхэн суралцах, хойч үедээ хэрхэн уламжлуулах сургалтын болон хөгжимдөх арга



барил зэргийг ярилцлага байдлаар дэлгэрэнгүй баримтжуулсан. Мөн түүний шавь Б.Энхжин нар нь лимбэний битүү амьсгааны энэ өвийг эзэмшин шимтэн суралцаж байгаа ба бидний энэхүү судалгааны ажилд хамрагдаж Цогт-овоо сумаас хүрэлцэн ирж, дүрс бичлэг, баримтжуулалтад хамрагдсан юм.

2019 оны 6 дугаар сарын 04-ны өдөр Ханхонгор сумын соёлын төвийн эрхлэгч Лимбэ хөгжмийн өвлөн уламжлагч С. Туяахүүтэй уулзаж өөрийн намтар, түүх, лимбэ хөгжим тоглох арга барилыг баримтжуулсан. 2019 оны 6 дугаар сарын 05-ны үүрээр Ханхонгор сумын тэмээчин айлд очиж, лимбэч Б.Батжаргал, морин хуурч нар лимбэ, морин хуурын эгшигт ботгоо голсон ингийг уярааж, ботгыг нь авхуулдаг байсан судлаач, ахмад лимбэчид, ард түмний яриаг баримтжуулах маягтай дүрс бичлэгийг хийсэн.

Мөн тус аймгийн музейд хадгалагдаж буй Лимбэний гэрэл зураг, дүрс бичлэгийг хийж, хэрхэн музейд ирсэн талаар хэд хэдэн аман мэдээг баримтжуулан авсан.

“Хаш лимбэ”-ний тухай: Өмнөговь аймгийн музейд байгаа “Хаш Лимбэ”-ний талаар янз бүр л ярьдаг. Намайг /Б.Батжаргал/ цэргээс 1972 онд халагдаад ирхэд л тэр лимбэний тухай яриа болж байсан. Баян-Овоо сумын Бунхантын худаг дээр Өндөр Лувсан гэж айлд нэг хаш лимбэ байдаг тухай сонсоод очсон байна.

Тухайн үед 2 мөнгөн бөгжтэй байсан санагдаж байна, сүүлд хугалаад 2 ч гуйлин материал оруулсан, тэр үед үлээж үзэхэд их сайхан дугарч байсан, манай бригадийн дарга энэ чинь одоо хэзээ яаж олсон талаар асуухад, 1932 оны үймээн самууны хөдөлгөөнөөр нэг айл урагшаа /хятадруу/ нүүж явсан гэнэ, харуй бүрий болж байхад цаанаас нь хилийн цэрэг буудаж, тэгсэн тэмээ мал нь туйлаад зарим хүмүүс нь цаашаа хил гараад, зарим нь наашаа буцаж зугтаагаад тэр үеэр урд говьд баахан юм хаягдсан юм гэнэ лээ, айлын гэр орон, авдар сав, сагсан тэгнээтэй тэмээтэй 2 хүүхэд бүтэн 2 өдөр говиор эзэнгүй явсан гэж ярьдаг, тэгээд тэрүүгээр хөглөрсөн юмнуудыг энэ “Долоо”-гийн хийд дээр цуглуулж авчирсан, одоогийн Баян-Овоо сумын төв, тэгээд зар тарааж урьд говьд юмаа гээсэн хүмүүс ирж юмаа таньж авцгаа гээд, хүмүүс ирээд аваад байсан, сүүлдээ жоожон юм үлддэг юм байна тэр дотор 2 хугарсан хаш лимбэ үлдэж хүн ирж авахгүй байхаар нь Лувсан гуай авсан байна.Тэгээд бөгжилчхөөд гэртээ байлгаад байсан байгаан, тэгээд очиж анх дугаргасан нь би. Сүүлд нь Данзанравжаа гуайн лимбэ гэж яриад байгаа, охин нь л нэг тэгэжсхийгээд ярисан юмуу даа. Тэр өвгөн бол тэгэж яриагүй, тэр үед надад ингэж л хэлсэн. Сүүлд музейд ирсэн байсан, Бадраа гуай надаар нэг үлээлгэж бичлэг хийсэн.

## ДОРНОГОВЬ АЙМАГТ ТОМИЛОЛТООР АЖИЛЛАСАН ТУХАЙ ТАЙЛАН

2019 оны 7 дугаар сарын 20-ны өдрөөс 3 хоногийн хугацаагаар Дорноговь аймгийн төв Сайншанд хотод ажиллав.

МУГЖ М.Дорж, Тээгэн хэмээх Самбуу, Б.Отгондүү, Н.Батнасан зэрэг олон лимбэчдийн өлгий нутаг юм.

Тус нутгийн өвлөн уламжлагч, залуу үеийн төлөөлөл Б.Отгондүү, Т.Мөнхдалай, Б.Баттайван, А.Уранжаргал, Ч.Эрдэнэбаатар нарын урын сан, лимбэ хөгжимдөх арга барилыг судлан дуу, дүрс бичлэгээр баримтжуулав.

Төслийн хүрээнд хийгдэх шавь сургагч багшаар Дорноговь аймгийн “Саран хөхөө” театрын Хөгжмийн багш Б.Отгондүү сонгогдож, лимбэний битүү амьсгаа, лимбэдэх ур чадварыг өвлүүлэх сургалтыг 3 жилийн хугацаанд Саран хөхөө театр, Музейн сургалт судалгааны төвд тулгуурлан хэрэгжүүлэхээр тохиролцов. Б.Отгондүү нь МУГЖ, нэрт лимбэч М.Бадамын лимбэдэх арга ухаан, авийг уламжилж яваа лимбэчин юм.

Мөн энэ үеэр Дорноговь аймгийн Музей сургалт, судалгааны төвийн сан хөмрөгт хадгалагдаж буй лимбэ хөгжмийн төрлүүдийн тухай, аймагт ажиллаж амьдарч буй лимбэчдийг оролцуулсан баримтат киноны зураг авалт, судалгааны ажил амжилттай зохион байгуулагдсан.

“Саран хөхөө” театрын хөгжимчин, Лимбэч, өвлөн уламжлагч Б.Отгондүү, түүний шавь өвлөн суралцагч А.Уранжаргал нарыг



аймгаас баруун урагш 45 км зайд орших Хамрын хийдийн цогцолбор газарт, Т.Мөнхдалай, Б.Баттайван нарыг Дорноговь аймгийн Музей, сургалт судалгааны төвийн Орчин үеийн танхим, Сүлд шүтээний танхимд, Ч.Эрдэнэбаатарыг өөрийн гэрт нь хөгжимдөх арга барил, намтар, түүх, сургалтын арга барил зэргийг дэлгэрэнгүй байдлаар дуу, дүрс бичлэг, гэрэл зургаар баримтжуулав.

Ерөөлч, магтаалч, Туульч

З.Чулуунбаатар агсаны хүү, лимбэний өвлөн суралцагч Ч.Эрдэнэбаатарынд аавынх нь хадгалж байсан Лимбэний тухай сурвалжлав. Энэхүү лимбэ нь Тээгэн Самбуу гэх нутаг орондоо алдартай лимбэчин хүний хэрэглэж байсан лимбэ гэдгээрээ онцог юм.

Өвлөн суралцагч Ч.Эрдэнэбаатарын ярьснаар: Дээр үед уран сайхан, суртлын бригад гээд хөдөөгүүр цуг явж байх үед Тээгэн Самбуу гэж манай нутгийн алдартай лимбэчин хүн байж, тухайн үед тэр хүний эдэлж хэрэглэж байсан хөгжмийн зэмсэг лимбэ нь манайд байдаг юм. Энэ лимбийг манай аав сүүлд хожим хойно 2000-аад оны үед айлын хог дээрээс олж ирсэн, өмнө нь мөнгөн тоногтой байсан, тухайн айл нь мөнгөн тоногнуудыг нь аваад хаясан, юм мэддэггүй хүнд хуучин муу мод л харагддаг юм байлгүй, тэгээд манай аав энэ чинь мундаг алдартай хүний лимбэ байна та нар хэрэггүй гээд хаяж байгаа бол ах нь авчъя гээд хэлсэн чинь тухайн айл нь тэгвэл бас зүгээр өгөхгүй гээд 5 төгрөгөөр өгч байсан гэж ярьдаг

байсан. Бид бол энэ лимбийг бурхан тахил, морин хууртайгаа адил хүндэтгээд хоймортоо залаад явж байдаг. Энэхүү лимбэ нь 4 хурууны барилаар тоглодог тэгш даралтад лимбэ, 5 таван эгшигтийн тогтолцооны хөгийг хадгалдаг, 6 нүхний хоорондын зай эн тэнцүү байдаг хуучны лимбэ юм.

Дорноговь аймгийн орон нутаг судлах музейд хадгалагдаж байгаа хулсан лимбэ 1, мөнгөөр бөгжилсөн лимбэ 1, төмөр материалтай лимбэ 1-ийг тус музейн тайлбарлагч, боловсролын ажилтан Б.Болорчимэг тодорхойлолт, бүтэц, түүхийн талаар тайлбар өгч дүрс бичлэгээр баримтжуулав.

Дорноговь аймгийн музей сургалт, судалгааны төвийн тайлбарлагч, боловсролын ажилтан Болдбаатар овогтой Болорчимэг музейн сан хөмрөгт байгаа лимбэнүүдийн тодорхойлолт, тайлбарыг хэлж баримтжуулалтад оролцов.



Дорноговь аймгийн Дорноговь аймгийн Музей, сургалт судалгааны төвийн сан хөмрөгт хадгалагдаж байгаа Лимбэ болон, Бишгүүрүүд байна, манай музей бол 1975 оноос эхлээд үзмэр цуглуулга, баяжилт хийж эхэлсэн, эхний лимбэ бол 1975 онд орон нутаг судлах кабинетийн эрхлэгч Мятав гуайн цуглуулсан ган төмрөөр хийсэн мөнгөн тоногтой ийм лимбэ хадгалагддаг байгаа, 2 дахь лимбэ нь 1985 онд манай музейн үзмэр цуглуулгаар орж ирсэн, нутаг судлах музейн эрхлэгч Баатар гэж хүн цуглуулсан байгаа, энэхүү лимбэ бол хулсаар хийсэн мөнгөн тоногтой, Тээгэн Самбуу гэж хүний эдлэж хэрэглэж байсан эд өлгийн зүйл гэдгээрээ онцлох үзмэр юм. Дараагийн лимбэ бол Соёлын тэргүүний ажилтан Батнасан багшийн эдлэж хэрэглэж байсан эд өлгийн зүйл байна, хулсаар хийсэн, Батнасан багш манай музейн сан хөмрөгт өөрөө бэлэг болгож өгсөн, манай музейн сан хөмрөгийн эрхлэгч Сарангэрэл гэж хүн цуглуулсан эд өлгийн зүйл юм. Манай музейн сан хөмрөгт хадгалагддаг нэг онцлох үзмэр байна энэ бол Хүрэн модоор хийсэн, төмөр тоногтой, 7 нүхтэй үлээвэр хөгжмийн зэмсэг, мөн ижил хээтэй, хээ угалзтай, ижил модоор хийсэн, төмөр тоногтой эд өлгийн зүйл хадгалагддаг, нэгэн төрлийн үлээвэр хөгжмийн зэмсэг болов уу гэж таамаглаж байгаа.

Өвлөн суралцагч Ч.Эрдэнэбаатарт хадгалагдаж байгаа Тээгэн хэмээх Самбуугийн хулсан лимбэ, аймгийн музейд хадгалагдаж байгаа 2 хулсан лимбэ дуугарч байгаа ба мөн л эгшиг дуурьсгах 6 цоолбор хоорондын зай эн тэнцүү, минорын эгшиглэгээтэй лимбэнүүд байв.

## ӨВӨРХАНГАЙ, ГОВЬ-АЛТАЙ, ХОВД, ЗАВХАН, АРХАНГАЙ АЙМАГТ ТОМИЛОЛТООР АЖИЛЛАСАН ТУХАЙ ТАЙЛАН

2019 оны 06 дугаар сарын 24-ны өдрөөс 14 хоногийн хугацаагаар Өвөрхангай, Говь-Алтай, Ховд, Завхан, Архангай аймагт ажиллав.



Баруун бүсийн судалгааны ажил Өвөрхангай аймгаас эхлэв. Тус аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын мэргэжилтэн, Лимбэч Н.Баярцэнгэлийн урын сан, хөгжимдөх арга барил, намтар түүхийг Өвөрхангай аймгийн Арвайхээр хотоос баруун хойш 1 км-т орших байгалийн өвөрмөц тогтоцтой “Хадан цохио”-г сонгож дуу, дүрс бичлэгээр баримтжуулав.

Лимбэч Н.Баярцэнгэл нь 1980 онд Дархан-Уул аймагт айлын 3 дахь хүү болж мэндэлсэн. 1992 онд Дархан-Уул аймагт Урлагийн мэргэжлийн сургууль байгуулагдаж МУГЖ Цэрэндорж багшийн ууган шавь нарын нэг Ганболд багш дээр Лимбэ хөгжмөөр суралцаж анхны төгсөгч нь юм. 1998 онд Соёл урлагийн их сургуульд Лимбэ хөгжмийн ангид

элсэн орж Н.Жамбалжанц, Ц.Цэвэгсүрэн багш нарын удирдлага дор суралцаж 2003 онд төгссөн. Сурч байх хугацаандаа мэргэжлээрээ /лимбэ хөгжим/ Цүки интэрнэшнл ХХК-ны “Сарны чулуу” чуулга, Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрийн “Уурхайчин” соёлын ордонд гоцлол хөгжимчнөөр ажиллаж байгаад сургуулиа төгсөөд Өвөрхангай аймагт ажил, амьдралынхаа гарааг эхлүүлсэн. 2003 онд Өвөрхангай аймгийн Хөгжимт драмын театрт гоцлол хөгжимчин, 2006 онд найруулагч, уран сайхны удирдаач, 2014 онд тус театрын даргаар ажиллаж байгаад одоо Өвөрхангай аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын Соёл урлагийн хэлтэст мэргэжлийн урлагийн байгууллага, сумдын соёлын төв, соёл урлагийн бодлогын хэрэгжилт хариуцсан мэргэжилтнээр ажиллаж байгаа өвлөн уламжлагч юм. Тэрээр ярихдаа: Би долоо, наймдугаар ангийн 8 шавьтай, тэд нар маань дөнгөж анхлан суралцаж байгаа хүүхдүүд байгаа тухайгаа дэлгэрэнгүй яриад өнөө цагт хэрэглэж байгаа 3 төрлийн лимбэний онцлогийн талаар ярьж, бусад орны лимбэний хийц-бүтээц хөгжимдөх арга барилын онцлогийг өөрийн орны лимбэ, хөгжимдөх арга барилын онцлогтой харьцуулан ярьж, лимбэний битүү амьсгааны өвийн талаар ярьсан юм.



Говь-Алтай аймгийн 3 өвлөн уламжлагчийг аймгийн “Алтай” чуулгын байр, хөгжмийн өрөө, холбоочин Жанчивын талбайд дүрс бичлэгээр баримтжуулав.

Уг аймагт ажиллаж амьдарч байгаа лимбэч Жамбалдорж эдүгээ 63 настай 40 жил лимбэдэж байгаа өвлөн уламжлагч юм. Тэрээр одоогоор Алтай чуулгын хөгжмийн багшаар ажилладаг ба лимбээ бараг тоглохгүй байна. Өөрийн энэхүү өвийг Жанчивдорж гэж чуулгынхаа эвэр бүрээч залууд уламжлуулж байгаа талаар ярьсан юм. Лимбэч Жамбалдорж нь аймгийнхаа төв талбайд өөрийн намтар, түүх, тухайн орон нутагт ажиллаж байсан амьдарч байсан өв уламжлагчид, өвийн

тухай ярилцлагыг өгч, нутгийн уртын дуу “Жороо баахан улаан” дууг лимбэдэж баримжуулалт хийлгэсэн.

Мөн энэ өдөр Халиун сумын хөгжмийн багшаар ажилладаг өвлөн уламжлагч Ц.Болдбаатар энэхүү өвийг хэрхэн суралцсан, өвийн онцлог шинж, хэрхэн уламжлуулах байгаа талаараа хүүрнээд чуулгад байрладаг орон нутгийн гэрлэх ёслолын ордонд “Дөрвөн цаг” уртын дууг лимбэдэн бичүүлж баримтжуулсан юм.



Ховд аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын байранд жишиг танхимын загвараар Лимбэний танхим байгуулав. Танхимын нээлтийн үйл ажиллагаанд аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөл, аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын дэд дарга, соёл хариуцсан мэргэжилтэн С.Алтангарэл болон ажилтнууд оролцож сургалтийг Лимбэч, өвлөн уламжлагч Ч.Ваша явуулахаар болов. Тус сургалтын танхимийг Ховд аймгийн ЗДТГ, БСУГ-ын газар нэмэлтээр шаардлагатай хөшиг, дуу чимээ тусгаарлагч хавтан зэргээр тоноглож дэмжин ажиллахаа илэрхийлсэн.

Ховд аймаг нь МУГЖ, нэрт лимбэч М.Бадам, өвлөн уламжлагч Ч.Ваша нарын



өлгий нутаг юм. Ч.Ваша нь МУГЖ, алдарт лимбэч Л.Цэрэндоржийн анхны шавь нарын нэг бөгөөд эдүгээ 62 настай ахмад өвлөн уламжлагч юм. Ч.Вашагийн намтар, түүх, дадлага, туршлага, тухайн орон нутагт байсан өв уламжлагчид, лимбэтэй холбоотой түүх, домог, зан үйлийн талаарх

яриаг аймгаас 30 гаруй км-т орших байгалын үзэсгэлэнт газар хийж, нутгийн ардын дууг лимбэдсэн бичлэгийг дүрс бичлэгт баримтуулсан.



Завхан аймгийн Хөгжим бүжгийн коллежийн байранд жишиг танхимын загвараар Лимбэний танхим байгуулав. Тус коллежийн Лимбэний багш Н.Эрдэнэлхавга хариуцан ажиллахаар болов. Аймгийн музей, ХБК-ийн захирал, удирдлагуудад танхимийг хүлээлгэн өгч, өвийг уламжлуулах энэ сургалтанд анхаарлаа хандуулж хамтран ажиллахаа ярилцав. Завхан аймаг нь хөгч хэмээн алдаршсан Сандаг, лимбэч П.Пүрэвжав, Л.Алтансүх зэрэг

чадварлаг лимбэчдийн өлгий нутаг юм. Тухайн орон нутгаас энэхүү өвийг уламжилж байгаа цөөнгүй залуу лимбэчид байдгаараа онцлог байна.

Хөгч Сандаг хэмээн уртын дууч, лимбэчний өвийг өвлөн уламжилж ядаа эдүгээ 80 гаран настай Шилүүстэй сумын иргэн Жамьянмядаг гэдэг хүнтэй аймгийн музейд ярилцаж, түүнд хадгалагдаж байгаа багш хөгч Сандагийн лимбийг гэрт очиж үзэж танилцсан юм. тэрээр энэхүү лимбээ аймгийн музейдээ хадгалуулна хэмээн бидэнд ярьсан юм. Түүний энэ лимбэ нь эгшиг дуурьсгах 6 цоолбортой, цоолбор хоорондын зай энэ тэнцүү, минорын хөг эгшиглэгээний тогтолцоотой, хулсан лимбэ байсан. Мөн аймгийн өвлөн уламжлагчдыг бүртгэх бүртгэл мэдээллийн сангийн мэдээллээр Идэр, Нөмрөг сумдад байгаа лимбэ сонирхогч, суралцагчидтай уулзаж баримтжуулалт, баримтат киноны зарим зураг авалтийг хийсэн болно.



## СҮХБААТАР АЙМАГТ ТОМИЛОЛТООР АЖИЛЛАСАН ТУХАЙ ТАЙЛАН

ЮНЕСКО, Соёлын өвийн үндэсний төв, ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комисс, "Монголын лимбэчдийн холбоо" ТББ хамтран хэрэгжүүлж байгаа "Монгол лимбэчдийн уртын дуу лимбэдэх уламжлалт арга битүү амьсгааг уламжлуулан өвлүүлэх, тогтворжуулах" нь төслийн хүрээнд лимбэчдийн уртын дууны урын санг сурвалжлан олох, дуу, дүрс бичлэгээр баримтжуулах, цуглуулах, өнөөгийн нөхцөл байдлын судалгааг хийж, судалгааны ажлаас цуглагдсан материал хэрэглэгдэхүүнээр Соёлын өвийн Улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санг баяжуулах зорилгоор 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөс 3 хоногийн хугацаанд Сүхбаатар аймагт ажилласан.

Судалгааны багийн бүрэлдэхүүнд:

Багийн ахлагч: О.Мэндсайхан /СӨҮТ-ийн Захиргаа, удирдлагийн газрын дарга/

Багийн гишүүн: Ж. Насанжаргал /СӨҮТ-ийн Соёлын өвийн бүртгэл, судалгааны газрын соёлын биет бус өв хариуцсан бүртгэл, мэдээллийн санч

Д.Нянгар /Жолооч/ нарын 3 хүний бүрэлдэхүүнтэй ажиллав.

Сүхбаатар аймагт урьдчилсан тандалт судалгаагаар 2 лимбэч, өвлөн уламжлагч бүртгэгдсэн ба Баруун-Урт хотод оршин суух 1 өвлөгчийг баримтжуулав. Баруун урт хотоос 220км-т орших Эрдэнэцагаан суманд оршин суудаг лимбэч, өвлөн уламжлагч Мишигдорж овогтой Ганболд нь хойшлуулашгүй ажилтай байсан тул 2020 онд баримтжуулхаар тохиролцов.

Максим овогтой Наранбат. 1983 онд Сүхбаатар аймгийн наран суманд төрсөн, Сүхбаатар аймгийн 3-р сургуулийн дуу хөгжмийн багш, 14 настайдаа анх лимбэ гэдэг хөгжмийг сурсан, энэ хөгжмийг манай дуу хөгжмийн багш МУСТА Оюун багш нэг лимбэ өгөөд үлээж сурна, дуу тоглодог болно гэж байсан, манай нутгийн Төмөрсүх гэж ахаар анх лимбэ үлээх, гэр хурууны барил тавилыг заалгаж “Цэнхэрлэн харагдана” гээд Монгол ардын дууг заалгаж байлаа. Битүү амьсгаагаар тоглодоггүй. Аймгийн хэмжээнд лимбээрээ оролцдог, оюутан байхдаа буриад дууг эвлүүлэг болгон тоглож байхад аяа сурахад бага зэрэг хэцүү байсан, одоо бол нутгийн дуунуудыг сонсоод шууд тоглоно. Энэ лимбийг /гуулин лимбэ/ оюутан байхад багш маань өгч байсан, орон нутагтаа соёл урлагийн үйл ажиллагаанд оролцохдоо энэ лимбээрээ л тоглодог. Дээр үеийн Хулсан лимбээр багшийнхаа бичсэн зохиолыг тоглож үзэж байхад хөглөгөө муутай, гуулин лимбнээс ялгаатай байдаг.



Дарьганга ардын дуу “Торгоны хээ” дууг тоглож үзүүлэв. Лимбэч өвлөн уламжлагчийн 2.13 gb хэмжээтэй дуу, дүрс бичлэгийг хийж УНБМСанд авч архивлан хадгалсан болно.

#### Судалгааны үр дүн:

Орон нутгийн Лимбэний өвлөн уламжлагчдын урын сан, ур чадвар, тоглох арга барилыг харьцуулсан суурь судалгаа хийгдсэнээр цаашид авах хамгаалалтын арга хэмжээг тодорхойлох, нөхцөл байдлыг үнэлэх боломжит мэдээллийг цуглуулсан гэж үзэж байна. Үүнд:

- Өвлөгч, өвлөн суралцагч болон Лимбэний битүү амьсгаа өвийг өвлөгч нарыг улсын хэмжээнд олж тогтоосон.
- Шавь сургалт явуулах сургагч багш нарыг олж тогтоосон.
- Өвлөгч болон суралцагчдын ур чадвар, урын санг тухайн орон нутагт нь дуу, дүрс бичлэгээр баримтжуулж УНБМСанг баяжуулсан.
- Орон нутгийн музей, хувь хүмүүст хадгалагдаж байгаа лимбэний хийц-бүтэц, хөг эгшиглэгээ, эгшиглээний онцлог, тэдгээрийг хэрэглэж байсан хүмүүсийг тодруулж баримтжуулсан.

-----х-----

## “ЛИМБЭДЭХ УЛАМЖЛАЛТ АРГА БИТҮҮ АМЬСГААНД СУРАЛЦАХ НЬ” ГАРЫН АВЛАГА ХЭВЛЭСЭН ТУХАЙ

Төслийн хүрээнд баруун, зүүн, төвийн бүсийн хэмжээнд шавь сургалтад ашиглах “ЛИМБЭДЭХ УЛАМЖЛАЛТ АРГА БИТҮҮ АМЬСГААНД СУРАЛЦАХ НЬ” DVD бүхий гарын авлагыг боловсруулан гаргаж гарын авлага, номын нээлтийг Юнеско-гийн Монголын үндэсний комиссын хурлын танхимд 2019 оны 10 дугаар сарын 16-ны 11:00 цагт хийсэн.



Нээлтийн үйл ажиллагаанд Юнеско-гийн Монголын үндэсний комисс, Соёлын өвийн үндэсний төв, Монгол Лимбэчдийн холбоо ТББ, Соёл урлагийн их сургууль, Монгол улсын Консерватори, Монголын хүүхдийн ордон, Глобал олон улсын дунд сургуулийн төлөөллүүд, Лимбэний өвлөн уламжлагч, суралцагч, нар оролцсон.

Энэхүү гарын авлагт монгол лимбэний хийц, бүтэц, лимбэдэх барил, тавил, амьсгааны төрөл, хэлбэр, хэлний цохилго ба хэллэг, хурууны хувиарилал, даралтын хувилбарууд, битүү амьсгаанд суралцах аргачлал, дөрвөн хуруугаар лимбэдэх аргын хувилбар, 57 үгний нэр томъёоны тайлбар хийж, бэсрэг болон айзам уртын дуунуудыг хөгжимчдийн хөгжимдсөн арга барилаар нь нотлон оруулж, DVD-нд битүү амьсгаанд суралцах хичээл, 6 хувилбар бүхий дасгал, алдарт гавьяат лимбэч

Л.Цэрэндорж, МУГЖ М.Дорж, СТА Д.Энхтайван, Ц.Цэвэгсүрэн, Г.Нямжанцан, Д.Даваасүрэн, Б.Мягмарцэрэн нарын тоглосон 16 бэсрэг болон айзам уртын дууг дуу, дүрстэй оруулсан нь урьд хэвлэгдсэн гарын авлагуудаас илүү баялаг болсон.

Гарын авлагыг Лимбэний сургагч багш болон өвлөн суралцагч, холбогдох Их дээд





сургууль, Ерөнхий боловсролын сургуулиудад сургалтанд ашиглуулахаар хүргүүлсэн.

-----х-----

**“МОНГОЛ АРДЫН УРТЫН ДУУ ТОГЛОХ УЛАМЖЛАЛТ АРГА ЛИМБЭНИЙ  
БҮТҮҮ АМЬСГААГ ХОЙЧ ҮЕД ӨВЛҮҮЛЭН УЛАМЖЛУУЛАХ,  
ТОГТВОРЖУУЛАХ НЬ” ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ШАВЬ СУРГАЛТ  
ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН ТАЙЛАН**

2019 оны 11 дүгээр сарын 13

Улаанбаатар хот

“Монгол ардын уртын дуу тоглох уламжлалт арга лимбэний бүтүү амьсгааг хойч үед өвлүүлэн уламжлуулах, тогтворжуулах нь” төслийн хүрээнд лимбэний битүү амьсгаа өвийг өвлүүлэн уламжлуулах шавь сургалтыг аймаг, нийслэлийн хэмжээнд 2019 оны 6 дугаар сараас 2019 оны 10 дугаар сарын хооронд зохион байгуулсан.

Төвийн, Баруун, Говийн гэсэн 3 бүсээс 11 Лимбэч, өвлөн уламжлагч сургагч багш нарыг дараах шалгууруудыг баримтлан сонгон тогтоож гэрээг байгуулсан. Үүнд:

1. Лимбэ хөгжмийг өндөр түвшинд өвлөн эзэмшсэн байдал
2. Лимбэний битүү амьсгааг эзэмшсэн
3. Сургалт явуулах чадвар, өөрийн арга барилтай
4. Тухайн орон нутаг, Лимбэч авъяастнууддаа хүлээн зөвшөөрөгдсөн

Сонгогдсон сургагч багш нар /3 бүсийн хэмжээнд/.

№	Овог нэр	Бүсчлэл	Харъяалал
1	Өлзий овогтой Батжаргал	Говийн бүс	Өмнөговь аймаг /Өвлөн уламжлагч, Лимбэч/
2	Буяндэлгэр овогтой Отгондүү		Дорноговь аймаг /Саран хөхөө театрын хөгжмийн багш, Лимбэч/
3	Чүлтэмсүрэн овогтой Даваажав	Төвийн бүс	Монголын хүүхдийн ордон /Хөгжмийн багш/
4	Мишигдорж овогтой Цэнгэлсайхан		Монголын Лимбэчдийн холбоо /Өвлөн уламжлагч, Лимбэч/
5	Нямсүрэн овогтой Баярцэнгэл		Өвөрхангай аймаг /Өвлөн уламжлагч, Лимбэч/
6	Янжмаа овогтой Болд		Сэлэнгэ аймаг /Өвлөн уламжлагч, Лимбэч/
7	Бямбадорж овогтой Цогтмагнай		Монголын Лимбэчдийн холбоо /Өвлөн уламжлагч, Лимбэч/

8	Баяраа овогтой Мягмарцэрэн		Монгол Улсын Консерваторын багш, Лимбэч
9	Чойжинжав овогтой Ваша	Баруун бүс	Ховд аймаг /Өвлөн уламжлагч, Лимбэч/
10	Ласар овогтой Жамбалдорж		Говь-Алтай аймаг /Алтай чуулгын хөгжмийн багш, Лимбэч/
11	Ростов овогтой Эрдэнэлхагва		Завхан аймаг /Хөгжим бүжгийн коллежийн багш/

Сургагч багшаар сонгогдсон багш нарт сургалт явуулах үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор өвлөн суралцагч тус бүрт 1 лимбэ, нэг багш 4 хүн сургахаар тооцож нийт 40 сургалтын лимбийг 11 багшид хүлээлгэн өгсөн.

Шавь сургалт зохион байгуулж дуусах эцсийн хугацааг 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөр тогтоож тухайн жилийн тайланг тус хугацаанаас өмнө хүлээн авахаар гэрээнд тусган тайлан, сургалтын үйл ажиллагаа, гэрээний биелэлтийг харгалзан гэрээг сунгах, цуцлах, үйл ажиллагааг сайжруулах талаар зөвлөмж өгч ажиллахаар төлөвлөсөн.



Гүйцэтгэгч нь хүндэтгэн үзэх шалтгааны улмаас шавь сургалтыг гэрээгээр тохиролцсон хугацаанд хэсэгчлэн болон бүхэлд нь хийх боломжгүй бол гэрээг цуцлаж өөр сургагч багштай гэрээ байгуулан ажилах тухай заалтыг оруулсан ба одоогийн байдлаар сургалт хэвийн явагдаж байгаа тухай мэдээллийг ирүүлээд байна.

2019 оны 9 дүгээр сарын 16-ны өдөр гэрээ байгуулан шавь сургалт явуулах багшийн нэг өдрийн ажлын хөлсийг 62.785 төгрөгөөр тооцож нийт 879.000, өдрийн хоолыг нэг өдрийн 7.900 төгрөгөөр тооцож нийт 110.600 нийт төлбөр 989.600 (есөн зуун наян есөн мянга зургаан зуун) төгрөгийн 60 хувь болох 593.760 /таван зуун ерэн гурван мянга долоон зуун жаран/ төгрөгийг сургагч багш нарт олгосон. Үлдэгдэл 40 хувь болох 395.840 /гурван зуун ерэн таван мянга найман зуун дөчин/ төгрөгийг сургалт явуулж дууссаны дараа буюу тайланг хүлээн авч дүгнэсний дараа олгоно.

Мөн сургагч багш нь 4 өвлөн суралцагчид лимбэ хөгжим тоглох уламжлалт арга битүү амьсгааг заах бөгөөд өвлөн суралцагч нарын томилолтын зардлыг нэг өдрийн 16.000 (арван зургаан мянга) төгрөгөөр тооцож нийт 14 хоног, 4 өвлөн суралцагчын 896.000 (найман зуун ерэн зургаан мянга) төгрөгийг сургагч багшаар дамжуулан олгоод байна. Өвлөн суралцагч нарын томилолтын зардлыг олгохдоо мөнгө



олгосон тухай акт үйлдэж гарын үсгээр  
201

баталгаажуулан иргэний үнэмлэх, насанд хүрээгүй тохиолдолд төрсний гэрчилгээг хавсарган шавь сургалт зохион байгуулж дуусах эцсийн хугацаанаас өмнө Захиалагч талд ирүүлнэ гэж гэрээнд тусгасан болно.

Мөн доорх хавсралтанд зааснаар шавь сургалтыг явуулах сургалтын хөтөлбөрийг “Монголын лимбэчдийн холбоо” ТББ, сургагч багш, Лимбэч өвлөн уламжлагчидтай зөвшилцөн боловсруулж гэрээнд хавсралтаар оруулсан.

Хавсралт №1

Сургалтын хөтөлбөр

д/д	Агуулга	Суралцагч	Хугацаа
1	Монгол лимбэний үүсэл гарвал, Лимбэний бүтэц зүйн талаар, уруулын тавил, гарын барил	Нийт 4 өвлөн суралцагчийг хамруулна	IX/20-24
2	Гам үлээх, амьсгаа хувиарлах дасгал ажил		IX/25-26
3	Нот, өнгө, давтлага		IX/27-29
4	Дадал олгох давтлага хичээл		X/01-02
5	Богино хэмжээний дуу, аяз тоглох, давтлага		X/03-05

Албан бус сургалтыг эхлүүлсэнтэй холбогдуулан сургалтад зориулсан зөвлөмж боловсруулж хүргүүлэв:

Албан бус сургалтыг зохион байгуулахад гол анхаарах зүйл бол тухайн өвд суралцагчдаас авьяас билигээс гадна уйгаагүй хөдөлмөр, тэвчээр, цаг хугацааг шаарддаг. Иймд гол нь суралцагчийн хичээл зүтгэл, итгэл үнэмшил нэн чухал. Мөн лимбэчдийн битүү амьсгааны өвийг өвлөн уламжлуулах албан болон албан бус сургалтад дараах зүйлүүдийг анхаарч байх нь туршлагаас харагдаж байдаг. Үүнд:

1. Тухайн өвд суралцахаар сонгогдсон суралцагчийн өвд шимтэн суралцах хүсэл эрмэлзэл. Тухайн өвөөр бахархах, өвийг хойч үедээ уламжлуулах хариуцлага өөрт оногдсон гэсэн хандлага, сэтгэлгээтэй байх. (Суралцагчдын тухайд хэн нэгэн ойр дотны хүний өвийг уламжилж авахаар эрмэлзэж байгаа бол давуу тал)
2. Сургалт явагдах орчин байх (Мэдээж танхимийн гэхээсээ илүү ахуй орчинд байх нь энэ өвийг суралцахад давуу байдаг. Бидний бүсчилсэн хэлбэрээр явуулж байгаа албан бус сургалтын хэлбэр бүгд танхимийн сургалтын хэлбэрээр явагдаж байна)
3. Сайн багш байх. (Туршлагатай өвлөн уламжлагч, сайн заах арга зүйтэй багш)
4. Маш ойлгомжтой гарын авлага, үзүүлэн таниулах материал (DVD цахим хичээл, дүрс бичлэг, зураг г.м) хөгжмийн зэмсэг, эх хэрэглэгдэхүүний хүрэлцээ хангамж.
5. Багшийг болон өв уламжлагчдад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, шагнаж урамжуулах байдлыг идэвхитэй байлгах
6. Богино хугацааны тодорхой системтэй үр дүнг тооцох аргачлалыг хэрэглэх гэсэн нэлээдгүй ач холбогдолтой зүйлүүдийг анхаарах нь үр дүнтэй сургалтын хэлбэр болно хэмээн үзэж байна.

-----X-----

## ЛИМБЭНИЙ ШАВЬ СУРГАЛТЫН ТАНХИМ БАЙГУУЛЖ, ТОХИЖУУЛСАН ТУХАЙ

Шавь сургалтын дэмжих зорилгоор Өмнөговь аймаг, Ховд аймаг, Завхан, Соёл урлагийн их сургууль, Монгол Улсын Консерватори гэсэн нийт 5 газар сургалтын танхим байгуулж хэрэгцээ шаардлагатай тоног төхөөрөмж, эд зүйлийг хүлээлгэн өгсөн.

СУИС-ийн лимбэний танхимийг жишиг танхим болгон тохижуулах үйл ажиллагааг



2020 оны 01 дүгээр сарын 14-ны өдөр Соёл урлагийн их сургуулийн I байрны 325 тоот хөгжмийн танхимын нээлтийн үйл ажиллагааг хийсэн.

Үйл ажиллагаанд ЮНЕСКО-гийн Соёлын асуудал хариуцсан мэргэжилтэн Ч.Цэцэгбаатар, СӨҮТ-ийн БМСанч Ж.Насанжаргал, Дэлхийн өв хариуцсан мэргэжилтэн Ц.Цолмон СУИС-ийн Хөгжмийн урлагийн сургуулийн сургалтын албаны дарга Хоролсүрэн, Үндэсний урлагийн тэнхимийн эрхлэгч С.Уранбилэг, урлаг судлаач, доктор Ж.Чулуунцэцэг, үндэсний хөгжмийн багш С.Энх-Амгалан, З.Бум-Эрдэнэ нар болон лимбэний оюутан залуус оролцов. Танхим тохижуулахад шаардлагатай тоног төхөөрөмжийг албан ёсоор СУИС-ийн Эрдэм шинжилгээ, Инновацийн газрын дарга, Монголын лимбэчдийн холбооны тэргүүн Ц.Цэвэгсүрэнд СӨҮТ-ийн мэргэжилтэн Ж.Насанжаргал хүлээлгэн өгч баримтжуулав. Мөн тус сургуулийн оюутан Т.Санжаасүрэн Монгол ардын уртын дуу “Цомбон туурайтай хүрэн”-г битүү амьсгаагаар лимбэдэж сонирхуулав.

Уг танхимд сургалтыг лимбэч, багш Ц. Цэвэгсүрэн, СУИС-ийн лимбэний багш М.Цэнгэлсайхан нар зохион байгуулж явуулхаар тохиролцов.

### Жишиг танхимын загвараар тооцов.

№	Нэр	Тоо, ширхэг	хариуцах	Зураг
1	ЮНЕСКО-д бүртгэгдсэн батламжын хуулбар, /хэмжээ, өргөн 42см, өндөр 30см/ жаазтай.	1	Соёлын өвийн үндэсний төв	
2	Сургалтанд зориулсан гэрэл зураг /хэмжээ 60 х 40/ жаазтай.	6	Соёлын өвийн үндэсний төв	

3	Бичгийн ширээ, сандал /багшийн/	1 ком	Соёлын өвийн үндэсний төв	
4	Сандал /сурагчийн/	4	Соёлын өвийн үндэсний төв	
5	Нотны тавиур	5	Соёлын өвийн үндэсний төв	
6	Дуу чимээ тусгаарлагч хавтан /тухайн танхимын хэмжээнээс хамаарна/	М <sup>2</sup> /дунджаар 40м <sup>2</sup> /	Тухайн аймгийн ЗДТГ	
7	Зөөврийн компьютер /Intel® Core™, 1.6, 4GB, DVD-Writer, 15.6"  Full HD (1920 x 1080), wireless LAN, 2 x Speaker, HDMI Output/	1	Соёлын өвийн үндэсний төв	
8	Поректор	1	Соёлын өвийн үндэсний төв	

9	Поректорын дэлгэц	1	Соёлын өвийн үндэсний төв	
10	Хивс эсвэл дроз /тухайн танхимын хэмжээнээс хамаарна/	M <sup>2</sup>	Тухайн аймгийн ЗДТГ	
<b>Нийт дүн</b>				

-----X-----

### ЛИМБЭ УРЛАЛЫГ ДЭМЖИХ, СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН ТАЙЛАН

Лимбэ урлалыг дэмжих, сургалт зохион байгуулах ажлыг 2019 оны 5 дугаар сарын 20-ны өдрөөс 14 хоногийн хугацаатай зохион байгуулав. Сургалтыг Монгол Улсын Консерваторийн Лимбэний багш Нямжанцан, “Монгол Лимбэчдийн холбоо”-ны тэргүүн, СУИС-ын лимбэний багш Ц.Цэвэгсүрэн нар удирдан явуулсан.



Сургалтанд Өмнөговь, Ховд, Улаанбаатар хотын нийт 6 лимбэч, урлаач нар хамрагдаж лимбэ урлах арга зүй, технологи, үйл явц, лимбэний хөг, хөгөлгөө, дадал олгох зэрэг онол, практик хосолсон байдлаар сургалтыг хийсэн.

Сургалтын үр дүнд сургагч багшаар сонгогдсон багш нарт сургалт явуулах үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор өвлөн суралцагч тус бүрт 1 лимбэ, нэг багш 4 хүн сургахаар тооцож нийт 40 сургалтын лимбийг 10 багшид хүлээлгэн өгч цаашид бие даан өөрийн орон нутагт лимбэ урлах, сургалт явуулах мэдлэг чадварыг эзэмшсэн байна.

## Сургалтын хөтөлбөр

д/д	Агуулга	Хугацаа
1	Монгол лимбэний үүсэл гарвал зүйн талаар	V/20, 21
2	Лимбэний бүтэц	V/22,23
3	Лимбэ урлах арга зүй	V/24,27
4	Лимбэ урлах технологи, үйл явц	V/28,29
5	Урлалд суралцах, дадал олгох хичээл	V/30,31
6	Хөгөлгөөний онцлог	VI/03, 04
7	Лимбэний хөг, хөгөлгөө	VI/05, 06



-----X-----

### ЛИМБЭНИЙ БИТҮҮ АМЬСГААНЫ УЛАМЖЛАЛ, СУРГАЛТЫГ ХАРУУЛСАН БАРИМТАТ КИНО БҮТЭЭХ, ОЛОН НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛЭЭР СУРТАЛЧИЛСАН ТУХАЙ

ЮНЕСКО, Соёлын өвийн үндэсний төв, “Монголын Лимбэчдийн Холбоо” ТББ хамтран хэрэгжүүлж буй “Монгол ардын уртын дуу тоглох уламжлалт арга лимбэний битүү амьсгааг хойч үед өвлүүлэн уламжлуулах, тогтворжуулах нь” төслийн хүрээнд лимбэний битүү амьсгааны уламжлал, сургалтыг харуулсан баримтат кино бүтээх, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах үйл ажиллагааг тусгасан.

Энэ ажлын хүрээнд 2019 оны 7 дугаар сарын 3-ны өдөр №01 тоот гэрээг “Соён Гэгээрүүлэгч” телевизтэй байгуулан “Нүүдэлчдийн лимбэдэх соёлын өвийн гайхамшиг” сэдэвт 27 минутын нэвтрүүлгийг тус телевизээр бүтээлгэх нэвтрүүлгийг улс орон даяар 2019 оны 09 дүгээр сараас 12 дугаар сарын хооронд нийт 10 удаагийн давтамжтайгаар олон нийтэд цацав.



Нэвтрүүлэгт Соёл урлагийн их сургуулийн багш, “Монгол Лимбэчдийн холбоо”-ны тэргүүн Ц.Цэвэгсүрэн Лимбэ хөгжмийн үүсэл хөгжил, түүхэн тойм, Уламжлалт битүү амьсгааны онцлог, төслийн хүрээнд хийгдсэн суурь судалгааны талаар, Соёлын өвийн үндэсний төвийн Соёлын өвийн бүртгэл, судалгааны газрын бүртгэл, мэдээллийн санч Ж.Насанжаргал “Монгол ардын уртын дуу тоглох уламжлалт арга лимбэний битүү амьсгааг хойч үед өвлүүлэн уламжлуулах, тогтворжуулах нь” төслийн ерөнхий танилцуулга, I үе шатны үйл ажиллагааны хэрэгжилт, цаашид хийгдэх үйл ажиллагааны төлөвлөлтийн талаар, The “НУ” хамтлагийн гишүүн, Лимбэний өвлөн уламжлагч Г.Нямжанцан Лимбэ урлалыг дэмжих, сургалт зохион байгуулсан талаар мэдээллийг өгч оролцов.

#### Лимбэний битүү амьсгааны уламжлал, сургалтыг харуулсан баримтат киноны тухай

“Монгол ардын уртын дуу тоглох уламжлалт арга лимбэний бүтүү амьсгааг хойч үед өвлүүлэн уламжлуулах, тогтворжуулах нь” төслийн хүрээнд хийгдэх Баримтат киноны дүрс цуглуулах ажлыг 2019 оны 05-р сарын 27-ний өдөр Соёлын өвийн үндэсний төв, Торомгор Пикчерс ХХК-ны хооронд байгуулсан №02/07 гэрээний дагуу төслийн үйл ажиллагаатай холбоотой үйл ажиллагааг баримтжуулж нийт **553.56** gb хэмжээтэй гэрэл зураг, дүрс бичлэгийг хийгээд байна. Тус баримтат кино нь төслийн үйл ажиллагаа дууссаны дараа буюу 2021 оны 11 сард хийж дуусгахаар төлөвлөн ажиллаж байна.



Баримтат киноны зохиолыг “Монголын лимбэчдийн холбоо”-ны тэргүүн Ц.Цэвэгсүрэн, Соёлын өвийн үндэсний төвийн захирал Г.Энхбат нар бичиж, найруулагчаар “Торгомор пикчерс” ХХК-ны найруулагч М.Цэдэнсодном ажиллаж эхний шатны үйл ажиллагааны дүрс бичлэгүүдийг цуглуудаад байна.

“Монгол уртын дуу лимбэдэх уламжлалт арга битүү амьсгааг өвлүүлэн уламжлуулах, тогтворжуулах нь” төслийн баримтат кино нь:

- Лимбэний үүсэл гарвал зүйтэй холбоотой баримт мэдээ



- Уртын дуу лимбэдэх арга ухаан, онцлог
- Лимбэний битүү амьсгаа, төмрийн дархчуудын нарийн ур хийцтэй зүйлээ урлаж байсан тухай баримт
- ЮНЕСКО-д бүртгүүлсэн тухай
- Монгол лимбэний онцлог, лимбэ урлах үйл ажиллагаа
- Өвийг уламжлуулах, тогтворжуулах сургалт
- Лимбэний тархалт харуулсан график, зураг зэрэг өргөн агуулгаар хийгдэхээр баримтат киноны зохиолд тусгагдсан.



Баримтат киноны зохиолыг хавсаргав.

ТАЙЛАН БИЧСЭН:  
Ж.НАСАНЖАРГАЛ. СОЁЛЫН ӨВИЙН БҮРТГЭЛ,  
СУДАЛГААНЫ ГАЗРЫН БҮРТГЭЛ  
МЭДЭЭЛЛИЙН САНЧ

Хавсралт

“МОНГОЛ УРТЫН ДУУ ЛИМБЭДЭХ УЛАМЖЛАЛТ АРГА БИТҮҮ  
АМЬСГААГ ӨВЛҮҮЛЭН УЛАМЖЛУУЛАХ, ТОГТВОРЖУУЛАХ НЬ”  
төслийн дүрст тайлан-баримтат киноны агуулга, зохиол

2019 оны 5 дугаар сарын 25-ны өдөр

АГУУЛГА

№	Агуулга	Хийх дүрс, зураглал	Түшиглэх баримтууд	Хугацаа МИН
1	Лимбэний үүсэл гарвал зүйтэй холбоотой баримт мэдээ	Лимбэчин Борхүү домогт сэдэвлэн зураглал хийх  Эртний лимбэнүүдийн зураг авах  Г.Гонгоржав,	Монгол лимбэний үүсэл гаралтай холбоотой 5 домог байгаа; Эртний ясан лимбэний олдворын баримтууд; Түүхэн эх сурвалжид тэмдэглэгдсэн лимбэний тухай баримтууд;  Г.Гонгоржавт хадгалагдаж байгаа лимбэчний баримал;	5-7 мин

			<p>Өмнөговь аймгийн музейд хадгалагдаж буй Данзанравжаагийн хэрэглэж байсан хаш лимбэ;</p> <p>Японы Хамамацу хөгжмийн музейд хадгалагдаж буй мөнгөөр тоноглогдсон суман модон лимбэ; Богд хааны өмсөж байсан хүрмэн дээр урлагдсан лимбэний дүрс;</p> <p>Баянгол дүүргийн иргэн Г.Нацагт хадгалагдаж буй эртний ясан лимбэ;</p> <p>Театрын музейд хадгалагдаж буй алдарт лимбэч Л.Цэрэндорж, М.Дорж нарын лимбэ;</p>	
2	Уртын дуу лимбэдэх ухаан, онцлог арга	Ахмад лимбэчдийн тухай яриа; Найр, наадам, төрийн хүндэтгэлийн үйл ажиллагаанд тоглож буй уртын дууч, морин хуурч, лимбэчний бичлэг; Битүү амьсгаагаар уртын дуу лимбэдэх онцлог, лимбэний олдворын талаарх яриа Ж.Энэбиш, Д.Галсантогтох, Ө.Батжаргал гэх мэт Зарим судлаачдын судалгааны үр дүн	<p>Манай аялгуу баримтат кинонд Л.Цэрэндоржийн лимбэ үлээж буй дүр; Сарлаг баримтат кинонд тоглосон МУГЖ, лимбэч М.Доржийн бичлэг; Ахмад лимбэчдийн зураг; Аялгуун солонго ном;</p> <p>Л.Цэрэндорж, М.Дорж, М.Бадам, Д.Энхтайван нарын лимбэдсэн уртын дууны бичлэгүүд;</p> <p>Анагаахын судлаач Ц. Доржсүрэнгийн судалгаа: Анагаахын дүрс оношилгоогоор хийгдсэн зураг, дүрс, хариу дүгнэлтийн талаар;</p>	5-7 мин
3	Лимбэний битүү амьсгаа, төмрийн дархчуудын нарийн ур хийцтэй зүйлээ урлаж байсан тухай баримт	Битүү амьсгаагаар урласан зарим дарханы бүтээлүүдийн дүрс авах	Ш.Дондов дарханы бичлэг; Монгол дархан баримтат кино;	2 мин
4	Нийгэм, өрнийн соёлын нөлөө		ХХ зууны эхэн үеийн түүхэн бичлэг, баримт;	1-2 мин
5	Түүх, соёлоо сэргээх хандлага	Яагаад устах болсон, яаж сэргээх талаарх яриа	Монгол улсаас өв соёлоо хамгаалах талаар хийгдсэн ажлуудын талаар;	2-3 мин

			Л.Цэрэндоржийн 100, 110 жилийг тэмдэглэн өнгөрүүлсэн бичлэг, зураг, уралдаан тэмцээн зохион байгуулж байсан тухай;	
6	ЮНЕСКО-д бүртгүүлсэн тухай  Хүлээх үүрэг хариуцлагын тухай	Яриа ЮНЕСКО-ийн нарийн бичгийн дарга Уянга, Лимбэч Цэвэгсүрэн нарын яриа	Судалгааны баримт, Битүү амьсгааны ЮНЕСКО-д илгээсэн конионы хэсэг ; Сертификат хүлээж авах ёслолын бичлэг, гэрэл зураг;	2-3 мин
7	Монгол лимбэний онцлог, лимбэ урлах үйл ажиллагаа	Сургалт, урлаж байгаа зураг дүрс бичлэг	Нямжанцангийн сургалт хийж буй бичлэг; Байгалжав гм-ийн лимбэ урлаж буй хүмүүсийн бичлэг; Суралцагчид орон нутагтаа ажиллаж буй бичлэг;	2-3 мин
8	Өвийг уламжлуулах, тогтворжуулах сургалт	Өв тээгчдийг илрүүлэх, залуу хойч үед уламжлуулж буй дүрс Бүсчилсэн сургалтуудын бичлэг	Ардын урлагийн наадмуудын бичлэг, архив;	3-5 мин
9	Лимбэний тархалт харуулсан график, зураг	Судалгаа хийж буй бичлэгүүд Хуралдааны бичлэг, ярилцлага Эрдэм шинжилгээний хурал	График зураг хийх; Цаг үеийн зургууд авах;	3 мин
10	Төслийн үр дүн	Уралдааны бичлэг, ярилцлага Битүү амьсгааны төсөлд хамрагдаж суралцсан суралцагчдын дунд явагдах уралдаан шалгаруулалт	Цаг үеийн зургууд авах;	3 мин
	Нийт			30-36 мин

## ЗОХИОЛ

Нэгдүгээр хэсэг буюу Лимбэний үүсэл гарвалтай холбоотой баримт мэдээ

*Эхлэл дүрс бичлэг:* Зуны сайхан байгаль, хурга хариулж байгаа хүүгийн дүрс гарна. Уртын дуу лимбэдэж буй аялгуу эгшиглэнэ.

*Дектор ярих:* Эрт цагт нэгэн хургачан хүү хургаан хариулж явахдаа байгалийн сайханд нэгэн исгэрэх дуу чимээг сонсож, хаанаас энэхүү дуу чимээ гарч буйг гайхан сонирхон орчныг ажиглан харжээ. Сайтар харвал салхины аясаар цооргоно өвснөөс аялгуу сайхан дуу гарч байгааг мэдэн, тэрээр цооргоныг авч, нүхлэн үлээж, уянгалаг сайхан “лимбэ” хэмээх нэгэн хөгжмийн зэмсэг үүссэн домогтой.

*ДЕКТОРЫН ЯРИАН ДУНД ДҮРСЭЭР ҮЗҮҮЛЭХ* /Хургаа хариулж яваа хүү, зэгс цооргоно ажиг, огтлон авч нүхлэн үлээх гэж оролдож байгаа бичлэг гарна./

Монгол ардын үлгэр домог, дуу, туульс лимбэний тухай өгүүлсэн зүйл олон байдаг ба лимбэний эгшгээр хүний дотоод сэтгэхүйн баяр баясгалан, уйтгар гуниг, бодол дурсамж зэргийг илэрхийлж болохоос гадна байгалийн зарим дуу авиаг ч дүрсэлж болно.

Монгол газар нутагт амьдарч байсан Хүннү, Сяньби, Түрэг Уйгар зэрэг монголчуудын өвөг дээдэс олон төрлийн хөгжмийн зэмсгийг үүдэн бүтээсэн талаар түүхийн судар бичигт тэмдэглэн үлдээжээ. Тухайлбал, үлээврээс цуур, *лимбэ* Хүннү нарт лавтай байсан, Ху нар хувцас, гэр, исэр, суудал, хоол, кунхоу, *лимбэ*, бүжигт дуртай байсан талаар эрдэмтэн судлаач Г.Сүхбаатар; “Сүй улсын хөгжмийн бичиг”-т “...маш эрт Баруун хан улсын үед баруун хойт дахь харь үндэстнүүдийн дунд уламжлагдан ирсэн... их бага хөндлөн бишгүүрийг цөм хулсаар үйлджээ. Хөндлөн бишгүүр болбоос Ху улсын үндэсний хөгжим болой хэмээснийг эрдэмтэн судлаач У.Хөгжилт; Оросын академич Б.Л.Рифтин “хэнчуй” хэмээх нэрлэгдэх лимбэ нь хүннүгээс хятадад орсон, мөн судлаач Р.Л. Садоков; “...Төв Азийн хөгжмийн зэмсэг Хятад руу нэвтэрч, түүний дотор хөндлөн лимбэ байв” хэмээн бүтээл судалгаандаа тус тус дурдсан байна.

Эрдэмтдийн судалгаанд “МЭӨ 121 оны үес Хүннү нар оройдоо дуу дуулан наргихдаа цуур, лимбэ, хуур зэргээр хөгжимддөг”, “МЭ-ний 285 оны үед адуу ноцолдсоны улмаас муудалцан ах Тугухунэ хөөн явуулчхаад гашуудан “Ахын дуу” гэдгийг зохион, бөмбөр, лимбээр хамсран хөгжимдөн дуулдаг”, Сяньби нар “Чилэгийн дуу” гэгчийг бийваагаар дагалдан лимбэддэг байсан”, XII-XIII зууны үест ордны төрийн ёслолын хуримлах хөгжмийн сав хэмээх найрал хөгжмийн бүрэлдэхүүнд хөндлөн бишгүүр буюу лимбэний төрлийн зэмсэг байсан талаар дурдсан нь цөөнгүй.

18-19 дүгээр зуунд монгол орны зүүн хязгаарт То вангийн үед уламжлан тоглогдож байсан “Ногоон морины дэг” хэмээх дуутай бүжиглэлийн наадам тоглолтод бийваа, морин хуур, лимбэ, хуучир, шанз, янчир, зэн, ёочин зэрэг үндсэн 8 хөгжим, ноён хутагт Данзанравжаагийн “Саран хөхөөний намтар” жүжгийн уриа дохионд лимбэ байсан талаар Сүхбаатар, Хүрэлбаатар, Цэрэндорж, Оюунчимэг, Соронзонболд нарын судлаачид тус тус тэмдэглэжээ.

**ДЕКТОРЫН ЯРИАН ДУНД ДҮРСЭЭР ҮЗҮҮЛЭХ** (зургийг Цэвэгсүрэнгийн судалгаанаас авах- Одоогийн байдлаар дээрх бичгийн сурвалжуудын мэдээ, тухайн цаг үед холбогдох Хүннүгийн үеийн гэх лимбэ үлээж буй хүний дүрс бүхий хүрэл олдвор судлаач Г.Гонгоржавт, Түрэг уйгар үеийн <sup>2</sup> (Хавсралт 2, Зураг.1.8); МЭӨ 206-МЭ 9-р зууны үеийн зүүн Хан улсын булшнаас нэгэн илүү нүх /сурдины хальс наах нүх байж магадгүй гэж үздэг. Ц.Ц/-тэй лимбэ<sup>3</sup>; МЭӨ 168 онд хамаарах булшнаас олдсон урт, богино 2 хулсан лимбэ<sup>4</sup>; Түрэгийн /МЭ 555-745/ үеийн хөгжимчид<sup>5</sup>-ийн зураг (Хавсралт 2, Зураг.1.12); МЭ 599-769 оны хүрээнд хамрагдах АНУ-ын Аризона муж дахь нэгэн агуйгаас олдсон олон тооны модон лимбэ<sup>6</sup> (Эдгээр лимбийг 1931 онд Эрл Х Моррис удирдсан археологийн экспедицээр 15 агуйг ухаж

<sup>2</sup> СГЗ, чулуу цуглуулагч Г.Гонгожавын хувийн цуглуулгад хадгалагдаж байна

<sup>3</sup> [http://music.chinesecio.com/en/article/2010-03/17/content\\_117831.htm](http://music.chinesecio.com/en/article/2010-03/17/content_117831.htm)

<sup>4</sup> Мөн тэнд

<sup>5</sup> Занабазарын нэрэмжит дүрслэх урлагийн музейд хадгалагдаж буй Б.Гомбосүрэнгийн хуулбарласан үзмэр

<sup>6</sup> Clint Goss. "[Anasazi Flutes from the Broken Flute Cave](#)". Flutopedia. Retrieved 2011-03-27.

олсон байна.<sup>7</sup> Лимбэнүүд нь 6 цоолбортой, эхлэл төгсгөл нь үл мэдэгдэх ба 5 цоолбортой Хопи /Hopi/ лимбэтэй олон талаараа төстэй байна)<sup>8</sup>; Өвөр монголын Зуу-Уд аймгийн нутгаас олдсон, царил барьсан болон лимбэдэж буй хүний дүрс бүхий Кидан улсын үеийн хөгжимчдийн зураг<sup>9</sup> (Хавсралт 2, Зураг.1. 16); Киданы үеийн ханын зураг дахь хөгжимчид<sup>10</sup>; Лимбэ үлээж буй хүний дүр<sup>11</sup>; 1982 онд ӨМӨЗО-ны Улаан хад хотын нэгэн дүүрэгт хийсэн археологийн малтлагаас Юань улсын үеийн хөгжмийн ангийн ханын зурагт монгол хүний лимбэ үлээж буй дүрс (Хавсралт 2, Зураг.1.21)

*Судлаач Г.Гонгоржав:* Өөрийн хувийн цуглуулганы лимбэний баримлын талаар маш товч ярина.

*ГОНГОРЖАВЫН ЯРИАН ДУНД ДҮРСЭЭР ҮЗҮҮЛЭХ* (дүрсээр хүрэл баримал литбийг үзүүлэх-Хүннүгийн үеийн гэх лимбэ үлээж буй хүний дүрс бүхий хүрэл олдвор судлаач Г.Гонгоржав)

*Судлаач Доктор Цэвэгсүрэн ярих:* Монголд лимбийг яс, суман мод, хаш чулуугаар урласан тохиолдол байгаа бөгөөд өнөөг хүртэл хадгалагдаж байна. Иргэн Н.Лувсангаар дамжин, 1975 оноос Өмнөговь аймгийн түүхийн музейд хадгалагдаж буй одоогийн Өмнөговь аймгийн Ханбогд сумын “Цагаан толгой”, “Дэмчиг”, “Эрээт”-ийн хийдэд 1911 онд Говийн ноён хутагт Данзанравжаагийн хаш чулуун лимбэ, БГД-ийн иргэн Гончигийн Нацагт 1970-аад оны эхээр жүжигчин Б.Дамчаагийн аав Банзар хэмээх хүний малын чөмгөний ясыг зүүж наан урласан ясан лимбэ, мөн Япон улсын Хамамацу хотын хөгжмийн музейд бас нэгэн чамин хийцтэй суман модон монгол лимбэ тус тус хадгалагдаж байна.

*ЦЭВЭГСҮРЭНГИЙН ЯРИАН ДУНД ДҮРСЭЭР ҮЗҮҮЛЭХ* (Дүрсээр үзүүлэх иргэн Н.Лувсангаар дамжин, 1975 оноос Өмнөговь аймгийн түүхийн музейд хадгалагдаж буй хаш лимбээр одоогийн Өмнөговь аймгийн Ханбогд сумын “Цагаан толгой”, “Дэмчиг”, “Эрээт”-ийн хийдэд, 1911 онд Говийн ноён хутагт Данзанравжаагийн хаш чулуун лимбэ, БГД-ийн иргэн Гончигийн Нацагт 1970-аад оны эхээр жүжигчин Б.Дамчаагийн аав Банзар хэмээх хүний малын чөмгөний ясыг зүүж наан урласан ясан лимбэ, Япон улсын Хамамацу хотын хөгжмийн музейд бас нэгэн чамин хийцтэй суман модон монгол лимбэ).

*Дектор ярих:* Нүүдэлчин монголчууд лимбийг дан ганц тоглолт, найр наадмын хүрээнд хэрэглэж байсангүй, лимбэний уран сайхан эгшгээр үр төлөө голсон эх малыг уяруулан голсон төлийг нь авхуулж байсан нь монголчууд мал, байгальтай хөгжмийн хэлээр харилцах хэрэглэгдэхүүн болгож байсан талаар өвгөн лимбэч Цэрэндорж, эрдэмтэн судлаач Дулам нар тэмдэглэсэн нь бий .

Богд хааны ордон музейн сан хөмрөгт хадгалагдаж буй Богд хааны төрийн их ёслол хүндэтгэлийн хувцас болох хүрмийн зүүн энгэрт лимбэ хөгжмийн дүрсийг уран сайхан хатгаж оёсон урлал, алдарт зураач Марзан Шаравын “Монголын нэг

<sup>7</sup> Coltrain, Joan Brenner; Janetski, Joel C.; Carlyle, Shawn W. 2007. "The Stable- and Radio-Isotope Chemistry of Western Basketmaker Burials: Implications for Early Puebloan Diets and Origins". American Antiquity.

<sup>8</sup> Morris, Elizabeth Ann April 1959. "Basketmaker flutes from the Prayer Rock District, Arizona". American Antiquity.

<sup>9</sup> Соронзонболд С. Монгол хөгжим. - УБ., 2013. - Х.71

<sup>10</sup> Соронзонболд С. Монгол хөгжим. - УБ., 2013. - Х.133

<sup>11</sup> Соронзонболд С. Монгол хөгжим. - УБ., 2013. - Х.143

өдөр хэмээх” зурагт найрлаж буй ард олны дунд лимбэч, хуурч нар гоцлон хөгжимдөж буйг дүрсэлсэн нь Монгол нутагт энэ эртнээс өнөөг хүртэл лимбийг нийгмийн бүхий л давхаргын хүрээнд өргөн хэрэглэж байсныг гэрчилж байна.

**ДЕКТОРЫН ЯРИАН ДУНД ДҮРСЭЭР ҮЗҮҮЛЭХ** (хонь хурга, тэмээ ботгоны дэргэд лимбэдэж буй дүрс авах, Богд хааны ордон музейн сан хөмрөгт хадгалагдаж буй Богд хааны төрийн их ёслол хүндэтгэлийн хувцас болох хүрмийн зүүн энгэрт лимбэ хөгжмийн дүрсийг уран сайхан хатгаж оёсон урлал, алдарт зураач Марзан Шаравын “Монголын нэг өдөр хэмээх” зурагт найрлаж буй ард олны дунд лимбэч, хуурч нар гоцлон хөгжимдөж буйг харуулсан дүрс үзүүлэх)

Хоёрдугаар хэсэг буюу Уртын дуу лимбэдэх арга ухаан, онцлог

*Эрдэмтэн, судлаач Ж.Энэбиш ярих:* Монголын театрын музейд болсон Лимбэний төслийн нээлтийн үеэр алдарт лимбэч Л.Цэрэндорж болон лимбэний битүү амьсгааны тухай яриаг оруулах.

**ЭНЭБИШ БАГШИЙН ЯРИАН ДУНД ДҮРСЭЭР ҮЗҮҮЛЭХ:** (Л.Цэрэндоржийн 1960 онд “Амьдралын цуурай” кинонд морь унаж, хонь хариулан “Дөрвөн цаг” уртын дууг лимбэдсэн бичлэг

*Дектор ярих:* Монгол лимбэчдийн уртын дууг битүү амьсгаагаар лимбэдэх урлаг нь монголчуудын уламжлалт сэтгэлгээ, уужим тал нутагтай салшгүй холбоотой.

Уртын дуу лимбэдэхэд амьсгааны урт, тасралтгүй үргэлжлэх арга, ухаан, тогтолцоо зайлшгүй шаардлагатай болсон нь монголчуудын бүтээлч сэтгэлгээ, эрэл хайгуулын үр дүн, амьдралын шаардлагаас урган гарсан битүү амьсгааны урлагийг үүсэх, хөгжих үндсэн шалтгаан болсон байна.

Битүү амьсгаа гэдэг нь үнэндээ амьсгааны нууц эргэлт бөгөөд “... уртын дуугаа лимбэдэхдээ утга санаа, уламжлалт сэтгэлгээг илэрхийлэх онцлог, тоглолтын арга барил, ур чадвар болгон бүтээсэн амьсгааны цогц урлаг гэж үздэг.

**ДЕКТОРЫН ЯРИАН ДУНД ДҮРСЭЭР ҮЗҮҮЛЭХ:** (Сарлаг баримтат кинонд тоглосон МУГЖ, лимбэч М.Доржийн бичлэг)

*МУК-ийн лимбэний багш Б.Цогтмагнай ярих:* Монголын театрын музейд болсон Лимбэний төслийн нээлтийн үеэр дүрс бичлэг авагдсан. Лимбийг анх багшаасаа сурж байхдаа багш нь галстукны бүч үлээж, үлээсэн салхинд нь бүч нь дэрвэж унахгүй байдаг тухай товч яриаг оруулна.

**Б.ЦОГТМАГНАЙН ЯРИАН ДУНД ДҮРСЭЭР ҮЗҮҮЛЭХ:** (Галстук үлээж байгаа сурагчийн бичлэг гарна)

*Дектор ярих:* Битүү амьсгаа хэмээх нь тасралтгүй үргэлжлэх хийн урсгалын битүү хэлхээ үүсгэхийн тулд амьсгалын хэвийн горимыг зориуд өөрчлөн, амьсгаа авах, гаргахыг зэрэг үйлддэг үйлдэл юм.

**ДЕКТОРЫН ЯРИАН ДУНД ДҮРСЭЭР ҮЗҮҮЛЭХ:** (Анагаахын дүрс оношилгооны дүрс бичлэг, 3D загварчлалын зураг гарна)

*МХО-ны лимбэний багш Ч.Даваажав ярих:* Монголын театрын музейд болсон Лимбэний төслийн нээлтийн үеэр дүрс бичлэг авагдсан. Шилэн аяганд гуурсаар битүү амьсгааны дасгал хийдэг тухай болон Лимбэ сурах хүүхдийн бие эрхтний онцлогийн тухай яриаг оруулна.

**Ч.ДАВААЖАВЫН ЯРИАН ДУНД ДҮРСЭЭР ҮЗҮҮЛЭХ:** (Шилэн аяганд гуурсаар битүү амьсгааны дасгал хийж, суралцаж байгаа хүний бичлэг гарна)

*Дектор ярих:* Битүү амьсаагаар лимбэдэх аргад суралцахад, суралцагчаас онцгой авьяас, чадвар, мэдрэмж, уйгагүй хөдөлмөр, тэсвэр тэвчээр шаарддаг. Мэргэжлийн сургалтын орчинд лимбэнд суралцаж эхэлснээс даруй 2-3 жилийн дараанаас битүү амьсгааны аргыг зааж эхэлдэг. Үүнийг лимбэдэх арга ухааны анхан шатанд суралцаж, улмаар бие махбодыг уян хатан байдлаар зохицуулах, эгшиглээний чанарын үзүүлэлтийг хангахуйц ур чадвар, мэдлэгийг олж авсан, эсэхтэй холбон тайлбарлах нь зүйтэй юм. Мөн дээрх хугацаанд уртын дууны мөн чанар, утга агуулга, дуулах хэв шинжийг бүрэн илэрхийлэх, түүнд суралцах, эзэмших зэрэг нь дээрх хугацааг баримтлах шалтгаан болдог. Тухайлбал, айзам уртын дууны нэг түрлэг ойролцоогоор 4-5 минут үргэлжилдэг. Нэг уртын дуу 3-5, түүнээс ч олон түрлэгтэй байх бөгөөд энэ нь нэг удаа дор хаяж 12-25 минут тасралтгүй үргэлжлүүлэн лимбэднэ гэсэн үг юм. Лимбэчин битүү амьсгааг эгшигийг гуйвуулахгүйгээр цэвэрхэн авч сурах нь уртын дууг лимбэдэх уламжлалт арга барилд суралцах эхний шат болдог. Харин уртын дууны ая дан, нугалаа хугалаа, цохилго, чимэглэл зэрэг арга ухааныг эзэмшиж, уртын дууны дотоод мөн чанар, гүн ухааныг илэрхийлэн хөгжимдөж сурах нь уйгагүй хөдөлмөр, тэсвэр, тэвчээр, ур авьяас, торгон мэдрэмжийг шаарддаг дараагийн шат болдог юм.

**ДЕКТОРЫН ЯРИАН ДУНД ДҮРСЭЭР ҮЗҮҮЛЭХ:** (МУГЖ лимбэч Галсантогтохын ардын арга барилаар манертайгаар лимбэ тоглож буй дүрс үзүүлэх зэргээр уртын дуу дуулж, лимбэдэж, хуурдаж байгаа бичлэг, зураг гарна)

*МУГЖ лимбэч Галсантогтох ярих:* МУГЖ М.Доржийн тухай яриа өрнүүлнэ.

**ГАЛСАНТОГТОХЫН ЯРИАН ДУНД ДҮРСЭЭР ҮЗҮҮЛЭХ:** (М.Доржийн лимбэдсэн уртын дуу бичлэг явж байна. Зураг, дүрс оруулна)

*Анагаахын судлаач магистр, Ц. Доржсүрэн ярих:* Судалгааны ажил, үр дүнгийн тухай ярих

**ДОРЖСҮРЭНГИЙН ЯРИАН ДУНД ДҮРСЭЭР ҮЗҮҮЛЭХ** (Анагаахын дүрс оношилгоогоор хийгдсэн зураг, дүрс, хариу дүгнэлтийн талаар)

*Дектор ярих:* Монгол лимбэчдийн уртын дуу лимбэдэх битүү амьсгааны урлаг нь зөвхөн битүү амьсгаагаар лимбэдэхдээ бус тэрхүү уртын дууны хэв шинж, донж маяг, утга, агуулгыг урлах эрдэмтэй холбоотой. Өөрөөр хэлбэл уртын дууг битүү амьсгаагаар лимбэдэх нь лимбэчдийн хувьд хамгийн чухал нандин өв болох бөгөөд, уртын дууны уужим тэнүүн айзам, уран тансаг хээ угалзыг төгс илэрхийлэх, уртын дуучинд бат түшиг болж, дуучин амьсгаа авах үед дууны ая аялгууг чимэглэнгээр баяжуулан хөгжөөн холбож, битүү амьсгааны гайхамшгаар аялгууг тасалдуулалгүй лимбэдэх нь лимбэчдийн ур чадварыг тодорхойлох чухал үнэлэмж болдог байна.

**ДЕКТОРЫН ЯРИАН ДУНД ДҮРСЭЭР ҮЗҮҮЛЭХ:** (Уртын дуу дуулж, лимбэдэж, хуурдаж байгаа бичлэг, зураг гарна)

*Судлаач Ц.Цэвэгсүрэнгийн яриа:* "Уртын дууг битүү амьсгаагаар лимбэдэх урлаг нь монголчуудын сэтгэлгээний онцлогийг шингээсэн, түүнийг бүрэн илэрхийлж чадахуйц лимбэчний бие махбод, тэвчихүй, бодохуй, сэтгэхүй, бясалгахуй, урлахуй гэх шалтгаант дарааллын нэгдэл юм". Манай багш, нэрт лимбэч Д.Энхтайван "...Лимбэний битүү амьсгаа бол лимбэчдийн чамирхах, дэгжирхэх, ур чадвараа гайхуулах зүйл юм" гэж хэлсэн байдаг.

*Ц.ЦЭВЭГСҮРЭНГИЙН ЯРИАН ДУНД ДҮРСЭЭР ҮЗҮҮЛЭХ:* (Д.Энхтайвангийн лимбэдсэн уртын дууны бичлэг явна. Зураг, дүрс оруулах)

*Дектор ярих:* Судлаач Ж.Бадраа “уртын дууны шинж төрхийг лимбэ хөгжмийн уянгалаг сайхан дуурьсал, битүү хөг, битүү амьсгаа, хурууны уран чамин чимэглэл, цохилгоор илэрхийлдэг билээ. Уртын дууг тоглох явцад битүү амьсгааг маш цэвэрхэн, эгшгийг гуйвуулахгүйгээр авах ба дуучин дуулж, амьсгаа авч байх үед ч холбоос, чимэглэлийг дууны аялгууг алдагдуулахгүй баяжуулж хөгжимдсөнөөр лимбэчний ур чадварын түвшин илэрдэг билээ” хэмээн хэлсэн байдаг. Үнэхээр монгол уртын дууны утга, агуулга, шинж төрх, нам, мөн чанарыг илэрхийлэхэд монгол лимбэний дуурьслын онцлог, лимбэчдийн лимбэдэх ур ухаан, эрдэм чадал зайлшгүй чухал билээ.

*ДЕКТОРЫН ЯРИАН ДУНД ДҮРСЭЭР ҮЗҮҮЛЭХ:* (Уртын дууч, лимбэч, хуурчдын найр наадам, төрийн ёслол хүндэтгэл, монгол байгаль, гэр, дэлхийн тайзнаа дуулж хөгжимдсэн бичлэг оруулах)

Гуравдугаар хэсэг буюу төмрийн дархчуудын битүү амьсгаагаар нарийн үр хийцтэй зүйлээ үрлаж байсан тухай

*Дектор ярих:* Монголын төмрийн дархчууд эртнээс нарийн эд зүйлсээ битүү амьсгаагаар үрлаж байсан түүхтэй. XX зууны сүүлийн үеийн Дарьгангын алдарт дархчуудын нэг Ш.Дондов битүү амьсгааны гайхамшгаар бүтээлээ туурвиж байсан тухай урлаг судлаач, доктор Л.Батчулуун судалгаандаа дурджээ.

Битүү амьсгаа гэх оюун ухааны чинад орших далдын хүч, хүний биеийн хийн урсгалын гайхамшиг, амьд эрчмийг өдөөгч эрдмийн үр, монголчуудын уламжлалт сэтгэлгээний онцлог бүхий дахин давтагдашгүй хосгүй үнэт биет болон биет бус өвийн дээжид /өөр дурсгал нэрлэж олох Дарьгангийн Дондовын бүтээлээс нэрлэх/, Туулын хар шугуйгаас судлаач, эрдэмтэн Д.Наваан нарын малтаж олсон XIII зууны үеийн язгууртны суран агсарганы алтан бэл тэргүүтнийг нэрлэж болно. Мөн “Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн Д.Дорж Шанхын баруун хүрээ хийдэд битүү амьсгаагаар Майдарын дүлцэн дэглэн бүтээлцэж байсан тухай баримтууд ч байсаар байна”<sup>12</sup>.

*ДЕКТОРЫН ЯРИАН ДУНД ДҮРСЭЭР ҮЗҮҮЛЭХ:* (битүү амьсгаагаар урласан дээрх зүйлсийн бичлэг, зураг гарах ялангуяа Дарьгангын алдарт дархан Ш.Дондов дарханы урлал байгаа дүрс гарна-монгол дархан баримтат киноноос дүрс авч оруулна, лимбэнээс өөр тохирох ая тавих)

Дөрөвдүгээр хэсэг буюу нийгэм, өрнийн соёлын нөлөө

*Дектор ярих:* XX зууны эхэн үеэс монгол оронд өрнийн нөлөө ихээр нэвтэрч эхэлсэн билээ. Өрнийн хөгжмийн эгшиглэгээ, дуу, хөгжим гээд олон зүйл бидний уламжлалт урлагт багагүй нөлөөлж 1980-аад он гэхэд уртын дуу дуулах, хуурдах, лимбэдэх уламжлал нэлээдгүй багассан байлаа. Мэргэжлийн хөгжмийн сургуулийн сургалтын хөтөлбөрөөс ардын арга барилаар хөгжимдөх хичээл хасагдаж, мэргэжлийн урлагийн байгууллагуудын тоглолтын хөтөлбөрт мэр сэр байх болсон нь уртын дуу, хуурч, лимбэчний хамсран урладаг нэгэн төрөл гээгдэх байдал ажиглагдах болсон юм.

<sup>12</sup> Батчулуун Л. Монгол дархан. - УБ.,2009. -Х.342



*ДЕКТОРЫН ЯРИАН ДУНД ДҮРСЭЭР ҮЗҮҮЛЭХ: (ХХ зууны эхэн үеийн нийгэм, өрнийн соёлын талаар дүрс бичлэг, тайзны бичлэг, зураг гаргах)*

Тавдугаар хэсэг буюу түүх, соёлоо сэргээх хандлага

*Дектор ярих: ХХI зууны эхэн үеэс уламжлалт урлагийг сэргээх, хадгалж хамгаалах талаар иргэд, улс нийгмийн хувьд анхаарлаа хандуулж эхэлсэн юм.*

Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон Монгол Улсын Их Хурлын 2012 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан Төрөөс соёлын талаар баримтлах бодлогын баримт бичигт “Манай орон түүх, соёл, урлагийн арвин өв баялагтай бөгөөд үндэсний соёл нь монголын ард түмний оюуны суурь дархлаа, өвөрмөц дүр төрхийн тодорхой илрэл, гурван цагийг холбосон ариун нандин холбоос мөн” хэмээн тодорхойлж, соёлын үнэт зүйлийг бүтээгч, соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийг бүтээн туурвих, өвөрмөц дэг сургуулиа өвлүүлэн үлдээх, шавь сургалт явуулахад нь дэмжлэг үзүүлж, төрийн хамгаалалтад байлгах тухай, Соёлын өвийг хамгаалах тухай хуулинд “соёлын биет бус өв” гэж хамт олон, бүлэг, хувь хүн соёлын өвийнхөө бүрэлдэхүүн хэсэг гэж хүлээн зөвшөөрсөн зан заншил, дүрслэх болон илэрхийлэх хэлбэр, уламжлалт мэдлэг, арга барил, тэдгээртэй холбоотой эд өлгийн зүйл, зэмсэг, урлагийн бүтээл, соёлын орон зайг хэлэх бөгөөд Соёлын биет бус өв устсан, мартагдсан тохиолдолд сэргээн уламжлуулах арга хэмжээг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага холбогдох бүртгэл, мэдээллийг үндэслэн зохион байгуулах зэргээр хуульчлан заажээ.

Эртний ахмадуудын адил уртын дуугаа чадварлаг лимбэдэх лимбэчид цөөрсөн нь өнөөгийн залуу лимбэчдийн хувьд анхаарах асуудлын нэг байсан бөгөөд 2007 онд “Монголын лимбэчдийн холбоо” байгуулагдан алдарт ахмад лимбэчдийн залуу халааг бэлтгэх, өв уламжлалыг сэргээх, дэлгэрүүлэх талаар төрийн болон төрийн бус байгууллага, хамт олон, мэргэжил нэгт нөхөдтэйгээ хамтран ажиллаж, үүний төлөө сэтгэл зовниж эхэлсэн юм.

*ДЕКТОРЫН ЯРИАН ДУНД ДҮРСЭЭР ҮЗҮҮЛЭХ: (Монголын лимбэчдийн холбоо Зохион байгуулсан уралдаан, үйл ажиллагаануудын зураг, бичлэг гаргах, Л.Цэрэндоржийн 100, 110 жилийг тэмдэглэн өнгөрүүлсэн бичлэг, зураг, уралдаан тэмцээн зохион байгуулж байсан тухай дүрс үзүүлэх)*

Зургаадугаар хэсэг буюу ЮНЕСКО-д бүртгүүлсэн, цаашид хүлээх үүрэг хариуцлагын тухай

*ЮНЕСКО-ийн МҮК-ийн нарийн бичгийн дарга Уянга ярих: Уртын дууг урьдын сайчуул шиг лимбэддэг лимбэч эдүгээ үгүйлэгдэх болж, лимбэчдийн урын санд ардын арга барилаар лимбэддэг бүтээлийн эзлэх хувийн жин багасаж байна. Энэ нь нэг талаас ардын уламжлалт урын сангаас судлах, суралцах бодлого, зохицуулалт алдагдсан, суралцах бүтээлч эрэл дутмаг байгаагаас үүдэлтэй бөгөөд уртын дуугаа мэдэх лимбэч цөөрч, битүү амьсгаагаар лимбэдэх уламжлалт арга барил мартагдах аюул ойрхон байгаа гэсэн утга мөн. Үүний нөгөө талд сонсогчид, ялангуяа залуу үеийнхний өв уламжлалдаа хандах хандлагад сөрөг нөлөө үзүүлж буйг бид анхаарах учиртай. Иймд өдөр хоногоор мартагдаж, устах аюул нүүрлээд байгаа эл өвийн амьдрах чадварыг нь хангах шаардлага хурцаар тавигдаж, улмаар 2011 онд “Монгол лимбэчдийн уртын дууг хөгжимдөх уламжлалт арга-битүү*

амьсгаа”–г ЮНЕСКО-гийн яаралтай хамгаалах биет бус өвд Монгол Улс бүртгүүлсэн билээ.

*УЯНГЫН ЯРИАН ДУНД ДҮРСЭЭР ҮЗҮҮЛЭХ:* (ЮНЕСКО-д явуулсан материал, батламж хүлээж авсан зураг, дүрс гарна)

Долоодугаар хэсэг хэсэг буюу өвийг уламжлуулах, тогтворжуулах сургалт

*СӨҮТ-ийн захирал Г.Энхбат ярих:* Битүү амьсгааны аргад суралцагчийг сургах аргын нэг бол шавь сургалт буюу гэр-танхимын сургалт гэж бид үзсэн бөгөөд үүнийг туршин хөгжүүлснээр уртын дууг лимбэдэх урлаг нь монгол ахуй, зан үйл, айлын найр, гэрийн хоймроос холдож, танхим, тайз хоёроос халихгүй болсон энэ цаг үед үүсч буй хүндрэл бэрхшээлийг даван туулах боломж бүрдэнэ. Ингэснээр хотжилт, даяаршил, шинэчлэлт гэх мэт шинэ аюул заналын хүчин зүйлийн нөлөөллөөс шалтгаалан өдрөөс өдөрт цөөрч буй уламжлалт арга барилаар хөгжимдөх лимбэчдийн тоог өсгөх, урын санг нэмэгдүүлэх боломж бий болно гэж үзсэн. Дээд мэргэжлийн сургалтаар лимбэчин бэлтгэж байгаа нь сайн хэрэг боловч, лимбэ гэрийн хоймроос концертын тайзнаа бүрэн шилжиж, улмаар ардын арга барилаар лимбэдэх лимбэч ховордох эрсдэл бий болж байна. Өөрөөр хэлбэл, лимбэний сургалтад мэргэжлийн чиг давамгайлж, уламжлал, шинэчлэлийн зохистой харьцааг хангах боломж хомс байна.

*ЭНХБАТЫН ЯРИАН ДУНД ДҮРСЭЭР ҮЗҮҮЛЭХ:* (Ардын урлагийн наадмын бичлэг үзүүлэх)

*Цэвэгсүрэн ярих:* Бусад төрлийн хөгжимчидтэй харьцуулбал, Монгол улсад лимбэчин цөөн, тэр дундаа битүү амьсгаатай нь бүр ч цөөн байна. Эдүгээ энэхүү уламжлалт арга барилаар лимбэдэх давтамж тогтмол бус, лимбэчдийн хүрээнд хааяа зохиогдох уралдаан тэмцээн, бие даасан уран бүтээлийн тоглолт төдийгөөр хязгаарлагдаж байна. Нөгөө талаар лимбэний битүү амьсгааг эзэмшсэн цөөн авъяастан бие биеэс алс ганц нэгээр амьдарч, уг өвийг хамгаалах талаар хүчин чармайлтаа нэгтгэж чадахгүй байгаад анхаарал хандуулж, уламжлал шинэчлэлийн зохист харьцааг зөв барих нэгдсэн зохион байгуулалт бүхий тогтолцоог бүрдүүлэх нь зүйтэй байсан юм.

*Насанжаргал ярих:* Энэ зорилгоор Монгол улс ЮНЕСКО-ийн дэргэдэх ..... санд 20..... онд “Монгол уртан дуу лимбэдэх уламжлалт арга битүү амьсгааг өвлүүлэн уламжлуулах, тогтворжуулах нь” төслийг санхүүжүүлэх хүсэлтийг илгээж, шалгуурыг ханган энэхүү төслийг хэрэгжүүлэх эрхийг Монголын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны харъяа Соёлын өвийн үндэсний төв хариуцан, Монголын лимбэчдийн холбоо төрийн бус байгууллага, аймаг орон нутаг, их дээд сургууль, судалгааны байгууллага, эрдэмтэн судлаачидтай хамтран 2019-2021 оны хооронд хэрэгжүүллээ. Төслийн хүрээнд Монгол орны .....бүс нутагт .... аймагт .....өвлөн уламжлагчийг шинээр сургах, шавь бий болгох, газар нутагт нь уламжуулж үлдээх, сэргээн зорилгоор хээрийн судалгааны ажил, шавь сургалт зохион байгуулж, лимбэ зааж сургах тоног төхөөрөмж бүхий ..... сургалтын танхимыг ЮНЕСКО-ийн санхүүжилт болон орон нутгийн төсвийн санхүүжилтээр хамтран нээн ажиллуулав.

*Цэвэгсүрэн ярих:* Төслийн хүрээнд лимбэ тоглож сургах гарын авлага, нот бичлэг, сурах арга барилын тухай хэвлэн гаргасан ном, гарын авлагын тухай ярина.

ЦЭВЭГСҮРЭН, НАСАНЖАРГАЛ НАРЫН ЯРИАН ДУНД ДҮРСЭЭР ҮЗҮҮЛЭХ:  
(Театрын музей дэх төслийн нээлт, хээрийн судалгаа, шавь сургалт, танхимын нээлтүүд, гарын авлаганы дүрс гарах, дүрс дүрс үзүүлэх)

Наймдугаар хэсэг буюу монгол лимбэ урлах үйл ажиллагаа

*Дектор ярих:* Төслийн хүрэнд хийгдэж буй үндсэн ажлуудын нэг нь лимбэ хөгжмийг урлан хийх арга ажиллагаанд суралцах, орон нутагт лимбэ хөгжим хийх урлаач бэлтгэх явдал байв.

Г.Нямжанцан ярих: Лимбэний хийц-бүтээц, дуурьслын онцлог, урлаач Д.Индрээ зэрэг урлаачдын талаар ярина. Мөн аймгуудын төлөөллөөс урлаачдын нэрсийг хэлнэ.

НЯМЖАНЦАНГИЙН ЯРИАН ДУНД ДҮРСЭЭР ҮЗҮҮЛЭХ: (Лимбэний урлал, сургалт явагдаж байгаа бичлэг дүрс, дүрс үзүүлэх)

Есдүгээр хэсэг буюу лимбэний тархалт харуулсан график зураг

*Цолмон ярих:* Төслийн хүрээнд хээрийн судалгаагаар цуглуулсан тоо баримт, эрдэм шинжилгээний хурал, төслийн үр дүнд лимбэний битүү амьсгааны тархалтын газрын зураг яаж өргөжин тэлсэн тухай, нийт хэдэн хүн суралцсан, тухай ярих, төслийн дүгнэж нэгтгэх.

ЦОЛМОНГИЙН ЯРИАН ДУНД ДҮРСЭЭР ҮЗҮҮЛЭХ: (хээрийн зарим судалгаа хийж буй дүрс, , хурал, уралдааны бичлэг, компьютер графикаар хийсэн газрын зураг зэрэг дүрс гаргах, үзүүлэх.)

Аравдугаар дугаар хэсэг буюу Төслийн үр дүн

*Киноны төгсгөл хэсэгт дектор унших:* Лимбэний битүү амьсгааг “хүн, байгаль хоёрыг.....газар, тэнгэр хоёрыг холбогч гүүр”, Монголчуудын бурханлаг, тэнгэрлэг, гүн ухаанлаг, аугаа хүчирхэг, хийсвэр дүрсэлийн сэтгэхүйн орон зайд хөгжимчин хүн өөрийн ур чадвараа хөгжүүлэхэд онцгой ач холбогдолтой арга хэмээн судлаач Л.Оюунчимэг тэмдэглэсэн нь угтаа монгол лимбэчдийн уртын дуу лимбэдэх уламжлалт арга битүү амьсгааны урлагийн аугаа мөн чанарыг хэлсэн гэлтэй.

Товчхондоо, монгол лимбэчдийн лимбэдэх урлаг дахь битүү амьсгаагаар урлахуйн үр дүнд монгол сэтгэлгээ, монгол хөг аялгуу, монгол дуурьсал бий болж байна. Энэ нь монгол ухаан, монгол арга бөгөөд үүгээрээ монголын төдийгүй Дэлхийн соёлын үнэт өв болон тэмдэглэгдэж байгаа юм.

ДЕКТОРЫН ЯРИАН ДУНД ДҮРСЭЭР ҮЗҮҮЛЭХ: (уяхан замба тивийг харуулсан зураг, дүрс бичлэг оруулах)

## КИНО ДУУСАХ

### *Дэлгэцэнд:*

- Кино зохиол бичсэн Г.Энхбат, Ц.Цэвэгсүрэнгийн албан тушаал, цол гуншин,
- Найруулагчийн нэр, цол гуншин,
- Төслийн багийн ажилтнуудын нэрс,
- Дүрс бичлэг хийсэн хүний нэр ус, байгууллага,
- Эвлүүлсэн газар, хүний нэр ус,
- Хамтран оролцсон хүний нэр ус /багш нар, сургагч багш нар, шавь нар гм./
- Жолооч,
- Дуу, дүрс бичлэг ашигласан кино, дүрс, дууны нэрс,

- Ивээн тэтгэсэн болон хамтран оролцсон байгууллага ЮНЕСКО-гийн лого, биет бус өвийн эмблем, төслийн лого зураг, ЮНЕСКО-ийн МҮК-ийн лого, СӨҮТ-ийн лого, БСШУСЯамны лого, Лимбэчдийн холбооны лого,
- Төсөлд хамрагдсан бусад байгууллага, аймгуудын лого нэрс,
- COPYRIGHT 2021 гэж бичнэ.

КИНО ЗОХИОЛ БИЧСЭН. Ц.ЦЭВЭГСҮРЭН. СУИС-ИЙН  
БАГШ, МОНГОЛЫН ЛИМБЭЧДЫН  
ХОЛБООНЫ ТЭРГҮҮН

-----oOo-----



Музей, эрдэм шинжилгээний хүрээлэн, Үндэсний номын сан, Эрдэнэсийн сан, сүм хийд, их дээд сургууль зэрэг нэр бүхий 27 байгууллагад хадгалагдаж буй 778 хосгүй үнэт дурсгалт зүйлс нь дараах төрөл зүйлийн ангилалд хамаарч байна. Үүнд:

- Түүхийн холбогдолтой эд өлгийн зүйл- 402 дурсгал,<sup>13</sup>
- Шашин шүтлэгийн холбогдолтой эд өлгийн зүйл- 274 дурсгал,
- Археологийн олдвор- 49 дурсгал,
- Байгалийн түүхийн холбогдолтой- 34 дурсгал,
- Урлаг, уран сайхны холбогдолтой- 11 дурсгал,
- Угсаатны зүйн эд өлгийн зүйл- 8 дурсгал байна.



Зэрэглэлд батлагдсан хосгүй үнэт дурсгалт зүйлсэд судалгаа хийж үзэхэд “Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалт”-д дараах 2 чиглэлээр нэмэлт, өөрчлөлтийг хийх зайлшгүй шаардлага гарч байна. Үүнд:

1. Засгийн газрын тогтоолын хавсралт “Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалт”-д бүртгэгдсэн дурсгалт зүйлийн талаарх үндсэн мэдээлэл, тодорхойлолтыг сайжруулах, залруулах замаар нэмэлт, өөрчлөлт оруулах.
2. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 8.3 дугаар зүйлд заасан хосгүй үнэт зэрэглэлийн шалгуур үзүүлэлтийг хангахгүй байгаа дурсгалт зүйлсийг “Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалт”-аас хасах.


#### НЭГ. ТҮҮХ, СОЁЛЫН ХОСГҮЙ ҮНЭТ ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ МЭДЭЭЛЭЛД ОРУУЛАХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТҮҮД

<sup>13</sup> Түүхийн холбогдолтой 402 хосгүй үнэт дурсгалт зүйлээс 316 ширхэгийг нь зооснууд эзэлж байна.

Засгийн газрын тогтоолоор батлагдсан “Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалт”-д бичигдсэн зарим хосгүй үнэт дурсгалт зүйлийн тодорхойлолт бичвэрт мэдээлэл нэмж оруулах, ташаарч алдаа мадагтай бичигдсэнийг засаж сайжруулахад дараах 6 чиглэлийн нэмэлт, өөрчлөлтүүдийг хийх шаардлагатай байна.

№	“Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалт”-д хийгдэх нэмэлт, өөрчлөлтүүд	Нэмэлт, өөрчлөлт хийгдэх хосгүй үнэт дурсгалын /Тоо ба Хувь үзүүлэлт/	Тайлбар
1.1	“Дурсгалт зүйлийн нэр”-нд нэмэлт өөрчлөлт оруулах	9 дурсгал /нийт хосгүй үнэт дурсгалын 1.15%/	Хүснэгт №1
1.2	“Бүтээсэн он цаг”, “Бүтээлч”-ийг тодруулан судлах	2 дурсгал /нийт хосгүй үнэт дурсгалын 0.25%/	Хүснэгт №2
1.3	Бичигдээгүй орхигдсон мэдээллийг нэмж оруулах	60 дурсгал /нийт хосгүй үнэт дурсгалын 77.2%/	Хүснэгт №3
1.4	Дурсгалт зүйлийн “хэмжээ” ба “хувийн дугаар”-ын өөрчлөлтийг оруулах	300 дурсгал /нийт хосгүй үнэт дурсгалын 38.6%/	Хүснэгт №4
1.5	Эзэмшигч байгууллагын нэр ташаарч орсоныг залруулах	1 дурсгал /нийт хосгүй үнэт дурсгалын 0.128%/	Хүснэгт №5
1.6	Эзэмшигч, өмчлөгчийн асуудлыг шийдвэрлэх	1 дурсгал /нийт хосгүй үнэт дурсгалын 0.128 %/	Хүснэгт №6

Хосгүй үнэт дурсгалт зүйлийн тодорхойлолт бичвэрт нэмэлт, өөрчлөлт оруулах



- "Хэмжээ" ба "хувийн дугаар"-ын өөрчлөлтийг оруулах - 300 дурсгал буюу 38.60 %
- "Дурсгалт зүйлийн нэр"-нд нэмэлт, өөрчлөлт оруулах - 9 дурсгал буюу 1.15%
- "Бүтээсэн он цаг", "Бүтээлч"-ийг тодруулан судлах - 2 дурсгал буюу 0.25%
- Эзэмшигч байгууллагын нэрийг залруулах - 1 дурсгал буюу 0.12%
- Эзэмшигч, өмчлөгчийн асуудлыг шийдвэрлэх - 1 дурсгал буюу 0.12%

1.1 “Дурсгалт зүйлийн нэр”-нд нэмэлт өөрчлөлт оруулах

Хүснэгт №1

№	Засгийн газрын тогтоолын он, дугаар	ЗГ-ын тогтоолд бичигдсэн “Дурсгалын нэр”	Тайлбар
1	1998 оны 126 дугаар тогтоолын 59-ээс 78 -д	21 Дара -Эх /Богд хааны ордон музей/	21 Дара эхийн дотор “эр лагшинтай, зүүн мөрөн дээгүүрээ гөрөөсний арьс давуулан нөмөрсөн Жанрайсиг бурхан”-ыг 21 Дара эхээс ялган салгаж, зөв нэршлээр нь бүртгэх. 21 Дара эхийн бүрдлийн дутуу эсэхийг тодруулах.
2	2002 оны 118 дугаар тогтоолын 159 дэх	Цагаан дара эх /Чойжин ламын сүм музей/	“Эр лагшинтай, зүүн мөрний цэцгэн дээр очир залаастай “Очирваань бодисадва” эсэхийг нягтлан шалгаж, зөв нэрээр бүртгэх
3	2002 оны 188 дугаар тогтоолын 180 дэх	Судар барьсан лам	Чухам ямар ламын дүр болохыг нягтлах, тодруулах
4	2002 оны 188 дугаар тогтоолын 181 дэх	Жийцэгмаа	Чухам ямар ламын дүр болохыг нягтлах, тодруулах
5	2011 оны 175 дугаар тогтоолын 137, 2011 оны 214 дугаар тогтоолын 603, 2012 оны 58 дугаар тогтоолын 692, 699, 726 дахь тус тус	Суварга	ЗГ-ын тогтоолд “Суварга” хэмээн ерөнхий нэрээр бичигдсэн байгаа 11 суваргыг чухам ямар суварга болохыг нь тодорхой нэрлэх.
№	Засгийн газрын тогтоолын он, дугаар	Дурсгалын нэр ташаарсан	Залруулах нь
6	2000 оны 175 дугаар тогтоолын 138 дахь	Шагш Жанрайсиг	Чагши Жанрайсиг
7	2004 оны 108 дугаар тогтоолын 205 дахь	Доржсэмбэ	Дэмчиггарав
8	2004 оны 108 дугаар тогтоолын 201 дэх	Очирдара	Доржсэмбэ
9	2005 оны 116 дугаар тогтоолын 257 дахь	Бурхан багш, 16 архад, 4 махранзын хамт лусын оронд	Хасарваань Жанрайсиг 16 архад, 4 махранзын хамт лусын оронд

1.2 “Бүтээсэн он цаг”, “Бүтээлч”-ийг тодруулан судлах шаардлагатай

Хүснэгт №2

№	Засгийн газрын тогтоолын он, дугаар	ЗГ-ын тогтоолд бичигдсэн “бүтээгч” болон “он цаг”-ийг судлах	Тайлбар
1	2012 оны 105 дугаар тогтоолын 772-т	Дарьганга эхнэрийн толгойн гоёл, хавчаар. Бүтээгч: Ш.Дондов, Бүтээсэн он цаг: (1906-1907)	Бүтээлч болон бүтээсэн он цагийг судлах, тодруулах. Шарав дархны хүү Дондов (1912-1984) /Л.Батчулуун “Монгол Дархны урлаг”-II боть 708-р тал/



2	2012 оны 105 дугаар тогтоолын 773-т	Үзэмчин эхнэрийн толгойн гоёл Бүтээгч: Тодорхойгүй, Бүтээсэн он цаг: <u>1950-иад он</u> Хувийн дугаар: <u>СҮМ1959.10.2</u>	Бүтээлчийг нь тодруулах, Хэдий үед хамаарах бүтээл болохыг нь судлах “Бүтээсэн он цаг”-ийн мэдээллийг тухайн музейн бүртгэлд орсон онтой ташаарч бичсэн байх магадлалтайг судлах шаардлагатай байна.
---	-------------------------------------	---	---

### 1.3 Бичигдээгүй орхигдсон мэдээллийг нэмж оруулах

Хүснэгт №3

№	Хийгдэх нэмэлт, өөрчлөлт	Засгийн газрын тогтоолын он, дугаар	Хосгүй үнэт дурсгалын тоо
1	Хувийн дугаар бичигдээгүйг нэмж оруулах	1995 оны 241 дугаар тогтоолын 1-39-т	39 дурсгал
2	Хэмжээ, хувийн дугаарын бичвэрийн алдааг засах	2005 оны 116 дугаар тогтоолын 256, 261-т	2 дурсгал
3	Хадгалагдаж буй газар: музейн нэр бичигдээгүйг нэмж оруулах	2011 оны 373 дугаар тогтоолын 652-670-д	19 дурсгал
	Нийт		60 дурсгал

### 1.4. Дурсгалт зүйлийн “хэмжээ” ба “хувийн дугаар”-ын өөрчлөлтийг оруулах

Хүснэгт №4

№	Байгууллага	Хосгүй үнэт 300 дурсгал	Хийгдэх засвар өөрчлөлт
1	Монголын Үндэсний музей	26	Хэмжээ, хувийн дугаарын өөрчлөлт
2	Дүрслэх урлагийн музей	71	Хэмжээ, хувийн дугаарын өөрчлөлт
3	Богд хааны ордон музей-	78	Хэмжээ, хувийн дугаарын өөрчлөлт
4	Чойжин ламын сүм музей	38	Хэмжээ, хувийн дугаарын өөрчлөлт
5	Монголын Үндэсний номын сан	20	Хэмжээ, хувийн дугаарын өөрчлөлт
6	Төрийн түүхийн музей	17	Жин, хувийн дугаарын өөрчлөлт
7	Байгалийн түүхийн музей	8	Хэмжээ бичигдээгүйг нэмэх,
8	Гандантэгчэнлин хийд	15	Хэмжээ, хувийн дугаарын өөрчлөлт
9	Эрдэнэ зуу музей	27	Хэмжээний өөрчлөлт, бичигдээгүй хувийн дугаарыг нэмж оруулах

Музейн сан хөмрөгийн 2 удаагийн /2006-2008 ба 2012-2014 он/ улсын тооллогоор үзмэрүүдийн хэмжээ жин, хувийн дугаар нь нэлээд өөрчлөгдөн бүртгэгдсэн юм. Улсын тооллогоор хийгдсэн засвар, өөрчлөлтийн дүнд “Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэл” болон Засгийн газрын тогтоол дахь мэдээлэл зөрүүтэй болсон байна.

### 1.5. Эзэмшигч байгууллагын нэр ташаарч орсоньг залруулах

Хүснэгт №5

№	Засгийн газрын тогтоолын он, дугаар	Ташаарсан нь	Эзэмшигч байгууллагын нэрийг Залруулах нь
1	ЗГ-ын 1998 оны 126-р тогтоолын 84-т	Чойжин ламын сүм музей	Богд хааны ордон музей

### 1.6 Эзэмшигч, өмчлөгчийн асуудлыг шийдвэрлэх

№	Засгийн газрын тогтоолын он, дугаар	Засгийн газрын тогтоолд бичигдсэн байгууллага	Одоо эзэмшиж, хадгалж байгаа газар
1	ЗГ-ын 2004 оны 108-р тогтоолын 228-д	Үндэсний түүхийн музей /хуучин нэрээр/	Өвөрхангай аймаг, Хархорин сум, Шанхын Баруун хүрээ хийд

“Дурсгалын шинж байдал”-ыг тодорхойлсон бичвэрийн талаар:

Засгийн газрын тогтоолын хавсралтад бичигдсэн зарим нэгэн “Дурсгалын нэр”, “Дурсгалын шинж байдал”-ийг бичсэн бичвэрийн утга найруулгыг засаж сайжруулах, зөв бичих дүрмийн дагуу цэг, таслал тавиагүйгээс гарсан найруулгын алдааг засах шаардлагатай байна.

Тухайлбал: Засгийн газрын 2012 оны 105 дугаар тогтоолын 672 дугаарт “Бурхан багш хоёр шавь, сэнтий, жавялын хамт”, 690 дүгээрт “Авид сэнтийн хамт”, 691 дүгээрт “Авид сэнтийн хамт”, 695 дугаарт “Ламид дара эх гүнгэрвааны хамт” хэмээн бурхадыг ширээ түшлэг, гүнгэрваатай нь хольж нэрлэн бичсэн энэ мэт найруулга муутайг засах;

Тухайлбал: Засгийн газрын 2012 оны 105 дугаар тогтоолын 740 дугаарт бичигдсэн “Ганц эвэрт барс толгойтой, шувуу биетэй амьтны дүрстэй алтан чимэг”-ийн “Дурсгалын шинж байдал”-д *Хүннүгийн хаадын хэрэглэж байсан сүйх тэрэгний хөллөгөө морины чимэглэл, төмөр голтой, дугуй хэлбэрийн алтан хөөмөл, 2 ширхэг оюу болон тунгалаг хүрэн өнгийн чулуун шигтгээтэй, голч 13.5 см* гэсэн бичвэрт “2 ширхэг алтан хөөмөл”-ийг тодорхойлохдоо 2 ширхэг-ийн урд талд таслалын (,) тэмдэг тавьсанаас алтан хөөмөл 2 ширхэг гэж уншигдахгүй, харин 2 ширхэг оюу шигтгээтэй гэсэн ойлголт төрүүлэхүйц найруулгын том алдаа гарсан байна, энэ мэт Засгийн газрын тогтоолын бичвэрийг засах, сайжруулах асуудлууд байсаар байна.


**ХОЁР. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ ХАНГАХГҮЙ ЗАРИМ ХОСГҮЙ ҮНЭТ  
ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙГ УГ ЖАГСААЛТААС ХАСАХ ТУХАЙ**

Засгийн газрын 2012 оны 105 дугаар тогтоолоор хосгүй үнэт зэрэглэлд батлагдсан дурсгалт зүйлсээс 34 нь ур хийцийн хувьд ядмаг дорой, өөр бусад музей болон сүм хийдүүдэд нийтлэг элбэг эд өлгийн зүйлс хамрагджээ. Иран зэрэг дундад Азийн орнуудад дэлдсэн, монгол болоод хөрш зэргэлдээ орнуудад нийтлэг элбэг байдаг 315 ширхэг зооснууд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 8.3.1, 8.3.2, 8.3.3, 8.3.4, 8.3.5-д заасан шалгууруудыг илт хангаж чадахгүй байна.

Мөн хууль, хяналтын байгууллагын дүгнэлтээр дутсан, солигдсон нь тогтоогдсон хосгүй үнэт дурсгалуудыг “Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалт”-аас хасах асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.

№	“Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалт”-аас хасах болсон шалтгаан	Жагсаалтаас хасах хосгүй үнэт дурсгалт зүйлийн Тоо ба Хувь үзүүлэлт	Тайлбар

1	Түүх, соёлын хосгүй үнэт зэрэглэлийн шалгуур үзүүлэлт хангахгүй	349 дурсгал /нийт хосгүй үнэт дурсгалын 44.9 %/	Хүснэгт №7
2	Солигдсон нь тогтоогдсон	5 дурсгал /нийт хосгүй үнэт дурсгалын 0.64 %/	Хүснэгт №8
3	Дутсан нь тогтоогдсон	2 дурсгал /нийт хосгүй үнэт дурсгалын 0.25 %/	Хүснэгт №9



### 2.1 Түүх, соёлын хосгүй үнэт зэрэглэлийн шалгуур үзүүлэлт илт хангахгүй дурсгалууд

Хүснэгт №7

№	Засгийн газрын тогтоолын он, дугаар	Дурсгалын нэр
1	2012 оны 105 дугаар тогтоол, №678	Ямандаг 3-42-30
2	2012 оны 105 дугаар тогтоол, №679	Пэрэнлэйжалбуу 3-42-45
3	2012 оны 105 дугаар тогтоол, №680	Зэмэрчойжин 3-42-51
4	2012 оны 105 дугаар тогтоол, №681	Дамдинсандүв 3-42-51
5	2012 оны 105 дугаар тогтоол, №699	Суварга 65-67, 2/57
6	2012 оны 105 дугаар тогтоол, №700	Суварга (бодь) 65-65, 2/55
7	2012 оны 105 дугаар тогтоол, №701	Авид 65-1126, 1/55
8	2012 оны 105 дугаар тогтоол, №702	Богд Зонхов хоёр шавийн хамт 65-406, 4/32
9	2012 оны 105 дугаар тогтоол, №703	Бурхан багш 65-1316, 3/32
10	2012 оны 105 дугаар тогтоол, №704	Махгал 65-566, 2/99
11	2012 оны 105 дугаар тогтоол, №705	Манал 65-920, 1/38
12	2012 оны 105 дугаар тогтоол, №706	Лхамноржмаа 65-28, 1/9
13	2012 оны 105 дугаар тогтоол, №707	Зуу бурхан 65-1478, 3/88

14	2012 оны 105 дугаар тогтоол, №708	Найдан /16 ширхэг/ 65-1317, 3-35
15	2012 оны 105 дугаар тогтоол, №709	Гэндэндармаа 65-1319, 3/34
16	2012 оны 105 дугаар тогтоол, №710	Зуу бурхан 65-1331, 3/37
17	2012 оны 105 дугаар тогтоол, №711	Богд Зонхов хоёр шавийн хамт 65-1311, 3/26, 65-1312-2, 3/27, 65-1312-1, 3/27
18	2012 оны 105 дугаар тогтоол, №712	Авид 65-491, 2/4
19	2012 оны 105 дугаар тогтоол, №713	Махгал 65-971, 2/64
20	2012 оны 105 дугаар тогтоол, №714	Суварга 65-997, 2/102
21	2012 оны 105 дугаар тогтоол, №715	Аюуш 65-1015, 2/31
22	2012 оны 105 дугаар тогтоол, №716	Бурхан багш 65-1022, 2/108
23	2012 оны 105 дугаар тогтоол, №717	Махгал 65-1491, 3/223
24	2012 оны 105 дугаар тогтоол, №718	Ловон Ёндон-Од 65-1509, 4/5
25	2012 оны 105 дугаар тогтоол, №719	Сэгва-аа 65-1486-1, 4/9
26	2012 оны 105 дугаар тогтоол, №720	Махгал 65-552, 2/141
27	2012 оны 105 дугаар тогтоол, №721	Өндөр гэгээн 65-348, 2/08
28	2012 оны 105 дугаар тогтоол, №722	Богд лам 65-1195, 1/32
29	2012 оны 105 дугаар тогтоол, №723	Балданлхам 65-543, 2/98
30	2012 оны 105 дугаар тогтоол, №724	Ногоон дара эх 65-532, 2/165
31	2012 оны 105 дугаар тогтоол, №725	Майдар 65-1295, 3/3
32	2012 оны 105 дугаар тогтоол, №726	Суварга /7 ширхэг/ 65-68 “А, Б, В, Г, Д, Е, Ё” 3/19
33	2012 оны 105 дугаар тогтоол, №727	Жүгдэрнамжил 65-869, 2/48
34	2012 оны 105 дугаар тогтоол, №728	Богд лам 65-40, 2/69

№	Засгийн газрын тогтоолын он, дугаар, тогтоолын хавсралт дахь дугаар	Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 8.3.1, 8.3.3-т заасан шалгууруудыг хангаж чадахгүй байгаа хосгүй үнэт дурсгалууд /нийт 315 ширхэг зоос/
1	2010 оны 103 дугаар тогтоол, № 294-547 дүгээрт	Зоос /255 ширхэг/
2	2011 оны 373 дугаар тогтоол, № 611-670 дугаарт	Зоос /60 ширхэг/

2.2 Солигдсон нь тогтоогдсон 5 дурсгал /Эрдэнэ Зуу музей/

Хүснэгт №8

№	Засгийн газрын тогтоолын он, дугаар	Дурсгалын нэр
1	2002 оны 118 дугаар тогтоолын 183-т	Аюуш бурхан (хувийн дугаар 1/8 “А”),
2	2002 оны 118 дугаар тогтоолын 184-т	Аюуш бурхан (хувийн дугаар 1/8 “В”),
3	2004 оны 108 дугаар тогтоолын 209-д	Санжаа марлий зод (хувийн дугаар 65-592, 1/23),
4	2004 оны 108 дугаар тогтоолын 211-т	Авид (хувийн дугаар 65-932, 1/48),
5	2004 оны 108 дугаар тогтоолын 215-д	Пагва лам (хувийн дугаар 65-585, 1/71)

2.3 Дутсан нь тогтоогдсон 3 дурсгал /Палеонтологийн төв, хуучин нэрээр/  
Хүснэгт №9

№	Засгийн газрын тогтоолын он, дугаар	Дурсгалын нэр
1	2010 оны 103 дугаар тогтоолын 584-т	Тарбозавр
2	2010 оны 103 дугаар тогтоолын 586-д	Ахиллобаторын бүрэн бус араг яс

Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд хамруулах заалтын хэрэгжилтэд:

- соёлын өв, дурсгалуудыг хавтгайруулан хамруулахгүй байх зарчмыг баримтлах,
- тухайн дурсгалын судлагдсан байдлыг нэн түрүүнд авч үзэх,
- дурсгалын талаарх тодорхойлолт бичвэрийн хэл найруулгыг сайтар хянаж байх шаардлагатай байна.

ТАЙЛАН БИЧСЭН:

Д.НАРАНТУЯА. СОЁЛЫН ӨВИЙН БҮРТГЭЛ,  
СУДАЛГААНЫ ГАЗРЫН  
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ

-----oO-----

## НЭМЭЛТ АЖИЛ

### СОЁЛЫН ӨВИЙН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН 2017-2018 ОНЫ БАЯЖИЛТЫН СУДАЛГААГ НЭГДСЭН ТАНИЛЦУУЛГА

Улаанбаатар хот

2019-04-06

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16.1.4, 20.1.3, 23.2-д заасны дагуу соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангаас байгууллага болон аймаг, нийслэлийн бүртгэл, мэдээллийн сангаас жил бүрийн баяжилтын тайланг 2015 оноос эхлэн авч, нэгтгэж ирлээ.

2017-2018 оны Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн тайланг авахаар Соёлын өвийн үндэсний төвийн захирлын 2019 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн 35/14 дугаартай албан бичиг, судалгааны маягыг орон нутгийн музейд цахим хэлбэрээр, Улаанбаатар хотод оршин байгаа музей, эрдэм шинжилгээний байгууллагуудад цаасан хэлбэрээр хүргүүлж маягыг [www.monheritage.mn](http://www.monheritage.mn) веб дээрээс татаж авахаар давхар байрлуулсан. Албан бичиг явуулсан 49 байгууллага:

#### Улсын чанартай музей

- |                                  |                              |
|----------------------------------|------------------------------|
| 1. Монголын үндэсний музей       | 20. Говьсүмбэр аймгийн музей |
| 2. Байгалийн түүхийн музей       | 21. Дархан-Уул аймгийн музей |
| 3. Богд хааны ордон музей        | 22. Дорноговь аймгийн музей  |
| 4. Дүрслэх урлагийн музей        | 23. Ноён хутагтын музей      |
| 5. Чойжин ламын сүм музей        | 24. Дорнод аймгийн музей     |
| 6. Монголын уран зургийн галерей | 25. Дорнод. Ялалт музей      |
| 7. Монголын театрын музей        | 26. Дундговь аймгийн музей   |
| 8. Төрийн түүхийн музей          | 27. Завхан аймгийн музей     |
| 9. Хархорум музей                | 28. Орхон аймгийн музей      |
| 10. Хөшөө цайдам музей           | 29. Өвөрхангай аймгийн музей |
| 11. Үлэг гүрвэлийн төв музей     | 30. Өмнөговь аймгийн музей   |
| 12. Монгол цэргийн музей         | 31. Сүхбаатар аймгийн музей  |
| 13. Үндэсний номын сан           | 32. Сэлэнгэ аймгийн музей    |
| 14. Улаанбаатар хотын музей      | 33. Төв аймгийн музей        |

#### Орон нутгийн чанартай музей

15. Архангай аймгийн музей
16. Баян-Өлгий аймгийн музей
17. Баянхонгор аймгийн музей
18. Булган аймгийн музей
19. Говь-Алтай аймгийн музей

#### Эрдэм шинжилгээний байгууллага

1. Монгол Улсын Их сургууль
2. Шинжлэх ухааны технологийн их сургууль
3. Улаанбаатарын Их сургууль
4. Ховд Их Сургууль
5. Нүүдлийн Соёл Иргэншлийг судлах олон улсын хүрээлэн
6. ШУА-ын Түүх, археологийн хүрээлэн

#### Шашны болон бусад байгууллага

Түүх, соёлын хөдлөх дурсгалын талаараа ихэвчлэн хувийн өмчлөлийн эд өлгийн зүйлээ улсын бүртгэлд хэрхэн бүртгүүлэх болон бүртгүүлсний ач холбогдол юу байдаг талаар сонирхож байсан бөгөөд 10 орчим хүнд “Монгол улсын түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл” маягтыг тарааж зөвлөгөө заавар өгсөн ба цөөнгүй хүмүүс манай байгууллага дээр ирж уулзахаар болсон.

Түүнчлэн манай байгууллагын үйл ажиллагааг магтан сайшаах хүмүүс байхад соёлын өвийн талаарх ойлголтыг олон нийтэд сурталчлах ажил хангалтгүй байна гэж үздэг хүмүүс ч байсан. Мөн манай байгууллагатай хамтран ажилладаг

судлаачид болон өв уламжлагчид олноороо ирж уулзаж санал бодлоо солилцсон өдөрлөг болж өндөрлөлөө. Гэрэл зураг хавсаргав.

### ХАВСРАЛТ ЗУРАГ



Зураг 1. Байгууллагын үйл ажиллагааг сурталчлах ажлын хэсэг



Зураг 2. Байгууллагаас сүүлийн жилүүдэд хэвлэгдсэн ном хэвлэл



Зураг 3. Иргэдэд соёлын өвийн талаар танилцуулж байна

ТАЙЛАН БИЧСЭН:

Ш.ЭНХТУЯА.СОЁЛЫН ӨВИЙН БҮРТГЭЛ,  
СУДАЛГААНЫ ГАЗАР, ЕРӨНХИЙ  
БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН САНЧ

Ц.ЖАРГАЛСАЙХАН. СОЁЛЫН ӨВИЙН БҮРТГЭЛ,  
СУДАЛГААНЫ ГАЗАР,  
БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН САНЧ

Г.БҮРЭНТӨГС. СОЁЛЫН ӨВИЙН БҮРТГЭЛ, СУДАЛГААНЫ  
ГАЗАР, БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН САНЧ

-----oO-----

## **“МУЗЕЙ БА ХӨГЖИЛ- 2019” ЧУУЛГАНЫ СПОРТЫН ТЭМЦЭЭНИЙ ТАЙЛАН**

2019 оны 09 сарын 17

Улаанбаатар хот

Монгол Улсад орчин цагийн музей байгуулагдсаны 95 жилийн ой тохиож буй түүхэн жил жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Музейн хөгжил-2019” чуулган энэхүү арга хэмжээний нэг салшгүй гар бөмбөгийн тэмцээн энэ жил 8 дахь удаагаа 2019 оны 09 дүгээр сарын 12-13-ны өдрүүдэд “Хүч” спорт хорооны спорт зааланд болж зохион байгуулагчаар Соёлын өвийн үндэсний төв ажиллалаа.

Уг тэмцээнд Соёлын өвийн үндэсний төв-Чойжин ламын музей, Монголын үндэсний музей, Байгалийн түүхийн музей-1, Байгалийн түүхийн музей-2, Богд хааны ордон музей-Дүрслэх урлагийн музей, Баян-Өлгий аймгийн музей, Баянхонгор аймгийн музей, Говьсүмбэр-Дундговь аймгийн музей, Дорнод аймгийн музей, Орхон-Сэлэнгэ аймгийн музей, Өвөрхангай аймгийн музей, Өмнөговь аймгийн музей-Театрын музей, Төв аймгийн музей, Увс аймгийн музей, Хөвсгөл аймгийн музей, Хэнтий аймгийн музей, Дэлхийн өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргаа, Хар хорум музей, Хөшөө цайдам музей, Эрдэнэзуу музей, Монголын уран зургийн галерей, Завхан аймгийн музей гэсэн 22 баг оролцов. Боломжтой байсан ч Улаанбаатар хотоос Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Соёл, урлагийн газар, Монгол төрийн түүхийн музей, Монгол цэргийн музей, Улаанбаатар хотын музей, Төрийн бус байгууллагын төлөөлөл, орон нутгаас Архангай, Булган, Говь-Алтай, Дархан-Уул, Дорноговь, Сүхбаатар, Ховд аймгийн музей тус тус оролцсонгүй.

Тэмцээнийг Монголын волейболын холбооны залуу шүүгч О.Энхжаргал, С.Алтангэрэл нар шүүж явууллаа. Соёлын өвийн үндэсний төвийн Захиргаа, удирдлагын газрын дарга О.Мэндсайхан, бүртгэл мэдээллийн санч Г.Бүрэнтөгс, видео техникч Т.Даваа-Очир, Систем хөгжүүлэлтийн инженер П.Чинбат, архив-бичиг хэргийн ажилтан Б.Лхамсүрэн, нярав С.Сайнзолбоо нар голлон ажиллав. Тэмцээн 6 хэсэгт хуваагдан тоглолт эхэлж 12 баг шалгарч, түүнээс 6 баг 2 хэсэгт хуваагдан тоглож Байгалийн түүхийн музейн баг алтан медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал, Дэлхийн өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргааны баг мөнгөн медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал, Богд хааны ордон музей-Дүрслэх урлагийн музейн баг хүрэл медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал тус тус хүртлээ.

“Шилдэг довтлогч”-оор Байгалийн түүхийн музей-1 багийн тамирчин Н.Нэмэхбаяр, “Тэгш тоглогч”-оор Монголын Үндэсний музей тамирчин Б.Мөнхбат, “Шилдэг холбогч”-оор Богд хааны ордон музейн тамирчин Н.Энхманлай тус тус шалгарч алтан медаль, өргөмжлөл мөнгөн шагналаар шагнууллаа.

Ирэх жилийн чуулган, тэмцээн Сүхбаатар аймагт болохоор товлогдлоо. Нийт багуудын идэвхи сайн, тэмцээний бэлтгэл, хувцаслалт жигд байв. Өвөрхангай аймгийн баг бэлтгэл, тоглолтын чанар сайн, онц сонирхолтой анхаарал татсан багуудын нэг байсан бөгөөд дөрөвдүгээр байранд орсонг онцолж байна. Тоглолт эхний өдөр 09.00 цагт эхэлж 20.00 хүртэл, дараагийн өдөр 09.00 цагт эхэлж 17.15 цагт тоглолт дуусаж шагнал гардуулах ажиллагаа явагдсан. Нэг тоглолтын дундаж

хугацаа 30, хамгийн богино хугацааны тоглолт 13 минут, хамгийн удаан тоглолт 45 минут байлаа.

ТАЙЛАН БИЧСЭН:  
Г.БҮРЭНТӨГС. СОЁЛЫН ӨВИЙН БҮРТГЭЛ,  
СУДАЛГААНЫ ГАЗАР, БҮРТГЭЛ,  
МЭДЭЭЛЛИЙН САНЧ

-----oOo-----

## ХОЁР. “СОЁЛЫН ӨВИЙГ АВРАН ХАМГААЛАХ” СТРАТЕГИЙН ЗОРИЛТЫГ ХАНГАХ АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ

### 2.1. ДӨ-Монгол Алтайн хадны зургийн дурсгалт газрыг нутгийн ард иргэдэд сурталчлах, мэдлэг олгох


#### “ДЭЛХИЙН ӨВ-МОНГОЛ АЛТАЙН ХАДНЫ ЗУРГИЙН ДУРСГАЛТ ГАЗРЫГ НУТГИЙН АРД ИРГЭДЭД СУРТАЛЧЛАХ, МЭДЛЭГ ОЛГОХ” СУРГАЛТЫН ТОВЧ ТАЙЛАН

2019.08.15

Улаанбаатар

Монгол Алтайн нурууны хадны зургийн дурсгалт газар нь соёлын ангиллаар (2011 он) дэлхийн өвд бүртгэгдсэн дурсгалт газар бөгөөд Соёлын өвийг хамгаалах хуулийн 42.3-т Соёлын өвийн дурсгалт газарт үндэсний болон дэлхийн өвийн дурсгалт газар хамаарна хэмээн заасан байдаг.

Соёлын өвийн үндэсний төвөөс Монгол Алтайн нурууны хадны зургийн хадгалалт хамгаалалтыг сурталчилгаагаар дамжуулан сайжруулах. Орон нутгийн иргэдийн соёлын өвийн боловсролыг дээшлүүлэх, олон нийтэд Монгол



Алтайн хадны зургийг хүртээмжтэй байдлаар цахим орчинд сурталчлах үүднээс Баян-Өлгий аймгийн музейтэй хамтран 2017-2018 онд хээрийн судалгаа зохион байгуулан ажилласан болно.

Дээрх хоёр жилийн хээрийн судалгааны явцад Монгол Алтайн нурууны хадны зургийн дурсгалт газрыг гэрэл зургаар баримтжуулах, виртуал тур хийх, Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санг баяжуулах, хадны зурагт сөрөг нөлөө үзүүлж байгаа эрсдэлийг олж тогтоох, зарим сэргээн засварлалтын материалыг турших, тэр орчмын хөшөө дурсгалыг цэвэрлэх, сэргээн засварлах, орон нутгийн холбогдох байгууллагын мэргэжилтнүүдийг дадлагажуулах зэрэг ажлыг шат дараатай хийж гүйцэтгэв.



Соёлын өвийн үндэсний төвөөс 2019 оны 07 дугаар сарын 29-нөөс өдрөөс 08 дугаар сарын 8-ны хооронд өмнөх жилүүдэд Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санг баяжуулсан хэрэглэгдэхүүн болон хийж гүйцэтгэсэн ажлын үр дүнг цахим болон хэвлэмэл байдлаар орон нутгийн иргэдэд сурталчлах ажлыг ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комиссоос Баян-Өлгий аймагт зохион байгуулагдсан “Дэлхийн өвийн хөдөлгөөнт сургалт”-ын үеэр хийж, <http://mongolaltai.mongoluv.mn> цахим хуудас, Монгол, Казах хэлээр гарсан Дэлхийн өв-Монгол Алтайн нурууны хадны зургийн цогцолбор (хадгалалт хамгаалалтын гарын авлага) хэвлэмэл материалыг орон нутгийн удирдлагууд, холбогдох байгууллагууд болох аймгийн музей, Алтайн нурууны

УТХГ-ын хамгаалалтын захиргаанд хүлээлгэн өгөв.

Мөн энэ ажлын маршрутын дагуу Баян-Өлгий, Архангай аймгийн музейд гадаад орчны судалгааг хийлээ. Энэ ажлын дэлгэрэнгүй тайланг бичиж байна.

ТАЙЛАН БИЧСЭН:

Г.АНХСАНАА. СОЁЛЫН ӨВИЙГ АВРАН  
ХАМГААЛАХ ГАЗРЫН ДАРГА

-----oOo-----

## 2.2.Эрсдэл бүхий соёлын өвийг хамгаалах арга хэмжээ

### “АРХЕОЛОГИЙН МАЛТЛАГЫН ҮЕД ОЛДВОРЫГ ХАДГАЛАХ, ХАМГААЛАХ АРГА ЗҮЙ” СУРГАЛТЫН ТОВЧ ТАЙЛАН

2019.04.26

Улаанбаатар хот

Соёлын өвийн үндэсний төвөөс “Археологийн малтлагын үед олдворыг хадгалах, хамгаалах арга зүй” сэдэвт сургалтыг Япон улсын Нара Их сургуулийн Хадгалалт, хамгаалалтын хүрээлэн, Япон улсын Ойта мужийн Түүхийн музей, Хархорум Музейтэй хамтран “Монголын Үндэсний Музейн сургалтын танхимд 2019 оны 04 дүгээр сарын 18-19 ны өдрүүдэд зохин байгууллаа.

Сургалтыг БСШУСЯ-ны Соёл, урлагийн бодлогын газрын дарга С.Сэргэлэн,

мэргэжилтэн Б.Даваацэрэн нар нээж, сургалтын бодит ач холбогдол, цаашдын хамтын үйл ажиллагааг онцлон тэмдэглэв.

Мөн сургалтын үеэр Соёлын өвийн үндэсний төвөөс боловсруулсан “Археологийн малтлагын үед олдворыг хадгалах, хамгаалах арга зүйн зөвлөмж” гарын авлагыг оролцогч байгууллагуудад тараалаа. Тус гарын авлагыг археологийн малтлага,

судалгаа хийдэг мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллага, музей, их дээд сургууль, археологич, судлаачдад зориулан малтлагын үед илэрч олдсон олдвор, эд зүйлийг гэмтэж муудахаас сэргийлэн цаг алдалгүй талбай дээр нь хийж гүйцэтгэвэл зохих арга хэмжээг авах, мэргэжлийн байгууллагын лабораторид шилжүүлэх хүртэлх цаг хугацаанд хэрхэн хадгалах хамгаалах талаар мэдлэг өгөх зорилгоор мэргэжил, арга зүйн зөвлөгөөг олон улсад баримталдаг зарчмууд болон өөрсдийн туршлага зэрэгт тулгуурлан боловсруулж анхан шатны зөвлөмжийг бэлтгэсэн болно.







Сургалтын эхний өдөр Д.Нямдорж, Г.Анхсанаа нар “Археологийн малтлагын үед олдворыг хадгалж, хамгаалах тухай”, М.Оюунтулга, Ямазаки Масахико “Соёлын биет өвд нөлөөлөх хүрээлэн буй орчны судалгаа”, Б.Дэжидмаа “Археологийн малтлага судалгаагаар илэрч буй олдворын анхан шатны хадгалалтын арга зүй”, Юуки Хиэда “Ойта мужийн Түүхийн музейд хадгалагдаж буй олдворуудын дэлгэлт, хадгалалт, хамгаалалт”, С.Даваадарь “Археологийн модон эдлэлийн хадгалалт, хамгаалтад Трехалос сахарын уусмалыг ашиглах нь” зэрэг 5 сэдвээр илтгэл хэлэлцүүлэв.

Сургалтын хоёр дахь өдөр Үдсэний музей дээр С.Даваадарь, М.Оюунтулга, Б.Дэжидмаа нар удирдан, “Хээрийн нөхцөлд илэрч буй археологийн олдворын анхан шатны хадгалалт, хамгаалалт ба сав баглаа боодол” сэдвийн хүрээнд, Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музей дээр М.Оюунтулга, Ямазаки Масахико нар удирдан Музейн хүрээлэн буй орчны судалгаа – Хэмжилт хийх, Юуки Хиэда удирдан Музейн үзмэрийг дэглэх сэдвийн хүрээнд дадлага ажлыг явууллаа.

Энэ удаагийн сургалтад археологийн малтлага, судалгаа явуулдаг мэргэжлийн байгууллагууд болох ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн, МУИС-ийн Антропологи, археологийн тэнхим, Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэн, Улаанбаатарын их сургуулийн Археологийн тэнхим, Монголын үндэсний музей, Дүрслэх урлагийн музей, Хархорум музей зэрэг судалгааны хүрээлэнгүүд, музей, их сургуулийн багш, судлаачид хамрагдав.

ТАЙЛАН БИЧСЭН:

Г.АНХСАНАА. СОЁЛЫН ӨВИЙГ АВРАН

ХАМГААЛАХ ГАЗРЫН ДАРГА

-----oOo-----

## **“СОЁЛЫН ӨВ-ДУРСГАЛТ БАРИЛГЫГ, ГАМШИГ, ЭРСДЭЛЭЭС ХАМГААЛАХ НЬ” ЗӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН**

БСШУСЯ-наас соёлын өвийн хадгалалт, хамгаалалтын цуврал уулзалт, хэлэлцүүлэг, хурлыг зохион байгуулж байгаа билээ. Энэ ажлын хүрээнд Соёлын өвийн үндэсний төвийн захирлын А/49 тоот тушаалаар “Соёлын өв- архитектурын дурсгалыг гамшиг эрсдэлээс хамгаалах нь” зөвлөгөөнийг тус төвийн Соёлын өвийг авран хамгаалах газар, Бүгд Найрамдах Солонгос улсын Соёлын өвийн судалгааны үндэсний хүрээлэнгийн Аюулгүй ажиллагаа, гамшгаас сэргийлэх хэлтсийн мэргэжилтэн, судлаачид хамтран 2019 оны 6 дугаар сарын 20, 21-ний өдрүүдэд амжилттай зохион байгууллаа.

Тус зөвлөгөөний зорилго нь манай улсын соёлын өвд тэр дундаа архитектурын дурсгалд гамшгийн эрсдэл тохиолдсон үед хэрхэн бие даан болон хамтран ажиллах, бэлэн байх, урьдчилсан хамгаалалт, төлөвлөлтийн талаар мэргэжлийн байгууллагуудад мэдлэг өгч, хамтыг ажиллагааг бий болгоход чиглэгдсэн болно.

Зөвлөгөөнд Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, БНСУ-ын Соёлын өвийн судалгааны үндэсний хүрээлэнгийн Аюулгүй ажиллагаа, гамшгаас сэргийлэх хэлтсийн дарга болон мэргэжилтнүүд, Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Онцгой Байдлын Ерөнхий газар, Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн, Монголын Урлагийн Зөвлөл, Богд хааны ордон музей, Чойжин ламын сүм музей, Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музей, Улаанбаатар хотын музей, ШУТИС-ийн Барилга, архитектурын сургууль, Эрдэнэ Зуу музей, Архангай аймгийн музей, Хэнтий аймгийн Цэцэн хааны ордон музей, Төв аймгийн музей, Увс аймгийн музей - Харлаг Бэйс Аюурзаны сүм, Дэлхийн өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргаа, Гэсэр сүм, “Сүлд Проект” ХХК, Нийслэлийн Хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газрын төлөөлөл оролцлоо.

Зөвлөгөөнийг БСШУСЯ-ны Соёл, урлагийн бодлогын газрын дарга С.Сэргэлэн, Соёлын өвийн үндэсний төвийн захирал Г.Энхбат, БНСУ-ын Соёлын өвийн судалгааны үндэсний хүрээлэнгийн Аюулгүй ажиллагаа, гамшгаас сэргийлэх хэлтсийн дарга Ким Дог Мүүн нар нээж, соёлын өв-архитектурын дурсгалыг гамшиг, эрсдэлээс хамгаалахад энэхүү зөвлөгөөн чухал ач холбогдолтойг онцлон тэмдэглэсэн юм.



Нээлтийн ажиллагааны дараа БНСУ-ын Соёлын өвийн судалгааны үндэсний хүрээлэнгийн Аюулгүй ажиллагаа, гамшгаас сэргийлэх хэлтсийн дарга Ким Дог Мүүний хоёр улсын хамтын ажиллагаанд оруулсан хувь нэмрийг үнэлж “Найрамдал” одонгоор, мөн Ким Дог Мүүн болон Кан Хюн нарыг “Архангай аймгийн хүндэт тэмдэг”-ээр тус тус шагнасныг БСШУСЯ-ны Соёл, урлагийн бодлогын газрын дарга С.Сэргэлэн, Монгол Улсын Зөвлөх архитектор З.Оюунбилэг нар гардуулж өгөв.

Тэмдэг гардуулсны дараа нь зөвлөгөөнд оролцогчид гэрэл зураг даруулав.



Зөвлөгөөний хөтөлбөр (Хавсралт 1)-ийн дагуу БСШУСЯ-ын Соёл, урлагийн бодлогын газрын мэргэжилтэн Б.Даваацэрэн “Дурсгалт барилгыг хамгаалахад баримталж буй бодлого, чиг хандлага” сэдвээр илтгэл хэлэлцүүлэв.



Дараагийн илтгэлийг БНСУ-ын Соёлын өвийн судалгааны үндэсний хүрээлэнгийн Аюулгүй ажиллагаа, гамшгаас сэргийлэх хэлтсийн дарга Ким Дог Мүүн “Газар хөдлөлтийн үед архитектурын дурсгалыг хамгаалах үйл ажиллагаа” сэдвээр тавьж, БНСУ-ын туршлагаас хуваалцав.

Зөвлөгөөний 3 дахь илтгэлийг СӨҮТ-ийн Соёлын өвийг авран хамгаалах газрын дарга Г.Анхсанаа “Соёлын өвийг гамшиг, эрсдэлээс хамгаалахад Соёлын өвийн үндэсний төвөөс авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа” сэдвээр тавьж, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцийн тухай болон Монгол Улсын Хууль эрх зүйн орчны тухай, түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг эрсдэлээс хамгаалахад авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа, хөдлөх дурсгалт зүйлийг

эрсдэлээс хамгаалахад авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа, соёлын биет бус өвийг эрсдэлээс хамгаалахад авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг танилцуулав.



Зөвлөгөөний дараагийн илтгэлийг Монгол Улсын Зөвлөх архитектор З.Оюунбилэг (Ph.D) “Монгол Улсын архитектурын дурсгалд нөлөөлж буй эрсдэлүүд” сэдвээр тавьж, архитектурын дурсгалд нөлөөлж байгаа байгалийн болон нийгмийн хүчин зүйлс, гамшиг, аюулт үзэгдэл, эрсдэл, архитектурын дурсгалуудын хамгаалалтын бүс, гамшгийн менежментийн мөчлөгийн талаарх нөхцөл байдлыг зөвлөгөөнд оролцогчдод танилцуулав.

БНСУ-ын Соёлын өвийн судалгааны үндэсний хүрээлэнгийн Аюулгүй ажиллагаа, гамшгаас сэргийлэх хэлтсийн ахлах судлаач Кан Хюн (Ph.D) “Архитектурын дурсгалыг галын эрсдэлийн гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх БНСУ-ын туршлага” сэдвээр илтгэл хэлэлцүүлэв.



Тус илтгэлийн дараа үдээс өмнөх илтгэлүүдтэй холбогдолтой хэлэлцүүлгийг Соёлын өвийн үндэсний төвийн захирал Г.Энхбат (Ph.D) зөвлөгөөнд оролцогчид болон илтгэгчдийн дунд удирдан явуулав.

Хэлэлцүүлгийн үеэр оролцогчдоос дараах санал, асуулт гарав. Тухайлбал, Зөвлөгөөнд оролцсон нийслэлийн хот төлөвлөлт, хөгжлийн газрын хүрээлэнгийн мэргэжилтэн Д.Жүрмэддорж, Улаанбаатар хотод орших дурсгалт барилгуудын талаар нийслэлээс хэрэгжүүлэх үйл ажиллагаанд мэдээлэл солилцох талаар хамтран ажиллах санал гаргав. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Соёлын улсын ахлах байцаагч Б.Отгонбаяр БНСУ-ын соёлын хяналтын талаар тодруулж асуулт асуув.



Үдээс хойших илтгэлийг Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн Уур амьсгалын өөрчлөлт нөөцийн судалгааны хэлтсийн дарга Д. Дуламсүрэн (Ph.D) “Монгол орны уур амьсгалын өөрчлөлт соёлын өв- архитектурын дурсгалд нөлөөлөх нь” сэдвээр хэлэлцүүлэв. Уур амьсгалын хувиралт болоод хүний хүчин зүйлсийн хам нөлөөгөөр сүүлийн 40 жилийн дотор Монгол орны экосистемд мэдэгдэхүйц өөрчлөлтөд орж, энэ нь цөлжилт, байгалийн гамшигт үзэгдлийн хөнөөл идэвхжих, усны нөөц, биологийн элдэв янз байдал хомсдох зэргээр илэрч эцсийн дүндээ улс орны эдийн засаг, ард түмний амьдралын түвшин, байгаль орчин, соёлын өвд сөргөөр нөлөөлөх хэмжээнд хүрчээд байна.

Иймд соёлын өвд нөлөөлөх уур амьсгалын өөрчлөлтийн дарамтыг нарийвчлан судалж, энэхүү өөрчлөлтөд дасан зохицох бодлогыг эртнээс боловсруулж, хэрэгжүүлэх нь улс орны хөгжлийн хэтийн төлөвт тулгараад байгаа томоохон асуудлын нэг болоод байна. Жилийн дундаж температур 2.2°C-аар нэмэгдсэн (өвөл 2.6°C, зун 1.4°C). Жилийн нийлбэр хур тунадас 7.3%-иар буурсан (өвөл +24%, зун -7%). Эрчимтэй хур тунадасны эзлэх хувь ихсэж байна. Монгол орны төвийн бүсэд эрчимтэй өөрчлөлт илэрч байна. Байгалийн дурсгалт газар болон соёлын өвийн барилга байгууламжид агаарын температур шууд нөлөө

үзүүлээд байдаггүй. Харин түүний сар жилийн агуураг, хэлбэлзэл нь барилгын материал болох мод, чулуу, тоосго, бетоны ашиглалтын горимд зохисгүй нөлөөлж хагаралт, цууралт үүсгэдэг. Жилд дунджаар 49 удаа тохиолддог байна. Сүүлийн 20 жилийг 2 арван жилд хувааж үзэхэд эхний 10 жилийн дунджаар нэг жилд 30 орчим аюултай үзэгдэл ажиглагддаг байсан бол сүүлийн 10 жилд энэ тоо даруй 2 дахин нэмэгджээ.

1966-2016 оны хооронд өдрийн чийгийн дарамт 22 өдрөөр, хоногийн чийгийн дарамт 5 өдрөөр тус нэмэгдсэн байна. Халуун өдөр, ялангуяа түүний дараалсан хоногийн тоо нэмэгдэж байна. Хур тунадасны хэмжээ багахан буурч байгаа хэдий ч өвлийн цасны хэмжээ нэмэгдэх, зуны борооны эрчим нэмэгдэх хандлагатай. Хуурайшил эрчимжих, ган зуд болон агаар мандлын гаралтай гамшигт үзэгдлийн давтагдал нэмэгдэх хандлагатай. Хүлэмжийн хийн өсөлтөөс үүдэлтэй даян дэлхийн уур амьсгалын дулааралт цаашид улам эрчимжиж, соёлын өвийн барилга байгууламжид үзүүлэх дарамт жилээс жилд улам нэмэгдэх төлөвтэй байгаа тул эртнээс хамгаалах, дасан зохицох бодлогыг боловсруулах шаардлага тулгараад байна.



Тус илтгэлийн дараа Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгаас урьдчилан сэргийлэх газрын мэргэжилтэн, ахмад Г.Энхцолмон “Гамшгийн тухай ойлголт, урьдчилан сэргийлэх арга хэмжээ” сэдвээр илтгэл хэлэлцүүлэв. Олон улсын хэмжээнд хүн амыг олноор сүйтгэж, тухайн орны эдийн засагт ихээхэн хохирол учруулж болзошгүйд тооцогддог 40 гаруй гамшгаас манай оронд 15 орчим төрлийн аюулт үзэгдэл, осол тохиолдож байна. Үүнд:

- Газар хөдлөлт
- Үер
- Хүчтэй салхи, шуурга
- Аянга
- Ган
- Зуд
- Хүн, мал амьтны гоц халдварт өвчин
- Тэсэрч дэлбэрэх бодис, сум, галт хэрэгсэл
- Цацраг, химийн осол
- Усны осол
- Үйлдвэрлэлийн осол

Гамшгаас хамгаалах менежмент нь гамшгийн өмнө, гамшгийн үед, гамшгийн дараа гэсэн үе шатаар тасралтгүй үргэлжлэх, нэгээс нөгөөд шилжих багц үйл ажиллагаа бөгөөд гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох үе шатуудад хэрэгжих арга хэмжээний цогц юм. Энэ нь дараах бүдүүвчээр илэрхийлэгдэнэ.

- Галын аюулгүй байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга /2015.07.2/
- Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулга /2017.02.02/
- Улсын нөөцийн тухай хууль /2007.07.05/
- Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс /УИХ-ын 2015 оны 85-р тогтоол/
- Монгол Улсын Батлан хамгаалахын багц хуулиуд /2016.09.01/
- Төрийн цэргийн байгууллын хөгжлийн стратеги-2030
- “Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд авч хэрэгжүүлэх Сендайн үйл ажиллагааны хүрээ” баримт бичгийг Монгол Улсад хэрэгжүүлэх төлөвлөгөө
- Гамшгаас хамгаалах тухай хуулийг дагаж гарах дүрэм, журам, заавар

Гамшгийн эрсдэлийг бууруулах мэдлэг, чадварыг олон нийтэд олгох “Үндэсний болон орон нутгийн сургагч багш”-аар 21 аймгийн 330 сумын 4497 иргэн, нийслэлийн 9 дүүргийн 48 хороод болон 21 томоохон аж ахуйн нэгж, байгууллагын 1014 иргэн, Нийт 5511 иргэнийг бэлтгэсэн байна.



Дараагийн илтгэлийг Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын өвийн хөтөлбөр хөтөлбөрийн зохицуулагч М.Биндэрьяа “Монголын Урлагийн Зөвлөлөөс хэрэгжүүлж буй архитектурын дурсгалын эрсдэлийн судалгаа” сэдвээр хэлэлцүүлэв. Сүүлийн жилүүдэд Монголын Урлагийн Зөвлөлөөс Амарбаясгалант хийд /2009 – 2013 он/, Чойжин ламын сүм музей, Богд хааны ордон музейд байгалийн болон нийгмийн нөлөөллийн судалгааг хийж байна. Үүнд:

Чойжин ламын сүм музейн байгалийн болон нийгмийн нөлөөллийн судалгаа /2016-2018 он/

Байгалийн:

- Агаарын чанарын судалгаа
- Цаг уур, орчны судалгаа

- Ургамалжилтын судалгаа
- Геофизик, инженер геологийн судалгаа
- Геодезийн хэмжилт, байрзүйн зураг
- Гамшгийн эрсдэлийн үнэлгээ

Нийгмийн:

- Барилгын гэмтлийн судалгаа, сэргээн засварлалтын түүх
- Нийгмийн нөлөөллийн судалгаа
- Хууль, эрх зүйн орчны судалгаа

Богд хааны ордон музейн байгалийн болон нийгмийн нөлөөллийн судалгаа /2019 он/

- Сэргээн засварлалтын түүх ба Барилгын гэмтлийн судалгаа,
- Гамшгийн эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ
- Нийгмийн орчны нөлөөллийн социологи судалгаа
- Геодезийн хэмжилт, байр зүйн зураглал
- Ургамалжилтын судалгаа
- Геологи, инженер геологи, геофизикийн судалгаа
- Агаарын чанарын судалгаа



Зөвлөгөөний сүүлчийн илтгэлийг БНСУ-ын Соёлын өвийн судалгааны үндэсний хүрээлэнгийн Аюулгүй ажиллагаа, гамшгаас сэргийлэх хэлтсийн соёлын өвийн сэргээн засварлалтын инженер, судлаач Пак Чан Мин “БНСУ-ын соёлын өвийн аюулгүй ажиллагаа, гамшгийн менежментийн тогтолцоо, технологи” сэдвээр хэлэлцүүлэв.





Тус илтгэлийн дараа үдээс хойш хэлэлцэгдсэн илтгэлүүдтэй холбогдолтой хэлэлцүүлгийг СӨҮТ-ийн захирал Г.Энхбат (Ph.D) удирдан явуулав.



Зөвлөгөөний үеэр соёлын өв, архитектурын дурсгалын өнөөгийн байдал, хууль эрхзүйн орчин, гамшгийн эрсдэлээс хамгаалах хэрэгцээ шаардлага, тогтолцоо, үйл ажиллагааны талаарх мэдээллийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд түгээв.





Зөвлөгөөн зохион байгуулагчдын зүгээс дараах санал, зөвлөмжийг гаргав.

Үүнд:

1. БСШУСЯ болон Онцгой байдлын ерөнхий газар соёлын өв, архитектурын дурсгалыг гамшиг, эрсдэлээс хамгаалах хүрээнд нягт хамтарч ажиллахад харьяа байгууллагуудаас идэвхи санаачлага гаргаж, олон талт үйл ажиллагааг зохион байгуулахад анхаарах,
2. Энэхүү зөвлөгөөний дараа сүм хийд, архитектурын дурсгалт барилгад үйл ажиллагаа явуулж буй музей болон бусад байгууллагуудын удирдлагууд харьяа Онцгой байдлын газар, хэлтэстэйгээ хамтран гамшиг, эрсдэлээс хамгаалах чиглэлээр нягт хамтарч ажиллах,
3. Сүм хийд, архитектурын дурсгалт барилгад үйл ажиллагаа явуулж буй музей болон бусад байгууллагууд харьяа Онцгой байдлын газар, хэлтэстэйгээ хамтран гамшиг, эрсдэлээс хамгаалах нөхцөл байдлын үнэлгээг цаг алдалгүй хийх.
4. Сүм хийд, архитектурын дурсгалт барилгад үйл ажиллагаа явуулж буй музей болон бусад байгууллагууд харьяа Онцгой байдлын газар, хэлтэстэйгээ хамтран гамшиг, эрсдэлээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө боловсруулж, дагаж мөрдөх.

Зөвлөгөөний хоёр дахь өдөр Соёлын өвийн үндэсний төв, БНСУ-ын Соёлын өвийн судалгааны үндэсний хүрээлэн, Төв аймгийн музей хамтран Төв аймгийн Зуунмод хотын орчимд орших Манзушир хийдийн туурийг хадгалж, хамгаалах талаар менежментийн төлөвлөгөөний зөвлөлдөх уулзалт хийж, цаашид хамтран ажиллах боломжыг судлахаар боллоо.





Манзуширийн хийдийн орто зураг

## ДҮГНЭЛТ

Зөвлөгөөний үеэр дурсгалт соёлын өв-архитектурын дурсгалыг хадгалж, хамгаалах, түүнийг гамшиг, эрсдэлээс хамгаалах чиглэлээр төрөөс баримталж буй бодлого, авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа, Монгол орны байгаль, цаг уурын өөрчлөлтөөс үүдэлтэй архитектурын дурсгалд үүсэж байгаа, үүсэж болохуйц гамшиг эрсдэлийн судалгааг танилцуулж, илтгэсэн нь зөвлөгөөнд оролцогчдод энэ талын цэгцтэй мэдлэг, ойлголтыг өгөхөөс гадна архитектурын дурсгал хариуцсан мэргэжилтэн, байгууллагууд цаашдын үйл ажиллагаандаа дээрх судалгааны үр дүн болон туршлагыг тусгах, мөрдөх боломжийг бүрдүүлэв.

Зөвлөгөөний үеэр Солонгосын Соёлын өвийн үндэсний судалгааны хүрээлэнгийн Аюулгүй ажиллагаа, гамшгаас сэргийлэх хэлтсийн мэргэжилтэн, судлаачид өөрийн орны туршлага, хадгалалт, хамгаалалтын арга зүйг танилцуулсан нь соёлын өв, архитектурын дурсгалыг хадгалж, хамгаалахад тэдгээрийн ололт амжилттай тал болон тулгамдаж буй асуудлуудыг манай орны архитектурын дурсгалыг хадгалж хамгаалж байгаа, судалгааны ажил хийж байгаа хүмүүст бодит туршлага боллоо.

Мөн нэг чиглэлийн шат шатны мэргэжилтэн, судлаачид хамтран оролцож, цугларсан нь цаашдын хамтын үйл ажиллагаанд эергээр нөлөөлөх боломжийг бүрдүүлэв. Түүнчлэн, Зөвлөгөөнд хэлэлцүүлсэн нийт илтгэлүүдийг энэ оны III улиралд багтаан олон нийтэд зориулан монгол, англи, солонгос хэл дээр эмхэтгэл

болгон хэвлүүлэх талаар оролцогчдоос санал гаргасныг зохион байгуулагчид дэмжиж шийдвэрлэхээр боллоо.

Зөвлөлгөөнд оролцогчдын нэрс

Д/д	Овог нэр	Албан тушаал	Холбогдох утас, цахим хаяг
<b>Зохион байгуулагчид Соёлын өвийн үндэсний төв</b>			
1	Г.Энхбат (Ph.D)	СӨҮТ-ийн захирал	
2	Г.Анхсанаа	СӨҮТ-ийн Соёлын өвийг авран хамгаалах газрын дарга	
3	М.Цэцэнбилэг	СӨҮТ-ийн Соёлын өвийн бүртгэл, судалгааны газрын дарга	
4	Ц.Цолмон	СӨҮТ-ийн Соёлын өвийг авран хамгаалах газрын Дэлхийн өвийн дурсгал хариуцсан мэргэжилтэн	
5	Г.Бүрэнтөгс	СӨҮТ-ийн Соёлын өвийн бүртгэл, судалгааны газрын бүртгэл мэдээллийн санч	
6	С.Баасандорж	СӨҮТ-ийн Соёлын өвийг авран хамгаалах Газрын газарзүйн мэдээлэл хариуцсан инженер	
<b>БСШУСЯ-ны төлөөлөл</b>			
6	Б.Сэргэлэн	БСШУСЯ-ны Соёл, Урлагийн Бодлогын газрын дарга	
8	Б.Даваацэрэн	БСШУСЯ-ны Соёл, Урлагийн Бодлогын газрын ахлах мэргэжилтэн	
<b>БНСУ-ын Соёлын өвийн судалгааны үндэсний хүрээлэн</b>			
9	Ким Дог Мүүн (Ph.D)	БНСУ-ын Соёлын өвийн судалгааны үндэсний хүрээлэнгийн Аюулгүй ажиллагаа, гамшгаас сэргийлэх дарга	
10	Кан Хюн (Ph.D)	БНСУ-ын Соёлын өвийн судалгааны үндэсний хүрээлэнгийн Аюулгүй ажиллагаа, гамшгаас сэргийлэх хэлтсийн ахлах судлаач	
11	Пак Чан Мин	БНСУ-ын Соёлын өвийн судалгааны үндэсний хүрээлэнгийн Аюулгүй ажиллагаа, гамшгаас сэргийлэх хэлтсийн соёлын өвийн сэргээн засварлалтын инженер, судлаач	
<b>Зочин илтгэгчид</b>			
12	Д.Дуламсүрэн (Ph.D)	Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн Уур	

		амьсгалын өөрчлөлт нөөцийн судалгааны хэлтсийн дарга,	
13	З.Оюунбилэг (Ph.D)	Монгол Улсын Зөвлөх архитектор	
14	Г.Энхцолмон	Онцгой байдлын ерөнхий газрын Гамшигаас урьдчилан сэргийлэх газрын мэргэжилтэн, ахмад	
15	М.Биндэрьяа	Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын өвийн хөтөлбөрийн зохицуулагч	
<b>Оролцогчид</b>			
<b>Богд хааны ордон музей</b>			
16	Ц.Эрдэнэбаатар	Богд хааны ордон узеин захирал	
17	Э.Мөнхсоёл	Менежер	
18	Ж.Болортуяа	Бүртгэл мэдээллийн санч	
<b>Дүрслэх урлагийн музей</b>			
19	У.Сарантуяа	Захирал	Утас. 99054055. email: <a href="mailto:Saraurta5@gmail.com">Saraurta5@gmail.com</a>
20	А.Дуламжав	Дэд захирал	Утас-99202345. email: <a href="mailto:duka.amarsaihan@gmail.com">duka.amarsaihan@gmail.com</a>
21	Т.Энхжаргал	Бүртгэл мэдээллийн санч	Утас- 96638189. email: <a href="mailto:enjaart@gmail.com">enjaart@gmail.com</a>
<b>Чойжин ламын сүм музей</b>			
22	Д.Отгонсүрэн	Чойжин ламын сүм музейн захирал	
23	Э.Ганбат	Бүртгэл мэдээллийн санч	
24	Б.Өлзийдэлгэр	Аюулгүй байдлын инженер	
<b>Улаанбаатар хотын музей</b>			
25	С.Цацралт	Захирал	99118445
26	Ч.Өсөхжаргал	Бүртгэл мэдээллийн санч	89785189
27	П.Ариунаа	Сан хөмрөгч	95729499
<b>Эрдэнэзуу музей</b>			
28	1. Н.Төмөрбаатар	Эрдэнэ Зуу музейн захирал	91995191
29	Д.Наранцацрал	Эрдэнэ Зуу музейн сан хөмрөгч	99169796
30	С.Рэгзэдпил	Эрдэнэ Зуу музейн Эрдэм шинжилгээний ажилтан	99901873
<b>Архангай аймгийн музей</b>			
31	Т.Мөнхбүрэн	Архангай аймгийн музейн захирал	99339269
32	Б.Баатархүү	Сан хөмрөгч	99213581
33	Э.Баярмаа	Бүртгэл мэдээллийн санч	99973776
<b>Хэнтий аймгийн музей</b>			

34	Нанзад Нямсүрэн	Хэнтий аймгийн музейн захирал	92118486 Khentiimuseum@g mail.com
35	Бэх-Очир Өнөрбаяр	Бүртгэл мэдээллийн санч	99131367 Khentiimuseum@g mail.com
36	Сандаг Өнөрбат	Музейн харуул хамгаалалтын ажилтан	95614165 Khentiimuseum@g mail.com
<b>Төв аймгийн музей</b>			
37	Б.Сүхбаатар	Төв аймгийн музейн захирал	91991791
38	С.Сувдаа	Арга зүйч /Музейн гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн ахлагч/	95002578 <a href="mailto:enkhjin0721@yahoo.com">enkhjin0721@yaho o.com</a>
39	Г.Дагмидмаа	Бүртгэл мэдээллийн санч	89692129 <a href="mailto:dmaa24@yahoo.com">dmaa24@yahoo.c om</a>
<b>Дэлхийн өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргаа</b>			
40	Л.Отгонбаяр	Дэлхийн өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргааны дарга	91919791 <a href="mailto:Otgonbayar_78@yahoo.com">Otgonbayar_78@y ahoo.com</a>
41	Ч.Догсом	Менежер	99012847 <a href="mailto:Dogsom2829@gmail.com">Dogsom2829@gm ail.com</a>
<b>ШУТИС-ийн Барилга, архитектурын сургууль</b>			
42	Д.Жүрмэддорж	Нийслэлийн Хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газар	99104333
43	Гэсэр сүм	Б. Баасанжав	
44	Н.Батжин,	“Сүлд проект” ХХК	
45	Н.Энхжин	“Сүлд проект” ХХК	

ТАЙЛАН БИЧСЭН:

Ц.ЦОЛМОН. СОЁЛЫН ӨВИЙГ АВРАН

ХАМГААЛАХ ГАЗРЫН ДЭЛХИЙН ӨВИЙН  
ДУРСГАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

ТАНИЛЦСАН:

Г.АНХСАНАА. СОЁЛЫН ӨВИЙГ АВРАН

ХАМГААЛАХ ГАЗРЫН ДАРГА

-----o0o-----

## **“ЁОХОР ХАТАР 2019” СЭДЭВТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛСАН ТУХАЙ ТАЙЛАН**

Соёлын өвийн үндэсний төвийн захирлын 2019 оны 07 дугаар сарын 6-ны өдрийн А/61 тоот тушаал, Соёлын өвийн үндэсний төв, Соёл, Урлагийн Их Сургуулийн Соёл, Урлаг Судлалын Хүрээлэн хооронд 2018 оны 02 дугаар сарын 08-ний өдөр байгуулсан “Хамтын ажиллагааны санамж бичиг”-ийн “2018-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”- ний 6 дугаарт заасан “Ёохор бүжгийн олон улсын наадам, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах” ажлын хүрээнд тус төвийн Соёлын өвийг авран хамгаалах газрын дарга, мэргэжилтэн Соёл, урлаг судлалын хүрээлэн, Хэнтий аймгийн Батширээт сумын Засаг Даргын Тамгын Газар, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Монголын Буриадын төв холбоо, “Батширээт хөгжлийн сан” ТББ болон Батширээт сумын Соёлын төвтэй хамтран “Ёохор хатар - 2019” эрдэм шинжилгээний бага хурал, судалгааны ажлыг Хэнтий аймгийн Батширээт суманд 2019 оны 07 дугаар сарын 16-аас 19-ний өдрүүдэд хамтран зохион байгууллаа.



Энэхүү эрдэм шинжилгээний хурал, судалгааны ажлын зорилго нь Буриад зоны дуут бүжиг Ёохор-оор дамжуулан залуу хойч үед Соёлын биет бус өвийн мэдлэг, ойлголтыг өгөх байв.

Хурал зохион байгуулах багт тус төвийн Соёлын өвийг авран хамгаалах газрын дарга Г.Анхсанаа, тус газрын дэлхийн өвийн дурсгал хариуцсан мэргэжилтэн Ц.Цолмон, жолооч Д.Чанагнянгар нар ажиллав. Хурлыг доорхи хөтөлбөрийн дагуу зохион явуулав.

Хурлын хөтөлбөр

2019 оны 7 дугаар сарын 16, Мягмар гариг

Цаг	Үйл ажиллагаа	Оролцогчид
-----	---------------	------------

08:00	Хэнтий аймгийн Батширээт сум руу хөдлөх	Соёлын өвийн үндэсний төв, Улсын Дуурь Бүжгийн Эрдмийн Театр, СУИС-ийн Соёл Урлаг Судлалын Хүрээлэн, Буриад судлалын академи, Монголын Буриадын Төв Холбоо
Жич: 15:00 цагт Биндэрийн овоон дээр СӨҮТ, УДБЭТ, СУСХ, Буриад судлалын академийн төлөөлөл Хэнтий аймгийн Батширээт сумын ИТХ, “Ёохор” наадмыг зохион байгуулагчдын төлөөлөлтэй уулзна. Рашаан хадны дурсгалт газартай танилцана.		
18:00	СӨҮТ, УДБЭТ, СУСХ, Монголын Буриадын Төв Холбоо, Буриад судлалын академийн төлөөлөл Батширээт сумын төвд буудаллах.	

2019 оны 7 дугаар сарын 17, Лхагва гариг

Цаг	Үйл ажиллагаа	Илтгэгч
10:00-10:30	Нээлтийн ажиллагаа: Эрдэм шинжилгээний хурлын нээлтийн үгийг: - Г.Энхбат /Ph.D, СӨҮТ-ийн захирал/ - Хэнтий аймгийн Батширээт сумын ИТХ-ийн дарга Д.Гансүрэн - Ш.Эрдэнэцэцэг / Ph.D, СУИС-ийн Соёл, урлаг судлалын хүрээлэнгийн захирал/ - М.Одмандах / Ph.D, Буриад Судлалын Академийн ерөнхийлөгч/ Оролцогчид дурсгалын зураг татуулах (5 минут)	
10:30-10:50	Илтгэлийн нэр: “Хамаг Монголын шүтээн нутаг”	О.Сүхбаатар (Профессор)
10:50-11:10	Илтгэлийн нэр: “Буриад хатарын төрөл зүйл”	Ш.Эрдэнэцэцэг (Ph.D, СУИС-ийн Соёл, урлаг судлалын хүрээлэнгийн захирал)
11:10 -11:30	Илтгэлийн нэр: “Буриад үндэсний хувцас, бэлгэдэл зүйн онцлог”	Л.Оюунцэцэг (Ph.D, Буриад судлалын академийн эрдэмтэн нарийн бичгийн дарга/
11:30-11:50	Илтгэлийн нэр: “Ёохор наадам зохион байгуулах шалтгаан, зохион байгуулж ирсэн товч түүхээс”	Д.Гансүрэн /Хэнтий аймгийн Батширээт сумын ИТХ-ын дарга/
11:50-12:10	Илтгэлийн нэр: “Буриадын Ёохор хатарын үүслийн тухайд”	Ч.Жавзмаа (Буриад судлаач)
12:10-12:30	Илтгэлийн нэр: “Ёохор хатарын уламжлалт хэлбэрийг хамгаалах асуудалд”	Ц.Цолмон /СӨҮТ-ийн Дэлхийн өвийн дурсгал хариуцсан мэргэжилтэн/
12:50-13:30	Хэлэлцүүлэг	Г.Энхбат, Д.Гансүрэн, О.Сүхбаатар Ш.Эрдэнэцэцэг Л.Оюунцэцэг Ц.Цолмон болон хуралд оролцогчид
13:30-14:30	Үдийн хоол	



ЁОХОР ХАТАР НААДААН (тусгай хөтөлбөрөөр)

2019 оны 7 дугаар сарын 18, Пүрэв гариг

Цаг	Үйл ажиллагаа	Оролцогчид
10:00	ЁОХОР ХАТАР НААДААН	

2019 оны 7 дугаар сарын 19, Баасан гариг

Цаг	Үйл ажиллагаа	Оролцогчид
09:00 -11:00	Батширээт сумын наадмын нээлт үзэх	Соёлын өвийн үндэсний төв, Улсын Дуурь Бүжгийн Эрдмийн Театр, СУИС-ийн Соёл Урлаг
11:00	Улаанбаатар хот руу хөдлөх	Судлалын Хүрээлэн, Буриад судлалын академи, Монголын Буриадын Төв Холбоо

2019 оны 07 дугаар сарын 16-ны өдөр, хурлын хөтөлбөрийн дагуу Улаанбаатар хотоос хүрэлцэн очсон төлөөлөгчдийг Хэнтий аймгийн ЗДТГ болон Ёохор наадам зохион байгуулах комисс Биндэр овоон дээр хүлээн авч, хүндэтгэл үзүүлэн, дурсгалын зураг татуулав.





“Ёохор хатар -2019” эрдэм шинжилгээний бага хурал 2019 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 10:00 цагт Батширээт сумын Соёлын төвд эхлэв. Хурлыг нээж Батширээт сумын засаг дарга Л.Болд, ИТХ-ын тэргүүлэгчдийн дарга Д.Гансүрэн, Монголын Буриадын Буриадын төв холбооны дарга М.Одмандах нар үг хэлэв. Хурлыг Соёлын өвийн үндэсний төвийн захирал Г.Энхбат удирдав.



Хуралд Батширээт сумын иргэдээс гадна Ёохор наадамд хүрэлцэн ирсэн ОХУ-ын Буриад улсын Могойтын райоин болон Агын тойргийн Буриад зон оролцов. Хурлын эхний илтгэлийг Батширээт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Д.Гансүрэн “Ёохор наадам зохион байгуулах шалтгаан, зохион байгуулж ирсэн товч түүхээс” сэдвээр тавьсан юм.



Тус эрдэм шинжилгээний хурлын хоёр дахь илтгэлийг СУИС-ийн Соёл, урлаг судлалын хүрээлэнгийн захирал Ш.Эрдэнэцэцэг Ph.D, “Буриад хатарын төрөл зүйл” сэдвээр оролцогчидод тавьсан юм /илтгэлийг хавсаргав/.



Хурлын дараагийн илтгэлийг Буриад судлалын академийн эрдэмтэн нарийн бичгийн дарга Л.Оюунцэцэг Ph.D “Буриад үндэсний хувцас, бэлгэдэл зүйн онцлог” сэдвээр тавив.




Хурлын 4 дэх илтгэлийг Буриад судлаач Ч.Жавзмаа “Буриадын Ёохор хатарын үүслийн тухайд” сэдвээр илтгэж, Ёохор нэрийн үүсэл, гарлын тухай судлаачдын судалгаа, таамаглалыг танилцуулав.



Хурлын сүүлийн илтгэлийг Соёлын өвийн үндэсний төвийн Соёлын өвийг авран хамгаалах газрын дэлхий өвийн дурсгал хариуцсан мэргэжилтэн Ц.Цолмон “Ёохор хатарын уламжлалт хэлбэрийг хамгаалах асуудалд” сэдвээр тавив.

Эрдэм шинжилгээний хурлын төгсгөлд хуралд суусан Буриад зоны төлөөлөл энэхүү Ёохор наадам, ялангуяа эрдэм шинжилгээний хурал нь Буриадын өв соёлыг цогцоор сэргээх, залуу хойч үед өвлүүлэн үлдээх, түгээн дэлгэрүүлэхэд чухал хувь нэмэр оруулж буйг онцлон хэлж байв. Мөн цаашид энэхүү хурлыг Ёохор наадмын дэргэд уламжлал болгон зохион байгуулж байхыг эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулагчдаас хүссэн юм.

Буриад Төв Холбоо болон Батширээт сумын Соёлын төв хамтран хурлын үеэр хэлэлцэгдсэн илтгэлүүдийг эмхэтгэл болгон хэвлүүлэн гаргав.



ТАЙЛАН БИЧСЭН:

Ц.ЦОЛМОН. СОЁЛЫН ӨВИЙГ АВРАН  
ХАМГААЛАХ ГАЗРЫН ДЭЛХИЙН ӨВИЙН  
ДУРСГАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

ТАНИЛЦСАН:

Г.АНХСАНАА. СОЁЛЫН ӨВИЙГ АВРАН  
ХАМГААЛАХ ГАЗРЫН ДАРГА

-----oOo-----

### **СЭЛЭНГЭ АЙМГИЙН БАРУУНБҮРЭН СУМЫН НУТАГТ ОРШИХ АМАРБАЯСГАЛАНТ ХИЙДИЙН ОРЧИМД ХИЙСЭН ТАНДАЛТ СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

Удиртгал

Хан-Уул дүүргийн 3-р хорооны иргэн Б.Даваадоржоос ирүүлсэн хүсэлтийн дагуу Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайдын 2019 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн А/43 дугаар тушаалаар Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын нутагт орших Амарбаясгалант хийдийн орчимд тандалт, судалгаа хийх ажлын хэсгийг байгуулсан болно. Дээрх ажлын хэсэг 2019 оны 2, 3 дугаар сард хуралдаж мэдээлэл ирүүлсэн Б.Даваадоржоос тодруулга хийсэн.

Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын А/43 дугаар тушаалын дагуу Соёлын өвийн үндэсний төвийн 2019 оны 5-р сарын 7-ны өдрийн А/27 тоот тушаалаар энэ сарын 10-наас 13-ны хооронд Амарбаясгалант хийдийн орчимд Г.Анхсанаа (СӨҮТ-ийн Соёлын өвийг авран хамгаалах газрын дарга), Б.Отгонбаяр (Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Соёл, урлагийн хяналтын улсын ахлах байцаагч), А.Энхтөр (ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, Доктор), Б.Амгаланбат (СӨҮТ-ийн Соёлын өвийн бүртгэл судалгааны газрын бүртгэл мэдээллийн санч) нарын бүрэлдэхүүнтэй тандалт судалгааг хийж гүйцэтгэлээ. Мөн Сэлэнгэ аймгийн мэргэжлийн хяналтын газрын боловсрол, соёлын хяналтын улсын байцаагч Ц.Цогт-Эрдэнэ, Баруунбүрэн сумын цагдаа, ахлагч Э.Энхтөр нар оролцов.

Ажлын хэсэг нь тус хийдийн орчимд тандалт судалгаа хийж, шаардлагатай тохиолдолд авран хамгаалах судалгааг зохион байгуулж, дурсгалыг малтан судалж, илэрсэн олдвор, эд өлгийн зүйлсийг цаг алдалгүй баримтжуулан авах, зохих газарт зөөж тээвэрлэх ажлыг зохион байгуулах удирдамжтай ажилласан бөгөөд Монгол улсын “Соёлын өвийг хамгаалах” тухай хууль болон холбогдох журмын дагуу тухайн газарт археологийн шинжлэх ухааны малтлагын арга зүйг баримтлан ажилласан ба ажлын явцыг, гэрэл зураг, гар зургаар баримтжуулав.

Бид 2019 оны 5 дугаар сарын 10-нд Улаанбаатараас гарч Амарбаясгалант хийдэд очиж, хийдийн хамба лам Эрдэнэчулуунтай уулзан, үдээс хойш ажлаа эхлүүлэв. Хамба лам энэ тухай “тийм яриа байдаг аа, манай хийдийн ойр орчимд янз бүрийн багаж бариад хүмүүс явж байсан тохиолдол ч гарч байсан” гэлээ.

Дурсгал байгаа гэсэн газар нь хийдийн зүүн өмнө талд, хэрмэн хашаан дотор, өгөрсөн мод болон монос мод ургасан булан (зураг 1) орчимд гэж хамба лам Эрдэнэчулуун, Б.Даваадорж нар зааж өгөв (зураг 2).

Энэ орчимд хагд өвс, навчаар битүү бүрхэгдсэн байдалтай (зураг 3) металл хайгч (x-terra 705) ажиллуулж үзэхэд маш олон газар тод дохио өгсөн бөгөөд дохио өгсөн орчимд шалгахад янз бүрийн цөгц, лааз, хадаас, төмөр утас зэрэг олон төрлийн металл зүйлс (зураг 4), хэрмэн хашааны дээвэр болох нүүр ваар, нөмрөг ваар, бүтэн болон хагархай тоосго зэрэг барилгын хэрэглэгдэхүүн (зураг 5) их хэмжээгээр гарч байна. Тиймээс энэ орчимд 4x4 м талбайг (зураг 6) 10-15 см гүнтэй, хэрмэн хашааны хормойн түвшин хүртэл цэвэрлэлээ (зураг 7).


Цэвэрлэсэн талбайд дахин металл хайгч ажиллуулж үзэхэд өмнө талын хэрмэн хашаа, өгөрсөн модны баруун талд 2 газар дохио өгч байв. Дохио өгч байгаа хэсгүүдийг оруулан 3x3 м хэмжээтэй талбайд 20 см гүнтэй үргэлжлүүлэн малтлага хийв (зураг 8). Энэ түвшинд чийглэг хар шороотой, навч шилмүүс холилдсон сэвсгэр хөрсөнтэй байв Мөн модны үндэс цухуй эхэлсэн бөгөөд үндэсний доогуур мэргэчийн нүх байв.

Энэ түвшинд дахин металл хайгчаар шалгахад өмнө дохио өгч байсан хэсэгт өмнөхийн адил дохио өгч байв (зураг 9). Өмнөх талбайг тал талаасаа 0.5 м хэмжээтэй хумин доош дахин 25 см гүн малтахад цагаан саарал, бор шаргал холилдсон хөрс илэрч эхэлсэн бөгөөд энэ төвшнөөс газар гэсээгүй, хөлдүү байна. Модны үндсийг тасалж авлаа. Металл хайгчаар шалгахад өмнө дохио өгч байсан 2 хэсэгт дохио өгч байв. Тиймээс өгөрсөн модны баруун талд дохио өгч байгаа хэсэгт 1 x 0.5 м хэмжээтэй, 40 см гүн доош малтахад тэс хөлдүү цагаан саарал эх хөрс

(зураг 11) гарснаар 90-110 см гүнээс шууд малтах боломжгүй болсноор малтлагыг зогсоов (зураг 10, 13).

Амарбаясгалант хийдийн ерөнхий байгуулалт.  
(Амарбаясгалант хийдэд 1892 онд ирсэн А.Позднеев, 1895 онд ирсэн Г.Ц.Цыбиков нарын тэмдэглэл, одоогийн байдлыг үндэслэж зурав.)

1. Ямнай хаалга
  2. Пайлуур
  3. Тамгын сүм
  4. Тугны мод
  5. Жин хонхын сүм
  6. Жин хэнгэрэгний сүм
  7. Махранз
  8. Түүхийн зүүн сүм
  9. Түүхийн баруун сүм
  10. Цогчин дуган
  11. Аюушийн сүм
  12. Маналын сүм
  13. I Богдын шарилын сүм
  14. IV Богдын шарилын сүм
  15. Зуугийн сүм
  16. Зүүн өргөө
  17. Баруун өргөө
  18. Яамны сүм
  19. Түгэлха
  20. Лавран
  21. Майдрын сүм
  22. Нархажидын сүм
  23. Арван Цагаан дуган
  24. Зүүн Цанидын дацан
  25. Манба дацан
  26. Жүдийн дацан
  27. Майдрын дуган
  28. Зурхайн дацан
  29. Баруун Цанидын дацан
  30. Гүрмийн дуган
  31. Пунцаглын аймгийн дуган
  32. Зоогийн аймгийн дуган
  33. Чойнхорлын аймгийн дуган
  34. Шүтээний аймгийн дуган
  35. Дэжидлын аймгийн дуган
  36. Сангай аймгийн аймгийн дуган
  37. Жорун хошир суварга
  38. Номун ханы дуган
  39. Шагны цагдаагийн байшин
- - байхгүй болсон сүм дуган



Зураг 1. Амарбаясгалант хийдийн ерөнхий байгуулалт, малтлага явуулсан хэсгийн тойм зураг



Зураг 2. Ажлын хэсэг, малтлага эхлэхийг өмнө



Зураг 3. Малтгалаа явуулсан булангийн ерөнхий байдал





Зураг 4. Өнгөн хөрснөөс илэрсэн металл зүйлс



Зураг 5. Малтлагын эхний үеэс гарсан барилгын материал



Зураг 6. Малтлагын эхний үеийн цэвэрлэгээ



Зураг 7. Хэрмэн хашааны хормойн хэсэг



Зураг 8. Малталтын 2-р үеэс олдсон барилыг материал



Зураг 9. Малтлагын 3-р үеийн явц



Зураг 10. Малтлагын нийт гүн



Зураг 11. Малтлагын 3-р үеийн зураг



Зураг 12. Малтлагаас гарсан барилын хэрэглэгдэхүүн



Зураг 13. Малтлага хийсэн хэсгийг буцаа булсан байдал



Зураг 14. Малтлагын багийн гишүүд (Зүүн гар талаас: Б.Отгонбаяр, Дааяа, А.Энхтөр, Б.Даваадорж, Г.Анхсанаа, н.Цогт-Эрдэнэ 2019.05.12)

## ДҮГНЭЛТ

Энэ удаагийн тандалт судалгааг 2019 оны 5 дугаар сарын 10-13 хооронд зохион байгуулан явууллаа. Б.Даваадорж болон хамба лам М.Эрдэнэчулуун нарын аман мэдээний дагуу хийдийн хэрмэн хашааны дотор зүүн урд булан орчимд нэгэн өмхөрсөн модны дэргэд 4x4 м хэмжээтэй талбайд малтлагыг 3 үе шаталсан байдлаар 110 см гүнтэй хийлээ. Дээрх талбайд эхний үеийн цэвэрлэгээний дараа металл хайгч (x-terra 705) ажиллуулж үзэхэд өмхөрсөн модны баруун талд нэг болон түүнээс баруун талд 2 хэсэг газар дохио өгч байна. Дохио өгч байгаа дээрх гарзуудад малтлага хийхэд 45-50 см орчмоос хөлдүү, газар гэсээгүй байгаа тул малталтыг 110 см орчимд зогсоосон болно. Учир нь дээрх талбайн өмнө болон баруун талаар 4 м орчим өндөр хэрмэн хашаатай, мөн тэр орчимд 1.5 м тойрог бүхий монос ургасан тул өдөртөө нар тусдаггүйтэй холбоотойгоор газар гэсээгүй, хөлдүү байна.

Тиймээс 7-8 дугаар сард газар бүрэн гэссэн үед металл хайгчийн дохио өгч байгаа хэсэн болон өмхөрсөн модноос зүүн талд малталтыг өргөн талбайд хийж, шалгах хэрэгтэй хэмээн үзэв.

Мөн бидний ажилласан хэсэгт байгаа 2 монос модыг шилжүүлэн суулгах шаардлагатай байна. Учир нь дээрх монос модны мөчир урт ургаснаар хэрмэн хашааны дээврийн ваарыг түлхэх, үндэс нь хэрмэн хашааны хормой хэсгийг эвдэх зэрэг эрсдэлийг учруулж байна.

ТАЙЛАН БИЧСЭН:  
Г.АНХСАНАА. СОЁЛЫН ӨВИЙГ АВРАН ХАМГААЛАХ  
ГАЗРЫН ДАРГА

Б.АМГАЛАНБАТ. СОЁЛЫН ӨВИЙН БҮРТГЭЛ  
СУДАЛГААНЫ ГАЗРЫН БҮРТГЭЛ  
МЭДЭЭЛЛИЙН САНЧ

-----oOo-----

## 2.3. Соёлын өвийг авран хамгаалах, ашиглах үндэсний систем, сүлжээг төгөлдөржүүлэх

### “СОЁЛЫН БИЕТ ӨВИЙН ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТ” УУЛЗАЛТЫН ИЛТГЭХ ХУУДАС

Улаанбаатар хот

2019.01.08

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20.3-д Соёлын өвийн үндэсний төв нь Монгол Улсын соёлын өвийг бүртгэх, мэдээлэх, авран хамгаалах чиг үүрэг бүхий соёл, эрдэм шинжилгээний байгууллага байна хэмээн заасны дагуу манай үндэсний төвөөс Монгол Улсын нутаг дэвсгэрт орших түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалтыг сайжруулах, авран хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулах талаар шат дараатай арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Дээрх ажлын хүрээнд соёлын өвийн хадгалалт, авран хамгаалах (гамшгаас хамгаалах, хууль бус) үйл ажиллагааны талаар Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Эрүүгийн цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Онцгой байдлын Гамшгаас урьдчилан сэргийлэх газрын төлөөллүүдийг оролцуулсан албан бус уулзалтыг 2019 оны 01 дүгээр сарын 8-ны өдөр 12<sup>00</sup> цагт (Соёлын төв өргөө “Б” корпус Соёлын өвийн үндэсний төв №3 тоот) зохион байгуулж, цаашид хийх ажлын талаар зөвлөлдөхөөр зөвлөлдөв.

Тус уулзалтад Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Соёл, урлагийн бодлогын газрын мэргэжилтэн Б.Даваацэрэн, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн референт н.Хатанбаатар, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн Соёл, соёлын өвийн хэлтсийн мэргэжилтэн Ч.Нацагням, Эрүүгийн цагдаагийн албаны 3 дугаар хэлтсийн дарга, цагдаагийн дэд хуландаа н.Нямаа, ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч Ё.Батцоож, Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгаас урьдчилан сэргийлэх газрын Сургалт, сурталчилгаа хариуцсан ахлах мэргэжилтэн, онцгой байдлын дэд хурандаа, Д.Бат-Эрдэнэ, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын улсын ахлах байцаагч Б.Отгонбаяр, Соёлын өвийн үндэсний төвийн захирал Г.Энхбат, Соёлын өвийн үндэсний төвийн Авран хамгаалах газрын дарга Г.Анхсанаа нар оролцов.

Уулзалтын эхэнд Соёлын өвийн үндэсний төвийн Авран хамгаалах газрын дарга Г.Анхсанаа түүх, соёлын үл хөдлөх дурсгал газар хөдлөл, объектын түймрийн үеийн нөхцөл байдал, булш оршуулга, эртний хот, хийдийн туурийг ухах, тонох, дурсгалын эвдэж сүйтгэх, цахим сүлжээн дэх хууль бус худалдааны зарлал, уул уурхайн нөлөөллийн өнөөгийн байдлын талаар, Соёлын өвийн үндэсний төвийн захирал Г.Энхбат түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн мэдээллийн сан, бүртгэл, тооллогын талаар оролцогчдод товч мэдээлэл өгч, салбаруудын тухайн онд болон ирээдүй, хэтийн төлөвлөлт, үйл ажиллагаанд соёлын өвийн хадгалалт хамгаалалтын асуудлыг хэрхэн уялдуулах, дурсгалыг авран хамгаалах талаар нэгдсэн систем бий болгох арга замыг оновчтой тодорхойлох, бодит үйл ажиллагааг эхлүүлэх талаар зөвлөлдөж, талуудын саналыг сонслоо. Тухайлбал, Онцгой



байдлын ерөнхий газрын Гамшгаас урьдчилан сэргийлэх газрын Сургалт, сурталчилгаа хариуцсан ахлах мэргэжилтэн, онцгой байдлын дэд хурандаа, Д.Бат-Эрдэнэ Онцгой байдлын газраас гаргасан сүүлийн үеийн тушаал шийдвэрүүд болон дурсгалыг гамшгийн үед авран хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулах үйл ажиллагааг зохион байгуулах талаар мэдээлэл өгөв. Мөн Эрүүгийн цагдаагийн албаны 3 дугаар хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа н.Нямаа түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хууль бус худалдаа, тонох сүйтгэх талаар авч болох арга хэмжээний талаар болон цаашдын хамтын ажиллагааг өргөжүүлэх, мэдээлэл солилцох, ажилтан албан хаагчдыг мэргэшүүлэх талаар авах арга хэмжээний талаар мэдээлэл хийсэн бол Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Соёл, урлагийн бодлогын газрын мэргэжилтэн Б.Даваацэрэн соёлын өвийн хадгалалт хамгаалалт, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тал дээр талуудын оролцоог идэвхжүүлэх, бодлогын хүрээнд хууль эрх зүйн зарим баримт бичгүүдийг сайжруулах талаар байр сууриа илэрхийлэв.

Уулзалтын төгсгөлд энэ оны нэгдүгээр улиралд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Цагдаагийн ерөнхий газар хамтран “Соёлын өв-гэмт хэрэг” сэдвээр салбар хоорондын уулзалт зохион байгуулах, бэлтгэл ажлын хангах, хамтарсан ажлын хэсэг байгуулах, төлөвлөгөө боловсруулах тал дээр хамтран ажиллахаар тохиров.

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН:  
Г.АНХСАНАА. СОЁЛЫН ӨВИЙГ АВРАН  
ХАМГААЛАХ ГАЗРЫН ДАРГА

-----oOo-----

## **СОЁЛЫН ӨВИЙГ АВРАН ХАМГААЛАХ ТАЛААР ЗАРИМ БАЙГУУЛЛАГУУДАЙ УУЛЗАЛТ ХИЙСЭН ИЛТГЭХ ХУУДАС**

Улаанбаатар

2019 оны 3 дугаар сарын 23

Соёлын өвийн үндэсний төв Авран хамгаалах газраас 2018 оны 11 сард Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг авран хамгаалах, хадгалалт хамгаалалтыг сайжруулах үүднээс газрын харилцаа, бүтээн байгуулалт болох уул уурхайн хайгуул, ашиглалт, төмөр ба авто зам, суурьшлын бүс газар олголт, газар тариалан, аялал жуулчлалтай холбоотой бодлого, төлөвлөлтийг хийдэг төрийн захиргааны төв байгууллагууд, төрийн захиргааны байгууллага болон мэргэжлийн байгууллагуудыг оролцуулсан “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалт, ашиглалтын нэгдсэн систем бий болгох зөвлөлдөх уулзалт”-ыг зохион байгуулсан.

Тус уулзалтын үргэлжлэл болгож Түүх, соёлын үл хөдлөх дурсгал хамгийн ихээр өртөж байгаа салбарын холбогдох байгууллагуудтай тухайлсан уулзалт

хийхээр албан бичиг явуулснаас Зам, тээврийн хөгжлийн яам, Нийслэлийн газрын алба, Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газраас хариу ирүүлсэн болно.

Энэ дагуу дээрх байгууллагуудын холбогдох мэргэжилтнүүдтэй уулзаж түүх, соёлын үл хөдлөх дурсгалын талаар болон нөхцөл байдлын талаар танилцуулга хийж, зарим асуудлыг тодрууллаа.

Зам тээврийн хөгжлийн яам: 2019 оны 1 дүгээр сарын 18-нд тус яаман дээр Бодлого, төлөвлөлтийн газрын Бодлогын хэрэгжилт, дотоод зохион байгуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн М.Угтахбаяр, Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Авто зам, замын байгууламж хариуцсан мэргэжилтэн С.Баярчимэг, Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын төмөр замын зурвас, байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Батзориг нартай уулзаж, Түүх, соёлын үл хөдлөх дурсгал болон түүнийг авран хамгаалах үйл ажиллагаа, цаашдын төлөвлөлтийн талаар танилцуулав. Тус яамны зүгээс авто болон төмөр зам барих төлөвлөлт хийхдээ улсын газар зохион байгуулалтын нэгдсэн сангийн төлөвлөлттэй уялдуулан хийдэг байна.

Тиймээс нэгдсэн санд дурсгалт газруудын мэдээлэл ороогүй тохиолдолд урьдчилан мэдэх боломжгүй, мөн хуулийн дагуу зам болон замын дагуу барилга байгууламж барьж байгаа аж ахуй нэгжүүдэд хайгуул судалгаа хийлгэх ажлын даалгавар өгдөг байна. Гэвч энэ талаар хуулийн хэрэгжилтэд хангалттай тавьж боломжгүй байдаг тухай хэлж байна. Түүнчлэн, зам барих үед ашиглах түүхийн эд элс хайрга зэргийг ашиглах зөвшөөрлийг орон нутгаас өгдөг тул энэ асуудалд хамаагүй гэлээ.

Мөн концессоор барьж байгаа замын ажлыг үндэсний хөгжлийн газар зэрэг холбогдох газруудаас хамаарч байгаа тул тус яамнаас зөвхөн мэргэжил арга зүй, стандарт зэргийг хариуцдаг учраас тухайн бүтээн байгуулалтын үед өртсөн дурсгалыг хариуцах боломжгүй аж.

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тухай мэдээллийг газар зүйн мэдээллийн нэгдсэн санд оруулсан тохиолдолд цаашдын төлөвлөлт хийхдээ анхаарч болно гэсэн байр суурь илэрхийллээ.

Нийслэлийн Газрын алба: 2019 оны 3 дугаар сарын 5-нд Хангарьд ордонд Нийслэлийн газрын албан дээр боллоо. Уулзалтад, Тус газрын албаны Газрын менежмент, төлөвлөлтийн хэлтсийн дарга Ч.Очир, тус хэлтсийн хот байгуулалтын мэргэжилтэн Б.Тэргүүнцэцэг нар оролцов.

Дээрх албаны хүмүүст 2018 оны 11 сард Соёлын өвийн төвөөс зохион байгуулсан зөвлөлдөх уулзалтын талаар болон Түүх, соёлын үл хөдлөх дурсгал болон түүнийг авран хамгаалах үйл ажиллагаа, цаашдын төлөвлөлтийн талаар танилцуулав. Мөн нийслэл хот орчимд газар олголтод өртсөн зарим үл хөдлөх дурсгалууд болох Их тэнгэрийн ам, Ван хааны орд хэмээх эртний хэрэм, Сонгинохайрхан дүүрэгт орших Тахилгат уул зэрэг газруудын талаар мэдээллийг тодрууллаа.

Нийслэлийн газрын албанаас газар олгох үйл ажиллагааг төлөвлөхдөө Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газартай хамтран төлөвлөдөг, нэгдсэн мэдээллийн санд тулгуурлан явуулдаг байна. Тиймээс нэгдсэн мэдээллийн санд дурсгалын тухай мэдээлэл ороогүй тул төлөвлөлтөд тусгах боломжгүй гэсэн мэдээлэл өглөө. Мөн дээр дурдсан дурсгалт газруудын талаар Их тэнгэрийн амны

дурсгал Богдхан уулын тусгай хамгаалалтын бүсэд ордог тул хамаарахгүй, Ван хааны ордон хэмээх дурсгалын дундуур шуудуу татсаныг Нийслэлийн захирагчийн ажлын алба мэднэ, Тахилгат уулыг дүүргийн газрын алба хариуцаж байгаа, иргэдийг нүүлгэж өөр байршилд газар олголт хийсэн гэлээ. Түүнчлэн нийслэл орчмын дурсгалын мэдээлэл байхгүй тул мэдээллээр хангах боломж байна уу гэсэн хүсэлт тавьсан бөгөөд холбогдох мэдээллийг илгээсэн болно.

Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар: 2019 оны 3 дугаар сарын 22-нд Засгийн газрын XII байр Кадастрын хэлтэс, Хэлтсийн дарга Д.Дашзэвэг, Хориглосон, хязгаарласан газрын бүртгэл, түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэн Н.Отгонсүрэн нартай уулзалт хийв. Уулзалтын эхэнд мэргэжилтэн Н.Отгонсүрэнд Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын талаар товч мэдээлэл хийгээд, тус газраас нийт хайгуулын болон ашиглалтын талбайд түүх, соёлын үл хөдлөх дурсгалын судалгаа хийсэн бүртгэл гарах уу гэхэд гарах боломжгүй, геологийн хэлтсээс гарч магадгүй гэсэн хариулт өгөв. Мөн олгогдсон талбайн тухай мэдээллийг бүх газарт өгдөг бөгөөд төлөвлөхдөө Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газарт явуулж санал авдаг гэв. Илүү нарийн мэдээллийг Геологи, хайгуулын хэлтсийн Металл бус, түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул хариуцсан мэргэжилтэн Г.Алтанхуягаас авч болно гээд утсаар яриулав.

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН:  
Г.АНХСАНАА. СОЁЛЫН ӨВИЙГ АВРАН  
ХАМГААЛАХ ГАЗРЫН ДАРГА

-----oOo-----

## 2.4.1. Монголоос ЮНЕСКО-д бүртгэгдсэн соёлын өвийг хамгаалах талаар хамтын ажиллагаа өрнүүлэх

### МОНГОЛ УЛСААС ДЭЛХИЙН ӨВД БҮРТГЭГДСЭН ДУРСГАЛТ ГАЗРУУДЫН ТАНИЛЦУУЛГА НОМЫГ ЭМХТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН

Улаанбаатар

2019.11.18

ЮНЕСКО-ийн Оролцооны хөтөлбөр “Дэлхийн өвийн хөдөлгөөнт сургалт” төслийн хүрээнд Дэлхийн өвд бүртгэгдсэн 5 дурсгалт газрын тухай номын эх боловсруулах ажлыг ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний Комисс, Соёлын өвийн үндэсний төвтэй байгуулсан 2019 оны МҮК/19/11 дугаар “Ажил гүйцэтгэх гэрээ”, Соёлын өвийн үндэсний төвийн захиралын 2019 оны 8 дугаар сарын 21-ны А/71 дүгээр тушаалын дагуу хийж гүйцэтгэв.

1. Дэлхийн Өв-Монгол Алтайн нурууны хадны зургийн цогцолбор ном нь дөрвөн бүлэг, ном зүйгээс бүдэнэ. Үүнд,




*Нэгдүгээр бүлэгт.* ЮНЕСКО ба Дэлхийн өв гэсэн агуулгын дор Өв гэж юу вэ?, ЮНЕСКО ба Дэлхийн өвийн конвенц, Дэлхийн соёлын өв, Дэлхийн байгалийн өв, Холимог өв, Дэлхийн өвийн урьдчилсан жагсаалт ба Монгол улсаас, Дэлхийн өвд бүртгэгдсэн өвийн газар нутгууд, Дэлхийн өвийн хадгалалт хамгаалалтын менежмент, Монгол улсын нэгдсэн орсон ЮНЕСКО-ийн соёлын конвенцууд 17 нүүр бичвэр, 1 газрын зураг боловсруулан, 9 гэрэл зураг сонгож оруулав.

*Хоёрдугаар бүлэгт.* Дэлхийн Өв-Монгол Алтайн нурууны хадны зургийн цогцолбор гэсэн агуулгын дор дурсгалт газрын товч танилцуулга, зүй, байгаль, цаг уурын онцлог, Хамгааллын үйл ажиллагаа, Засаг захиргааны нэгж, байршил, Баян-Өлгий аймаг, Улаанхус сум, Цэнгэл сум товч танилцуулга 7 нүүр бичвэр, 4 газрын зураг, 8 гэрэл зураг сонгов.

*Гуравдугаар бүлэгт.* Дэлхийн өвийн газар нутаг дахь соёлын өв гэсэн агуулгын дор угсаатны товч түүх, соёлын биет бус өв, археологийн судалгааны тойм, түүх, соёлын үл хөдлөх дурсгалууд, түүх, соёлын хөдлөх дурсгалуудын талаар 20 нүүр бичвэр, 2 газрын зураг боловсруулан, 23 гэрэл зураг оруулав.

*Дөрөвдүгээр бүлэгт.* Монгол улсын соёлын өвийг хамгаалах хууль болон холбогдох хууль тогтоомжууд, Хавсралт зураг, бүтээлийн боловсруулахад ашигласан ном зүйн жагсаалтыг орууллаа. Нийт 44 нүүр бичвэр, 7 газрын зураг боловсруулан, 40 гэрэл зураг сонгож хийлээ.

2. Дэлхийн Өв - Увс нуурын ай сав газар ном нь дөрвөн бүлэг, ном зүйгээс бүдэнэ. Үүнд.



*Нэгдүгээр бүлэгт.* ЮНЕСКО ба Дэлхийн өв гэсэн агуулгын дор Өв гэж юу вэ?, ЮНЕСКО ба Дэлхийн өвийн конвенц, Дэлхийн соёлын өв, Дэлхийн байгалийн өв, Холимог өв, Дэлхийн өвийн урьдчилсан жагсаалт ба Монгол улсаас, Дэлхийн өвд бүртгэгдсэн өвийн газар нутгууд, Дэлхийн өвийн хадгалалт хамгаалалтын менежмент, Монгол улсын нэгдсэн орсон ЮНЕСКО-ийн соёлын конвенцууд 17 нүүр бичвэр, 1 газрын зураг боловсруулан, 9 гэрэл зураг сонгож оруулав.


*Хоёрдугаар бүлэгт.* Увс нуурын ай сав газрын Засаг захиргааны нэгж, байршил, Увс аймаг, Баруунтуруун, Давст, Сагил, Тариалан, Түргэн, Улаангом, сумдын товч танилцуулга 5 нүүр

бичвэр боловсруулав.

*Гуравдугаар бүлэгт.* Дэлхийн өвийн газар нутаг дахь соёлын өв гэсэн агуулгын дор угсаатны товч түүх, соёлын биет бус өв, археологийн судалгааны тойм, түүх, соёлын үл хөдлөх дурсгалууд, түүх, соёлын хөдлөх дурсгалуудын талаар 19 нүүр бичвэр, 2 газрын зураг боловсруулан, 18 гэрэл зураг оруулав.

*Дөрөвдүгээр бүлэгт.* Монгол улсын соёлын өвийг хамгаалах хууль болон холбогдох хууль тогтоомжууд, Хавсралт зураг, бүтээлийн боловсруулахад ашигласан ном зүйн жагсаалтыг орууллаа. Нийт 41 нүүр бичвэр, 3 газрын зураг боловсруулан, 27 гэрэл зураг сонгож хийлээ.

3. Дэлхийн Өв- Бурхан Халдун, түүнийг хүрээлсэн тахилга шүтлэгт газар нутаг ном нь дөрвөн бүлэг, ном зүйгээс бүдэнэ. Үүнд.



*Нэгдүгээр бүлэгт.* ЮНЕСКО ба Дэлхийн өв гэсэн агуулгын дор Өв гэж юу вэ?, ЮНЕСКО ба Дэлхийн өвийн конвенц, Дэлхийн соёлын өв, Дэлхийн байгалийн өв, Холимог өв, Дэлхийн өвийн урьдчилсан жагсаалт ба Монгол улсаас, Дэлхийн өвд бүртгэгдсэн өвийн газар нутгууд, Дэлхийн өвийн хадгалалт хамгаалалтын менежмент, Монгол улсын нэгдсэн орсон ЮНЕСКО-ийн соёлын конвенцууд 17 нүүр бичвэр, 1 газрын зураг боловсруулан, 9 гэрэл зураг сонгож оруулав.

*Хоёрдугаар бүлэгт.* Бурхан Халдун, түүнийг хүрээлсэн тахилга шүтлэгт газар нутгийн товч танилцуулга, Дэлхийн өвд бүртгэгдсэн шалгуурууд, дурсгалт газрын товч түүх, тахилгын зан үйлийн

түүхэн уламжлал, төрөөс гаргасан бодлого, шийдвэр, хууль, дүрэмүүд зэргийг багтаасан 5 нүүр бичвэр, 4 гэрэл зураг, 1 газрын зураг боловсруулав.

*Гуравдугаар бүлэгт.* Бурхан Халдун, түүнийг хүрээлсэн тахилга шүтлэгт газар нутгийн бүс нутгийн тухай гэсэн агуулгын дор тус дурсгалт газар орших бүс нутаг болох Хэнтий нурууны уулсын физик газар зүй, Уур амьсгал, өндөрийн шаталбар болон эдгээр уулсаас эх аван урасдаг томоохон голууд болох Онон, Хэрлэн, Туул голын тухай танилцуулга хийв.

Мөн Бурхан Халдун, түүнийг хүрээлсэн тахилга шүтлэгт газар нутаг байрлах Засаг захиргааны нэгжийн товч танилцуулга, угсаатны бүлгийн хэсэгт Хэнтий, Төв аймаг болон Өмнөдэлгэр, Мөнгөнморьт сумын товч танилцуулга, энэ бүсэд орших суух Халх, Буриад, Хаминган, Урианхай зэрэг угсаатаны товч түүх, угсаа гарвалын талаар товч, зарим онцлог зан үйл, тэдгээрийн дотороос “Уул овоо тахих зан үйл”-ийн талаар товч танилцуулан бичив. Түүнчлэн нийт Монгол угсаатны дунд ховордож, зөвхөн энэ бүсэд хадгалагдан үлдсэн гэж болох Тал хээрийн адуу, Монголчууд эртнээс нохойг ан ав, Хурх-Биндэр аялгуугаар дуулах зэрэг онцлог өвийн төрлүүдийн судалгааны тойм, танилцуулга хийлээ.

Үүний дараа Бурхан Халдун, түүнийг хүрээлсэн тахилга шүтлэгт газар нутаг, түүний хамгаалалтын бүс болон орчны бүсэд Монголын дундад үеийн түүхэнд чухал үйл явдал болсон түүхт газар нутгууд болон дурсгалт газрууд цөөнгүй байдгийг судлаачид шинжлэн тогтоосон байдаг. Тухайлбал, Гурван голын эх, Хар Зүрхний Хөх нуур, Хагийн Хар нуур, Хөдөө арал, Рашаан хад, Өглөгчийн хэрэм, Аваргын балгас, Сарьдгийн хийдийн туурь, Гүнжийн сүм, Балдан бэрээвэн хийд зэргийн талаар судалгааны түүх болон сүүлийн үеийн судалгааны тойм, товч үр дүнг тусгалаа.

Бурхан Халдун, түүнийг хүрээлсэн тахилга шүтлэгт газар нутаг орчимд хийсэн археологийн судалгааны тоймыг 1922 оноос буюу шинжлэх ухааны үүднээс судлаж эхэлсэн үеэс 2017 он хүртэл тоймлон өгүүлэв.

Сүүлд нь Бурхан Халдун, түүнийг хүрээлсэн тахилга шүтлэгт газар нутаг орчмын соёлын өвийг төрөл тус бүрээр нь танилцуулж, судалгааны тоймыг багцлан бичив. Үүнд, Түүх, соёлын үл хөдлөх дурсгал хэсэгт Чулуун зэвсгийн үе, Хүрэл, төмрийн түрүү үе, Хүннүгийн үе, Түрэгийн үе, Монголын үеийн дурсгалын төрөл, онцлогуудыг бичив.

Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл хэсэгт Хэнтий аймгийн музейн товч танилцуулга болон үзмэр, эд өлгийн танилцуулга, тоо, хувь хэмжээг оруулав.

Соёлын биет бус өвийн талаар тухайн бүс нутгийн голлох угсаатны төлөөлөлүүд оршин суудаг Хэнтий аймгийн соёлын биет бус өв, өвлөн уламжлагчид болон 2018 онд зохион байгуулагдсан “Соёлын биет бус өвийн их наадам”-д тус аймгаас оролцсон төлөөлөлүүдийн талаар нийт 35 нүүр бичвэр, 25 гэрэл зураг оруулав.

*Дөрөвдүгээр бүлэгт.* Монгол улсын соёлын өвийг хамгаалах хууль болон холбогдох хууль тогтоомжууд, Хавсралт зураг, бүтээлийн боловсруулахад ашигласан ном зүйн жагсаалтыг орууллаа. Нийт 40 нүүр бичвэр, 2 газрын зураг боловсруулан, 29 гэрэл зураг сонгож хийлээ.

4. Дэлхийн Өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газар ном нь дөрвөн бүлэг, ном зүйгээс бүдэнэ. Үүнд,

*Нэгдүгээр бүлэгт.* ЮНЕСКО ба Дэлхийн өв гэсэн агуулгын дор Өв гэж юу вэ?, ЮНЕСКО ба Дэлхийн өвийн конвенц, Дэлхийн соёлын өв, Дэлхийн байгалийн өв, Холимог өв, Дэлхийн өвийн урьдчилсан жагсаалт ба Монгол улсаас, Дэлхийн өвд бүртгэгдсэн өвийн газар нутгууд, Дэлхийн өвийн хадгалалт хамгаалалтын менежмент, Монгол улсын нэгдсэн орсон ЮНЕСКО-ийн соёлын конвенцууд 17 нүүр бичвэр, 1 газрын зураг боловсруулан, 9 гэрэл зураг сонгож оруулав.

*Хоёрдугаар бүлэгт.* Дэлхийн Өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын ерөнхий мэдээлэл, танилцуулга, Орхон гол, Орхоны хөндийн дэлхийн болон монголын түүх, соёлын ач холбогдол, Дурсгалт газрын ач холбогдол, 4 нүүр бичвэр, 2 гэрэл зураг, 1 газрын зураг боловсруулав.

*Гуравдугаар бүлэгт.* Дэлхийн Өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын газар зүй, байгаль, цаг уурын онцлог, Засаг захиргааны нэгжийн товч танилцуулга, угсаатны бүлгийн мэдээлэлд Архангай, Өвөрхангай аймгуудын танилцуулга болон дурсгалт газарыг хамарах Хашаат, Хотонт, Бат-Өлзий, Хархорин, Хужирт сумдын танилцуулгыг оруулав.

Мөн дээрх хоёр аймгийн нутаг дахь угсаатны бүлэг, тэдгээрийн онцлог уламжлалт зан үйлийн тухай талаар мэдээлэл, тэдгээрийн дотороос ЮНЕСКО-ийн Соёлын биет бус өвийн Төлөөллийн жагсаалтад бүртгэгдсэн Монгол Ардын уртын дуу, Шувуучлахуй, Монгол гэрийн уламжлалт урлал, зан үйл зэрэг өвүүдийн дэлгэрэнгүй танилцуулга хийв.

Түүнчлэн Орхоны хөндийн соёлын дурсгалт газар нь Монголын төдийгүй дэлхий дахины түүхийн олон арван дурсгалт газрыг агуулж байдагын хувьд манай улсын археологийн судалгааны эхлэл эндээс тавигдасан байдаг. Тиймээс дээрх бүс нутагт хийсэн археологийн судалгааны тоймын 1889 оноос 2018 он хүртэл хийж, шинжилгээ судалгааны ажлыг он дарааллын дагуу өгүүлхийн зэрэгцээ тухайн судалгааны ололт амжилтыг орууллаа.

Энэ бүлэгт Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын соёлын өвийг төрөл тус бүрийн танилцуулгыг хийсэн бөгөөд тус дурсгалт газрын хамгаалтад орсон Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын 24 дурсгалын үе бүрээр нь танилцуулга хийв. Үүнд, Чулуун зэвсгийн үед Мойлтын амны чулуун зэвсгийн дурсгал, Орхон-1, 7 чулуун зэвсгийн суурин, Хүрлийн үед Ар Бөөрөгийн булш, Бэрхийн булан дахь эртний булш, хиргисүүрийн цогцолбор дурсгал, Гүмбийн дэнжийн буган хөшөө, булш хиргисүүр, Нарийны амны булшнууд, Майхан толгойн дурсгал, Орхон голын хадны зураг, эртний булшнууд, Тэмээн чулууны буган хөшөө, Ширээт уулын буган чулуун хөшөө, Шунхлай уулын булш, Хүннүгийн үед Хутаг уулын булш, хиргисүүр, Түрэг, Уйгурын үед Хөшөө Цайдамын цогцолбор дурсгал, Шивээт уулын дурсгал, Хар балгас, Монголын үед Баянголын амны туурь, Дойтын балгас, Захын булагийн дурсгал, Мэлхийт толгойн туурь, Чулуун яст мэлхийн дурсгалууд Монголын эртний нийслэл Хархорум хотын туурь, Хар Бондгорын балгас болон Эрдэнэзуу хийд, Шанхын Баруун хүрээ, Тахилгат хайрхан болох Хангайн овоо, Тахилгат хайрхан Өндөр Сант уул зэргийг хамарууллаа.

Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлд дурсгалт газар орших улсын болон засаг захиргааны нэгжийн музей болох Хархорум музей, Өвөрхангай аймгийн музей, Эрдэнэзуу музей, Хөшөө цайдам музей болон Дэлхийн Өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргааны үйл ажиллгаа, үзмэр эд өлгийн зүйлсийн

танилцуулга хийв. Мөн Архангай аймгийн хэмжээнд 1 ш, Өвөрхангай аймгийн хэмжээнд 175 ш дурсгал байгаа нь нийт хосгүй үнэт дурсгалын 22.7 % буюу бусад аймаг, орон нутгаас онцлог бөгөөд дээгүүр үзүүлэлт болох бөгөөд дээрх хосгүй үнэт үзмэрүүдийн дээжисээс танилцуулав.

Соёлын биет бус өвийн хувьд Монгол Улсын хэмжээнд нийт 8383 соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч бүртгэгдсэнээс Өвөрхангай аймаг 169, Архангай аймаг 261 өвлөн уламжлагч бүртгүүлсэн байна. Эдгээрээс Орхоны хөндийн соёлын дурсгалт газар орших дээрх хоёр аймгийн 5 сум болох Бат-Өлзий суманд 8, Хархорин суманд 13, Хужирт суманд 9, Хашаат суманд 18, Хотонт суманд 25, нийт 73 өвлөн уламжлагч бүртгэгдсэн байдаг бөгөөд Архангай, Өвөрхангай аймгийн соёлын биет бус өв, өвлөн уламжлагчид болон 2018 онд зохион байгуулагдсан “Соёлын биет бус өвийн их наадам”-д тус аймгаас оролцсон төлөөлөлүүдийн талаар нийт 46 нүүр бичвэр, 1 газрын зураг боловсруулан, 41 гэрэл зураг оруулав.

*Дөрөвдүгээр бүлэгт.* Монгол улсын соёлын өвийг хамгаалах хууль болон холбогдох хууль тогтоомжууд, Хавсралт зураг, бүтээлийн боловсруулахад ашигласан ном зүйн жагсаалтыг орууллаа. Нийт 51 нүүр бичвэр, 2 газрын зураг боловсруулан, 41 гэрэл зураг сонгож хийлээ.

#### 5. Дэлхийн Өв- Монгол дагуурын ландшафт ном нь дөрвөн бүлэг, ном зүйгээс бүдэнэ. Үүнд,

*Нэгдүгээр бүлэгт.* ЮНЕСКО ба Дэлхийн өв гэсэн агуулгын дор Өв гэж юу вэ?, ЮНЕСКО ба Дэлхийн өвийн конвенц, Дэлхийн соёлын өв, Дэлхийн байгалийн өв, Холимог өв, Дэлхийн өвийн урьдчилсан жагсаалт ба Монгол улсаас, Дэлхийн өвд бүртгэгдсэн өвийн газар нутгууд, Дэлхийн өвийн хадгалалт хамгаалалтын менежмент, Монгол улсын нэгдсэн орсон ЮНЕСКО-ийн соёлын конвенцууд 17 нүүр бичвэр, 1 газрын зураг боловсруулан, 9 гэрэл зураг сонгож оруулав.

*Гуравдугаар бүлэгт.* Монгол дагуурын ландшафт оршиж байгаа засаг захиргааны нэгжийн товч танилцуулга, угсаатны бүлэг сэдэвийн доор Дашбалбар, Чулуунхороот, Гурванзагал сумдын танилцуулга, энэ бүс нутагт оршин суудаг голлох угсаатны төлөөлөл болох Халх, Буриад, Баргуудын угсаатны түүх, ёс заншил болон Халхын хэцүү То ван хэмээх Тогтохтөр, Манлайбаатар Дамдинсүрэн зэрэг түүхэн хүмүүсийн тухай бичлээ.

Мөн Дорнод аймгийн нутаг дахь түүх, соёлын дурсгалыг бүртгэж судласан тухай тоймыг шинжилгээ судлагааны ажил эхэлсэн 1940-өөд оноос 2018 хүртэл он дарааллын дагуу товчоолон бичиж, зарим үр дүнг оруулав.

Түүнчлэн, Дорнод аймгийн хэмжээнд соёлын өвийг төрөл тус бүрээр нь тоймлон танилцуулав. Үүнд, Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг түүхэн үе бүрээр нь төлөөлөх дурсгалт газруудын танилцуулга хийсэн ба эдгээр дурсгалуудаас Монгол дагуурын ландшафт орших дурсгалуудын тоо, тархалт, онцлог шинжүүдийг бичив.

Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл хэсэгт Дорнод аймгийн музейн товч танилцуулга болон үзмэр, эд өлгийн танилцуулга, тоо, хувь хэмжээг оруулав.

Соёлын биет бус өвийн талаар тухайн бүс нутгийн голлох угсаатны төлөөлөлүүд оршин суудаг Дорнод аймгийн соёлын биет бус өв, өвлөн уламжлагчид болон 2018 онд зохион байгуулагдсан “Соёлын биет бус өвийн их наадам”-д тус



аймгаас оролцсон төлөөлөлүүдийн талаар нийт 28 нүүр бичвэр, 2 газрын зураг боловсруулан, 24 гэрэл зураг оруулав.

*Дөрөвдүгээр бүлэгт.* Монгол улсын соёлын өвийг хамгаалах хууль болон холбогдох хууль тогтоомжууд, Хавсралт зураг, бүтээлийн боловсруулахад ашигласан ном зүйн жагсаалтыг орууллаа. Нийт 41 нүүр бичвэр, 3 газрын зураг боловсруулан, 27 гэрэл зураг сонгож хийлээ.

ТАЙЛАН БИЧСЭН:

Г.АНХСАНАА. СОЁЛЫН ӨВИЙГ АВРАН

ХАМГААЛАХ ГАЗРЫН ДАРГА

-----oOo-----

**2.4.2.Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн тайланг боловсруулахад дэмжлэг үзүүлэх (Лимбэ, Ботго)**

**ЯАРАЛТАЙ ХАМГААЛАХ ШААРДЛАГАТАЙ СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙН  
ЖАГСААЛТАД БҮРТГЭГДСЭН ЭЛЕМЕНТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ  
/СТАТУС/-ЫН ТАЙЛАН**

2019 ОНЫ 12 ДУГААР САРЫН 15

2020 ОНЫ ХЯНАЛТ

Тайлангийн маягтыг бөглөх зааварчилгаа

<https://ich.unesco.org/en/forms> цахим хуудсанд байршиж байна

**ICH-11 МАЯГТ**

**А. НҮҮР ХУУДАС**

**А.1. Оролцогч улс**

МОНГОЛ УЛС

**А.2. Конвенцод нэгдэх, хүлээн авах, батлах буюу элсэх баримт бичгийг байршуулсан огноо.**

Энэ мэдээлэл [www.unesco.org/culture/ich](http://www.unesco.org/culture/ich) хуудсанд бий.

29/06/2005 конвенцид нэгдэн орсон.

**А.3. Энэхүү тайланд холбогдох Яаралтай хамгаалах шаардлагатай СББӨ-ийн жагсаалтад бүртгэгдсэн элемент**

Үндэстэн дамнасан өвийн тухайд холбогдох оролцогч талын нэрийг тэмдэглэнэ.

Өвийн нэр: Монгол лимбэчдийн уртын дуу хөгжимдөх уламжлалт арга барил-битүү амьсгаа

Бүртгэгдсэн он: 2011

**А.4. Энэхүү тайланд хамрагдах тайлангийн хугацаа**

Энэхүү тайланд хамрагдах тайлангийн хугацааг тодруулна уу.

Эхэлсэн огноо: 2015

Дууссан огноо: 2019

**А.5. Яаралтай хамгаалах шаардлагатай СББӨ-ийн жагсаалтад бүртгэгдсэн бусад өвийн төрөл зүйлс**

Өөрийн улсаас Яаралтай хамгаалах шаардлагатай СББӨ-ийн жагсаалтад бүртгэлтэй бусад өвийг бүртгэгдсэн оны хамт бичнэ үү. Үндэстэн дамнасан өвийн тухайд холбогдох оролцогч талын нэрийг тэмдэглэнэ.

Монгол бүжгийн уламжлалт урлаг-Бий биелгээ (2009)

Монгол цуур хөгжмийн урлаг (2009)

Монгол тууль (2009)

Монгол уран бичлэг (2013)

Ингэнд ботго авахуулах зан үйл (2015)

Уул овоо тахих Монгол зан үйл (2017)

**А.6. Тайлангийн гүйцэтгэлийн хураангуй**

Өвийн элементийн өнөөгийн байдал, бүртг эгдсэнээс улбаатай эерэг ба сөрөг талууд, тайлангийн хугацаанд хэрэгжүүлсэн хамгаалалтын арга хэмжээ, хэрэгжилт, дараагийн жилүүдэд хийх боломжтой шинэчлэл зэргийг нийт уншигчдад ойлгомжтой байдлаар тайлангийн гүйцэтгэлийн хураангуй бичнэ үү. \400-600 үгэнд багтаах\

Тайлангийн хугацаанд холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн театр, чуулга, орон нутгийн холбогдох байгууллага, өвлөн уламжлагчид хамтран лимбэний битүү амьсгаа өвийн уламжлалыг өвлөгчдийг судлан тогтоох, бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх, судалж, сурталчлах, уг өвийг хойч үед өвлүүлэх чиглэлээр хадгалалт, хамгаалалтын урт болон дунд хугацааны олон талт үйл ажиллагааг хэрэгжүүлсний үр дүнд өвлөн уламжлагч болон өвлөн суралцагчдын тоо нэмэгдсээр байна. 2019 оны байдлаар Соёлын өвийн үндэсний төвийн Соёлын өвийн Улсын Нэгдсэн Бүртгэл, Мэдээллийн Санд нийт лимбэний битүү амьсгаа өвийн холбогдолтой 168 хүний мэдээлэл цуглагдснаас 40 нь өвлөн уламжлагч, 128 нь өвлөн суралцагч 15 нь лимбэ урлаач байна.

Энэхүү өв бүртгэгдсэнтэй улбаатайгаар ямарваа нэгэн сөрөг тал байхгүй, харин энэхүү нь өв бүртгэгдсэн цагаас хойш өвийн талаархи олон нийтийн ойлголт, үнэ цэнэ нэмэгдэж, өвийн оршин тогтнох орон зайн тэлж байна.

Тухайлбал, ЮНЕСКО-гийн Соёлын биет бус өвийн сангийн санхүүжилттэйгээр хэрэгжиж эхлээд байгаа “Монгол лимбэчдийн уртын дуу лимбэдэх уламжлалт арга битүү амьсгааг өвлүүлэх, тогтворжуулах нь” төслийн хүрээнд Соёлын өвийн үндэсний төв, “Монголын Лимбэчдийн Холбоо” ТББ хамтран лимбэний битүү амьсгаа өвийг өвлөн уламжлагчдыг бүртгэх, урын санг баримтжуулах ажлыг хийж соёлын өвийн УНБМС-г баяжуулав.

Лимбэний битүү амьсгаа өвийг албан болон албан бус сургалтаар өвлүүлэн, уламжлуулах чиглэлээр дээрхи төслийн хүрээнд Лимбэний сургалтын 5 танхимийг Улаанбаатар, Завхан, Ховд, Өмнөговь аймгуудад нээн тохижуулж, Говийн, Баруун Төвийн бүсүүдэд 10 лимбэч, өвлөн уламжлагчыг тулгуурлан 40 шавийг сургах шавь сургалтыг 2019 оноос эхлүүлээд байна. Мөн албан буюу танхимын сургалтын хүрээнд СУИС-ийн “Бадмаараг” ахлах сургууль, “Шинэ монгол” ахлах сургууль, “Глобал” ахлах сургуулиудад лимбэний сургалт хичээллэж байна. Түүнчлэн СУИС, МУБИС-ийн “Багш урлагийн боловсрол” хөтөлбөрт лимбэ хөгжмийн зэмсэг, лимбэний битүү амьсгаа өвийг сонгон суралцах сургалтын хөтөлбөрийг боловсруулж, оруулсан нь энэхүү өвийг өвлөн уламжлагчдын тоог нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулж байна.

Соёлын биет бус өвийг хадгалж, хамгаалах, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас 2018 онд Нүүдэлчин монгол “Соёлын биет бус өвийн наадам”-ыг зохион байгуулж, Дорноговь, Өмнөговь, Сүхбаатар, Төв, Хэнтий, Хөвсгөл аймгаас энэхүү наадамд амжилттай оролцсон лимбэний битүү амьсгаа өвийг өвлөн уламжлагч 8 хүнд батламж гардуулав.

Мөн ахмад лимбэчдийн алдаршуулах зорилгоор Төв, Ховд аймаг, сумдуудын ИТХ, ЗДТГ, тэдгээрийн үр хүүхдүүд, шавь нар, ажлын болоод нутгийн иргэдийн оролцоотойгоор тус нутгийн соёлын төвүүдийг алдарт лимбэч Л.Цэрэндорж, М.Бадам нарын нэрэмжит болгон шийдвэрлүүлж, тохижуулж үйл ажиллагааг эхлүүллээ. Тайлангийн хугацаанд алдарт лимбэч “Л.Цэрэндоржийн нэрэмжит

улсын уралдаан"-ыг 2018 онд зохион байгуулж 32 лимбэч, өвлөн уламжлагчид амжилттай оролцлоо.

Ази, Европ тивүүдэд зохиогдсон олон улсын чанартай мэргэжлийн уралдаан, наадмуудад давхацсан тоогоор 10 лимбэчин амжилттай оролцож лимбэний битүү амьсгааг олон улсад сурталчилаад байна. Лимбэний битүү амьсгаа өвийг олон нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх чиглэлээр лимбэдэх урлагтай холбоотой 4 ном, DVD хичээл бүхий гарын авлагыг хэвлэж, улсын болон олон улсын чанартай 5 удаагийн эрдэм шинжилгээний хуралд оролцож, хурлын эмхэтгэлд хэвлүүлэв.

Монгол Улсын Засгийн газраас 2019 оны 2 дугаар сард 68 тоот тогтоолоор “Соёлын биет бус өвийг хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийг баталж, БСШУС-ын сайдын А/235 дугаар тушаалаар тус хөтөлбөрийг 2019-2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлагдаж, хэрэгжиж эхлээд байна. Энэхүү хөтөлбөрийн гол зорилго нь СББӨ-ийн талаар баримтлах бодлого, эрхзүйн орчныг боловсронгуй болгож, соёлын биет бус өвийг хамгаалах конвенцийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, судалгаа, бүртгэн баримтжуулалт, бүртгэл, мэдээллийн сангийн үйл ажиллагааг олон улсын жишигт хүргэх Соёлын биет бус өвийнталаар олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг салбар хоорондын хамтын ажиллагаанд түшиглэн зохион байгуулах, Соёлын биет бус өвийн мэргэжилтнийг чадавхжуулах, өвлөн уламжлагчдыг дэмжих үйл ажиллагаануудыг шат дараалалтайгаар зохион байгуулахаар төлөвлөсөн.

#### **А.7. Холбогдох хүний хаяг:**

Тайланг хариуцан ажиллах хүний нэр, хаяг болон бусад мэдээллийг бичнэ үү

Ноён/Хатагтай: Хатагтай

Овог: Цэрэндорж

Нэр: Цолмон

Хаяг: Монгол улс, 21 06 20а, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Сүхбаатарын талбай 3, Жамъяангийн гудамж, Соёлын Төв Өргөө “Б” хэсэг, Соёлын Өвийн Төв Шуудангийн хаяг: Сүхбаатарын талбай 3, СБ дүүрэг Улаанбаатар 21 06 20а, Монгол улс

Утас: + 976-11312735

Факс: +976-11-312735

E-mail: [tsolmon.ncch@gmail.com](mailto:tsolmon.ncch@gmail.com)

#### **В. Яаралтай хамгаалах шаардлагатай СББӨ-ийн жагсаалтад бүртгэгдсэн өвийн өнөөгийн байдал \статус\**

Тухайн өвийн **одоогийн** статусыг мэдээлэхдээ тухайн өвийг жагсаалтад бүртгүүлэхээр нэр дэвшүүлсэн файлыг үндэс болгон зөвхөн жагсаалтад бүртгэгдсэнээс хойших буюу сүүлийн тайлан мэдээллээс хойш хийсэн холбогдох өөрчлөлтийг дурдана. Нэр дэвшүүлсэн файл болон өмнөх тайлан [www.unseco.org/culture/ich](http://www.unseco.org/culture/ich) хуудаст бий, мөн Нарийн бичгийн дарга нарын газарт хүсэлт тавин авч болно.

Оролцогч тал нь тайланг бэлтгэх явцад холбогдох хамт олон, бүлэг, хувь хүмүүс, төрийн бус байгууллагын оролцоог аль болох өргөн хамруулан баталгаажуулахад хүчин чармайлт гаргаж, жөндөрийн үүрэгт анхаарал хандуулж ажиллах

шаардлагатай бөгөөд D хэсэгт энэ шаардлага хэрхэн хангагдсан талаар тайлбар өгнө.

### **В.1. Нийгэм, соёлын гүйцэтгэх үүрэг**

Тухайн холбогдох хамт олны хувьд уг соёлын биет бус өвийн өнөөгийн нийгэм, соёлын гүйцэтгэх үүрэг, өвийн өнөөдрийн утга учрыг тайлбарлана уу. Мөн тухайн соёлын биет бус өвийн өвлөн уламжлагч нарын шинж чанар, онцгой үүрэг эсхүл бусдын дунд болон өвийн тухайд онцгой үүрэг хүлээдэг хүмүүсийн ангиллыг тайлбарлана уу. Жагсаалтад бүртгэх шалгуур U.1-д холбоотой аливаа өөрчлөлтөд анхаарах хэрэгтэй (“тухайн элемент нь конвенцын 2-р зүйлд тодорхойлсноор соёлын биет бус өв байна”). \200-500 үгэнд багтаах\

2010 онд лимбэний битүү амьсгаа өвийг яаралтай хамгаалах шаардлагатай СББӨ-ийн жагсаалтад нэр дэвшүүлэх үед энэхүү өвийн оршин тогтнох чадвар туйлын эрсдэлтэй нөхцөл байдалд байсан. Учир нь нийгэм, эдийн засгийн болон нийтлэг соёлын нөлөөгөөр тус өвийн оршин тогтнох ахуй орчин алдагдаж, өвлөн уламжлагчдын тоо цөөрснөөр зөвхөн Улаанбаатар хотод төвлөрөх хандлага үүсч эхэлсэн. Тэр үед, энэхүү өвийг хадгалж, хамгаалах нэг арга нь танхимын сургалтаар дамжуулан залуу, хойч үед өвлүүлэн үлдээх сонголт болоод байсан юм. Хэдийгээр танхимд заах нь “битүү амьсгаа” гэх аргыг авч үлдсэн ч өвийг хэрэглэх орчин, хэрэглээ өөрчлөгдсөнөөс түүний язгуур шинж чанар буюу уртын дууг битүү амьсгаагаар лимбэдэхүйн мөн чанар алдагдаж байсан юм. Тус өв бүртгэгдсэнээр, өвийн талаархи олон нийтийн ойлголт өсч, сонирхон суралцах хүсэлтэй авьяастнуудын тоо нэмэгдэж, өвийн тархац тэлж эхэлсэн. Тухайлбал, энэхүү өвийг өвлөн уламжлагч болон өвлөн суралцагчдын тархац Завхан, Ховд, Өмнөговь, Говь-Алтай, Дорноговь, Дархан-уул, Төв, Өвөрхангай аймаг болон Улаанбаатар хотоор хязгаарлагдаж байсан бол энэхүү тайлангийн хугацаанд Говьсүмбэр, Сүхбаатар, Хэнтий, Увс, Сэлэнгэ, Булган, Хөвсгөл аймгуудад өвлөн уламжлагчид байгааг бүртгэл судалгаагаар гаргаж, мөн шинээр өвлөн суралцагчид суралцаж эхэлснийг тогтоов.

Энэхүү өвийг өвлөн уламжлагч нийт 40 хүнээс Улаанбаатар хотод 16, орон нутагт 24 уламжлагч байна. Өвлөн суралцагч 128 үүнээс 46 нь албан боловсролын хүрээнд СУИС, СУИС-МУБИС-БУБ, СУИС-Бадмаараг, МУК-д суралцаж байна. Албан бус боловсролын хүрээнд МХО–д 25 өвлөн суралцагч суралцаж байна. Харин орон нутагт нийт Завхан, Ховд, Өмнөговь, Говь-Алтай, Дорноговь, Дархан-уул, Төв, Өвөрхангай аймгуудад албан боловсролын хүрээнд 12, албан бус боловсролын хүрээнд 45 гаруй өвлөн суралцагч суралцаж байна.

Тус өвийг “Үндэсний Их баяр наадам”, “Цагаан сар”, хурим, хүүхдийн сэвлэг үргээх ёслол зэрэг уламжлалт баяр наадмуудын үеэр тоглох болсон нь өвийн язгуур хэрэглээ сэргэж байгааг харуулж байна. Мөн томоохон соёлын наадмууд, орон нутгийн шинж чанартай язгуур урлагийн тэмцээн уралдаанд тоглогдохын зэрэгцээгээр, үндэсний болон орон нутгийн театр, чуулга, язгуур урлагийн хамтлагууд өндөр ач холбогдол өгч уран бүтээлийн урын сандаа тусгаж, сэргээн тоглох болсон нь энэхүү өвийг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, сурталчилахад чухал хувь нэмэр оруулж байна. Жишээлбэл, 2018 онд лимбэний битүү амьсгаа

өвийн өвлөн уламжлагч Б.Мягмарцэрэн “Авьяслаг Монголчууд” наадамд оролцож тус наадмын дэд байрыг эзэлсэн.

Хөгжимдөх ур чадвар, урын санд тулгуурлан өвлөн уламжлагчдыг дотор нь “Ур чадварын өндөр түвшинд өвлөсөн өвлөн уламжлагч” болон “өвлөн уламжлагч” гэж хоёр ангилж байна. Тус өвийг өвлөн уламжлагч 40 хүний 10 нь “Ур чадварын өндөр түвшинд өвлөсөн өвлөн уламжлагч” нар байгаа тул өвийн оршин тогтнох чадварт онцгой үүрэг хүлээж, албан болон албан бус сургалтаар дамжуулан өвлөн суралцагчдыг сургаж, өвийн онцлог шинж чанарыг өвлүүлэн уламжлуулахад их үүрэгтэй байна. Мөн энэхүү өвийн оршин тогтнох чадвар, хадгалалт, хамгаалалтад онцгой үүрэг, хариуцлага хүлээдэг хүмүүсийг дараах байдлаар ангилж болно. Үүнд: шат шатны төрийн байгууллагын соёлын биет бус өвийн бодлого, зохицуулалт, бүртгэл, судалгаа, хадгалалт, хамгаалалт хариуцсан мэргэжилтнүүд, судлаачид, төрийн бус байгууллагын гишүүд, дэмжигчид, орон нутгийн удирдлага, нутгийн иргэд, өвийг уламжлагч, суралцагчдын ар гэр, хамт олон, мөн албан болон албан бус сургалтыг зохион явуулахад үүрэг гүйцэтгэж байгаа хүмүүс, тухайлбал, соёлын төвийн эрхлэгч, дуу хөгжмийн багш, сургалтын менежер, захирал, аймгийн БСГ-ын мэргэжилтэн, дарга гэх мэт.

## **В.2. Соёлын биет бус өвийн оршин тогтнох чадвар болон өнөөгийн тулгарч буй эрсдэлийн үнэлгээ**

Тухайн биет бус өвийн оршин тогтнох чадварын өнөөгийн түвшин, тухайлбал түүнийг практик, үйлдэх давтамж, цар хэмжээ, өвлүүлэн уламжлуулах арга барилын чадавх, болон үзэгчдийн хүн ам зүй, тэдгээрийн тогтвортой байдал зэргийг тайлбарлан бичнэ үү? Түүнчлэн тухайн өвийн тасралтгүй өвлүүлэн уламжлуулах, практикт нүүрлэж байгаа аливаа аюул, эрсдэл, тэдгээрийн цар хүрээ, тулгамдсан байдлыг тодорхойлж бичнэ. Тодорхойлж бичихдээ өвийн элемент бүртгэгдсэнээс хойших оршин тогтнох чадварт нөлөөлж буй эерэг ба сул талуудад голчлон анхаарлаа хандуулах нь зүйтэй. \200-500 үгэнд багтаах\

2015 онд 14 өвлөн уламжлагчтай байсан бол 2019 онд 40-д хүрээд байгаа нь энэхүү өвийн оршин тогтнох чадвар сайжирч байгааг харуулж байна. Лимбэний битүү амьсгаа өвийг албан сургалтаар СУИС, СУИС болон МУБИС-ийн Багш урлагийн боловсрол хөтөлбөр, СУИС-Бадмаараг ахлах сургууль, Монгол Улсын Консерватор, Завханы ХБК, Монголын Хүүхдийн Ордон зэрэг газруудад долоо хоногт 2 цагаар, 2-оос 4н жилийн хугацаатай мэргэжлийн сургалтыг зохион явуулж байна. Харин албан бус буюу шавь сургалтыг Ховд, Завхан, Өмнөговь, Дорноговь, Сэлэнгэ, Өвөрхангай, Хөвсгөл, Хэнтий, Төв аймгууд болон Улаанбаатар хотын Шинэ монгол сургууль, Глобал зэрэг сургуульд зааж байна. Энэхүү албан болон албан бус сургалтанд өнөөдрийн байдлаар нийт 130 гаруй өвлөн суралцагчид хамрагдаж байна. Сургалтыг өвлөн уламжлагч нар уламжлалт арга барилаар буюу үзүүлэн таниулах (тухайлбал: DVD цахим хичээл, 3D загварчлал, рентгэн лабораторийн зураг г.м), дагуулан хөгжимдөх, “Ур чадварын өндөр түвшинд өвлөсөн өвлөн уламжлагч” нарын дэг сургууль, хөгжимдөх арга барилын онцлогийг ялган таниулах хэлбэрээр заадаг.

Өвлөн уламжлагч 40 хүн нь 30-70 насны хооронд, өвлөн суралцагч 130 хүн нь 10-30 насны хооронд байна. Албан болон албан бус сургалтын үр дүнг

тайлагнах тоглолтыг өвлөн суралцагчдын анги хамт олон, эцэг эх, сургуулийн хүүхдүүдэд жилд 2-4 удаагийн давтамжтай зохион байгуулдаг ба үзэгчдийн хүн ам зүйн мэдээллийг нарийвчлан гаргах боломжгүй ч насны ангилалын хувьд тайлан тоглолтыг 10- 65 насны хүмүүс үзэж сонирхдог. Өвлөн уламжлагч, өвлөн суралцагч болон үзэгчдийн хүн амзүйн мэдээлэл харьцангуй тогтвортой юм.

Тус өвийг бүртгүүлснээр оршин тогтнох чадварт олон шинэ эерэг хандлагууд бий болсон. Тухайлбал:

- Албан болон албан бус сургалтын тоо нэмэгдсэнээр өвийг сонирхож, шамдан суралцагчдын тоо бодитоор нэмэгдсэн.
- Өвийн талаархи олон нийтийн мэдлэг, ойлголт нэмэгдсэн.
- Өвийг судлах шинжлэх ухааны хавсрага, хэрэглээний судалгаа, судлаачдын тоо нэмэгдэж, судалгааны нэгэн сэдэвт бүтээлүүд гарсан .
- Өвийн холбогдолтой гарын авлага, ном, цахим хичээлийн эх хэрэглэгдэхүүн бий болсон.

Даяаршлын үйл явц хүчтэй түрж, дэлхийн болон улс орны нийгэм соёлын орчин нэг загвар, стандартад орох, өвлөн сургах тогтолцоо, орчин нөхцөл, язгуур хэв шинж алдагдах зэрэгтэй холбоотой сөрөг үр дагавруудаас дурьдвал:

- Төрөөс дэмжих бодлого барьж байгаа боловч өвлөн уламжлагчийг алдаршуулах, урамшуулах, нийгмийн баталгааг хангах, дэмжлэг үзүүлэх ажил зохих түвшинд хүрэхгүй байна.
- Лимбэний битүү амьсгаа өвийн хэрэглээний орчин нөхцөл өөрчлөгдөж байгаатай холбоотойгоор тус өвийн язгуур мөн чанарыг өвлөн суралцагчид гүйцэд таньж мэдэхгүй байх тохиолдол байсаар байна.
- Лимбэний битүү амьсгаа өвийг уртын дуучин, морин хуурчтай хамтран хөгжимддөг уламжлал төдийлэн сэргэхгүй байна.
- Өвийг өвлөн суралцагчийн ур чадвар дутмаг байх, шантрах, байнгын бэлтгэл сургуулилалтгүйн улмаас өвийг мартах, гээгдүүлэх эрсдэл байсаар байна.

### **В.3. Хамгаалах үйл ажиллагааны хэрэгжилт**

Номинацид нэр дэвшүүлэх баримт бичигт орсон болон өмнөх тайланд орсон хамгаалалтын үйл ажиллагаануудын талаар энд бичнэ үү. Тэдгээр үйл ажиллагаанууд нь хэрхэн, яаж хэрэгжиж, тайлангийн хугацаанд өвийн элементийн хамгаалалтад хэрхэн ач холбогдол өгч хувь нэмрээ оруулсан талаар тайлбар хийнэ үү. Тэгэхдээ хязгаарлагдмал нөөц гэх мэт гадаад болон дотоод саад бэрхшээлүүдийг дурдана уу. Ялангуяа тухайн хамт олон өвийн тасралтгүй үргэлжлэх практик, өвлүүлэн уламжлуулах нөхцөлийг хангах замаар өвийн элементийн оршин тогтнох чадварыг ханган баталгаажуулахад чиглэсэн үйл ажиллагааг оруулах нь зүйтэй. Дараах шат дараалал бүхий үйл ажиллагааны хэрэгжилттэй холбоотой асуултуудад нарийвчилсан хариултуудыг өгнө үү.

#### **В.3.а. Зорилтууд ба үр дүн**

Тайлангийн хугацаанд ямар үндсэн зорилт(ууд)-ыг дэвшүүлсэн мөн тус хугацаанд ямар бодит үр дүнд хүрсэн талаар энд бичнэ үү.

\200-500 үгэнд багтаах\

**Зорилтууд:**

- Лимбэний битүү амьсгааг хойч үед өвлүүлэхэд уламжлалт шавь сургалт болон танхимын сургалтыг бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулах, өргөжүүлэх,
- Монгол лимбэчний Уртын дуу тоглох уламжлалт арга барил- битүү амьсгааг судлах, хадгалж хамгаалах, баяжуулан хөгжүүлэх
- Өвлөн уламжлагчдийг тодруулан алдаршуулах, сурталчлах, дэмжих, дэлгэрүүлэх
- Монгол лимбэчний Уртын дуу тоглох уламжлалт арга барил- битүү амьсгаа талаар олон нийтийн мэдлэг, ойлголт, оролцоог нэмэгдүүлэх,
- Лимбэчдийн үзүүлэх тоглолт, үзэсгэлэн, семинарыг тодорхой хугацаанд бүх шатанд зохион явуулж хэвших,
- Үндэсний хөтөлбөрийн хүрээнд битүү амьсгааг сэргээх, хамгаалах, хөгжүүлэх төлөвлөгөөг БСШУЯ-наас батлан гаргаж түүнийг хэрэгжүүлэхэд төрийн бүх шатны холбогдох байгууллагууд ЮНЕСКО-гийн МҮК, Соёлын өвийн үндэсний төв, холбогдох төрийн бус байгууллагууд шууд оролцож дэмжлэг үзүүлэх.

#### Үр дүн:

- Монгол лимбэчний Уртын дуу тоглох уламжлалт арга барил- битүү амьсгааг албан болон албан бус сургалтыг бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулж, өргөжүүлсэнээр өвлөн уламжлагчид, өвлөн суралцагсдын тоо 168 хүрээд байна. Энэ ажлын хүрээнд, СУИС-ийн “Бадмаараг” ахлах сургууль, “Шинэ монгол”, “Глобал” ахлах сургуулиудад лимбэний сургалтыг эхлүүлж, СУИС, МУБИС-ийн “Багш, урлагийн боловсрол” хөтөлбөрт тулгуурлан тухайн өвд суралцах гаргалгааг гаргаж өгсөн.
- Битүү амьсгаа өвийн бүртгэл мэдээллийн сан баяжиж, өвлөн уламжлагчдийн нэгдсэн бүртгэл, судалгаатай болов.
- Лимбэний битүү амьсгаа өвийн судалгаанд ахиц дэвшил гарч нэг сэдэвт бүтээл бий болов. Монгол Улсын Соёл, Урлагийн Их Сургуулийн багш, өвлөн уламжлагч Ц.Цэвэгсүрэн “Лимбэ, лимбэдэх урлагийн судалгаа” сэдвээр нэг сэдэвт бүтээл бичиж, 2018 онд докторын зэрэг хамгаалав. Мөн Монгол Улсын Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуульд Ц.Доржсүрэн “Битүү амьсгааны арга барилаар лимбэдэхэд оролцох эрхтэнүүдийн бүтэц, үйл зүйн зарим үзүүлэлтийг судалсан дүн” сэдвээр магистрын ажил хийсэн байна.
- Өвлөн уламжлагчдийг тодруулан алдаршуулах, сурталчлах, дэмжих, дэлгэрүүлэх ажлын хүрээнд Ховд аймгийн Мянгад, Төв аймгийн Сэргэлэн сумын соёлын төвийг нэрт өвлөн уламжлагчдын нэрэмжит болгон тохижуулав. Мөн энэ ажлын хүрээнд, лимбэчдийн улсын уралдааныг 2018 онд бүх лимбэчдийн дунд нээлттэй хэлбэрээр, 3 ангиллаар зохион байгуулав.
- Лимбэний битүү амьсгаа өвийн талаархи олон нийт, ард иргэдийн ойлголт, ухамсар дээшилж, нийгмийн үнэлэмж үлэмж сайжирч байна. Лимбэний битүү амьсгаа өвийн холбогдолтой ном сэтгүүл хэвлүүлж, телевиз радио зэрэг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлж, DVD бүхий гарын авлага, ном товхимол хэвлүүлэв.



- Лимбэчдийн үзүүлэх тоглолт, үзэсгэлэн, семинар зохион байгуулах зорилтын хүрээнд “Лимбэний битүү амьсгаа өвийн үзэсгэлэн”-г 2015, 2019 онд 2 удаа Монголын театрын музей, Соёлын өвийн үндэсний төв, Монголын лимбэдийн холбооноос зохион хамтран байгуулав. Үзэсгэлэнгийн зорилго нь ахмад лимбэчдийг алдаршуулах үзэсгэлэн, битүү амьсгааны танхимыг байгуулах, хүүхэд залуучуудад энэхүү өвийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх байв. Давхардсан тоогоор үзэсгэлэнд нийтдээ хот, орон нутгаас 30 гаруй лимбэчин оролцож, 400 орчим хүн үзэсгэлэнг үзэж танилцсан байна. Үзэсгэлэнгийн хугацаа 7-10 хоног байв.
- 2018 онд лимбэний битүү амьсгаа өвийн үзүүлэх тоглолтыг 3 удаа, эрдэм шинжилгээний хурлыг 1 удаа тус тус зохион байгуулав.
- Монгол Улсын засгийн газраас 2019 оны 2 дугаар сард 68 тоот тогтоолоор “Соёлын биет бус өвийг хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийг баталж, 2019-2023 онд 4 үндсэн зорилтын хүрээнд 58 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр үйл ажиллагааны төлөвлөгөөг баталснаас 5 нь битүү амьсгаа өвийг хадгалж, хамгаалахтай холбогдолтой байна.

### **В.3.б. Хамгаалах үйл ажиллагаанууд**

Тайлангийн хугацаанд дээрх бодит үр дүнд хүрэхийн тулд хэрэгжүүлсэн гол үйл ажиллагаануудыг энд жагсаана уу. Тус үйл ажиллагаануудад дэлгэрэнгүй тайлбар өгөхдөө тэдгээрийг хэрэгжүүлэх явцад гарсан үр өгөөж, тулгарсан бэрхшээлүүдийг тэмдэглэнэ үү..

\500-1000 үгэнд багтаах\

- 1. Лимбэний битүү амьсгаа өвийг бүртгэх, баримтжуулах, мэдээллийн сан бүрдүүлэх ажлын хүрээнд:**
  - Соёлын өвийн үндэсний төв нь чиг үүргийнхээ хүрээнд соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын бүртгэл, судалгааг жил бүр шинэчлэн баяжуулдаг ба 2019 оны байдлаар УНБМС-нд нийт 168 лимбэний битүү амьсгаа өвийн өвлөн уламжлагч анхан шатны байдлаар бүртгэгдсэн байна. Тус бүртгэлийг “Монголын лимбэний холбоо” ТББ, 21 аймгийн БСГ болон Нийслэлийн Соёл, урлагийн газартай хамтран зохион байгуулав.
  - 2019 онд “Монгол лимбэчдийн уртын дуу лимбэдэх уламжлалт арга битүү амьсгааг өвлүүлэх, тогтворжуулах нь” төслийн хүрээнд лимбэний битүү амьсгааны өвлөн уламжлагчдийн бүртгэл, судалгаа, баримтжуулах ажлыг 15 аймгийн 24 суманд ажиллаж лимбэний битүү амьсгаа өвийн өвлөн уламжлагч 28 хүнийг бүртгэн баримтжуулав.
- 2. Монгол лимбэчний Уртын дуу тоглох уламжлалт арга барил- битүү амьсгааг албан болон албан бус сургалтын хүрээнд:**
  - СУИС, МУБИС-ийн “Багш, урлагийн боловсрол” хөтөлбөрт тухайн өвийг эзэмших аргачлалыг тусгав.
  - СУИС, МУК, МУБИС, Завхан аймаг дахь ХБК, МХО, “Бадмаараг”, “Шинэ Монгол”, “Глобал” ахлах сургуулиуд нийт 90 гаруй оюутан, 11 багштай сургалтын үйл ажиллагааг явуулж байна.

- 2019 онд “Монгол лимбэчдийн уртын дуу лимбэдэх уламжлалт арга битүү амьсгааг өвлүүлэх, тогтворжуулах нь” төслийн хүрээнд Улаанбаатар хот болон Завхан, Ховд, Өмнөговь аймгуудад лимбэний битүү амьсгаа өвийн албан бус сургалтын 5 танхимыг нээн тохижуулж, үйл ажиллагааг эхлүүлэв.
- 2019 оны байдлаар Өмнөговь, Завхан, Ховд, Говь-Алтай, Дорноговь, Өвөрхангай, Сэлэнгэ, Хөвсгөл аймгууд болон Улаанбаатар хотод 10 багш 40 өвлөн суралцагчтай лимбэний битүү амьсгааны шавь сургалтуудыг явуулж байна.
- Эвэр бүрээ, бишгүүр хөгжмийн сургалтын хөтөлбөрт битүү амьсгаагаар хөгжимдөх өвийн сургалт үргэлжилж байна.
- 2015-2017 онд СУИС, МУК, Завханы ХБК, Монголын Театрын Музей хамтран лимбэний битүү амьсгаа өвийн нээлттэй хичээлийг 5 удаа зохион байгуулав.
- 2015-2017 онд М.Лхагвагэрэл, О.Лхагвадорж нар хамтран лимбэний битүү амьсгаа өвийн нээлттэй хичээлийг Япон улсад 3 удаа зохион байгуулав.
- 2019 онд “Монгол лимбэчдийн уртын дуу лимбэдэх уламжлалт арга битүү амьсгааг өвлүүлэх, тогтворжуулах нь” төслийн хүрээнд лимбэ урлалын шавь сургалтыг зохион байгуулж, 4 урлаачыг бэлтгэж, дээрхи төслийн хүрээнд зохион байгуулагдаж буй шавь сургалтанд хэрэглэгдэх 40 лимбийг урласан болно.
- 2016 онд лимбэч Р.Эрдэнэлхагва лимбэний анхан, дунд шатны сургалтын гарын авлага, лимбээр ардын дуу лимбэдэх арга барилын “Монгол ардын дууг лимбэдэхүй”, “Лимбэний судалбар аяз” номыг тус бүр 300 ш хэвлүүлж олны хүртээл болгосон.
- 2017 онд лимбэч, багш Ц.Цэвэгсүрэнгийн “Лимбэнд зориулсан бүтээлүүд” ном хэвлэгдэн гарав.
- “Монгол лимбэчдийн уртын дуу лимбэдэх уламжлалт арга битүү амьсгааг өвлүүлэх, тогтворжуулах нь” төслийн хүрээнд “Лимбэдэх уламжлалт арга битүү амьсгаанд суралцах нь” гарын авлага, DVD ном 800 хувийг хэвлэн нийтийн хүртээл болгоод байна.

**1. Монгол лимбэчний Уртын дуу тоглох уламжлалт арга барил- битүү амьсгааны талаарх судалгааны хүрээнд**

- 2018 онд “Л.Цэрэндорж -110” эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулж, 12 илтгэгч илтгэлээ хэлэлцүүлж, эмхэтгэл хэвлэгдсэн.
- 2017 онд лимбэний битүү амьсгаа өвийн өвлөн уламжлагч, судлаач Ц.Цэвэгсүрэн /Ph.D/ нь ОХУ -ын Барнаул хотноо зохиогдсон ОУ-ын ЭШХ-д “Монгол лимбэчдийн битүү амьсгаагаар лимбэдэх урлаг соёлын өв болох нь”, “Үлээвэр хөгжмийн хөгжимдөх арга барилын болон зэмсгийн эд бүрдлийн нэр томъёог жигдлэх асуудалд” 2017; “Лимбээр хөгжимдөх уламжлалт арга барилын онцлог” 2017; Дөрвөн хуруугаар лимбэдэх арга ба таван эгшигтийн шүтэлцээ, Лимбэдэх үесийн чимэглэн ба уламжлал-шинэчлэл //“Соёлын бүтээлч үйлдвэрлэл - 2018” эрдэм шинжилгээ - онол, практикийн хуралд тус тус илтгэл хэлэлцүүлсэн.

- 2018 онд лимбэч Ц.Цэвэгсүрэн /Ph.D/ “Лимбэ, лимбэдэх урлагийн судалгаа” сэдвээр докторын зэргийг хамгаалсан. Үүнд Битүү амьсгаагаар уртын дуу лимбэдэх арга барилын онцлогийг анагаах, физикийн шинжлэх ухаан зэрэг олон салбар шинжлэх ухааны уулзвараар судалж энэхүү өв нь лимбэчний бие мах бод, тэвчихүй, бодохуй, сэтгэхүй, бясалгахуй, урлахуй гэсэн шалтгаант дарааллаар битүү дуун хэлхээ болдог хэмээх саналыг дэвшүүлж батлав.

**4. Монгол лимбэчний Уртын дуу тоглох уламжлалт арга барил- битүү амьсгааны талаарх олон нийтийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх сурталчилгаа, өвлөн уламжлагчдийг алдаршуулах чиглэлээр:**

- 2015-2019 онд давхацсан тоогоор 10 лимбэчин Ази, Европ, Америк тивүүдэд лимбэний битүү амьсгааг сурталчлах тоглолтуудыг хийгээд байна.
- 2015-2019 онуудад МҮОНРТ, UBS, HD Mongol, NTV зэрэг телевизүүдэд лимбэ, өвийг сурталчлах нийт 7 нэвтрүүлэгт давхацсан тоогоор 30 гаруй хүн оролцсон байна
- 2016 онд БНСУ-д зохиогдсон “Азийн лимбэчдийн наадам”, Тюрское олон улсын соёлын байгууллагын мэргэжлийн хөгжимчдийн олон улсын оркестрын тоглолт зэрэгт өвлөн уламжлагч Ц.Цэвэгсүрэн, Г.Нямжанцан нар оролцсон.
- 2017 онд “Авьяслаг монголчууд” шоу наадамд лимбэч Б.Мягмарцэрэн, Б.Булган-Эрдэнэ, Д.Даваасүрэн нар оролцож тус өвийн үзүүлбэрээр Б.Мягмарцэрэн дэд байрт шалгарсан.
- 2016, 2017, 2018 оны “Алтан намар” хөгжмийн наадмуудад лимбэч Ц.Цэвэгсүрэн, Г.Нямжанцан, Б.Мягмарцэрэн нар лимбэнд зориулсан том хэлбэрийн бүтээлүүдийг хөгжимдөв.
- 2018 онд Л.Цэрэндоржийн мэндэлсний 110 жилийн ойг БСШУСЯ, Төв аймгийн ЗДТГ, ИТХ, мэргэжлийн сургуулиуд, соёл урлагийн байгууллагуудтай хамтран улс орон даяар тэмдэглэв.
- 2018 онд Алдарт лимбэч Л.Цэрэндоржийн нэрэмжит мэргэжлийн лимбэчдийн улсын 2-р уралдааныг зохион байгуулж 7 аймаг, 14 байгууллагын 32 лимбэчин оролцов. Үүнд тухайн өвийг өвлөн уламжлагч 6, өвлөн суралцагч 26 хүн оролцсоноос 29 нь эрэгтэй, 3 нь эмэгтэй оролцогч байв.
- Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 195 дугаар тогтоол, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 12-р сарын 28-ны өдрийн А/843 тушаалын дагуу Үндэсний болон олон улсын хэмжээнд амжилт гаргасан шилдэг уран бүтээлчийг тодруулан алдаршуулах “Мөнгөн мод” цом гардуулах ёслолын ажиллагаанаас лимбэч, өвлөн уламжлагч Г.Нямжанцанг 2018 оны шилдэг өвлөн уламжлагчаар тодруулан алдаршуулав.
- Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд БСШУСЯ, ЗХГА-ын СУГ, СӨҮТ, 21 аймгийн БСГ, Нийслэлийн БСГ хамтран үндэсний хэмжээний “Нүүдэлчин Монгол” СББӨ-ийн их наадмыг 2018 онд зохион байгуулсан. Тус наадмын эхний шатанд нийт

оролцсон 10000 орчим өвлөн уламжлагч оролцсоноос 40 орчим лимбэч оролцож, 8 лимбэч, өвлөн уламжлагч төгсгөлийн шатанд шалгаран “СББӨ-ийг өвлөн уламжлагчийн батламж”-г гардан авсан байна.

- Төв аймгийн Сэргэлэн сумын соёлын төвийг Л.Цэрэндоржийн нэрэмжит болгон тохижуулж, үйл ажиллагааг эхлүүлэв.
- 2019 онд Ховд аймгийн ЗДТГ, ИТХ, нутгийн иргэд, үр хүүхдүүдтэй хамтран Ховд аймгийн Мянгад сумын соёлын төвийг лимбэч М.Бадамын нэрэмжит болгон тохижуулав.
- Ахмад лимбэчдийг алдаршуулах ажлын хүрээнд Монголын театрын музейтэй хамтран лимбэчдийн үзэсгэлэнг “Лимбэчдийг алдаршуулахуй”, “Лимбэний үзэсгэлэн”-г 2015, 2019 онуудад зохион байгуулав.

### **В.3.с. Хамгаалалтын үйл ажиллагаан дахь хамт олон, бүлэг, хувь хүмүүсийн оролцоо**

Хамт олон, бүлэг, хувь хүмүүсийн хамгаалалтын арга хэмжээнд хэрхэн идэвхтэй, үр дүнтэй оролцсон талаар тайлбар өгнө үү. Хэрэгжүүлэгч байгууллага, бүрэлдэхүүн (нэр, туршлага г.м) ба хэрэгжүүлэхэд оролцсон хүний нөөцийн талаар тайлбар өгнө үү. \200-500 үгэнд багтаах\

БСШУСЯ, ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисс, Соёлын өвийн үндэсний төв, Монголын лимбэчдийн холбоо, СУИС, МУК, МХО, Завхан аймгийн ХБК, Ховд, Өмнөговь, Төв аймгийн ЗДТГ, ИТХ, БСГ лимбэний битүү амьсгаа өвийг хадгалж хамгаалах, түгээн дэлгэрүүлэх, судлах, сурталчилах, өвлүүлэн уламжлуулах чиглэлээр энэхүү өвийн өвлөн уламжлагч нартай идэвхитэй хамтран ажилладаг. Тухайлбал битүү амьсгаа өвийг хадгалж хамгаалах, өвлүүлэхэд гол үүрэгтэй хүмүүс болох Монгол Улсын гавъяат хөгжимчин, лимбэч Л. Цэрэндоржийн үе үеийн шавь нар, “Монголын лимбэчдийн холбоо”-ны гишүүн лимбэчид Д.Галсантогтох, Ө.Батжаргал, Ч.Даваажав, Ц.Цэвэгсүрэн, Г.Нямжанцан, Ч.Ваша, Р.Эрдэнэлхагва, Б.Цогтмагнай, Отгондүү нар болон Л.Цэрэндорж, М.Бадам нарын үр хүүхдүүд, Төв, Ховд аймгийн нутгийн иргэд, нутгийн зөвлөл, Монголын лимбэчдийн холбооны гишүүд, дэмжигчид, “Үхэрчин хүү Л.Цэрэндорж” ТББ-тай хамтран албан болон албан бус сургалт зохион байгуулах, энэхүү өвийг залуу хойч үед өвлүүлэн уламжлуулах, уралдаан тэмцээн зохион байгуулах, ахмад өвлөн уламжлагчдыг алдаршуулах, үзэсгэлэн, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах, ном бүтээл туурвих зэргээр хадгалалт, хамгаалалт, түгээн дэлгэрүүлэлтийн үйл ажиллагааг хамтран зохион байгуулсан. Үүнээс дурдвал, Монгол Улсын гавъяат хөгжимчин, лимбэч Л. Цэрэндоржийн мэндэлсний 110 жилийн ойг тэмдэглэх ажлыг БСШУСЯ, Төв аймгийн ЗДТГ, ИТХ, Сэргэлэн сумын ЗДТГ, ИТХ, сумын соёлын төв, “Монголын Лимбэчдийн Холбоо” ТББ, “Үхэрчин Хүү Л.Цэрэндорж” ТББ, СУИС, Монгол Улсын Консерватори хамтран зохион байгуулсан. Энэ хүрээнд нэрэмжит уралдаан, эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулснаас гадна Төв аймгийн Сэргэлэн сумыг Л. Цэрэндоржийн нэрэмжит болгосон.

### **В.3.d. Хуваарь**

Үйл ажиллагаа бүрийн хэрэгжсэн хугацааг бичнэ үү. \200-500 үгэнд багтаах\

1. 2015-2019 онд нийт 5 удаа лимбэч Р.Эрдэнэлхагвын уран бүтээлийн тоглолтыг дэмжиж зохион байгуулав.
2. 2015-2019 онд лимбэч М.Лхагвагэрэл Япон улсад лимбэний бие даасан тоглолтоо 4 удаа зохион байгуулав.
3. 2015-2019 онд давхацсан тоогоор 10 лимбэчин Ази, Европ, Америк тивүүдэд лимбэний битүү амьсгааг сурталчлах тоглолтуудыг хийгээд байна.
4. 2015-2019 онуудад MYONPT, UBS, HD Mongol, NTV зэрэг телевизүүдэд лимбэ, өвийг сурталчлах нийт 7 нэвтрүүлэгт оролцсон байна.
5. 2015, 2019 онуудад Монголын театрын музейд монголын лимбэчдийн үзэсгэлэнг 2 удаа зохион байгуулав.
6. 2015-2017 онуудад “Лимбэний битүү амьсгааны тухай” нээлттэй хичээл, хэлэлцүүлгийг СУИС, Монголын театрын музей, МУК, Завхан аймгийн ХБК-д 5 удаа зохион байгуулав.
7. 2016 онд Лимбэч Р.Эрдэнэлхагвын “Монгол ардын дууг лимбэдэхүй”, “Лимбэний судалбар аяз” гарын авлага, ном хэвлэгдэн гарав.
8. 2016, 2017, 2018 оны “Алтан намар” хөгжмийн наадмуудад лимбэч Ц.Цэвэгсүрэн, Г.Нямжанцан, Б.Мягмарцэрэн нар лимбэнд зориулсан том хэлбэрийн бүтээлүүдийг хөгжимдөв.
9. 2017 онд лимбэч, багш Ц.Цэвэгсүрэнгийн “Лимбэнд зориулсан бүтээлүүд” ном хэвлэгдэн гарав.
10. 2017 онд зохион байгуулагдсан “Авьяслаг монголчууд” наадамд лимбэч, лимбэний битүү амьсгаа өвийг өвлөн уламжлагч Б.Мягмарцэрэн оролцож дэд байрт шалгарав.
11. 2018-2019 онд лимбэч Лхагвадорж Япон улсад битүү амьсгааны тухай нээлттэй хичээл зохион байгуулж 3 удаагийн бие даасан тоглолтоо хийв.
12. 2018 оны 7 сард зохион байгуулагдсан “Нүүдэлчин монгол” наадмын эхний шатанд нийт 10000 орчим өвлөн уламжлагч оролцсоноос 40 орчим лимбэч оролцож, 8 лимбэч, өвлөн уламжлагч төгсгөлийн шатанд шалгаран “СББӨ-ийг өвлөн уламжлагчийн батламж”-г гардан авав.
13. 2018 оны 10 сарын 2 нд лимбэч Ц.Цэвэгсүрэн “Лимбэ, лимбэдэх урлагийн судалгаа” сэдвээр докторын зэрэг хамгаалав.
14. 2018 оны 5 сарын 8-15 ны хооронд Алдарт лимбэч Л.Цэрэндоржийн 110 жилийн ойг улс орон даяаар тэмдэглэн өнгөрүүлсэн. /Үүнд улсын уралдаан 1, эрдэм шинжилгээний хурал 1/
15. 2019 оны 6 сарын 13 нд Төв аймгийн Сэргэлэн сумын соёлын төвийг Л.Цэрэндоржийн нэрэмжит болгон тохижуулав.
16. 2019 оны 8 сарын 19 нд Ховд аймгийн Мянгад сумын соёлыг төвийг алдарт лимбэч М.Бадамын нэрэмжит болгон тохижуулав.
17. 2019 оны 5 сарын 21-нд “Монгол лимбэчдийн уртын дуу лимбэдэх уламжлалт арга битүү амьсгааг өвлүүлэх, тогтворжуулах нь” төслийн нээлтийг Монголын театрын музейд зохион байгуулав.
18. 2019 оны 5 сарын 20-оос 6 сарын 16-ны хооронд лимбэ урлаачдын сургалтыг зохион байгуулав.

19. 2019 оны 5 сарын 23-аас 9 сарын 23-ны хооронд “Монгол лимбэчдийн уртын дуу лимбэдэх уламжлалт арга битүү амьсгааг өвлүүлэх, тогтворжуулах нь” төслийн хүрээнд нийт 15 аймгийн 24 сумын нутагт судалгаа хийв.
20. 2019 оны 5 сарын 23-аас 7 сарын 23-ны хооронд СУИС, МУК, МХО, Ховд, Завхан, Өмнөговь аймгуудад лимбэний сургалтын жишиг танхим байгуулж тохижуулав.
21. 2019 оны 10 сарын 16 нд НҮБ-ын танхимд “Лимбэдэх уламжлалт арга битүү амьсгаанд суралцах нь” гарын авлага, DVD номын нээлтийг хийж, төслийн явцыг танилцуулав.

### **В.3е. Төсвийн зарлага**

Үйл ажиллагаа бүрийг хэрэгжүүлэхэд зарцуулсан хөрөнгийн нарийвчилсан дүнг бичнэ үү (ам.доллар). Тус бүрийн санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлох (Засгийн газрын санхүүжилт, хамт олны дэмжлэг) \200-500 үгэнд багтаах\

Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас лимбэчдийг дэмжих төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэхэд тодорхой хэмжээний мөнгө хөрөнгө зарцуулж байсан боловч лимбэний битүү амьсгааны хамгаалах эрэлт хэрэгцээг бүрэн хангаж чадахгүй байгааг тэмдэглэх нь зүйтэй. 2014 онд Монгол Улсын Их хурлын чуулганаар шинэчлэн батлагдсан Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 41 дүгээр зүйлд Соёлын өвийн санхүүжилтийг улсын төсөв, орон нутгийн төсөв, Монгол Улсын болон гадаадын иргэн, олон улсын байгууллага, хуулийн этгээдээс олгосон хөрөнгө, хандив, тусламж, бусад эх үүсвэрээс санхүүжүүлнэ, 13 дугаар зүйлийн 13.1.13-д "соёлын өвийг Дэлхийн өвийн жагсаалтад бүртгүүлэхээр нэр дэвшүүлэх болон Дэлхийн өвийн жагсаалтад бүртгэгдсэн соёлын өвийг хадгалж хамгаалах, өвлөн уламжлуулах, түгээн дэлгэрүүлэхтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээг жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлэх" гэсэн заалтуудыг тусгасан байна. Мөн тус хуулийн 15 дугаар зүйлд Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрхэд "15.1.1. нутаг дэвсгэртээ соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, шаардлагатай төсөв хөрөнгийг баталж, хяналт тавих", 16 дугаар зүйлд Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрхэд "16.1.12. соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийг олж тогтоох, олон нийтэд таниулах, дэмжлэг үзүүлэх, өвлөн уламжлуулах ажлыг зохион байгуулах" тухай заалтуудыг тусгасан нь орон нутгийн төсвөөс соёлын биет бус өвийг хамгаалахад зарцуулах боломжийг олгож байна. Мөн хуулийн 40.5-д Соёлын биет бус өвийг үндэсний болон дэлхийн хэмжээнд сурталчлан алдаршуулах, түгээн дэлгэрүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан өвлөн уламжлагчийг жил бүр тодруулж, мөнгөн шагнал олгохоор анх удаа тусгасан нь соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн нийгмийн үнэлэмжийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой болно гэж үзэж байна. БСШУСЯ энэхүү мөнгөн шагнал олгох журмыг боловсруулсныг Монгол Улсын Засгийн газар батлан хэрэгжүүлж байна. 2015 -2019 онд Лимбэний битүү амьсгаа өвийг хадгалж, хамгаалах

чиглэлээр зохион байгуулсан үйл ажиллагаанд нийт 52 200 \$-г зарцуулсан байна. Үүнийг үйл ажиллагаа нэг бүрээр задалвал: (1 ам долларыг 2700₮)-өөр бодов.

- Л.Цэрэндоржийн 110 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх үйл ажиллагаанд нийт 25.000.000 төгрөг зарцуулав. Үүнээс лимбэчдийн улсын уралдаанд 17.000.000₮, Төв аймгийн Сэргэлэн сумын соёлын төвийг нэрэмжит болгон тохижуулах үйл ажиллагаанд 8.000.000₮. Үүнээс БСШУСЯ-аас 5.000.000₮, Төв аймгийн ЗДТГ, ИТХ-аас 4.500.000₮, Төв аймгийн нутгийн зөвлөлөөс 1.500.000₮, лимбэчид, төрийн бус байгууллагуудын хандив 14.000.000₮ байв.
- 2019 оны 8 сард алдарт лимбэчний алдрыг сурталчлах зорилгоор түүний төрсөн нутаг Ховд аймгийн Мянгад сумын соёлыг төвийг М.Бадамын нэрэмжит болгон тохижуулахад Ховд аймгийн ЗДТГ, ИТХ, үр хүүхэд, шавь нар, төрийн бус байгууллагуудын дэмжлэг 8.000.000₮-ийн санхүүжилтээр тохижуулав.
- Лимбэч Р.Эрдэнэлхагва гарын авлага, номыг 1200 \$-ийн санхүүжилтээр хэвлэв.
- Ц.Цэвэгсүрэнгийн “Лимбэнд зориулсан бүтээлүүд” номыг 1600 \$-ийн СУИС-ийн санхүүжилтээр,
- 2019 оны 5 сарын 21-нд “Монгол лимбэчдийн уртын дуу лимбэдэх уламжлалт арга битүү амьсгааг өвлүүлэх, тогтворжуулах нь” төслийн нээлтийг 500 \$.
- 2019 оны 5 сарын 20-оос 6 дугаар сарын 6-ны хооронд лимбэ урлаачдын сургалтыг 4000 \$ ийн санхүүжилтээр зохион байгуулав.
- 2019 оны 5 сарын 23-аас 9 сарын 23-ны хооронд “Монгол лимбэчдийн уртын дуу лимбэдэх уламжлалт арга битүү амьсгааг өвлүүлэх, тогтворжуулах нь” төслийн хүрээнд нийт 15 аймаг 8 сумын нутагт 9100 \$-ийн санхүүжилтээр судалгаа хийв.
- СУИС, МУК, МХО, Ховд, Завхан, Өмнөговь аймгуудад лимбэний сургалтын жишиг 5 танхимыг 6000 \$ байгуулж тохижуулав.
- Лимбэний битүү амьсгаа өвийн зохион байгуулалтын зардал болон багшийн урамшуулалд нийт 13000 \$-ийг зарцуулав.
- 2019 оны 10 сарын 16 нд НҮБ-ын танхимд “Лимбэдэх уламжлалт арга битүү амьсгаанд суралцах нь” гарын авлага, DVD номыг 4500 \$-ийн санхүүжилтээр хэвлэж нээлтийг зохион байгуулав.

### **В.3.f. Хамгаалалтын үйл ажиллагаануудын ерөнхий үр өгөөж**

Дээр дурдсан үр дүнд хүрэхийн тулд хэрэгжүүлсэн үйл ажиллагаануудын үр өгөөж, зохилдлогын талаарх ерөнхий үнэлгээ, хэм хэмжээг тодорхойлон тайлбарлана уу. Мөн үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэхэд зарцуулагдсан төсөв хэр бодитой туссан талаар тайлбар хийнэ үү. Үйл ажиллагаанууд нь зорьсон үр дүнд хүрэхэд хэрхэн хувь нэмрээ оруулсан, мөн адил үр дүнд хүрэхийн тулд өөр ямар бусад үйл ажиллагаануудыг авч хэрэгжүүлснээр илүү хувь нэмрээ өгөх байсан эсэх талаар тодорхой дурдана уу. Түүнчлэн бага төсөв, зардлаар адил үр дүнд хүрэх бололцоотой байсан эсэх, хүний нөөц хангалттай болон тохиромжтой байсан эсэх, мөн хамт олон, бүлэг, хувь хүмүүсийн оролцоо арай илүү идэвх, өргөн цар хүрээг хамарч болохоор байсан эсэх талаар дурдана уу.

Дээр дурьдсан хадгалалт, хамгаалалтын цуврал үйл ажиллагааны үр дүнд Монгол лимбэчдийн Уртын дуу хөгжимдэх уламжлалт арга барил- битүү амьсгааны оршин тогтнох чадварын түвшин дээшилж байна. Монгол лимбэний битүү амьсгааны уламжлалыг сэргээх, хамгаалах, сургах, судлах, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, оршин тогтнох чадварыг тогтворжуулах чиглэлд тодорхой хэмжээний ахиц гарав. Жишээлбэл:

**Бүртгэл, судалгааны хүрээнд:** Лимбэчдийн уртын дуу хөгжимдэх уламжлалт арга -битүү амьсгаа өвийг өвлөн уламжлагч болон өвлөн суралцагчийн бүртгэл, судалгааг жил бүр шинэчилж, өвийн холбогдолтой аман түүх цуглуулах, зарим өвлөн уламжлагчдын урын сан, хөгжимдэх арга барилын онцлогийг тодруулах баримтжуулалтын ажлыг жил бүр хийсэн нь өвийг хадгалж, хамгаалах чиглэлээр зохион байгуулж буй үйл ажиллагаанд бодитой хувь нэмэр оруулж байна.

**Албан болон албан бус сургалтын хүрээнд:** Лимбэчдийн уртын дуу хөгжимдэх уламжлалт арга -битүү амьсгаа өвийг албан сургалтын хүрээнд залуу хойч үед өвлүүлэн үлдээх ажил, СУИС, МУК, Завхан аймгийн ХБК зэрэг их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрийн хүрээнд тогтвортой зохион байгуулагдсан. Харин албан бус сургалтын тухайд сургалт явуулах боломжит хүний нөөц хүрэлцээтэй байсан хэдий ч тэдгээрт олгох урамшуулал, цалин хангалтгүй, сургалтыг зохион явуулах орчин хязгаарлагдмал, хөгжмийн зэмсгийн хүрэлцээ дутмаг зэрэг шалтгаанаас өвлөн уламжлагчдыг түшиглэсэн шавь сургалтыг хангалттай хэмжээнд зохион байгуулж, өвлөн суралцагчдын тоог нэмэгдүүлэхэд хүндрэл тулгарч байсан юм. Тиймээс цаашид энэхүү албан бус сургалтын үйл ажиллагааг тогтворжуулах, чанаржуулах, байнгын санхүүгийн эх үүсвэртэй болгох шаардлага байсаар байна.

**Судлах, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, алдаршуулах ажлын хүрээнд:** Энэхүү тайлангийн хугацаанд Лимбэчдийн уртын дуу хөгжимдэх уламжлалт арга -битүү амьсгаа өвийн судалгааны холбогдолтой эрдэм шинжилгээний хурал, нэг сэдэвт бүтээл, хэд хэдэн эрдэм шинжилгээний өгүүлэл, ном, гарын авлага хэвлэгдэж, өвийн холбогдолтой судалгаанд бодитой хувь нэмэр оруулсан ч энэ нь тодорхой өвлөн уламжлагчид, мэргэжлийн хүрээнд хэлэлцүүлэгдэж, ашиглагдаж байх талтай байна. Хэрэв эдгээр эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлийг хялбаршуулан тус өвийн талаарх олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхэд ашигласан бол хадгалалт, хамгаалалтын үйл ажиллагаа илүү үр дүнтэй болох боломжтой байсан юм.

Ахмад өвлөн уламжлагчдийг алдаршуулах зорилгоор Төв, Ховд аймагт соёлын төвүүдийг алдарт лимбэч Л.Цэрэндорж, М.Бадам нарын нэрэмжит болгон шийдвэрлүүлж, тохижолт хийн үйл ажиллагааг эхлүүлж, үзэсгэлэн зохион байгуулж, мэндэлсний ойг тэмдэглэн өнгөрүүлэх зэрэг үйл ажиллагааг зохион байгуулсан нь ахмад үеэсээ суралцах, хийж бүтээсэн зүйлүүдтэй нь танилцах, тэдний үр хүүхэд, нутаг орны иргэд, хамт олонтой хамтран ажиллах үйл ажиллагаанд эерэг хандлагыг бий болгосон юм. Гэсэн хэдий ч өвлөн уламжлагчдын амьдралын баталгааг хангах, тэдэнд өгөх урамшууллын



тогтолцоог бүрдүүлэхэд хууль эрхзүй, эдийн засгийн орчныг цаашид боловсронгуй болгох шаардлага байсаар байна.

Уралдаан тэмцээн, хурал зохион байгуулах, ном, гарын авлага хэвлэх, ахмад өвлөн уламжлагчдыг алдаршуулах, үзэсгэлэн гаргах, албан болон албан бус сургалт зохион байгуулах зэрэг эдгээр үйл ажиллагааг төрийн болон төрийн бус байгууллагууд, олон улсын байгууллагууд, дэмжигчид, өвлөн уламжлагчид, тэдний гэр бүл, орон нутгийн иргэд, шавь нар зэрэг олон талын оролцоотойгоор зохион байгуулсан ч санхүүгийн хувьд хүндрэлүүд байсан юм. Эдгээр үйл ажиллагааг өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан, хамгийн бага зардлаар зохион байгуулсан бөгөөд цаашид өвийн оршин тогтнох байдлыг тогтвортой хадгалахад зарцуулах төсөв, хөрөнгийг нэмэгдүүлэх шаардлагатай юм.

Эдгээр хадгалалт, хамгаалалтын үйл ажиллагаа үр өгөөжтэй байж, өвийн оршин тогтнох чадвар тогтворжиж байгаа нь өвийг хамгаалахад оролцогч талуудын оролцоо, идэвхи санаачлага хангалттай сайн байсантай шууд холбоотой юм.

### **С. Хамгаалах үйл ажиллагааны шинэчлэл**

#### **С.1 Хамгаалалтын шинэчилсэн төлөвлөгөө**

Нэр дэвшүүлэх баримт бичиг эсвэл өмнөх тайланд дурдагдсан т хамгаалалтын арга хэмжээг хэрхэн сайжруулж, боловсронгуй болгосон тухай дурдана уу. Дараах байдлаар мэдээллийг өгнө үү. Үүнд:

- a. Ямар зорилго, зорилт дэвшүүлж, ямар үр дүн хүлээгдэж буй тухай
- b. Зорилтот үр дүнд хүрэхийн тулд ямар гол үйл ажиллагааг, хэрхэн хэрэгжүүлэх тухай, үйл ажиллагааг нарийвчлан тайлбарлах ба хамгийн сайн дэс дарааллаар нь боломжит байдлаар тусгах.
- c. Оролцогч тал нь хамгаалалтын шинэчилсэн төлөвлөгөөний хэрэгжилтийг хэрхэн дэмжих вэ \200-500 үгэнд багтаах\

Хамгаалалтын шинэчилсэн төлөвлөгөөг нэр дэвшүүлсэн баримт бичиг болон өмнөх тайланд дурдагдсан хамгаалалтын арга хэмжээг сайжруулж, Монгол Улсын Засгийн Газраас баталсан “Соёлын биет бус өвийг хамгаалах тухай” үндэсний хөтөлбөр болон “Монгол лимбэчдийн уртын дуу лимбэдэх уламжлалт арга битүү амьсгааг өвлүүлэх, тогтворжуулах нь” төслийн хүрээнд хэрэгжих хадгалалт, хамгаалалтын үйл ажиллагаатай уялдуулан шинэчлэн гаргав.

Энэхүү шинэчилсэн төлөвлөгөөний зорилго нь:

- a.) Монгол ардын уртын дуу тоглох уламжлалт арга лимбэний битүү амьсгаанг бүртгэл судалгаа, баримтжуулалтыг шинэчлэх, хойч үед албан болон албан бус сургалтаар дамжуулан өвлүүлэн уламжлуулах, судлах, сурталчлах, оршин тогтнох чадварыг бэхжүүлэх, үзлэг тооллого зохион явуулах, олон нийтийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх,

Шинэчилсэн төлөвлөгөөний зорилт нь:

- Өвийн-өвлөн уламжлагчийн бүртгэл, судалгааг шинэчлэх,
- Лимбэний битүү амьсгааг хойч үед өвлүүлэх,
- Мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, түгээн дэлгэрүүлэх, сурталчлах,
- Өвийн холбогдолтой судалгааг эрчимжүүлэх,
- Оршин тогтнох чадварыг бэхжүүлэх.

Хүлээгдэж буй үр дүн:

- Өвлөн уламжлагчдын бүртгэл, судалгаа тогтмол шинэчлэгдэнэ.

- Олон нийтийг мэдлэг ойлголт нэмэгдэж тухайн өвийг сонирхогч, судлаач нарын тооны өсөлт нэмэгдэнэ.
- Өвийн оршин тогтнох чадвар бэхжинэ.
- Өвлөн суралцагчдын тооны өсөлт, ур чадварын түвшин нэмэгдэнэ.
- Өвийн холбогдоолтой судалгааны ажилд ахиц дэвшил гарна.
- Үзлэг тооллогын үр дүнд суурилсан оновчтой хадгалалт хамгаалалтын төлөвлөгөө бий болно.
- Дээрх үйл ажиллагааг хэрэгжүүлснээр тухайн өвийг Яаралтай хамгаалах шаардлагатай СББӨ-ийн жагсаалтаас Төлөөллийн жагсаалтад шилжүүлэх боломжыг тодорхойлно.

b) Зорилтот үр дүнд хүрэх зорилгоор дараах үйл ажиллагааг зохион байгуулна:

Үүнд:

- Олон нийтийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх, сурталчлах чиглэлээр олон нийтийг хамарсан аян зохион байгуулах,
- Цуврал нэвтрүүлэг бэлтгэж, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацах,
- Монгол ардын уртын дуу тоглох уламжлалт арга лимбэний битүү амьсгаа өвийн үүсэл, түүх, домгийг харуулсан хүүхэдэйн киног 4-7 настай хүүхдэд зориулан бүтээх,
- Баримтат кино бүтээх,
- Харьцуулсан судалгааны ажлыг ОХУ-ын Тува, Буриад, Халимаг, БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орон, Шиньжаан Уйгарт зохион байгуулах,
- Харьцуулсан судалгааны үр дүнг ашиглан ном, CD хэвлэх,
- Монгол ардын уртын дуу тоглох уламжлалт арга лимбэний битүү амьсгаа өвийн өвлөн уламжлагч, өвлөн суралцагчийн дунд бүсчилсэн уралдаан зохион байгуулах,
- Монгол ардын уртын дуу тоглох уламжлалт арга лимбэний битүү амьсгаа өвийн судлаач, өвлөн уламжлагчдын дунд эрдэм шилжилгээний хурал зохион байгуулах.

c) Монгол Улсын Засгийн Газар, БСШУСЯ, ЗГХА-ны СУГ, СӨҮТ, ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комисс, “Монголын Лимбэчдийн Холбоо” ТББ, өвлөн уламжлагчид, өвлөн суралцагчид, судлаачид дээрхи хадгалалт, хамгаалалтын шинэчилсэн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд бодлогын, зохион байгуулалтын, санхүү, хөрөнгө оруулалтын бүх талын дэмжлэгийг үзүүлэн ажиллана.

## **С.2 Цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө**

Шинэчилсэн хамгаалах төлөвлөгөөний хуваарь (ойрын 4 жилээр)

\200-500 үгэнд багтаах\

- ЮНЕСКО-гийн Лимбэний битүү амьсгаа өвийг түгээн дэлгэрүүлэх сурталчлах чиглэлээр зорилтот төслүүдийг 2019-2023 онд хэрэгжүүлнэ (СББӨ-ийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.4.2).

- “Лимбэ- Лимбэний битүү амьсгаа” аяныг 2022 онд зохион байгуулна. (СББӨ-ийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 3.3.5).
- Лимбэний битүү амьсгааг хүүхэд залууст сурталчлан таниулах баримтат кино бүтээж олон нийтийн хүртээл болгоно. (СББӨ-ийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 3.4.1).
- Лимбэний битүү амьсгааг өвлүүлэх зорилгоор албан болон албан бус сургалтын хөтөлбөрийг боловсруулж зорилтот сургуулиудын сургалтын хөтөлбөрт тусгана.
- Лимбэний битүү амьсгааг өвийн үзлэг, тооллогыг улсын хэмжээнд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн хүрээнд 2020, 2023 онуудад хийнэ.
- Лимбэний битүү амьсгаа өвийг өвлүүлэх зорилгоор шавь сургалтыг 2019-2021 оны хооронд зохион байгуулах.
- Лимбэчдийн хуучны уртын дууны урын санг сурвалжлан олох, баримтжуулах, цуглуулах судалгааны ажлыг 2019-2020 онд зохион байгуулна.
- Олон нийтийн ойлголтыг дээшлүүлэх зорилгоор хэвлэл, мэдээллийн хэрэгслүүд, телевизээр цуврал баримтат нэвтрүүлэгийг 2019, 2020 онд хийнэ.
- "Тогтвортой хөгжил ба Монгол лимбэчдийн уртын дуу хөгжимдөх уламжлалт арга барил- битүү амьсгаа" сэдвээр эрдэм шинжилгээний хурлыг 2021 онд зохион байгуулах.
- "Монгол лимбэчдийн бүтээлийн дээжис" CD-г 2020 онд хэвлүүлнэ.
- Лимбэчдийн намтар, танилцуулга бүхий номыг 2020 онд хэвлүүлнэ.
- “Монгол лимбэчдийн уртын дуу хөгжимдөх уламжлалт арга барил- битүү амьсгаа” өвийн өвлөн уламжлагчдын дунд уралдаант наадмыг 2021 онд зохион байгуулна.
- Лимбэний битүү амьсгаа өвийн өвлөн уламжлагчдын бүртгэл, мэдээллийн санг үүсгэх, баяжуулах үйл ажиллагааг 2019-2023 онд хийж гүйцэтгэхээр төлөвлөж байна.
- Монгол ардын уртын дуу тоглох уламжлалт арга лимбэний битүү амьсгаа өвийн үүсэл, түүх, домгийг харуулсан хүүхэлдэйн киног 4-7 настай хүүхдэд зориулан бүтээх ажлыг 2020-2023 онд хийнэ.
- Монгол ардын уртын дуу тоглох уламжлалт арга лимбэний битүү амьсгаа өвийн харьцуулсан судалгааны ажлыг ОХУ-ын Тува, Буриад, Халимаг, БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орон, Шиньжаан Уйгарт зохион байгуулах ажлыг 2021-2023 онд зохион байгуулна.

### С.3 Цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөв

Хамгаалалтын шинэчилсэн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай урьдчилсан төсвийг бичнэ үү (ам.доллар). Тус бүрийн санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлох (Засгийн газрын санхүүжилт, хамт олны дэмжлэг)

Соёлын биет бус өвийг хамгаалах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төсөв, Гадаад, дотоодын төсөл, хөтөлбөр, ТББ-уудын санхүүгийн эх үүсвэрээс бүрдэнэ.

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Эх үүсвэр	Төсөв /\$/
1	Лимбэний битүү амьсгаа өвийг түгээн дэлгэрүүлэх сурталчлах чиглэлээр зорилтот төслүүдийг хэрэгжүүлнэ.	2019-2023	Улсын төсөв	8 000
2	“Лимбэ- Лимбэний битүү амьсгаа” аяныг зохион байгуулна	2022	Улсын төсөв Хандив тусламж	10 000
3	Лимбэний битүү амьсгааг хүүхэд залууст сурталчлан таниулах баримтат кино бүтээнэ.	2021	Улсын төсөв Төслийн санхүүжилтээр	3 500
4	Лимбэний битүү амьсгааг өвлүүлэх зорилгоор албан болон албан бус сургалтын хөтөлбөрийг боловсруулж зорилтот сургуулиудын сургалтын хөтөлбөрт тусгана.	2021	Улсын төсөв Бусад эх үүсвэр	2 000
5	Лимбэний битүү амьсгаан өвийн үзлэг, тооллогыг улсын хэмжээнд хийх	2020, 2023	Улсын төсөв Бусад эх үүсвэр	18 000
6	Лимбэний битүү амьсгаа өвөөр шавь сургалт зохион байгуулах	2019-2021	Төслийн санхүүжилтээр	35 000
7	Лимбэчдийн хуучны уртын дууны урын санг сурвалжлан олох, баримтжуулах, цуглуулах судалгааны ажлыг зохион байгуулах зардал:	2019-2020	Улсын төсөв Төслийн санхүүжилтээр	11 000

8	Хэвлэл, мэдээллийн хэрэгслүүд, телевизээр цуврал баримтат нэвтрүүлэг хийх	2019-2020	Улсын төсөв Төслийн санхүүжилтээр	1 200
9	“Тогтвортой хөгжил ба Монгол лимбэчдийн уртын дуу хөгжимдөх уламжлалт арга барил-битүү амьсгаа” сэдвээр эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах.	2021	Төслийн санхүүжилтээр Бусад эх үүсвэр	1 600
10	“Монгол лимбэчдийн бүтээлийн дээжис” CD хэвлүүлэх.	2020	Төслийн санхүүжилтээр Бусад эх үүсвэр	6220
11	Лимбэчдийн намтар, танилцуулга бүхий ном хэвлүүлэх;	2020	Төслийн санхүүжилтээр Бусад эх үүсвэр	3 450
12	“Монгол лимбэчдийн уртын дуу хөгжимдөх уламжлалт арга барил-битүү амьсгаа” өвийн өвлөн уламжлагчдын дунд уралдаант наадам зохион байгуулах;	2021	Улсын төсөв Төслийн санхүүжилтээр Бусад эх үүсвэр	14 000
13	Лимбэний битүү амьсгаа өвийн өвлөн уламжлагчдын бүртгэл, мэдээллийн сан үүсгэх.	2019-2023	Улсын төсөв Төслийн санхүүжилтээр	4 000
14	Монгол ардын уртын дуу тоглох уламжлалт арга лимбэний битүү амьсгаа өвийн үүсэл, түүх, домгийг харуулсан хүүхэддэйн киног 4-7 настай хүүхдэд зориулан бүтээх	2020-2023	Улсын төсөв Бусад эх үүсвэр	25000
15	Монгол ардын уртын дуу тоглох уламжлалт арга лимбэний битүү амьсгаа өвийн харьцуулсан судалгааны ажлыг ОХУ-ын Тува, Буриад, Халимаг, БНХАУ-ын	2021-2023	Улсын төсөв Бусад эх үүсвэр	72000

	Өвөр Монголын Өөртөө Засах Орон, Шиньжаан Уйгарт зохион байгуулах			
	<b>Нийт дүн</b>			<b>214 970\$</b>

#### **С.4. Хамт олны оролцоо**

Хамт олон, бүлэг, хувь хүмүүс, төрийн бус байгууллага болон жендэрийн үүргийн хувьд хэрхэн хамгаалалтын шинэчилсэн төлөвлөгөөнд оролцож байгааг тайлбарлах, цаашид хэрэгжилтэд хэрхэн оролцох талаар бичнэ үү.

\200-500 үгэнд багтаах\

Энэхүү шинэчилсэн үйл ажиллагааны төлөвлөгөөг БСШУСЯ, СӨҮТ, МҮК, ЗГХА СУГ, Монголын Лимбэчдийн холбоо ТББ, “Үхэрчин хүү Л.Цэрэндорж” ТББ, өвлөн уламжлагчдын ахмад болон залуу үеийн төлөөлөл, холбогдох төрийн байгууллагууд, эрдэмтэн судлаачдын санал, Монгол улсын засгийн газраас хэрэгжүүлж буй “Соёлын биет бус өвийг хамгаалах үндэсний хөтөлбөр”-тэй уялдуулан хамтран боловсруулав.

БСШУСЯ нь хууль эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх, бодлого боловсруулах, шаардлагатай төсвийг улсын төсөвт суулгах, хяналт тавих, ЗГХА СУГ Үндэсний хэмжээний үйл ажиллагааг удирдлага, арга зүйгээр хангаж хэрэгжүүлнэ. СӨҮТөв нь Олон нийтийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх, сурталчлах чиглэлээр олон нийтийг хамарсан аян зохион байгуулах, цуврал нэвтрүүлэг, баримтат кино, ном, CD бүтээх, Судалгааны ажлыг эрчимжүүлж үзлэг, тооллого зохион байгуулах, өвлөн уламжлуулах зорилгоор шавь сургалтыг зохион байгуулах, лимбэчдийн дунд үндэсний хэмжээний уралдаант наадам, эрдэм шилжилгээний хурал зохион байгуулах зэрэг олон талт үйл ажиллагааг гардан хэрэгжүүлнэ. Дээрхи ажил, арга хэмжээнээс Соёлын өвийг хамгаалах тухай хуульд заасан чиг үүргийн байгууллагатай зөвшилцөж, хамтарч зохион байгуулж гүйцэтгэнэ.

Монголын Лимбэчдийн холбоо ТББ нь Лимбэний битүү амьсгаа өвийг хадгалж хамгаалах зорилгоор 2007 онд байгуулагдсан тогтвортой үйл ажиллагаа явуулдаг цорын ганц ТББ юм. Энэхүү ТББ нь энэхүү төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлэх, мэргэжлийн арга зүйгээр хангах, сургалт судалгааны ажлыг бие даан болон өвлөн уламжлагч, холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх үүрэг хүлээж байна. “Үхэрчин хүү Л.Цэрэндорж” ТББ нь Лимбэний нэрт зүтгэлтэн, мэргэжлийн лимбэний сургалтыг үндэслэгч Л.Цэрэндорж асантай холбоотой үйл ажиллагаануудад дэмжлэг үзүүлэх байдлаар хамтран оролцно.

Өвлөн уламжлагчид нь лимбэний битүү амьсгааг үндэсний болон олон улсын хэмжээнд түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, өвлүүлэх үүргийг хүлээсэн ба бусад хадгалалт хамгаалалтын төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагаанд идэвхитэй оролцох үүргийг хүлээж байна.

Лимбэний битүү амьсгаа өвийг өвлөн уламжилж байгаа өвлөгчдийн хүйсийн харьцааг авч үзвэл нийт 168 өвлөгчдийн 8 нь эмэгтэй буюу 5 хүрэхгүй хувь нь эмэгтэй хүн байна. Эмэгтэй өвлөгчдийн тоо харьцангуй бага байгаа нь тухайн өвийн хөгжиж ирсэн уламжлалын нөлөө, /албан сургалтаар 2004 оноос эмэгтэй

суралцагч сурч эхэлсэн/ лимбэ хөгжмийг үлээх арга техник нь тухайн өвлөгчөөс амьсгаа, үлээлтийн нилээдгүй хүч шаарддаг онцлогтой тул тэр бүр эмэгтэй хүн суралцах нь ховор байдагтай холбоотой юм. Эдгээр эмэгтэй өвлөгчид нь энэхүү өвийг судлах, сурталчилах, өвлүүлэн үлдээх, түгээн дэлгэрүүлэх зэргээр шинэчилсэн төлөвлөгөөнд тодорхой хувь нэмэр оруулна.

### **С.5. Холбогдох албан байгууллагууд**

Яаралтай хамгаалах шаардлагатай СББӨ-ийн жагсаалтад бүртгэгдсэн элемент, орон нутгийн менежментэд хариуцагч бүхий албан байгууллагуудын талаар тайлагнана уу. Үүнд:

а. тухайн өвийг хамгаалах эсхүл түүний менежментэд оролцсон эрх бүхий байгууллага(ууд);

б. тухайн өвийн элемент, түүнийг хамгаалахад чиглэсэн бүлэг эсхүл хамт олны байгууллага(ууд).

\150 үгэнд багтаах\

#### **а) БСШУСЯ-НЫ СОЁЛ, УРЛАГИЙН БОДЛОГЫН ГАЗАР**

**Хаяг:** Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу-44, Засгийн газрын III байр

СББӨ хариуцсан мэргэжилтэн: Г.Ичинхорлоо

**Утас:** +976- 51-262467

**Факс:**976-11-323158

**Емэйл:** [Info@mecs.gov.mn](mailto:Info@mecs.gov.mn)

#### **б) ЗГХА СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН СОЁЛ, СОЁЛЫН ӨВИЙН ХЭЛТЭС**

**Хаяг:** Улаанбаатар-15160, Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр, ББӨ-ийн бодлогын хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн: Д.Мэндсайхан

**Утас:** +976- 51-264943

**Емэйл:** [Mendsaikhan@culture.gov.mn](mailto:Mendsaikhan@culture.gov.mn)

**Вэб:** [www.culture.gov.mn](http://www.culture.gov.mn)

### **СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ**

**Хаяг:** Монгол улс, 21 06 20а, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Сүхбаатарын талбай 3, Жамъяангийн гудамж, Соёлын Төв Өргөө “Б” хэсэг, Соёлын Өвийн Төв Шуудангийн хаяг: Сүхбаатарын талбай 3, СБ дүүрэг Улаанбаатар 21 06 20а, Монгол улс

**Захирал:** Г.Энхбат.

**Утас:** + 976-11-312-735

+ 976- 70110877

**Факс:** 976-11-312735

**Email:** [cch@monheritage.mn](mailto:cch@monheritage.mn)

**Web:** <http://ncch.gov.mn/>

**Мэргэжилтэн:** Ц.Цолмон

СӨҮТ-ийн Соёлын өвийг авран хамгаалах газрын Дэлхийн Өвийн дурсгал хариуцсан мэргэжилтэн

**Утас:** + 976-99057308

**E-mail:** [tsolmon.ncch@gmail.com](mailto:tsolmon.ncch@gmail.com)

## ЮНЕСКО-ГИЙН МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ КОМИСС

**Мэргэжилтэн:** Ч.Цэцэгбаатар Соёлын асуудал эрхэлсэн мэргэжилтэн

**Утас:** + 976-70105652  
+ 976- 88094552

**Факс:** 976-11-322612

**Email:** [ch.tsetsegbaatar@unesco.mn](mailto:ch.tsetsegbaatar@unesco.mn)

b) тухайн өвийн зүйлийг төлөөлж хамгаалах үүрэг хүлээсэн бүлэг эсвэл хамт олны байгууллага

### **TSEVEGSUREN Tserenbaljir**

Director of Mongolian Association of Limbe Performers

Address: Ulaanbaatar city, Chingeltei District, Baga Toiruu street 46, National University of Mongolia Arts and Culture, room 310

Tel : +976-99182023

c) E-mail: [ts\\_limbe@yahoo.com](mailto:ts_limbe@yahoo.com)

### **D. Энэ тайланг бэлтгэхэд оролцсон хамт олны оролцоо**

Энэхүү тайланг бэлтгэх явцад холбогдох хамт олон, бүлэг, хувь хүмүүс, төрийн бус байгууллагын аль болох өргөн оролцоог ханган баталгаажуулах талаар авсан арга хэмжээнүүдийн талаар тайлбар хийнэ үү.

\150-200 үгэнд багтаах\

Монгол улсын БСШУСЯ, ЗХГА-ны СУГ, ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисс, Соёлын өвийн үндэсний төв, Монголын лимбэчдийн холбоо, СУИС, МУК, МХО, Завхан аймгийн ХБК, лимбэч, өвлөн уламжлагч Ц.Цэвэгсүрэн, Р.Эрдэнэлхагва, Б.Мягмарцэрэн зэрэг хувь хүмүүс биечлэн оролцов.

### **E. Оролцогч талыг төлөөлсөн гарын үсэг**

Энэхүү тайланд тухайн улсыг төлөөлж буй эрх бүхий албан тушаалтан өөрийн нэр, албан тушаалыг тэмдэглэж гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

**Нэр: Ё.БААТАРБИЛЭГ**

**Албан тушаал: БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙД**

**Огноо: 2019.12.15**

**Гарын үсэг:**

-----oOo-----



### МОНГОЛ УЛСААС ДЭЛХИЙН ӨВИЙН КОНВЕНЦИЙН УРЬДЧИЛСАН ЖАГСААЛТАД БАГТСАН “БУГАН ХӨШӨӨ БҮХИЙ ХҮРЛИЙН СОЁЛЫН ЦОГЦОЛБОР ДУРСГАЛУУД” ӨВД “ХӨШӨӨ ДУРСГАЛТ ГАЗРУУДЫН ОЛОН УЛСЫН ЗӨВЛӨЛ”-ӨӨС ТЕХНИКИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН ТАЙЛАН

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 07 сарын 31-ний өдрийн А/481 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг 2019 оны 8 дугаар сарын 13-наас 22-ны өдрүүдэд Дэлхийн өвийн жагсаалтад бүртгүүлэхээр нэр дэвшүүлсэн “Буган чулуун хөшөө бүхий хүрлийн үеийн цогцолбор” өвийг “Хөшөө дурсгалт газруудын олон улсын зөвлөл”-өөс Техникийн Үнэлгээ хийхээр томилогдсон шинжээч Хаяаши Тошиод танилцуулах ажлыг зохион байгууллаа. Шинжээчийн дурсгалт газарт техникийн үнэлгээ хийх ажлыг БСШУСЯ-ны Соёл, урлагийн бодлогын газар, ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисс, ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн, Соёлын өвийн үндэсний төв, Байгаль соёлын өвийг хамгаалах сан ТББ-ийн төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг. Энэхүү ажлын хүрээнд ажлын хэсэг Улаанбаатар хот, Архангай аймгийн төв Цэцэрлэг хот, тус аймгийн Их Тамир, Өндөр-Улаан сум болон Хөвсгөл аймгийн Мөрөн хот, мөн тус аймгийн Бүрэнтогтох суманд хавсралт дахь хөтөлбөр (1 дүгээр хавсралт)-ийн дагуу хавсралт дахь бүрэлдэхүүн (2 дугаар хавсралт)-тэй ажиллав.

Шинжээч Хаяаши Тошио 2019 оны 8 дугаар сарын 13-ны өдөр Монголд Улсад хүрэлцэн ирсэн бөгөөд ажлын хэсгийн зүгээс ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулах, Техникийн Үнэлгээ хийх ажилд зориулан боловсруулсан хөтөлбөрийг зөвлөлдөх уулзалтыг 8 дугаар сарын 14-ний өдөр Соёлын өвийн үндэсний төв дээр зохион байгуулав.



Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулж, хөтөлбөрийн талаар зөвлөлдсөний дараа, Монгол Улсын Засгийн газар, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны зүгээс соёлын өв, ялангуяа чулуун соёлын өвийг хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа, 2019 оны 2 дугаар сарын 13-ны өдөр Засгийн газрын 69 дүгээр тогтоолоор батлагдсан “Чулуун соёлын өв” үндэсний хөтөлбөр, хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, “Буган чулуун хөшөө бүхий хүрлийн үеийн цогцолбор” номинацид багтсан 3 дурсгалт газарт хийгдэхээр төлөвлөгдсөн үйл ажиллагааг шинжээчид танилцуулж, мэдээлэл өгөв.



Мөн өдөр, хөтөлбөрийн дагуу Дэлхийн өвийн үндэсний хорооны дарга бөгөөд Гадаад харилцааны дэд сайд Б.Батцэцэг шинжээч Хаяаши Тошиог Гадаад Харилцааны Яамны байранд хүлээн авч, уулзан Техникийн Үнэлгээ хийх ажлын талаар яриа өрнүүлэв.




2019 оны 8 дугаар сарын 15-ны өдөр ажлын хэсгийн гишүүд шинжээчийн хамт Архангай аймаг руу хөдөлж, замдаа Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутагт орших Хархорум музейг үзэж танилцав. Хархорин музейг үзэж танилцсаны дараа хөтөлбөрийн дагуу Архангай аймгийн Цэцэрлэг хотод буудаллав.



2019 оны 8 дугаар сарын 16-ны өглөө өдөр ажлын хэсэг шинжээчийн хамт Архангай аймгийн Засаг Даргын Тамгын газрын дарга, Боловсрол, соёл, урлагийн газрын дарга, Нийгмийн бодлогын хэлтсийн дарга болон бусад холбогдох мэргэжилтнүүдтэй уулзав. Уулзалтын үеэр Дэлхийн өвд бүртгүүлэхээр нэр дэвшүүлсэн “Буган чулуун хөшөө бүхий хүрлийн үеийн цогцолбор” өвийн номинацид багтсан Их Тамир сумын “Цацын эрэг” буюу Хойд Тамирын хөндийн буган чулуун хөшөөний дурсгалт газар, Өндөр-Улаан сумын Хануй багийн нутагт орших “Жаргалантын ам”-ны дурсгалт газарт техникийн үнэлгээ хийх ажлыг танилцуулж, аймаг, орон нутгийн зүгээс дээрхи дурсгалт газруудыг хадгалж, хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлж буй үйл ажиллагааг сонсож, танилцлаа.



Уулзалтын дараа ажлын хэсэг болон шинжээч Архангай аймгийн музейд байх буган чулуун хөшөөг үзэв.



Дараа Их Тамир сумын “Цацын эрэг” буюу Хойд Тамирын хөндийн буган чулуун хөшөөний дурсгалт газарт ажиллав. Дурсгалт газарт ажлын хэсэг, шинжээчээс гадна Архангай аймгийн ЗДТГ, Нийгмийн бодлогын хэлтэс, БСУГ, музей, Их Тамир сумын ЗДТГ, ИТХ, сумын Соёлын төвийн төлөөлөл, байгал орчны байцаагч нар хамтран ажиллав.



Шинжээч Хаяаши Тошио, “Цацын эрэг”-ийн дурсгалт газрын хамгаалалтын болон орчны бүсийн дотор орших буган чулуун хөшөө, хиргисүүр, хадны зургийн байршил, тоог ширхэгийг номинацийн материалд хавсаргасан газрын зураг дээрхи тэмдэглэгээтэй тулгаж, орчны бүсийн гадна орших дурсгалын талаар зарим тодруулгыг холбогдох мэргэжилтэн, сум, орон нутгийн удирдлагаас авсан юм.



Мөн тус дурсгалт газар ажиллах үеэрээ шинжээч нүүрсний уурхайн ашиглалтын талаар тодруулав. Тус сумын нутагт байх нүүрсний уурхайн нөөц багассан, мөн гүний ус гарсан зэрэг шалтгаанаар ашиглагдахгүй байгааг, цаашид ашиглагдахгүй гэдгийг нутгийн удирдлагууд хэлж байв. Мөн чулуу олборлож байсан орд газрыг очиж үзэв.



Дараа нь “Цацын Эрэг”-ийн дурсгалт газрын орчны бүсэд байх Шивэртийн Амны буган чулуун хөшөөний дурсгалт газарт очиж, дурсгалын хадгалалт, хамгаалалтын нөхцөл байдалтай танилцаж, газрын зурагтай тулгах ажлыг хийв.



2019 оны 8 дугаар сарын 17-ны өдөр хөтөлбөрийн дагуу Архангай аймгийн Өндөр-Улаан сумын нутагт орших Жаргалантын Амны дурсгалт газарт ажиллав. Дурсгалт газарт ажлын хэсэг, шинжээчээс гадна Өндөр-Улаан сумын ЗДТГ, ИТХ, БСГ, Соёлын төвийн төлөөлөл болон Хануй багийн засаг дарга хамтран ажиллав. Дурсгалт газарт ажиллах үеэр Хануй багийн иргэд, удирдлага ажлын хэсгийг тусгайлан хүлээн авч, “Буган чулуун хөшөө бүхий хүрлийн үеийн цогцолбор” өвийг Дэлхийн өвийн жагсаалтад бүртгүүлэх гэж байгаад талархалтай буйгаа илэрхийлсэн юм.



Шинжээч “Жаргалантын Ам”-ны дурсгалт газрын хамгаалалтын болон орчны бүсийн дотор орших буган чулуун хөшөө, хиргисүүрийн байршил, тоог ширхэгийг номинацийн материалд хавсаргасан газрын зураг дээрхи тэмдэглэгээтэй тулгаж, орчны бүсийн гадна орших дурсгалын талаар зарим тодруулгыг холбогдох мэргэжилтэн, сум, орон нутгийн удирдлагаас авав.



Дурсгалт газар ажиллаж дуусаад Хөвсгөл аймгийн Мөрөн хот руу хөдлөв. Хөтөлбөрийн дагуу 2019 оны 8 дугаар сарын 18-ны өдөр Мөрөн хотод ирж, Хөвсгөл аймгийн музейг үзэж, тус музейд байх “Уушгийн өвөр”-ийн дурсгалт газрын 14-р буган чулууны хэсгийг үзэв.



8 дугаар сарын 19-ний өглөө Хөвсгөл аймгийн ЗДТГ, ИТХ, БСГ, музей, Бүрэнтогтох сумын засаг дарга болон “Хөвсгөл Далай Ээж” ТББ-тай хамтарсан уулзалт хийв. Уулзалтын үеэр Дэлхийн өвд бүртгүүлэхээр нэр дэвшүүлсэн “Буган чулуун хөшөө бүхий хүрлийн үеийн цогцолбор” өвийн номинацид багтсан Бүрэнтогтох сумын нутагт орших “Уушгийн өвөр”-ийн буган чулуун хөшөөний дурсгалт газарт техникийн үнэлгээ хийх ажлыг танилцуулж, аймаг, орон нутгийн зүгээс дээрхи дурсгалт газруудыг хадгалж, хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлж буй үйл ажиллагааг сонсож, танилцлаа.



Уулзалтын дараа Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын нутагт орших “Уушгийн өвөр”-ийн дурсгалт газарт ажиллав. Дурсгалт газарт ажлын хэсэг, шинжээчээс гадна

Хөвсгөл аймгийн ЗДТГ, ИТХ, БСГ, музей, Бүрэнтогтох ЗДТГ, ИХТ, Соёлын төв, Туяа багийн засаг дарга, байгаль орчны байцаагч болон “Хөвсгөл Далай Ээж” ТББ-ын төлөөлөл хамтран ажиллав. Шинжээч дурсгалт газарт ажиллах үеэрээ хадгалалт, хамгаалалтын өнөөгийн нөхцөл байдалтай танилцаж, хамгаалалтын болон орчны бүсийн дотор болон гадна орших дурсгалын байршил, тоо, хэмжээг нягталж, газрын зурагтай тулгах, тэмдэглэх ажлыг хийв.



Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Соёлын өвийн үндэсний төвийн Соёлын биет өвийг сэргээн засварлах газрын Ерөнхий технологич М.Оюунтулга оролцож, хадгалалт, хамгаалалтын холбогдолтой нарийвчилсан мэдээлэл цуглуулах, хадгалалтын хамгаалалтын өнөөгийн нөхцөл байдлыг дүгнэх, чулуулгийн онцлог, эвдрэл гэмтлийн мэдээллийг цуглуулах, цаашдын хадгалалт, хамгаалалтын арга ажиллагаа боловсруулав (хавсралт 3). тайлбарыг шинжээчид өгөхөд чухал үүрэг гүйцэтгэв. Дээрхи 3 дурсгалт газарт хадгалалт, хамгаалалтын судалгаа хийж,

Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын нутагт орших “Уушгийн Өвөр”-ийн дурсгалт газарт ажилласнаар дурсгалт газарт ажиллах хөтөлбөр өндөрлөж, Улаанбаатар хотод хөтөлбөрийн дагуу ажилласан юм.

2019 оны 8 дугаар сарын 21-ний өдөр , хөтөлбөрийн дагуу БСШУС-ын дэд сайд Г.Ганбаяр шинжээчийг БСШУСЯ-ны байранд хүлээн авч уулзаж, “Техникийн Үнэлгээ”-ний талаар санал солилцов.





Шинжээч Хаяаши Тошио ажлын хэсгээс “Буган чулуун хөшөө бүхий хүрлийн үеийн цогцолбор” номинацийн материалд дараах 11 асуулгын дагуу тодруулга (Хавсралт 3) шаардлагатай байгааг мэдэгдэж, тодруулгыг 2019 оны 09 дүгээр сарын 01-ний дотор илгээхийг хүссэн юм. Ажлын хэсгийн гишүүд өөрсдийн чиглэлийн дагуу нэмэлт тодруулгыг хийн, Англи хэл рүү орчуулж (Хавсралт 4) шинжээч Хаяаши Тошиод хүргүүлсэн болно.

Хөшөө дурсгал, дурсгалт газруудын олон улсын зөвлөл (ICOMOS)-ийн шинжээч тус техникийн үнэлгээний тайланг Дэлхийн өвийн хороонд хүргүүлэх бөгөөд 2020 онд болох Дэлхийн Өвийн Хорооны ээлжит хурлаар “Буган хөшөө бүхий хүрлийн соёлын цогцолбор дурсгалууд” өвийг Дэлхий Өвд бүртгэх эсэх асуудлыг хэлэлцэх юм.

Хавсралт №1

**МОНГОЛ УЛСААС ДЭЛХИЙН ӨВИЙН КОНВЕНЦИЙН УРЬДЧИЛСАН  
ЖАГСААЛТАД БАГТСАН “БУГАН ХӨШӨӨ БҮХИЙ ХҮРЛИЙН СОЁЛЫН  
ЦОГЦОЛБОР ДУРСГАЛУУД” ӨВД “ХӨШӨӨ ДУРСГАЛТ ГАЗРУУДЫН ОЛОН  
УЛСЫН ЗӨВЛӨЛ”-ИЙН ШИНЖЭЭЧИЙН ТЕХНИКИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ  
УРЬДЧИЛСАН ХӨТӨЛБӨР**

2019 оны 8 дугаар сарын 13-аас 22-ны өдөр

№	Өдөр	Цаг	Үйл ажиллагаа	Ажиллах газар
1	1 дэх өдөр 2019 оны 8 дугаар сарын 13	19:15	Шинжээч Монгол Улсад ирэх	Чингис Хаан Олон Улсын Нисэх буудал

2	2 дахь өдөр	10:00	Техникийн Үнэлгээний хийх талаар холбогдох албан тушаалтнуудтай уулзах.	Соёлын өвийн үндэсний төв
3	2019 оны 8 дугаар сарын 14		ГХЯ-ны Дэд сайд буюу Дэлхийн Өвийн Үндэсний Хороо-ны даргатай уулзах.	Гадаад Харилцааны Яам
4	3 дахь өдөр		Улаанбаатар хотоос Архангай аймаг руу хөдлөх	Архангай аймаг
5	2019 оны 8 дугаар сарын 15		Хархорум, Эрдэнэ зуу музей үзэх, дурсгалт газартай танилцах	Өвөрхангай аймаг, Хархорин сум
6			Зочид буудалд буух.	Архангай аймгийн төв
7	4 дэхь өдөр 2019 оны 8 дугаар сарын 16		Архангай аймгийн Засаг дарга, ЗДТГ, ИТХ, БСГ болон бусад холбогдох газрын удирдлага, мэргэжилтнүүдтэй уулзах.	Архангай аймгийн Эрдэнэбулган сумын нутаг, Цэцэрлэг хотод байх ЗДТГ-т уулзалт болно.
8			Цэцэрлэг хотоос Их-Тамир сум “Цацын эрэг”-ийн дурсгалт газар руу хөдлөх	Их Тамир сум, Архангай аймаг
9			“Цацын эрэг”-ийн дурсгалт газартай танилцах	Их Тамир сум, Архангай аймаг
10			Их Тамир сумын Засаг Дарга, ЗДТГ, сумын БСГ, ИТХ-ын дарга, төлөөлөгч, мэргэжилтнүүд болон орон нутгийн иргэдтэй уулзалт хийх	Их Тамир сум, Архангай аймаг
11			“Цацын эрэг”-ийн дурсгалт газраас Архангай аймгийн Цэцэрлэг хот руу хөдлөх	Их Тамир сум, Архангай аймаг
12			Зочид буудалд буух.	Архангай аймгийн төвд зочирд буудалд буудаллах.
13	5 дахь өдөр 2019 оны 8 дугаар сарын 17		Архангай аймгийн Өндөр-Улаан сумын нутагт орших Жаргалантын Амны дурсгалт газартай танилцах	Өндөр-Улаан сум, Архангай аймаг
14			Жаргалантын Амны дурсгалт газартай танилцах	Өндөр-Улаан сум, Архангай аймаг
15			Өндөр -Улаан сумын Засаг Дарга, ЗДТГ, сумын БСГ, ИТХ-ын дарга, төлөөлөгч, мэргэжилтнүүд болон орон нутгийн иргэдтэй уулзалт хийх	Өндөр-Улаан сум, Архангай аймаг

16			Өндөр -Улаан сумаас Булган аймгийн Баян-Агт сум руу хөдлөх	Баян-Агт сум, Булган аймаг
17			Зочид буудалд буух.	Баян-Агт сум, Булган аймаг
18	6 дахь өдөр 2019 оны 8 дугаар сарын 18		Булган аймгийн Баян-Агт Хөвсгөл аймаг руу хөдлөх	Мөрөн сум, Хөвсгөл аймаг
19			Зочид буудалд буух.	Мөрөн сум, Хөвсгөл аймаг
20	7 дахь өдөр 2019 оны 8 дугаар сарын 19		Хөвсгөл аймгийн Засаг дарга, ЗДТГ, ИТХ, БСГ болон бусад холбогдох газрын удирдлага, мэргэжилтнүүдтэй уулзах.	Мөрөн сум, Хөвсгөл аймаг
21			Мөрөн хотоос Бүрэнтогтох сумын “Уушгийн өвөр”-ийн дурсгалт газар руу хөдлөх	Бүрэнтогтох сум, Хөвсгөл сум
22			“Уушгийн өвөр”-ийн дурсгалт газартай танилцах	Бүрэнтогтох сум, Хөвсгөл сум
23			Бүрэнтогтох сумын Засаг Дарга, ЗДТГ, сумын БСГ, ИТХ-ын дарга, төлөөлөгч, мэргэжилтнүүд болон “Уушгийн өвөр” дурсгалын орчмын орон нутгийн иргэдтэй уулзалт хийх	Бүрэнтогтох сум, Хөвсгөл сум
24			"Уушгийн өвөр"-ийн дурсгалт газраас Хатгал сум руу хөдлөх	Хатгал сум, Хөвсгөл аймаг
25			Зочид буудалд буух.	Хатгал сум, Хөвсгөл аймаг
26		8 дахь өдөр		Хатгал сумаас Мөрөн хот руу хөдлөх.
27	2019 оны 8 дугаар сарын 20		Шинжээч Улаанбаатар хот руу нисэх	Улаанбаатар хот
28	9 дэхь өдөр 2019 оны 8 дугаар сарын 21		Анхан шатны үнэлэлт, дүгнэлтийг танилцуулах уулзалт	Соёлын өвийн үндэсний төв
29			БСШУС-ын Дэд сайдтай уулзах (дүгнэлт уулзалт)	БСШУСЯ
30	10 дахь өдөр 2019 оны 8 дугаар сарын 22	07:45	Шинжээч буцах	Чингис Хаан Олон Улсын Нисэх Буудал

**МОНГОЛ УЛСААС ДЭЛХИЙН ӨВИЙН КОНВЕНЦИЙН УРЬДЧИЛСАН  
ЖАГСААЛТАД БАГТСАН “БУГАН ХӨШӨӨ БҮХИЙ ХҮРЛИЙН СОЁЛЫН  
ЦОГЦОЛБОР ДУРСГАЛУУД” ӨВД “ХӨШӨӨ ДУРСГАЛТ ГАЗРУУДЫН ОЛОН  
УЛСЫН ЗӨВЛӨЛ”-ӨӨС ТЕХНИКИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ШИНЖЭЭЧТЭЙ ХАМТРАН  
АЖИЛЛАХ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

№	Овог нэр	Албан тушаал
1	С.Уянга	ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комиссын Ерөнхийн нарийн бичгийн дарга
2	Б.Даваацэрэн	БСШУСЯ-ны Соёл, урлагийн бодлогын газрын мэргэжилтэн
3	Н.Уртнасан	Байгаль, соёлын өвийг хамгаалах сан, Монголын ИКОМОС-ын ерөнхийлөгч,
4	Ц.Төрбат	ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн Хүрэл, төмрийн судалгааны секторын эрхлэгч
5	Н.Батболд	ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн Хүрэл, төмрийн судалгааны секторын эрдэм шинжилгээний ажилтан
6	М.Оюунтулга	Соёлын өвийн үндэсний төвийн Соёлын биет өвийг сэргээн засварлах газрын ерөнхий технологич
7	Ц.Цолмон	Соёлын өвийн үндэсний төвийн Соёлын өвийг авран хамгаалах газрын Дэлхийн өвийн дурсгал хариуцсан мэргэжилтэн

Орон нутагт хамтран ажилласан багийн бүрэлдэхүүн

Архангай аймгийн Засаг даргын тамгын газар

№	Овог нэр	Албан тушаал
1	Б.Цэрэннадмид	Архангай аймгийн ЗДТГ-ын дарга
2	И.Амартүвшин	Архангай аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
3	М.Октябрь	Архангай аймгийн ЗДТГ-ын БСУГ-ын газрын мэргэжилтэн
4	Б.Баатархүү	Архангай аймгийн музейн сан хөмрөгч

Их Тамир сум

№	Овог нэр	Албан тушаал
1	Б. Сэнгээ	Их Тамир сумын Засаг дарга
2	Б.Цэвээндорж	Их Тамир сумын ИТХ-ын дарга
3	Б.Пүрэвдамба	Их Тамир сумын Соёлын төвийн эрхлэгч
4	Л.Ганболд	Их Тамир сумын Соёлын төвийн соёлын өвийн ажилтан
5	Б.Цэцэгжаргал	Их Тамир сумын Соёлын төвийн ажилтан
6	Н.Осорбазар	Их Тамир сумын байгаль, орчны байцаагч

Өндөр-Улаан сум

№	Овог нэр	Албан тушаал
1	Л. Цогтгэрэл	Сумын засаг даргын орлогч
2	Б. Дэлгэр далай	Соёлын төвийн өвийн ажилтан
3	Б. Мөнх эрдэнэ	Засаг даргын тамгын газрын үйлчлэгч
4	Г. Даахидовчин	Хануй багийн засаг дарга
5	Б. Цэрэндэжид	Соёлын төвийн үйлчлэгч

Хөвсгөл аймгийн Засаг даргын тамгын газар

№	Овог нэр	Албан тушаал
1	Х.Ган-Очир	Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын дарга
2	Л.Нарангэрэл	НБХ-ийн соёл, спорт хариуцсан мэргэжилтэн
3	Х.Баасансүрэн	БСУГ-ын соёлын өв хариуцсан мэргэжилтэн
4	М.Одмаа	Хөвсгөл аймгийн музейн эрдэм шинжилгээний ажилтан
5	Ж.Оюумаа	“Далай ээж” ТББ-ын тэргүүн

Бүрэнтогтох сум

№	Овог нэр	Албан тушаал
1	Г.Сонинпил	Бүрэнтогтох сумын засаг дарга
2	Д.Рэнчиндорж	Сумын ИТХ-ын дарга
3	Х.Наранцацрал	Соёлын төвийн эрхлэгч
4	Д.Сайнзаяа	Соёлын төвийн соёлын өвийн ажилтан
5	Б.Пүрэвдорж	Туяа багийн Засаг дарга
6	Б.Даваадорж	Туяа багийн ИТХ-ын дарга
7	Б.Уламбаяр	Байгаль, орчны улсын байцаагч

Хавсралт №3

“ЦАЦЫН ЭРЭГ”-ИЙН БУГАН ЧУЛУУН ХӨШӨӨ, “ЖАРГАЛАНТЫН АМ”-НЫ БУГАН ЧУЛУУН ХӨШӨӨ, “УУШИГИЙН ӨВӨР”-ИЙН БУГАН ЧУЛУУН ХӨШӨӨНИЙ ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТЫН АСУУДЛУУД

1.Өмнөтгөл

Уг дурсгалуудын хадгалалт хамгаалалт, хадгалалтын байдалтай танилцаж орон нутгаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ болон цаашид авч хэрэгжүүлэх хадгалалт хамгаалалтын арга зүйг боловсруулах зорилготой тус дурсгалуудад ажиглалт дүгнэлт судалгааг хийсэн.

2.Чулуулгийн онцлог

Цельсийн 11-12 мянган градус температур бүхий шингэн, өтгөрсөн байдалтай хайлмаг биет цагийн эрхэнд царцсаар нарийн төвөгтэй урвалжийн дүнд бэхжин боржин, хүрмэн чулуу, диорит мэтийн хатуу чулуулаг болон хувирсан байдаг. Дурсгалууд нь боржин чулуун материал зонхилсон ба зарим тохиолдолд цөөн хэд нь хүрмэн чулуун материалаар хийгдсэн байна. Чулуулгын силикатуудыг бүрдүүлэгч үндсэн химийн элементүүдэд Si, O, Al, Fe<sup>2+</sup>, Fe<sup>3+</sup>, Mg, Mn, Ca, Na, K зэрэг багтдаг. Эдгээр нь чулуулаг үүсгэгч эрдэсүүд бөгөөд, уулын чулуулагийн дийлэнхийг бүрдүүлэгч хээрийн жоншууд, кварууд, оливинууд, пироксенууд, амфиболууд, гранатууд энэ бүлэгт багтдаг. Боржин нь пегматик гаралтай гол чулууны нэг бөгөөд болор, халтмал, молор, биндэрьяа, апатит, ортит, циркон, монацит, колумбит, танаталит, пирохлор, литий, цагаан тугалга, молибденит, титан, уран, хайлуур жонш зэрэг олон эрдсийг агуулдаг. Найрлаганд кварц, хээрийн



Зураг1: Боржин чулуу

жонш, гялтгануур голлодог. Боржин чулуу нь ширхэгийн хувьд том, бага байхаас гадна саарал, хөх, цагаандуу, шаргал, улаан, ягаан, ногоон, хар зэрэг олон өнгөтэй байдаг. Нvх сvгvй, ус нэвчдэггvй, элэгддэггvй, их бөх, хvйтэн даахдаа сайн учир дурсгалуудын хувьд монгол орны эрс тэрс уур амьсгалд удаан хугацааны туршид хадгалагдаж ирэх гол хүчин зүйл нь болсон. Галт уул дэлбэрэхэд дэлхийн цөмөөс гадагшилж байгаа 6000 градус цельсийн температуртай буцламтгай лав замд таарсан чулуу, шороог хайлуулж цахиурын давхар исэлийг ( $\text{SiO}_2$ ) 40%-50%-тай агуулсан дэлхийн гадаргуудээр түрэгдэж гарч ирсэн сүвэрхэг чулууг хүрмэн чулуу гэдэг. Хүрмэн чулуу нь халуун хайлмаг үедээ асар их даралтын нөлөөн доор олон талт багана хэлбэртэй болж тогтдог ба өнгө үзэмж, бат бөх чанар, хагалж цуулхад ширхэг дагаж цуурах эрсдэл бага байдаг зэргээс боржин чулуу болон хүрмэн чулууг ашиглаж байсан байх магадлал өндөр байна.

### 3. Чулуулгийн гэмтэл

Эвдрэл гэмтлийн хувьд механик, химийн, биологийн, байгалийн хүчин зүйлээс хамааралтай орчинд хадгалагдаж байна. Буган чулуун хөшөөн хувьд байгаль дээр ил байдаг тул урт хугацааны туршид үүсэх гэмтлийн шалтгаан нь хөрсний давсжил, халуун хүйтний хэлбэлзэл, агаар мандалийн бохирдолоос үүдэлтэй гэмтэж муудах эрсдэл өндөртэй байгаа тул, урдчилан сэргийлж хүрээлэн буй орчны судалгаа явуулах шаардлагатай байна. Ил чулуун дурсгалыг хадгалж хамгаалах үндсэн 3 арга зүйд:

1. Байгаль орчин хүрээлэн буй орчныг сайжруулах
2. Механик болон хими, биологийн гэмтлийг зогсоож, багасгах
3. Хадгалалт хамгаалалт, бэхжүүлэлт, сэргээн засвар хийх

### 4. Чулуулгийн өнгө



Зураг2: Хүрмэн чулуу

Хүрмэн чулуун дурсгалын хувьд: хүрмэн чулуу нь бичил жижиг толбонууд ихтэй хар бараан өнгө зонхилдог хэдийч төмрийн исэлдэлтээс хамаарч саарал, улаавтар өнгөтэй байдаг. Ил дурсгалуудын хүрмэн чулуу нь төмрийн исэлдэл багатай хүрмэн чулуу байсан. Боржин чулуун дурсгалын хувьд: боржин чулууны 10%-г өнгөт эрдэс бүрдүүлдэг учир хар тариа бүхий гялтгар саарал цагаан байдаг. Хээрийн жонш кали ихтэй бол улаавтар өнгөтэй болдог учираас ил дурсгалуудын улаавтар боржин чулуунууднь калийн (K) агууламж ихтэй чулуулгууд байна.

### 5. Гэмтэл үүсгэж буй шалтгаан

Механик гэмтлээс гадна шувууний сангаснаас үүсэх аммиакийн хий  $\text{NH}_3$  гэх мэт химийн болон чулуун гадарга дээр ургасан хаг бүхий биологийн гэмтлээс урьдчилан сэргийлэх шаардлагатай. Ил дурсгал учираас гол анхаарах зүйл нь хөрсөнд агуулагдах давс юм. Давсны ууршилт буюу давсжилт нь хамгийн гол

муудах хүчин зүйл болдог. Чулуу нь хөрсний усанд агуулагдах давсыг уусгаж авдаг ( $\text{CaCO}_3$ ,  $\text{CaSO}_4$ ,  $\text{NaCl}$ ,  $\text{Na}_2\text{SO}_4$  гэх мэт). Хөрсөн дахь давсны усан уусмал нь чулуунд нэвчин орж халуунд усаа ууршуулснаар чулуулгийн давсны агууламж ихэсдэг. Үүний үр дүнд чулууны хөндийд давсны талстууд үүсч чулуун хөндийн дотоод хананд гадагш чиглэлтэй аажим аажмаар нэмэгдэж чулуулгийн гадаргууг гэмтээж цаашлаад чулуулгийн бүтцийг гэмтээж хагалбар үүсгэж бутлах хүчин зүйл нь болдог. Давсны талстжилт нь хөрсний уснаас шууд хамааралтай байдаг. Өөр нэг чухал хүчин зүйл нь чулуунд ус хөлдсөнөөс болж усны эзэлхүүн тэлж мөсөн талстууд чулуулгийн эзэлхүүнийг гэмтээх юм. Мөн агаарын бохирдол ялангуяа хүхрийн исэл ( $\text{SO}$ ) нь чулуулгийн бүрэлдэхүүнд байдаг кальцийн карбонаттай ( $\text{CaCO}_3$ ) урвалд орж гадаргууг харлуулж гэмтээх эрсдэлтэй байдаг.



Зураг3: Шувууны сангас



Зураг4: Малын нударсан хэсэг

## 6.Дүгнэлт

Цаашид чулуулгийн материалын судалгааг хүрээлэн буй орчны судалгаатай хослуулж механик болон химийн, биологийн гэмтлийг тодорхойлж хадгалалт



Зураг5: Улаавтар хэсгүүд

хамгаалалт, сэргээн засварлах арга зүйг дурсгалын онцлогт тааруулж нутагшуулах судалгааг хийх шаардлагатай байна. Материал судлалыг хийснээр судлаачдын дунд сонирхол татаж буган чулуун хөшөөны зосон будаг гэгдэх улаан өнгийг судлан тогтоож чулуулгийн улаануу, нарны хэт ягаан туяаны ионжилтоос үүсч буй химийн урвалаас хувирсан улаалтуу зэргийг тодорхойлж судлах чухал ач холбогдолтой юм.

**“Буган хөшөө бүхий хүрлийн соёлын цогцолбор дурсгалууд” өвд  
ИКОМОС-оос Техникийн Үнэлгээ хийхэд анхаарах асуудлууд**

---

Дэлхийн өвд бүртгүүлэхээр нэр дэвшүүлсэн “Буган хөшөө бүхий хүрлийн соёлын цогцолбор дурсгалууд” өвийн номинацийн материалтай анхан шатны байдлаар танилцахад тодруулах шаардлагатай дараах асуудлууд байна.

1. **Онцлог шинж чанар:** Энэхүү дурсгал нь буган чулуун хөшөө, хиргисүүр, булш, хадны зураг, чулуун зэвсгийн үед хамаарах чулуу олборлож байсан ул мөр бүхий газар, тахилын байгууламж зэргийг багтаасан онцлог шинж чанартай (40-р хуудас). Номинацийн материалд багтсан 3 дурсгалт газарт дээрхи дурсгалууд байгаа эсэхийг баталгаажуулна уу.

Дурсгалт газруудын тодорхойлолтын хэсэгт (хуудас 24-31) хэдэн төрлийн, хэдий тооны дурсгал байгаа талаар бүрэн мэдээлэл байхгүй байна. Тиймээс оролцогч тал 3 дурсгалт газарт байгаа дурсгалуудын төрөл болон тоог хүснэгтэд хийж, мэдээллийг ирүүлэх шаардлагатай байна.

2. **Газрын зураг:** Номинацийн материалд хавсаргасан газрын зурагт дээрхи 3 газарт байх буган чулуун хөшөө болон дурсгалт газруудын гадна болон орчны бүсэд байх бусад дурсгалуудыг тэмдэглэсэн байна (хуудас 8-10). Эдгээр бусад дурсгалуудыг дурсгалын газрын зурагт тэмдэглэх хэрэгтэй эсэхийг анхааралдаа авна уу.

Дурсгалын орчны бүсийн гадна байх хамаарал бүхий бусад дурсгалуудын байршлыг бүхэлд нь харуулсан газрын зураг байгаа эсэх нь тодорхойгүй. Бүтэн газрын зурагт тэмдэглэсэн эсэх нь мөн тодорхойгүй. Дурсгалт газруудад ажиллах үедээ дурсгалын орчимд болон орчны бүсийн гадна орших бусад дурсгалуудын байршлыг газрын зурагт боломжтой байдлаар нягталж чадах уу?

Хэдийгээр номинацийн материалын хавсралтад 2 жижгэвтэр бүрэлдэхүүн хэсгийн нарийвчилсэн дэвсгэр зураг байгаа ч дэвсгэр зураг дээрхи тэмдэглэгээнүүд, жишээлбэл дугуй дүрсээр юуг тэмдэглэсэн бэ гэдэг нь тодорхойгүй (Хавсралт V). Тиймээс дурсгалт газар дээр ажиллах үедээ газрын зургууд дээрхи тэдгээр дүрс, тэмдэглэгээнүүд юу болохыг тодруулж болох уу?

3. **Газар нутгийн зааг хязгаар ба орчны бүс:** Номинацид багтсан дурсгалт газруудын газар нутгийн зааг болон орчны бүсийг тогтоосон үндэслэл юу



вэ, бүсийг тогтоосон байдал нь шаардлага хангаж байгаа эсэхийг тодруулна уу? Жишээлбэл, Жаргалантын Амны цогцолбор дурсгалын хойд хэсгийн орчны бүс хойд хэсэгтээ бага, урд хэсэгтээ их хэмжээний газрыг хамарсан байна. Мөн Уушгийн өвөр-ийн дурсгалт газрын орчны бүс баруун хэсэгтээ бага зүүн хэсэгтээ их газар хамарсан байна (хуудас 8-10).

4. **Хадгалалт, хамгаалалтын байдал:** Номинацийн материалд бэлчээрийн даац хэтэрсэн тухай болон бэлчээрийн хүчин чадлыг тодорхойлох тухай дурдсан (хуудас 51). Бэлчээрийн даацын хүчин чадлыг тодорхойлох, хянах болон сэргээх ажлын явц ямар байна вэ?

Зарим буган чулуун хөшөөг дахин босгосон талаар дурдсан. Номинацийн материалд багтсан дурсгалууд дотор тараан байрлуулсан буюу шилжүүлэн байрлуулсан буган чулуу байгаа юу? (хуудас 51)

Номинацийн материалд дурсгал дээр бичих, зурах, будах болон хугарч эвдрэх зэрэг орчин цагийн гэмтэл үүсч байгааг дурдсан (хуудас 51). Орчин цагийн энэ гэмтэл хир хэмжээнд байна вэ? Бүхий л дурсгалуудад тодорхой хэмжээтэй байна уу, эсвэл зөвхөн буган чулуун хөшөөнүүдэд тохиолдоу байна уу?

Номинацийн материалд хэд хэдэн буган чулуун хөшөөг дахин босгосон талаар дурдсан (хуудас 41). Ингэж дахин босгосон нь хадгалалт, хамгаалалтын сайн туршлага болж байна уу, үр дүн нь дурсгалын хадгалалт, хамгаалалтад эерэгээр нөлөөлж байна уу?. Буган чулуун хөшөөний байрлал анхнаасаа ямар байрлалтай байсныг, байх ёстойг яаж тогтоосон бэ? Номинацийн материалд багтсан буган чулуун хөшөөний хэдийг нь дахин босгон бэ? Хэсэгчлэн босгосон уу эсвэл бүгдийг нь босгосон уу? Тоог нь дурдана уу?

Уушгийн өвөр-ийн дурсгалын нарийвчилсан зурагт хамгаалалтын хашаа хиргисүүр (дугуй байгууламж)-ийн дундуур баригдаж, хэсэг дурсгалыг цогцолбор дурсгалаас тусгаарласан байсан (хуудас 31 болон хавсралт V). Энэ хашааны нөлөөллийг үнэлнэ үү.

Цаг уурын нөлөөлөл болон малаас шалтгаалсан эвдрэл гэмтлийн талаар дурдсан, оролцогч улс энэ тал дээр урьдчилан сэргийлэх ямар арга хэмжээ авч байна вэ (хуудас 53).

Номинацын материалд буган чулууны хэсгийг мал, амьтны саравч барих зорилгоор ашигласан дахин ашигладаг тухай дурдсан (хуудас 52). Цаашид чулууг энэ мэт байдлаар ашиглахыг хэрхэн зогсоох вэ?

5. **Байгалийн гамшиг болон эрсдэлээс сэргийлэх:** Дурсгалт газарт эрсдэл учруулж байгаа нэг эрсдэл бол хээрийн түймэр юм (хуудас 53). Дурсгалт

газрыг хээрийн түймрээс хэрхэн хамгаалж, урьдчилан сэргийлэх вэ?

Номинацийн материалд гамшгийн эрсдэлийн менежмент байхгүй талаар дурдсан (54 дүгээр хуудас). Гамшгийн эрсдэлийн менежментийн төлөвлөгөөг дурсгалт газарт зориулан болвсруулах уу? Хэрэв тийм бол хэзээ боловсруулж дуусгах вэ?

6. **Хамгаалалт:** Номинацийн материалын 55 дугаар хуудаст авч хэрэгжүүлэхээр дурдсан хамгаалалтын арга ажиллагааны үр дүн ямар байгааг тодруулна уу. Одоо байгаа зохицуулалтын механизм дурсгалыг ямар тодорхой хэмжээнд үр дүн үзүүлж байна уу эсвэл хамгаалах асуудал зөвхөн онолын түвшинд байна уу?

Дурсгалын хамгаалалт болон менежмент нь өнөөг хүртэл уламжлалт арга, туршлагаас их хамаардаг бололтой (хуудас 50). Аялал жуулчлал болон бусад өсөн нэмэгдэж байгаа үйл ажиллагаатай холбоотойгоор эдгээр уламжлалт арга туршлага дурсгалын хамгаалалт, менежментийг цаашид хэрхэн хангах талаар судлана уу. .

Дурсгалыг Дэлхийн өвд бүртгүүлэх талаар орон нутгийн иргэд болон оролцогч талуудын хандлага ямар байгааг, ойлгож, дэмжиж байгаа эсэхийг судлана уу (хуудас 50).

Уушгийн Өвөр-ийн дурсгалт газар нь улсын хамгаалалтад багтсан учраас номинацид орсон 3 газраас хамгийн илүү хамгаалагдсан гэж ажиглагдсан (хуудас 53). Үлдсэн 2 дурсгал бүгд улсын хамгаалалтад багтах уу? Хэрэв тийм бол улсын хамгаалалтад авах хугацааг дурсгалт газруудад ажиллах үеэдээ лавлаж асууна уу.

5.с хэсэгт хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа хамаардаг (хуудас 56). Энэ хэсэгт хийгдэх ажлыг бичсэн боловч яг ямар үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа нь тодорхойгүй. Яг ямар ажил хийгдэж байгаа нь тодорхойгүй.

Номинацийн материалд мөн цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай байгаа үйл хадгалалт, хамгаалалтын арга ажиллагааг дурдаж бичсэн (хуудас 56). Эдгээр санал санаачлага, үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүчин чадал болон цаг хугацааг тодорхойлно уу.

Уул уурхайн олборлолт дурсгалд аюул заналхийлэл учруулж байгааг номинацийн материалд дурдсан. Дурсгалын хамгаалалтын бүс болон орчны бүсийн гадна цаашид ашигт малтмал олборлох боломж байгаа эсэхийг, хамгаалах механизм байгааг эсэхийг тодруулах (хуудас 52)?

7. **Менежмент:** Номинацийн материалд менежментийн төлөвлөгөөг анхан

шатны байдлаар боловсруулж байгааг дурдсан (хуудас 57). Энэхүү төлөвлөгөөний үр нөлөө, бодит байдалд яг юу хэрэгжиж байгааг тодруулна уу: Сүүлийн байдлаар менежментийн төлөвлөгөө хэзээ бэлэн болохыг тодруулна уу?

Номинацын материалд энэхүү менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх захиргаа байгуулах талаар мөн дурдсан (хуудас 58). Энэхүү захиргаа байгуулагдах цаг хугацааг тодруулна уу. Мөн түүнчлэн санал болгож буй менежмент болон захиргааны нэгжийн дурсгалын хамгаалалт болон менежментийг хангах боломжийг судлана уу (хуудас 50).

Ажиллах боловсон хүчин болон тэдгээрийн туршлагын хувьд захиргааны байгууллага, түүний бүтцийн талаар хараахан тогтоогоогүй байна. (хуудас 52) Ажиллах боловсон хүчний зэрэг дэв, тэдгээрийн туршлага болон боловсон хүчнийг хэзээ ажиллуулж эхлэх талаар дэлгэрэнгүй мэдээлэл авах.

Өвийн газар бүрт түүний хадгалалт хамгаалалт, менежменттэй холбоотойгоор туслалцаа үзүүлэх орон нутгийн харгалзан хамгаалагчийн талаар номинацид дурджээ. (хуудас 53) Үүнийг хэрэгжүүлэх эсэхийг баталгаажуулж шалгах.

Жаргалантын амны цогцолбортой холбоотой түрээсийн гэрээлэгчийн нөхцөл байдлыг шалгах. (хуудас 55) Өвийн газар нутгийн Дэлхий нийтийн хосгүй гайхамшигт үнэ цэнийг хадгалах хамгаалах, менежментийг хэрэгжүүлэхтэй уг гэрээ холбоотой эсэхийг шалгах.

8. **Санхүүжилт.** Номинацийн материалд өвд зориулсан санхүүгийн эх үүсвэр хомс байгааг дурдаж түүнчлэн өвийг хадгалж хамгаалах талаарх санхүүжилтийг хариуцсан тодорхой байгууллага байхгүй гэжээ. (хуудас 60) Өвтэй холбоотой санхүүжилт хуваарилах талаар оролцогч тал аливаа санаачлага гаргаж буй эсэхийг судлах.
9. **Аялал жуулчлалын төлөвлөгөө ба менежмент.** Оролцогч улс аялал жуулчлалын төлөвлөгөө болон менежменттэй холбоотойгоор юу хийхээр төлөвлөж байгааг сонирхож хангалттай эсэхийг үзэх. (хуудас 54) Ялангуяа, өвийн газарт аялагчдад зориулж ямар байгууламж, дэд бүтцийг, хаана хийхээр төлөвлөж байгааг тодруулах. Аялагчдын хандлагыг хэрхэн яаж зохицуулахаар бэлтгэж буйг судлах.
117	Хэнтий	Өмнөдэлгэр сумын Дээд Өлзийтийн дөрвөлжин булшнууд	Судалгаа бүрэн хийгдээгүй, нийтлэг шинжтэй
118	Хэнтий	Өмнөдэлгэр сумын төвд орших буган чулуу хөшөө	Судалгаа бүрэн хийгдээгүй, нийтлэг шинжтэй
119	Хэнтий	Өмнөдэлгэр сумын Жаргалант хэмээх газар орших хадны зураг	Судалгаа бүрэн хийгдээгүй, нийтлэг шинжтэй
120	Улаанбаатар	Монгол улсын Ерөнхий сайд П.Гэндэнгийн амьдарч байсан байшин	Эх төрхөө алдсан

Хавсралт 7

**АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ХАМГААЛАЛТААС ХАСАХ  
САНАЛТАЙ ДУРСГАЛЫН ЖАГСААЛТ**

№	Аймаг	Дурсгал	Тайлбар
1	Архангай	Өндөр-Улаан сумын Хануй голын хөндийн хиргисүүр, буган чулуун хөшөө бүхий дурсгал	Өөр нэрээр давхардаж орсон
2	Говь-Алтай	Цогт сумын Найтааст хэмээх газар орших хадны зураг	2015 оны үзлэг тооллогоор олдоогүй

3	Дорнод	Матад сумын Наран хэмээх газар орших хүн чулуун хөшөө	2015 оны үзлэг тооллогоор олдоогүй
4	Дундговь	Дэлгэрцогт сумын Сөдөтийн амны эхний хадны зураг	Нэр давхардсан
5	Өвөрхангай	Уянга сумын нутагт орших Мааньтын хөшөө	Нэр давхардсан
6	Өмнөговь	Номгон сумын Далан уулын өмнө биед орших Түрэг бичээс	2015 оны үзлэг тооллогоор олдоогүй
7	Өмнөговь	Хүрмэн сумын Бичигт хэмээх газар орших хадны зураг	2015 оны үзлэг тооллогоор олдоогүй
8	Хөвсгөл	Арбулаг сумын Дэлгэрхаан уулын өвөр, Мөрөнгийн голын эрэгт орших хадны зураг	2015 оны үзлэг тооллогоор олдоогүй
9	Хөвсгөл	Ханх сумын Жаргалантын ам хэмээх газар орших хадны зураг	2015 оны үзлэг тооллогоор олдоогүй
10	Хэнтий	Өмнөдэлгэр сумын Жаргалант хэмээх газар орших хадны зураг	2015 оны үзлэг тооллогоор олдоогүй
11	Улаанбаатар	Анхны европ хоёр давхар байшин	Эх төрхөө алдсан
12	Улаанбаатар	Зүүн хүрээний нууц бүлгэм байрлаж байсан байшин	Эх төрхөө алдсан

Хавсралт 8

### АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ХАМГААЛАЛТАД БАЙХ ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛЫН УРЬДЧИЛСАН ЖАГСААЛТ

№	Аймаг	Дурсгал
1	Архангай	1.Батцэнгэл сумын Цагд уулын хүн чулуу
2	Архангай	2.Батцэнгэл сумын Шивэртийн амны дөрвөлжин булш, буган хөшөө бүхий цогцолбор дурсгал
3	Архангай	3.Жаргалант сумын Бугатын амны Шар хадны зураг
4	Архангай	4.Ихтамир сумын Цацын эрэг-2 чулуун зэвсгийн суурин
5	Архангай	5.Өгийнуур сумын Чилэн балгас
6	Архангай	6.Өлзийт сумын Гацааны хадны зосон зураг
7	Архангай	7.Өлзийт сумын төвд орших Бишрэлт гүний хүрээний дуганууд
8	Архангай	8.Өлзийт сумын Хөшөөтийн дэнжийн буган хөшөө
9	Архангай	9.Өндөр-Улаан сумын Бичигт хангай уулын эртний бичээс, зосон зургийн дурсгал
10	Архангай	10.Өндөр-Улаан сумын Шар дугуйн дэнжийн буган хөшөө
11	Архангай	11.Тариат сумын Бунхантын хадны зосон зураг
12	Архангай	12.Төвшрүүлэх сумын Хөх сүмийн туурь
13	Архангай	13.Хайрхан сумын Наймаа толгойн хүннү булш
14	Архангай	14.Хайрхан сумын Уртын амны буган хөшөөд
15	Архангай	15.Хайрхан сумын Эмээл толгойн хүн чулуу
16	Архангай	16.Хангай сумын Ноён хангайн хүн чулуу, тахилын онгон
17	Архангай	17.Хашаат сумын Бага Номгоны хөндийн хүн чулуу бүхий цогцолбор дурсгал

18	Архангай	18.Хашаат сумын Их Номгоны бэхэн зураг, бичээс
19	Архангай	19.Хотонт сумын “Найман талт” хэмээх чулуун байгууламж
20	Архангай	20.Цэнхэр сумын Ар хоолойн хүн чулуу
21	Архангай	21.Цэнхэр сумын Цагаан сүмийн балгас
22	Архангай	22.Чулуут сумын Бургасны энгэрийн буган хөшөөд, хиргисүүрийн цогцолбор дурсгал
23	Архангай	23.Эрдэнэмандал сумын Их Хануй нуурын руни бичиг бүхий тахилын хашлага, хүн чулуут цогцолбор дурсгал
24	Баян-Өлгий	1.Алтанцөгц сумын Олон нуурын Алаг үзүүрийн хүн чулууд
25	Баян-Өлгий	2.Булган сумын Ёлт голын буган хөшөөд, хиргисүүрийн цогцолбор дурсгал
26	Баян-Өлгий	3.Дэлүүн сумын Хар чирхийн эрт цагт төмөр хайлуулж байсан зуухны үлдэгдэл бүхий газар
27	Баян-Өлгий	4.Сагсай сумын Битүүгийн хүн чулуу
28	Баян-Өлгий	5.Сагсай сумын Цагаан асгын буган хөшөөд, хиргисүүр, бусад үеийн булш, тахилын байгууламж бүхий цогцолбор дурсгал
29	Баян-Өлгий	6.Цэнгэл сумын Их Хатуугийн голын буган хөшөө, хиргисүүрийн цогцолбор дурсгал
30	Баянхонгор	1.Баян-Өндөр сумын Чихэнгийн агуйн чулуун зэвсгийн дурсгал
31	Баянхонгор	2.Баян-Овоо сумын Улаан толгойн хадны зураг, хиргисүүр, хүннү булш бүхий цогцолбор дурсгал
32	Баянхонгор	3.Баянлиг сумын Ширээгийн гашууны палеонтологийн олдворт газар
33	Баянхонгор	4.Богд сумын Пунцаг овооны буган хөшөөд, хиргисүүрийн цогцолбор дурсгал
34	Баянхонгор	5.Заг сумын Бумбатын амны хүн чулууд
35	Баянхонгор	6.Гурванбулаг сумын Морин мөртийн хадны зураг, буган хөшөөд, хиргисүүрийн цогцолбор дурсгал
36	Баянхонгор	7.Өлзийт сум Бийрийн хөндийн буган хөшөө, хиргисүүр, дөрвөлжин булш, тахилын онгон бүхий цогцолбор дурсгал
37	Баянхонгор	8.Өлзийт сумын Түйн голын балгас
38	Баянхонгор	9.Өлзийт сумын Хар Нүдэнгийн хүрмийн хадны зургийн цогцолбор дурсгал
39	Баянхонгор	10.Шинэжинст сумын Бичигт ханангийн хадны зураг
40	Баянхонгор	11.Шинэжинст сумын Сүүжийн чулуун зэвсгийн дурсгал
41	Баянхонгор	12.Эрдэнэцогт сумын Бор шорооны амны буган хөшөө, булш, хиргисүүрийн цогцолбор дурсгал
42	Булган	1.Баян-Агт сумын Халтарын голын буган хөшөөд
43	Булган	2.Бугат сумын Хужиртын голын Бичигтийн хадны зураг, бичээс
44	Булган	3.Бугат сум Цацын толгойн хүн чулуу
45	Булган	4.Булган сум Баруун замын байлдааны штаб байрлаж байсан байшин
46	Булган	5.Булган сумын Майдарын голын хөндий дэх Цагаан суварга

47	Булган	6.Булган сумын төвд орших Диваажингийн сүм
48	Булган	7.Бүрэгхангай сумын Бичигт шургуулгын хадны бичээс
49	Булган	8.Гурванбулаг сумын Гурвалжин уулын руни бичээс
50	Булган	9.Дашинчилэн сумын Лах уул, Арслантын хадны зураг
51	Булган	10.Дашинчилэн сумын Хангидайн бичээс, хадны зураг
52	Булган	11.Орхон сумын Сээрийн адагийн буган хөшөөд, хиргисүүрийн цогцолбор дурсгал
53	Булган	13.Рашаант сумын Хөгнө ханы их, бага хийдийн түүрх
54	Булган	13.Сайхан сумын Нарийн хүрмийн Хөшөөн дэвсэгийн хүн чулууд
55	Булган	14.Сэлэнгэ сумын Бүхын манханы чулуун зэвсгийн суурин
56	Булган	15.Сэлэнгэ сум Цүүцийн хадны зосон зураг
57	Булган	16.Тэшиг сум Дүгнэнгийн хясааны бурханы хөрөг, бичээс
58	Булган	17.Хишиг-Өндөр сумын Ар ханангийн руни бичээс
59	Булган	18.Хангал сумын Хандгайтын амны зосон зураг
60	Булган	19.Хутаг-Өндөр сумын Битүүгийн цагааны хадны зураг
61	Булган	20.Хутаг-Өндөр сумын Харганын голын чулуун зэвсгийн суурин
62	Говь-Алтай	1.Баян-Уул сумын Бага бэрх, Доогийн бууцны хадны зураг
63	Говь-Алтай	2.Баян-Уул сумын Доогийн ханангийн бууцны хадны зураг
64	Говь-Алтай	3.Бигэр сумын Морин толгойн хадны зураг, булш бүхий цогцолбор дурсгал
65	Говь-Алтай	4.Бугат сумын Тамчийн бэлчирийн буган хөшөө, хүн чулуу, булшны цогцолбор дурсгал
66	Говь-Алтай	5.Есөнбулаг сум Говь Алтай аймгийн Орон нутгийг судлах Музейн барилга
67	Говь-Алтай	6.Тайшир сумын Наробанчин хийдийн түүрх
68	Говь-Алтай	7.Тонхил сумын Зүйлийн Огтрогын хүн чулуу
69	Говь-Алтай	8.Тонхил сумын Улаан нурууны оцонгийн буган хөшөөд
70	Говь-Алтай	9.Тонхил сумын Хяр хараачийн хөшөө чулуу бүхий булшнууд
71	Говь-Алтай	10.Чандмань сумын Чандмань уулын бунхан-овоо
72	Говь-Алтай	11.Чандмань сумын Шаахар толгойн цогцолбор дурсгал
73	Говь-Алтай	12.Шарга сумын Халзан ширэгийн балгас
74	Говьсүмбэр	1.Сүмбэр сумын Мөнх хайрханы чулуун зэвсгийн суурин
75	Говьсүмбэр	2.Сүмбэр сумын Чойрын хийдийн түүрх
76	Дархан-Уул	1.Орхон сумын Цагааннуурын зосон зураг
77	Дархан-Уул	2.Хонгор сумын Буурал уулын булш
78	Дархан-Уул	3.Шарын гол сумын төвийн буган хөшөөд
79	Дорноговь	1.Зүүнбаян сумын Хонгил цав, Бурхантын палеонтологийн олдворт газар
80	Дорноговь	2.Иххэт сумын Ар-Улааны хүн чулуу
81	Дорноговь	3.Иххэт сумын Бурхантын хүн чулуу
82	Дорноговь	4.Мандах сумын Өлгий хийдийн түүрх
83	Дорноговь	5.Мандах сумын Шарилын уулын чулуун зэвсгийн суурин
84	Дорноговь	6.Өргөн сумын Хамрын хуралын палеонтологийн олдворт газар

85	Дорноговь	7.Өргөн сумын Цагаан эргийн палеонтологийн олдворт газар
86	Дорноговь	8.Хатанбулаг сумын Дунгийн палеонтологийн олдворт газар
87	Дорноговь	9.Хөвсгөл сумын Сүлдэнэ хөх овоо
88	Дорноговь	10.Хөвсгөл сумын Цувираагийн хийдийн туурь
89	Дорноговь	11.Эрдэнэ сумын Дулааны говийн чулуун зэвсгийн суурин
90	Дорноговь	12.Эрдэнэ сумын Хамрын арын палеонтологийн олдворт газар
91	Дорнод	1.Булган сумын Норовлин уулын чулуун зэвсгийн суурин
92	Дорнод	2.Булган сумын Түгийн сүмийн туурь
93	Дорнод	3.Гурванзагал, Дашбалбар, Баяндун, Баян-Уул сумдын нутагт орших "Чингисийн хэрмэн зам" хэмээх дурсгал
94	Дорнод	4.Гурванзагал сумын Цагаан чулуутын олон үеийн булшны цогцолбор дурсгал
95	Дорнод	5.Дашбалбар сумын Сүүжийн булагийн чулуун зэвсгийн суурин
96	Дорнод	6.Матад сумын Барчигар, Буян-Өндөрийн хүн чулууд
97	Дорнод	7.Матад сумын Ловохын овоогийн хүн чулуу
98	Дорнод	8.Сүмбэр сумын Тамсагбулагийн Утай уулын сүмийн туурь
99	Дорнод	9.Сүмбэр сумын Тамсагбулагийн чулуун зэвсгийн үеийн суурин
100	Дорнод	10.Хөлөнбуйр сумын Буян-Өлзийтийн хүн чулуу
101	Дорнод	11.Хэрлэн сумын Дорнод аймгийн Ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргааны барилга, түүний өмнө орших маршал Х.Чойбалсангийн хөшөө
102	Дорнод	12.Цагаан-Овоо сумын Зүүн дөрөөгийн эртний хотын туурь
103	Дундговь	1.Адаацаг сумын Баруунбулагийн хүн чулуу
104	Дундговь	2.Адаацаг сумын нутагт Зуутын хийд
105	Дундговь	3.Адаацаг, Дэлгэрцогт сумдын Бага газрын чулууны Дунд шанд, Дураал, Ихэрийн ам, Ханан, Хүрэн хонд, Хөх хад, Цагаан ухаагийн хүннү булш
106	Дундговь	4.Баянжаргалан сумын Саруулын бичигт хадны бичээс
107	Дундговь	5.Дэлгэрхангай сумын Хархашаатын хадны зураг
108	Дундговь	6.Дэлгэрхангай сумын Хүрэн хад (Хүрэн хайрхан, Элгэн хад)-ны ханз бичиг
109	Дундговь	7.Дэлгэрцогт, Адаацаг сумдын Бага газрын чулууны Сөдөтийн хоолой, Өндөр хонд, Очирт хүрээ, Босгын хоолой, Рашаант, Монгол уул, Тахилтын хадны зураг
110	Дундговь	8.Өндөршил сумын Мухарын булагийн чулуун зэвсгийн суурин
111	Дундговь	9.Сайхан-Овоо сумын Шаазан хотын туурь
112	Дундговь	10.Сайхан-Овоо сумын Ахар уулын палеонтологийн олдворт газар
113	Дундговь	11.Хулд сумын Шарангадын агуйн монгол, төвд бичээс

114	Завхан	1.Баянтэс сумын Их Бэрх уулын зосон зураг
115	Завхан	2.Баянхайрхан сумын Урт булагийн дөрөлжийн хүн чулууд
116	Завхан	3.Идэр сумын Ар дугуйтын буган хөшөөд
117	Завхан	4.Нөмрөг сумын Ялаат нуурын буган хөшөө, хиргисүүрийн цогцолбор дурсгал
118	Завхан	5.Сантмаргаз сумын Буга Согоотын хадны зураг
119	Завхан	6.Тэлмэн сумын Дунд шургахын амны буган хөшөө, хиргисүүрийн цогцолбор дурсгал
120	Завхан	7.Тэлмэн сумын Дээд шумуултайн буган хөшөөд
121	Завхан	8.Тэс сумын Сүм толгойн балгас
122	Завхан	9.Улиастай сумын Сангийн хэрмийн туурь
123	Завхан	10.Цагаанчулуут сумын Хяларын өвөлжөөний хадны зураг
124	Завхан	11.Цэцүүхийн амны зэл чулуу, тахилын цогцолбор дурсгал
125	Орхон	1.Жаргалант сумын Айрагийн гозгорын булш оршуулгын дурсгал
126	Орхон	2.Жаргалант сумын Чингэлийн голын булш, оршуулгын дурсгал
127	Өвөрхангай	1.Баруунбаян-Улаан сумын Шаазан толгойн туурь
128	Өвөрхангай	2.Баруунбаян-Улаан сумын Буйласт худагийн палеонтологийн олдворт газар
129	Өвөрхангай	3.Бат-Өлзийт сумын Тэмээн чулууны дөрвөлжин булш, сийлмэл зураг, буган хөшөөний цогцолбор дурсгал
130	Өвөрхангай	4.Баян-Өндөр сумын Бууралын хүн чулуу
131	Өвөрхангай	5.Богд сумын "Илжгэн чихт хааны хэрэм" хэмээх дурсгал
132	Өвөрхангай	6.Богд сумын Арц Богдын чулуун зэвсгийн суурин
133	Өвөрхангай	7.Богд сумын Тэвш уулын хадны зураг
134	Өвөрхангай	8.Гучин-Ус сумын Их Дөрөлж, Паалуугийн хадны зураг
135	Өвөрхангай	9.Нарийнтээл сумын Арцад толгойн дөрвөлжин булш, хиргисүүр, буган хөшөөний цогцолбор дурсгал
136	Өвөрхангай	10.Нарийнтээл сумын Ламын гэгээний суварга
137	Өвөрхангай	11.Хархорин сумын Захын булагийн хотын туурь
138	Өвөрхангай	12.Хархорин сумын Баянголын амны хотын туурь
139	Өвөрхангай	13.Хархорин сумын Гүмбийн дэнжийн буган хөшөө
140	Өвөрхангай	14.Хархорин сумын Зараа толгойн хадны зураг, бичээс
141	Өвөрхангай	15.Хархорин сумын Мэлхий толгойн барилгын туурь, чулуун яст мэлхий
142	Өвөрхангай	16.Хархорин сумын Орхон-1 чулуун зэвсгийн суурин
143	Өвөрхангай	17.Хархорин сумын Хар чулууны хүн чулуу
144	Өвөрхангай	18.Хужирт сумын Майхан толгойн булш хиргисүүрийн цогцолбор дурсгал
145	Өвөрхангай	19.Хужирт сумын Хужирт амралт сувилалын барилга
146	Өмнөговь	1.Баяндалай сумын Баянзүрхийн хадны зураг
147	Өмнөговь	2.Баян-Овоо сумын Тогоо хайрханы хадны зураг
148	Өмнөговь	3.Гурвантэс сумын Наранбулагийн палеонтологийн олдворт газар
149	Өмнөговь	4.Гурвантэс сумын Хайчин уулын палеонтологийн олдворт газар
150	Өмнөговь	5.Гурвантэс Хүрэн цавийн палеонтологийн олдворт газар
151	Өмнөговь	6.Ноён сумын Дунд хоргын шар даваа хадны зураг

152	Өмнөговь	7.Ноён сумын Ихэр гашууны хадны зураг
153	Өмнөговь	8.Номгон сумын Баянбулагийн туурь
154	Өмнөговь	9.Номгон сумын Сангийн далай хийдийн дуганууд
155	Өмнөговь	10.Номгон сумын Уртын амралтын хадны зураг, хүн чулуу
156	Өмнөговь	11.Номгон сумын Цагаан дэрстийн Бичигтийн усны хадны зураг
157	Өмнөговь	12.Номгон сумын Шилүүтийн палеонтологийн олдворт газар
158	Өмнөговь	13.Номгон сумын Эрүүгийн цавын палеонтологийн олдворт газар
159	Өмнөговь	14.Номгон сумын Өндөр Богдын палеонтологийн олдворт газар
160	Өмнөговь	15.Номгон, Хүрмэн, Баяндалай, Сэврэй сумын нутаг дахь "Чингисийн далан" хэмээх дурсгал
161	Өмнөговь	16.Сэврэй сумын Арц богд уулын Хонгилын палеонтологийн олдворт газар
162	Өмнөговь	17.Сэврэй сумын Үүдэн сайрын палеонтологийн олдворт газар
163	Өмнөговь	18.Сэврэй сумын Замын хондын палеонтологийн олдворт газар
164	Өмнөговь	19.Ягаан ховилын палеонтологийн олдворт газар
165	Өмнөговь	20.Сэврэй сумын Баруун Зүүн шургуулгын палеонтологийн олдворт газар
166	Өмнөговь	21.Сэврэй сумын нутаг Сэврэй уулын Хар дэлийн бууцны хадны зураг
167	Өмнөговь	22.Ханбогд сумын Байшинт харын чулуун зэвсэг, хадны зураг, руни бичгийн цогцолбор дурсгал
168	Өмнөговь	23.Ханбогд сумын Баян хөөвөрийн хүн чулуу
169	Өмнөговь	24.Ханбогд сумын Мангасын хүрээ
170	Өмнөговь	25.Ханбогд сумын Оцон мааньтын чулуун зэвсгийн суурин
171	Өмнөговь	26.Ханбогд сумын Хүрдэт агуйн бичээс
172	Өмнөговь	27.Ханбогд Хавиргын зоогийн палеонтологийн олдворт газар
173	Өмнөговь	28.Ханхонгор сумын Годил балгас
174	Өмнөговь	29.Хүрмэн сумын Улаан хүрээгийн палеонтологийн олдворт газар
175	Өмнөговь	30.Цогт-Овоо сумын Баянгийн палеонтологийн олдворт газар
176	Өмнөговь	31.Манлай сумын Шунхатын палеонтологийн олдворт газар
177	Өмнөговь	32.Манлай сумын Могойн дэл уулын палеонтологийн олдворт газар
178	Сүхбаатар	1.Дарьганга сумын Салаа булагийн чулуун зэвсгийн суурин
179	Сүхбаатар	2.Дарьганга сумын Молцог элсний чулуун зэвсгийн дурсгалт газар
180	Сүхбаатар	3.Дарьганга сумын нутагт орших Гөхөлийн ширээний хүн чулуу
181	Сүхбаатар	4.Түвшинширээ сумын Дэлгэрхаан уулын Их Хүнгүйн монгол булшны оршуулгын газар
182	Сүхбаатар	5.Түвшинширээ сумын Зараа уулын чулуун зэвсгийн суурин, булш оршуулгын дурсгал
183	Сэлэнгэ	1.Алтанбулаг сумын Төгсөгийн чулуун зэвсгийн суурин

184	Сэлэнгэ	2.Алтанбулаг сумын төвд орших Ардын хувьсгалын түүхэнд холбогдох барилга
185	Сэлэнгэ	3.Алтанбулаг сумын Улаан бургасын чулуун зэвсгийн суурин
186	Сэлэнгэ	4.Ерөө сумын Алтан овооны буган хөшөө, дөрвөлжин бүлш, хиргисүүрийн цогцолбор дурсгал
187	Сэлэнгэ	5.Орхон сумын Нартын уулын арын хүн чулуу
188	Сэлэнгэ	6.Орхон сумын Цантын хотын түүрх
189	Сэлэнгэ	7.Орхонтүүл сумын Жаргалантын бурханы хөрөг
190	Сэлэнгэ	8.Түшиг сумын Майхант уулын хадны зосон зураг
191	Сэлэнгэ	9.Түшиг сумын Өгөөмөр уулын зосон зураг
192	Төв	1.Баян сумын Багахангай, Хангайбулагийн хүн чулууд
193	Төв	2.Баян сумын Өгөөмөрийн хүн чулуу
194	Төв	3.Баян-Өнжүүл сумын Баян булагийн хүн чулуу
195	Төв	4.Заамар сумын Хэрмэн дэнжийн балгас
196	Төв	5.Мөнгөнморьт сумын Мүхар Гутайн буган хөшөөд
197	Төв	6.Сүмбэр сумын Загдалын голын хүн чулуу, цогцолбор дурсгал
198	Төв	7.Эрдэнэ сумын Сарьдагийн хийдийн түүрх
199	Төв	8.Эрдэнэсант сумын Сэрвэнгийн үзүүрийн араб бичээст хөшөө
200	Увс	1.Баруунтуруун сумын Агиртаг уулын хүн чулуу
201	Увс	2.Бөхмөрөн сумын Баадайн амны буган хөшөөд, хиргисүүрийн цогцолбор дурсгал
202	Увс	3.Зүүнговь сумын Баяннуурын дурсгалт газар
203	Увс	4.Зүүнговь сумын Өгөөмөр бүлш оршуулгын дурсгалт газар
204	Увс	5.Зүүнхангай сумын Хүрдлэгийн амны цогцолбор дурсгал
205	Увс	6.Малчин сумын Хөтөл нуурын Бор толгойн хүн чулууд
206	Увс	7.Наранбулаг сумын Жаажаагийн хөтөлийн хүн чулууд
207	Увс	8.Наранбулаг сумын Хар тэрмэсийн палеонтологийн олдворт газар
208	Увс	9.Өмнөговь сумын Хагийн улаан толгойн буган хөшөө ашиглан хийсэн түрэгийн үеийн тахилын байгууламж
209	Увс	10.Өмнөговь сумын Шарбулагийн онцын хадны зураг
210	Увс	11.Өндөрхангай сумын Чигжийн голын хүн чулуу, буган хөшөө бүхий дурсгал
211	Увс	12.Сагил сумын Ихсарын хадны зураг
212	Увс	13.Түргэн сумын Хөх бэлчэр, Эрээн харгай, Бууралын ам, Саалинт, Төгсбуянт орчмын эртний төмөр хайлуулж байсан зуухны үлдэгдэл бүхий дурсгалт газар
213	Увс	14.Улаангом сумын Харлаг бэйсийн сүм
214	Увс	15.Улаангом сумын Чандмань уулын бүлш
215	Ховд	1.Буянт сумын Чандмань хар үзүүрийн хадны зураг
216	Ховд	2.Дарви сумын Жүргэрийн цагаан толгойн рүни бичээс
217	Ховд	3.Дарви сумын Загалын хиргисүүр
218	Ховд	4.Дарви сумын Чулуутын огторгын буган хөшөө



219	Ховд	5.Дөргөн сумын Чоно харайх, Татаалын палеонтологийн олдворт газар
220	Ховд	6.Жаргалант сумын Ж.Чулууны нэрэмжит Ховд аймгийн хөгжимт драмын театрын барилга
221	Ховд	7.Жаргалант сумын Сангийн хэрмийн түүрь
222	Ховд	8.Зэрэг сумын Алтан тээлийн палеонтологийн олдворт газар
223	Ховд	9.Манхан сумын Нүхэн өтгийн хадны зураг
224	Ховд	10.Манхан сумын Өөшийн бор үзүүрийн палеонтологийн олдворт газар
225	Ховд	11.Мөнххайрхан сумын Дээд улаан говийн аманд орших буган хөшөөд, хиргисүүрийн цогцолбор дурсгал
226	Ховд	12.Мөнххайрхан сумын Улаан говийн амны хүн чулуу
227	Ховд	13.Мөнххайрхан сумын Шуурхайн хөх нуурын хүн чулуу
228	Ховд	14.Мөнххайрхан сумын Тэлэнгэдийн амны буган хөшөө
229	Ховд	15.Үенч сумын Харуул овоо
230	Ховд	16.Ховд сумын Торх улаан уулын хүн чулуу
231	Хөвсгөл	1.Галт сумын Нүхтийн амны буган хөшөө, булшны цогцолбор дурсгал
232	Хөвсгөл	2.Жаргалант сумын Агьтны голын баруун салааны хадны зураг
233	Хөвсгөл	3.Жаргалант сумын Гэлэнхүүгийн суварга
234	Хөвсгөл	4.Жаргалант сумын Жаргалантын дуган
235	Хөвсгөл	5.Жаргалант сумын Тойн эрдэнэ Тээлийн амны арын хүрээний 108 гишгүүр бүхий хийдийн түүрь
236	Хөвсгөл	6.Ренчинлхүмбэ сумын Тарган нуурын буган хөшөөд
237	Хөвсгөл	7.Рэнчинлхүмбэ сумын Тэнгис голын Хоргын шивээ хэмээх чулуун байгууламж
238	Хөвсгөл	8.Улаан-Уул сумын Дээд Цахир, Доод Цахир, Зүүн Шүүрэгтэй, Баруун Шүүрэгтэй уулын булш оршуулгын дурсгалт газар
239	Хөвсгөл	9.Улаан-Уул сумын Толжгий боомын хадны зураг
240	Хөвсгөл	10.Улаан-Уул сумын Шүүрэгтэй талын буган хөшөө, хиргисүүрийн цогцолбор дурсгал
241	Хөвсгөл	11.Улаан-Уул сумын Хориг, Их, Бага Номт уул, Цагаан уул, Ёлт уул, Тархаш уулын булш оршуулгын дурсгалт газар
242	Хөвсгөл	12.Хөвсгөл аймгийн Рашаант сумын Мухтагийн амны бичээс бүхий хөшөө чулуу
243	Хөвсгөл	13.Цэцэрлэг сумын Бага Харгантын хадны зураг
244	Хөвсгөл	14.Цэцэрлэг сумын Жаргалантын амны ноёдын бунхан
245	Хөвсгөл	15.Эрдэнэбулган сумын Даян дээрхийн агуй, хийдийн түүрь
246	Хэнтий	1.Батноров сумын Дүнгэнэдэгийн туурай тамга бүхий хадны зураг
247	Хэнтий	2.Батноров сумын Тунсаг овооны хадны зураг
248	Хэнтий	3.Батширээт сумын Баянголын амны хүн чулуу

249	Хэнтий	4.Батширээт сумын Эгийн Живхээстэйн амны хүн чулуу
250	Хэнтий	5.Баян-Адарга, Норовлин сумын "Чингисийн хэрмэн зам" хэмээх дурсгал
251	Хэнтий	6.Баян-Овоо сумын Ханзат хотын туурь
252	Хэнтий	7.Баян-Овоо сумын Майхан толгойн түүвэр олдворт газар
253	Хэнтий	8.Дархан сумын Талын хөшөөний хүн чулуу
254	Хэнтий	9.Дэлгэрхаан сумын Гүнбүрдийн хүн чулуу, тахилын байгууламж бүхий цогцолбор дурсгал
255	Хэнтий	10.Жаргалтхаан сумын Барууны-Арын хүн чулуу
256	Хэнтий	11.Жаргалтхаан сумын Цэнхэрийн голын хэрэм
257	Хэнтий	12.Мөрөн сумын Баруун, Зүүн хэрэм
258	Хэнтий	13.Мөрөн сумын Салбар уулын бичээс, булш
259	Хэнтий	14.Мөрөн сумын Худагтын амны хүн чулуу
260	Хэнтий	15.Өмнөдэлгэр сумын Хүрэн чулуут уулын хүн чулууд15
261	Хэнтий	16.Хэрлэн сумын Баян бүрдийн Сүүл ухаагийн хүн чулуу
262	Хэнтий	17.Цэнхэрмандал сумын Бургастайн руни бичээс
263	Баянзүрх дүүрэг	1.Анхны холбооны байшин
264	Баянзүрх дүүрэг	2.Сэлбэ голын гүүрний 2 ширхэг чулуун арслан
265	Баянзүрх дүүрэг	3.Консулын дэнжийн нууц бүлгэм байрлаж байсан байшин
266	Баянзүрх дүүрэг	4."Гоожингийн өндөр" хэмээх хоёр давхар барилга
267	Сүхбаатар дүүрэг	5.Бэлхийн амны хүннү булш
268	Сүхбаатар дүүрэг	6.Монгол Улсын Их Сургуулийн нэгдүгээр байрны өмнөх хоёр чулуун арслан
269	Сүхбаатар дүүрэг	7.Анхны орон сууцны хороолол 40 мянгатын 44, 60 дугаар байр
270	Сүхбаатар дүүрэг	8.БНМАУ-ын Засгийн газар байрлаж байсан 3 давхар барилга
271	Сүхбаатар дүүрэг	9.Нэгдүгээр сургуулийн барилга
272	Сүхбаатар дүүрэг	10.Хүүхдийн урлан бүтээх төвийн барилга
273	Сүхбаатар дүүрэг	11.Монгол Улсын Их Сургуулийн хичээлийн төв байр
274	Сүхбаатар дүүрэг	12.Мал, тариалангийн яам байрлаж байсан байшин
275	Сүхбаатар дүүрэг	13.Монгол Улсын Их Сургуулийн анхны хичээлийн байр
276	Сүхбаатар дүүрэг	14.Монголын Үндэсний Номын Сангийн барилга
277	Сүхбаатар дүүрэг	15.Шарга морьтын ам дахь Дондогдулам хатны дурсгалын газар
278	Сүхбаатар дүүрэг	16.Гадаад Харилцааны Яамны барилга

279	Сүхбаатар дүүрэг	17.Д.Нацагдоржийн хөшөө
280	Хан-Уул дүүрэг	18.Богд хааны Хүрэн ордны цогцолбороос үлдсэн дөрвөн барилга
281	Хан-Уул дүүрэг	19.“Буянт Ухаа” нисэх онгоцны буудал байрлаж байсан барилга
282	Хан-Уул дүүрэг	20.Зайсан толгой дахь Зөвлөлтийн дайчдын дурсгалын хөшөөт цогцолбор
283	Чингэлтэй дүүрэг	21.Монголын орчин үеийн анхны “Алтай” зочид буудлын барилга
284	Чингэлтэй дүүрэг	22.Элдэв-Очирын нэрэмжит Хүүхдийн кино театрын барилга
285	Чингэлтэй дүүрэг	23.Анхны их дэлгүүр, кино театрын барилга

ТАЙЛАН БИЧСЭН:  
Г.АНХСАНАА. СОЁЛЫН ӨВИЙГ АВРАН  
ХАМГААЛАХ ГАЗРЫН ДАРГА

----oOo----

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ГАЛУУТ СУМЫН НУТАГТ ОРШИХ ЧИН СҮЖИГТ  
НОМУН ХАНЫ ХҮРЭЭ, БАЯН-ӨНДӨР СУМЫН НУТАГТ ОРШИХ БОСОО  
ХОРООТЫН ПАЛЕОНТОЛОГИЙН ОЛДВОРТ ГАЗАРТ  
АЖИЛЛАСАН ТУХАЙ ТАЙЛАН**

Соёлын өвийн үндэсний төвд 2019 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүй- Байгалийн музейгээс ирүүлсэн албан бичигт тус аймгийн Баян-Өндөр сумын 2-р багийн “Босоо хороот” хэмээх газарт үлэг гүрвэлийн мөр бүхий дурсгалт газар олдсон гэх мэдээллийн дагуу тус газарт 2019 оны 03 дугаар сарын 10-ны өдөр газар дээр нь тус сумын соёлын төвийн эрхлэгч Ж.Болдбаатар, Газрын даамал Т.Төмөрсүх нарын хамт очиж зураг болон уг дурсгалт газрын солбицлыг авч манайд мэдэгдсэн. Уг дурсгалыг авран хамгаалах, малтан судлах ажлыг мэргэжлийн эрх бүхий байгууллагаар хийлгэх. Дурсгалыг орон нутгийн хамгаалалтад авч чадахгүй тул малтан судлуулах шаардлагатай байгааг харгалзан үзэж арван хамгаалах малтан судлах ажлыг нэн даруй хийлгэх хүсэлттэй байна.

Мөн тус музейгээс 2019 оны 9 дүгээр сарын 24-ны өдөр Чин сүжигт номун ханы хүрээ хийдийн “Майдарын сүм” буюу төв дуганы ар талын хана цууралт өгч нуралт өгсөн. Иймд мэргэжлийн эрх бүхий байгууллагаар авран хамгаалах баг ажиллуулж, сэргээн засварлах ажлыг нэн даруй хийлгэх хүсэлтийг уламжилсан байна. Хүсэлтийг Соёлын өвийн үндэсний төвөөс Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газарт хандсан болно.

Дээрх хүсэлт ирүүлсний дагуу 2019 оны 11 сарын 22-25 хооронд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг соёл, урлагийн газрын дарга Г.Эрдэнэбат, Соёл, соёлын өвийн хэлтсийн дарга Н.Мөнхзул, мэргэжлийн урлагийн байгууллага хариуцсан мэргэжилтэн Д.Мөнхцэцэг, Олон нийттэй харилцах, мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтэн У.Одонтуяа. Соёлын өвийн үндэсний төвийн захирал Г.Энхбат, Авран хамгаалах газрын дарга Г.Анхсанаа, Үл хөдлөх дурсгал хариуцсан мэргэжилтэн Б.Амгаланбат, Палеонтологийн хүрээлэнгийн Б.Буянтэгш, Жолооч Б.Шижир. Баянхонгор аймгийн түүх угсаатны зүй-байгалийн музейн Захирал А.Мандах, ЭША Б.Насантогтох, Бүртгэл мэдээллийн санч Б.Эрдэнэхуяг нарын бүрэлдэхүүнтэй баг Чин сүжигт номун ханы хүрээ, босоо хороотын палеонтологийн олдворт газарт танилцах, тандалт судалгаа хийх ажлыг зохион байгууллаа.

Чин сүжигт номун ханы хүрээ: Тус хүрээн нь 1755 онд Ханхар уулын өвөрт Цагаан цэцэрлэг голын ойролцоо Цогчин хурснаар энэ хийдийн үүсэл тавигджээ. Энд 1807 онд 81 жангийн шинэ сүм бариулж, түмэн Аюуш бүтээлгэн залсан байна. Чин сүжигт номун ханы тавдугаар дүрийн хувилгаан Цэдэнбалжирын үед Манжийн эзэн хаанаас "Сайнаар судалсан сүм" хэмээх нэр шагнажээ. VIII Богд Живзундамба хутагтаас хуучин сүмд Дэчиннямлин, шинэ сүмд Самданлхүндэвлин хэмээх нэр тус тус шагнажээ. Зөвхөн шинэ сүм Самданлхүндэвлин нь хоёр зуу гаруй лам хуврагтай байсан бөгөөд нийтдээ 1920-иод оны эхэн үеэр 500-аад ламтай байжээ. Чин сүжигт номун ханы хүрээг удирдаж явсан нэгдүгээр дүр Норовшарав, гуравдугаар дүрийн хувилгаан Жигмэддамбийжалцан нар нь төвд хэлээр хэд хэдэн боть зохиол туурвисан Монголын алдартай эрдэмтэд байв. Ялангуяа Чин сүжигт номын ханы

Гүр дууны бичиг нь эрдэмтдийн анхаарлыг ихээр татаж судлагдаж байна. Чин сүжигт номун ханы хүрээн дээр Чин сүжигтийн Бандида Түвдэнням хэмээх хувилгаан тодорч байжээ. Түвдэнням нь 1915 онд Их хүрээнд залагдаж Их хүрээний Зава Дамдин зэрэг олон лам нарт ванчин жарз гэдэг олон бурхдын жинанг хайрлаж байжээ. Одоогийн Галуут сумын Мандал багт орших хийд нь 1755 онд байгуулагдаад олон сүм байснаас ганц нь л үлджээ. 1999-2003 онд Соёл урлагийн сангийн хөрөнгө оруулалтаар хийдийн гурван сүмийг сэргээн засварлаж, 2003 оны есдүгээр сард ашиглалтад оруулжээ.

Чин сүжигт номун ханы хүрээнд ажиллахад Галуут сумаас сумын засаг дарга С.Баярсайхан, Байгал орчны улсын байцаагч Б.Ганзориг нар замчилж хамтран ажиллав.

Ажлын хэсэг тус хийдийн нөхцөл байдалтай танилцаж, “Майдарын сүм”-ийн баруун тал болон хойд талын цууралт үүссэн болон нурсан хэсгийг баримтжуулалт хийв.

Босоо хороотын Палеонтологийн олдворт газар: Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын нутагт үлэг гүрвэлийн мөр илэрсэн гэх мэдээллийг анх нутгийн иргэд өгсний дагуу 2019 оны 2-р сарын 26 нд Соёлын төвийн эрхлэгч Ж. Болдбаатар аймгийн музейд мэдээлсэн бөгөөд энэ талаар 2019 оны 4 дүгээр сарын 10-д Соёлын өвийн үндэсний төвд албан бичгээр хандсан байна.

Соёлын өвийн үндэсний төвөөс ШУА-ийн Палеонтологийн хүрээлэнд мөн энэ талаар амаар мэдэгдсэн байна. 2019 оны 6 дугаар сард ШУА-ийн хүрээлэнгийн Палеонтологич Палеонтологийн хүрээлэнгийн Б.Майнбаяр, Б.Буянтэгш нар Баянхонгор аймгийн Баян-Өндөр, Шинэжинст сумдын нутагт байх нүүрсний уурхайгаас Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт байх Шивээ хүрэнгийн боомт хүртэлх 297 км хатуу хучилт бүхий тээврийн авто замын трассын дагуу судалгаа хийх явцдаа тус олдворт газрыг нягтлан шалгасан байна.

Манай ажлын хэсэг Босоо хороотын палеонтологийн олдворт газар ажиллахад Баян-Өндөр сумын ИТХ-ын дарга Б.Далай, Соёлын төвийн эрхлэгч Ж.Болдбаатар, Малчин Б.Түмэннаст, Х.Алтангэрэл нарын хүмүүс байлцсан бөгөөд олдворт газрын нөхцөл байдалтай танилцан, иргэдийн зааж өгсөн зарим мэдээллийг шалгаж, агаарын зураг авлаа.

Тус олдворт газар нь сумаас зүүн урагш 38 орчим км-т Дэлийн шанд буюу 2-р багийн нутагт орших ухаа, улаан саарал цайвар цагаан өнгийн эртний тунамал хурдас бүхий байгалийн илэрц газарт очиж шалгаж үзэн 21.20 см урт талбайд байрших 28 ширхэг хуягт үлэг гүрвэлийн байж болох явж өнгөрсөн мөрний байгалийн хэв, 2 ширхэг 40 x 54 см хэмжээтэй завропод маягийн үлэг гүрвэлийн мөр болон эртний ургамлын үлдэгдлийг мөн илрүүлсэн байна. Уг олдворт газрыг Палеонтологич Б.Буянтэгш палеонтологийн судалгаанд чухал ач холбогдолтой томоохон олдворт газар байж болох юм гэсэн таамгийг дэвшүүлж байв.

## САНАЛ, ДҮГНЭЛТ

- Чин сүжигт номун ханы хүрээ хийдийн нь Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 175 дугаар тогтоолоор Улсын хамгаалтад байх дурсгалын жагсаалт орсон бөгөөд тус хийдийн “Майдарын сүм”-ийн цууралт, нуруулт нь газрын

хөрсний гүний хөдөлгөөнөөр үүссэн байж болох бөгөөд орон нутгийн холбогдох байгууллагууд БСШУСЯ-нд хандаж санхүүжилтийг шийдвэрлэн, сүмийн гэмтлийг тодорхойлон, мэргэжлийн байгууллагуудтай хамтран сэргээн засварлах төлөвлөгөөг боловсруулах,

- Босоо хороотын палеонтологийн олдворт газрыг эхний ээлжид илэрцийн хил хязгаарыг тогтоож, дэвсгэр зургийг мэргэжлийн байгууллагатай хамтран хийж, богино хугацаанд судалгаа шинжилгээний эргэлтэд оруулах,
- Судалгааны ажлын явцад хадгалалт хамгаалалтын төлөвлөгөөг холбогдох байгууллагууд хийж, тухайн газраас зөөж, шилжүүлэх, авран хамгаалах болон газар дээр нь үлдээх олдворуудыг тодорхойлох зэрэг үйл ажиллагааг эхлүүлэх,



*Зураг 1. Чин сүжигт номун ханы хүрээ хийд*




*Зураг 2. Чин сүжигт номун ханы хүрээ хийдийн агаарын зураг*



*Зураг 3. Чин сүжигт номун ханы хүрээ хийдийн  
“Майдарын сүм”-ийн буруун ханын цуурсан байдал*



*Зураг 4. Чин сүжигт номун ханы хүрээ хийдийн "Майдарын сүм"-ийн буруун ханын цуурсан байдал*



*Зураг 5. Чин сүжигт номун ханы хүрээ хийдийн "Майдарын сүм"-ийн буруун ханын цуурсан байдал*




*Зураг 6. Чин сүжигт номун ханы хүрээ хийдийн "Майдарын сүм"-ийн арын ханын нурсан байдал*





*Зураг 7. Чин сүжигт номун ханы хүрээ хийдийн “Майдарын сүм”-ийн арын ханын нурсан байдал*



*Зураг 8. Чин сүжигт номун ханы хүрээ хийдийн “Майдарын сүм”-ийн арын ханын нурсан байдал*



*Зураг 9. Босоо хороотын палеонтологийн олдворт газрын ерөнхий байдал*



*Зураг 10. Босоо хороотын палеонтологийн олдворт газрын Үлэг гүрвэлийн мөр*



*Зураг 11. Босоо хороотын палеонтологийн олдворт газрын Үлэг гүрвэлийн мөр*



*Зураг 12. Босоо хороотын палеонтологийн олдворт газрын Үлэг гүрвэлийн мөрний зураг авч буй байдал*



*Зураг 13. Баянхонгор аймагт ажилласан багийн  
бүрэлдэхүүн, орон нутгийн төлөөлөл*

ТАЙЛАН БИЧСЭН:  
Г.АНХСАНАА. СОЁЛЫН ӨВИЙГ АВРАН  
ХАМГААЛАХ ГАЗРЫН ДАРГА

-----oOo-----

## **“СОЁЛЫН БИЕТ БУС ӨВ БА ДЭЭД БОЛОВСРОЛ: МОНГОЛ УЛСЫН ИХ, ДЭЭД СУРГУУЛИУДЫН ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ” СУРГАЛТЫГ ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛСАН ТУХАЙ ИЛТГЭХ ХУУДАС**

“Соёлын биет бус өв ба дээд боловсрол: Монгол Улсын их, дээд сургуулиудын чадавхыг бэхжүүлэх нь” сэдэвт сургалтыг Соёлын өвийн сүлжээ, харилцаа холбооны зөвлөл ТББ, Соёлын өвийн үндэсний төв, ЮНЕСКО-гийн итгэмжит байгууллага болох БНХАУ-д төвтэй Соёлын биет бус өвийн олон улсын сургалтын төв (CRINAP) хамтран 2019 оны 11 дүгээр сарын 28-наас 30-ны өдрүүдэд Монгол Улсын их, дээд сургуулийн багш нарт зориулан Улаанбаатар хотноо зохион байгууллаа.



Энэхүү сургалтын гол зорилго нь их, дээд сургуулийн хөтөлбөрөөр дамжуулан Соёлын биет бус өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, ЮНЕСКО-ийн Соёлын биет бус өвийг хамгаалах тухай 2003 оны Конвенцийн талаархи их, дээд сургуулийн багш нарын мэдлэг, ойлголт, чадавхыг нэмэгдүүлэх, СББӨ-г хамгаалах, Конвенцийг хэрэгжүүлэхэд тэдний үүрэг, оролцоог тодорхойлох байв.

Сургалтыг ЮНЕСКО-гийн итгэмжит сургагч багш, мэргэжилтнүүд болох Сюзанн Ог, А.Саруул нар “Монгол улс дахь Соёлын биет бус өв”, “СББӨ ба боловсрол: Монгол Улсын байр суурь: өнөөгийн байдал, хэрэгцээ шаардлага, тулгарч байгаа сорил, санаа”, “Конвенцийн суурь зарчим, үзэл баримтлал”, “Боловсрол болон олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх”, “Хамт олны оролцоо, ёс зүйн дүрэм, хамрах хүрээ болон урьдчилсан мэдэж ойлгосны үндсэн дээр чөлөөтэй өгөх зөвшөөрөл”, “СББӨ ба тогтвортой хөгжил”, “Хадгалалт, хамгаалалт ба алхам бүрийн хөтөч”, “Бүртгэл ба боловсрол”, “СББӨ-ийн хадгалалт, хамгаалалт ба боловсрол” зэрэг сэдвийн хүрээнд онолын мэдлэг олгох, дадлага ажиллуулах байдлаар зохион байгуулав.



Сургалтад МУИС, МУБИС, ШУТИС, СУИС, Монгол Улсын Консерватор, Монгол Улсын Эрдмийн Их Сургууль, Отгонтэнгэр, Идэр, Ховд, СУИС-ийн Завхан аймаг дахь Хөгжим Бүжгийн Коллеж, Монголын Үндэсний Их Сургууль, Соёл эрдэм зэрэг их, дээд сургуульд бакалавр, магистр, докторын түвшинд соёлын биет бус өв, соёлын өв, угсаатан зүй, антропологи, соёл судлал, түүх, сэтгүүл зүй, аялал жуулчлалын чиглэлээр хичээл заадаг 35 багш хамрагдав.



Сургалтын явцад оролцогчид ЮНЕСКО-гийн Соёлын биет бус өвийг хамгаалах тухай 2003 оны Конвенци, түүний хэрэгжилтийн талаархи онолын мэдлэг

ойлголтыг, өөрийн орны болон олон улсын жишээ, туршлагуудтай хослуулан суралцснаас гадна, соёлын биет бус өвийг өөрсдийн сургуульд хэрхэн зааж, сургалтын хөтөлбөрт оруулсан талаархи туршлагыг хуваалцаж, багийн ажлын явцад соёлын биет бус өвийн хадгалалт, хамгаалалтын төлөвлөгөөг боловсруулж, цаашид их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт соёлын биет бус өвийн хадгалалт, хамгаалалтыг хэрхэн тусгах, багш нарын үүрэг оролцоог хэрхэн хангах талаар зөвлөмж боловсруулж холбогдох яаманд хүргүүлэхээр болов.



ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН:  
Ц.ЦОЛМОН. СОЁЛЫН ӨВИЙГ АВРАН  
ХАМГААЛАХ ГАЗРЫН ДЭЛХИЙН ӨВИЙН  
ДУРСГАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

-----oO-----

## ЮНЕСКО-ИЙН СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙГ ХАМГААЛАХ ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН 14 ДҮГЭЭР ХУРАЛДААНД МОНГОЛЫН ТӨЛӨӨЛӨГЧИД ОРОЛЦСОН ТУХАЙ ИЛТГЭХ ХУУДАС

ЮНЕСКО-ийн Соёлын биет бус өвийг хамгаалах Засгийн Газар Хоорондын Хорооны 14 дүгээр хуралдаан Бүгд Найрамдах Колумби улсын Богота хот дахь “Агора” Олон Улсын Конвенийн төв дээр 2019 оны 12 дугаар сарын 09-өөс 15-ны өдрүүдэд зохион байгуулагдлаа. Хуралдаанд Конвенцийн гишүүн 134 орны төлөөлөл, хөндлөнгийн ажиглагч нийлсэн 1400 орчим хүн оролцов.



Уг хуралд Монгол улсыг төлөөлж БСШУС-ын сайд Ё.Баатарбилэг тэргүүтэй 10 хүний бүрэлдэхүүнтэй баг оролцлоо. Багийн бүрэлдэхүүнд, Байгаль Орчин, Аялал жуулчлалын яамны төрийн нарийн бичгийн дарга Ц.Цэнгэл, мөн тус яамны Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн Б.Түвшинжаргал, БСШУСЯ-ны Соёл, Урлагийн Бодлогын Газрын дарга Б.Сэргэлэн, мөн тус яамны Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн Б.Энхбаяр, ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний Комиссын Ерөнхий Нарийн бичгийн дарга С.Уянга, ЮНЕСКО-ийн итгэмжит Байгаль, соёлын өвийг хамгаалах сангийн тэргүүн Н.Уртнасан, Соёлын өвийн үндэсний төвийн Соёлын өвийг амран хамгаалах газрын Дэлхийн өвийн мэргэжилтэн Ц.Цолмон нар ажиллав.

Тус хурлын хэлэлцэх асуудлын 10 б хэсэгт Үнэлгээний хэсгийн дарга Монгол Улсаас Хүн төрөлхтний соёлын биет бус өвийн төлөөллийн жагсаалтад нэр дэвшүүлсэн “Хөхүүрийн айраг исгэх уламжлал, холбогдох зан үйл” өвийн материалд хийсэн Үнэлгээний хэсгийн хяналт, дүгнэлтийг танилцуулж, тодруулга материалыг хэлэлцсэн. Тодруулганд хүргүүлсэн материалыг хангалттай гэж үзээд, жагсаалтанд бүртгэхийг дэмжиж, шалгуур R1-ээс R5 хүртэл батлаж “Хөхүүрийн айраг исгэх уламжлал, холбогдох зан үйл” өвийг ЮНЕСКО-ийн Хүн төрөлхтний соёлын биет бус өвийн төлөөллийн жагсаалтад бүртгэснийг албан ёсоор зарлав.





Хурлын явцад Хорооны дэргэдэх Үнэлгээний хэсэг 2019 онд Яаралтай Хамгаалах Шаардлагатай СББӨ-ийн жагсаалтанд бүртгэгдсэн *4 өвийн тайлан*, Яаралтай Хамгаалах Шаардлагатай Соёлын Биет Бус Өвийн жагсаалтанд нэр дэвшүүлсэн *6 өвийн материал*, Хүн Төрөлхтөний Соёлын Биет Бус Өвийн жагсаалтанд нэр дэвшүүлсэн *42 өвийн материал*, Олон улсын тусламж хүссэн *1 хүсэлт*, Сайн хадгалалт, хамгаалалтын жагсаалтанд нэр дэвшүүлсэн *3 өвийн төсөл*, ТББ-ыг магадлан итгэмжлүүлэх *63 хүсэлт*, магадлан итгэмжлэгдсэн *81 ТББ-ын тайланд шалгалт хийж, холбогдох шийдвэрийн саналыг Хороонд хүргүүлснээ танилцууллаа.*

ЮНЕСКО-ийн Соёлын Биет Бус Өвийг Хамгаалах Засгийн Газар Хоорондын Хуралдаанд Монгол Улсаас өргөн бүрэлдэхүүнтэй баг явсан нь, мөн Соёлын өвийн үндэсний төвийн төлөөлөл оролцсон хурлын явцыг биечлэн ажиглах, Монгол улсын үүрэг оролцоог тодорхойлох, Хорооны гишүүн улсууд болон бусад Конвенцийн Гишүүн улсуудтай харилцах, хамтран санал солилцох, цаашлаад дараа дараагийн хуралд баг бүрэлдэхүүн, мэргэжлийн шинжээчдийн оролцоог тодорхойлоход арвин туршлага хуримтлуулсан ажил боллоо.

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН:

Ц.ЦОЛМОН. СОЁЛЫН ӨВИЙГ АВРАН

ХАМГААЛАХ ГАЗРЫН ДЭЛХИЙН ӨВИЙН

ДУРСГАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

---oOo---

## ГУРАВ. “СОЁЛЫН БИЕТ ӨВИЙГ СЭРГЭЭН ЗАСВАРЛАХ” СТРАТЕГИЙН ЗОРИЛТЫГ ХАНГАХ АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ

### 3.1. Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл, археологийн олдвор эд зүйлийг бэхжүүлэх, сэргээн засварлах

- 6 байгууллагын 17 үзмэр сэргээн засварлах.

2019 онд музейн үзмэрийн улсын нэгдсэн тооллого хийгдсэнтэй холбогдон эхний 2 улиралд музейгээс үзмэр сэргээн засварлах санал аваагүй болно. Өмнөх онуудаас он дамжсан үзмэрүүдийн сэргээн засварлалтыг хийж гүйцэтгэхээр ажиллаж, нэмэлтээр үзмэр, олдворуудад сэргээн засварлалт, хадгалалт хамгаалалтын ажлуудыг хийсэн.

“Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл, археологийн олдвор эд зүйлийг бэхжүүлэх, сэргээн засварлах гэсэн ажил, үйлчилгээнд тусгагдсан улс, аймгийн **14 музейн 107ш** үзмэр, нэмэлтээр **5 байгууллагын 106ш** үзмэр, олдворууд **нийт 213 ширхэг музейн үзмэр, археологийн олдворуудад** хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалтын ажил хийж гүйцэтгэлээ.

## I. СЭРГЭЭН ЗАСВАРЛАЛТ, ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТЫН АЖИЛ ХИЙГДСЭН ҮЗМЭР

### 1. Танка зураг – 8ш

Чойжин ламын сүм музей

- “Аюуш” бурхан, танка зураг
- “Цагаан дарь эх”, танка зураг
- “Жүгдэрнамжил”, танка зураг

Дорнод аймгийн музей

- “Балданлхам”, танка зураг, № 66-16-4
- “Цагаан дарь эх”, танка зураг, № 66-16-2
- “Говийн Лха”, танка зураг, № 66-16-1
- “Далха дэдгү”, танка зураг, № 66-16-3
- “Цамбагарав”, танка зураг, № 66-16-5

/зураг 1, 2,3,4/

### 2. Уран зураг – 9ш

Монгол цэргийн музей

- “Энхжин мөнхөжсөн Халх гол”
- “Халх голын тэнгэрт”
- “Чойбалсан”
- “Байтаг богдын тулаан”
- “Хатанбаатар Магсаржав”
- “Өлгий нутгаа өмгөөлөхөөр”
- “Чогдонгийн атак”

/зураг 5,6,7,8/

Театрын музей

- “Хөгжмийн хичээл”
- “Хөгжимчин О. Дашдэлэг”

### **3. Баримал - 9**

Уран зургийн галерей

- “Инээд”, уран баримал, гипс, № 66,01
- “Чойбалсан”, уран баримал, гипс, № 89,11
- “Сүхбаатар”, уран баримал, гипс, № 89,34
- “Эмнэг сургагч”, уран баримал, гипс, № 64,01

Хэнтий аймгийн музей

- “Дамдин” бурхан, цаасан шуумал, № 59-19
- “Ленин”, уран баримал, гипс,

Хөвсгөл аймгийн музей

- “Цаатан”, уран баримал, холимог техник, № ү-65-13

Баян-Өлгий аймгийн музей

- “Саз сырнай”, хөгжмийн зэмсэг, гипс, № БӨМ 1988,04

Чойжин ламын сүм музей

- “Жамсран”, модон сийлбэр

/Зураг 9,10,11,12/

### **4. Металл эдлэл - 6ш**

Эрдэнэ-Зуу музей

- “Босоо Майдар”, металл бурхан, 4ш үүнээс 1ш хосгүй үнэт
- “Суугаа Майдар”, металл бурхан 1ш
- “Дүйнхор”, металл бурхан 1ш

/зураг 13,14/

### **5. Модон эдлэл – 18ш**

Өвөрхангай аймгийн музей

- “Цахиур буу”

Улаанбаатар хотын музей

- “Монгол зөвлөлтийн найрамдал” сэргээн засварлалт хийгдэж байгаа

Баян-Өлгий аймгийн музей

- “Айрагны хутгуур”
- “Домбо”

Дундговь аймгийн музей

- “Морин хуур”

Богд хааны ордон музей

- “Ирвэсийн арьсан гэр”- ийн модон эдлэл 13ш

### **6. Даавуу зөөлөн эдлэл – 25ш**

Дундговь аймгийн музей

- “Жанч” 1ш

Чойжин ламын сүм музей

- “Лавир”

- “Тохойвч” 2ш
- Увс аймгийн музей
- “Цэгдэг, тэрлэг”
- Богд хааны ордон музей
- “Ирвэсийн арьсан гэр”- ийн даавуу зөөлөн эдлэл 19ш

### **7. Археологи – 32ш**

Дархан уул аймгийн музей

- “Ваар” 1ш

Сүхбаатар аймгийн онгон сумаас олдсон

- Бурхан, тахилын эд зүйлс болох 15 дэсийн 31 ширхэг эд өлгийн зүйлс 2019 онд үр дүнгийн гэрээнд тусгагдсан улс, аймгийн 14 музейн 107ш үзмэр

### **Нэмэлт ажлууд**

ШУА-ийн Археологийн хүрээлэн

- “Хүйс толгойн 1р хөшөө”-ний хэв авах ажил, Засгийн газрын ордонд байрлуулсан ажил

Гандан тэгчинлин хийд

- “Дондогдулам хатны дамар” 1ш
- Малгай, дээл, гутал, дэнгав, намшир, лагай, шантов, цамц, оймс зэрэг 32ш даавуу зөөлөн эдлэл

Түүхийн хүрээлэн

- Үйсэн бичиг 26ш
- Шаазан аяга 1ш

Уран зургийн галерей

- “Алтайн уулс”, уран зураг

Үндэсний музей

- Айргийн гозгорын археологийн малтлагаас гарсан 43ш археологийн олдвор

## **II. БОГД ХААНЫ ОРДОН МУЗЕЙД ХАДГАЛАГДАЖ БУЙ “ИРВЭСИЙН АРЬСАН ГЭР”- ИЙГ СЭРГЭЭН ЗАСВАРЛАСАН АЖИЛ**

Төслийн тухай

Богд хааны ордон музей өөрийн сан хөмрөгт хадгалагдаж байдаг “Ирвэсийн арьсан гэр”- ийг сэргээн засварлахаар Америкийн нэгдсэн улсын элчин сайдын Соёлын өвийг хамгаалах сангийн дэмжлэгийг хүлээн авсан бөгөөд уг сэргээн засварлах төслийн гүйцэтгэх ажлыг Соёлын өвийн үндэсний төвтэй хамтран хийхээр тохиролцож, хоёр тал уулзалдаж уг ажлыг төлөвлөж 2018 оны 11 дүгээр сарын 20нд № 67/05 дугаар бүхий гэрээг байгуулан хамтарч ажиллав.

Уг төслийн хүрээнд сэргээн засварлалтад хамрагдсан эд зүйлсийг тоймловол дээвэр, туурга, өрх, хөшиг, олбог, аравч зэрэг даавуу зөөлөн эдлэлүүд, унь, тооно, хана, хаалга, багана гэх мэт модон эдлэлүүд нийт 2 төрөл зүйлд хамаарах 25 ширхэг гэрийн

иж бүрдэл хэсгүүд сэргээн засварлах ажилд хамрагдсан байна. Сэргээн засварлах ажлын төлөвлөлт, судалгаа, сэргээн засварлалт зэрэг шат, шатны ажлын бүрэлдэхүүнд Соёлын өвийн төвийн захирал Г.Энхбат, Соёлын биет өвийг сэргээн засварлах газрын дарга Д.Нямдорж даавуу зөөлөн эдлэлийн сэргээн засварлагч Б.Мягмарсүрэн, О.Оюунчимэг, Г.Ууганчимэг модон эдлэлийн сэргээн засварлагч Т.Сүхбаатар сэргээн засварлагч Э.Батжаргал нар оролцон ажиллав.

Энэхүү цэвэрлэгээ, бэхжүүлэлт, сэргээн засварлалт, хадгалалт хамгаалалтын ажлыг хийж гүйцэтгэхдээ дурсгалын онцлогт таарсан аргазүйг ашиглаж хадгалалт хамгаалалт, бэхжүүлэлт, сэргээн засварлалтын ажлыг төлөвлөн хийж гүйцэтгэв.

№	Он Сар Хийгдэх ажлууд	2019						
		4 сар	5 сар	6сар	7сар	8сар	9сар	10сар
1	Ирвэсийн арьсан гэрийн хадгалалтын нөхцөл байдалтай танилцаж, төлөвлөгөө, арга зүй боловсруулах							
2	Төслийн гүйцэтгэлд шаардлагатай материалыг бэлдэх, татах							
3	Сэргээн засварлалтад үе шаттайгаар хүлээж авах							
4	Сэргээн засварлах ажил хийгдэх, үргэлжлэх							
5	Ажлын гүцэтгэлийг дүгнэх, төслийн гүйцэтгэлийг тайлагнах							

## Төслийн зорилго

Уг төслийн зорилго нь түүх, соёлын өндөр ач холбогдол бүхий Богд хааны “Ирвэсийн арьсан гэр” дурсгалд бэхжүүлэлт, сэргээн засварлалт хийж хадгалалтын байдлыг сайжруулахад оршино. Төслийн хэрэгжилтийг доорх үе шат, хуваарийн дагуу гүйцэтгэв.

### Богд хааны ордон музейд хадгалагдаж байгаа Богд хааны ирвэсийн арьсан бүрээстэй гэрийг сэргээн засварлах ажлын судалгаа

Богд хааны ирвэсийн арьсан гэрийг сэргээн засварлах ажил эхлэхийн өмнө гэрийг музейн үзмэрт байхад Соёлын өвийн үндэсний төвийн соёлын биет өвийг сэргээн засварлах газрын сэргээн засварлагчдаас бүрдсэн баг газар дээр нь очиж хадгалалтын байдалтай танилцаж, гэмтэл бохирдлын судалгаа, хэмжилт хийж тодорхойлолт, гэмтлийн гар зураглал хийн эхний байдлаар уг гэрийн сэргээн засварлах ажлын анхан шатны төлөвлөгөө, хэрэгцээт материалын жагсаалт, хэмжээ, ажиллах хугацаа зэргийг тооцож гаргасан.

#### 1. Даавуу зөөлөн эдлэл

№	Гэрийн иж бүрдэл хэсгийн нэр	Зураг	Хэмжээ	Гэмтэл бохирдол	Хийгдэх ажил
1	Гэрийн зүүн хаяавч		9,53м х 0,30м	Цайвар шаргал өнгийн торгон дээр улаан хүрэн өнгийн торгоор хас болон ланз хээ оёж гадна хүрээг мөн торгоор эмжсэн. Их хэмжээний тоос шорооны бохирдолтой, усны толботой, өмнө нь шинээр сэлбэж байсан ба хуучин эх хэсэг болох 1/3 хэсгийн ар цайвар торго ихэд үжирч муудсан дээрх ланз хээ мөн үжирч муудсан байна	Цэвэрлэгээ хийх. Хуучин эх хэсэг болох 1/3 хэсэгийн ар цайвар торго үжирч муудсан тул энэ хэсгийн торгыг солих ингэхдээ боломжтой бол дээрх ланз хээг эх байдлаар нь буцааж бэхлэх. Хэрэв ингэх нь боломжгүй тохиолдолд гэмтэлтэй муудсан хэсгийг шинээр сэргээж хийх шаардлагатай.

2	Гэрийн баруун хаяавч		9,10м х 0,30м	<p>Мөн ижил цайвар шаргал өнгийн торгон дээр улаан хүрэн өнгийн торгоор хас болон ланз хээ оёж гадна хүрээг мөн торгоор эмжсэн. Их хэмжээний тоос шорооны бохирдолтой, усны толботой, өмнө нь шинээр сэлбэж байсан ба хуучин эх хэсэг болох 1/3 хэсэгийн ар цайвар торго ихэд үжирч муудсан дээрх ланз хээ мөн үжирч муудсан байна</p>	<p>Цэвэрлэгээ хийх. Хуучин эх хэсэг болох 1/3 хэсэгийн ар цайвар торго үжирч муудсан тул энэ хэсгийн торгыг солих ингэхдээ боломжтой бол дээрх ланз хээг эх байдлаар нь буцааж бэхлэх. Хэрэв ингэх нь боломжгүй тохиолдолд гэмтэлтэй муудсан хэсгийг шинээр сэргээж хийх шаардлагатай.</p>
3	Эсгий хаалга /ирвэсийн арьсан/		164см х 115см	<p>Эсгий хаалганы ар талыг торгоор өнгөлж гадрыг ирвэсийн арьсаар өнгөлж хар хамба хилэн хүрээ эмжээр хийсэн байна. Тоос шорооны бохирдол ихтэй. Ирвэсийн арьс бүхий хэсэгт баруун доод талаас дээш чигт 20см х 70см томоохон урагдалтай, арьс хэврэгшиж урагдаж зарим хэсгээрээ унасан байна. Зарим хэсгээрээ оёдол ханзарсан арласан даавуу нь 2 хажуу ухаараа сэмэрсэн байна.</p>	<p>Цэвэрлэгээ хийх. Эсгий хаалга 30% орчим гэмтэлтэй. Оёдол урагдсан хэсгийн оёдлыг гүйцээж бэхжүүлэх, мөн ирвэсийн арьсан хэсгийн уранхайг нөхөх сэлбэх. Даавууны сэмэрсэн хэсгийг бэхжүүлэх</p>

4	Өрх /ирвэсийн арьсан/		143см х 145см	Өрхийг өөр өөр өнгө бүхий торгоор доторлосон, ирвэсийн арьсаар гадарлаж хар хамбан хүрээ хийсэн. Арьс хэсэгт 40% урагдал гэмтэлтэй, гэмтлийн үндсэн хэсэг нь өрхний тоонон дээр доош харж байрлах хэсэгт зонхилж байна , дотор торго их хэмжээний гэмтэл урагдалтай. Их хэмжээний бохирдолтой	Цэвэрлэгээ хийх. Арласан торго, даавууг шинээр сольж сэлбэх, ирвэсийн арьсан хэсгийн уранхайг бэхжүүлэх, шаардлагатай хэсэгт нөхөлт хийх
5	Халз /баруун/		685см х 515см	Ирвэсийн арьсан гадартай улаан, шар, хөх даавуун эмжээртэй, эмжээрийн өнгө гандсан, урагдсан, ирвэсийн арьс 2хэсэг газар цоорхой, 10% орчим урагдал гэмтэлтэй, тоос шорооны бохирдол ихтэй	Цэвэрлэгээ хийх, урагдсан ханзарсан хэсгүүдийг оёж бэхжүүлэх, цоорхой хэсгийг нөхөх.
6	Халз /зүүн/		695см х 525см	Ирвэсийн арьсан гадартай улаан, шар, хөх даавуун эмжээртэй. эмжээрийн өнгө гандсан, урагдсан, ирвэсийн арьс 6н хэсэг газар дутуу цоорхой байна. Ар талын хөх даалимба хэсэг урагдсан. Гэмтлийн хувь хэмжээ 30% орчим байна.	Цэвэрлэгээ хийх, урагдсан ханзарсан хэсгүүдийг оёж бэхжүүлэх, цоорхой хэсгийг нөхөх.
7	Урд дээвэр		530см х 195см	Дотор талыг доторлосон торго нилээд муудаж үжирсэн олон тооны нөхөөстэй.	Цэвэрлэгээ хийх. Дотор торгыг шинээр сэлбэх, урагдаж цоорсон хэсгийг



				Баруун урд хэсэг газарт ус чийг орж арьс дарайж хатсан. 3хэсэг газарт урагдалтай байна. Мөн доод хүрээг эмжсэн улаан цайвар цэнхэр цацаг чимэг баруун үзүүр хэсэгт 50см орчим дутуу байна. Тоос шорооны их хэмжээний бохирдолтой.	нөхөж бэхжүүлэлт хийх.
8	Хойд дээвэр		550см х 208см	Дотор талыг доторлосон торго их хэмжээний уранхай болон нөхөөстэй, ирвэсийн арьсны доод ирмэг урагдаж халцарсан нийт гэмтэл 30-40% орчим, тоос шорооны их хэмжээний бохирдолтой.	Цэвэрлэгээ хийх, урагдаж муудсан дотор торгыг шинээр сэлбэх, ирвэсийн арьсны халцарч муудсан урагдсан хэсгийг шинээр нөхөж гүйцээх.
9	Зүүн туурга		370см х 173см	Туурганы оёдол сэмэрч салсан 3-4 хэсэгт урагдаж цоорсон, хүрээ хэсгийн цэнхэр торго урагдаж сэмэрсэн цоорсон. Арьс нь 20% орчим гэмтэлтэй. Ар талыг хөх даавуугаар бүрсэн байна. Тоос шорооны бохирдол ихтэй.	Цэвэрлэгээ хийх, хүрээ цэнхэр торгыг оёж бэхжүүлэх, урагдаж цоорсон хэсгүүдийг оёж бэхжүүлэн дутуу хэсэгт нөхөлт хийх.
10	Зүүн хойд туурга		370см х 168см	Дээд хүрээ торго 2 хэсэгт урагдаж сэмэрсэн, туурга хооронд зөрдөг босоо эмжээр даавуу сэмэрсэн, ирвэсийн арьсны үс халцарсан ойролцоогоор 10% орчим гэмтэлтэй, тоос	Цэвэрлэгээ хийх, урагдсан дээд хүрээ эмжээр даавуу хэсгийг оёж бэхжүүлэх, халцарч урагдсан ирвэсийн


				шорооны бохирдол ихтэй.	арьсийг шинээр нөхөх оёдол сэмэрч суларсан хэсгүүдийг бэхлэх.
11	Баруун хойд туурга		436см х 161см	Ирвэсийн арьс 2 хэсэг газарт урагдсан, үс халцарсан, оёдол ханзарсан, доод хэсгээрээ ус чийгэнд норж хатахдаа арьс хатуурсан, ойролцоогоор 10% урагдал гэмтэлтэй, их хэмжээний тоос шорооны бохирдолтой.	Цэвэрлэгээ хийх, ирвэсийн арьс урагдсан, оёдол ханзарсан хэсгүүдийг оёж бэхжүүлэх, үс халцарсан хэсэгт нөхөлт хийх.
12	Баруун урд туурга		460см х 170см	Ирвэсийн арьсан туурга баруун урд хэсгээрээ ус чийгний гэмтэлтэй, усанд норж хатахдаа дарайж хатуурсан, 2 хэсэгт урагдаж цоорсон, 10% орчим урагдал гэмтэлтэй, туурганы зөрдөг хэсгийн даавуун зөрүүлгэний даавуу сэмэрч муудсан. Даавуун ар дээр усны толбо тогтож үлдсэн, тоос шорооны их хэмжээний бохирдолтой.	Цэвэрлэгээ хийх, урагдаж сэмэрсэн хэсгүүдийг оёж бэхжүүлэх, 2 хэсэг газарт ирвэсийн арьсийг нөхөх.
13	Зүүн хөшиг		513см х 184см	Зарим хэсэгтээ язарч урагдсан, сэмэрсэн, торгоны нэхээс суларч хэврэгшсэн, өнгө гандсан, ойролцоогоор 30% орчим гэмтэлтэй, тоос шорооны бохирдол ихтэй.	Цэвэрлэгээ хийх, торгоны сэмэрч урагдсан болон хэт хэврэгшсэн хэсгүүдийг оёж бэхжүүлэх.

14	Хойд хөшиг		655см х 182см	Торгон хөшигний торго нэхээс суларч муудсан, өнгө гандсан, сэмэрч урагдсан ойролцоогоор 30% орчим гэмтэлтэй, тоос шорооны бохирдол ихтэй.	Цэвэрлэгээ хийх, торгоны сэмэрч урагдсан болон хэт хэврэгшсэн хэсгүүдийг оёж бэхжүүлэх
15	Баруун хөшиг		490см х 178см	Торгон хөшигний торго нэхээс суларч муудсан, өнгө гандсан, сэмэрч урагдсан ойролцоогоор 30%-40% орчим гэмтэлтэй, тоос шорооны бохирдол ихтэй.	Цэвэрлэгээ хийх, торгоны сэмэрч урагдсан болон хэт хэврэгшсэн хэсгүүдийг оёж бэхжүүлэх
16	Орны аравч			Улаан өнгийн торгыг хүрээ модонд татаж хийсэн орны аравч хэсэг нь торго нилэнхүйдээ нэхээс суларсан, зарим хэсэгтээ сэмэрч урагдсан, таталт суларч хүлхийсэн. Тоос шорооны бохирдолтой.	Цэвэрлэгээ хийх. Торгоны суларч урагдсан хэсгүүдийг оёж бэхжүүлэх, ар талд нь хөнгөн зөөлөвч хийж арлах
17	Орны олбог /2ш/			Голоороо нугардаг, 2салангид хэсэг бүхий олбогны өнгө торго хэрэглээ болон он цагийн явцад үжирч муудан зах ирмэг хэсгүүдээр сэмэрч урагдсан гэмтэлтэй	Цэвэрлэгээ хийх, урагдаж сэмэрсэн хэсгүүдийг оёж бэхжүүлэх.
18	Гэрийн гадуур бүс 2ш			Дээсийг торгон даавуугаар өнгөлж оёсон гэрийн гадар бүслүүр 2ш. Эдгээр нь хэрэглээ болон он цагийн явцад гадна торгон бүрээс урагдаж сэмэрсэн байна	Шаардлагатай хэсгүүдэд оёдол бэхжүүлэлт хийх


19	Гэрийн дотор бүс			Гэрийн дотор бүс нь мөн дээсийг даавуугаар бүрж хийсэн ба 2ширхэг байхаас нэг нь үгүй болж энгийн олсоор орлуулан хийсэн байна	Олсоор орлуулж хийсэн гэрийн дотор бүсийг шинээр уламжлалт үндсэн хийцийг хадгалан шинээр хийх.
----	------------------	---	--	--	---

## 2. Модон эдлэл


№	Гэрийн бүрдэл хэсгийн нэр	Зураг	Тоо хэмжээ	Гэмтэл бохирдол	Хийгдэх ажил
1	Тооно		1ш	Тоононы модон хийцийн наалт нилэнхүйдээ суларсан, чимэглэж хийсэн зүмбэр хээнээс 1ш унаж үгүй болсон, 4ш зүмбэр хээний үзүүр хэсэг унаж алга болсон байна.	Цэвэрлэгээ хийх, наалт суларсан хэсгүүдийг бэхжүүлэх, унаж үгүй болсон зүмбэр хээнүүдийг нөхөж хийн өнгө будгийн засвар хийх.
2	Багана		4ш	Гэрийн 4н багананы тулгуур хөлний мод ширхэгийн дагуу хатаж цуурсан, толгой хэсгийн чимэглэлийн зүмбэр хээ, хадаг, 8н тахилын хэсгүүдэд хээ чимэглэл хугарч алга болсон байна.	Цэвэрлэгээ хийх, тулгуур хөлийн цууралтыг нөхөх, алга болсон хээ зүмбэрийг нөхөх, өнгө будгийн засвар хийх.
3	Унь		86ш	Гэрийн унь 88 ширхэг байхаас 2ш үгүй болсон, унины зарим хээ болон өнгө будаг гэмтэлтэй, сагалдрагыг сүүлд шинээр орчин үеийн материал ашиглан хийсэн байна.	Цэвэрлэгээ хийх, 2ш унь шинээр хуулбарлан хийж тоог гүйцээж өнгө будгийг мөн тааруулах, сагалдрагыг

					дээс хялгасаар хийх
4	Хана		4ш	зарим хэсэгтээ ханын тод хугарсан, эдгээр хугархай хэсгүүдийг нимгэн гуулин листээр ороож хадсан байна Ханын хугарсан хэсгүүдийг гуулин листээр бөгжилж хадсан нь өнөөг хүртэл ямар нэг сөрөг нөлөө үзүүлсэн зүйлгүй гэж үзэж байна..	Ханын үдээр тасарсан хэсгийг шинэчлэн засах
5	Хаалга		1ш /2хавтас бүхий/	Хаалганы зүмбэр чимэглэлээс 5ш унаж үгүй болсон, мөн 2ш чимэглэлийн хугарч тал хэсэг үгүй болсон, булангийн зүмбэр 8ш дутуу, өнгө будаг халцарч гэмтсэн.	Цэвэрлэгээ хийх, унаж үгүй болсон хэсгүүдийг эхийг дууриалган шинээр хуулбарлан хийж гүйцэтгэх, өнгө будгийн сэргээн засварлалт хийх
6	Ор		1ш	Орны нүүрний гурвалжин хэлбэрийн угалз чимэг хөдөлгөөн орж суларсан, орны арын түшлэгийн оройн хээ угалз хугарсан, баруун үзүүрийн хээ байхгүй	Цэвэрлэгээ хийх, дутуу хэсгүүдийг нөхөж гүйцээх, хөдөлгөөн орж суларсан хэсгүүдийг бэхжүүлэх, өнгө будгийг нөхөн сэргээх.


Хаяавч, өрх, хаалганы гэмтлийн гар зураглал.




Гэрийн хөшигний гэмтлийн гар зураглал




Гэрийн туурганы гэмтлийн гар зураглал




Ар талын дээврийн гэмтлийн гар зураглал




Урд дээврийн гэмтлийн гар зураглал



Гэрийн халзны гэмтлийн гар зураглал



Олбог болон орны аравчны гэмтлийн гар зураглал



## Сэргээн засварлах ажлын урьдчилсан төлөвлөгөө

Богд хааны ордон музейн Ирвэсийн арьсан гэрийн сэргээн засварлалтын ажилд баримтлах арга зүй.

1. Гэрийн хаяавч /2ш/
  - Гэрэл зургийн баримтжуулалт, хэмжилт
  - хуурай цэвэрлэгээ хийх
  - хаяавч дээрх хас, ланз хээг кальцдаж авч загвар шаблон бэлдэх
  - сонгож бэлдсэн торго, даавуун дээр загварыг буулгаж эсгүүр хийх
  - хээг нэг бүрээр нугалж бэлдэх
  - арын фонн дээр оёх
  - бэлэн болсон шинэ хэсгийг их бие дээр тогтоож оёх
  - хүрээ даавуу торгоор эмжиж оёх
2. Ирвэсийн арьсан эсгий хаалга
  - гэрэл зургийн баримтжуулалт, хэмжилт
  - хуурай цэвэрлэгээ
  - гэмтлийн хувиар нөхөлтийн бэлдэц хийх
  - нөхөж оёх/гар оёдол/
  - даавууны нөхөлт хийх
3. Ирвэсийн арьсан өрх
  - гэрэл зургийн баримтжуулалт, хэмжилт
  - хуурай цэвэрлэгээ
  - гэмтлийн хувиар нөхөлтийн бэлдэц хийх
  - нөхөж оёх/гар оёдол/
  - арьсны нөхөлт хийх/гар оёдол, нөхөөс/
  - даавууны нөхөлт хийх/гар оёдол/
4. Гэрийн халз /баруун, зүүн/
  - гэрэл зургийн баримтжуулалт, хэмжилт
  - хуурай цэвэрлэгээ
  - гэмтлийн хувиар нөхөлтийн бэлдэц хийх
  - нөхөж оёх/гар оёдол/
  - арьсны нөхөлт хийх/гар оёдол, нөхөөс/
  - даавууны нөхөлт хийх/гар оёдол/
  - эмжээр даавууг нөхөж оёх
5. Гэрийн дээвэр /урд, хойд/
  - гэрэл зургийн баримтжуулалт, хэмжилт
  - хуурай цэвэрлэгээ
  - гэмтлийн хувиар нөхөлтийн бэлдэц хийх
  - нөхөж оёх/гар оёдол/
  - арьсны нөхөлт хийх/гар оёдол, нөхөөс/
  - дотор торгыг сэлбэх, нөхөлт хийх/гар оёдол/



- эмжээр, цацаг чимэг торгыг нөхөж оёх
  - 6. Гэрийн туурга /баруун урд, баруун хойд, зүүн хойд, зүүн урд/
    - гэрэл зургийн баримтжуулалт, хэмжилт
- хуурай цэвэрлэгээ
- гэмтлийн хувиар нөхөлтийн бэлдэц хийх
- нөхөж оёх/гар оёдол/
- арьсны нөхөлт хийх/гар оёдол, нөхөөс/
- даавууны нөхөлт хийх/гар оёдол/
- эмжээр даавууг нөхөж оёх
  - 7. Дотор хөшиг /зүүн, баруун, хойд/
    - гэрэл зургийн баримтжуулалт, хэмжилт
    - хуурай цэвэрлэгээ
    - гэмтлийн хувиар нөхөлтийн бэлдэц хийх
    - нөхөж оёх/гар оёдол/
    - урагдаж сэмэрсэн хэсгийн ард өнгө ижил торго барьж хүр хорхойн утсаар даруулж бэхэлж оёх /гар оёдол/
      - эмжээр даавууг шаардлагатай хэсгүүдэд нөхөж оёх
  - 8. Орны аравч
    - гэрэл зургийн баримтжуулалт, хэмжилт
    - хуурай цэвэрлэгээ
    - хүрээ модноос салгах
    - урагдаж суларсан, сэмэрсэн хэсгүүдийг дуближ хийж даруулж оёх
    - планшет хийж зөөлөвч хадан торгыг эргүүлэн арлаж углаж тогтоох
  - 9. Гэрийн дотуур бүс /1ш/
    - тохирох дээс буюу олс бүрээсийн материалыг бэлдэж хуучин бүсийг дууриалган шинээр хийх

Модон эдлэл.

#### 1. Тооно

- Гэрийн модыг буулгасны дараа нэг бүрчлэн үзлэг хийж баримтжуулалт хийх
- Хуурай болон нойтон цэвэрлэгээ хийх
- Наалт суларсан хэсгүүдийг хэрхэн бэхжүүлэх аргачлал боловсруулж бэхжүүлэлт хийх
- Унаж үгүй болсон деталл хэсгүүдийг нөхөж хийж гүйцээх
- Өнгө будгийн сэргээн засварлалт хийх
- Өнгө будгийг бэхжүүлэх

#### 2. Багана

- Гэрийн модыг буулгасны дараа нэг бүрчлэн үзлэг хийж баримтжуулалт хийх
- Хуурай болон нойтон цэвэрлэгээ хийх

- Наалт суларсан хэсгүүдийг хэрхэн бэхжүүлэх аргачлал боловсруулж бэхжүүлэлт хийх

- Унаж үгүй болсон деталл хэсгүүдийг нөхөж хийж гүйцээх

- Өнгө будгийн сэргээн засварлалт хийх

- Өнгө будгийг бэхжүүлэх

### 3. Унь

- Гэрийн модыг буулгасны дараа нэг бүрчлэн үзлэг хийж баримтжуулалт хийх

- Хуурай болон нойтон цэвэрлэгээ хийх

- Унаж үгүй болсон деталл хэсгүүдийг нөхөж хийж гүйцээх

- Өнгө будгийн сэргээн засварлалт хийх

- Өнгө будгийг бэхжүүлэх

- Дутуу 2ш унийг шинээр хуулбарлаж хийх

- Унины дутуу болон гэмтэлтэй хээ угалзыг нөхөх, сэргээх

### 4. Хана

- Гэрийн модыг буулгасны дараа нэг бүрчлэн үзлэг хийж баримтжуулалт хийх

- Хуурай болон нойтон цэвэрлэгээ хийх

- бэхжүүлэх

- Өнгө будгийн сэргээн засварлалт хийх

- Өнгө будгийг бэхжүүлэх

### 5. Хаалга

- Гэрийн модыг буулгасны дараа нэг бүрчлэн үзлэг хийж баримтжуулалт хийх

- Хуурай болон нойтон цэвэрлэгээ хийх

- Наалт суларсан хэсгүүдийг хэрхэн бэхжүүлэх аргачлал боловсруулж бэхжүүлэлт хийх

- Унаж үгүй болсон деталл хэсгүүдийг нөхөж хийж гүйцээх

- Өнгө будгийн сэргээн засварлалт хийх

- Өнгө будгийг бэхжүүлэх

### 6. Ор

- Гэрийн модыг буулгасны дараа нэг бүрчлэн үзлэг хийж баримтжуулалт хийх

- Хуурай болон нойтон цэвэрлэгээ хийх

- Наалт суларсан хэсгүүдийг хэрхэн бэхжүүлэх аргачлал боловсруулж бэхжүүлэлт хийх

- Унаж үгүй болсон деталл хэсгүүдийг нөхөж хийж гүйцээх

- Өнгө будгийн сэргээн засварлалт хийх

- Өнгө будгийг бэхжүүлэх

## Сэргээн засварлалт

Арьс, даавуу зөөлөн эдлэлийн сэргээн засварлалт

Соёлын өвийн үндэсний төвд ирвэсэн арьсан гэрийн иж бүрдэл болох дээвэр туурга гэх мэт ирвэсийн арьсаар хийсэн хэсгүүдийг хүлээн авсны дараа НЕРА

шүүлтүүртэй тоос сорогч хэрэглэн хуурай цэвэрлэгээ хийж аралсан даавууг задалж үзэхэд зарим зүйлсийн нөхцөл байдал анхны дүгнэлтээс өөр байсан.

Жишээ нь:

- Арьснууд ус чийгний улмаас зарим хэсэгт хатуурч дарайсан байснаас гадна өөр хоорондоо харилцан адилгүй зузаан, нимгэн болон хатуу, зөөлөн гэх мэт
- Арьсны үс сор залгаас бүрээр хоорондоо өөр олон төрөл
- Залгаас нөхөөс ихтэй
- Арьсны нимгэн хэсэг нь маш эмзэг болсон
- Жижиг цоорхой ихтэй
- Арьс сунаж гэмтсэн
- Урагдсан хэсгийг буруу оёж тогтоосон гэх мэт



*Урагдсан хэсгийг оёсон байдал*




*Залгаж оёсон утас тасарч суларсан*



Эдгээр гэмтлийн нөхцөл байдлууд нь тухайн гэрийн иж бүрдэл хэсгийг анх гадна талаас нь хийсэн үзлэгийн дүгнэлтэд зарим зүйлд өөрчлөлт орж улмаар сэргээн засварлалт, хадгалалт, бэхжүүлэлтийн ажлын төлөвлөгөөнд бага зэрэг өөрчлөлт орсон.

Урагдаж гэмтсэн ирвэсийн арьсыг засах тухай сэргээн засварлах ажлын анхан шатны төлөвлөгөөнд гар аргаар оёж, хатгаж урагдсан хэсгүүдийг хооронд нь холбож бэхжүүлэх төлөвлөгөө гаргаж байсан бол уг ирвэсийн арьсаар хийгдсэн хэсгүүдийг



задалж үзэн нөхцөл байдалтай сайтар танилцахад гэмтлийн байдлаас шалтгаалан бүх гэмтлийг шууд оёж бэхжүүлэх боломж муу байсан тул өөр тохирох арга зүйг судлаж хэрэглэх шаардлага гарсан.

Улмаар судалгааны явцад энэ тохиолдолтой ойролцоо байж болох ангийн арьсаар хийсэн эдлэлийн сэргээн засварлалтад BEVA-371 цавууг хэрэглэн сэргээн засварлах ажил хийсэн тухай өгүүлэл олсон ба энэ арга зүйг ашиглаж болох талаар хэлэлцэж BEVA-371 цавууг хэрэглэн ирвэсийн арьсан хэсгийг ар талаас нь буюу хөрсөн талаас нь нааж бэхжүүлэхээр шийдвэрлэн ажиллав.

Уг цавууг олон улсад уран зураг сэргээн засварлахад өргөнөөр ашиглаж байгаа ба зарим тохиолдолд арьсан эдлэл сэргээн засварлахад мөн хэрэглэж байна.

BEVA-371 цавуу нь этиль, вениль ацетат суурьт цавуу бөгөөд ксилол, толуол зэрэг уусгагчид халааж хайлуулан хэрэглэнэ. Энэ тохиолдолд цавууг хайлуулан урагдсан арьсны нийлж буй ирмэг болон цуу ямбуу давуунд түрхэн сайтар царцаасны дараа бэлдсэн цавуутай даавууг урагдалд таарах хэмжээгээр нарийн зүсэж индүүгээр нааж арьсны урагдлыг нөхөв.

BEVA цавуугаар нааж бэхэлсэн дараалал



Бодиснуудаа саванданд хийж устай саванд тавьж халааж хайлуулж найруулна



Даавуун дээр түрхэж хатаана



Өргөн нарийн зүсэж бэлдэнэ



Наах хэсгийн гадаргуун дээр цавуу түрхэж хатаана



Бэлдэж зүссэн даавуугаа наах хэсэгтээ байрлуулж халуун индүүгээр индүүдэж наана




Нааж бэхэлж дууссан байдал

Даавуу зөөлөн эдлэлийн гэмтлүүд

*Олон жилийн элэгдэл, гандалт, хэврэгшсэн, сэмэрч урагдсан гэмтлүүд.*



*Ус чийг, дусаал орж хөгцөрсөн, хорхой шавьжинд идэгдсэн гэмтэл.*



*Таталт механик хүчний үйлчлэлээс үүссэн урагдалт, урагдсаныг буруу оёж тогтоосон*





Гадна тал



Арьсны үс урт тул хайчилж гадаргуутай тэгш болгов

*Олон жилийн элэгдэж, гандаж хэврэгшин маш олон газарт сэмэрсэн.*



Даавуу зөөлөн эдлэлийн цэвэрлэгээ, бэхжүүлэлт, сэргээн засварлалт

Нийт торго, даавуун материалаар хийсэн гэрийн иж бүрдэл хэсгүүд тус бүрт хуурай, чийгтэй, нойтон цэвэрлэгээ тус бүрийг шаардлагатай хэсэгт нь тохирсон цэвэрлэгээг хийж гүйцэтгэв. Торго нь маш ихээр муудсан хэсгийг шинэ торгоор сольж, сэмэрч нимгэрсэн хэсгийн ард нимгэн даавуу барьж өнгөн талаас нь өнгө ижил хүр хорхойн гаралтай утсаар сэргээн засварлалтын технологийн дагуу оёж бэхлэв. Урагдаж цоорсон хэсгүүдэд өнгө ойролцоо даавуу болон торгоор нөхөлт хийв.

Хаяавч нь олон жилийн элэгдэл, гандалтаас болж сэмэрч урагдсан. Хаяавчны 65% ыг шинээр хийсэн, үлдсэн хэсэг нь анх хийц байдлаараа боловч ус, чийгний улмаас нилээд илжирч муудсан байдалтай байсан. Иймд тухайн хэсгийг шинээр нөхөх хэсэг буюу сэргээн засварлалт хийх хэсгийг анхны байдалтай нь аль болох адил төстэй хийхийг зорьсон. Ижил төстэй нимгэн торго сонгон авч уг материалыг даавуу будах технологийн дагуу будаад 1:1 хэмжээгээр нь хээг бэлдэж шар торгон дээр гараар оёж тогтоов.



*Засварын ажлын явц болон дараах байдал.*



## Модон эдлэлийн сэргээн засварлалт

Унины чимэглэлийн хээ угалз ховхорч унаж гэмтсэн 3 ширхэг унины хээ угалзнаас 2 ширхэг нь хагарч гэмтсэн байсан бол үлдсэн 1 унины хээ чимэг бүрэн ховхорч унасан байсныг нөхсөн. Нөхөхдөө үлдсэн хээ угалзан дээр залгаж хийх байдлаар хуш мод хэрэглэн нөхөж хийв. Дутуу байсан 2 ширхэг унийг шинээр нөхөж хийсэн. Ингэхдээ зориулалтын хатаалганд хатаасан 5см –ийн нарсан банзын зүсэж ух оригинал унины хэмжээ хийцийг дууриалган гар аргаар ухаж сийлж хийв. Унины сагалдрагыг солихоор тооцож байсан боловч одоо байгаа сагалдрагыг унины бөгсөнд сүвлэсний дараа маш сайн шаантаглаж бэхэлсэн байсан тул тасарсан хэсгүүдийг нөхөж хийн бусад сагалдрагыг хуучнаар үлдээв.



Нийт 4 ширхэг багананаас 2 ширхэгийн нь хөл, толгой хэсгийн наалт хөндийрч хөдөлгөөн орсон байсан тул наалт хэсгээр салгахад хуучин углуурга хэсгийг даавуугаар ороон чигжиж хийсэн байсан. Салгасны дараа хуучин цавууг бэгнүүрдэн дэвтээж цэвэрлэсний дараа хуучин эм углуурганы дотор талд мод нааж хөдөлгөөнгүй болгож буцааж наасан.



Багананы толгойн 2 талд найман тахилын сийлбэртэй байсны зарим деталл хэсгүүд хугарч унасан байсан. Үүнд хадаг, шүхэр зэраг хээ чимэглэл хэд хэдэн хэсэгтээ хагарсан байсан ба энэ хэсгүүдийг мөн хуучинтай нь залгах маягаар хуш модоор нөхөж сийлж гүйцээв. Мөн бүх багананы хөлнүүд цууралттай байсан энэ хэсгүүдийг модны зориулалтын замааскаар нөхөж гүйцээв.

Тоононы гадна хүрээний дотор, цамхраан дээр наалт, шаантаг бүхий 16 ширхэг угалзан хээнүүдээс 4 ширхэг нь эх оригиналаараа байсан бол бусад 12 ширхэгийг сүүлд нэмж нөхөж хийсэн байна. Энэ хэсгийн наалт залгаа хэсэгт байсан угалз хээний үзүүрийн шаантаг хэсэг суларч унасны улмаас тооно углуурга наалт хэсгээрээ мөн суларсан байна. Эдгээр угалз хээнүүдийн нэг хугарсан, үлдсэн угалз хээнүүд бүгд суларч хөдөлгөөн орсон байв.

Мөн тоононы гадна хүрээний дотор талд байх зүмбэр хээнүүд унасан, голын хорол чимэгийн дотор талын нэг цацраг ховхорч унасан хөдөлгөөн орж холхисон зэрэг гэмтэлтэй байсан.

Эдгээр хэсгүүдийг хуучин наалт цавууг цэвэрлэж буцаан нааж бэхжүүлсэн. Дутуу хэсгүүдийг хуш модоор нөхөж сийлж, шаантаг унаж суларсан хэсгүүдэд шинээр шаантаг хийж нөхөж бэхэлсэн.



Хаалганы модон хийцийн бүх наалт углуурга хэсгүүд суларсан, хаалганы дотор хавтсан дээрх зүмбэр хээ чимэгнүүдээс булангийн зүмбэр 8 ширхэг дутуу, голын зүмбэр хээнээс 5 ширхэг дутаж алга болсон байсан бусад хээ зүмбэрний үзүүр деталл хэсгүүд хугарч гэмтсэн байсан. Тогтоны унь тогтоох 8 ширхэг сагалдарганы сэнжнээс 2 ширхэг нь хугарч алга болсон байсан. Эдгээр алга болсон хээ зүмбэр чимэглэлийг хуш модоор тогтоны сэнжийг нарс модоор нөхөж хийсэн.



Орны аравч наалтаараа салж хөдөгөөн орсон, аравчны оройн чимэгнүүдийн баруун талын үзүүрийн хээ хугарч алга болсон, голын оройн чимэг байхгүй байсан.

Аравчны наалт хэсгийн хуучин цавууг цэвэрлэж буцааж наан хөдөлгөөнийг хорьж бэхжүүлсэн. Оройн чимэгийг шинээр хийж нөхөж гүйцээсэн.

Хананы зарим тасарсан үдээрийг сураар нөхөж хийсэн. Хуучин хугарсан хэсэгт нөхсөн гуулин бэхэлгээг хэвээр үлдээсэн. Ханан боолтууд тасарч муудсан байсныг шинээр сураар нөхөж хийв.

#### Модон эдлэлийн бүдгийн ажил

Гэрийн унь нийт 88 ширхэг байхаас 86 ширхэг унь ирсэн. Тэдгээрийн будагны гэмтлүүдийг тодорхойлвол:

30% гэмтэлтэй-41ш

50% гэмтэлтэй-27ш

80% гэмтэлтэй-18ш

100% буюу шинээр будах-2ш унь байна



*Унины будгийн гэмтлийн зураг*

Уг унины болон гэрийн бусад хэсгүүдийн (тооно, хаалга, багана) будаг нь усан суурьтай будаг болох нь тэдгээрийг цэвэрлэх явцад ус болон этанолын холимог цэвэрлэгээний уусмалд будаг нь хөдөлж байгаагаас харагдаж байсан. Мөн тухайн үед хэрэглэсэн будгийн бэхжүүлэгч, маажин шинж чанараа алдаж будгийн үе давхарга суларсан байна.

Эдгээр унинуудын будаг халцарч унасан, арилсан хэсэгт усан суурьтай будаг болох гуаш, усан будаг, алтлаг өнгөт боронз зэргийг өнгө будаг халцарч гэмтсэн хэсгүүдэд нөхөлт хийж хэрэглэсэн ба өнгө будгийг хамгаалж бэхжүүлэхийн тулд орос нитро лак -1х2- ацетон хэмжээгээр шингэлэн маш нимгэн үе давхарга тавьсан.




*Өнгө будгийн ажлын явцын гэрэл зургууд.*

Уг гэр нь дөрвөн баганатай бөгөөд тэдгээрийн будагны гэмтлийн хувьд харьцангуй өөр их, бага гэмтэлтэй байна. Тэдгээр гэмтлүүд нь будаг халцарч, ховхорч унасан гэмтлүүд маш их байна.



*Гэрийн багана өнгө будгийн явцын байдал.*

Гэрийн хаалгыг өмнө нь сэргээн засварлаж байсан нь хаалганы хавтсан дээр сийлж будсан хээн чимэгнүүдээс тодорхой харагдаж байна. Хаалганы будгийн гэмтлийн хувьд будаг халцарч, ховхорч унасан, өмнө сэргээн засварлахдаа будгийн өнгийг хаалганы өөрийн өнгөнөөс ялгаатай, өөр будсан байдалтай байна.



*Гэрийн хаалга будгийн өмнөх байдал.*



*Гэрийн хаалга өнгө будгийн ажлын дараах байдал.*

Гэрийн тооныг мөн өмнө сэргээн засварлаж байсан нь тоонон дээр сийлсэн чимэг, хээнүүд болон тэдгээрийг өөр бронзоор будсан байгаагаас харж болно. Тоононы будгийн гэмтлийн хувьд будаг халцарч арилсан гэмтэлтэй байна.



*Гэрийн тооно будгийн өмнөх, дараах байдал байдал.*

Богд хааны ирвэсийн арьсан гэр нь урьд өмнө нөхөн сэлбэх, сэргээн засварлах ажлууд хийгдэж байсан нь энэ удаагийн сэргээн засварлах ажлын явцад тодорхой харагдаж байсан ба эдгээр хуучин сэргээн засварласан хэсгүүдийг тэр хэвээр нь үлдээв. Эдгээрээс онцолвол гэрийн тоононы цамхрааны хээ угалзууд болон хаалганы самбар дээрх зарим хээ угалзууд байх ба эдгээр хэсгүүд нь эх оригиналтай харьцуулахад хийц болон өнгө будаг зэргээрээ тодорхой ялгарч харагдаж байна.

Энэ удаагийн сэргээн засварлалтын ажлын явцад шинээр хийгдсэн модон эдлэлийн деталл хэсгүүдийн зарим нь тусдаа бие даасан хээ угалз бол зарим нь эх хэсгээс хугарч унасан хэсгүүд байсан ба хийцийн хувьд эх оригиналтай тодорхой хэмжээнд ойролцоо болсон ба эдгээр хэсгүүдийг гэрэл зургаар баримтжуулан тайлан бичвэрт хавсаргасан болно.



## Сэргээн засварлалтын ажлын өмнөх болон дараах байдал

### 1. Даавуу зөөлөн эдлэл

№		Засварын өмнө	Засварын дараа	Хийгдсэн ажил
1	Хойд дээвэр	 	 	<p>Хуурай цэвэрлэгээ хийгээд арьсны гэмтэл тус бүрийг гэрэл зургаар баримтжуулалт хийв./40+ ш/ Арьсны урагдсан цоорсон хэсгүүдийг нөхөж наасан, арын торгыг шинээр сольсон. Хоолой хэсгийн 3 өнгийн торгоны цэнхэр өнгийн торгыг шинээр солив. Хормой болон хоолой хэсэгт шинэ арьсаар нөхөлт хийв.</p>
2.	Урд дээвэр	 	 	<p>Хуурай цэвэрлэгээ хийгээд арьсны гэмтэл тус бүрийг гэрэл зургаар баримтжуулалт хийв./20+ ш/. Зохих наалт бэхэлгээг хийв. Баруун хажуу хэсгийн нимгэн арьс таталтаас болж маш их гэмтсэн тул наалт бэхэлгээ хийсний дараа ар талд нь даавуу барьж бэхэлгээ хийв. Ар талын хоолой хэсгийн 3 өнгийн торго, хоёр хажуу хэсгийн торго болон цэнхэр эмжээр зэргийг шинээр солив. Торгоны урагдсан хэсгүүдийг засаж оёсон.</p>
3.	Туурга №1	 		<p>Хуурай цэвэрлэгээ хийгээд арьсны гэмтэл тус бүрийг гэрэл зургаар баримтжуулалт хийв./18+ ш/. Арьсанд зохих наалт бэхэлгээг хийв. Дээд талын цэнхэр торготой хэсэг нь хэд хэдэн газарт арьснаас 10-20см ханзарсныг бэхэлж оёсон. Баруун хажуу талын торго, дээд талын хөх торгыг шинээр солив. Татлага уяанаас үүссэн урагдалтуудыг засаж оёсон</p>

4.	Туурга№2		<p>Хуурай цэвэрлэгээ хийгээд арьсны гэмтэл тус бүрийг гэрэл зургаар баримтжуулалт хийв./8+ ш/. Арьс усанд норж чийг авснаар хатуурсан ба ар талын арласан даавуу хөгзөрсөн байсан. Арласан даавуунд чийгтэй цэвэрлэгээ хийж 50%-ийн этилийн спиртээр ариутгав. Арьсанд зохих наалт бэхэлгээг хийв. Зүүн хажуу талын торго, дээд талын хөх торгыг шинээр солив. Татлага уяанаас үүссэн урагдалтуудыг засаж оёсон.</p>
5.	Туурга №3		<p>Хуурай цэвэрлэгээ хийгээд арьсны гэмтэл тус бүрийг гэрэл зургаар баримтжуулалт хийв./8+ ш/./. Арьс хормой хэсгээрээ усанд норж чийг авснаар хатуурсан ба хугарч гэмтсэн. Иймээс зарим хэсэгт шинэ арьсаар нөхөлт хийв. Арьсанд зохих наалт бэхэлгээг хийв. Дээд талын хөх торгыг шинээр солив. Татлага уяанаас үүссэн урагдалтуудыг засаж оёсон .</p>
6.	Туурга №4		<p>Хуурай цэвэрлэгээ хийгээд арьсны гэмтэл тус бүрийг гэрэл зургаар баримтжуулалт хийв./8+ ш/./. Арьс хормой хэсгээрээ усанд норж чийг авснаар хатуурсан ба хугарч гэмтсэн. Иймээс зарим хэсэгт шинэ арьсаар нөхөлт хийв. Арьсанд зохих наалт бэхэлгээг хийв. Дээд талын хөх торгыг шинээр солив. Татлага уяанаас үүссэн урагдалтуудыг засаж оёсон . арласан даавуу зүүн доод</p>



7.	Хаалга			<p>Хуурай цэвэрлэгээ хийгээд арьсны гэмтэл тус бүрийг гэрэл зургаар баримтжуулалт хийв. Нимгэн арьстай учир маш ихээр урагдсан, хэсэгчлэн алга болсон байсан. Арьсанд зохих наалт бэхэлгээг хийв. Дутуу хэсэгт шинэ арьсаар нөхөлт хийв. Ар талыг аралсан торгоны сэмэрч урагдсан /3 талын ирмэг/ -ыг өнгө ижиг торгоор нөхөж оёсон. Урагдсан хэсгүүдийг засаж оёов.</p>
8.	Өрх			<p>Хуурай цэвэрлэгээ хийгээд арьсны гэмтэл тус бүрийг гэрэл зургаар баримтжуулалт хийв. Нимгэн арьстай учир маш ихээр урагдсан./8+ ш/ Арьсанд зохих наалт бэхэлгээг хийв. Дутуу хэсэгт шинэ арьсаар нөхөлт хийв. Ар талыг шинэ торгоор торголов. Урагдсан хэсгүүдийг засаж оёов.</p>
9.	Хөлтрөг			
10.	Хөлтрөг			
11.	Хаяавч /баруун/			<p>Хуурай цэвэрлэгээ хийгээд гэмтэл тус бүрийг гэрэл зургаар баримтжуулалт хийв. 30% нь уранхай. Шинэ торгоо технологийн дагуу будаад шаблоны дагуу хээгээ бэлдэж 20 ш хээ хийж нэг хуучин хийсэн арга барилын дагуу гараар оёж гүйцэтгэв. Солих шаардлагагүй үлдсэн хэсгийг нойтон цэвэрлэгээ хийж цэвэрлэв.</p>

12.	Хаяавч /зүүн/			Хуурай цэвэрлэгээ хийгээд гэмтэл тус бүрийг гэрэл зургаар баримтжуулалт хийв. 35% нь уранхай. Шинэ торгоо технологийн дагуу будаад шаблоны дагуу хээгээ бэлдэж 24 ш хээ хийж нэг хуучин хийсэн арга барилын дагуу гараар оёж гүйцэтгэв. Солих шаардлагагүй үлдсэн хэсгийг нойтон цэвэрлэгээ хийж цэвэрлэв.
13.	Хөшиг /баруун урд/			Хуурай цэвэрлэгээ хийгээд гэмтэл тус бүрийг гэрэл зургаар баримтжуулалт хийв. Гандаж, хэврэгшиж ихээр сэмэрч урагдсан. Эх биеийг бэхлэхийн тулд ар талд 50-60% д нимгэн даавуу барьж оёж тогтоолоо. Чийгтэй цэвэрлэгээ хийсэн, урардаж ханзарсан газруудыг засаж оёлоо.
14.	Хөшиг /зүүн урд/			Хуурай цэвэрлэгээ хийгээд гэмтэл тус бүрийг гэрэл зургаар баримтжуулалт хийв. Гандаж, хэврэгшиж ихээр сэмэрч урагдсан. Эх биеийг бэхлэхийн тулд ар талд 50-60% д нимгэн даавуу барьж оёж тогтоолоо. Чийгтэй цэвэрлэгээ хийсэн, урардаж ханзарсан газруудыг засаж оёлоо.
15.	Хөшиг /хойд/			Хуурай цэвэрлэгээ хийгээд гэмтэл тус бүрийг гэрэл зургаар баримтжуулалт хийв. Гандаж, хэврэгшиж ихээр сэмэрч урагдсан. Эх биеийг бэхлэхийн тулд ар талд 50-60% д нимгэн даавуу барьж оёж тогтоолоо. Чийгтэй цэвэрлэгээ хийсэн, урагдаж

				ханзарсан газруудыг засаж оёлоо.
16.	Аравч			Хуурай цэвэрлэгээ хийж,арийн холбож хадсан модыг салгаж авсан.2 хэсэг рам модыг кардон зузаан цаас үдэж планшет хийж даавуугаар бүрээд зөөлөвч хийж эргүүлэн углаж хийв. Жижиг урагдаж цоорсон хэсгүүдын ар талд дублиаж хийн 5% оёдол хийсэн.
17.	Олбог I			
18.	Олбог II			Хуурай цэвэрлэгээ хийж доод тал, гол оёдолыг ханзалж эсгийг гаргаж аван цэвэрлэгээ хийж хөргөгчинд 14 хонуулсан. Урагдаж сэмэрсэн хэсгүүдийг 50% ийг торго доор нь барьж даруулан оёсон. Эсгийг нэг бүрчилэн хуурай цэвэрлэгээ хийж эргүүлэн битүүлэн оёж гүйцэтгэв.

## 2. Модон эдлэл

№	Гэрийн иж бүрдлийн нэр	Засварын өмнө	Засварын дараа	Хийгдсэн ажил
1.	Тооно			Цэвэрлэгээ хийж, хуучин цавууны бохирдлыг арилгаж, хоролны алга болсон цацрагийг нөхсөн. Зүмбэрийг нөхөж зайг нөхөж өнгө будгийг нөхсөн
2	Унь			Унины чимэглэлийн хээ угалз ховхорч унаж гэмтсэн 3 ширхэг унины хээ угалзнаас 2 ширхэг нь хагарч гэмтсэн байсан бол үлдсэн 1 унины хээ чимэг бүрэн ховхорч унасан байсныг нөхсөн. Нөхөхдөө үлдсэн хээ угалзан дээр залгаж хийх байдлаар

				хуш мод хэрэглэн нөхөж хийв.
3	Багана	 	 	Багананы толгойн 2 талд найман тахиллын сийлбэртэй байсны зарим деталл хэсгүүд хугарч унасан байсан. Үүнд хадаг, шүхэр зэрэг хээ чимэглэл хэд хэдэн хэсэгтээ хагарсан байсан ба энэ хэсгүүдийг мөн хуучинтай нь залгах маягаар хуш модоор нөхөж сийлж гүйцээв. Мөн бүх багананы хөлнүүд цууралттай байсан энэ хэсгүүдийг модны зориулалтын замаскаар нөхөж гүйцээв.
4	Хаалга	 	 	Хаалганы модон хийцийн бүх наалт углуурга хэсгүүд суларсан, хаалганы дотор хавтсан дээрх зүмбэр хээ чимэгнүүдээс булангийн зүмбэр 8 ширхэг дутуу, голын зүмбэр хээнээс 5 ширхэг дутаж алга болсон байсан бусад хээ зүмбэрний үзүүр деталл хэсгүүд хугарч гэмтсэн байсан. Тогтоны унь тогтоох 8 ширхэг сагалдарганы сэнжнээс 2 ширхэг нь хугарч алга болсон байсан. Эдгээр алга болсон хээ зүмбэр чимэглэлийг хуш модоор тогтоны сэнжийг нарс модоор нөхөж хийсэн.

5	Ор			<p>Орны аравч наалтаараа салж хөдөгөөн орсон, аравчны оройн чимэгнүүдийн баруун талын үзүүрийн хээ хугарч алга болсон, голын оройн чимэг байхгүй байсан. Аравчны наалт хэсгийн хуучин цавууг цэвэрлэж буцааж наан хөдөлгөөнийг хорьж бэхжүүлсэн. Оройн чимэгийг шинээр хийж нөхөж гүйцээсэн.</p> <p>Хананы зарим тасарсан үдээрийг сураар нөхөж хийсэн. Хуучин хугарсан хэсэгт нөхсөн гуулин бэхэлгээг хэвээр үлдээсэн. Ханын боолтууд тасарч муудсан байсныг шинээр сураар нөхөж хийв.</p>
6	Хана			<p>Цэвэрлэгээ хийж, тасарсан үдээр, дутуу ханын боолтыг сур ашиглан нөхөж гүйцээв.</p>

### Дүгнэлт

Энэхүү цэвэрлэгээ, бэхжүүлэлт, сэргээн засварлалт, хадгалалт хамгаалалтын ажлыг хийж гүйцэтгэхдээ дурсгалын онцлогт таарсан аргазүйг ашиглаж хадгалалт хамгаалалт, бэхжүүлэлт, сэргээн засварлалтын ажлыг төлөвлөн хийж гүйцэтгэв.

Хадгалалт хамгаалалт, бэхжүүлэлт, сэргээн засварлах ажилбар дууссаны дараа олдворын нөхцөлд таарсан тогтвортой орчин бүрдүүлж хадгалах нь нэн чухал юм. Музейн орчинд органик эдлэлийг 55%-аас 65%-ийн чийгшил, 150 люкс гэрэлтүүлэгт, хадгалан, дундаж дулааныг 20 градуст байлгаж, чийгшил дулааны хэлбэлзэл аль болох бага орчинд хадгалах нь зүйтэй хэмээн дүгнэв.

## ХАВСРАЛТ

Сэргээн засварласан үзмэр, эд өлгийн зүйлийн гэрэл зураг



/Зураг 1, 2,3,4/



*/Зураг 5,6,7,8/*



*/Зураг 9,10/*





/Зурга 11/  
488



/Зургаг 12/

-----oOo-----

### 3.2.Шороон бумбагарын дурсгалт газрын ханын зургийн цэвэрлэгээ, судалгааны ажил.

-Өвөл, хавар, зун, намрын цэвэрлэгээ,

-Бичил цаг уур, орчны мэдээллийн судалгаа,

-ЮНЕСКО-ийн боловсон хүчин бэлтгэх, хадгалалт хамгаалалтын судалгааны ажлын тайлан ном хэвлэх.

Булган аймгийн Баяннуур сумын нутагт орших Майхан уулын шороон бумбагарын бунхант булшны өнөөгийн нөхцөл байдалд хяналт тавих, бунханд байрлуулсан бичил цаг уурын төхөөрөмжүүдийн датаг хуулж авч байршлыг өөрчлөн үүдэвч хэсэгт байршуулж тус хэсгийг битүүмжлэх, бунхны модон бэхэлгээ болон хананд ургасан бичил биетэн, хөгц мөөгөнцрийг цэвэрлэх зэрэг ажлыг хийхээр Соёлын өвийн үндэсний төвийн соёлын биет өвийг сэргээн засварлах газрын дарга Д. Нямдорж, Ерөнхий технологич М. Оюунтулга сэргээн засварлагч С. Даваадарь, А. Мөнгөнцоож, Э. Батжаргал нарын бүрэлдэхүүнтэй баг 2019 оны 4, 7, 11 саруудад томилолтоор ажиллаж тухай бүрт дурсгалын нөхцөл байдалтай танилцав.

Дурсгал дээр очиж дурсгалын байдалтай танилцахад үүдэвч хэсэгт хуучин хөрсний чийг голлон нэвчиж, давс талстжиж байсан 2 лууны дүрслэл байсан хэсгүүдэд мөн давсны талстжих үзэгдэл тодорхой хэмжээгээр үүссэн, үүний улмаас шавар үе давхарга аажмаар үйрч, сайрж унах үзэгдэл үргэлжилсээр байна.



*Зурагт үйрч унаж байгаа шавар давхарга, хананд үүсэж буй давсны талстжих үзэгдэл*

Цаашлан 2 лууны хойно байрлах туг, дарцаг бүхий 8 хүний дүрслэл 2 талын хананд байдаг. Энэ хэсэгт, урд талаасаа эхэнд байх хүний дүрслэл хэсгийн хана 4 дүгээр сар буюу хаврын улиралд нилээд чийг авсан, ялангуяа баруун талын хана зүүн хананаас илүү чийгтэй байгаа нь энгийн нүдээр ажиглагдаж байв. Уг чийгний улмаас өнгө будаг бүхий нимгэн шавар давхаргын өнгөн хэсэгт тэлэлт үүсэн улмаар хананаас хөндийрэл үүсэж эхэлсэн байна.



*Ханын зурганд ус чийг нэвчсэн байдал*

Тус хэсгийн хөндийрсөн өнгө будаг бүхий шавар давхаргыг зөөлөн даралт өгч буцааж буулгах ажлыг тухайн үед хийсэн. Гэвч энэ нь тус давхарга дахин хөндийрхөөс бүрэн сэргийлэх арга биш ба зөвхөн түр хугацаанд хөндийрлийг буулгах, хууларч унахаас сэргийлэх зорилготой арга хэмжээ болно.

Бунхны дотор модон бэхэлгээ болон ханын зураг бүхий ханын зарим хэсгүүдээр хөгц мөөгөнцөр нийлээд ургасан ба ихэнх хэсэг нь харьцангуй хатаж хуурайшсан байсан.

Бунхны дотор талд хойд болон баруун хананаас нуралт хуучин нурж байсан хэсгээс нэмж нурсан, бунхны урд хүзүүвч хэсэгт шинээр нилээд хэмжээний чулуу шороо нурсан байдалтай байна.




*Зурагт хүзүүвчинд шинээр нурсан хэсэг, хөгц мөөгөнцөр, хөмгийн нуралт*

Өрхнүүдэд хийсэн модон бэхэлгээ нилэнхүйдээ нилээд өгөршиж муудсан, зарим газраа хамгаалалттын модон бэхэлгээ дотогш цүлхийсэн, мөн бунхны зүүн хөмөгний бэхэлгээ нурж унасан байдалтай байна, энэ нь хананы хөрс шорооны бага хэмжээний нуралтыг модон бэхэлгээ дааж, ачаалал авах боломжгүй болсныг илтгэж байна.

Өвөл газрын хөрс тодорхой хэмжээнд хөлдөж харьцангуй тогтвортой байсан бол цаг агаар дулааран газар гэсэж байгаагаас үүдэн уг дурсгалд ямар нэг хэмжээнд эрсдэл үүсэж болзошгүй ба цаашид бунхан дотор ажиллах нь эрсдэлтэй байж болхоор харагдаж байна.

Томилолтоор ажиллахдаа бунхны бэхэлгээ болон ханын зурагт үүссэн хөгц мөөгөнцрийн цэвэрлэгээний ажлыг хийж гүйцэтгэсэн. Бунханд үүссэн хөгц мөөгөнцрийг цэвэрлэхдээ бэхэлгээний модыг бүхэлд нь цэвэрлэдэг байсан бол энэ удаад аюулгүй байдлыг хангах үүднээс бэхэлгээний доод хэсэг буюу гар хүрэхүйц хэсгүүд болон зөвхөн аркнуудын дээд талд байх зайлшгүй цэвэрлэх шаардлагатай зургуудыг цэвэрлэн модон бэхэлгээнд хлорамины уусмалаар ариутгал хийв.



*Цэвэрлэгээний ажил*

Япон улсын Киотогийн их сургуулийн докторант О. Ангарагсүрэн өөрийн хийж буй бичил орчны судалгааны хэмжилтийн багаж төхөөрөмжүүдийн цуглуулсан мэдээллийг хуулж авах, тэдгээрийг үүдэвч хэсэгт байрлуулан тус хэсгийг битүүмжлэн тандалт хийх шаардлага үүссэний дагуу тус хэмжилтийн багажнуудын байрлалыг өөрчилж үүдэвч хэсэгт зохих байрлалуудад байршуулан үүдэвч хэсгийг хөөсөнцөр хавтангаар битүүмжлэн дээрх хучилтыг буцааж битүүмжилсэн.



Мөн тус оны 9 дүгээр сарын 17-19 ний хооронд докторант О. Ангарагсүрэн, сэргээн засварлагч Э. Батжаргал нар дурсгалт газрын хөрсөнд өрөмдлөгө хийн дээж цуглуулан шинжилгээнд өгсөн.

2019 оны 11 сарын 5-ны өдөр ажиллах үед үүдэвч хэсгийн нийлэг уутан хучлага доор нилээд хэмжээний цан үүссэн байсан ба дурсгалын дотоод орчин үүдэвчний хоёр талын хананд давс талстжих үзэгдэл дахин явагдсан байдалтай байсан бол ханын ус чийгний байдал харьцангуй хуурай байгаа нь ажиглагдаж байсан.

### **БУЛГАН АЙМГИЙН БАЯННУУР СУМЫН ШОРООН БУМБАГАР БУНХНЫ ДОТООД ОРЧНЫ СУДАЛГААНЫ ХҮРЭЭНД ХИЙСЭН СУДАЛГААНЫ ТОВЧ ТАЙЛАН**

Булган аймгийн Баяннуур сумын Улаан Хэрэмийн Шороон Бумбагар бунхны гэмтлийн шалтгаан, дотоод орчны судалгааны хүрээнд дор дурдсан үйл ажиллагаануудыг 2019 онд хийж хэрэгжүүллээ. Үүнд:

#### **Нэг. Бунхны үүд хэсгийн баруун, зүүн хананы хөрсний чийгийн хэмжилт**

2019 оны 1 сарын 26-27 өдрүүдэд Шороон Бумбагар бунханд ажиллаа. Хөрсний чийг хэмжигчийг бунхны үүд хэсгийн баруун, зүүн хананд байршуулж, мэдээллийг хэмжив. Багажны байршлыг хүснэгт 1-т, зураг 1-т үзүүлэв. Мэдээлэлийн үр дүнгээс харахад хөрсний чийг хэмжигчийн мэдээлэл нь баруун хананы дунд хэсэгт чийгийн агууламж өндөр байв. Харин зүүн хананы дунд хэсэгт байршуулсан мэдээлэл хэмжигчийн үр дүн, баруун ханатай харьцуулахад бага байгаа нь тогтоогдов. Баруун,

зүүн хананы доод хэсгийн мэдээлэл хэмжигч ойролцоо утгыг зааж байна (Зураг 1). Бунхны үүд хэсгийн баруун хананы дунд хэсэгт чийг өндөр байгаа нь бунхан байршиж буй газрын тогтоц, ул хөрсний бүтэцтэй холбоотой, эсвэл мэдээлэл хэмжигч алдаатай зааж байх магадлалтай гэсэн ерөнхий таамаглал гарсан. Энэ асуудлыг тодруулах зорилгоор 2019 оны 9 сарын 18- 21 өдрүүдэд Шороон Бумбагар бунханд дахин ажиллаа. Баруун хананы чийгийн мэдээлэл хэмжигч зөв ажиллаж байгааг шалгах зорилгоор Port 1 буюу баруун хананы дээд хэсэгт байршиж буй мэдээлэл хэмжигчийг шалнаас ойролцоогоор 50 см зайд, харин Port 2 хэмжигчийг дээд хэсэгт байршуулан хэмжилт хийсэн. Хэмжилтээр хөрсний чийгийн сенсорүүд зөв ажиллаж байгаа ба үүд хэсгийн баруун хананы дунд хэсэгт чийгийн агууламж өндөр байгаа нь мэдээллийн үр дүнгээс харагдав.

Шороон Бумбагар бунхны үүд хэсэгт хийсэн ажиглалтаар, баруун хананы VIB хэсгээс XIB хэсэгт (зураг 3) хөрсний цайвар шар, хүрэн бор хөрс болон бутармал чулуулагийн судал байгаа нь илт байна. Энэ судлуудад чийгийн мэдээлэл хэмжигчүүдийг 2019 оны 9 сарын 21-ны өдрийн 10 цаг 45 минутаас эхлэн 5 минутын давтамжтай хэмжилтийг хийв. Байршлын хувьд Port 1 хэмжигчийг VII хэсэгт буюу ханын дээд ирмэгээс доош 50 см зайд, Port 2 хэмжигчийг цайвар шар хөрс байгаа хэсэгт буюу хананы дээд ирмэгээс 100 см зайд, Port 3 хэмжигчийг нь хүрэн бор хөрс байгаа хэсэгт буюу ханын дээд ирмэгээс 130 см зайд, Port 4 хэмжигчийг ханын дээд ирмэгээс 166 см зайд тус тус байршуулж мэдээлэл хэмжив. Багажийн байршлыг хүснэгт 2, зураг 4-т үзүүлэв.


12 сарын 5 өдрийн 14 цагийн 45 минут хүртэлх мэдээллийг харахад Port 2 хэмжигчийн утга чийгийн агууламж өндөр, Port 4 хэмжигч чийгийн агууламж хамгийн бага байгааг зааж байна. 2019 оны 11 сарын 14-нөөс 17 хооронд баруун ханын 130 см, 166 см зайд чийг гэнэт багасах байдал харагдав. Мөн 2019 оны 11 сарын 17 өдөр, 50 см чийгийн агууламж бага болж байгаа байдал харагдав (Зураг 5).

Хүснэгт 1. Хөрсний чийг хэмжигчийн байршил (2019.02.01-нээс 04.06 хүртэл)


Багаж зураг	Хэмжигчийн дугаар	Байршил	
	Port-1	Дунд хэсэг (Баруун хана)	Шалнаас 155 см
	Port-2	Доод хэсэг (Баруун хана)	Шалнаас 50 см
	Port-3	Дунд хэсэг (Зүүн хана)	Шалнаас 160 см
	Port-4	Доод хэсэг (Зүүн хана)	Шалнаас 60 см



Зураг 1. Бунхны үүд хэсгийн баруун хананд байршуулсан хөрсний чийг хэмжигч



Зураг 2. хөрсний чийг хэмжигчийн үр дүн (2019.02.01-нээс 04.06 хүртэл)



Зураг 3. Бунхны баруун хананы ул хөрсний зураг






Зураг 4. Бунхны үүд хэсгийн баруун хананд байршуулсан хөрсний чийг хэмжигч

Хүснэгт 2. Хөрсний чийг хэмжигчийн байршил (2019.09.21)

Багаж зураг	Хэмжигчийн дугаар	Байршил	
	Port-1	Дээд хэсэг (Баруун хана)	Дээрээс 50 см
	Port-2	Дунд хэсэг (Баруун хана)	Дээрээс 100 см
	Port-3	Дунд хэсэг (Баруун хана)	Дээрээс 130 см
	Port-4	Доод хэсэг (Баруун хана)	Дээрээс 166 см



Зураг 5. Бунхны үүд хэсгийн баруун хананд байршуулсан хөрсний чийг хэмжигчийн үр дүн

## Хоёр. Бунхны үүд хэсгийн баруун, зүүн хананы хөрсний температурын хэмжилт

Шороон Бумбагар бунхны хөрсний чийгийн судалгаатай уялдуулан хөрсний температурын хэмжилтийг 2019 оны 9 сарын 21-нээс эхлүүлэв. Соёлын өвийн хадгалалт хамгаалалтын хувьд чийг, температурын хоорондын хамаарал чухал нөлөөтэй. Баруун ханын хөрсний температурыг зургийн гадаргуугаас дотогш ойролцоогоор 3 см зайд хэмжив. Хэмжигчүүдийг Unit 1, Unit 2, Unit 3, Unit 4 гэж дугаарлаж, хананы дээд ирмэгээс 50 см, 100 см, 150 см, 200 см зайд тус тус байршуулав.

Unit 1	Дээд хэсэг (Баруун хана)	Дээрээс 50 см
Unit 2	Дунд хэсэг (Баруун хана)	Дээрээс 100 см
Unit 3	Дунд хэсэг (Баруун хана)	Дээрээс 150 см
Unit 4	Доод хэсэг (Баруун хана)	Дээрээс 200 см

Мэдээллийн үр дүнгээр баруун хананы хөрсний температурын хэмжигчүүд гүний төвшингөөс хамаарч ойролцоогоор температур нь доороос дээшээлэх тусам 1 хэмийн дулаан байв. Тухайлбал, Unit 4 нь 2019 оны 9 сарын 21-ны 14 цагийн байдлаар 9.8 хэмтэй байсан бол Unit 1 нь 11,3 хэмийн дулаантай байв. 2019 оны 12 сарын 5 өдрийг хүртэлх мэдээлэлээс харахад хөрсний температур аажмаар буурч 2-4 хэм болов.


2019 оны 10 сарын 25 -наас долоо хоногийн турш температурын хэлбэлзлэл бага, тогтмол 7-7.3 °C хэмтэй байснаа буурсан үр дүн харагдаж байна. Хэдийгээр бунхны үүд хэсгийг битүүмжлэсэн ч орчны температурын хүйтрэлтийн нөлөөнөөс үүдэн ул хөрсний температур буурч байгаа нь тодорхой байна.



Зураг 6. Бунхны үүд хэсгийн баруун хананд байршуулсан хөрсний дулаан хэмжигчийн үр дүн

## Гурав. Бунхан байршиж буй газрын ул хөрсний өрөмдлөг

Шороон Бумбагар бунхны ханын зургийн хадгалалтын арга хэмжээ, хөрсний чийг, түүний шилжих, уурших хөдөлгөөний талаар цаашид судлах зорилгын хүрээнд бунхан байршиж буй газарт хэд хэдэн цэгт өрөмдлөг хийж, ул хөрсний бүтцийг нягтлах шаардлага үүссэн. Шороон Бумбагар бунхан байршиж буй газарт хийх өрөмдлөгийн талаар Нарагийн Соёлын Өвийн Хүрээлэнгийн Хадгалалт Хамгаалалт Сэргээн засварлалтын газрын ахлах судлаач Вакияа Соичиро, тус хүрээлэнгийн Хадгалалт Хамгаалалт Сэргээн засварлалтын газрын дарга, Киото Их Сургуулийн Хүн ба Байгаль Шинжлэлийн Сургуулийн багш Коүзүма Ёосүйтай зөвлөлдсөн ба судлаачдын зөвлөгөөний үр дүнд бунхны байгууламжийн гадна хэсэгт өрөмдлөг хийх ба байгууламжийн нүүрэн талын баруун, зүүн талд мөн бунхны овоолго шорооны хойд хэсэгт талд баруун, зүүн талд өрөмдлөг хийх нь зүйтэй гэж үзсэн. Зураг 7-т өрөмдлөг хийх байршлыг харуулав. Ул хөрсний өрөмдлөгийг бунхны хамгаалалтын байгууламжийн баруун, зүүн, урд тал болон бунхны овоолго шорооны хойд талд тус бүр нийт 4 байршилд 2019 оны 9 сарын 18-наас 20 хооронд хийж гүйцэтгэв. Өрөмдлөгийн гүн нь байгууламжийн баруун талд 8 м (Bore hole 1), зүүн талд 5 м (Bore hole 2), байгууламжийн урд тал 6 м (Bore hole 4), бунхны овоолго шорооны хойд талд 6 м (Bore hole 3) тус тус байв (зураг 7).



Зураг 7. Ул хөрсний өрөмдлөгийн байршил.


Өрөмдлөгөөр үр дүнгээр bore hole 1 өрөмдлөгийг барилгын гадна, баруун талд барилгын хананаас 4 м, үүд хэсгээс 11м 8 см зайд хийв. Өнгөн хөрс нь 0-300 см, бутармал, хэмхдэс бүхий өгөршсөн занарын үе 300 -500 см хэсгээс, шар өнгийн шаварлаг үе 500 см гүнээс тус тус илрэв (Зураг 8).

Bore hole 2 өрөмдлөгийг барилгын гадна, зүүн талд барилгын хананаас 4 м, үүд хэсгээс 11м 8 см зайд хийв. Өнгөн хөрс нь 0-170 см, бутармал, хэмхдэс бүхий өгөршсөн занарын үе 300 см хэсэгт байгаа бол 450 см гүнээс том том хадтай давхарга илэрлээ.


Bore hole 3 өрөмдлөгийг барилгын гадна, шороон овоолгоны ард талд барилгын нуруу голлож, хананаас 4 м см зайд хийв. Өнгөн хөрс нь 0-90 см, цайвар шар өнгийн хөрс 100-150 см гүнээс, бага зэргийн чулуутай хөрс 150-300 см гүнд байгаа бол 450 см гүнээс том том хадтай давхарга илэрлээ.


Bore hole 4 өрөмдлөгийг барилгын гадна урд талд хийв. Өрөмдлөгөөр улаандуу элсэрхэг хөрс 0-100 см гүнээс, цайвар шар өнгийн хөрс 100-200 см гүнээс, бага зэргийн чулуутай хөрс 200 см гүнээс, занарын жижиг хэмхдэс 350 см гүнээс, шар шавар давхарга 470-500 см гүнээс, жижиг чулуутай бор шар өнгийн хөрс 530 см гүнээс, занар чулуулаг давхарга 580 см гүнээс тус тус илрэв.

Нэгж цооногны өрөмдлөгөөс 50 см тутамд чийг болон хөрсний ширхэглэгийн бүрэлдэхүүн тодорхойлох шинжилгээний дээжийг авсан. Зураг 8-т шинжилгээний үр дүнгээс харуулав. Bore hole 1 цооногны нийт 9 дээжийн үр дүнгээр 150 -400 см хүртлэх зайд “gravel” хувь өндөр байгаа нь тогтоогдов. 500 см доош гүнд “Silt-Clay” агууламж өндөр байв (Зураг 8,9 ). Өрөмдлөгийн цооногноос илэрсэн дээжүүдийн ширхэглэгийн бүрэлдэхүүн, чийг, уян налархай, нягт, сүвэгшил гэх мэт лабораторийн шинжилгээ хараахан дуусаагүй байгаа ба судалгааг нэгтгэн дүгнэсний дараа танилцуулах төлөвлөгөөтэй байна.




Зураг 8. Bore hole 1, ул хөрсний өрөмдлөгийн дээж





Зураг 9. Bore hole 1, ул хөрсний өрөмдлөгийн ширхэглэгийн бүрэлдэхүүн




Зураг 10. Bore hole 1, ул хөрсний өрөмдлөгийн ширхэглэгийн бүрэлдэхүүн

### Дөрөв. Бунхны баруун хананы чийгийн тархалтын судалгаа

Энэ судалгаанд бетон ба зуурмаг дахь диэлектрик тогтмолын өөрчлөлтөөр материал дахь чийгийг агууламжийг илрүүлэх HI-520 тестерийг ашиглалаа. Уг тестерийг аль болох тэгш гадаргууд хэмжилт хийх хэрэгтэй ба бунхны хананы гадаргуу тэгш бус байсан нь хэмжилт хийхэд төвөгтэй байдал үүсгэж байв. Хэмжилтээр бунхны үүд хэсгийн баруун хана, зураг хадгалагдан үлдсэн хэсэгт хэмжилтийг хийв. Энэ судалгааг лабораторид бэлтгэсэн шавар зуурмагийн дээж, тэдгээрийн тогтмол


температур дахь чийгийн агууламжийн өөрчлөлт, туршилтын үр дүнтэй харьцуулан нэгдсэн дүгнэлтийг гарах юм.



Зураг 11. Бунхны баруун хана дахь чийгийн судалгаа, хэмжилтийн цэг

### Тав. Бунхны дотоод орчны судалгааны талаар


2017 оны 3 сараас орчны бичил цаг уурын судалгааг хийж эхлүүлсэн бөгөөд бунхны гадна талд, үүд, цооног, бунханд болон байгууламж дотор нийтдээ 13 ширхэг температур, харьцангуй чийгшлийн багаж суурилуулж мэдээллийн санамжийг 15 минутаар тохируулав (Зураг 12). Энэ удаагийн судалгаагаар No.6, 7, 8, 9 дугаартай мэдээлэл хэмжигч сенсоруудыг бунхны үүдний хэсэгт байршуулан мэдээллийг хэмжив.




Зураг 12. Бунхны гадна талд, үүд, цооног, бунханд болон байгууламж дотор байршуулсан температур, харьцангуй чийгшлийн багажны байршил

Зураг 13-т үзүүлсэн зурагт 2019 оны 9 сарын 21 өдөр бунхны үүд хэсэгт байршуулсан температур, харьцангуй чийгшлийн багажны байршлыг харуулав. No.1 дугаартай хэмжигчийг барилгын агааржуулалтын хоолойн ойролцоо байршуулав. Хэмжилтийн үр дүнгээр гадна температурын өөрчлөлтийг даган байгууламж доторх хэмжигч (No.11, No.1) өөрчлөгдөж байгаа нь тодорхой байна. Харин No.2, No.3, No.15, No.16 хэмжигчүүд тогтвортой байдлыг зааж байна. 2019 оны 11 сарын дунд үеэс гадна температур огцом хүйтрэхэд үүд хэсгийн No.3 дугаартай хэмжигч бага зэргийн хэлбэлзэлттэй байна (Зураг 14).


Харьцангуй чийгшлийн мэдээллийн хувьд No.10, No.15, No.16 сенсорууд 100 % чийгшил зааж байгаа бол No.2, No.3 дугаартай сенсорууд 2019 оны 10 сарын эхэн үеэс чийгшил буурч байгаа байдал харагдаж байна. Харин No.13 дугаартай сенсоруудын мэдээлэл 9 сарын сүүлээр огцом буурсан байдал ажиглагдаж байна (зураг 14).



Зураг 13. Бунхны үүд хэсэгт байршуулсан температур, харьцангуй чийгшлийн багажны байршил (2019.9.21)







Зураг-14. Бунхны үүд хэсгийн бичил цаг уурын судалгааны үр дүн (Температур, харьцангуй чийгшил, үнэмлэхүй чийгшлийн үзүүлэлт)

ТАЙЛАН БИЧСЭН:  
 О.АНГАРАГСҮРЭН. КИОТО ИХ СУРГУУЛИЙН  
 СОЁЛЫН ӨВИЙН ХАДГАЛАЛТ  
 ХАМГААЛАЛТ, СЭРГЭЭН  
 ЗАСВАРЛАЛТЫН ДОКТОРАНТ

### **3.3. Увс аймгийн Могоогийн хадны зургийг цэвэрлэх, бэхжүүлэх, хэв дардас авч хамгаалах.**

- Засгийн газрын 2018 оны 175 дугаар тогтоолоор батлагдсан Увс аймгийн Сагил сумын нутагт орших Могоогийн хадны зурагт үүссэн биологийн болон физик гэмтлийг зогсоох, бэхжүүлэх, хэв дардас авах.

Соёлын өвийн үндэсний төвийн (СӨҮТ) Соёлын биет өвийг сэргээн засварлах газрын (СБӨСЗГ) 2019 оны Үр дүнгийн гэрээний 3.3 дахь ажил үйлчилгээ, “Чулуун соёлын өв” хөтөлбөрийн ажлын хүрээнд тусгагдсаны дагуу Увс аймгийн Сагил сумын IV багийн нутаг Цагаан голын сав газарт байрлах Могоо, Бужаагийн хадны зураг мөн Их сартын хадны зургаас хэв авч, хуулбар хийх ажлыг Соёлын өвийн үндэсний төв болон Увс аймгийн музей хамтран 2019 оны 6 дугаар сарын 03 ны өдөр хамтран ажиллах гэрээ байгуулан 2019 оны 8 дугаар сарын 4-ний өдрөөс 14-ний өдрийн хооронд дурсгалт газар очиж ажиллан, дурсгалаас хэв авах ажлыг хийж гүйцэтгэв.

Уг ажлын баг бүрэлдэхүүнд Соёлын өвийн үндэсний төвийн захирал Г.Энхбат, Соёлын өвийг авран хамгаалах газрын дарга Г.Анхсанаа, Мэдээллийн технологи, аюулгүй байдлын газрын систем хөгжүүлэлтийн инженер П.Чинбат, Увс аймгийн музейн захирал Ш.Цэдэнбал нар тус дурсгалт газар эрсдлийн судалгаа хийх, агаарын зураг, гэрэл зургийн баримтжуулалт хийх, Соёлын биет өвийг сэргээн засварлах газрын дарга Д.Нямдорж, сэргээн засварлагч А.Мөнгөнцоож, Э.Батжаргал, жолооч Д.Чанагнянгар, Увс аймгийн музейн БМС О.Мянганбуу, ЭША Н.Гэрэлмаа, нягтлан бодогч Ц.Анхзаяа, жолооч Ч.Батхүү нарын бүрэлдэхүүнтэй баг дурсгалаас хэв авах ажлыг хийж гүйцэтгэх чиг үүрэгтэйгээр ажиллав.

Уг хадны зураг оршин буй хад чулууны дээд талд томоохон хэмжээний үхэр чулуу байгалийн тогтоц хэлбэрээр удаан хугацааны туршид тогтон байх ба уг чулуу нь газрын хөрстэй холбогдоогүй, өөрийн хүндийн жин, төвөөрөө сул тогтож байгаа нь байгалийн болон бусад хүчин зүйлийн улмаас дурсгалд хэзээ нэг цагт гэмтэл учруулах магадлалтай байна. Мөн дурсгал байрлах газраас харалдаа урд доод бэлд нь айлын өвөлжөө байрлана. Энэ нь дурсгал орчимд айлын мал бэлчээрлэх орчин, хотлох зам болж байгаа нь дурсгалын хадгалалтын орчин, эрсдэлийн нөхцөл байдлыг нэмэгдүүлэх магадлалтай байна.

Могоогийн хадны зургаас 3 төрлийн, Их сартын хадны зургаас 1 төрлийн нийт 4 төрлийн хэв авав.

Хэвийг Соёлын өвийн үндэсний төвийн сэргээн засварлах лабораторт засаж янзалсны дараа, цутгуурын аргаар хуулбар хийх, хуулбар хийсний дараа өнгө будаг тавьж, дурсгалын эх төрхтэй адил хэмжээнд 1х1 хэмжээнд мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэв.

## МОЖОО, БУЖААГИЙН ХАДНЫ ЗУРАГ

Увс аймгийн Сагил сумын нутаг Могоогийн хад хэмээх газар Монголд төдийгүй дэлхийд гайхагдах нэгэн сонирхолтой дурсгал бий. Могоогийн хадны зурагт аргаль, янгир, тэмээ, нохой, үхэр, хүн зэргийг дүрсэлжээ. Үхрийг нум сумаар харваж байгаа болон хөтлөн явж буй хүний дүрсэлсэн бөгөөд Хойд цэнхэрийн агуйн зургийн адил түүхийн үнэ цэнийг агуулдаг. Тодруулбал Могоогийн нэгэн том толигор хаданд хэд, хэдэн үхэр дүрсэлжээ. Тэдгээрийн дунд данхар том эвэртэй, гоёмсог биетэй бухыг дүрслэхдээ биеийг нь зориуд тодоор гаргаж палеолитийн урлагт өргөн дэлгэрсэн тэмдэг болох "амьтны үржлийг бэлгэдсэн" зууван дугуй хонхорыг бухны хүйсийн харалдаа урлажээ.

Уг зураг зурагдах үед үхрийг гэршүүлсэн үе болохыг үзүүлэхийн сацуу нум сумыг хүн мезолитын үеэс эхлэн хийж хэрэглэж байсан цаг үеийг давхар нотолдог хэмээн судлаачид үздэг.

Дурсгалт газар ажиллах баг бүрэлдэхүүн 2019 оны 8 дугаар сарын 4-ний өдөр Улаанбаатар хотоос хөдөлж тус сарын 6-ны өдөр дурсгалт газар хүрч дурсгалт газар орчны эрсдлийн судалгааны ажлыг хийсэн ингэхдээ орчны байдал, дурсгалын нөхцөл байдалтай танилцаж гэрэл зураг болон агаарын зураг авч баримтжуулсан.



*Зурагт Могоогийн хадны зураг*

Тус дурсгал нь өргөрөг, уртрагийн ... цэгт уулын урд энгэрт дунд хавьцаа байрлах ба, налуу хэвтээ чулуун дээр уг хадны зургийг дүрсэлсэн байна. Уг хадны зураг оршин буй хад чулууны дээд талд томоохон хэмжээний үхэр чулуу байгалийн тогтоц хэлбэрээр удаан хугацааны туршид тогтон байх ба уг чулуу нь газрын хөрстэй холбогдоогүй, өөрийн хүндийн жин, төвөөрөө сул тогтож байгаа нь байгалийн болон бусад хүчин зүйлийн улмаас дурсгалд хэзээ нэг цагт гэмтэл учруулах магадлалтай байна. Мөн дурсгал байрлах газраас харалдаа урд доод бэлд нь айлын өвөлжөө байрлана. Энэ нь дурсгал орчимд айлын мал бэлчээрлэх орчин, хотлох зам болж байгаа нь дурсгалын хадгалалтын орчин, эрсдлийн нөхцөл байдлыг нэмэгдүүлэх магадлалтай.

Иймд дурсгалын дээд талд байрлах үхэр чулууны үзүүлж болох эрсдлийг сайтар тооцоолон, шаардлагатай гэж үзвэл уг чулууг дурсгал орчмоос хөдөлгөж холдуулах ажлыг хийх, ингэхдээ аюулгүй ажиллагааг сайтар тооцож шаардлагатай техник, гар өргөгч, татагч зэргийг ашиглан дурсгалыг гэмтээлгүй ажиллах арга зүйг боловсруулан ажиллах, мөн хамгаалалтын хашаа, хайс барих зэргээр дурсгалын хадгалалт, хамгаалалтын байдлыг сайжруулах ажлыг хийх шаардлагатай байна.



*Зурагт Дурсгалын хэв, хуулбар авах цэвэрлэгээний ажлын явц*



*Зурагт Дурсгалын хэв, хуулбар авах ажлын бэлтгэл*

Хатуу, зөөлөн буюу силикон, полистер материал ашиглан хэв авах ажлыг 8 дугаар сарын 6- аас эхлэн 3 хоногийн хугацаатай ажиллав.

Уг ажлыг хийж гүйцэтгэхэд дурсгал болон ойр орчныг цэвэрлэх ажлаар эхлүүлсэн. Дурсгалын орчимд уулын сул чулуу, хайрга ихтэй ба эдгээрийг зайлуулж зайчлан, дүрслэл бүхий хаданд ургасан чулууны хагийг механик аргаар цэвэрлэх хадны зурагтай чулууг цэвэр усаар зөөлөн шүршиж щёткаар зөөлөн үрж угааж цэвэрлэн сайтар хатаасны дараа силикон хэвний тусгаарлагчийг 2 үе давхарлан түрхэж хатаан хэв авах ажилд бэлдсэн.

Үүний дараа дүрслэл бүхий хадны өөрийн байгалийн хэлбэр, мөн зургийн ухаж сийлсэн дүрслэлийг 1х1-ийн хэмжээтэй нарийвчлалтайгаар зөөлөн хэв буюу силикон резин ашиглан авсан. Үүний дараа полистер материал хэрэглэн гадна хатуу хэвийг бэхжүүлж авав.

Хатуу болон зөөлөн хэвийг сайтар хатаж бэхжсэний дараа зураг бүхий хаднаас салган авч хаданд түрхсэн тусгаарлагч гелийг усаар сайтар угааж, орны цэвэрлэгээ хийв.



*Зурагт Дурсгалын хэв, хуулбар авах ажлын явц*

## **ИХ САРТЫН ХАДНЫ ЗУРАГ**

Увс аймгийн Сагил сумын нутаг Үүрэг нуурт баруунтайгаас цутгадаг Цагаан голын цутгалын урд орших хоёр жижиг толгойн урд талынх нь "Бага сар", хойд талынх нь "Их сар" гэнэ. Их сарын хойд талын баруун тийш харсан нэгэн том толигор хаданд эртний нум сум онилсон хүн, хэдэн амьтдын зургийг цоолборложээ.

Хаднаа дүрслэгдсэн хүн одоогийн жанжин малгай маягийн шовх оройтой, дөрвөн талтай, хоёр тийш унжсан чих бүчтэй, духаа дагасан хүрээтэй харагдах малгай, ээтгэр шовх хошуутай гутал өмсөж өргөн бүс бүсэлсэн байх нь эрт үеэс уламжлагдаж ирсэн монгол малгай гуталтай төстэй бөгөөд нумын хэлбэр хийц ч гэсэн XIII зууны үед хэрэглэгдэж байсан монгол нумтай ижил ажгуу. Энэхүү нум сум онилсон хүнийг нарийн зураасаар зурсан нь ч гэсэн дүрсэлсэн аргаараа өвөрмөц байна. Хүний зурагны хажууд болон зүүн хийгээд чанх доор нь нийт арав гаруй амьтад, тэмдэг зураасыг бүх

талбайгаар нь хонхойлгон өргөн зураа- саар цоолборлосны дунд лавтай таван янгир, чоно болон буга согоо байж болохоор дүрсүүд ажиглагддаг.

Их сартын хаднаа шовх оройтой малгайтай хүний дүрс, хүчит нум саадаг зэрэг нь Төв аймгийн Алтанбулаг сумын нутагт байдаг Морин толгойн нумчны зурагтай ихэд төсөөтэй юм. Морин толгой болон Их Сарын хаданд дүрсэлсэн хүчит нум нь хэлбэр хийцийн хувьд дундад зууны үед монголчуудын хэрэглэж байсан хүчит нумтай ижил агаад Их Сарын хаданд дүрсэлсэн жанжин малгай, ээтэн хоншоортой монгол гутал зэргээр дээрх хоёр зургийг судлаачид дундад зууны үед холбогдуулан авч үздэг.



*Зурагт Их сартын хадны зураг*

Хадны баруун дээд хэсэгт матмал, махир мөртэй нуманд навчин хэлбэрийн сум онилсон, нэг хөлөө гишгэж нөгөө хөлөө ергөн гүйж яваа хүнийг дүрсэлжээ.

Их сартын хадны зураг нь 3м орчим өндөр ханан хадны элгэнд байх ба уг хадны байгалийн бүтэц, тогтоц нь маш сонирхолтой ширхэглэг бүхий чулуу байдаг.

Дүрслэл бүхий хаднаас хэв авхаас өмнө хадыг цэвэрлэх ажлыг хийж гүйцэтгэв. Ингэхдээ хадны завсар зайд шигсэн шороо, ургамлын хатсан үлдэц зэргийг механик

аргаар цэвэрлэн усаар шүршиж багс, щёткаар зөөлөн үрж угааж хатаан силикон хэвний тусгаарлагч гель түрхэж хатаав.



*Зурагт хэв, хуулбар авах ажлын бэлтгэл*

Үүний дараа хэвний ажлыг дарааллын дагуу хийв.



*Зурагт хэв, хуулбар авах ажлын явц*

Эдгээр хэв авах ажлыг хийж гүйцэтгэсний дараа хэвэнд хуулбарыг цутгах ажлыг Улаанбаатар хотод хийж гүйцэтгэсэн. Хуулбар хувийг хийхэд мөн полистер материалыг ашиглан хэвэнд шуумалдах аргаар хийдэг. Хуулбарыг хийхдээ цутгуурын материалдаа уг дурсгалын эх өнгөнд ойролцоо пигментээр өнгө өгч хийх ба цутгаж, хатааж, салгасны дараа гадна ирмэгийг хөрөөдөж, зүлгэж цэвэрлэн нарийвчилсан өнгө будгийн ажлыг гүйцэтгэв.

Уг дурсгалуудаас хэв авч хуулбар хийх ажил дууссаны дараа тайлан үзэсгэлэн гарч хуулбарууд Увс аймгийн музейд байрших юм.



*Зурагт хэвэнд хуулбарыг цутгах ажил*



*Зурагт дурсгалын хуулбарт будгийн ажил хийх явц*





*Зурагт дурсгалын хуулбар*

Эдгээр хосгүй үнэт болон бусад дурсгалуудаас 1x1 хэмжээтэй хэв авч, хуулбар хийж музейд байршуулснаар уг дурсгалыг олон нийт болон судлаачдад ойртуулах, таниулах ач холбогдолтойн дээр хэв, хуулбар нь улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд хадгалагдаж үлдэж байгаагаараа чухал ач холбогдолтой юм. Цаашид эх дурсгалуудын хадгалалт, хамгаалалтын байдалд байнгын хараа хяналт тавьж эрсдэлд орохоос урьдчилан сэргийлж ажиллах шаардлагатай байна.

-----oOo-----

### 3.4. “Чулуун соёлын өв” үндэсний хөтөлбөрийн Зорилт 2 дахь Чулуун соёлын өвийг хамгаалах, сэргээн засварлах /Хэв, дардасыг авах, хуулбарыг хийж хадгалах/

- Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын нутагт орших Баруун элгэний бичээсийн хэвийг авч, хуулбар хийн хадгалах;
- Дундговь аймгийн Өлзийт сумын нутагт орших Дэл уулын хадны зургийн дардсыг авч хадгалах;
- Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутагт орших Жаргалантын ширээний хадны зургийн дардсыг авч хадгалах

## I. ДУНДГОВЬ АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН НУТАГТ ОРШИХ ДЭЛ УУЛЫН ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛ

### 1. Дэл уулын түүх соёлын дурсгалын судалгааны тойм

Дэл уулын хадны зураг болон бусад түүх, соёлын дурсгалыг судлах анхны шанг 1960 онд А.П.Окпадников, Д.Дорж нарын удирдсан Монгол-Зөвлөлтийн шинжилгээний ангийнхан татжээ. Тэр цагаас хойш гадаад дотоодын олон судлаачид уг дурсгалт газар очиж судалгааны ажил хийсээр өдийг хүрчээ.

1969, 1975 онуудад Д.Дорж, Э.А.Новгородова нар Дэл уулын хадны зургийн дурсгалыг дахин нягтлан судалж, 1975 онд хэвлүүлсэн “Петроглифы Монголии” бүтээлдээ тэмээ болон морь унаж жад барьсан хүн, шувуу, янгир, тэмээ, цэг, гэр зэрэг зургуудыг оруулан нийтэлжээ [Дорж, Новгородова, 1975, с.30-31 таб XXV].

1987 онд Т.Санжмятав нарын бүрэлдэхүүнтэй МЗТСХЭ Дундговь аймгийн музейтэй хамтран Дэл уулын Өлзийтийн хуудас хэмээх газарт судалгаа хийж олон тооны хадны зураг илрүүлсний сацуу, “Гучин хоёр хүнт хөшөө” хэмээн нэрлэгдсэн хашлага чулууд дээрээ элдэв амьтны сийлмэл зураг, бүжиж буй хүмүүсийн зурагтай дөрвөлжин булшийг нутгийн ард Нацагаар газарчилуулан олж малтан судалсан байна [Санжмятав, 1987, 74-75].

1990-ээд оноос МУИС-ын Түүхийн тэнхимийн багш профессор Д.Хүүхэнбаатар Дэл ууланд салбарын оюутны дадлагыг удирдан явуулж цөөнгүй дурсгалыг илрүүлэн олохын зэрэгцээ өмнө нь илэрч олдсон дурсгалуудыг нягтлан үзэж, руни бичиг, хадны зураг зэрэг хэд хэдэн дурсгалыг эрдэм шинжилгээний эргэлтэнд оруулж, эрдэмтэн судлаачдын сонорт хүргэжээ. Тухайлбал: судлаач Ю.Болдбаатар Дэл уулнаас илрүүлсэн руни бичгийг “**Жаран хулан авлав, халтар тэх, тэмээн гөрөөс авлав, хорин чоно авлав**” хэмээн тайлан уншсан бөгөөд үр дүнгээ нийтлүүлсэн байна [Болдбаатар, 1997, 26-37; Болдбаатар, Хүүхэнбаатар, 1998, 191-196; Болдбаатар, 2000, 209-219].

Мөн судлаач Д.Сүхбаатар, Э.Жигмэддорж нар Дэл уулын эртний түүхийн дурсгалыг ерөнхийд нь 1.Чулуун зэвсгийн зүйл, 2.Дөрвөлжин булш хэрэглэгдэхүүн, 3.Хадны зураг, 4.Бичээс хэмээн ангилсны дотор хадны зургийг сэдвээр нь

- а. Тамга дүрс
- б. Хүн

- c. Гэрийн ба тэжээмэл амьтан
- d. Хөсөг тээвэр болон нүүдэлчдийн гэр ахуй
- e. Ан гөрөөний холбогдолтой
- f. Дайн тулааны гэсэн ерөнхий 6 хэсэгт хуваан үзсэн [2003, 13-18,]

бол хожим дахин 1. Булш оршуулгын зүйлс, 2. Хадны сүг зураг, 3. Бичиг үсгийн дурсгал хэмээн 3 ангилаад хадны зургийг дотор нь 5 хэсэг болгон хувааж, дүрслэлийг авч үзэж, он цагийг МЭӨ II мянганы сүүл хагаст холбогдуулан үзжээ. Мөн дээрх судлаачид Зүүн билүүний худгийн баруун талын мөрөгцөг хаданд буй хятад бичээсийг 4 мөр, 21 ханз үсгээс тогтоно хэмээн үзээд **“665 оны Линь Дэ-гийн 2-р дугаар он буюу хөхөгчин үхэр жилийн 8 дугаар сарын 29-ний өдөр”** хэмээн уншжээ [2006, 40-55].

Дэл уулын хадны зурагт гэр дүрслэн зурсан байдаг нь судлаачдын анхаарлын ихээр татдаг бөгөөд энэ талаар эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл хэвлэгдсэн байдаг [Жанболат, 1997, 20-25; Баатархүү, Жигмэддорж, 2004, 64-72].

Дэл ууланд байх нэгэн сонирхолтой дурсгал бол ханз үсгээр бичиж үлдээсэн бичиг бөгөөд уг хятад бичигийг Ц.Баттулга нарын судлаачид анх хуулан авч, **“Лю Вэнь-цзи Линьдэ-гийн 2-р он Зургаан сарын 28-ны өдөр, Линчжоу фу-гийн туслах мэргэдийн сяовэй зарилаг болгов”** хэмээн уншиж, үр дүнг “Дэл уулнаас шинээр олдсон хятад бичээс” нэртэйгээр өгүүлэл нийтлүүлсэн байна [2001, 103-105].

Мөн Дэл уулын Баруун билүүний эхэнд Булаг билүүтийн хурлын туурийн арын хаданд байх 4 хэсэг руни бичээсний II, III бичээсийг ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Ц.Баттулга судлан (2-р бичээсний орчуулга **“антай салаа, тэнгэр минь та эзэн, нээ, 3-р бичээсний орчуулга “Өтүс дэхь их хөндий” хэмээн**) уншиж, судлаад II бичээс ангийн хишиг, үүдийг нээж хайрла гэсэн, III бичээс овог аймагтаа нэр хүндтэй, нөмөр нөөлөг болсон нэгэн буурлыг урт наслахыг ерөөж бичсэн Түрэгийн сонгодог бичгээс өмнө үед холбогдох дурсгал хэмээн үзжээ [1998, 109-113].

1998 онд хэвлэгдсэн “Монгол нутаг дахь түүх, соёлын дурсгал” сэдэвчилсэн лавлахад Дэл уулын зүүн Билүүний нэгэн хаднаас хоёр гараа тулан зогсож буй 2 хүний зургийг авч оруулсан байна [1998, 38-39].

2003 онд ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн захирал Д.Цэвээндорж, эрдэм шинжилгээний ажилтан Н.Батболд нарын бүрэлдэхүүнтэй шинжилгээний анги “BoGuKhaTe” ХХК-ийн дэмжлэгтэйгээр Дэл уулын баруун, зүүн Билүүний хадны зургаас 50 гаруй зургийг хэсэгчлэн хуулбар хийн авч, тайлбар сэлтийн хамт 2005 онд нэгэн сэдэвт ном болгон хэвлүүлсэн байна. Судлаачид Дэл уулын Зүүн, Баруун билүүний хадны зургийн дүр дүрслэл, зохиомж, холбогдох цаг хугацааны талаар авч үзээд агуулга, зохиомжийн хувьд ан хийж буй буюу анчид морь мал хөтөлсөн хүмүүс, ан амьтны зураг зонхилож байгаа ба зургийг дүрсэлсэн арга барил зэргээс үзэхэд он цагийн хувьд хүрэл зэвсгийн үеэс төмөр зэвсгийн үед холбогдуулжээ [2005, 64].

2006 онд Б.Батсүрэн, Д.Хүүхэнбаатар нар “Дэл уулын хадны нэгэн зургийн тухайд” нэртэй эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлсэн нь 1995 онд “Монголын эртний түүх, соёлын дурсгалтай танилцах” дадлага хийж байх үеэр олсон Дэл уулын

Зүүн билүүний амны дунд биеийн Хөтөл Билүүний худаг болон задгай устай булгаас баруун хойд зүгийн худгийн ойролцоо 3-4 км зайд 19х26 см харьцаатай хадан дээр морь унасан 8 хүн, нэг тэмээг хурц үзүүртэй мэсээр сийлсэн хадны зураг илрүүлэн олсноо Дэл уулын түрэг, хятад бичигтэй холбон үзэж, түрэгийн цэргийн хэргийг харуулсан хадны зураг бололтой гээд VII зууны хоёр дугаар хагаст Төв Азид нөлөөгөө тогтоосон тэлэ буюу түүний нэг том салбар аймаг болох уйгурууд бүтээсэн гэсэн таамаглал дэвшүүлсэн байна [2006, 28-41].

2005 онд МУИС-ийн түүхийн тэнхимийн багш Д.Сүхбаатар Дэл уулын цогцолбор дурсгалыг тусгайлан судалж “Дэл уулын түүх соёлын дурсгал” хэмээх сургалтын баримтат кино бүтээсэн бөгөөд 2008 онд “Дэл уулын хадны зураг” хэмээх гэрэл зургийн цомог хэвлэн гаргасан нь дотроо:

1. Ан гөрөө
2. Дэлийн оршин суугчдын аж ахуй
3. Тамга
4. Булш, тахилын зан үйл

5. Соёл, бичгийн дурсгал хэмээн ангилж гэрэл зургуудыг сонгон оруулсан байна [Сүхбаатар, 2008] ба эдгээр нь танин мэдэхүйн ач холбогдолтойгоос гадна уг дурсгалт газрын судалгаанд зохих нэмэр болох нь дамжиггүй.

2011 онд БСШУЯ-ний харьяа Соёлын өвийн төв, Дундговь аймгийн музейн мэргэжилтэн судлаачдын баг “Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэл” төслийн хүрээнд Дэл уулын баруун, зүүн Билүү, Өлзийтийн хуудасны хадны зургийг, “32 хүнт” болон бусад булшийг бүртгэн баримтжуулж мэдээллийн санд хадгалсан байна.

## **2. Дэл ууланд орших дөрвөлжин булшны хавтан чулуун дээрх 32 хүнт гэгдэх хадны зургаас хэв авах ажил**




Уг дурсгал нь Дундговь аймгийн Өлзийт сумын төвөөс баруун урагш 80 орчим км зайд Дэл уулын Зүүн билүүнд орших дөрвөлжин булшны хавтан дээрх сийлмэл зураг юм.

Дурсгалт газрын 1ш хавтан чулуунаас хэв авахаар төлөвлөж очсон боловч газар дээр очиж танилцахад 32 хүнт гэгдэх гол хадны зураг нь уртрагийн дагуу суулгасан хэвтээ, тэгш өнцөгт хэлбэрийн 2ш хавтан чулууны

ертөнцийн зүгээр хойд талдаа байрлах хавтан чулууны дээд талд байх ба урд талдаа байх 2 дахь хавтан чулууг дамжин үргэлжилсэн нь тодорхой болсон бөгөөд 2 дахь хавтан чулуу нь зүүн талын хажуу нүүрэндээ буга, шувуу зэрэг өвөрмөц дүрслэлтэй байсан тул 2 дахь хавтан чулууны хэвийг хамтад нь авхаар шийдвэрлэн ажилласан.

Уг зурагт хад нь тунамал чулуулгийн төрөл бөгөөд цаг уурын элэгдэлд маш их өртсөн үе давхаргаараа цууралттай нүүрэн тал нь үе давхаргаар хууларсан, үүнээс болж зарим дүрслэл бүдгэрсэн ба цаашид энэ процесс үргэлжлэн явагдах боломжтой, хатуулаг багатай зөөлөн байгалийн материал бөгөөд үүн дээр зургийг цохиж, сийлж дурсэлсэн байна.



*Зурагт: дурсгалын зүүн, баруун талын хавтан чулуун дээрх дүрслэлийг харуулсан гар зураг*

Ойр орчмын хөрс шорооны байдал ерөнхийдөө сул, нарийн элсэрхэг, өвс ургамлын гарц сийрэг байх ба энэ нь салхи шуурганд амархан зөөгдөх боломжтой ажиглагдаж байсан төдийгүй уг дурсгалын болон ойр орчмын ижил бүтэц бүхий хад чулуунуудын босоо хавтгай хавтаслагт ширхэг бүхий ан цавуудад нарийн шороо, элс орж суусан байгаа нь үүнийг гэрчилж байсан. Иймд цаашид дурсгал орчимд орны судалгаа хийх шаардлагатай юм.

Уг дурсгалаас хэв авах ажлын өмнө хадны зураг бүхий 2ш хавтан чулууг цэвэр усаар шүршин багс, щёткоор чулуулгийн ширхэгийн дагуу зөөлөн үрж угааж цэвэрлэсэн ба хадны зурагт хавтан нь бохирдлын хувьд харьцангуй бага байв. Цэвэрлэгээ хийсний дараа сайтар хатааж үе давхаргаар хуулах эрсдэл үүсэж болзошгүй байсан тул хөнгөн чигжээс хийв. Силикон тусгаарлагч гель 2 үе давхарлан түрхэж хатаав. Үүний дараа силикон резин орж үлдэх магадлалтай гүнзгий цууралт, ан цавуудад цэвэрлэгээний чийгтэй цаасаар чигжээс хийсэн.

Зөөлөн хэв авах ажлын бэлтгэл хангагдсаны дараа силикон резинээр 2 үе давхарлан түрхэж, хэвний дээд хэсгээр хэв салгах зааг гарган хатаасан ба мөн хэвийг бат бөх болгох үүднээс марло нааж 3 дахь резинэн үеийг түрхэж резин түгжээнүүдийг нааж хатаав.



Зөөлөн хэвийг сайтар бэхжүүлэн хатааж хонуулсаны дараагийн өдөр хатуу хэв хийх ажилд орсон ба хэв авхаар төлөвлөж байсан дурсгалын хэмжээ буюу тоо нэмэгдсэн учир хатуу хэв хийх материал дээр бага зэрэг хүндрэл үүссэн. Мөн 2 хавтан чулуу нь хоорондоо маш ойрхон 5см орчим зайтай, хойд талдаа босоо чулуун хавтан тулсан тул хавтан чулууны хэвийг тойруулан бүтэн авах боломжгүй байв. Хатуу болон зөөлөн хэв хатсаны дараа хэвнүүдийг салгаж аван дурсгал болон орчин тойронд цэвэрлэгээ хийв.



Дээрх дурсгал нь нийт 4 ширхэг хэвтээ тэгш өнцөгт хавтан чулуунаас бүрдэх ба эдгээр нь бүгд дээрээ дүрслэл бүхий байсан тул бусад үлдсэн 2 ширхэг хавтан чулуунаас мөн хэв авч хуулбарыг хийж гүйцэтгэх нь зүйтэй гэж үзэн тус дурсгалын хэв хуулбарыг цаашид цогц байдлаар хадгалан үлдээх зорилгоор 2019 оны 9 дүгээр сарын 16-19 ний хооронд дурсгалын үлдсэн 2 ширхэг хавтан чулуунаас хэв авах мөн орчны судалгааны ажлыг хийхээр дурсгалт газар дээр ажилласан болно. Ажлын хэсэг Д.Нямдорж (СБӨСЗГазрын дарга), М. Оюунтулга (СБӨСЗГ Ерөнхий технологич), А.Мөнгөнцоож (СБӨСЗГ сэргээн засварлагч), Т. Сүхбаатар (СБӨСЗГ сэргээн засварлагч), Г.Бүрэнтөгс (СӨБСГ бүртгэл мэдээллийн санч), Б. Амгаланбат (СӨБСГ бүртгэл мэдээллийн санч), Д. Даваа-Очир (МТАБГ оператор), Ч. Өсөхбаяр (туслах) нарын бүрэлдэхүүнтэй томилогдон ажиллав.

Уг томилолтоор ажиллах хугацаанд дурсгалын хэв аваагүй үлдээсэн 2 ширхэг хавтан чулуунаас хэв авсан ба дурсгалын орчны судалгааны ажлыг мөн хийж гүйцэтгэв.



Дэл уулын 32 хүнт дурсгалаас нийт 4 ширхэг хавтан чулуунаас зөөлөн хэв - 4ш, хатуу хэв – 4ш, 1х1 хэмжээтэй хуулбар 4 ширхэг тус бүр соёлын өвийн төвд хадгалагдаж байна.



### **3. Дэл уулын дурсгалд хийсэн орчны судалгаа ба дурсгалын гэмтэж буй байдал, дурсгалд муугаар нөлөөлж буй хүчин зүйл**

#### **Өмнөтгөл**

Дундговь аймгийн Өлзийт сумын Тагт багийн нутагт сумын төвөөс баруун урд зүгт 80 км орчимд байрлах хүрэн улаан өнгөтэй босоо хуудаслаг чулуун тогтоц бүхий Дэл уулын дурсгалууд болох хадны зураг, 32 хүнтийн дөрвөлжин булшны хадгалалтын байдалтай танилцаж дурсгалыг муутгаж буй эрсдэлийг тодорхойлох зорилготой тус дурсгалуудад ажиглалт дүгнэлт судалгааг хийсэн.

#### **Судалгааны зорилго**

Үл хөдлөх чулуун дурсгалын материалын судалгаа хийж, хүрээлэн буй орчны эрсдэлийг тодорхойлж, нарийвчилсан суурь судалгааны үндсэн дээр тулгуурлаж чулууллагийн онцлогт таарсан хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалтын арга зүйг нутагшуулах зорилготой юм.

## Чулууллагийн онцлог

Чулуулаг гэдэг нь эрдэсийн агрегатыг хэлэх ба магмын чулуулаг, тунамал чулуулаг ба хувирмал чулуулаг гэсэн үндсэн төрөлд хуваагдана. Цельсийн 11-12 мянган градус температур бүхий шингэн, өтгөрсөн байдалтай хайлмаг биет цагийн эрхэнд царцсаар нарийн төвөгтэй урвалжийн дүнд бэхжин боржин, хүрмэн чулуу, диорит мэтийн хатуу чулуулаг болон хувирсан байдаг. Уг дурсгалын чулуулгууд нь тунамал чулуулаг бөгөөд газрын гадаргуу дээр ил эсвэл маш бага гүнд, өгөршлийн үр дүнд үүссэн чулуулгийн хэмхдэсүүд, эсвэл төрөл бүрийн органик материал болон химийн тунадасжилтаар үүссэн тунадас нягтран, барьцалдах үйл явцын үр дүнд үүссэн тунадас бүхий элсэн чулуулаг юм. Температурын хэлбэлзэл, ус, амьд организм зэргийн нөлөөгөөр уулын чулуулгийн өгөршлөөр үүссэн тунадас, салхи ба ус гэх мэт байгалийн хүчин зүйлийн нөлөөнд шилжин зөөгдөж газрын гадаргуугийн нам дор хэсэгт (хонхор, хотгор хэсэгт) хуримтлагддаг. Тунадас нь жилд миллиметрээс (далай, тэнгисийн ёроолд) - хэдэн метр (томоохон уулын голын хөндийд) хүртэл зузаантайгаар хуримтлагдаж болно. Тунадас хуримтлагдсаны дараа, эхэлж хуримтлагдсан тундас нь түүнийг хучиж буй тунадсын үүсгэх даралтын нөлөөгөөр нягтран, үелэсэн бүтэцтэй болж чулуужих процесс эхэлдэг.



Зураг:1 Уулын чулуу

## Чулууллагийн гэмтэл

Эвдрэл гэмтлийн хувьд механик, химийн, биологийн, байгалийн хүчин зүйлээс хамааралтай орчинд хадгалагдаж байна. Хадны зураг, 32 хүнтийн дөрвөлжин булшны хувьд ил байдаг тул урт хугацааны туршид үүсэх гэмтлийн шалтгаан нь хөрсний давсжил, халуун хүйтний хэлбэлзэл, салхи шуурга, цөлжилт, агаар мандалийн бохирдолоос үүдэлтэй өгөршил буюу физик гэмтэлд гэмтэж муудах эрсдэл маш



өндөртөй байгаа тул, урдчилан сэргийлж хүрээлэн буй орчны судалгаа явуулах шаардлагатай байна.


Ил чулуун дурсгалыг хадгалж хамгаалах үндсэн 3 арга зүйд:

1. Байгаль орчин хүрээлэн буй орчныг сайжруулах
2. Механик болон хими, биологийн гэмтлийг зогсоож, багасгах
3. Хадгалалт хамгаалалт, бэхжүүлэлт, сэргээн засвар хийх

### Чулууллагийн өнгө ба найрлага



Зураг:2 Чулууллагийн гадаргуу



Зураг:3 Чулууллагийн хавтас

Хадархаг сайр, элсэн чулууны холимог төрлийн тунамал чулуу зонхилсон гадаргуу хэсэг нь хүрэн улаан, дотор хавтаслаг хэсгүүд нь саарал, цайвар шардуу өнгө зонхилсон. Гадаргуу хэсэг нь төмрийн исэлдэлтээс хамаарч улаавтар хүрэн өнгөтэй болж хувирсан хэсгүүд байсан. Дэл уулын дурсгал орчмын чулууны гадарга дээр СӨҮТ-ийн СБӨСЗГ-ын лабораторт HORIBO XGT загварын багажаар XRF буюу рентген флуоресцент спектрийн багажит дүн шинжилгээ хийж чулууллагийн гадаргуун өнгөний хувиралд нөлөөлж буй эрдсийн найрлагыг тогтоосон. Чулууллагийн гадаргуу нь төмрийн ислийн нөлөөгөөр улаан, тод ягаан улбар шар өнгөнд хувирсан ба чулууллагийн үндсэн өнгөний гадаргад мөн төмрийн найрлага илэрцтэй байгаа нь цаашид гадаргуун өнгө хувирах эрсдэлтэй байна. Цагаан өнгөний хувьд хөрсний эрдэсийн найрлага кальцийн агууламж ихээр илэрсэн.




Зураг:4 HORIBO XGT,XRF




Зураг:5 Чулууллагийн дээж

*Дундговь аймгийн Өлзийт сумын Дэл уулын 32 хүнт дурсгал орчмын ижил төрлийн чулууны гадарга дээрх улаан өнгө бүхий хэсэг: Хүснэгт 1*




Live time : 100 s Processing Time : P3  
 XGT Dia. : 100 μm X-ray tube vol. : 50 kV  
 Current : 1.000 mA  
 X-ray Filter : Nonexistence Cell : Nonexistence  
 Quant. Corr. : Standard-less  
 Elem. Line Mass 2sigma Atomic Intensity



	[%]	[%]	[%]	[cps/mA]
13 Al K	6.55	0.44	8.69	15.15
14 Si K	47.63	0.41	60.64	247.56
19 K K	4.65	0.11	4.26	90.08
22 Ti K	0.53	0.03	0.40	27.34
26 Fe K	40.63	0.33	26.02	4237.19
51 Sb K	0.00	0.09	0.00	0.03



*Дундговь аймгийн Өлзийт сумын Дэл уулын 32 хүнт дурсгал орчмын ижил төрлийн чулууны гадарга дээрх тод ягаан өнгө бүхий хэсэг: Хүснэгт 2*




Live time : 100 s Processing Time : P3  
 XGT Dia. : 100  $\mu\text{m}$  X-ray tube vol. : 50 kV  
 Current : 1.000 mA  
 X-ray Filter : Nonexistence Cell : Nonexistence  
 Quant. Corr. : Standard-less  
 Elem. Line Mass 2sigma Atomic Intensity

	[%]	[%]	[%]	[cps/mA]
13 Al K	7.03	0.44	9.18	15.96
14 Si K	49.60	0.41	62.23	248.88
19 K K	4.44	0.11	4.00	80.41
22 Ti K	0.65	0.03	0.47	31.14
25 Mn K	0.13	0.02	0.08	11.29
26 Fe K	37.84	0.32	23.88	3790.96
30 Zn K	0.11	0.02	0.06	9.95
37 Rb K	0.08	0.01	0.03	8.35
40 Zr K	0.11	0.01	0.04	13.77
51 Sb K	0.00	0.09	0.00	0.02



*Дундговь аймгийн Өлзийт сумын Дэл уулын 32 хүнт дурсгал орчмын ижил төрлийн чулууны гадарга дээрх улбар шар өнгө бүхий хэсэг: Хүснэгт 3*




Live time : 100 s    Processing Time : P3  
 XGT Dia. : 100  $\mu\text{m}$     X-ray tube vol. : 50 kV  
 Current : 1.000 mA  
 X-ray Filter : Nonexistence    Cell : Nonexistence  
 Quant. Corr. : Standard-less  
 Elem. Line    Mass    2sigma    Atomic Intensity



	[%]	[%]	[%]	[cps/mA]
13 Al K	14.26	0.54	16.81	31.68
14 Si K	55.19	0.51	62.52	217.66
15 P K	0.70	0.17	0.72	2.97
19 K K	8.22	0.18	6.69	100.82
20 Ca K	3.54	0.11	2.81	56.57
22 Ti K	1.38	0.06	0.92	38.78
24 Cr K	0.09	0.02	0.05	4.22
25 Mn K	0.19	0.02	0.11	10.87
26 Fe K	16.43	0.19	9.36	1172.30

*Дундговь аймгийн Өлзийт сумын Дэл уулын 32 хүнт дурсгал орчмын ижил төрлийн чулууны гадарга дээрх цагаан өнгөө бүхий хэсэг: Хүснэгт 4*




Live time : 100 s Processing Time : P3  
 XGT Dia. : 100  $\mu\text{m}$  X-ray tube vol. : 50 kV  
 Current : 1.000 mA  
 X-ray Filter : Nonexistence Cell: Nonexistence  
 Quant. Corr. : Standard-less  
 Elem. Line Mass 2sigma Atomic Intensity



	[%]	[%]	[%]	[cps/mA]
13 Al K	3.31	0.44	4.62	5.97
14 Si K	19.75	0.38	26.48	87.19
16 S K	1.36	0.07	1.60	22.43
19 K K	4.72	0.10	4.54	85.29
20 Ca K	55.94	0.41	52.56	1064.01
22 Ti K	1.24	0.08	0.97	18.79
25 Mn K	0.18	0.03	0.13	6.09
26 Fe K	13.49	0.14	9.10	566.43

*Дундговь аймгийн Өлзийт сумын Дэл уулын 32 хүнт дурсгал орчмын ижил төрлийн чулууны өөрийн нь саарал гадаргын хэсэг: Хүснэгт 5*




Live time : 100 s Processing Time : P3  
 XGT Dia. : 100  $\mu\text{m}$  X-ray tube vol. : 50 kV  
 Current : 1.000 mA  
 X-ray Filter : Nonexistence Cell : Nonexistence  
 Quant. Corr. : Standard-less




Elem.	Line	Mass [%]	2sigma [%]	Atomic Intensity [cps/mA]
13	Al K	12.71	0.45	14.32
14	Si K	66.30	0.44	71.71
19	K K	10.48	0.19	8.14
22	Ti K	1.41	0.05	0.89
23	V K	0.00	0.02	0.00
25	Mn K	0.18	0.02	0.10
26	Fe K	8.86	0.10	4.82
37	b K	0.06	0.01	0.02

Чулуулагийн найрлагыг XRD багажит дүн шинжилгээгээр эрдсийн түвшинд тодорхойлсон. Хүснэгт 6:

UU3.dat (зос чулуу)





UU3.dat (зос чулуу)

Mineral name	Formula	Quant, (wt. %)
Quartz	SiO <sub>2</sub>	34,0
Albite	Na[AlSi <sub>3</sub> O <sub>8</sub> ]	21,4
Goethite	FeO(OH)	3,9
Anorthite	CaAl <sub>2</sub> Si <sub>2</sub> O <sub>8</sub>	3,2
Chlorite (clay)	[Mg <sub>1.3</sub> Fe <sup>2+</sup> <sub>3.4</sub> Al <sub>1.3</sub> ][Si <sub>2.7</sub> Al <sub>1.3</sub> O <sub>10</sub> (OH) <sub>8</sub> ]	7,1
Dickite (clay)	Al <sub>2</sub> [Si <sub>2</sub> O <sub>5</sub> ](OH) <sub>4</sub>	2,3
Calcite	CaCO <sub>3</sub>	2,4
Orthoclase	[Ba <sub>0.4</sub> K <sub>0.47</sub> Na <sub>0.13</sub> ][Si <sub>2.59</sub> Al <sub>1.41</sub> O <sub>8</sub> ]	1,7
Illite (clay)	K <sub>0.78</sub> (Al,Mg) <sub>2</sub> [(Si,Al) <sub>4</sub> O <sub>10</sub> ](OH) <sub>2</sub>	2,0
Feldspar	TiAlSi <sub>3</sub> O <sub>8</sub>	3,3
Perovskite	BaTiO <sub>3</sub>	4,5
Anorthoclase	(Na,K)[AlSi <sub>3</sub> O <sub>8</sub> ]	3,2
Cristobalite	SiO <sub>2</sub>	3,5
Hematite	Fe <sub>2</sub> O <sub>3</sub>	6,7



## Гэмтэл үүсгэж буй шалтгаан

Механик гэмтлээс гадна шувууний сангаснаас үүсэх аммиакийн хий  $\text{NH}_3$  гэх мэт химийн болон чулуун гадарга дээр ургасан хаг бүхий биологийн гэмтлээс урьдчилан сэргийлэх шаардлагатай. Ил дурсгал учираас гол анхаарах зүйл нь хөрсөнд агуулагдах давс юм. Давсны ууршилт буюу давсжилт нь хамгийн гол муудах хүчин зүйл болдог. Чулуу нь хөрсний усанд агуулагдах давсыг уусгаж авдаг ( $\text{CaCO}_3$ ,  $\text{CaSO}_4$ ,  $\text{NaCl}$ ,  $\text{Na}_2\text{SO}_4$  гэх мэт). Хөрсөн дахь давсны усан уусмал нь чулуунд нэвчин орж халуунд усаа ууршуулснаар чулуулгийн давсны агууламж ихэсдэг. Үүний үр дүнд чулууны хөндийд давсны талстууд үүсч чулуун хөндийн дотоод хананд гадагш чиглэлтэй аажим аажмаар нэмэгдэж чулуулгийн гадаргууг гэмтээж цаашлаад чулуулгийн бүтцийг гэмтээж хагалбар үүсгэж бутлах хүчин зүйл нь болдог. Давсны талстжилт нь хөрсний уснаас шууд хамааралтай байдаг. Өөр нэг чухал хүчин зүйл нь чулуунд ус хөлдсөнөөс болж усны эзэлхүүн тэлж мөсөн талстууд чулуулгийн эзэлхүүнийг гэмтээх юм. Мөн агаарын бохирдол ялангуяа хүхрийн исэл (SO) нь чулуулгийн бүрэлдэхүүнд байдаг кальцийн карбонаттай ( $\text{CaCO}_3$ ) урвалд орж гадаргууг харлуулж гэмтээх эрсдэлтэй байдаг.

Ил дурсгалын хувьд хамгийн ихээр эрсдэл учруулж буй нөхцөл нь цаг агаар, салхи, хуурай элс шорооны нөлөөгөөр чулуулгын цууралт хэсгүүд дүүрч тэлснээр хагарал нэмэгдэж шороогоор дүүрч тэр хэсгүүдэд өвс ногоо, хаг ургах, хорхой шавьж үүрлэх зэрэг механик биологийн гэмтлүүд явагдсаар байна.



Зураг:6 Чулууллагийн цууралт болон сангасны бохирдол

### Цаг агаарын нөлөө

Дундговь аймгийн Өлзийт сумын өмнөд хэсэг нь физик газар зүйн бүслэлтээрээ говийн их мужид хамаардаг учираас уур амьсгалын хувьд дулаан, чийг багатай, тал бүрээсээ уул нуруудаар хүрээлэгдсэн учир чийглэг агаарын урсгал хомс тул хур тунадас багатай байдаг. Эх газрын эрс тэрс уур амьсгалтай, чулуулгийн хүчиллэг,

шүлтлэг найрлага идэвхтэй тектоник хөдөдлгөөний бүсд багтдаг. Судалгаа хийж байх явцад 9-р сарын сүүл гэхэд харьцангуй дулаан, чийгшил багатай, хуурай шороон салхи ихтэй байсан. (хэмжилт хийсэн багажны загвар TR72-Wf)



Зураг:7 Орчны чийгшил



Зураг:8 Орчны дулаан

(Өдөр 2 цагын байдлаар)

Салхиар туугдсан гадаргуун хөрс шороо, халуун хуурай цаг агаар болон бороо цастай үеийн чийглэг нөхцөлөөс шалтгаалах чулууллагийн өгөршил гэмтлийн эрсдэл явагдсаар байна.



Зураг:9 Чулууллагийн өгөршил

### Хөрсний шинж чанар

Цөлийн буюу цөлжүү хээрийн бүсэд оршдог учираас цөлөрхөг хээрийн цайвар бор хөрс зонхилсон байдаг. Алаг цоог элсэн хучаастай, сийрэг ургамал бүрхэцтэй, жижиг хэмхдэс чулуулаг, хэсэгчилсэн газруудаар хужирын дайртсан өнгөртөй, дэрс бударгана голлон ургасан хөндий ихтэй. Энэ төрлийн хөрсний онцлог шинж нь хөрс үүсэлтийн хуурай үйл явцын хөгжилтөй, давс үүсэлтийн орчин цагийн хуримтлал бараг байхгүй, хөрсний гадаргад дайрга ба чулуун хучилга үүссэн, шим тэжээлийн найрлага гэгдэх хумусын агууламж бага, хөрсний найрлаганд уусах давс бараг байхгүй, давсжилт карбонатжилт нь голдуу үлдмэл шинжтэй. Хөрс салхиар хийсэх, сайраар гүйх усаар урагдах үйл явц ихтэй, профиль буюу хөрсний зүсэлт нимгэн шинж чанар бүхий онцлогтой байдаг.



*Зураг:10 Хөрсний байдал*

Эрдэсийн өгөршлийн явцад чөлөөлөгдсөн хлор суурийн ба газрын шүлтийн катионуудтай нэгдэж хялбар уусах давсуудыг үүсгэдэг. Саармаг орчинтой хөрсөнд хлор нэн бага, харин хүчиллэг, ялангуяа төмрийн исэл арвингайд сайн шингэдэг шинж чанартай байдаг. Тиймээс хөрсний нүүдлээс үүсэх чулууны элэгдэл, цууралтыг дүүргэж буй хөрс шорооноос үүдэлтэй тэлэлт, түүн дээр ургасан бударгана гэх мэт өвс ургамлын нөлөөгөөр чулууллагийн өгөршил гэмтэл мөн адил явагдсаар байна.

#### **Биологийн гэмтэл**

Ил дурсгалын цуурал болоод хүрээлэн буй орчны чулуулагт үүссэн цуурал гэмтлийн орон зай нь хөрс шороогоор дүүрхээс гадна хаг ургаж, хорхой шавьж үүрлэж байгаа эрсдэл байна. Шавьж нь элдэв ургамлын үндэс, иш, навч, цэцгийг идэж ихээхэн гэмтэл учруулж ургацыг доройтуулан цөлжилт үүсгэж, дурсгалын эргэн тойрондох шороог суллаж сийрэгжүүлж байна. Шавьжнаас үүдэлтэй механик гэмтэл органик хүчлийн нөлөө урт хугацааны туршид чулууллагийн гэмтэлт нөлөө үзүүлэхүйц байна.



*Зураг:11 Чулууллагт үүрэлсэн шавьж*

Өөр нэг томоохон биологийн хүчин зүйл нь хаг ургалт юм. Дэлхий дээрх хагийн хөгжлийн түүхэн хувьлсын үр дүнд үүссэн хэлбэр төрх, өнгийн хувьд олон янз 24000 зүйл тэмдэглэгдсэн байдаг. Хагны зарим нэг нь 1мм ч хүрэхгүй байхад нөгөө хэсэг нь хэдэн метр болон сунаж ургах чадвартай байдаг.



*Зураг:12 Хаг ургасан байдал*

Хагийн морфологи шинж буюу гадаад бүтэц төрх байдал нь наалдмал, илтэслэг ба навчлаг, бутлаг гэсэн гэсэн амьдарлын 3 үндсэн хэлбэр шинжтэй байдаг. Хаг нь үржил шимгүй янз бүрийн боржин болон шохойлог гэх мэт уулын чулуулаг дээр болон ургамал ургах тохиромжгүй, шим тэжээлийн тэжээлийн бодисоор хомс элсэрхэг юмуу хөвдөрхөг, эсвэл хайрга чулуутай хөрсөнд тохиолддог. Ил дурсгалын хувьд өгөршиж цуурсан хэсгүүд болон эргэн тойрны чулууллагийн цуурч ангайсан хэсгүүдэд хаг ургаж улмаар чулуулгийн хатуулаг болон цууралтад нөлөөлж хагны төрлөөсөө хамаарч хувирмал чулуулаг ялангуяа шохойн чулууллагийн эпилит хайрст, наалдмал хаг боргол хадандай, талын наалдаахай зэрэг нь чулууллагийн дотор 20 мм орчим гүн шигдэж тухайн чулууллагийг уусгах бодисыг ялгаруулж уулын чулууллагийн биологийн өгөршлийн процессыг нэг талаар түргэсгэх эрсдэл үзүүлсээр байна.

Дурсгалын чулуулагт болон эргэн тойрны чулуулагт ургасан хагны төрөлд:



*Зураг:13 Илтэслэг хаг*



*Зураг:14 Заагдал биет наалдмал хаг*



*Зураг:15 Салбант биет наалдмал хаг*



*Зураг:16 Дугуй апотеци*



*Зураг:17 Хоёрч хэлбэрт бие*



*Зураг:18 Талмайт биет наалдмал хаг*



*Зураг:19 Хайрслаг хаг*



*Зураг:20 Дугуй апотеци*

### **Дүгнэлт**

Дэл уулын үл хөдлөх дурсгалын хувьд байгалын хүчин зүйлээс хамаарах чулууллагт муугаар нөлөөлөх эрсдэлтэй орчны нөлөөнд байна. Механик болон химийн гэмтлээс хамаарах өгөршил, гадаргуу хэсэгт хагарал явагдаж, биологийн гэмтэл зэрэг орчноос хамаарах бүхийл хүчин зүйлийн нөлөөлөлд уг дурсгал нь муудаж удаан хугацааны өгөршил явагдсаар байна. Цаашид чулууллагийн материалын судалгааг хүрээлэн буй орчны судалгаатай хослуулж механик болон хими, биологийн гэмтлийг тодорхойлж хадгалалт хамгаалалт, сэргээн засварлах арга зүйг дурсгалын онцлогт тааруулж нутагшуулах судалгааг хийх шаардлагатай байна. Манай орны үл хөдлөх дурсгалын хувьд хадгалалт хамгаалалтын судалгаа болон эрсдэлийг тодорхойлох бие даасан нарийвчилсан судалгааны арга зүй боловсруулж судалгаа хийсэн жишиг одоогоор байхгүй байна. Тиймээс энэхүү судалгаагаар үл хөдлөх дурсгалд муугаар нөлөөлж буй орчны судалгааг олон талаас нь хийж, дурсгалын онцлог шинж болон хүрээлэн буй орчны судалгааг нарийвчлан хийж, ажиглалт хийсний дүнд хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалт хийх арга зүй боловсруулах ажлыг эхлүүлээд байна.

ТАЙЛАН БИЧСЭН:

Д.НЯМДОРЖ. СОЁЛЫН БИЕТ ӨВИЙГ СЭРГЭЭН  
ЗАСВАРЛАХ ГАЗРЫН ДАРГА

М.ОЮУНТУЛГА PH.D. СОЁЛЫН БИЕТ ӨВИЙГ  
СЭРГЭЭН ЗАСВАРЛАХ ГАЗРЫН  
ЕРӨНХИЙ ТЕХНОЛОГИЧ

## **ДУНДГОВЬ АЙМГИЙН ДЭДГЭРХАНГАЙ УУЛЫН БАРУУН ЭЛГЭНИЙ ХЯТАД БИЧЭЭС**

Чингис хаан дээд сургууль Өвөрмонгол их сургуулийн багш нартай хамтарч түүхэн бичээс илрүүлсэн билээ. Эртний ханз үсэг судлалаар Хятадад нэрд гарсан судлаачдыг урьж хамтран Ононгийн сав Дэлгэрхангай сумын орчимд археологийн судалгаа хийж, чулуун зэвсгийн үе, 40 мянган жилийн өмнөх бууцыг олж илрүүллээ. Энэ бичээс эртний түүхэн үйл явдлыг бичсэн бичээс байна. Энэ бичээсэнд Өмнөд Хүннү, Умард Хүннү байлдсан тухай, хэрхэн байлдсан тухай, мөн хэн удирдсан хэдий хэмжээний хор хохирол гарсан талаар бичсэн байна. Энэ бичээсний ач холбогдол нь юунд байна гэвэл эвтэй байгаагүйгээсээ болж хоорондоо эвдрэлцэж, нэг орон, нэг үндэстэн хоорондоо дайтаж, нэгнийгээ хороож байсныг бодитойгоор тэмдэглэсэнээрээ онцлогтой.

Монгол орны нутгаас Хүн гүрний үеийн томоохон бичээс анх удаа олдлоо. Энэ бичээсийг эртний Зүүн хань улсын бичгээр бичсэн байна. Бидний өвөг дээдсийн анхны байгуулсан төрт улс бол Хүннү. Энэ улс маань хоорондоо эвдрэлцэж Умард Хүннү, Өмнөд Хүннү гэж салсан. Өнөөгийн байдлаар Хүннүгийн судалгааны талаар зуун жилийн хугацаанд 1000 гаруй ном бичигдсэн байдаг. Гэвч зөвхөн түүхийн хувьд гол үйл явдлуудыг л дурдсан байдаг ба зарим талаар он тооллын хувьд зөрдөг. Түүхэн ховор бичээсийг олсноор Хүннү судлалд том нэмэр оруулсан хэмээн судлаачид үздэг. Тус бичээс нь Монгол нутгаас олдсон бичгийн томохон дурсгал юм.

### Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын нутагт орших Баруун элгэний бичээсээс хэв авсан ажил

Соёлын өвийн үндэсний төвийн (СӨҮТ) Соёлын биет өвийг сэргээн засварлах газрын (СБӨСЗГ) 2019 оны Үр дүнгийн гэрээний 3.4, “Чулуун соёлын өв” хөтөлбөрийн ажлын хүрээнд тусгагдсаны дагуу

1. Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын нутагт орших Баруун элгэний бичээс
2. Дундговь аймгийн Өлзийт сумын нутагт орших Дэл ууланд орших дөрвөлжин булшны хавтан чулуун дээрх 32 хүнт гэгдэх хадны зургаас хэв авахаар

СӨҮТ-ийн СБӨСЗГ газрын ерөнхий сэргээн засварлагч Д. Нямдорж, сэргээн засварлагч А. Мөнгөнцоож, Э. Батжаргал, Т. Сүхбаатар, Соёлын өвийн бүртгэл судалгааны газрын мэргэжилтэн Г. Бүрэнтөгс нарын бүрэлдэхүүнтэй баг 2019 оны 5-р сарын 27-оос 6-р сарын 5-ны өдрийг хүртэл 10 хоног томилогдон тус дурсгалт газрууд дээр ажилласан болно.

Уг бичээс нь сумын төвөөс баруун урагш 30 орчим км зайд байрлах бичгийн дурсгал юм. Баруун илгэний өмнө зүг хандсан өндөрлөгийн 7.6 м орчим өндөр хадны элгэнд газраас дээш 3.4 м өндөрт сийлэгдсэн бөгөөд хадны гадаргууг 1.3 м өргөн, 1 м өндөр талбайтайгаар бүхэлд нь тусгайлан засаж тэгшлээд уг бичээсийг 1-2 мм орчим гүн сийлжээ. Ханзны нүдэлсэн хэмжээ 4x4см, мөр хоорондын зай 2.5-3 см, мөрийн өндөр ойролцоогоор 90 см, ханзны хоорондох зай 3.5-4.5 см байна. Нэг мөрийн дүүргэлт 14

ханз үсэгтэй. Тодруулбал, мөнхүү тооны ханзыг нэг мөрөөр тооцож сийлсэн бололтой. Он цагийн уртад нар салхи, бороо, цасны усанд идэгдсэнээс бичээсний зүүн дээд хэсгийн зарим ханз бүдгэрсэн байна.



Томилолтын баг 2019 оны 5-р сарын 28-ны өдөр дурсгалт газар хүрч очиж хэв авах ажлын бэлтгэл ажил болох тавцант шат засах, дурсгалд анхан шатны цэвэрлэгээ хийх зэргээр ажлаа эхлүүлэв.



Уг дурсгалыг боржин хаданд сийлсэн гэсэн мэдээлэл анх байсан. Гэвч газар дээр очиж ажиллахад боржин биш ... хад болох нь тодорхой болсон ба хадгалалтын байдлын хувьд уг ханз бичээс нь зарим газраа элэгдэж бүдгэрсэн байх ба хадны нягт байдлаас хамааран харьцангуй сайн, тогтвортой байдалд байна гэсэн дүгнэлтэд хүрсэн.



Бичээс байрлах хад нь байгалаасаа нааш духайж, тонгойсон маягийн хэлбэртэй тул шувууны сангас гэх мэт органик гаралтай бохирдол тогтох боломжгүй тул гадарга харьцангуй цэвэрхэн байсан бөгөөд цэвэр усаар зөөлөн шүршиж багс, щёткаар зөөлөн үрж угааж цэвэрлэн сайтар хатааж силикон хэвний тусгаарлагчийг 2 үе давхарлан түрхэж хатаав.

Зөөлөн хэв буюу силикон резинийг 2 үе давхарлан түрхсэн ба үүний дараа хэвийг урагдаж ханзрах хэвээ алдаж сунахаас сэргийлэн даавуун тор буюу марло нааж дахин 1 үе силикон резин түрхэж хатуу хэв зөрхөөс сэргийлэн мөн резинэн түгжээнүүдийг нааж хатаав. Хатуу хэвийг полистер материалыг барилгын замасктай хольж өтгөрүүлэн нийлэг даавуу тороор бэхжүүлэн хийж уг байрлалд нь сайтар хатааж бэхжүүлэв.







Хатуу болон зөөлөн хэв сайтар хатаж бэхжсэний дараа буюу дараагийн өдөр хэвнүүдийг салгаж авсан. Зөөлөн болон хатуу хэв авах ажлын үед салхины хурд маш их байсан ба энэ нь ажлыг хийж гүйцэтгэх болон орчныг цэвэр байлгахад нилээд хүндрэл учруулсан ба хэвийг салгаж авсаны дараа орчин тойрныг цэвэрлэх ажлыг хийсэн.



Хэв авах ажлын дараа Баруун элгэний бичээс дурсгалын фотограмметрийг хийх ажлыг хийсэн. Уг ажлыг хийж гүйцэтгэхдээ Canon 6D фото аппарат болон 50мм-ийн дуранг ашигласан.

Эдгээр дурсгалын баримтжуулалтаас цаашдын судалгаанд ашиглах 241 JPEG файл, 2 GB цахим файл үүсгэн УНБМСангын журмын дагуу дугаарлан архивлан хадгалав.

## **СҮХБААТАР АЙМГИЙН ЭРДЭНЭЦАГААН СУМЫН НУТАГТ ОРШИХ ЖАРГАЛАНТЫН ШИРЭЭНИЙ ХАДНЫ ЗУРГААС ДАРДАС, ХЭВ АВСАН АЖИЛ**

Соёлын өвийн үндэсний төвөөс тус ажлыг хийж гүйцэтгэхээр СӨҮТ-ийн СБӨСЗГазрын ерөнхий сэргээн засварлагч Д. Нямдорж, сэргээн засварлагч А. Мөнгөнцоож, Т. Сүхбаатар, Авран хамгаалах газрын дарга Г. Анхсанаа нарын бүрэлдэхүүнтэй баг 2019 оны 6-р сарын 10-аас 17-ны өдрийг хүртэл 8 хоног томилогдон Сүхбаатар аймгийн музей болон тус дурсгалт газар дээр ажилласан болно.

Томилолтын баг аймгийн музейд ажилласны дараа орон нутагт орших дурсгалт газрыг зорьсон ба аймгийн музейгээс бүртгэл мэдээллийн ажилтан А. Болортунгалаг хамт явхаар төлөвлөж байсны дагуу багийн бүрэлдэхүүнд нэмэгдэж нэгдэн Эрдэнэцагаан сумын нутагт орших Жаргалантын ширээний хадны зураг байх газар очсон.



Дурсгалт газар очиж хадны зургуудыг үзэж танилцан хэв авах 2ш зургийг сонгож хэв авах ажлын бэлтгэлийг хангах ажлыг хийв.

Уг хадны зургууд нь галт уулын гаралтай чулуун дээр хонхойлгон сийлсэн байх ба зургийн зарим зах ирмэг хэсэгт чулуу хагарч унасан гэмтэлтэй, бохирдол харьцангуй бага байсан. Хадны зурагтай чулууг цэвэр ус болон багс, щёткоор угааж тоос шорооны бохирдлыг цэвэрлэсэн ба хатсаны дараа силикон хэвний тусгаарлагч гелийг 2 үе давхарлан түрхэж хатаав.



Зөөлөн хэв буюу силиконон хэвийг эхлээд 2 үе давхарлан түрхэж сэврээгээд марло нааж бөхлөн 3 дахь үеийг давхарлан түрхэж резинэн түгжээ нааж хатаав.

Үүний дараа полистер хатуу хэвийг хийсэн ингэхдээ полистерт 1 х 1 хэмжээтэй барилгын замаска хольж хатаагчийн хэмжээг 100гр тутамд 4гр байхаар хольж зууран зузаан даавуугаар бие болгон зөөлөн хэвний гадуур бүрхүүлэн 2 үе давхарлан хийж гүйцэтгэв.

Хатуу, зөөлөн хэвийг сайтар хатаж бэхжсэний дараа хэвийг салгаж аван дурсгалд түрхсэн тусгаарлах гелийг сайтар угааж, орчин тойрны хог хаягдлыг цэвэрлэн хэв авах ажлыг хийж гүйцэтгэв.





### **Үр дүн:**

Уг ажлын үр дүнд “Чулуун соёлын өв” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын нутагт орших Баруун элгэний бичээс, Өлзийт сумын нутагт орших Дэл уулын 32 хүнтийн дурсгалаас 1:1 хэмээжтэй 7 ширхэг хатуу болон зөөлөн хэв авч баримтжуулан, хуулбаруудыг тус тус хийж гүйцэтгэн улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд хадгалав.

Уг дурсгалуудаас хэв авсан нь түүх, соёлын дурсгалуудыг бодит байдлаар хуулбар хийн архивлан хадгалах, үзмэр болгон ашиглах бүрэн боломжтой болов.

Дурсгалаас авсан хэвнүүдэд хуулбарыг цутгах болон өнгө будгийн ажлыг Улаанбаатар хотод Соёлын өвийн үндэсний төвд СБӨСЗГазрын сэргээн засварлагчид хийж гүйцэтгэж 2019- 2020 оны заагт тайлан үзэсгэлэн гаргав.

Мөн онцлууштай нэг зүйл бол Дэл уулын дурсгалд хийсэн орчны судалгаа ба дурсгалын гэмтэж буй байдал, дурсгалд муугаар нөлөөлж буй хүчин зүйлийн судалгааны ажлыг эхлүүлснээр цаашид бусад дурсгалуудын энэ төрлийн судалгааг хийж харьцуулан өөрийн орны онцлогт суурилсан судалгааны ажил эхэлж байгаа нь урагшлах нэг томоохон алхам болж байна.

### 3.5. “Их хөшөөт” чулуун дурсгалын хадгалалт хамгаалалтын судалгааны ажил

- Хамтын судалгааны үр дүнд цаашид хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалтын ямар ажил хийхийг тодорхойлно.

#### Нэг. “Чулуун соёлын өвийн хадгалалт, хамгаалалт”

сургалтыг зохион явуулах удирдамж

##### 1. Зорилго

Соёлын өвийн үндэсний төвийн Соёлын биет өвийг сэргээн засварлах газрын сэргээн засварлагчид, Венийн Хэрэглээний урлагийн их сургуулийн Хадгалалт, хамгаалалтын хүрээлэнгийн чулуун дурсгалын сэргээн засварлагчидаас бүрдсэн баг Төв аймгийн Дэлгэрхаан сумын нутагт орших Их Хөшөөтийн цогцолбор дурсгалт газрыг түшиглэн чулуун дурсгалыг цэвэрлэх, бэхжүүлэх, хамгаалах, сэргээн засварлах ажлын сургалт, дадлага ажлыг зохион явуулах.

Сургалтын үндсэн зорилго нь хээр хөдөө, орон нутагт буй чулуун дурсгалын хадгалалт, хамгаалалтын ажлыг мэргэжил арга зүйгээр хангахад орших ба Австри улсын Венийн Хэрэглээний урлагийн их сургуулийн Хадгалалт, хамгаалалтын хүрээлэнгийн чулуун дурсгалын сэргээн засварлагчдын заавар, зөвлөгөөн дор явагдах бөгөөд тэдний чулуун дурсгалын хадгалалт, хамгаалалтын арга технологийг өөрийн орны нөхцөл, хөрсөнд буулгахад чиглэнэ.

Сургалтад Соёл, Урлагийн Их Сургуулийн Дүрслэх, дизайн урлагийн сургуулийн сэргээн засварлах ангийн оюутан оролцоно.

Сургалтыг дараах дарааллын дагуу зохион явуулна. Үүнд:

1. Дурсгалт газарт түшиглэсэн сургалт зохион явуулах орчныг бүрдүүлэх, бэлтгэл ажлыг хангах, кэмп байгуулах
2. Дурсгалт газар дээр ажиллах, сургалт явагдах техникийн зөвлөгөөнийг сургалтанд оролцогчидод хийх.
3. Сургалтыг хөтөлбөрийн дагуу зохион явуулах
  - 2018 оны дадлага ажлын үр дүнг танилцуулах
  - Онол, практик хосолсон дадлага ажил
  - Сонгосон чулуун дурсгалд хадгалалт хамгаалалт, сэргээн засварлах ажил хийх
  - Дадлага ажлыг дүгнэх, үр дүнг хэлэлцэх

##### 2.Хугацаа

2019оны 7 дугаар сарын 3 – 9ний хооронд.

##### 3. Сургалтын багийн бүрэлдэхүүн

###### Соёлын өвийн үндэсний төвөөс

1. Д. Нямдорж (Соёлын биет өвийг сэргээн засварлах газрын (СБӨСЗГ) ерөнхий сэргээн засварлагч)
2. А.Мөнгөнцоож (СБӨСЗГ газрын сэргээн засварлагч)

3. Ц.Цолмон (Соёлын өвийг авран хамгаалах газрын Дэлхийн өв хариуцсан мэргэжилтэн)
4. Г.Ууганчимэг (СБӨСЗГазрын сэргээн засварлагч)
5. С.Даваадарь (СБӨСЗГазрын сэргээн засварлагч)
6. Б. Лхамсүрэн (СБӨСЗГазрын сан хөмрөгч)
7. Г. Бүрэнтөгс (Соёлын өвийн бүртгэл судалгаан газрын түүх, соёлын үл хөдлөх дурсгал хариуцсан бүртгэл мэдээллийн санч)
8. Б. Амгаланбаатар (Соёлын өвийн бүртгэл судалгаан газрын түүх, соёлын үл хөдлөх дурсгал хариуцсан бүртгэл мэдээллийн санч)
9. С.Сайнзолбоо (Захиргаа удирдлагын газар, нярав)
10. Д. Чанагнянгар (Жолооч)

#### Венийн Хэрэглээний урлагийн их сургуулиас

11. Мария Милчин (Венийн Хэрэглээний урлагийн их сургуулийн Хадгалалт, хамгаалалтын хүрээлэнгийн чулуун дурсгалын ахлах сэргээн засварлагч)
12. Мартина Хаселбергер (Венийн Хэрэглээний урлагийн их сургуулийн Хадгалалт, хамгаалалтын хүрээлэнгийн чулуун дурсгалын ахлах сэргээн засварлагч)
13. Катарина Фух (Венийн Хэрэглээний урлагийн их сургуулийн Хадгалалт, хамгаалалтын хүрээлэнгийн ахлах сэргээн засварлагч, чулуу судлаач)

#### Соёл, Урлагийн Их Сургуулийн Дүрслэх, дизайн урлагийн сургуулиас

14. Т. Анударь (Сэргээн засварлах анги 3-р курсийн оюутан)

#### **4. Дурсгалт газрыг түшиглэн зохион байгуулах сургалтын маршрут**

Улаанбаатар хот -Төв аймгийн Дэлгэрхаан сумын Их Хөшөөтийн цогцолбор дурсгал-Улаанбаатар хот гэсэн дарааллаар ажиллана.

#### **5. Үр дүн:**

1. Их Хөшөөтийн цогцолбор дурсгалын хадгалалт, хамгаалалтын өнөөгийн нөхцөл байдлын судалгааг сургалтын явцад дахин хийнэ.
2. Их Хөшөөт болон бусад чулуун дурсгалыг хадгалах, хамгаалах, сэргээн засварлах ажлын онол болон практикийн мэдлэг туршлага солилцох, суралцах.

#### **Хоёр. Чулуун соёлын өвийн хадгалалт, хамгаалалт”**

Сургалтын хуваарь:

1 дэх өдөр: 2019 оны 7-р сарын 3, Лхагва гариг (Улаанбаатар)

Зааварлагч нар Улаанбаатар хотод ирэх.

2 дахь өдөр: 2019 оны 7-р сарын 4, Пүрэв гариг (Их-Хөшөөт)

08:30-09:00 Бэлтгэл ажил (материал, хэрэглэгдэхүүнийг шалгах), дурсгалт газар руу хөдлөх

13:00-14:30 Өдрийн хоол

14:30-16:30 2018 оны дадлага ажлын үр дүнг танилцуулах

- Чулуун материал болон дурсгалын нөхцөл байдалд хийсэн судалгааны тухай
- Авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тухай товч
- Дадлага ажлын үр дүнгийн талаарх хэлэлцүүлэг

3 дахь өдөр: 2019 оны 7-р сарын 5, Баасан гариг (Их-Хөшөөт)

07:30-08:30 Өглөөний цай

08:30-11:00 Онол, практик хосолсон дадлага ажил: Чулуун соёлын өвийн урьдчилан сэргийлэх хадгалалт, хамгаалалт, мониторинг болон засвар

- Жишиг туршлагууд
- Их Хөшөөтийн дурсгалын мониторинг болон засвар, – 2018 оны хадгалалт, хамгаалалтын үйл ажиллагаанд хийсэн үнэлгээ

11:00-11:30 Цайны завсарлага

11:30-13:00 Үргэлжлэл

13:00-14:30 Өдрийн хоол

14:30-16:00 Онол, практик хосолсон дадлага ажил: Дурсгалд эвдрэл гэмтэл учруулахгүйгээр судалгаа хийх

- Нөхцөл байдлыг үнэлэх, элэгдэл, гэмтлийн хэмжээг тодорхойлох
- Чулуун дурсгалын гадаргад үнэлэлт, дүгнэлт хийх (усны нэвчилт, чулуулгийн элэгдэл, г.м)
- Чулуун дурсгалын гүн дэх элэгдэл, гэмтлийг гадаргаас хэт авиагаар шинжлэх (хэт авиа)

16:00-16:30 Цайны завсарлага

16:30-18:00 Үргэлжлэл

4 дэхь өдөр: 2019 оны 7-р сарын 6, Бямба гариг (Их-Хөшөөт)

07:30-08:30 Өглөөний цай

08:30-11:00 Онол, практик хосолсон дадлага ажил: Чулуун соёлын өвийн хадгалалт, хамгаалалтын үндсэн арга ажиллагаа

- Цэвэрлэгээ (давтан шалгах болон цэвэрлэх)
- Бэхжүүлэх
- Цавуу болон шаантагын аргаар засварлах (давтан шалгах болон цэвэрлэх)

11:00-11:30 Цайны завсарлага

11:30-13:00 Үргэлжлэл

13:00-14:30 Өдрийн хоол  
14:30-16:00 Дадлага ажил  
- Сонгосон чулуун дурсгалд хадгалалт, хамгаалалтын ажиллагааг хийх  
16:00-16:30 Цайны завсарлага  
16:30-18:00 Үргэлжлэл  
5 дахь өдөр: 2019 оны 7-р сарын 7, Баасан гариг (Их-Хөшөөт)  
07:30-08:30 Өглөөний цай  
08:30-11:00 Дадлага ажил  
- Сонгосон чулуун дурсгалд хадгалалт, хамгаалалтын ажиллагааг хийх  
11:00-11:30 Цайны завсарлага  
11:30-13:00 Үргэлжлэл  
13:00-14:30 Өдрийн хоол  
14:30-16:00 Үргэлжлэл  
16:00-16:30 Цайны завсарлага  
16:30-18:00 Үргэлжлэл  
6 дахь өдөр: 2019 оны 7-р сарын 8, Даваа гариг (Их-Хөшөөт)  
07:30-08:30 Өглөөний цай  
08:30-10:00 Дадлага ажлыг дүгнэх, үр дүнг хэлэлцэх Асуулт & Хариулт  
10:00-15:30 Улаанбаатар хот руу буцах  
7 дахь өдөр: 2019 оны 7-р сарын 9, Мягмар гариг (Их-Хөшөөт)  
10:00-11:00 Соёлын өвийн үндэсний төвийн захирал Г.Энхбаттай уулзаж, дадлага ажлыг дүгнэх, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар зөвлөлдөх

**Гурав. Чулуун соёлын өвийн хадгалалт, хамгаалалт”**  
сургалтын товч тайлан

Соёлын өвийн үндэсний төв, Австри улсын Венийн хэрэглээний их сургууль, Соёл урлагийн их сургуулийн хамтарсан “Чулуун дурсгалын хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалт” сэдэвт сургалт 2019 оны 7 дугаар сарын 3-аас 10-ны өдрүүдэд Төв аймгийн Дэлгэрхаан сумын нутагт орших Кульчурын дурсгалт газрыг түшиглэн 3 дахь жилдээ амжилттай зохион байгуулагдлаа.



Тус сургалтад Австри улсын Венийн хэрэглээний их сургуулиас чулууны хадгалалт, хамгаалалтын мэргэжилтэн Мария Милчин, Мартина Хаселбергер, Катарина Пухх нар хүрэлцэн ирсэн бол Соёлын өвийн үндэсний төвийн Соёлын биет өвийг сэргээн засварлах газраас ерөнхий сэргээн засварлагч Д. Нямдорж, сэргээн засварлагч А. Мөнгөнцөөж, С. Даваадарь сан хөмрөгч Б. Лхамсүрэн, Соёлын өвийг авран хамгаалах газрын дэлхийн өв хариуцсан мэргэжилтэн Ц.Цолмон Бүртгэл мэдээллийн газрын бүртгэл мэдээллийн санч Г. Бүрэнтөгс нярав С. Сайнзолбоо, жолооч Чанагнаггар, Соёл урлагийн их сургуулийн Дүрслэх урлаг дизайны сургуулийн Сэргээн засварлах ангийн 3-р курсийн оюутан Т. Анударь нар оролцов.



Сургалтыг дурсгалт газар зохион байгуулах ажлын бэлтгэлийг хангахаар 2019 оны 7 дугаар сарын 3-ны өдөр эхний баг Улаанбаатар хотоос дурсгалт газар очин 2 ширхэг Монгол гэр барьж орчны тохижилтын ажлыг хийж сургалт явуулах гэр кампыг бэлдэв.




2019 оны 7 дугаар сарын 4-ний өдрөөс эхлэн Австрийн Венийн хэрэглээний их сургуулийн мэргэжилтнүүд дурсгалт газар хүрэлцэн ирж өмнөх жилүүдэд хийгдсэн ажлын нөхцөл байдалтай танилцаж сургалтыг эхлүүлэв.

Сургалтын төлөвлөгөөнд өмнө жилүүдэд хийгдсэн ажлыг дүгнэх эргэн сануулах, шинээр оролцож буй оролцогчдод танилцуулах лекцийг Мартина Хаселбергэр эхлүүлэн дүгнэлт хийсэн ба үргэлжлүүлэн лекц болон практик ажил хослуулан сургалтын хөтөлбөрийн дагуу явагдав. Энэ удаагийн сургалтын онцлог нь лекц болон практик үйл ажиллагааг дурсгалт газар дээр нь хослуулан явуулсан нь оролцогчдод илүү ойр дөт байсан.

Австри улсын Венийн хэрэглээний их сургуулиас чулууны хадгалалт, хамгаалалтын мэргэжилтэн Катарина Фухкс Non destructive field test буюу дурсгалд гэмтэл учруулалгүй дурсгал дээр судалгаа хийх аргыг танилцуулж зарим судалгааны тоног төхөөрөмжийг хэрэглэн дурсгалууд дээр хэмжилт хийв.



Мөн сургуулийн чулууны хадгалалт хамгаалалтын мэргэжилтэн Мария Милчин чулууны гэмтэл бохирдол, хадгалалт хамгаалалт, хүрээлэн буй орчны нөлөө, судалгааны энгийн арга зүйн талаар танилцуулах лекц хичээл орж, улмаар оролцогчдыг 2 багт хуваарилан Их хөшөөтийн дурсгалууд дээр хэмжилт хийв. Мөн өнгөрсөн жил Цогтын хадны бичээсээс авсан дээжийн судалгааны үр дүнг танилцуулав



Сургалтын нэг хэсэг нь хадгалалт хамгаалалтын тодорхой ажлыг хийх байсан ба үүний хүрээнд тус дурсгалт газар орших тогос шувууны дүрслэл бүхий хагарсан хавтан чулууг эвлүүлэх, цаашид сэргээн засварлалт хийх зорилго байсан.

Хавтан чулууны хагарч тарж бутарсан хэсгүүдийг өнгөрсөн жилийн сургалтын үеэр нилээд цуглуулсан байсан ба энэ жил мөн дахин эргэн тойронд хайгуул хийж жижиг хэсгүүдийг олж илрүүлэн олдсон хэсгүүдийг эвлүүлж үзэв. Хавтан чулууны тоймтой 20 гаруй деталл хэсгүүдийг нийлүүлж эвлүүлж чадсан ба энэ нь ойролцоогоор уг хавтан чулууны 60 орчим хувь болж байгаа юм. Эдгээр эвлүүлсэн хэсгүүд нь зарим хэсгээрээ шууд холбогдож байсан бол зарим хэсгээрээ шууд холбогдох боломжгүй байсан, хэмжээний хувьд нилээд том болох нь тогтоогдсон.

Сургалтын дараа Австри талын төлөөлөгчид Соёлын өвийн үндэсний төвийн захирал Г. Энхбаттай уулзсан ба тус уулзалтын үеэр хоёр байгууллагын цаашдын хамтын ажиллагааг сунгах санамж бичигт гарын үсэг зурав. Мөн цаашид энэ төрлийн сургалт хамтын ажиллагааг өргөжүүлэх боломжийн талаар санал солилцов.



-----oOo-----

### ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ СУДАЛГАА

#### Орхон аймгийн музейн орчин дахь соёлын биет өвд муугаар нөлөөлөх хорт хийн бохирдлийн судалгааны тайлан

##### 1. Өмнөтгөл

Дэлхий нийтийн соёлын түүхэн хөгжлийг илтгэх чулуун зэвсэг, хадны зургаас эхлээд дэлхийг байлдан дагуулсан хүчирхэг гүрнүүдийн соёл гэх мэт маш олон тооны үндэстэн угсаатны биет болоод биет бус соёлын өв, дурсгалууд маш ихээр хадгалагдан үлдсэн байдаг. Эдгээрийг төрх байдлаар нь хадгалан хамгаалж хойч үедээ уламжлуулах нь бидний үүрэг бөгөөд ингэхийн тулд олон асуудалтай дэлхий нийтээрээ тулгараад байгаа билээ.

Хадгалалт хамгаалалтын олон асуудлын нэгээхэн гол анхаарах зүйтэй судалгааны хэсэг бол соёлын биет дурсгал хүрээлэн буй орчны нөлөөллөөс муудаж буй үр дагаварыг судлан тогтоох ажил болоод байна.

Энэ төрлийн судалгааг японы эрдэмтэн судлаач нар хийж эхэлсэн бөгөөд агаарын бохирдол болоод хүрээлэн буй агаарт байх органик хүчиллэг зэргийн төрөлжүүлсэн судалгаа хийж, тэдгээр нь дурсгалд хэрхэн муу нөлөө үзүүлж буйг шинжлэн тодорхойлох ажилбар юм.

Сүүлийн үед энэ талын судалгааг ялангуяа түүхэн дурсгал хадгалагдаж буй музейн салбарт маш ихээр анхааран хийх болсон. Энэхүү судалгаа шинжилгээг хийснээр дурсгалд муугаар нөлөөлж буй хүрээлэн буй орчны нөлөөллийн судалгааны үндсэн суурь мэдлэг, өөрсдийн гэсэн мэдээлэл мэдлэгтэй, юунаас ямар эрсдэл учирч болохыг урьдчилан мэдэж, сэргийлэх маш давуу талын судалгаа болж байна.


##### 2. Эрсдэл учруулах аюултай хорт хийн бохирдлийг судлах зорилго

Музей, галерей зэрэг байгууллагуудад хадгалагдаж буй соёлын үнэт дусгалын насжилтыг уртасгахын тулд байнгын судалгаа шинжилгээ хийн, хяналт тавьж, муудаж гэмтсэн тохиолдолд материал болоод хийц арга зүйд нь тохирсон анхан болоод урт хугацааны хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалтын ажил хийж байдаг.

Гэвч хүрээлэн буй орчны нөлөөллөөс ямарч материал тодорхой хэмжээнд аажим аажмаар муудаж гэмтэх эрсдэлд ордог учраас дахин сэргээн засварлах ажил хийх шаардлагатай болдог. Ахин дахин сэргээж хадгалах боломжтой олдвор байдагч, сэргээн засварлалтын үйл ажиллагааг даахгүй эмзэг олдворууд ч бий. Тиймээс соёлын дурсгал хадгалах тогтвортой орчныг бүрдүүлэх хамгийн гол хүчин зүйл нь агаарт агуулагдах хүчиллэг хийг тогтоох, хянах, устгах нь суурь судалгааны үндсэн нэг зорилго юм.

### 3. Судалгаанд ашиглагдах багаж

#### 3.1 Органик хүчил мэдрэгч шилэн сорил бүхий багаж




Зураг.1 Органик хүчил мэдрэгч багаж- загвар 910 (R-COOH)

#### Хүснэгт.1 Органик хүчил мэдрэгч багаж 910

Нэр	№910	Өнгөний хувиарал	Ягаан →цайвар шар
Хэмжих хүрээ	10~1000 $\mu\text{g}/\text{m}^3$	Хэрэглэх дулааны орчин	5~35°C
Хэмжих хүрээ ба цаг	10~400 $\mu\text{g}/\text{m}^3/60\text{min}$	Чийгшил	(20~80%RH)
	25~1000 $\mu\text{g}/\text{m}^3/30\text{min}$	Хүчинтэй хугацаа	3 жил
Агаарыг сорох хэмжээ	200mL/min	Хадгалах орчин	Гэрлээс хол (0~25°C)

#### 3.2 Аммиак хийг хэмжих багаж



Зураг .2 Аммиак хийг хэмжих багаж - загвар 900 (NH<sub>3</sub>)

#### Хүснэгт.2 Амони хийг хэмжих багаж 900

Нэр	№900	Өнгөний хувиарал	Ягаан →цайвар шар
Хэмжих хүрээ	10~80 $\mu\text{g}/\text{m}^3$	Хэрэглэх дулааны орчин	10~40°C
Хэмжих хүрээ ба цаг	10~80 $\mu\text{g}/\text{m}^3/60\text{min}$	Чийгшил	(10~90%RH)
	Хувьсах боломжтой	Хүчинтэй хугацаа	2 жил
Агаарыг сорох хэмжээ	400mL/min	Хадгалах орчин	Гэрлээс хол (0~25°C)

### 3.3. Формальдегид мэдрэгч багаж



Зураг.3 Формальдегид мэдрэгч багаж - загвар 710 (R-CHO)

#### Хүснэгт.3 Формальдегид мэдрэгч багаж - загвар 710

Нэр	№710	Өнгөний хувиарал	Улбар шар→ягаан
Хэмжих хүрээ	0.01~0.48ppm	Хэрэглэх дулааны орчин	10~35°C
Хэмжих хүрээ ба цаг	0.01~0.12ppm/30min	Чийгшил	(5~90%RH)
	0.04~0.48ppm/10min	Хүчинтэй хугацаа	1 жил
Агаарыг сорох хэмжээ	300mL/min	Хадгалах орчин	Хөргөгчинд (0~10°C)

### 3.4 Агаар сорогч багаж (тогтмол сорох)

#### Хүснэгт.4 Агаар сорогч багаж загвар ASP-1200

Нэр	ASP-1200
Хэмжих хүрээ	10~1200mL/min
Хэмжих орчин	0~40°C、10~90%RH
Зайн тогоор	4 ш
Хэмжих цаг	Тогтмол 12 цагаас дээш
Хэлбэр хэмжээ	145(W)×54(D)×99(H)mm
Жин	490g (зай ороод)



Зураг.4

Агаар сорогч багаж

#### 4. Судалгаа хийгдсэн байдал

хийгдсэн өдөр:2019 оны 4 дүгээр сарын 15 (11цагт)

хийгдсэн газар: Орхон аймгийн музейн сан хөмрөг, үзэсгэлэнгийн танхим, үзмэрийн хорго, гадаах орчинд хийж гүйцэтгэсэн.

#### 5. Химийн дэгдэмхий хорт хийн төрөл болон багаж, хийгдсэн нөхцөл

5.1 Химийн хорт хийн төрөл: Органик хүчил, Амони , Формальдегид

5.2 Багаж техник: Агаар сорогч ASP -1200

Хорт хийн мэдрэгч тестер: Китагава Органик хүчил мэдрэгч багаж- загвар 910

Китагава Аммиак хийг хэмжих багаж - загвар 900

Китагава Формальдегид мэдрэгч багаж - загвар 710

※Органик хүчил мэдрэгч 910 загварын тестер нь шоргоолжний хүчлийг, формальдгид хүчил мэдрэгч 710 загварын тестер нь ацетальдегид  $C_2H_4O$  хүчлийг давхар мэдэрдэг учираас хорт хийн нийлбэрт тооцогдоно.

5. 3 хийгдсэн нөхцөл:Органик хүчил:0.2L/min×60min(12Lсорох)

аммиак : 0.4L/min×60min(24Lсорох)

формальдегид $\circ$  : 0.3L/min×30min(19Lсорох)

5.4 Сорилын цэгүүд

цэгүүд	цэгийн нэршил	Цэгүүд	цэгийн нэршил
№1	2F тусгай сан хөмрөг	№3	3F сан хөмрөг
№2	2F сан хөмрөг	№4	3Fномын сан

5.5 Хорт хийн стандарт хэмжээ

нэршил	стандарт хэмжээ	
	ppb	$\mu g/m^3$
шоргоолжний хүчил (органик хүчил)	10	20
цууны хүчил (органик хүчил)	170	430
аммиак	30	22
формальдгид	80	100
ацетальдегид	30	48

※ $\mu g/m^3$ :22°C дулаанд тооцох

## 6. Хэмжилтийн үр дүн

6.1 сан хөмрөг, үзэсгэлэнгийн танхим, хорго (битүүмжилхээс өмнө)、гадаа

байршил	сар өдөр	хийн төрөл	дулаан (°C)	сорох агаар(L)	хувиргах (ppb)	хяналт (ppb)	агааржуулагч
гадаа	4/15 15:40~	органик хүчил	17	12.0	N.D.	N.D.	
		аммиак		24.0	N.D.	N.D.	
		формальдгид		9.0	N.D.	N.D.	
		азотын давхар исэл NO <sub>2</sub>		4.0	N.D.	N.D.	
үзэсгэлэнгийн танхим	4/15 13:50~	органик хүчил	24	12.0	4.1	4.1	—
		аммиак		24.0	14.3	14.3	
		формальдгид		9.0	10.0	8.8	
		азотын давхар исэл NO <sub>2</sub>		4.0	N.D.	N.D.	
хорго	4/15 15:00~	органик хүчил	24	6.0	8.1	20.3	
		аммиак		12.0	14.3	28.6	
		формальдгид		9.0	70.0	61.6	
		азотын давхар исэл NO <sub>2</sub>		4.0	N.D.	N.D.	
сан хөмрөг	4/15 11:00~	органик хүчил	28	12.0	162	136	
		аммиак		24.0	115	115	
		формальдгид		3.0	30.0	91.2	
		азотын давхар исэл NO <sub>2</sub>		4.0	N.D.	N.D.	

※танхимд агааржуулагч байхгүй

※үзэсгэлэнгийн танхим цонх нээлттэй үеэр хэмжилтийг хийсэн



※хоргон доторх хэмжилтийг хоргыг хаасны дараа хийсэн  
 ※N.D.илэрцгүй

## 6.2 Хоргыг15 цаг битүүмжилсны дараа хэмжилтийг хийсэн

хэмжилтийн цэг	сар өдөр	хийн төрөл	Дулаан (°C)	сорох агаар(L)	Хувиргах (ppb)	Хяналт (ppb)	агааржуулагч
хорго	4/16 8:00 ~	органик хүчил	28	12.0	61.7	51.8	—
		аммиак		24.0	58.0	58.0	
		формальдгид		3.0	60.0	182	
		азотын давхар исэл NO <sub>2</sub>		4.0	N.D.	N.D.	



※агаар сорогч төхөөрөмжийг 15цагийн дараа ажилхаар тохируулсан

6.2.1Органик хүчлийн хэмжилтийн үр дүнд бүх цэг дээр стандарт тунгийн хэмжээнээс харьцангуй бага хэмжээтэй илэрсэн. Мөн адил хоргонд 15 цагийн дараа хэмжилт хийсэн цэг дээр стандарт тунгийн хэмжээнээс харьцангуй бага хэмжээтэй илэрсэн.


6.2.2 Аммиак хүчлийн хэмжилтийн үр дүнд сан хөмрөгийн хэсэгт стандарт тунгаас харьцангуй өндөр тунтай илэрсэн. Мөн адил хоргонд 15 цагийн дараа хэмжилт хийсэн цэг дээр стандарт тунгийн хэмжээнээс харьцангуй өндөр хэмжээтэй илэрсэн. Бусад цэг дээр стандарт тунгийн хэмжээнээс харьцангуй бага хэмжээтэй илэрсэн.

6.2.3 формальдегидийн хүчлийн хэмжилтийн үр дүнд сан хөмрөгийн хэсэг, хоргонд 15 цагийн дараа хэмжилт хийсэн цэг дээр стандарт тунгаас харьцангуй өндөр тунтай илэрсэн. Бусад цэг дээр стандарт тунгийн хэмжээнээс харьцангуй бага хэмжээтэй илэрсэн.


6.2.4 Азотын давхар исэлийн хэмжилтийн үр дүнд хоргонд 15 цагийн дараа хэмжилт хийсэн цэг дээр болон бусад бүх цэг дээр илэрцгүй байсан.




Хүснэгт 5




Хүснэгт 6




Хүснэгт 7




Хүснэгт 8



Хүснэгт 9



Хүснэгт 10



## 7. Дүгнэлт

- 7.1 Сан хөмрөгийн органик хүчлийн тун хэмжээ нь бусад цэгүүдийн органик хүчлийн тун хэмжээтэй харьцуулхад харьцангуй өндөр байсан нь агаарын урсгал багатай, битүү байдагтай холбоотой байна. Органик хүчлийн хэмжээг багасгахын тулд агаарын урсгалыг сайжруулах шаардлагатай хэдий ч, агааржуулалттай холбоотой температур, чийгшлийн хэлбэлзлийг анхаарах нь нэн чухал юм. Агааржуулалт хийхэд хэт эрсдэлтэй нөхцөлд органик хүчил шүүг ч тусгай бодисыг ашиглах нь зүйтэй.
- 7.2 Сан хөмрөгийн аммиакийн тун хэмжээ нь стандарт тунгаас харьцангуй өндөр хэмжээтэй байсан нь агааржуулалттай мөн адил холбоотой байна. Хоргонд 15 цагийн дараа хэмжилт хийсэн цэг дээр стандарт тунгийн хэмжээнээс харьцангуй өндөр хэмжээтэй илэрсэн. Судалгаагаар хоргон доторх аммиакийн хэмжээ харьцангуй бага байдаг учраас уг аммиакийн өндөр тунтай хэмжээ нь гадны нөлөөлөлтэй буюу хорго нь зай завсартай байсан нь нөлөөлсөн. Хэмжилт хийсэн өдөр үзэсгэлэнгийн танхимийн цонх нээлттэй байсан нь аммиак харьцангуй бага

илрэх шалтгаан болсон хэдий ч ерөнхийдөө танхимд дунджаар харьцангуй өндөр тунтай байдаг.

7.3 Сан хөмрөгийн формальдегидийн тун хэмжээ нь стандарт тунгаас харьцангуй өндөр хэмжээтэй байсан нь агааржуулалттай мөн адил холбоотой байна. Хоргонд 15 цагийн дараа хэмжилт хийсэн цэг дээр стандарт тунгийн хэмжээнээс харьцангуй өндөр хэмжээтэй илэрсэн хэдий ч хоргыг онгойлж багажыг хийх үед хоргоны формальдегидийн хэмжээ танхимийн агаартай холилдож тун багассан байдаг. Тиймээс хоргоны үндсэн хүчиллэг хийн хэмжээг багажаа хийж урт хугацааны туршид агаарын урсгал тогтворжисний дараа хэмжих нь зүйтэй юм.

7.4 Азотын давхар исэл нь машины яндангаас гарах утаанаас гардаг учир үзмэр болон барилгын материалаас ялгарах боломжгүй. Хэмжилтийг хийсэн өдөр гадаах агаарын найрлага болон үзэсгэлэнгийн танхимд азотын давхар исэл илрээгүй. Өвлийн улиралд агаарын бохирдлоос болж агаарын найрлаган дахь азот болон бусад нэгдлүүдийн агууламж үлэмж ихэсдэг. Тиймээс өвлийн улиралд цонх онгойлж агааржуулалт хийх нь музейн доторх агаарыг бохирдуулж, хүчиллэг хийн хэмжээг нэмэгдүүлэх эрсдэл өндөр байдаг. Агаарын бохирдлыг энгийн агааржуулах систем болон хүчиллэг хийг шүүх тусгай агааржуулалтын систем ашиглаж цэвэршүүлж байх шаардлагатай бөгөөд соёлын өвийг хадгалах, тогтвортой хүрээлэн буй орчныг бүрдүүлхийн тулд үндсэн суурь судалгааг иж бүрэн байдлаар хянаж явуулах нь чухал юм.



Зураг.5 сан хөмрөг



Зураг.6 үзэсгэлэнгийн танхим



Зураг.7 хорго



Зураг.8 гадаа

-----oOo-----

# УЙГУРЫН НИЙСЛЭЛ ХАР БАЛГАС ОРДОН ХОТЫН ХУДАГААС ИЛЭРСЭН ТӨМӨР ЦООЖ, ХҮРЭЛ ХОНХНЫ СЭРГЭЭН ЗАСВАРЛАЛТЫН АЖИЛ

## 1 Өмнөтгөл

Археологийн малтлага судалгааны явцад илэрч буй олдворын төрөлд металл эдлэл багагүй хувийг эзэлдэг. Урт хугацаанд хөрсөн доор хадгалагдаж үлдсэнтэй холбоотой хөрсний эрдэсийн нөлөөнд орж микроэлементийн нөлөөлөл буюу металийн гадаргууд улаах урвалын исэл үүсгэдэг. Газрын гүнд тогтвортой орчинд хадгалагдаж байсан олдворыг малтан гаргаж агаар дахь хүчилтөрөгч ( $O_2$ , чийгийн нөлөөнд дахин орж зэврэлт үүсгэх эрсдэлийг бүрдүүлдэг: Тиймээс металл эдлэлийг удаан хугацаагаар хадгалж хамгаалхийн тулд зэврэлтийг зогсоох зорилгоор хадгалалт хатмгаалалт, бэхжүүлэлтийг хийдэг. Хар балгасны археологийн малтлага судалгаагаар илэрсэн металл эдлэлийн хувьд харьцангуй өндөр чийгтэй орчинд байсан хэдийч зэврэлт буюу исэлийг бүрдүүлэгч агаарын хүчилтөрөгч, усны давс, хлоридийн агууламж (Cl бага зэрэг нь сайн хадгалагдаж үлдэх хүчин зүйл нь болсон.

## 2 Уйгурын нийслэл Хар балгас Ордон хотын судалгаа

Орхоны хөндий дэх Уйгурын хаант улсын (745-840) нийслэл Ордубалык буюу Хар балгасыг 2007 оноос хойш Монгол Германы хамтарсан “Орхон” экспедици археологийн талаар шинжлэн судалж байгаа билээ. Өнгөрсөн оны зун Монгол, Герман археологичид Уйгурын нийслэлийн Ордон худгийг нээж олсон. Худаг хамгийн багадаа 12м гүн байсан төдийгүй ёроолд нь хүрэхэд устай байв. Худгийн байгууламж маш сайн хадгалагдсан ба боржин чулууг үелүүлэн доторлосон аж. Мөн худгийн ёроолоос маш сайн хадгалагдсан органик, металл эдлэлүүд илэрч олдсон. Эдгээр олдворыг малтлагын талбайд цэвэрлэх, RP систем ашиглан вакуумжуулах, зориулалтын сав баглаа, боодол ашиглан зөөж тээвэрлэх ажлуудыг Монголын Соёлын өвийн үндэсний төв, Хархорум музейн хамтарсан хадгалалт хамгаалалтын баг хийж гүйцэтгэв. Одоогийн байдлаар илэрсэн бүх олдворууд Соёлын өвийн төв дээр хадгалагдаж байгаа бөгөөд сэргээн засварлалтын өмнөх үеийн хадгалалтын орчин нөхцлийг стандартын дагуу бүрдүүлээд байна.



Худгын зохион байгуулалт



Судалгааны багынхан



*RP систем вакумжуулалт*



*Олдворын сав баглаа боодол*

2018 оны 11 дүгээр сард Монгол, Герман, Япон 3 улсын археологич, сэргээн засварлагч нар Монголд уулзалт зохион байгуулан, дээрх дурсгалаас илэрсэн олдворуудыг цаашид хэрхэн сэргээн засварлах, тулгамдаж буй асуудлыг хэрхэн шийдэх талаар санал солилцон Хэвлэлийн бага хурал зохион байгуулсан.

### **3. Олдворын хадгалалт хамгаалалт**

Дурсгалаас илэрсэн хүрэл хонх, алтаар бүрсэн төмөр цоожинд цэвэрлэгээ, бэхжүүлэлтийн ажил хийлгэхээр 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдөр Нара сургуулийн Хадгалалт хамгаалалтын тэнхимийн мэргэжилтэн доктор М.Оюунтулга Хархорум музейд хүргэж ирэв.



*Олдворыг хүлээж авч буй байдал*



*Бодис хэрэглэгдхүүн*

Төмрийн гадаргуу болон алтатсан гадаргуун хэсэгт чулуужсан шаврыг унагаж, гадаргуу хэсгийн гүн бохирдлыг чийгтэй болон хуурай цэвэрлэгээ хийн, зэврэлтийг зогсоож олдворын үндсэн шинж төрхийг хадгалж үлдээх зорилгыг дагуу хадгалалт хамгаалалт бэхжүүлэлтийн үйл ажилгааг хийсэн.

### 3.1 Төмөр цоожний цэвэрлэгээний өмнөх үеийн олдворын тодорхойлолт:

Цоож. 1 ширхэг. ННВ2-046. Төмөр. Маш нимгэн алтаар бүрсэн. Жин 3,2 кг. Урт-63 см, Өн-8 см. Олон мянган жил усанд байсан учир усны нөлөөнд автаж нилээд муудсан. Зэврэлт ихтэй гадаргуу нилэнхүйдээ барзайж чулуужсан, цоожны цүүний хэсэгт хагаралттай. Шавар шороо ихтэй. Бүтэн.



Цэвэрлэгээ, бэхжүүлэлт хийхийн өмнө



Цэвэрлэгээ, бэхжүүлэлт хийхийн өмнө

### 3.2 Ажлын журам:




Цэвэрлэгээний бодис, багаж хэрэглэгдхүүн:

- Этанол 3%  $C_2H_5OH$
- Паралойд В72
- Бензотриазол ВТА  $C_6H_5N_3$
- ацетон  $(C_3H_6O)$
- Бийр /хатуу зөөлөн үстэй, бүдүүн нарийн
- Зориулалтын зөөлөвч салфетка, хулсан савх, хутга


### 3.3 Цоожний механик цэвэрлэгээ

Цоожний үндсэн хэлбэрийг тодорхойлж, чулуужсан шороон давхарга болон зэвэрсэн хэсэг нь цоожний гадаргуу дээр ямар байдалтай байгааг ажиглахын тулд 2018 оны 11 дүгээр сард X рентген туяан зураглалыг (60kV) Улаанбаатар хотын СОНГДО

эмнэлэгт PACS Plus загварын багажаар авсан. Зэвний механик цэвэрлэгээг рентген туяан зураглалаас ажиглалт хийж үндсэн их биеийг гэмтээлгүй хийсэн.



*Рентген зураглал цоожний их биеий хэсэг*



*Рентген зураглал цоожний үзүүр хэсэг*

### 3.4 Бэхжүүлэлтийн явц:


2019 оны 05 сарын 14-ны өдрүүдэд бэхжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэв. Эхлээд 97%-н ацетон ( $C_2H_6O$ ), 3% парлойдны уусмалаар түрхэж 3 цагийн дараа ажиглалт хийхэд хэвийн, өөрчлөлт ороогүй байв. Бэхжүүлэлтийн бодис түрхэхдээ алтанд хүргэхгүйгээр бусад хэсгүүдэд түрхсэн. 13 цаг 30 минутанд дахин түрхсэн. Мөн л хэвийн байдалтай байсан. Иймд 3 дахь удаа паралоидыг 5% түрхэх явцад өнгө өөрчлөгдөж эхэлсэн. Алтан эдлэл жигд биш, энэ тэнд нүх, халцархай хэсгүүдтэй учир тэдгээр бодис түрхсэн хэсгүүд жигд биш, энэ тэнд үл ялиг тодорч харагдаж байна. Ингээд бэхжүүлэлтийн ажлыг дуусгав. Металл эдлэлийн гадаргууд алтан ялтасийг (Au) хүрэл эдлэлтэй адил мөнгөн усаар (Hg) ууршуулж тогтоох боломжгүй учраас алтан ялтасыг усан суурьтай цавуугаар нааж тогтоосон онцлог шинж хийцтэй учир, этанолийн шингэнд удаан хугацаанд хийж эрдэсийг гадагшлуулах боломжгүй байсан. Учир нь этаноль нь цавуулгыг задлаж наасан алтны гадаргууг төмрийн гадаргуугаас салгах эрсдэл өндөр байсан. Тиймээс чийгтэй цэвэрлэгээг бийр багсны тусламжтай гадаргуу хэсэгт хэсэгчилэн нийтэд нь хийсэн.



*Цэвэрлэгээний явц*



*Зөвлөгөө өгч буй байдал*



*Цэвэрлэгээний дараа*



*Бэхжүүлэлтийн дараа*

#### **4. Нангиад бичигтэй хүрэл хонхны олдворын тодорхойлолт:**

Хүрэл хонх: Хонх 1 ширхэг. ННВ2-047. Хүрэл. Жин 2700 гр, Өн-25 см, Өр- , дм-13 см, зу-1 см, Сэнжний өн-3 см, сэнжний дм 3,5 см, зу-1,4 см. Нүхний дм-1,5 см. Хонхны хэл. Урт-17,8 см, дм-1,8 см. Дээрээ ямар нэгэн зүйлээс унжуулан зүүх зориулалт бүхий бат бөх сэнжтэй. Уг сэнжийг хонхруу нэвт цоолон доош унжуулж түүнээс хонхны хэлийг дэгээ хэлбэрт оруулан эгц доош зүүсэн. Хонхны хэл дээрээсээ доош өргөссөн хэлбэртэй. Хонхны 2 талыг тэгшлэн засаад гол дунд 4 ханз үсэг сийлж босоо зураасаар тусгаарлан, дээд, доод буланд тус бүр 2 ширхэг үүлэн хээг товойлгон дүрсэлжээ. Хонх нилэнхүйдээ босоо ташуу зураастай. Хонхны их биеийг хүрлээр хийж, хэлийг нь төмрөөр хийсэн онцлогтой. Гэмтэл багатай, харьцангуй сайн хадгалагдсан. Хонхны гадаргуу хэсэгт ногоолин буюу зэсний урвал явагдаж янз бүрийн өнгөний өөрчлөлт орж хүрлийн өвчилөлд орсон байдалтай байсан.






*Цэвэрлэгээ, бэхжүүлэлт хийхийн өмнө*



*Цэвэрлэгээ, бэхжүүлэлт хийсний дараа*

#### 4.1 Хонхний механик цэвэрлэгээ

Хонхий үндсэн хэлбэрийг тодорхойлж, шороон давхарга болон зэвэрсэн хэсэг нь хонхний гадаргуу дээр ямар байдалтай байгааг ажиглахын тулд 2018 оны 11 дүгээр сард X рентген туяан зураглалыг (60kV) Улаанбаатар хотын СОНГДО эмнэлэгт PACS Plus загварын багажаар авсан. Зэвний механик цэвэрлэгээг рентген туяан зураглалаас ажиглалт хийж үндсэн их биеийг гэмтээлгүй хийсэн.



Рентген зураглал хонх

#### 4.2 Бэхжүүлэлтийн явц:

Этанолын 99%-н шингэнд нийт гадаргуугаар хийж чийгтэй цэвэрлэгээ хийсэн. Механик цэвэрлэгээг мэсний хутга, саваа мод зэрэг гарын доорх материалаар хийж гүйцэтгэсэн. Эрдэсийн бохирдол гэмтэл харьцангуй бага тогтвортой байсан учир трилон (этилендиаминететр ацетик хүчил  $C_{10}H_{16}N_2O_8$ ) ашиглаж химийн цэвэрлэгээг хийгээгүй.

ацетон 95% (C<sub>3</sub>H<sub>6</sub>O) , паралоид 3%, ВТА 2% найруулан, зөөлөн бийрээр хүрэл болон төмрийн гадаргуу хэсэгт 4 удаа давхарлаж бэхжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэв.

## 5. Дүгнэлт

Орхоны хөндийд орших Уйгурын нийслэл Хар балгас ордон хотын худагаас илэрсэн Нангиад бичигтэй хүрэл хонх, алтан шармал төмөр цоож нь хот суурины малтлагаар анх удаа илэрч буй бөгөөд нүүдэлчдийн уран барилга, соёлын үнэт өв болоод зогсохгүй түүхийн тайлагдашгүй олон асуултын хариулт болохуйц түүхэн ач холбогдолтой чухал дурсгалд тооцогдож байна. Энэхүү чухал металл олдворын хадгалалт хамгаалалтын ажлыг монголын мэргэжилтэн багын хамт олон хийж гүйцэтгэсэн ба Хархорум музейд анх удаа металл эдлэлийн хадгалалт хамгаалалт бэхжүүлэлтийн ажлыг хийснээрээ онцлогтой юм. Металл эдлэлийн хадгалалт хамгаалалтын үндсэн аргазүй болох баримтжуулалт, гадаргуун механик хими цэвэрлэгээ, зэвний цэвэрлэгээ, давсгүйжүүлэх, бэхжүүлэх, сэргээн засварлах, тогтвортой орчин бүрдүүлж хадгалах гэсэн дарааллын дагуу ажилсан хэдийч музейн лабораторын хувьд хийх боломжгүй ажилбар, бодис хэрэглэгдэхүүн, багаж техник дутагдалтай байна. Металл эдлэл нь зэс (Cu) , төмөр (Fe) , алт (Au) , мөнгө (Ag) , хүрэл (Cu, Zn) гэх мэт өөр шинж чанартай байдаг учраас зэвэрч муудах нөхцөл нь орчноосоо хамаараад өөр өөр онцлогтой байдаг. Тиймээс хадгалалт хамгаалалт, бэхжүүлэлт, сэргээн засварлах аргазүйг олдворын шинж чанар, нөхцөл байдалд тохирсон байдлаар боловсруулж хийх шаардлагатай. Хадгалалт хамгаалалт, бэхжүүлэлт, сэргээн засварлах ажилбар дууссаны дараа олдворын нөхцөлд таарсан тогтвортой орчин бүрдүүлж хадгалах нь нэн чухал юм.

## 6. Номзүй

1. М.Оюунтулга 2017 оны 12сар Модон эдлэлийн судалгаа ба хадгалалт хамгаалалтын тулгамдсан асуудал, Музей судлал Үндэсний түүхийн музей улаанбаатар хот
2. Mendbazar Oyuntulga 2010 , 『 Reserch Report of liaodynastys Castle Town site Chintolgoi, Mongolia 』 , Nara University · The institute of archeology of Academy of Sciences Mongolia,
3. メンドバザル オユントルガ 2014年。 日本文化財科学会・モンゴルにおける出土木製品の保存処理について。 日本文化材科学会第31回大会 研究発表要旨集336 p - 337 p
4. М.Оюунтулга 2016 оны 12сар МОДОН ЭДЛЭЛИЙН ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТАНД “ТРЕХАЛОС” САХАРЫН УУСМАЛЫГ АШИГЛАСАН СУДАЛГАА (Алтайн мөнх цэвдэгт, ойт хээрийн бүсийн олдворын жишээн дээр) Улаанбаатар их сургууль 129-135 улаанбаатар хот

5. М.Оюунтулга 2016 оны 12сар МОДОН ЭДЛЭЛИЙН ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТАНД “ТРЕХАЛОС” САХАРЫН УУСМАЛЫГ АШИГЛАСАН СУДАЛГАА(тал хээрийн бүсийн олдворын жишээн дээр) Үндэсний түүхийн музей улаанбаатар хот
6. 今津節生・肥塚隆保 1996 「金属遺物の脱塩処理—高温高压脱酸素水による脱塩効果の実例—」 『保存科学研究集会保存修復をとりまく問題—出土金属—』 奈良国立文化財研究所 pp.28-32

ТАЙЛАН БИЧСЭН:

М.ОЮУНТУЛГА Ph.D. СОЁЛЫН БИЕТ ӨВИЙГ  
СЭРГЭЭН ЗАСВАРЛАХ ГАЗРЫН  
ЕРӨНХИЙ ТЕХНОЛОГИЧ

КАНЭХАРА ЮМИКО. ЯПОН УЛС ТЭНРИ ХОТЫН  
СОЁЛЫН ӨВИЙГ СУДЛАХ  
ШИНЖЛЭХ УХААНЫ  
СУДАЛГААНЫ ТӨВИЙН СУДЛААЧ

КАНЭХАРА МИНАКО. ЯПОН УЛС ТЭНРИ ХОТЫН  
СОЁЛЫН ӨВИЙГ СУДЛАХ  
ШИНЖЛЭХ УХААНЫ  
СУДАЛГААНЫ ТӨВИЙН СУДЛААЧ

-----oOo-----

# УЙГУРЫН НИЙСЛЭЛ ХАР БАЛГАС ХОТЫН ТУУРИАС ИЛЭРСЭН ЛАКАН БОЛОН МОДОН ЭДЛЭЛД ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТ, БЭХЖҮҮЛЭЛТ СЭРГЭЭН ЗАСВАР ХИЙСЭН ТАЙЛАН

## 1 Өмнөтгөл

2018 оны 07 дугаар сард Уйгурын нийслэл Хар балгас хотын туурь Ордон худгаас илрүүлсэн органик эдлэлийг сүүлийн үеийн дэвшилтэд технологи, олон улсад нэвтэрч буй шинэ арга зүйгээр хослуулан сэргээн засварлах зайлшгүй шаардлага тулгараад байна. Иймд эдгээр олдворт хадгалалт хамгаалалтыг дээрх стандартын дагуу хийж илэрсэн ховор нандин олдворуудыг судалгааны эргэлтэнд оруулах, олон жилийн настай үзмэр болгох, дэлхий нийтэд сурталчилах зорилгоор Монгол Герман, Японы хамтарсан мэргэжлийн судалгааны баг мөн оноос эхлүүлээд байна. Мөн оны 7-р сард тус дурсгал дээр монголын мэргэжлийн баг хамт олон очиж, эрс тэс уур амьсгалтай монгол орны нутаг дэвсгэрээс илэрч буй органик болон металл эдлэлийг археологийн малтлагын талбайд хэрхэн хадгалж хамгаалах, тохирсон орчин нөхцөл бүрдүүлэх, анхан шатны цэвэрлэгээ хийх, зориулалтын сав баглаа боодол ашиглан зөөж тээвэрлэх, мөн хээрийн лабораторид ашиглагдах багаж, бодис хэрэглэгдхүүнтэй танилцах, талаар зөвөлгөө өгч газар дээр нь 30-аад олдворын стандарт сав баглаа боодлыг хийж ажилсан.



зураг 1:Лакан эдлэл зураг



зураг 2:Металл эдлэл



зураг3:Цэвэрлэгээ



зураг 4:Сав баглаа хийсэн байдал

## 2 Олдворын ерөнхий хадгалалтын байдал

Энэхүү дурсгал нь тал хээрийн бүсэд хамаарах бөгөөд газрын хөрсний хувьд тайгын цэвдэгт карбонатлаг хүрэн ангилалд багтана. Цаг уур нь эх газрын эрс тэс уур амьсгалтай, 1 дүгээр сарын дундаж хүйтэн нь  $-20^{\circ}\text{C}$ - $-21^{\circ}\text{C}$ , 7 дугаар сарын харьцангуй дулаан нь  $+16^{\circ}\text{C}$ - $+18^{\circ}\text{C}$  орчим бөгөөд жилд дундажаар 300-400мм хур тундас унадаг. Хөрсний урвалын орчин сул хүчиллэг орчин зонхилсон.

Хөрсний давсжилтын зэрэглэлээр үзвэл давсжилтгүй ангилалд ордог, сэрүүн агаарын урсгал багатайгаас шалтгаалж хадгалагдаж байгаа модон олдворууд нян бактерийн нөлөөнд оролгүй харьцангуй сайн хадгалагдаж үлдсэн байсан. Гэвч байгалийн болоод хүний хүчин зүйлийн нөлөөллөөс ихэнх олдворууд шаталттай, хугарч хэсэг хэсэг болон жижгэрсэн, цуурч гэмтсэн байдал зонхилж байсан. Газрын гадаргаас доош дунджаар 12 метрийн гүнд 0-аас  $5^{\circ}\text{C}$ -н хэмд, 100%-н чийгшилд агаарыг урсгал багатай тогтвортой орчиноос илэрсэн.



зураг 5: Усны агууламж ихтэй гарч буй байдал

## 3 Хадгалалт хамгаалалт, бэхжүүлэлтийн зорилго

Тал хээрийн бүсээс илэрч буй усны агууламж өндөртөй модон эдлэлийн анхны эх төрхийг хадгалж тэр хэвээр нь удаан хугацааны хадгалалт хамгаалалт, бэхжүүлэлтийг хийж, эсийн бүтцийн гэмтлийн бат бөх байдлыг тогтворжуулах, хийгдэх боломжтой материал судлал дээр багажит дүн шинжилгээ хийн, түүхийн давтагдашгүй эд өлгийн зүйлийг суртчилан таниулах, хойч үедээ үлдээх зорилготой юм.

## 4 Хадгалалт хамгаалалт, бэхжүүлэлт хийх ажлын төлөвлөгөө

Уусмалын аргаар бэхжүүлэлт хийх лакан эдлэл нь 3ш, модон эдэл нь 26 ш жижиг хэмжээний олдвор байна.

**4.1** Соёлын өвийн үндэсний төв СБӨСЗГ-ын хадгалалт хамгаалалт, бэхжүүлэлтийн арга зүй.

Лакан эдлэл болон модон эдлэлийг трехалос сахарын уусмалаар бэхжүүлнэ. Олдворын карт хөтлөн, олдворын талаарх мэдээллийг тэмдэглэн баримтжуулна. Уусмалд хийхийн өмнөх ба дараа нь хийгдэх ажилбарт:

- Баримтжуулалт
- Цэвэрлэгээ
- хүчил шүлтийг тогтворжуулах
- Уусмалын аргаар бэхжүүлэх
- Талст үүсгэж хатаах
- Гадаргуун цэвэрлэгээ
- Сэргээн засварлах
- Баримтжуулалт
- сав баглаа боодол гэсэн ажилбарыг хийнэ.

#### **4.2 Уусмалд хийхийн өмнөх бэлтгэл ажил**

Малтлагын талбайгаас өндөр усны агууламжтай, битүүмжлэгдсэн сав баглаа боодолтой ирсэн. Эхний ээлжинд гадаргууд наалдсан бохирдол шороог усаар угааж, баримтжуулалт хийнэ. Баримтжуулалт дууссаны дараа хуванцар саванд химийн цэвэрлэгээ буюу трилон Б-EDTA 1%, нэрмэл ус 99%-ийн уусмалаар модон эдлэлийн гүн боирдлыг цэвэрлэж гадагшлуулах зорилгоор Ph буюу усны хүчиллэг болон шүлтлэгийг хэвийн хэмжээнд болтол 60 градусаас дээш бүлээн уусмалыг 5 цаг тутамд сольж цэвэрлэгээ хийнэ. Лакан эдлэл нь 60 градусаас дээш халуунд хайлж, зөөлрөх эрсдэлтэй тул химийн цэвэрлэгээг хийхгүй. Лакан болон модон эдлэл тус бүрийг уусмалд байх хугацаанд жинлэх аргаар сахарын уусмалыг олдворт шингэж байгааг хянана. Уусмалд байх хугацаанд олдворт хагарал цуурал үүсэх зэрэгт нарийн ажиглалт явуулна.

#### **4.3 Модон эдлэлийн трехалос сахарын уусмалын бэхжүүлэлт**

Олдворын эзэлхүүнээс 10 дахин илүү уусмал орох хэмжээтэй хуванцар саванд трехалос сахарын уусмалыг 20%-иар найруулж олдворыг уусмалд хийж эхлүүлнэ. Уусмалын тунг олдворын жин тогтвортой болсны дараа 10%-иар тус тус нэмж, ханасан уусмал болтол трехалос сахарын уусмал 20%+трехалос сахарын уусмал 30%+трехалос сахарын уусмал 40%+ трехалос сахарын уусмал 50%+трехалос сахарын уусмал 60%+трехалос сахарын уусмал 72% гэсэн уусмалын хэмжээгээр нэмнэ. Халаагч зууханд +80 градусын халуунд сахарыг хайлуулна. Уусмалын сахарын хувийг нэмэх үед ATAGO-PEN.J загварын сахар хэмжигчээр хэмжиж, ханасан уусмал болох 72%-ийн уусмалд орж дуусах хүртэл ууршихаас сэргийлж уусмалын дээгүүр уутан хучилга тавьж битүүмжилсэн хэлбэрээр уусмалд байлгана. Уусмал нэмэх үндсэн 3 аргачлалаас шинээр тус тусийн хувиар найруулж бэлдэж нэмэх арга зүйг сонгоно. Сахарын уусмалыг олдворыг хийснээс авч дуусах хугацаанд долоо хоногийн 1 дэхь өдөр болон 5 өдөр болгон хэмжиж уусмалын хувийг нь хянана. Сахарын уусмал

олдворын усыг тууж, усны эзэлхүүнд бүрэн орж солигдох хугацаа 3 сарын турш үргэлжилнэ.

#### **4.4 Модон эдлэлийг уусмалаас гаргаж авах**

Олдворын жин ханасан уусмалд тогтмол жинд хүрсний дараа олдворыг уусмалаас гаргана. Гаргах үедээ гялгар уут дэвсэн, уутан бээлий, зөөлөвчтөй савх бэлдэн салхи нэвтрэх боломжтой саванд хийж гаргана. Гаргаж авсны дараа олдворын гадаргуу дээрх цуурал гэмтэл, агшилт зэргийг 2-оос 4 өдөр тасралтгүй хянах шаардлагатай тул ажлын эхний өдөр гаргах нь чухал юм. Хатаалт болон сахарын талст үүсгэлтийг дунджаар 1 сарын хугацаанд хийнэ.

#### **4.5 Лакан эдлэлийн трехалос сахарын уусмалын бэхжүүлэлт**

Олдворын эзэлхүүнээс 10 дахин илүү уусмал орох хэмжээтэй хуванцар саванд трехалос сахарын уусмалыг 20%-иар найруулж олдворыг уусмалд хийж эхлүүлнэ. Уусмалын тунг олдворын жин тогтвортой болсны дараа 10%-иар тус тус нэмж, ханасан уусмал болтол трехалос сахарын уусмал 20%+трехалос сахарын уусмал 30%+трехалос сахарын уусмал 40%+ трехалос сахарын уусмал 50%+трехалос сахарын уусмал хэмжээгээр нэмнэ. Халаагч зууханд +60 градусын халуунд сахарыг хайлуулна. Уусмалын сахарын хувийг нэмэх үед ATAGO-PEN.J загварын сахар хэмжигчээр хэмжиж, 50%-ийн уусмалд орж дуусах хүртэл ууршихаас сэргийлж уусмалын дээгүүр уутан хучилга тавьж битүүмжилсэн хэлбэрээр уусмалд байлгана. Уусмал нэмэх үндсэн 3 аргачлалаас шинээр тус тусийн хувиар найруулж бэлдэж нэмэх арга зүйг сонгоно. Сахарын уусмалыг олдворыг хийснээс авч дуусах хугацаанд долоо хоногийн 1 дэхь өдөр болон 5 өдөр болгон хэмжиж уусмалын хувийг нь хянана. Сахарын уусмал олдворын усыг тууж, усны эзэлхүүнд бүрэн орж солигдох хугацаа 3 сарын турш үргэлжилнэ.

#### **4.6 Лакан эдлэлийг уусмалаас гаргаж авах**

Олдворын жин ханасан уусмалд тогтмол жинд хүрсний дараа олдворыг уусмалаас гаргана. Гаргах үедээ ханасан уусмал болох 72%-ийн уусмалд 10 минут байлгаж гадаргууд сахарын нягт давхрага үүсгэнэ. Түүний дараа гялгар уут дэвсэн, уутан бээлий, зөөлөвчтөй савх бэлдэн салхи нэвтрэх боломжтой саванд хийж гаргана. Гаргаж авсны дараа олдворын гадаргуу дээрх цуурал гэмтэл, агшилт зэргийг 2-оос 4 өдөр тасралтгүй хянах шаардлагатай тул ажлын эхний өдөр гаргах нь чухал юм. Хатаалт болон сахарын талст үүсгэлтийг дунджаар 1 сарын хугацаанд хийнэ.

#### **4.7 Сахарын талст үүсгэх**

Салхин сэнсээр олдворын гадаргууруу үлээлгэж, бүх гадаргууг жигд үлээлгэхийн тулд олдворыг эргүүлж тойруулан хөдөлгөх шаардлагатай. Талстыг түргэсгэхийн тулд сэнсээр үлээлгэн хаталт хийхээс гадна орчныг сэрүүн нөхцөлтөй болгох шаардлагатай. Талст үүсгэх явцад олдворын гадаргуу дээр цуурал үүсэх шинж тэмдэг ажиглагдвал сахарын ханасан уусмал 72%-ийн уусмалаар түрхлэг хийж зогсооно.

Хаталт болон талст үүсч байгаа жинг эхний 3 өдөр өглөө 9 цаг, өдөр 2 цаг, орой 5 цагт хэмжиж, жин тогтвортой болох хүртэл үлдсэн өдрүүдэд өглөө 9 цаг, орой 5 цагт хэмжих шаардлагатай.

#### **4.8 Гадаргуун цэвэрлэгээ**

Сахарын талстыг даралттай уурын индүүгээр хайлуулан, хайлсан сахарыг техникийн цаасаар арчиж, хатаах арга зүйгээр цэвэрлэнэ. Нэг удаагийн хайлуулалтаар сахар арилаагүй үлдсэн тохиолдолд дахин давтах маягаар цэвэрлэгээг дуусгана. Хэт их гадаргууд ойртуулж, халуун усны агууламжийг нэмэх нь сахарын хэмжээг багасгаж гадаргууд цууралт үүсгэх эрсдэлтэй.

#### **4.9 Сэргээн засварлалт**

Паралойд В72, ацетон  $C_3H_6O$  болон бонд эпоксийн төрлийн нийлэг цавуу ашиглан нааж, нөхөх ажилбарыг хийж WENSOR маркийн акрилкийн будгаар өнгө будгын сэргээнийг хийнэ.

**4.10** Олдворт таарсан эрсдэлгүй сав баглаа хийж, хадгалах горимын талаар заавар өгөх чиглэлээр хадгалалт хамгаалалт, бэхжүүлэлт сэргээн засварын арга зүйн төлөвлөгөөний дагуу ажилна.

### **5 Модон эдлэлийн хадгалалт хамгаалалт**

Олдворын дугаар НВ2-№038, НВ2-№104, НВ2-№099, НВ2-№045, НВ2-№044 дугаартай олдвор дээр хадгалалт хамгаалалт, бэхжүүлэлтийн ажлыг хийсэн. Олдворын нийт гадаргуу хэсгүүд нарийн шороон давхрага үүсгэсэн 500%-аас 800%-ийн усны агууламжтай, НВ2-№038 дугаартай хулсан хутганы хуйны үзүүр хэсэг нь олон хэсэг болж салаалсан, их биеийн үндсэн хэлбэр нь сайн хадгалагдаж үлдсэн байсан. Бусад олдворын хувьд жижин хэсгүүд болон хагарсан байдалтай, модны эсийн гэмтэл дундаж хэмжээнд явагдаж лигнин нь харьцангуй сайн хатуулагтай дунд зэргийн хадгалалттай байсан. Модон эдлэлийн хадгалалт хамгаалалт сэргээн засвар хийх ажлын үндсэн дараалалд

-Баримтжуулалт

-Цэвэрлэгээ

- хүчил шүлтийг тогтворжуулах

-Уусмалын аргаар бэхжүүлэх

-Талст үүсгэж хатаах

-Гадаргуун цэвэрлэгээ

-Сэргээн засварлах

- Баримтжуулалт

-сав баглаа боодол хийх арга зүйн дарааллаар хийдэг



## 5.1 Баримтжуулалт

CANON 2 T2i болон OLYMPUS-ToughF 2 загварын дижитал аппарат, KODAK Color ашиглаж хадгалалтын өмнөх ба дараах болон хадгалалт хамгаалалт, бэхжүүлэлтийн явцын зургыг авч баримтжуулсан.

## 5.2 Цэвэрлэгээ

Бийр, багс, чигчлүүр мод ашиглан усан дотор хийж гадаргуун усан цэвэрлэгээг 4 удаагийн давтамжтай хийсэн.

## 5.3 Хүчил шүлтлэгийг тогтворжуулах

Олдворын хувьд цэвэр усанд хадгалагдаж байсан ба нуранга үүсэн шороонд дарагдсан нь гэмтэж муудах гол шалтгаан болсон хэдийч хөрс шорооны хувьд хөнгөн, шавранцар, нарийн ширхэгтэй, урвалын орчин сул хүчиллэг орчин зонхилсон, давсжилтын зэрэглэлээр үзвэл давсжилтгүй ангилалд ордогтой холбоотой модны бохирдол нь харьцангуй бага байсан учир гүн бохирдлыг гадагшлуулж хүчил шүлтлэгийг тогтворжуулах шаардлагагүй байсан.

## 5.4 Уусмалын аргаар бэхжүүлэх

Модны эсийн түвшинд шингэн орсон ус нь хэт халуун хуурай нөхцөлөөс үүдэлтэй ууршилт өгснөөр модны эсийн хэлбэрийг гэмтээж гадаргууд цууралт, агшилт, тэлэлт өгч анхны эх төрхий нь алдуулж муутгадаг. Тиймээс модонд агуулагдаж буй усны эзэлхүүний оронд уусмалын аргаар халааж бэхжүүлэгч сахарыг оруулдаг.

- Трехалос сахарын уусмалын 10%-ийн уусмалд 14 хоног
- Трехалос сахарын уусмалын 20%-ийн уусмалд 14 хоног
- Трехалос сахарын уусмалын 30%-ийн уусмалд 14хоног
- Трехалос сахарын уусмалын 40%-ийн уусмалд 14 хоног
- Трехалос сахарын уусмалын 50%-ийн уусмалд 14 хоног
- Трехалос сахарын уусмалын 60%-ийн уусмалд 14 хоног
- Трехалос сахарын уусмалын 72%-ийн уусмалд 14 хоногийн хугацаанд хатаагч зуух ашиглан тус тус 80 градусын халуунд сахарын уусмалын нэвчилт хийсэн.



зураг 6: Уусмал бэлтгэл



зураг 7: 20%-ийн уусмал



зураг 8: 50%-ийн уусмал



зураг 9: Уусмалын хувь хяналт



зураг 10: Сахарын хувь хяналт



зураг 11: Сахарын хувь хяналт



зураг 12: Сахарын хувь хяналт



зураг 13: Уусмалын хувь өсгөлт

### 5.5 Талст үүсгэж хатаах

Уусмалаас гаргасны дараа 5 градусаас 10 градус хэмд салхин сэнсний тусламжтай үлээлгэн сахарыг талсжуулах ажилбарыг 25 хоногийн хугацаанд хийсэн.



зураг 14: Уусмалын гаргах явц



зураг 15: Талст үүсгэх явц



зураг 16: Орчны хяналт



зураг 17: Талст үүссэн байдал

### 5.6 Гадаргуун цэвэрлэгээ

Жинлэх аргаар талсжилт бүрэн дууссаныг хяналт хийн, гадаргууд үүссэн сахарын талстыг даралттай уурын индүүгээр хайлуулан, хайлсан сахарыг техникийн цаасаар арчиж, 5 градусаас 10 градус хэмд салхин сэнсний тусламжтай үлээлгэн сахарыг талсжуулах ажилбарын дарааллаар 3-аас 4 удаагийн давтамжтай хийж гадаргуун цэвэрлэгээг хийсэн.

### 5.7 Сэргээн засварын ажилбар

Модон олдворууд нь тус тусдаа эвлэх хэсэггүй, хугарч халцарсан гэмтэлгүй учраас нөхөх, наах, будах зэрэг сэргээний ажилбар хийх шаардлагагүй болно.

### 5.8 Баримтжуулалт

CANON 2 T2i загварын дижитал аппарат, KODAK Color ашиглаж бэхжүүлэлтийн дараах зургыг авч баримтжуулсан.

### 5.9 Сав баглаа боодол

Хадгалалтын тогтвортой орчин бүрдүүлэх анхан шатны арга зүй нь олдворын сав баглаа юм. Сав баглааг ус чийг болон агаарын урсгалаас тусгаарлаж, хайрцагны материалаас үүсэлтэй хүчлүүдээс тусгаарлах зорилгоор хүчил шүлтлэггүй цаасанд боох шаардлагыг хангаж боосон. Мөн зөөж тээвэрлэх үед доргилтоос үүсэх эрсдэлийг хязгаарлаж зөөлөвч хийсэн.

## 6 Лакан эдлэлийн хадгалалт хамгаалалт

Олдворын дугаар НВ2-№039, НВ2-№097, НВ2-№040, дугаартай олдвор дээр хадгалалт хамгаалалт, бэхжүүлэлтийн ажлыг хийсэн. Олдворын нийт гадаргуу хэсгүүд нарийн шороон давхрага үүсгэсэн 500%-аас 800%-ийн усны агууламжтай, НВ2-№039 дугаартай жижиг модны лакан гадаргуу нь жижиг хэсгүүд болон хагарсан байдалтай байсан. НВ2-№097 дугаартай бөөрөнхий хэлбэртэй лакан гадаргуутай модны лакны дийлэнх хэсгүүд нь ховхорсон, модны их биеийн хэсгүүд зарим хэсгээрээ цууралттай байсан. НВ2-№040 дугаартай голдоо хөндий бүхий лакан эдлэлийн жижиг хэсгийн

гадаргуу нь нарийн цууралт өгсөн байдалтай, олдворуудын үндсэн хэлбэр нь сайн хадгалагдаж үлдсэн бөгөөд эсийн гэмтэл дундаж хэмжээнд явагдаж лигнин нь харьцангуй сайн хатуулагтай дунд зэргийн хадгалалттай байсан.

### 6.1 Баримтжуулалт

CANON 2 T2i болон OLYMPUS-ToughF 2 загварын дижитал аппарат, KODAK Color ашиглаж хадгалалтын өмнөх ба дараах болон хадгалалт хамгаалалт, бэхжүүлэлтийн явцын зургыг авч баримтжуулсан.

### 6.2 Цэвэрлэгээ

Бийр, багс, чигчлүүр мод ашиглан усан дотор хийж гадаргуун усан цэвэрлэгээг 4 удаагийн давтамжтай хийсэн.

### 6.3 Хүчил шүлтлэгийг тогтворжуулах

Лакан эдэлд химийн гаралтай гүн бохирдлыг гадагшлуулж хүчил шүлтлэгийг тогтворжуулах трилон Б-EDTA нь лаканд муу нөлөө үзүүлэх эрсдэлтэй байдаг тул олон улсын жишигт энэ ажилбарыг хийдэггүй.

### 6.4 Уусмалын аргаар бэхжүүлэх

- Трехалос сахарын уусмалын 10%-ийн уусмалд 14 хоног
- Трехалос сахарын уусмалын 20%-ийн уусмалд 14 хоног
- Трехалос сахарын уусмалын 30%-ийн уусмалд 14хоног
- Трехалос сахарын уусмалын 40%-ийн уусмалд 14 хоног
- Трехалос сахарын уусмалын 50%-ийн уусмалд 14 хоног
- Трехалос сахарын уусмалд 72%-ийн уусмалд 10 минутын хугацаанд байлгаж сахарын уусмалын нэвчилт хийсэн.



зураг 18: 50%-ийн уусмал



зураг 19: 72%-ийн түрхлэг

### 6.5 Талст үүсгэж хатаах

Уусмалаас гаргасны дараа 5 градусаас 10 градус хэмд салхин сэнсний тусламжтай үлээлгэн сахарыг талсжуулах ажилбарыг 25 хоногийн хугацаанд хийсэн.



зураг 20: Талст үүссэн байдал

## 6.6 Гадаргуун цэвэрлэгээ

Жинлэх аргаар талсжилт бүрэн дууссаныг хяналт хийн, гадаргууд үүссэн сахарын талстыг даралттай уурын индүүгээр хайлуулан, хайлсан сахарыг техникийн цаасаар арчиж, 5 градусаас 10 градус хэмд салхин сэнсний тусламжтай үлээлгэн сахарыг талсжуулах ажилбарын дарааллаар 3-аас 4 удаагийн давтамжтай хийж гадаргуун цэвэрлэгээг хийсэн.



зураг 21: Гадаргуун цэвэрлэгээ



зураг 22: Эхний цэвэрлэгээ

## 6.7 Сэргээн засварын ажилбар

Лакан эдлэлийн хагарч, нумарсан хэсгүүдийг нарийн ажилбар хийх боломжтой гар индүүгээр 80 градусаар халааж модон суурин дээр лагыг PAOGEN-PP15 төрлийн усан суурьтай цавуугаар нааж эвлүүлсэн. Цуурч ангайсан хэсгүүдэд бонд эпоксийн төрлийн цавуугаар нөхөлт хийж WENSOR маркийн акрилкийн будгаар өнгө будгын сэргээнийг хийсэн.



зураг 23: Наалт хийж буй байдал

## 6.8 Баримтжуулалт

CANON 2 T2i загварын дижитал аппарат, KODAK Color ашиглаж бэхжүүлэлтийн дараах зургыг авч баримтжуулсан.

## 6.9 Сав баглаа боодол

Хадгалалтын тогтвортой орчин бүрдүүлэх анхан шатны арга зүй нь олдворын сав баглаа юм. Сав баглааг ус чийг болон агаарын урсгалаас тусгаарлаж, хайрцагны материалаас үүсэлтэй хүчлүүдээс тусгаарлах зорилгоор хүчил шүлтлэггүй цаасанд боох шаардлагыг хангаж боосон. Мөн зөөж тээвэрлэх үед доргилтоос үүсэх эрсдэлийг хязгаарлаж зөөлөвч хийсэн.



зураг 24: Орчны хяналт

## 15. Дүгнэлт

2018 оны Монгол Германы хамтарсан археологийн малтлага судалгаагаар Уйгурын нийслэл Хар балгас хотын туурь Ордон худгаас илрүүлсэн олдворууд нь соёлын үнэт өв болоод зогсохгүй түүхийн тайлагдашгүй олон асуултын хариулт болохуйц түүхэн ач холбогдолтой чухал дурсгалд тооцогдож байна. Энэхүү чухал органик болон металл олдворын хадгалалт хамгаалалтын ажлыг монголын мэргэжилтэн багын хамт олон хийж гүйцэтгэсэн ба лакан эдлэл болон модон эдлэл тус бүр дээр олдворын онцлогт таарсан стандарт аргазүйг ашиглаж хадгалалт хамгаалалт бэхжүүлэлтийн ажлыг хийснээрээ онцлогтой юм. Органик эдлэл нь дулаан чийгшлийн тогтворгүй орчинд муудалт явагдах эрсдэл өндөртэй байдаг. Мөн материал харгалзахгүй олдворыг хамгийн гол муутгаж буй эрсдэлд олон төрлийн органик хүчил ордог. Тиймээс хадгалалт хамгаалалт, бэхжүүлэлт, сэргээн засварлах аргазүйг олдворын шинж чанар, нөхцөл байдалд тохирсон байдлаар боловсруулж хийх шаардлагатай. Хадгалалт хамгаалалт, бэхжүүлэлт, сэргээн засварлах ажилбар дууссаны дараа олдворын нөхцөлд таарсан тогтвортой орчин бүрдүүлж хадгалах нь нэн чухал юм. Музейн орчинд органик эдлэлийг 55%-аас 65%-ийн чийгшил, 150 люкс гэрэлтүүлэгт хадгалан дундаж дулааныг 20 градуст байлгаж, чийгшил дулааны хэлбэлзэл аль болох бага орчинд хадгалах нь зүйтэй.

## ХАВСРАЛТ-1


### Олдворын хадгалалт хамгаалалт хийхийн өмнөх ба дараах



зураг 1: хадгалалт хамгаалалт хийхийн өмнөх



зураг 2: хадгалалт хамгаалалт хийхийн өмнөх



зураг 3: хадгалалт хамгаалалт хийхийн өмнөх



зураг 4: хадгалалт хамгаалалт хийхийн өмнөх



зураг 5: хадгалалт хамгаалалт хийхийн өмнөх



зураг 6: хадгалалт хамгаалалт хийсний дараа




Уусмалын бэхжүүлэлт дуусч, сахар бүрэн талсжиж дууссаны дараах HB2-№038, HB2-№104, HB2-№099, HB2-№045, HB2-№044 дугаартай олдворуудын байдал.



зураг 7: хадгалалт хамгаалалт хийсний өмнө дараа



зураг 8: хадгалалт хамгаалалт хийсний өмнө дараа



зураг 9: хадгалалт хамгаалалт хийсний өмнө дараа

## ХАВСРАЛТ-2

### Модон элдэлийн уусмалд хийгдсэн хугацаа

8 р сарын 5	Трехалос 20%	хэмжилт
8 р сарын 6	Трехалос 20%	
8 р сарын 7	Трехалос 20%	

8 р сарын 8	Трехалос 20%	
8 р сарын 9	Трехалос 20%	хэмжилт
8 р сарын 10	Трехалос 20%	
8 р сарын 11	Трехалос 20%	
8 р сарын 12	Трехалос 20%	хэмжилт
8 р сарын 13	Трехалос 20%	
8 р сарын 14	Трехалос 20%	
8 р сарын 15	Трехалос 20%	
8 р сарын 16	Трехалос 20%	хэмжилт
8 р сарын 17	Трехалос 20%	
8 р сарын 18	Трехалос 20%	
8 р сарын 19	Трехалос 30%	хэмжилт
8 р сарын 20	Трехалос 30%	
8 р сарын 21	Трехалос 30%	
8 р сарын 22	Трехалос 30%	
8 р сарын 23	Трехалос 30%	хэмжилт
8 р сарын 24	Трехалос 30%	
8 р сарын 25	Трехалос 30%	
8 р сарын 26	Трехалос 30%	хэмжилт
8 р сарын 27	Трехалос 30%	
8 р сарын 28	Трехалос 30%	
8 р сарын 29	Трехалос 30%	
8 р сарын 30	Трехалос 30%	хэмжилт
8 р сарын 31	Трехалос 30%	
9 р сарын 1	Трехалос 30%	
9 р сарын 2	Трехалос 40%	хэмжилт
9 р сарын 3	Трехалос 40%	
9 р сарын 4	Трехалос 40%	
9 р сарын 5	Трехалос 40%	
9 р сарын 6	Трехалос 40%	хэмжилт
9 р сарын 7	Трехалос 40%	
9 р сарын 8	Трехалос 40%	
9 р сарын 9	Трехалос 40%	хэмжилт
9 р сарын 10	Трехалос 40%	
9 р сарын 11	Трехалос 40%	
9 р сарын 12	Трехалос 40%	
9 р сарын 13	Трехалос 40%	хэмжилт
9 р сарын 14	Трехалос 40%	
9 р сарын 15	Трехалос 40%	
9 р сарын 16	Трехалос 50%	хэмжилт
9 р сарын 17	Трехалос 50%	

9 р сарын 18	Трехалос 50%	
9 р сарын 19	Трехалос 50%	
9 р сарын 20	Трехалос 50%	хэмжилт
9 р сарын 21	Трехалос 50%	
9 р сарын 22	Трехалос 50%	
9 р сарын 23	Трехалос 50%	хэмжилт
9 р сарын 24	Трехалос 50%	
9 р сарын 25	Трехалос 50%	
9 р сарын 26	Трехалос 50%	
9 р сарын 27	Трехалос 50%	хэмжилт
9 р сарын 28	Трехалос 50%	
9 р сарын 29	Трехалос 50%	
9 р сарын 30	Трехалос 60%	хэмжилт
10 р сарын 1	Трехалос 60%	
10 р сарын 2	Трехалос 60%	
10 р сарын 3	Трехалос 60%	
10 р сарын 4	Трехалос 60%	хэмжилт
10 р сарын 5	Трехалос 60%	
10 р сарын 6	Трехалос 60%	
10 р сарын 7	Трехалос 60%	хэмжилт
10 р сарын 8	Трехалос 60%	
10 р сарын 9	Трехалос 60%	
10 р сарын 10	Трехалос 60%	
10 р сарын 11	Трехалос 60%	хэмжилт
10 р сарын 12	Трехалос 60%	
10 р сарын 13	Трехалос 60%	
10 р сарын 14	Трехалос 72%	хэмжилт
10 р сарын 15	Трехалос 72%	
10 р сарын 16	Трехалос 72%	
10 р сарын 17	Трехалос 72%	
10 р сарын 18	Трехалос 72%	хэмжилт
10 р сарын 19	Трехалос 72%	
10 р сарын 20	Трехалос 72%	
10 р сарын 21	Трехалос 72%	хэмжилт
10 р сарын 22	Трехалос 72%	
10 р сарын 23	Трехалос 72%	
10 р сарын 24	Трехалос 72%	
10 р сарын 25	Трехалос 72%	хэмжилт
10 р сарын 26	Трехалос 72%	
10 р сарын 27	Трехалос 72%	
10 р сарын 28	Уусмалаас авсан	хэмжилт

11 р сарын 22	25 хоног хатаалт	
---------------	------------------	--

### ХАВСРАЛТ-3

#### Лакан элдэлийн уусмалд хийгдсэн хугацаа

8 р сарын 5	Трехалос 20%	хэмжилт
8 р сарын 6	Трехалос 20%	
8 р сарын 7	Трехалос 20%	
8 р сарын 8	Трехалос 20%	
8 р сарын 9	Трехалос 20%	хэмжилт
8 р сарын 10	Трехалос 20%	
8 р сарын 11	Трехалос 20%	
8 р сарын 12	Трехалос 20%	хэмжилт
8 р сарын 13	Трехалос 20%	
8 р сарын 14	Трехалос 20%	
8 р сарын 15	Трехалос 20%	
8 р сарын 16	Трехалос 20%	хэмжилт
8 р сарын 17	Трехалос 20%	
8 р сарын 18	Трехалос 20%	
8 р сарын 19	Трехалос 30%	хэмжилт
8 р сарын 20	Трехалос 30%	
8 р сарын 21	Трехалос 30%	
8 р сарын 22	Трехалос 30%	
8 р сарын 23	Трехалос 30%	хэмжилт
8 р сарын 24	Трехалос 30%	
8 р сарын 25	Трехалос 30%	
8 р сарын 26	Трехалос 30%	хэмжилт
8 р сарын 27	Трехалос 30%	
8 р сарын 28	Трехалос 30%	
8 р сарын 29	Трехалос 30%	
8 р сарын 30	Трехалос 30%	хэмжилт
8 р сарын 31	Трехалос 30%	
9 р сарын 1	Трехалос 30%	
9 р сарын 2	Трехалос 40%	хэмжилт
9 р сарын 3	Трехалос 40%	
9 р сарын 4	Трехалос 40%	
9 р сарын 5	Трехалос 40%	
9 р сарын 6	Трехалос 40%	хэмжилт
9 р сарын 7	Трехалос 40%	
9 р сарын 8	Трехалос 40%	

9 р сарын 9	Трехалос 40%	хэмжилт
9 р сарын 10	Трехалос 40%	
9 р сарын 11	Трехалос 40%	
9 р сарын 12	Трехалос 40%	
9 р сарын 13	Трехалос 40%	хэмжилт
9 р сарын 14	Трехалос 40%	
9 р сарын 15	Трехалос 40%	
9 р сарын 16	Трехалос 50%	хэмжилт
9 р сарын 17	Трехалос 50%	
9 р сарын 18	Трехалос 50%	
9 р сарын 19	Трехалос 50%	
9 р сарын 20	Трехалос 50%	хэмжилт
9 р сарын 21	Трехалос 50%	
9 р сарын 22	Трехалос 50%	
9 р сарын 23	Трехалос 50%	хэмжилт
9 р сарын 24	Трехалос 50%	
9 р сарын 25	Трехалос 50%	
9 р сарын 26	Трехалос 50%	
9 р сарын 27	Трехалос 50%	хэмжилт
9 р сарын 28	Трехалос 50%	
9 р сарын 29	Трехалос 50%	
9 р сарын 30	Уусмалаас авсан	хэмжилт
10 р сарын 25	25 хоног хатаалт	

#### ХАВСРАЛТ-4

##### Ашиглагдсан багаж хэрэгсэл

хуванцар сав	ацетон
шилэн сав	гуурсан шүршигч
зөөлөн үстэй бийр	өнгө ялгагч тестер
ширүүн үстэй бийр	ширээний гэрэл
зөөлөн үстэй багс	томруулагч шил
ширүүн үстэй багс	уураар буудагч индүү
чигчлүүр мод	битүүмжлэгч хуванцар сав
чих цэвэрлэгч	түрхэгч саваа мод
хөвөн	үлээгч гуурс
даавуу	хүнсний скоч
техникийн цаас	зөөлөвч уут
ам дарагчтай уут	шүлтлэггүй цаас
мэсний хутга	хэмжилттэй колор

нунтаг шороо	дигитал штангенциркуль
нийлэг цавуу	тасалгааны сэнс
бонд, эпоксид цавуу	гуурсан термометр
трехалос сахар	зөөврийн компьютер
хатаах зуух	суурин компьютер
вакуум үүсгэгч багаж	A4-ийн цаас
элсэн буу	хатуулагтай цаас
нарийн индүү	резинэн бээлий
моторт зүлгүүр	маск
рентген флуоресцент спектрийн багаж	жин хэмжүүр
микроскоп	тугалган цаас
дигитал аппарат	аппаратын хөл
трилон Б	хавчуурга
паралойд	нэрмэл ус
бензотриазол	хүндрүүлэгч
сахар хэмжигч	цаасны хутга
дулаан, чийгшил хэмжигч	цаасан скоч
акрилкан будаг	өөлөвчтөй савх
этанол	уутан бээлий
холигч шил	плитк

ТАЙЛАН БИЧСЭН:

М.ОЮУНТУЛГА Ph.D. СОЁЛЫН БИЕТ ӨВИЙГ  
СЭРГЭЭН ЗАСВАРЛАХ ГАЗРЫН  
ЕРӨНХИЙ ТЕХНОЛОГИЧ

-----oOo-----

## МОДОН ЭЛДЭЛИЙН ТӨРӨЛД ХИЙСЭН БАГАЖИТ ДҮН ШИНЖИЛГЭЭ

### 1 Өмнөтгөл

Уйгурын нийслэл Хар балгас хотын туурь Ордон худгаас илрүүлсэн модон эдлэл дээр модны эсийн онцлогоор модны төрөл тогтоох шинжилгээг хийсэн. Малтлагаас илэрсэн модон эдлэлийн гол эсийн нэгдэл целлюлоз гэгдэх генийн бүтцээр тодорхойлдог. Мод нь цэцгийн тоосонцор болон чулуужсан материалыг бодвол хөдөлгөөн багатай учир ойр орчмын ургамалжилтыг тодорхойлох, модны төрлийг тогтооход дөхөм болдог.

### 2 Материал болон арга зүй

Уйгурын нийслэл Хар балгас хотын туурь Ордон худгаас илрүүлсэндээж авах боломжтой 36ш модны төрлийг тогтоосон. Дээжийг нимгэн дээж бэлдцийн хутгаар модны хөндлөн цагирган огтлол, босоо цагирган огтлол, тангенцал огтлол гэсэн 3 хэрчилтийг 0.03мм зузаанд хэрчиж, суурь шилэн дээр тавин Mount-Quick“Aqueous” төрлийн усанд хатах чадвартай цавуугаар таг шилийг дээрээс нь нааж бэлдсэн. Бэлдсэн дээжийг ОРТИННОТО-2 : Nikon загварын эсийн микроскоп ашиглан 40-өөс 1000 дахин томруулж модны бүтцийн шинж чанарыг бодит сорьцтой харьцуулж төрлийг тодорхойлсон.

### 3 Үр дүн

Доорх хүснэгт 1 дээр модны төрлийг, зураг 1 дээр бүтцийн онцлогийг харуулсан микроскопын зураглалыг хавсаргав.

**3.1 Abies** буюу жодоо нь усны суваг болон зөөлөн босоо цагирган цацраг эсээс бүрддэг шилмүүст төрлийн мод юм. Модны ургаж буй цагиргийн төлжилт нь цагиргийн төлжилт зогсох хүртлээ аажимаар явагддаг. Босоо цагирган эсийн хананы нүх нь жижиг хуш модны төрөлтөй төстэй бөгөөд 1 талбайд 1-ээс 4 ширхэг нүхэн бөмбөлөг байдаг. Босоо цагирган эсийн хана нь зузаан дугуй хэлбэртэй ажиглагддаг. Цагирган эсийн хөндлөн хана нь нэг эгнээнд ижил төрлийн цагирган эсийн хана үүсгэдэг. Эдгээр шинж тэмдгээр жодоо модны төрлийг тогтоосон бөгөөд жодоо мод нь манай орны нөхцөлд дунджаар 2025 м өндөр, 60см хүртэл бүдүүн ургадаг мөнх ногоон шилмүүст мод. Жодоо нь 200 гаруй жил насалдаг. Ургах орчин тохиромжтой нөхцөлд 40 м хүртэл өндөр, 36 см хүртэл бүдүүн ургана. Сибирь жодооны холтос нь гялгар бараан саарал, сууриасаа эхэлсэн хурц шовгор цацархуу титэмтэй. Шилмүүс нь 2,5-3 см хүртэл урт, мохоо эсвэл үзүүртэй оньтой.

**3.2 Larix** буюу шинэс нь усны суваг болон зөөлөн босоо цагирган цацраг эс болон босоо хэвтээ гэсэн давирхай ялгарах эсийн сувгийг тойрсон эпицерийн эсүүдээс бүрддэг шилмүүст мод юм. Модны ургаж буй цагиргийн төлжилт нь цагиргийн төлжилт зогсох хүртлээ аажимаар явагддаг. Босоо төрлийн давирхайн суваг ажиглагддаг. Босоо цагирган эсийн хананы нүх нь гацуур болон сурress модны төрөлтөй төстэй бөгөөд 1 талбайд 3-аас 5 ширхэг нүхэн бөмбөлөг байдаг. Цагирган цацрагийн хоолой

нь цоорхойтой байдаг. Хэлбэр нь линз хэлбэртэй бөгөөд тоо нь цөөхөн байдаг. Цагирган эсийн хананд нэг эгнээндээ 1-ээс 20 ширхэг эстэй, хэвтээ хэлбэрийн давирхай ялгаруулах эс нь зууван хэлбэртэй байдаг. Эдгээр шинж тэмдгээр шинэс модны төрлийг тогтоосон бөгөөд шинэс модны аймагт улаан нарс, сибирийн нарс зэрэг орно. Сибирь шинэс нас гүйцсэн үедээ 24-26 м дундаж өндөртэй, 26-28 см бүдүүнтэй байдаг.

Нэг настай найлзуурын холтос цайвар саарал өнгөтэй, нилээд хөгшин найлзуурын холтос саарал-хүрэндүү, хуучирсан ишин дээрх холтос нь зузаан, гүнзгий хагаралтай, саарал бараан өнгөтэй бөгөөд шилмүүсний урт нь 13-45 мм, өргөн 1-2 мм, цайвар ногоон өнгөтэй ба богиносон найлзуур дээр шилмүүс 25-50 ширхэгээр багц үүсгэн гардаг. Ургах орчины хувьд сибирь шинэс нь гэрэлсэг, ган, хүйтэнд тэсвэртэй - 500 С ба түүнээс дээш хүйтнийг тэсвэрлэдэг тул манай оронд далайн түвшинөөс дээш 2400-2650 м өндөрт ургадаг.

Тархалтын хувьд сибирь шинэс нь манай орны Хэнтий, Хангай, Хөвсгөл, Монгол Алтайн нуруу, Монгол дагуурын нуруунд шинэсэн ойг бүрдүүлэн тархан ургадаг.

**3.3** *Betula* буюу хус нь жижиг бөөрөнхий хэлбэрийн усны суваг болон ганц эсвэл хэд хэдэн чиглэлд нийлсэн, босоо цагиргийн дагуу гадагш чиглэн үүссэн байдаг. Гуурсан хоолойнууд нь шатлаж цоорсон нүхтэй, шаталсан тоо нь цөөхөн ба 10-аад ширхэг шаталсан нүхний хоорондын зай нь 1 ширхэг нүхний зайны хэмжээтэй байдаг онцлогтой. Цагирган эсийн хөндлөн хана нь нэг эгнээнд ижил төрлийн цагирган эсийн хана үүсгэдэг хэдийч дээд доод идэвхтэй эсүүд нь дөрвөлжин хэлбэртэй, цагирган эсийн зузаан 1-ээс 3 эсийн өргөнтэй харилцан адилгүй байдаг. Эдгээр шинж тэмдгээр хус модны төрлийг тогтоосон бөгөөд хус нь дунджаар 13-18 метр өндөр ургадаг. Ургах орчны сайн нөхцөлд 18 метр хүрдэг ба хусны дундаж наслалт нь 54 жил байдаг.

Холтос нь цагаан өнгөтэй, үйсний дотор тал нь хүрэн, модлог нь цагаан зөөлөн шинж чанартай байдаг. Хусны навч өргөн өндгөрхүү буюу гурвалжин өндгөрхүү, богино шовх үзүүртэй, хөрөөн шүдлэгтэй. Навч 4-5 хажуугийн судалтай. Навчны дээд тал нь гялгар ногоон, доод тал нь цайвар ногоон, тод судалтай бөгөөд ургах орчин нь чийглэг, хөнгөн хөрсөнд сайн ургадаг. Хус нь далайн түвшинөөс дээш 600-1200 метр өндөрт зохицон ургадаг. Хус нь нарсан ой, нарс шинэсэн ой, шинэсэн ойн орчинд элбэг ургаж, цаг уурын эрс тэс янз бүрийн орчинд зохицон ургах чадвар сайн байдаг.

Тархалтын Хэнтийн баруун хойд талд нилээд тархалттай. Нарс хус, шинэс хусан холимог ой үүсгэхээс гадна заримдаа цэвэр хусан зураа үүсгэдэг. Хангайд хус улиангаран холимог ой тохилдоно. Хэнтийн нурууны төв, баруун, зүүн хэсэгт, Хангайн нурууны зүүн ба зүүн өмнөд, баруун хэсэгт нилээд тохиолддог.

**3.4** *Bambusoideae* буюу хулсны зөөлөн эс болон судаслаг суваг, судаслаг сувагны бүрхүүл нь цагиргын тэнхэлгийн чиглэлд жигд үүссэн бүтэцтэй байдаг шинжээр нь шууд таних боломжтой байдаг. Хулсны аймагт *madake*, *medaka*, *sasa* төрөл зүйлүүд ордог.



#### 4 Ажиглалт

Модон эдлэлийн дийлэнх хувийг шинэс төрлийн мод эзэлж байна. Шинэс мод нь өө сэв багатай шулуун, удаан эдэлгээтэй, шилмүүст модон дотроо хамгийн хатуу шинж чанартай байдаг. Модны гадаргуу нь барзгар хэдийч модны ширхэг нь сайн харагддаг. Модыг хатааж бэлтгэх явцад модны гол хэсгийг салгаж хатаахгүй бол үндсэн их биед хагарал, цуурал өгч модыг мушгиж агшилт өгөн, модны гадаргууд хар толбо үүсгэх эрсдэл өндөр байдаг. Гол төлөв барилгын материал, усан онгоц, тоног хэрэгсэлхийх гэх мэтэт өргөн ашигладаг. Японд шинэсний бие даасан төрөл зүйл байдаг хэдийч Монгол оронд сибирийн шинэс зонхилон ургадаг. Монгол нутгаас археологийн малтлагаар илэрч буй модон эдлэлийн дийлэнх нь шилмүүст, шинэс төрлийн мод байдаг нь олдоц сайтай эдэлгээ даадаг, сайн чанарын хатуулаг шинжтэй учраас эрт үеэс хэрэглээнд өргөн хэрэглэгддэг байжээ. Жодоо модны хувьд Монголд эрт үеэс ажиглагдаж ирсэн ба сибирь болон евроазийн бүсээс эхлэлтэй бөгөөд тайгын гол бүрэлдэхүүн хэсэг юм. Энэ модны төрөл зүйл нь ялзрал багатай, хадгалалтын байдал тогтвортой хэдийч хөнгөн зөөлөн учир эдэлгээ даах чадвар муутай байдаг.


Хөндий болон зөөлөн налуу, үржил шимтэй газар зонхилон ургадаг. Ихэвчлэн байшингийн дотоод засал чимэглэл, шавьжны нөлөөнд орохдоо удаан учир хоол хүнсний сав, Япон улсад зарим тохиолдолд модны цагаан өнгийг тэр хэвээр нь ашиглан суварга хийсэн жишээ байдаг. Хус модыг мөн өргөн ашигласаар ирсэн. Зэр зэвсэг, сав суулга, гоёмсог хальсыг нь ашиглаж гоёл чимэглэл хийх зэргээр ахуйн хэрэглээнд өргөн хэрэглэдэг. Хулс модны хувьд Монгол оронд ургадгүй боловч археологийн малтлага судалгаагаар өргөн тархацтай олддог. Тиймээс эрт үеэс Хятад болон гадны бусад орноос хулс модыг авчирч хэрэглээндээ нэвтрүүлсэн байна. Хулс нь дулаан, чийглэг бүс нутагт ургах чадвартай байдаг. Монгол орон нь сэрүүн бүс бүслүүрт ордог учраас хүйтэн цаг уурт тэсвэртэй шилмүүст болон навчит төрлийн моднууд ургадаг онцлогтой.

Хүснэгт 1 Модны төрөл зүйн жагсаалт

№	Үр дүн (нэршил)		тэмдэглэл
024	<i>Larix</i>	шинэс	
029	<i>Abies</i>	жодоо	Хөндлөн зүсэлтгүй, урт том хэсэг
030 1	<i>Larix</i>	шинэс	
030 2	<i>Larix</i>	шинэс	
030 3	<i>Larix</i>	шинэс	
032	<i>Larix</i>	шинэс	
033	charcoal fragments	Карбонатлаг	
034	<i>Larix</i>	шинэс	
038	Bambusoideae	хулс	Хөндлөн огтлол

039	<i>Abies</i>	жодоо	
040	<i>Betula</i>	хус	
043	<i>Betula</i>	хус	хар лакан эдлэл
047	<i>Lagenaria siceraria</i> Standl.	цагаан будаа	хагархай хэсэг
052	<i>Abies</i>	жодоо	хар лакан бүрхүүл хэсэг
097	<i>Betula</i>	хус	бөмбөлөг
103 1	<i>Larix</i>	шинэс	
103 2	<i>Betula</i>	хус	
106	<i>Larix</i>	шинэс	
107	charcoal fraguments	Карбонатлаг	
108	<i>Larix</i>	шинэс	
109	<i>Larix</i>	шинэс	
109	<i>Larix</i>	шинэс	
113 1	<i>Larix</i>	шинэс	
113 2	<i>Larix</i>	шинэс	
115	<i>Larix</i>	шинэс	
116	<i>Larix</i>	шинэс	
118	<i>Larix</i>	шинэс	
119	<i>Larix</i>	шинэс	
120	<i>Larix</i>	шинэс	
126	<i>Betula</i>	шинэс	
127	<i>Larix</i>	шинэс	
128	<i>Larix</i>	шинэс	
129	<i>Larix</i>	шинэс	
131 1	<i>Larix</i>	шинэс	
131 2	<i>Larix</i>	шинэс	
133	<i>Larix</i>	шинэс	

зураг 1 Модны бүтцийн онцлог



ТАЙЛАН БИЧСЭН:  
М.ОЮУНТУЛГА Ph.D. СОЁЛЫН БИЕТ ӨВИЙГ  
СЭРГЭЭН ЗАСВАРЛАХ ГАЗРЫН  
ЕРӨНХИЙ ТЕХНОЛОГИЧ

-----oOo-----

# **АЙРАГИЙН ГОЗГОР ХЭМЭЭХ ГАЗРААС АРХЕОЛОГИЙН МАЛТЛАГА, СУДАЛГААГААР ИЛЭРСЭН ОЛДВОР ЭД ӨЛГИЙН ЗҮЙЛД ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТ, БЭХЖҮҮЛЭЛТ СЭРГЭЭН ЗАСВАР ХИЙСЭН ТАЙЛАН**

## **1.Өмнөтгөл**

Орхон аймгийн Айрагийн гозгорын дурсгал газарт Монголын үндэсний музейн 2019 онд Хятадтай хамтарсан археологийн малтлага судалгаагаар илэрсэн олдворуудад хадгалалт хамгаалалт, бэхжүүлэлт, сэргээн засварын ажлыг хийсэн.

Мөн оны 8-р сард тус дурсгал дээр хээрийн сургалт-дадлага зохион байгуулж, эрс тэс уур амьсгалтай монгол орны нутаг дэвсгэрээс илэрч буй органик болон металл эдлэлийг археологийн малтлагын талбайд хэрхэн хадгалж хамгаалах, тохирсон орчин нөхцөл бүрдүүлэх, анхан шатны цэвэрлэгээ хийх, зориулалтын сав баглаа боодол ашиглан зөөж тээвэрлэх, мөн хээрийн лабораторид ашиглагдах багаж, бодис хэрэглэгдхүүнтэй танилцах, талаар зөвөлгөө өгч газар дээр нь ажилсан. Тус сургалтад хэрэгжүүлсэн богино хугацааны хадгалалт хамгаалалт, сав баглаа боодол хийх арга зүйг ашиглан хээрийн нөхцөлд олдворуудыг анхны төрх байдлаар нь гэмтээлгүй амжилттай хотруу зөөж тээвэрлэн 9-р сард дугаар бүхий 36ш олдворыг СӨҮТ-д хүлээлгэн өгсөн. Олдворын төрөл зүйл нь алтан эдлэл 1ш: Au, хүрэл эдлэл 8ш: Cu, алтан шармал хүрэл эдлэл 1ш: Au-Cu, төмөр эдлэл 3ш: Fe, сувсан эдлэл 9ш, ясан эдлэл 5ш, тааран суурь, хүрэл амсар бүхий лакан аяга 1ш: Au-Hg, вааран эдлэл 5ш, шавар эдлэл 1ш, даавуу эдлэл 1ш, модон эдлэл 1ш тус тус байсан.

## **2.Олдворын ерөнхий хадгалалтын байдал**

Энэхүү дурсгал нь тал хээрийн бүсэд хамаарах бөгөөд хөрсний зүсэлтийн бичиглэлээс харахад уулын бэл дов сондуул, уулын ар энгэр ургамлан бүрхүүлтэй, морфологийн бичиглэлээс харвал хар шар хүрэн өнгөтэй, хөнгөн, шавранцар, нарийн ширхэгтэй хөрс зонхилно. Хөрсний урвалын орчин сул хүчиллэг орчин зонхилсон. Хөрсний давсжилтын зэрэглэлээр үзвэл давсжилтгүй ангилалд ордог учир хөндий бунхан хэлбэрт өндөр чийгшил, сэрүүн, агаарын урсгал багатайгаас шалтгаалж хадгалагдаж байгаа олдворууд харьцангуй сайн хадгалагдаж үлдсэн байдаг. Гэвч байгалийн болоод хүний хүчин зүйлийн нөлөөллөөс хөрсний нуранга үүсч шороонд дарагдсан органик. металл олдворууд өндөр чийглэг хөрсний нөлөөнд олон зуун жил нян бактерт идэгдэж өгөршилт болон зэврэл явагдаж муудсан байдалтай олддог. Газрын гадаргаас доош дунджаар 5-аас 6-н метрийн гүнд 5-аас 10°C-н хэмд, 90%-н чийгшилд агаарыг урсгал багатай тогтвортой орчиноос илэрдэг.

## **3.Хадгалалт хамгаалалт, бэхжүүлэлтийн зорилго**

Тал хээрийн бүсээс илэрч буй усны агууламж багатай модон эдлэл металл болон бусад олдворын анхны эх төрхийг хадгалж тэр хэвээр нь удаан хугацааны хадгалалт хамгаалалт, бэхжүүлэлтийг хийж, эсийн бүтцийн гэмтлийн бат бөх байдлыг

тогтворжуулах, хийгдэх боломжтой материал судлал дээр багажит дүн шинжилгээ хийх зорилготой юм.

#### **4. Алтан эдлэлийн хадгалалт хамгаалалт**

Олдворын дугаар АГ14-№5 2 ширхэг нимгэн алтан товрууны 1 нь цуурал өгч урагдаж ангайсан байдалтай, шороон бохирдолтой, хадгалалт дунд зэрэгтэй байсан.

**4.1 Au:** Алтаар хийсэн материал учраас төмөр болон хүрэл эдлэлийг бодвол маш сайн эдэлгээ даадаг учир орчны нөлөөнд хэр баргийн хими болон биологийн гэмтэлд орж муудах эрсдэл бага байдаг. Тиймээс зурган баримтжуулалт хийсний дараа гадаргуун механик болон хими цэвэрлэгээ хийж, гадаргуу хэсгийг бэхжүүлэх ажилбар хийсэн.

#### **4.2 Олдворын цэвэрлэгээ**

Энэхүү ажилбар нь бэхжүүлэлт, сэргээн засвар хийхийн өмнөх ажилбар бөгөөд гадаргууг цэвэрлэснээр тухайн олдворын эх төрх байдал, хэлбэр хэмжээ, хээ угалз дүрслэл байгаа эсэх гэх мэт мэдээллийг авах боломжтой болдог. Гэвч гадаргуун бохирдол бүхий шороо, зэврэлийн тогтоц нь зарим тохиолдолд уг олдворын үндсэн эх биеийг барих үүрэг гүйцэтгэж байдаг учир гадаргуун цэвэрлэгээг олдворын хадгалагдаж үлдсэн ерөнхий шинж нөхцөл, онцлогт нь тааруулж бүрэн ба бүрэн бус хэлбэрээр явуулах нь зүйтэй. Уг олдворын гадаргууг бийр, хутга ашиглан арилгаж, гүн бохирдлыг этанолийн  $C_2H_5OH$  уусмалаар цэвэрлэсэн.

#### **4.3 Бэхжүүлэлт**

Гадаргууг бүрэн цэвэрлэж дууссаны дараа Acryloid B-72 (Obsolete) буюу паралойд бэхжүүлэгч бодисыг 3%-иар ацетонд  $C_3H_6O$  найруулан гадаргуу хэсэгт 3 удаа бийр ашиглан түрхлэг хэлбэрээр бэхжүүлсэн.

#### **5.Хүрэл эдлэлийн хадгалалт хамгаалалт**

Олдворын дугаар АГ97-№6 хүрэл цагираг, АГ97-№13 хүрэл арал, АГ97-№19 хүрэл арал, АГ97-№8 хүрэл цагираг, АГ97-14 хүрэл унжлага, АГ97-18 хүрэл унжлага, АГ45-8 бүсний хүрэл чимэглэл , АГ96-4 хүрэл чимэг, хавтгай суурьтай бөмбөгөр оройтой олдворууд дээр хүрэл эдлэлийн хадгалалт хамгаалалт, бэхжүүлэлтийн ажлыг хийсэн. Олдворуудын нийт гадаргуу хэсгүүд жигд хүрлийн өвчлөл буюу ногоорч зэвэрсэн байдалтай, зарим хэсгүүд нь толбот төрлийн физик хөнөөлт шинжид орсон тогтворгүй орчинд хурдан хугацаанд зэвэнд идэгдэх чийгний төрлийн хөх ногоон өнгийн физик хөнөөлт шинж ихтэй өвчлөлд орсон байдалтай байсан.

Хүрэл эдлэлийн хадгалалт хамгаалалт сэргээн засвар хийх ажлын үндсэн дараалалд  
-Баримтжуулалт


- Цэвэрлэгээ
- Зэврэлтийг зогсоох
- Бэхжүүлэлт
- Сэргээн засварлах
- Баримтжуулалт
- сав баглаа боодол хийх арга зүйн дарааллаар хийдэг

### 5.1 Баримтжуулалт

CANON 2 T2i болон OLYMPUS-ToughF 2 загварын дижитал аппарат, KODAK Color ашиглаж хадгалалтын өмнөх ба дараах болон хадгалалт хамгаалалт, бэхжүүлэлтийн явцын зургыг авч баримтжуулсан.

### 5.2 Цэвэрлэгээ

Хүрэл олдворуудыг эхний ээлжинд мэсийн хутга, бийр, багс, чигчлүүр мод, моторт зүлгэгчийг ашиглан механик цэвэрлэгээнд оруулж гадаргууны зэвний хэсгүүд, шороо, жижиг чулуунуудыг цэвэрлэж дууссаны дараа химийн цэвэрлэгээ буюу трилон Б-EDTA 1%, нэрмэл ус 99%-ийн уусмалаар гадаргуун зэвний ногоорлыг арилгах зорилгоор 3 цаг уусмалд байлгаж, 30 минут тутамд уусмалаас гаргаж хөвөн болон техникийн цаасаар гадаргууд ялгарсан зэвний ногооныг цэвэрлэсэн.



Зураг 2: трилон Б-EDTA 30 минут

Зураг 3: трилон Б-EDTA 1 цаг

### 5.3 Зэврэлтийг зогсоох

Хүрэл эдлэлийн зэврэлтийг зогсоолгүй гадаргуун бэхжүүлэлт хийх нь богино хугацаанд дотроосоо зэврэл явагдах нөхцөлийг бүрдүүлдэг. Тиймээс зэвний физик хөнөөлийн үүсгэвэрийг бензотриазол  $C_6H_5N_3$  -3%, этанол  $C_2H_5OH$  97%-ийн уусмалд 10 хоног байлгаж, уусмалаас гаргаж 3 хоног, дунджаар 25 градусын тасалгаанд тасалгаанд хатааснаар бүрэн устгасан.



Зураг 4: бензотриазол 5 дахь өдөр



Зураг 5: хатаалт 5 дахь өдөр

#### 5.4 Бэхжүүлэлт

Зэврэлтийг зогсоосон хэдий ч чийгшил дулааны хэлбэлзэлтэй орчинд хүрэл эдлэл нь тогтворгүй орчны нөлөөнөөс дахин урвалд орж зэврэл үүсэх магадлал өндөр байдаг. Тиймээс олдворын сийрэгжсэн гүний нүх сүв, гадаргуун эмзэг давхаргыг бэхжүүлэгч бодисоор дүүргэх шаардлагатай байдаг. Олдворын гүнлүү бэхжүүлэгчийг сайн хийхийн тулд агаарын даралтыг ашиглах зорилгоор вакуум үүсгэх төхөөрөмжинд паралойд В72-10%, ацетон С<sub>3</sub>Н<sub>6</sub>О-90%- ийн уусмалд олдворыг 20 минутын хугацаагаар 3 удаа бэхжүүлэгчийг татуулж, 3 хоног дунджаар 25 градусын тасалгаанд хатаасан.



Зураг 6: В72-10%



Зураг 7: хатаалт

#### 5.5 Сэргээн засварын ажилбар

Эдгээр олворын хувьд хугарч халцарсан гэмтэлгүй учраас нөхөх, наах, будах зэрэг сэргээний ажилбар хийх шаардлагагүй болно.

#### 5.6 Баримтжуулалт

CANON 2 T2i загварын дижитал аппарат, KODAK Color ашиглаж бэхжүүлэлтийн дараах зургыг авч баримтжуулсан.

## 5.7 Сав баглаа боодол

Хадгалалтын тогтвортой орчин бүрдүүлэх анхан шатны арга зүй нь олдворын сав баглаа боодлыг ус чийг болон агаарын урсгалаас тусгаарлаж, хайрцагны материалаас үүсэлтэй хүчлүүдээс тусгаарлах зорилгоор хүчил шүлтлэггүй цаасанд боох шаардлагыг хангаж боосон. Мөн зөөж тээвэрлэх үед доргилтоос үүсэх эрсдэлийг хязгаарлаж зөөлөвч хийсэн.

## 6. Алтан шармал хүрэл эдлэлийн хадгалалт хамгаалалт

Олдворын дугаар АГ45-№6 алтан шармал хүрэл эдлэлийн хадгалалт хамгаалалт, бэхжүүлэлтийн ажлыг хийсэн. Олдворуудын нийт гадаргуу хэсгүүд жигд хүрлийн өвчлөл буюу ногоорч зэвэрсэн байдалтай, зарим хэсгүүд нь толбот төрлийн физик хөнөөлт шинжид орсон шороон гадарга үүсч тогтворгүй орчинд хурдан хугацаанд зэвэнд идэгдэх чийгний төрлийн хөх ногоон өнгийн физик хөнөөлт шинж ихтэй өвчлөлд орсон байдалтай байсан. Олдворын ар хэсэгт түгжээ бүхий модон хэсэг нь дунд зэргийн хадгалалттай үлдсэн байсан.

### 6.1 Баримтжуулалт

CANON 2 T2i загварын дижитал аппарат, KODAK Color ашиглаж хадгалалтын өмнөх зургыг авч баримтжуулсан.

### 6.2 Цэвэрлэгээ

Олдворыг эхний ээлжинд мэсийн хутга, бийр, багс, чигчлүүр мод, моторт зүлгэгчийг ашиглан механик цэвэрлэгээнд оруулж гадаргууны зэвний хэсгүүд, шороо, жижиг чулуунуудыг цэвэрлэж дууссаны дараа химийн цэвэрлэгээ буюу трилон Б-EDTA 1%, нэрмэл ус 99%-ийн уусмалаар гадаргуун зэвний ногоорлыг арилгах зорилгоор 3 цаг уусмалд байлгаж, 10 минут тутамд уусмалаас гаргаж хөвөн болон техникийн цаасаар алтны гадаргууд ялгарсан зэвний ногоорлыг цэвэрлэж, алтны өнгийг гаргасан.



Зураг 8: трилон Б-EDTA



Зураг 9: трилон Б-EDTA 30 минут





Зураг 10: зэвний хөвөн цэвэрлэгээ      Зураг 11: зэвний мэсэн цэвэрлэгээ

### 6.3 Зэврэлтийг зогсоох

Алт нь бусад металтай харьцуулбал харьцангуй бат бөх чанартай байдаг учраас бэхжүүлэх шаардлагагүй байдаг. Тиймээс хүрэл эдлэлийн зэврэлийг зогсоох зорилгоор бензотриазол  $C_6H_5N_3$  -3%, этанол  $C_2H_5OH$  97%-ийн уусмалд 7 хоног байлгаж, уусмалаас гаргаж 10 хоног 25 градусын тасалгаанд тасалгаанд хатааснаар бүрэн устгасан.



Зураг 12: бензотриазол 5 дахь өдөр

### 6.4 Бэхжүүлэлт

Паралойд В72-5%, ацетон  $C_3H_6O$ -95%- ийн уусмалд олдворын гадаргууг бийрний тусламжтай түрхлэг хэлбэрээр бэхжүүлж 3 хоног, дунджаар 25 градусын тасалгаанд хатаасан. Модон жижиг хэсэг нь хаталттай учраас Паралойд В72-3%, ацетон  $C_3H_6O$ -97%- ийн уусмалаар мөн адил хэлбэрээр бэхжүүлсэн.



Зураг 13: В72-3%-ийн эхний түрхлэг      Зураг 14: В72-3%-ийн 6 дахь түрхлэг

## 6.5 Сэргээн засварын ажилбар

Олворын хувьд хугарч халцарсан гэмтэлгүй учраас нөхөх, наах, будах зэрэг сэргээний ажилбар хийх шаардлагагүй болно.

## 6.6 Баримтжуулалт

CANON 2 T2i загварын дижитал аппарат, KODAK Color ашиглаж бэхжүүлэлтийн дараах зургыг авч баримтжуулсан.

## 6.7 Сав баглаа боодол

Ус чийг болон агаарын урсгалаас тусгаарлаж, хайрцагны материалаас үүсэлтэй хүчилүүдээс тусгаарлах зорилгоор хүчил шүлтлэггүй цаасанд боох шаардлагыг хангаж боосон. Мөн зөөж тээвэрлэх үед доргилтоос үүсэх эрсдэлийг хязгаарлаж зөөлөвч хийсэн.

## 7. Төмөр эдлэлийн хадгалалт хамгаалалт

Олдворын дугаар АГ97-№21 төмөр зэвний хугархай, АГ97-№23 төмөр арлын үлдэгдэл, АГ96-№7 төмөр арлын үлдэгдэл дээр хадгалалт хамгаалалт, бэхжүүлэлтийн ажлыг хийсэн. Олдворуудын нийт гадаргуу хэсгүүд жигд зэвэрсэн байдалтай, зарим хэсгүүд нь шороон гадарга үүсч хуяглаж давхрага үүссэн байдалтай байсан.

### 7.1 Баримтжуулалт

CANON 2 T2i загварын дижитал аппарат, KODAK Color ашиглаж хадгалалтын өмнөх зургыг авч баримтжуулсан.

### 7.2 Цэвэрлэгээ

Олдворуудыг эхний ээлжинд мэсийн хутга, бийр, багс, чигчлүүр мод, моторт зүлгэгчийг ашиглан механик цэвэрлэгээнд оруулж гадаргууны зэвний хэсгүүд, шороо, жижиг чулууны цэвэрлэж дууссаны дараа моторт элсний буугаар гадаргуун гүн бохирдол, хучигдсан хэсгүүдыг цэвэрлэсэн.



Зураг 15: элсэн буу




Зураг 16: сумны зэвний цэвэрлэгээ

### 7.3 Зэврэлтийг зогсоох, давсгүйжүүлэх

Төмөр эдлэлийн зэврэлийн гол шалтгаанд он удаан жил хөрсний найрлагаас татаж авсан эрдэс давс нь гол нөлөө үзүүлдэг. Тиймээс археологийн малталгаас илэрсэн төмөр олдворын гүн бохирдлыг натрийн сескикарбонат дигидрат  $\text{Na}_2\text{H}(\text{CO}_3)_2 \cdot 2\text{H}_2\text{O}$  ашиглан уусмалын аргаар давсгүйжүүлэх арга зүйг хэрэглэдэг. Энэ удаагын төмөр эдлэлүүд нь хар хүрэн өнгийн зэврэл зонхилсон, давсны нөлөө багатай орчноос илэрсэн учраас давсгүйжүүлэлтийг хийх шаардлагагүй байсан.

### 7.4 Бэхжүүлэлт

Вакум үүсгэх төхөөрөмжинд паралоид В72-10%, ацетон  $\text{C}_3\text{H}_6\text{O}$ -90%- ийн уусмалд олдворыг 20 минутын хугацаагаар 3 удаа бэхжүүлэгчийг татуулж, 3 хоног дунджаар 25 градусын тасалгаанд хатаасан.



Зураг 17: В72-ийн бэлтгэх байдал



Зураг 18: вакум орчны хөөсрөлт



Зураг 19: В72-ийн түрхлэг



Зураг 20 : олдворын хатаалт

### 7.5 Сэргээн засварын ажилбар

Олдворын хувьд хугарч халцарсан гэмтэлгүй учраас нөхөх, наах, будах зэрэг сэргээний ажилбар хийх шаардлагагүй болно.

## 7.6 Баримтжуулалт

CANON 2 T2i загварын дижитал аппарат, KODAK Color ашиглаж бэхжүүлэлтийн дараах зургыг авч баримтжуулсан.

## 7.7 Сав баглаа боодол

Ус чийг болон агаарын урсгалаас тусгаарлаж, хайрцагны материалаас үүсэлтэй хүчлүүдээс тусгаарлах зорилгоор хүчил шүлтлэггүй цаасанд боох шаардлагыг хангаж боосон. Мөн зөөж тээвэрлэх үед доргилтоос үүсэх эрсдэлийг хязгаарлаж зөөлөвч хийсэн.

## 8. Сувсан эдлэлийн хадгалалт хамгаалалт

Олдворын дугаар АГ96-№6 жижиг хөх сувс, АГ96-№2 хөх сувс, АГ97-№16 шилэн сувс, АГ97-№22 шилэн сувс, АГ97-№15 шилэн сувс, АГ96-№3 чулуун зүүлт гонзгой, АГ97-№9 ромбо хэлбэрийн дөрвөн талт сувс, АГ14А-№3 сувс, АГ45-№9 сувсан дээр хадгалалт хамгаалалт, бэхжүүлэлтийн ажлыг хийсэн. Олдворуудын нийт гадаргуу хэсгүүд жигд шороон гадарга үүсч нимгэн хуяглаж давхрага үүссэн, олдворын материал бүтцийн гэмтэл багатай сайн хадгалагдаж үлдсэн байдалтай байсан.

## 8.1 Баримтжуулалт

CANON 2 T2i загварын дижитал аппарат, KODAK Color ашиглаж хадгалалтын өмнөх зургыг авч баримтжуулсан.

## 8.2 Цэвэрлэгээ

Олдворуудыг эхний ээлжинд бийр, багс, чигчлүүр мод ашиглан механик цэвэрлэгээнд оруулж гадаргууны шороог цэвэрлэж дууссаны дараа этанол  $C_2H_5OH$  99%-ийн уусмалаар химийн цэвэрлэгээ хийсэн.



Зураг 21 : этанолийн цэвэрлэгээ

### 8.3 Бэхжүүлэлт

Вакум үүсгэх төхөөрөмжинд паралоид В72-3%, ацетон  $C_3H_6O$ -97%- ийн уусмалд олдворыг 20 минутын хугацаагаар 1 удаа бэхжүүлэгчийг татуулж, 3 хоног дунджаар 25 градусын тасалгаанд хатаасан.



Зураг 22 : В72-ийн бэлтгэх байдал

### 8.4 Сэргээн засварын ажилбар

Олдворын хувьд хугарч халцарсан гэмтэлгүй учраас нөхөх, наах, будах зэрэг сэргээний ажилбар хийх шаардлагагүй болно.

### 8.5 Баримтжуулалт

CANON 2 T2i загварын дижитал аппарат, KODAK Color ашиглаж бэхжүүлэлтийн дараах зургыг авч баримтжуулсан.

### 8.6 Сав баглаа боодол

Ус чийг болон агаарын урсгалаас тусгаарлаж, хайрцагны материалаас үүсэлтэй хүчлүүдээс тусгаарлах зорилгоор хүчил шүлтлэггүй цаасанд боох шаардлагыг хангаж боосон. Мөн зөөж тээвэрлэх үед доргилтоос үүсэх эрсдэлийг хязгаарлаж зөөлөвч хийсэн.

## 9 Ясан эдлэлийн хадгалалт хамгаалалт

Олдворын дугаар АГ96-№17 гичир наалтын хугархай, АГ97-№5 ясан эдлэл, АГ96-№5 ясан эдлэл, АГ97-№11 ясан савх, АГ14А-№2 ясан хатгуур дээр хадгалалт хамгаалалт, бэхжүүлэлтийн ажлыг хийсэн. Олдворуудын нийт гадаргуу хэсгүүд жигд шороон гадарга үүсч нимгэн хуяглаж давхрага үүссэн, ясны бүтцийн гэмтэл багатай сайн хадгалагдаж үлдсэн байдалтай байсан.

### 9.1 Баримтжуулалт

CANON 2 T2i загварын дижитал аппарат, KODAK Color ашиглаж хадгалалтын өмнөх зургыг авч баримтжуулсан.

## 9.2 Цэвэрлэгээ

Олдворуудыг эхний ээлжинд бийр, багс, чигчлүүр мод ашиглан механик цэвэрлэгээнд оруулж гадаргууны шороог цэвэрлэж дууссаны дараа этанол  $C_2H_5OH$  99%-ийн уусмалаар химийн цэвэрлэгээ хийсэн.

## 9.3 Бэхжүүлэлт

Вакум үүсгэх төхөөрөмжинд паралойд В72-3%, ацетон  $C_3H_6O$ -97%- ийн уусмалд олдворыг 20 минутын хугацаагаар 3 удаа бэхжүүлэгчийг татуулж, 3 хоног дунджаар 25 градусын тасалгаанд хатаасан.



Зураг 23 : В72-ийн бэхжүүлэлт



Зураг 24 : В72-ийн хатаалт

## 9.4 Сэргээн засварын ажилбар

АГ97-№11 олдворын хувьд үзүүр хэсгээрээ хугарсан байсныг бонд эпоксийн төрлийн цавуугаар наасан. Халцарч цуурсан гэмтэлгүй учраас нөхөх, будах зэрэг сэргээний ажилбар хийх шаардлагагүй болно.



Зураг 25 : савхны наалт

## 9.5 Баримтжуулалт

CANON 2 T2i загварын дижитал аппарат, KODAK Color ашиглаж бэхжүүлэлтийн дараах зургыг авч баримтжуулсан.

## 9.6 Сав баглаа боодол

Ус чийг болон агаарын урсгалаас тусгаарлаж, хайрцагны материалаас үүсэлтэй хүчлүүдээс тусгаарлах зорилгоор хүчил шүлтлэггүй цаасанд боох шаардлагыг хангаж боосон. Наалт хийсэн олдворын хувьд доор нь хатуу суурь тавьж боосон ба зөөж тээвэрлэх үед доргилтоос үүсэх эрсдэлийг хязгаарлаж зөөлөвч хийсэн.

## 10. Тааран суурь, хүрэл амсар бүхий лакан аяганы хадгалалт хамгаалалт

Олдворын дугаар АГ45-№ тааран суурь бүхий хүрэл амсартай лакан аяганы хадгалалт хамгаалалт, бэхжүүлэлтийн ажлыг хийсэн. Аяганы хүрэл амсарны нийт гадаргуу хэсгүүд жигд хүрлийн өвчлөл буюу ногоорч, толбот төрлийн физик хөнөөлт шинж ихтэй өвчлөлд орсон байдалтай байсан. Лакан аяганы хувьд ёроол хэсэг нь бүрэн устаж үгүй болсон, тааран суурьтай учир орчны нөлөөнд маш хурдацтай хаталт өгч лакны чийгэнд нөлөөлж агшилт өгсөнөөр гадна болон дотор талын гадаргуун нимгэн лакнуудад хагарал үүссэн байсан.

### 10.1 Баримтжуулалт

CANON 2 T2i болон OLYMPUS-ToughF 2 загварын дижитал аппарат, KODAK Color ашиглаж хадгалалтын өмнөх ба дараах болон хадгалалт хамгаалалт, бэхжүүлэлтийн явцын зургыг авч баримтжуулсан.



Зураг 26 : аяганы ёроол хэсэг



Зураг 27 : амсрын дотор хэсэг



Зураг 28 : аяганы дотор хэсэг

## 10.2 Цэвэрлэгээ

Малтлагын талбай дээр боосон сав баглаа боодлоос нь авах үед маш хурдацтай агшилт өгч байсан учраас усаар чийгтэй цэвэрлэгээ хийж гадаргууд тогтсон шороог арилгасан. Хүрэл амсрыг эхний ээлжинд мэсийн хутга, бийр, багс, чигчлүүр мод, моторт зүлгэгчийг ашиглан механик цэвэрлэгээнд оруулж гадаргууны зэвний хэсгүүд, шороо, жижиг чулуунуудыг цэвэрлэж дууссаны дараа химийн цэвэрлэгээ буюу трилон Б-EDTA 1%, нэрмэл ус 99%-ийн уусмалаар гадаргуун зэвний ногоорлыг арилгах зорилгоор 3 цаг уусмалд байлгаж, 30 минут тутамд уусмалаас гаргаж хөвөн болон техникийн цаасаар гадаргууд ялгарсан зэвний ногооныг цэвэрлэсэн.



Зураг 29 : амсар



Зураг 30 : трилон Б-EDTA 30 минут



Зураг 29 : бийрэн цэвэрлэгээ

## 10.3 Зэврэлтийг зогсоох

Хүрэл амсрын зэвний физик хөнөөлийн үүсгэвэрийг бензотриазол  $C_6H_5N_3$  -3%, этанол  $C_2H_5OH$  97%-ийн уусмалд 10 хоног байлгаж, уусмалаас гаргаж 3 хоног, дунджаар 25 градусын тасалгаанд хатааснаар бүрэн устгасан.

## 10.4 Уусмалын аргаар бэхжүүлэх

Лакан аяга нь нимгэн тааран суурьтайгаас гадна нимгэн лакан гадаргуутай учир орчны нөлөөнд хурдан хугацаанд орж муудаж байсан учир сахарын уусмалд оруулах



бэлтгэл ажлын явц, уусмалд ороод шингэний нөлөөлөл бүхий ачааллыг даалгүй гэмтэх эрсдэлтэй эмзэг байсан учир уусмалын аргаар бэхжүүлэлт хийгээгүй.

### 10.5 Түрхэх аргын бэхжүүлэлт

Аяганы хүрэл амсрын зэврэлтийг паралоид В72-10%, ацетон  $C_3H_6O$ -90%- ийн уусмал ашиглаж бийрний тусламжтай 3 удаагийн давтамжтай түрхэж 3 хоног дунджаар 25 градусын тасалгаанд хатааж бэхжүүлсэн. Аяганы их биеийн тааран материалыг лактай нь хамт эхний ээлжинд трехалос сахарын 72%-ийн уусмалаар түрхлэг хийж, тасалгааны орчинд 7 хоног сахарын талст үүсгэсэн. Сахарын талстаар хучигдсан лакны хэсгүүдийн агшиж, нумарч сөрдийх нь зогсож, сахарын талст хэсгүүдэд орших орон зайн агаарын урсгалын тусламжтай чийгийг ууршуулж багасгасаны дараа сахарын талстыг цэвэрлэж авсан. Паралоид В72-10%, ацетон  $C_3H_6O$ -90%- ийн бэхжүүлэгч уусмалыг ашиглаж тааран хэсгүүдэд түрхэж биежүүлэлт хийн аяганы ерөнхий хэлбэр төрх, лагыг анхны хагарал цуурал хэлбэрээр нь авч үлдэж чадсан.



Зураг 31 : В72-ийн түрхлээ



Зураг 32 : В72-ийн хатаалт



Зураг 33 : сахардсан аяга



Зураг 34 : таарны В72-ийн түрхлээ

### 10.6 Сэргээн засварын ажилбар

Ерөнхий хэлбэрийг авч үлдэсний дараа лакан эдлэлийн хагарч, нумарсан хэсгүүдийг нарийн ажилбар хийх боломжтой гар индүүгээр 80 градусаар халааж тааран суурин дээр лагыг PAOGEN-PP15 төрлийн усан суурьтай цавуугаар нааж эвлүүлсэн.

Цуурч ангайсан хэсгүүдэд бонд эпоксийн төрлийн цавуугаар нөхөлт хийж WENSOR маркийн акрилкийн будгаар өнгө будгын сэргээнийг хийсэн. Амсрын хэсгийг бонд эпоксийн төрлийн цавуугаар нааж залгасан.



Зураг 35 : амсрын наалт



Зураг 36 : лакны наалт



Зураг 35 : аяганы нөхөлт



Зураг 36 : лакны тэнийлгээлт



Зураг 37 : цууралтын нөхөлт

## 10.7 Баримтжуулалт

CANON 2 T2i загварын дижитал аппарат, KODAK Color ашиглаж бэхжүүлэлтийн дараах зургыг авч баримтжуулсан.

## 10.8 Сав баглаа боодол

Ус чийг болон агаарын урсгалаас тусгаарлаж, хайрцагны материалаас үүсэлтэй хүчилүүдээс тусгаарлах зорилгоор хүчил шүлтлэггүй цаасанд боох шаардлагыг хангаж боосон. Мөн зөөж тээвэрлэх үед доргилтоос үүсэх эрсдэлийг хязгаарлаж зөөлөвч хийсэн.

## 11. Вааран эдлэлийн хадгалалт хамгаалалт

Олдворын дугаар АГ14-№1 чимэглэлийн үлдэгдэл, АГ45-№ ваар, АГ96 ваарны хагархай, АГ14-№1 ваарны хагархай, АГ97-№4 ваарны хагархай дээр хадгалалт хамгаалалт, бэхжүүлэлтийн ажлыг хийсэн. Олдворууд шаталт сайтай учраас сайн хадгалагдаж үлдсэн хэдийч хагархай хэсэг болсон, АГ45 дугаартай том ваар нь бөөр хажуу хэсэгтээ босоо хагарал өгч бага хэмжээний гажилт үүссэн байсан.



Зураг 38 : цуурсан хэсэг

### 11.1 Баримтжуулалт

CANON 2 T2i болон OLYMPUS-ToughF 2 загварын дижитал аппарат, KODAK Color ашиглаж хадгалалтын өмнөх ба дараах болон хадгалалт хамгаалалт, бэхжүүлэлтийн явцын зургийг авч баримтжуулсан.

### 11.2 Цэвэрлэгээ

Шаталт сайтай байсан учраас чийгтэй усан цэвэрлэгээг сойз, багс, бийр хэрэглэж гадаргуу болон дотор талын шороо чулууны хэсгүүдийг арилгаж цэвэрлэсэн. Уснаас гаргаж 3 хоног 25 градусын тасалгаанд тасалгаанд хатаасан.



Зураг 39 : бийрний цэвэрлэгээ



Зураг 40 : сойзны цэвэрлэгээ

### 11.3 Сэргээн засварын ажилбар

Ваарны хагархайн эвлэх хэсгүүдийг UHU загварын нийлэг төрлийн цавуугаар нааж, нөхөх хэсгүүдийг бонд эпоксийн төрлийн цавуугаар нөхөлт хийж WENSOR маркийн акрилкийн будгаар өнгө будгын сэргээнийг хийсэн.



Зураг 41 : цууралтын нөхөлт



Зураг 42 : наах ажилбар



Зураг 43 : залгаасны нөхөлт



Зураг 44 : будгийн ажилбар

### 11.4 Баримтжуулалт

CANON 2 T2i загварын дижитал аппарат, KODAK Color ашиглаж бэхжүүлэлтийн дараах зургыг авч баримтжуулсан.

### 11.5 Сав баглаа боодол

Ус чийг болон агаарын урсгалаас тусгаарлаж, хайрцагны материалаас үүсэлтэй хүчлүүдээс тусгаарлах зорилгоор хүчил шүлтлэггүй цаасанд боох шаардлагыг хангаж боосон. Мөн зөөж тээвэрлэх үед доргилтоос үүсэх эрсдэлийг хязгаарлаж зөөлөвч хийсэн.

## 12.Шавар эдлэлийн хадгалалт хамгаалалт

Олдворын дугаар АГ45 шавар вааранд хадгалалт хамгаалалт, бэхжүүлэлтийн ажлыг хийсэн. Шаталт муутай учраас маш эмзэг, хүрэх төдийд бутарч гэмтсэн байдалтай байсан.



*Зураг 45 : савлагдсан байдал*

### 12.1 Баримтжуулалт

CANON 2 T2i болон OLYMPUS-ToughF 2 загварын дижитал аппарат, KODAK Color ашиглаж хадгалалтын өмнөх ба дараах болон хадгалалт хамгаалалт, бэхжүүлэлтийн явцын зургыг авч баримтжуулсан.

### 12.2 Цэвэрлэгээ

Шаталт муутай учраас чийгтэй усан цэвэрлэгээ хийх боломжгүй байсан. Тиймээс хуурай цэвэрлэгээг сойз, багс, бийр хэрэглэж гадаргуу болон дотор талын шороо чулууны хэсгүүдийг арилгаж цэвэрлэсэн.



*Зураг 46 : цуурсан байдал*



*Зураг 47 : цууралтаас үүдэлтэй хуваагдал*

### 12.3 Сэргээн засварын ажилбар

Малтлагын талбай дээр бэхжүүлж боосон гипсийг авч задлах үед хэт эмзэг, түүхий шавар учраас хагарал үүсч 3 хэсэг болон хагарсан. Паралойд В72-10%, ацетон С<sub>3</sub>Н<sub>6</sub>О-90%- ийн уусмал ашиглаж бийрний тусламжтай суларсан шавар хэсгүүдийг бэхжүүлэн биежүүлсний дараа хуваагдсан хэсгүүдийг UHU загварын нийлэг төрлийн цавуугаар нааж, нөхөх хэсгүүдийг бонд эпоксийн төрлийн цавуугаар нөхөлт хийж WENSOR маркийн акрилкийн будгаар өнгө будгын сэргээнийг хийсэн.



Зураг 48: В72-ийн бэхжүүлэлт



Зураг 49 : наах ажилбар



Зураг 50 : будгийн ажилбар

### 12.4 Баримтжуулалт

CANON 2 T2i загварын дижитал аппарат, KODAK Color ашиглаж бэхжүүлэлтийн дараах зургыг авч баримтжуулсан.

### 12.5 Сав баглаа боодол

Ус чийг болон агаарын урсгалаас тусгаарлаж, хайрцагны материалаас үүсэлтэй хүчлүүдээс тусгаарлах зорилгоор хүчил шүлтлэггүй цаасанд боох шаардлагыг хангаж боосон. Мөн зөөж тээвэрлэх үед доргилтоос үүсэх эрсдэлийг хязгаарлаж зөөлөвч хийсэн.

### 13. Даавуун эдлэлийн хадгалалт хамгаалалт

Олдворын дугаар АГ45 нэхмэл даавуун эдлэлд хадгалалт хамгаалалт, бэхжүүлэлтийн ажлыг хийсэн. Даавууний үндсэн материал хатуулаг шинжээ алдаж өгөршин, хуниралдаж шороогоор хучигдсан байдалтай хэсэг даавуунууд байсан.

#### 13.1 Баримтжуулалт

CANON 2 T2i болон OLYMPUS-ToughF 2 загварын дижитал аппарат, KODAK Color ашиглаж хадгалалтын өмнөх ба дараах болон хадгалалт хамгаалалт, бэхжүүлэлтийн явцын зургыг авч баримтжуулсан.

#### 13.2 Цэвэрлэгээ

Зөөлөн үстэй бийрээр хуурай болон усан цэвэрлэгээ хийж, этанол  $C_2H_5OH$  99%-ийн уусмалаар бийрэн түрхлэг хийж тэнийлгэх ажилбар хийсэн.



Зураг 50 : тэнийлгэх ажилбар



Зураг 51 : чийглэх ажилбар

#### 13.3 Бэхжүүлэлт

Паралойд В72-3%, ацетон  $C_3H_6O$ -97%-ийн уусмал ашиглаж бийрний тусламжтай өгөршиж муудсан хэсгүүдэд 3 удаагийн бэхжүүлэлт хийсэн.



Зураг 52 : В72-ийн түрхлэг



Зураг 53 : арьсны хэсэг

#### **13.4 Баримтжуулалт**

CANON 2 T2i загварын дижитал аппарат, KODAK Color ашиглаж бэхжүүлэлтийн дараах зургыг авч баримтжуулсан.

#### **13.5 Сав баглаа боодол**

Ус чийг болон агаарын урсгалаас тусгаарлаж, хайрцагны материалаас үүсэлтэй хүчлүүдээс тусгаарлах зорилгоор хүчил шүлтлэггүй цаасанд боох шаардлагыг хангаж боосон. Мөн зөөж тээвэрлэх үед доргилтоос үүсэх эрсдэлийг хязгаарлаж зөөлөвч хийсэн.

#### **14. Модон эдлэлийн хадгалалт хамгаалалт**

Олдворын дугаар АГ45-№13 модон самны хугархайн олдвор дээр хадгалалт хамгаалалт, бэхжүүлэлтийн ажлыг хийсэн. Олдворын нийт гадаргуу хэсгүүд нарийн шороон давхрага үүсгэсэн 90%-аас 120%-ийн усны агууламжтай самны шүдний хэсгүүд бүрэн устаж үгүй болсон, их биеийн модны эсийн гэмтэл дундаж хэмжээнд явагдаж лигнин нь чийгийн нөлөөнд зөөлөрсөн дунд зэргийн хадгалалттай байсан. Модон эдлэлийн хадгалалт хамгаалалт сэргээн засвар хийх ажлын үндсэн дараалалд

-Баримтжуулалт

-Цэвэрлэгээ

- хүчил шүлтийг тогтворжуулах

-Уусмалын аргаар бэхжүүлэх

-Талст үүсгэж хатаах

-Гадаргуун цэвэрлэгээ

-Сэргээн засварлах

- Баримтжуулалт

-сав баглаа боодол хийх арга зүйн дарааллаар хийдэг

#### **14.1 Баримтжуулалт**

CANON 2 T2i болон OLYMPUS-ToughF 2 загварын дижитал аппарат, KODAK Color ашиглаж хадгалалтын өмнөх ба дараах болон хадгалалт хамгаалалт, бэхжүүлэлтийн явцын зургыг авч баримтжуулсан.

#### **14.2 Цэвэрлэгээ**

Бийр, багс, чигчлүүр мод ашиглан усан дотор хийж гадаргуун цэвэрлэгээг 4 удаагийн давтамжтай хийсэн.

#### **14.3 Хүчил шүлтлэгийг тогтворжуулах**

Олдворын хувьд бунхант хэлбэрийн хөндий нөхцөлд хадгалагдаж байсан ба нуранга үүсэн шороонд дарагдсан нь гэмтэж муудах гол шалтгаан болсон хэдийч хөрс шорооны хувьд хөнгөн, шавранцар, нарийн ширхэгтэй, урвалын орчин сул хүчиллэг



орчин зонхилсон, давсжилтын зэрэглэлээр үзвэл давсжилтгүй ангилалд ордогтой холбоотой модны бохирдол нь харьцангуй бага байсан учир гүн бохирдлыг гадагшлуулж хүчил шүлтлэгийг тогтворжуулах шаардлагагүй байсан.

#### **14.4 Уусмалын аргаар бэхжүүлэх**

Модны эсийн түвшинд шингэн орсон ус нь хэт халуун хуурай нөхцөлөөс үүдэлтэй ууршилт өгснөөр модны эсийн хэлбэрийг гэмтээж гадаргууд цууралт, агшилт, тэлэлт өгч анхны эх төрхий нь алдуулж муутгадаг. Тиймээс модонд агуулагдаж буй усны эзэлхүүний оронд уусмалын аргаар халааж бэхжүүлэгч сахарыг оруулдаг.

- Трехалос сахарын уусмалын 10%-ийн уусмалд 7 хоног
- Трехалос сахарын уусмалын 20%-ийн уусмалд 7 хоног
- Трехалос сахарын уусмалын 30%-ийн уусмалд 7 хоног
- Трехалос сахарын уусмалын 40%-ийн уусмалд 7 хоног
- Трехалос сахарын уусмалын 50%-ийн уусмалд 7 хоног
- Трехалос сахарын уусмалын 60%-ийн уусмалд 7 хоног
- Трехалос сахарын уусмалын 70%-ийн уусмалд 7 хоногийн хугацаанд хатаагч зуух ашиглан тус тус 80 градусын халуунд сахарын уусмалын нэвчилт хийсэн.

#### **14.5 Талст үүсгэж хатаах**

Уусмалаас гаргасны дараа 5 градусаас 10 градус хэмд салхин сэнсний тусламжтай үлээлгэн сахарыг талсжуулах ажилбарыг 14 хоногийн хугацаанд хийсэн.

#### **14.6 Гадаргуун цэвэрлэгээ**

Жинлэх аргаар талсжилт бүрэн дууссаныг хяналт хийн, гадаргууд үүссэн сахарын талстыг даралттай уурын индүүгээр хайлуулан, хайлсан сахарыг техникийн цаасаар арчиж, 5 градусаас 10 градус хэмд салхин сэнсний тусламжтай үлээлгэн сахарыг талсжуулах ажилбарын дарааллаар 3-аас 4 удаагийн давтамжтай хийж гадаргуун цэвэрлэгээг хийсэн.

#### **14.7 Сэргээн засварын ажилбар**

Модон савны хувьд хугарч халцарсан гэмтэлгүй учраас нөхөх, наах, будах зэрэг сэргээний ажилбар хийх шаардлагагүй болно.

#### **14.8 Баримтжуулалт**

CANON 2 T2i загварын дижитал аппарат, KODAK Color ашиглаж бэхжүүлэлтийн дараах зургыг авч баримтжуулсан.

#### **14.9 Сав баглаа боодол**

Ус чийг болон агаарын урсгалаас тусгаарлаж, хайрцагны материалаас үүсэлтэй хүчлүүдээс тусгаарлах зорилгоор хүчил шүлтлэггүй цаасанд боох

шаардлагыг хангаж боосон. Мөн зөөж тээвэрлэх үед доргилтоос үүсэх эрсдэлийг хязгаарлаж зөөлөвч хийсэн.


## 15. Дүгнэлт

Орхон аймгийн Айрагийн гозгорын дурсгал газарт Монголын үндэсний музейн 2019 онд Хятадтай хамтарсан археологийн малтлага судалгаагаар илэрч буй олдворууд нь соёлын үнэт өв болоод зогсохгүй түүхийн тайлагдашгүй олон асуултын хариулт болохуйц түүхэн ач холбогдолтой чухал дурсгалд тооцогдож байна. Энэхүү чухал органик болон металл олдворын хадгалалт хамгаалалтын ажлыг монголын мэргэжилтэн багын хамт олон хийж гүйцэтгэсэн ба олдвор тус бүр дээр олдворын онцлогт таарсан стандарт аргазүйг ашиглаж хадгалалт хамгаалалт бэхжүүлэлтийн ажлыг хийснээрээ онцлогтой юм. Органик эдлэл нь дулаан чийгшлийн тогтворгүй орчинд муудалт явагдах эрсдэл өндөртэй байдаг ба металл эдлэл нь зэс (Cu) ,төмөр (Fe) ,алт (Au) , мөнгө (Ag) ,хүрэл (Cu,Zn) гэх мэт өөр шинж чанартай байдаг учраас зэвэрч муудах нөхцөл нь орчноосоо хамаараад өөр өөр онцлогтой байдаг. Мөн материал харгалзахгүй олдворыг хамгийн гол муутгаж буй эрсдэлд олон төрлийн органик хүчил ордог. Тиймээс хадгалалт хамгаалалт, бэхжүүлэлт, сэргээн засварлах аргазүйг олдворын шинж чанар, нөхцөл байдалд тохирсон байдлаар боловсруулж хийх шаардлагатай. Хадгалалт хамгаалалт, бэхжүүлэлт, сэргээн засварлах ажилбар дууссаны дараа олдворын нөхцөлд таарсан тогтвортой орчин бүрдүүлж хадгалах нь нэн чухал юм. Музейн орчинд органик эдлэлийг 55%-аас 65%-ийн чийгшил, 150 люкс гэрэлтүүлэгт, металл эдлэлийг 45%-иас доош чийгшил, 300 люкс гэрэлтүүлэгт хадгалан, дундаж дулааныг 20 градуст байлгаж, чийгшил дулааны хэлбэлзэл аль болох бага орчинд хадгалах нь зүйтэй.

## ХАВСРАЛТ -1

Материал судлалыг СӨҮТ-ийн СБӨСГ-ийн лабораторийн HORIBO XGT5200. XRF загварын рентген флуоресцент спектрийн багажийг ашиглаж зарим олдвор дээр материал судлал хийж найрлагыг тогтоосон.

Айрагийн гозгор төмөр эдлэл /зэв/ ОА-АГ, М-96, №-21



Live time : 100 s Processing Time : P3  
XGT Dia. : 100  $\mu\text{m}$  X-ray tube vol. : 50 kV  
Current : 1.000 mA  
X-ray Filter : Nonexistence Cell :  
Nonexistence

Quant. Corr. : Standard-less




Elem.	Line	Mass	2sigma	Atomic Intensity
		[%]	[%]	[%] [cps/mA]

13 Al K	3.27	0.30	6.31	7.14
14 Si K	3.22	0.16	5.98	18.63
15 P K	0.23	0.06	0.39	2.96
20 Ca K	0.62	0.02	0.80	40.08
26 Fe K	92.59	0.33	86.45	13901.64
29 Cu K	0.08	0.01	0.07	5.53
42 Mo K	0.00	0.01	0.00	0.03




Айрагийн гозгор. №46, АГ45 /алт шармалын хэсэг/



Live time : 100 s    Processing Time : P3  
 XGT Dia. : 100 μm    X-ray tube vol. : 50 kV  
 Current : 1.000 mA  
 X-ray Filter : Nonexistence    Cell :  
 Nonexistence

Quant. Corr. : Standard-less


Elem. Line    Mass    2sigma    Atomic Intensity



	[%]	[%]	[%]	[cps/mA]
20 Ca K	0.26	0.05	0.98	3.37
22 Ti K	0.17	0.04	0.53	3.91
29 Cu K	14.11	0.09	33.42	1426.14
60 Nd L	0.41	0.13	0.43	4.16
79 Au L	66.64	0.22	50.93	1406.03
80 Hg L	14.04	0.17	10.54	295.31
82 Pb L	4.37	0.12	3.17	97.31



Айрагийн гозгор. №46, АГ45 /үндсэн их биеийн хүрэл хэсэг/




Live time : 100 s Processing Time : P3  
 XGT Dia. : 100  $\mu$ m X-ray tube vol. : 50 kV  
 Current : 1.000 mA  
 X-ray Filter : Nonexistence Cell : Nonexistence

Quant. Corr. : Standard-less

Elem.	Line	Mass	2sigma	Atomic Intensity
		[%]	[%]	[cps/mA]
15 P	K	1.78	0.13	3.93
25 Mn	K	0.04	0.01	0.05
28 Ni	K	0.10	0.02	0.11
29 Cu	K	83.23	0.27	89.63
50 Sn	K	5.50	0.23	3.17
68 Er	L	0.24	0.05	0.10
82 Pb	L	9.12	0.16	3.01



Айрагийн гозгор. №46, АГ45 /гархи/



Live time : 100 s Processing Time : P3



XGT Dia. : 100  $\mu$ m X-ray tube vol. : 50 kV

Current : 1.000 mA


X-ray Filter : Nonexistence Cell :  
Nonexistence

Quant. Corr. : Standard-less


Elem.	Line	Mass [%]	2sigma [%]	Atomic Intensity [cps/mA]
15	P K	0.49	0.09	1.07
27	Co K	0.02	0.01	0.03
28	Ni K	0.08	0.01	0.10
29	Cu K	89.56	0.23	94.58
50	Sn K	4.30	0.19	2.43
82	Pb L	5.54	0.12	1.79



Бүсний хүрэл чимэглэл. №8, АГ45 /чимэглэлийн толгой хэсгийн улаан өнгийн хүрэл/




Live time : 100 s Processing Time : P3  
 XGT Dia. : 100  $\mu\text{m}$  X-ray tube vol. : 50 kV  
 Current : 1.000 mA  
 X-ray Filter : Nonexistence Cell :  
 Nonexistence




Quant. Corr. : Standard-less

Elem.	Line	Mass [%]	2sigma [%]	Atomic Intensity [cps/mA]
29	Cu K	28.56	0.13	56.57 3361.57
77	Ir L	0.74	0.08	0.48 17.96
82	Pb L	70.70	0.14	42.94 1674.56



Бүсний хүрэл чимэглэл. №8, АГ45 /чимэглэлийн ар талын хүрэл хэсэг/






Live time : 100 s Processing Time : P3  
 XGT Dia. : 100  $\mu\text{m}$  X-ray tube vol. : 50 kV  
 Current : 1.000 mA  
 X-ray Filter : Nonexistence Cell :  
 Nonexistence



Quant. Corr. : Standard-less

Elem.	Line	Mass	2sigma	Atomic Intensity
		[%]	[%]	[cps/mA]
13	Al K	3.18	0.33	13.19 6.19
14	Si K	1.46	0.18	5.81 7.09
26	Fe K	4.04	0.07	8.10 225.38
28	Ni K	0.04	0.02	0.07 2.73
29	Cu K	6.69	0.08	11.79 573.16
40	Zr K	0.08	0.02	0.10 3.63
50	Sn K	37.97	0.48	35.80 115.85
82	Pb L	46.55	0.41	25.15 1110.00

Бүсний хүрэл чимэглэл. №8, АГ45 /ногоон зэврэлтэй хэсэг/




Live time : 100 s    Processing Time : P3  
 XGT Dia. : 100 μm    X-ray tube vol. : 50 kV  
 Current : 1.000 mA  
 X-ray Filter : Nonexistence    Cell :  
 Nonexistence




Quant. Corr. : Standard-less


Elem.	Line	Mass	2sigma	Atomic Intensity
		[%]	[%]	[cps/mA]
14	Si K	2.68	0.24	5.88    8.11
29	Cu K	94.52	0.24	91.81    12263.86
33	As K	2.80	0.06	2.31    127.49



Хүрэл чимэг (хавтгай суурьтай бөмбөгөр оройтой) №4, АГ96 /алт шармал хэсэг/




Live time : 100 s    Processing Time : P3  
 XGT Dia. : 100  $\mu\text{m}$     X-ray tube vol. : 50 kV  
 Current : 1.000 mA  
 X-ray Filter : Nonexistence    Cell :  
 Nonexistence




Quant. Corr. : Standard-less


Elem.	Line	Mass [%]	2sigma [%]	Atomic Intensity [cps/mA]
22	Ti K	0.13	0.03	0.36
29	Cu K	22.32	0.11	47.09
79	Au L	61.85	0.19	42.10
80	Hg L	13.77	0.16	9.20
82	Pb L	1.93	0.10	1.25



Xex cybc №2, AГ96




Live time : 100 s      Processing Time : P3  
 XGT Dia. : 100  $\mu$ m      X-ray tube vol. : 50 kV  
 Current : 1.000 mA  
 X-ray Filter : Nonexistence      Cell : Nonexistence




Quant. Corr. : Standard-less

Elem.	Line	Mass [%]	2sigma [%]	Atomic Intensity [%]	Intensity [cps/mA]
13	Al K	5.37	0.31	6.11	17.63
14	Si K	69.42	0.35	75.88	440.51
16	S K	0.39	0.06	0.38	4.74
17	Cl K	5.34	0.13	4.63	70.97
19	K K	2.70	0.10	2.12	36.54
20	Ca K	8.24	0.14	6.31	158.35
22	Ti K	0.25	0.03	0.16	7.86
25	Mn K	2.95	0.05	1.65	203.66
26	Fe K	4.26	0.06	2.34	381.85
29	Cu K	0.62	0.02	0.30	77.80
30	Zn K	0.05	0.01	0.02	6.42
38	Sr K	0.17	0.01	0.06	29.85
71	Lu L	0.24	0.05	0.04	7.73



Лакан тавагны хар гадаргуу № АГ45




Live time : 100 s Processing Time : P3

XGT Dia. : 100  $\mu\text{m}$  X-ray tube vol. : 50 kV

Current : 1.000 mA

X-ray Filter : Nonexistence Cell : Nonexistence




Quant. Corr. : Standard-less

Elem. Line Mass 2sigma Atomic Intensity

	[%]	[%]	[%]	[cps/mA]
13 Al K	7.16	1.24	9.68	3.01
14 Si K	23.24	0.90	30.19	21.96
19 K K	1.50	0.19	1.40	6.01
20 Ca K	56.85	1.05	51.76	256.53
25 Mn K	2.99	0.25	1.98	23.78
26 Fe K	2.93	0.21	1.92	30.29
29 Cu K	5.32	0.22	3.06	79.69
42 Mo K	0.00	0.08	0.00	0.01



Лакан тавагны улаан гадаргуу № АГ45



Live time : 100 s    Processing Time : P3

XGT Dia. : 100  $\mu$ m    X-ray tube vol. : 50 kV


Current : 1.000 mA

X-ray Filter : Nonexistence    Cell : Nonexistence



Quant. Corr. : Standard-less

Elem. Line	Mass [%]	2sigma [%]	Atomic Intensity [cps/mA]
20 Ca K	1.98	0.10	8.88    22.35
26 Fe K	0.83	0.03	2.66    48.41
29 Cu K	0.51	0.02	1.45    48.49
56 Ba K	0.76	0.54	1.00    0.36
80 Hg L	95.92	0.54	86.01    2058.03



## ХАВСРАЛТ-2



Зураг 1: №5-АГ14 засварын өмнө



Зураг 2: №5-АГ14 засварын дараа

алтан товруу чимэг



Зураг 3: №6-АГ97 засварын өмнө



Зураг 4: №6-АГ97 засварын дараа

Хүрэл цагираг



Зураг 5: №13-АГ97 засварын өмнө



Зураг 6: №13-АГ97 засварын дараа

хүрэл арал



Зураг 7: №19-АГ97 засварын өмнө



Зураг19:№13-АГ97 засварын дараа

хүрэл арал



Зураг 7: №8-АГ97 засварын өмнө  
Зураг19:№8-АГ97 засварын дараа



хүрэл цагираг



Зураг 7: №8-АГ97 засварын өмнө



Зураг19:№8-АГ97 засварын дараа

хүрэл унжлага





Зураг 9: №18-АГ97 засварын өмнө    Зураг10:№18-АГ97 засварын дараа  
хүрэл унжлага



Зураг 11: №18-АГ97 засварын өмнө    Зураг 12: №18-АГ97 засварын дараа  
Алтан шармал хүрэл эдлэл



Зураг 13: №8-АГ45 засварын өмнө    Зураг 14: №8-АГ45 засварын дараа  
бүсний хүрэл чимэглэл



*Зураг 15: №4-АГ96 засварын өмнө    Зураг 16: №4-АГ96 засварын дараа*

*Хүрэл чимэг, хавтгай суурьтай бөмбөгөр оройтой*



*Зураг 15: №4-АГ96 засварын өмнө    Зураг 16: №4-АГ96 засварын дараа*

*төмөр зэвний хугархай*



*Зураг 17: №23-АГ97 засварын өмнө    Зураг 18: №23-АГ97 засварын дараа*

*төмөр арлын үлдэгдэл*



Зураг 19: №7-АГ96 засварын өмнө    Зураг 20: №7-АГ96 засварын дараа  
төмөр бүсний үзүүрийн чимэг



Зураг 21: №6-АГ96 засварын өмнө    Зураг 22: №6-АГ96 засварын дараа  
жижиг хөх сувс



Зураг 21: №6-АГ96 засварын өмнө    Зураг 22: №6-АГ96 засварын дараа  
хөх сувс



Зураг 23: №6-АГ96 засварын өмнө    Зураг 24: №6-АГ96 засварын дараа

шилэн суус



Зураг 25: №22-АГ97 засварын өмнө    Зураг 26: №22-АГ97 засварын дараа

шилэн суус



Зураг 27: №15-АГ97 засварын өмнө    Зураг 28: №15-АГ97 засварын дараа

шилэн суус



Зураг 29: №3-АГ96 засварын өмнө    Зураг 30: №3-АГ96 засварын дараа

*Гонзгой чулуун зүүлт*



Зураг 31: №9-АГ97 засварын өмнө    Зураг 32: №9-АГ97 засварын дараа

*ромбо хэлбэрийн дөрвөн талт хэлбэрийн сувс*



Зураг 33: №3-АГ14А засварын өмнө    Зураг 34: №3-АГ14А засварын дараа

*сувс*



Зураг 35: №9-АГ45 засварын өмнө

Зураг 36: №9-АГ45 засварын дараа

суус



Зураг 37: №17-АГ97 засварын өмнө

Зураг 38: №17-АГ97 засварын дараа

гичир наалтын хугархай



Зураг 39: №5-АГ97 засварын өмнө

Зураг 40: №5-АГ97 засварын дараа

ясан эдлэл



*Зураг 41: №5-АГ96 засварын өмнө    Зураг 42: №5-АГ96 засварын дараа  
ясан эдлэл*



*Зураг 43: №11-АГ97 засварын өмнө    Зураг 44: №11-АГ97 засварын дараа  
ясан савх*



*Зураг 45: №11-АГ97 засварын өмнө    Зураг 46: №11-АГ97 засварын дараа  
ясан савх*



Зураг 47: №-АГ45 засварын өмнө      Зураг 48: №-АГ45 засварын дараа  
хүрэл амсартай лакан тавагны дотор тал



Зураг 49: №-АГ45 засварын өмнө      Зураг 50: №-АГ45 засварын дараа  
хүрэл амсартай лакан тавагны гадна тал





Зураг 49: №-АГ45 засварын өмнө      Зураг 50: №-АГ45 засварын дараа  
хүрэл амсар






Зураг 51: №-АГ45 засварын өмнө    Зураг 52: №-АГ45 засварын дараа  
том ваар



Зураг 53: №-АГ45 засварын өмнө    Зураг 54: №-АГ45 засварын дараа  
дунд ваар



Зураг 55: №-АГ45 засварын өмнө    Зураг 56: №-АГ45 засварын дараа  
жижиг ваар





Зураг 61: №1-АГ14 засварын өмнө      Зураг 62: №1-АГ14 засварын дараа

чимэглэлийн үлдэгдэл



Зураг 63: №-АГ45 засварын өмнө      Зураг 64: №-АГ45 засварын дараа

шавар ваар



Зураг 65: №-АГ45 засварын өмнө      Зураг 66: №-АГ45 засварын дараа

нэхмэлийн үлдэгдэл



*Зураг 67: №13-АГ45 засварын дараа  
модон самны хугархай*

### ХАВСРАЛТ- 3

Даавуун эдлэлийн нэхмэлийг OLYMPUS-ToughF 2 загварын дижитал аппарат ашиглан 10-аас 40 дахин томруулан харж, ажиглалт хийн төрлийг тодорхойлсон.



*Зураг 1 ToughF 2x10*

1. Нарийн үндсэн 1 ширхэг утсан дээр бүдүүн ширхэгтэй 1 утсаар хөндлөн нэхэж, хөндлөн нэхээсний аргаар гадаргууг товойлгон, үндсэн утсыг дан давуулж нэхсэн энгийн тэгш сүлжмэлийн технологээр нэхсэн даавуун хэсэг байна.




*Зураг 2 ToughF 2x30*

2. Үндсэн утасны гэмтэл харьцангуй хадгалалт сайтай байгаа хэдийч хөндлөн утасны хувьд өгөршил өгч сэмэрч муудсан байдалтай байна.



*Зураг 3 ToughF 2x40*

3. Үндсэн утасны гэмтэл харьцангуй хадгалалт сайтай байгаа хэдийч хөндлөн утасны хувьд өгөршил өгч сэмэрсэн, үндсэн утсыг 2 ширхэг нарийн утсаар эрчилж нийлүүлсэн, хөндлөн утас нь 2 ширхэг бүдүүн утсыг нэг нэхээсээр хамтад нь дан давуулж нэхсэн энгийн тэгш сүлжмэлийн технологээр нэхсэн даавуун хэсэг байна.



*Зураг 4 ToughF 2x30*

4. Үндсэн болон хөндлөн утасны гэмтэл харьцангуй хадгалалт сайтай байгаа хэдийч өгөршил өгч сэмэрсэн, үндсэн босоо утас хөндлөн утсыг дан давуулж нэхсэн энгийн тэгш сүлжмэлийн технологээр нэхсэн даавуун хэсэг байна.




*Зураг 5 ToughF 2x30*

5. Шорооноос үүдэлтэй нүхжилт болон хагарал, цуурал өгсөн хадгалалт дунд зэргийн хаталттай арьсан эдлэлийн тасархай гарч ирсэн.



*Зураг 6 ToughF 2x30*

6. Шорооноос үүдэлтэй нүхжилт болон хагарал, сийрэгжилт өгсөн хадгалалт дунд зэргийн нимгэн ясны хэсэг гарч ирсэн.



*Зураг 7 ToughF 2x30*

7. Хуниралдсан даавууны хэсгээс 3.5 см урттай 2 нарийн төмөр эд зүйл гарч ирсэн. Хар хүрэн өнгийн тогтвортой төрлийн зэврэлт явагдаж, гадаргуу хэсгийг бүхэлд нь хучиж давхрага үүсгэсэн байдалтай байсан.



## ХАВСРАЛТ-4

Ашиглагдсан багаж хэрэгсэл:

хуванцар сав	ацетон
шилэн сав	гуурсан шүршигч
зөөлөн үстэй бийр	өнгө ялгагч тестер
ширүүн үстэй бийр	ширээний гэрэл
зөөлөн үстэй багс	томруулагч шил
ширүүн үстэй багс	уураар буудагч индүү
чигчлүүр мод	битүүмжлэгч хуванцар сав
чих цэвэрлэгч	түрхэгч саваа мод
хөвөн	үлээгч гуурс
даавуу	хүнсний скоч
техникийн цаас	зөөлөвч уут
ам дарагчтай уут	шүлтлэггүй цаас
мэсний хутга	хэмжилттэй колор
нунтаг шороо	дигитал штангенциркуль
нийлэг цавуу	тасалгааны сэнс
бонд, эпоксид цавуу	гуурсан термометр
трехалос сахар	зөөврийн компьютер
хатаах зуух	суурин компьютер
вакуум үүсгэгч багаж	A4-ийн цаас
элсэн буу	хатуулагтай цаас
нарийн индүү	резинэн бээлий
моторт зүлгүүр	маск
рентген флуоресцент спектрийн багаж	жин хэмжүүр
микроскоп	тугалган цаас
дигитал аппарат	аппаратын хөл
трилон Б	хавчуурга
паралойд	нэрмэл ус
бензотриазол	хүндрүүлэгч
сахар хэмжигч	цаасны хутга
дулаан, чийгшил хэмжигч	цаасан скоч
акрилкан будаг	өөлөвчтөй савх
этанол	уутан бээлий
холигч шил	принтер

ТАЙЛАН БИЧСЭН:  
М.ОЮУНТУЛГА PH.D. СОЁЛЫН БИЕТ ӨВИЙГ  
СЭРГЭЭН ЗАСВАРЛАХ ГАЗРЫН  
ЕРӨНХИЙ ТЕХНОЛОГИЧ

----oOo----

## СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН СОЁЛЫН БИЕТ ӨВИЙГ СЭРГЭЭН ЗАСВАРЛАХ ГАЗАР ХЭРЭГЦЭЭТ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ТӨСӨЛ

Соёлын өвийн үндэсний төв Бүгд найрамдах Турк улсын ТИКА байгууллага хоорондын хамтын ажиллагааны хүрээнд тус улсаас Монгол улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхэт элчин сайд ноён М. Ахмет Язал-д соёлын өвийн сэргээн засварлалтын лаборатори байгуулах хэрэгцээний талаар танилцуулж доорх төслийн саналыг албан ёсоор хүргүүлээд байна.



**СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ**  
14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу 1,  
Ерөнхий сайд Амарын гудамж, Соёлын төв өргөө Б корпус,  
Утас: 7011 0879, 7011 0877, Факс: (976-11) 31 27 35,  
И-мэйл: ncch@monheritage.mn, Вэбсайт: www.ncch.gov.mn

2019.11.15 № 01/525  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т


**БҮГД НАЙРАМДАХ ТУРК УЛСААС  
МОНГОЛ УЛСАД СУУГАА  
ОНЦ БӨГӨӨД БҮРЭН ЭРХТ ЭЛЧИН  
САЙД М. АХМЕТ ЯЗАЛ ТАНАА**

Тус төвийн захирал миний бие тантай уулзсан уулзалтын үеэр соёлын өвийг хамгаалахад Монгол-Турк хоёр улсын хамтын ажиллагаа бүхий соёлын өвийн сэргээн засварлалтын лаборатори байгуулах хэрэгцээний талаар танилцуулсныг та хүндэтгэн найрсагаар хүлээн авсан билээ.

Бид лаборатор байгуулах хэрэгцээ шаардлага, хэрэгцээт тоног төхөөрөмжийн талаар төслийн саналыг танд хүргүүлж байна.

Соёлын өвийг хамгаалах талаар сэтгэл тавин ажиллаж буй танд гүнээ талархаж буйгаа илэрхийлье.

Хавсралт 5. хуудастай.

ЗАХИРАЛ  Г.ЭНХБАТ

  
58319 0165

Соёлын өвийн үндэсний төвийн шинэ байранд Монгол-Туркийн хамтарсан  
археологийн олдвор бэхжүүлэх, сэргээн засварлах  
лаборатори байгуулах тухай

Монгол Улсын нутаг дэвсгэрт Түрэг угсаатанд холбогдох археологийн эд өлгийн дурсгалт зүйл гэвэл, юуны өмнө хаад ноёд, жирийн иргэдэд зориулсан тахил тайлгын онгон, хүн чулуу, адгуус амьтны дүрс бүхий хөшөө чулуу, хадны зураг, руни бичээст гэрэлт хөшөө, уран барилгын холбогдолт дурсгал, хад чулуу болон бусад эд зүйлд сийлбэрлэн гаргасан элдэв зураг, их бага бичээсийн зүйлс, нас барагсдыг оршуулсан бунхан, булш хиргисүүр зэрэг зүйлс орж байна.

Түрэгийн эд өлгийн дурсгал, нэн ялангуяа тэдний хамгийн их нийтлэг бөгөөд өргөн тархсан дурсгал болох тахил тайлгын онгоны цогцолборууд нь түрэг угсаатан оршин суусан Евразийн уудам нутгаар өргөн тархсан бөгөөд манай орны Хэнтийн уулсаас Алтайн их уулсыг хүртэлх нутагт элбэг олддог.


Тухайлбал, сүүлийн жилүүдэд хийсэн археологийн судалгааны үр дүнд эртний Түрэгийн язгууртны тахилын онгон 87 илрүүлэн судлаад байгаа бол энэ үеийн хүн чулуу 731 бүртгэгдээд байна. Мөн энэ үеийн нэгэн чухал дурсгал болох бичгийн дурсгал 100 гаруй олдсоны 90 орчим нь бага бичиг буюу хад чулуунд сийлж үлдээсэн бичиг байна.

Тухайн үеийн чухал дурсгал нь булш оршуулгын дурсгал бөгөөд ойрын жилүүдэд энэ талын судалгаа эрчимжсээр өнөөгийн байдлаар эртний “түрэгийн үеийн морьт оршуулга” хэмээн нэрлэгдсэн дурсгал 30 гаруйг малтан судлаад байна.

Монгол нутгаас илэрч буй эдгээр дурсгалуудад хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалт хийж археологийн судалгааны эргэлтэд оруулснаар Монголын төдийгүй евроазийн түүх соёлын ээдрээ зангилааг тайлж, танин мэдэх, ирээдүй хойч үедээ уламжлуулахад чухал ач холбогдолтой юм.

Үл хөдлөх болон археологийн малтлага судалгаагаар илэрч буй хөдлөх дурсгалын хувьд урт болоод богино хугацааны хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалт, сав баглаа боодол хийж, тогтвортой орчин бүрдүүлж хадгалах арга зүй, багаж техник дутмаг байгаа хэдий ч эдгээр хөдлөх, үл хөдлөх дурсгалуудын бүртгэл, хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалтын ажлыг улсын хэмжээнд БСШУСЯамны харъяа Соёлын өвийн үндэсний төв хариуцан судалгаа, шинжилгээ үйл ажиллагаа явуулж байна. Тус төв нь биет өвийн хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалтын ажлыг өөрийн дотоод нөөц бололцоо, хүчин чадал болон гадаад улс орнуудын хамтын ажиллагааны хүрээнд явуулж ирсэн ба Турк улсын ТИКА байгууллагатай хамтран олон төслүүдийг амжилттай хэрэгжүүлж, хөдлөх, үл хөдлөх дурсгалуудын археологийн судалгаа болон хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалтын арга зүйг амжилттай боловсруулж хэрэгжүүлсээр байна.

Сүүлийн үеийн судалгаагаар, Соёлын өвийн үндэсний төвийн мэдээллийн санд байгаль, нийгмийн хүчин зүйлсийн сөрөг нөлөөллийн эрсдэлд хэрхэн өртөж байгаад холбогдуулан гаргасан судалгаанаас үзэхэд, нийт дурсгалын 12.7% буюу 11007 дурсгал хүний нөлөөллөөр гэмтсэн. Үүнээс, тоносон 16%, сүйтгэсэн 31%, будаж балласан 10%, хугалсан 9.7%, сийлсэн 2.5%, зөөгдсөн 3.3%, алга болсон 3.2%, тос, сүүний бохирдолттой 8.8%, буруу зассан 2.4%, хадаг, бөс даавуу ороож уясан 4.8%, дэд бүтцийн аюулд өртсөн 2%, аж ахуйн үйл ажиллагаанд өртсөн нь 4.6%-ийг тус тус эзлэж байна (Зураг 1).



**Зураг 1. 2015 оны ТСҮХД-ын үзлэг, тооллогын судалгаан дахь гэмтлийн судалгаа**

Соёлын өвийн үндэсний төв нь 1988 онд анх зөвхөн музейн үзмэр сэргээн засварлах урлан нэртэй анхлан байгуулагдаж улмаар үйл ажиллагааны цар хүрээгээ улам тэлж, 1994 онд Соёлын өвийн төв, 2018 онд Соёлын өвийн үндэсний төв болон өргөжжээ.

Монгол Улсын Засгийн газраас Соёлын биет болон биет бус өвийг бүртгэн баримтжуулах, хадгалах, сэргээн засварлах, сурталчлах, хөгжүүлэх үйл ажиллагааг улсын хэмжээнд арга зүй, удирдлаар ханган ажиллах, үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор 2020 оны 3 сард Улаанбаатар хотын Хан уул дүүрэгт Буянт-Ухаа-2 цогцолборын урд шинээр зориулалтын барилгыг ашиглалтад оруулахаар ажиллаж байна.

Асар уудам өргөн газар нутаг дээр тархан байрласан дурсгал болох хүн чулуун хөшөө, хадны зураг бичээс зэргийг газар дээр нь хамгаалах, археологийн малталт судалгааны үед илэрч олдсон дурсгалыг газар дээр нь бэхжүүлэх, авран хамгаалах зэрэг ажлыг хийхэд хөдөлгөөнт буюу бартаа туулах хүчин чадалтай явуулын лаборатор бүхий авто машин, музейн үзмэр, археологийн олдвор болон лабораторт шилжүүлж сэргээн засварлах шаардлагатай хөшөө чулуу зэргийг оношлох, материал

бүтцийн судалгаа хийх, бэхжүүлэх, сэргээн засварлах үйл ажиллагааг хийх нарийн мэргэжлийн монголын зах зээлд байхгүй тоног төхөөрөмжөөр хангах, соёлын өвийг хамтран судлах, хамгаалах техникийн болон хамтын ажиллагааны лаборатор байгуулах хэрэгцээ шаардлага байна.

Монгол нутаг дахь Түрэгийн үеийн түүх соёлын дурсгалыг хадгалж хамгаалах үйл ажиллагаанд Турк улсын соёлын өвийн хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалтын салбарын ололт амжилт, туршлагыг нэвтрүүлэх, мэргэжилтэн боловсон хүчний хамтарсан судалгаа шинжилгээний ажлыг өрнүүлэхэд зарим лабораторийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл нэн шаардлагатай байгаа бөгөөд цаашид уг хамтын ажиллагааг хөгжүүлэн, улам идэвхтэй өрнүүлэх тал дээр энэхүү техникийн хамтын ажиллагаа нь томоохон дэмжлэг түлхэц болох юм.

Соёлын өвийн үндэсний төвийн зүгээс хавсралтад дурдсан тоног төхрөөмжийн саналыг жагсаалтаар хавсарган танилцуулж байна.

1. Соёлын өвийн үндэсний төвийн судалгаа, сэргээн засварлалтын ажилд хэрэгцээт лабораторийн тоног төхөөрөмжийн жагсаалт

№	тоног төхөөрөмжийн нэр, загвар	зураг	Тоо ширхэг	зориулалт
1	<b>micro chisel, дагалдах хошуунууд, хийн даралтын шланкны хамт</b> чулууны цэвэрлэгээ		3ш	Чулуун объектийн цэвэрлэгээ, сэргээн засварлалтын ажилд
2	<b>100 VIBRATING CUTTER CTS F1 дагалдах хошуунууд, хийн даралтын шланкны хамт</b>		3ш	Чулуун объектийн цэвэрлэгээ, сэргээн засварлалтын ажилд
3	<b>Суурин цахилгаан хийн компрессор /дуу чимээгүй/</b> Шаардлагатай дагалдах хэрэгслийн хамт		2ш	Хийн даралтын дагаж, хэрэгсэл ажиллуулах зориулалт бүхий өндөр хүчин чадалтай байх


4	<b>MINIHYDROSANDBLAST ER CTS ART</b>		1ш	Чулуун объектийн цэвэрлэгээ, сэргээн засварлалтын ажилд
5	<b>ARTDUO LASER for stone, дагалдах болон, хамгаалалтын хэрэгслийн хамт</b>		1ш	Чулуун объектийн цэвэрлэгээ, сэргээн засварлалтын ажилд
6	<b>PETROL ENGINE COMPRESSOR MOD. AGRI 90/670</b>		1ш	Чулуун объектийн цэвэрлэгээ, сэргээн засварлалтын ажилд
7	<b>Чулуу зүсвэрийн суурин хөрөө</b>		1ш	Сэргээн засварлах ажлын чулуун бэлдэц бэлтгэх зориулалт бүхий үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж
8	<b>DIGITAL VIDEOMICROSCOPE Дагалдах иж бүрдэл дурангуудын хамт</b>		2ш	Чулуун объектийг тандан судлах явуулын болон суурин судалгааны ажилд
9	<b>Ажлын зөөврийн компьютер</b>		2ш	Дурсгалт газар ажиллаж мэдээлэл цуглуулж хадгалах, боловсруулах, судалгааны зориулалтын өндөр багтаамж, хүчин чадалтай

10	<b>Pundit plus</b> Хэт авианы хэмжилтийн багаж, дагалдах хошуунуудын хамт Хошууны марк: - 54kHz /2төрөл/ - 150kHz - 500kHz		Төхөөрөмж 1ш Дагалдах хошуу 4ш	Чулуун объектийн дотоод хагарал, хугарал, гэх мэт далд гэмтлийг хэт авиагаар тандан судлах судалгааны ажилд
11	<b>UK1401 ultrasonic instrument</b>		3ш	Чулуун объектийн дотоод хагарал, хугарал, гэх мэт далд гэмтлийг хэт авиагаар тандан судлах судалгааны ажилд
12	<b>Digital imaging analyse</b> Дагалдах дуран хэрэгслийн хамт		1ш	Чулуун объектийн гадна гэмтэл бохирдлыг дан болон давтамжтайгаар хийх судалгааны ажилд
13	Хатуулгийг шалгах суурин төхөөрөмж дагалдах хэрэгсэл, суурин компьютерийн хамт		1иж бүрдэл байх	Чулууны хатуулаг бөх бат байдлыг лабораторийн орчинд судлах судалгааны ажилд
14	<b>Schmidt hammer</b> Хатуулаг шалгах гар багаж /чулуунд зориулагдсан/		2ш	Чулуун объектийн хатуулгийн явуулын болон суурин судалгааны ажилд
15	<b>Equo-tip rebound hardness tester</b>		3ш	Чулууны хатуулаг хэмжигч багаж

16	<b>Thermometer /digital/ термометр</b>		Зш	Бичил Орчны судалгаа
17	<b>Non contact thermometer /digital/ Зайнаас хэмжигч термометр</b>		Зш	Бичил орчны судалгаа
18	<b>Hygrometer /digital/ Чийг хэмжигч</b>		Зш	Бичил орчны судалгаа
19	<b>Illuminometer /digital/ Гэрэл хэмжигч</b>		Зш	Бичил Орчны судалгаа
	<b>Portable weather station Хөдөлгөөнт цаг уурын станц</b>		1ш	Бичил Орчны судалгаа



20	<b>Dry oven</b> <b>Хатаагч зуух</b>		2ш	Модон эдлэлийн хадгалалт хамгаалалт
21	<b>Stainless steel bat</b> <b>ган төмөр сав</b>		20ш	Металл болон модон эдлэлийн хадгалалт хамгаалалт
22	<b>Vacuum pressure impregnation</b> <b>вакум даралтын зуух</b>		1ш	Металл эдлэлийг хадгалалт хамгаалалт
23	<b>LED spotlight</b> <b>микроскопний гэрэл</b>		1ш	Бичил орчны судалгаа

24	<b>Microscope adapter</b> <b>микроскоп адаптер</b>		1ш	Микроскопноос зураг авах
25	<b>Photography studio light portable</b> <b>Зөөврийн гэрэл зургийн студи</b>		1ш	Судалгааны баримтжуулалт хийх
26	<b>Microscope smooth arm</b> <b>микроскоп сунгах гар</b>		1ш	Бичил орчинд ажиглалт хийх
27	<b>LED light source</b> <b>Тохиргоотой гэрэл</b>		1ш	биетийн нөхцөлд тааруулж ажиглалт хийх

28	<b>Sugar meter</b> <b>Сахар хэмжигч</b>		1ш	Бэхжүүлэгч бодисын тун хэмжээ тааруулах
29	<b>Freezer</b> <b>хөлдөөгч</b>		2ш	Туршилт судалгаа, олдворын хадгалалт
30	<b>Vacuum freeze dryer</b> <b>вакуумжуулж хөлдөөж хатаах</b>		1ш	Органик эдлэлийн хадгалалт хамгаалалт
31	<b>Infrared camera</b> <b>Хэт улаан туяаны камер</b>		1ш	Хүрээлэн Буй Орчны судалгаа

32	<b>Digital infrared camera</b> <b>PENTAX 645Z IR</b>		1ш	Уран Зургын судалгаа
33	<b>Silica gel</b> <b>Силика гел</b>		100кг	Металл эдлэлийн хадгалалт хамгаалалт
34	<b>Steam cleaner</b> <b>Уураар буудагч</b>		1ш	Модон эдлэлийн цэвэрлэгээ
35	<b>Grinder</b> <b>Нарийн зүлгүүрийн</b> <b>багаж</b>		2ш	Хатуу биетийн нарийн цэвэрлэгээ
36	<b>RP system</b> <b>RP сав баглаа</b>		10 багц	Олдворын нян, хорхой шавьжны устгал

37	<b>Avtomatic vacuum sealer desktop sealing machine</b> <b>вакуумжуулж савлах төхөөрөмж</b>		1ш	Олдворын богино болон урт хугацааны тогтвортой савалгаа
38	<b>Dry cabi</b> <b>Чийгшил сорогч шүүгээ</b>		1ш	Олдворын тогтвортой хадгалалт
39	<b>Digital PH meter</b> <b>Хүчил шүлтлэг хэмжигч</b>		1ш	Олдвор болон уусмалын Бохирдлыг хэмжих
40	<b>desalination tool</b> <b>давсгүйжүүлэх багаж буюу ванн</b>		1ш	Металл эдлэлийн бохирдол давсыг цэвэрлэх
41	<b>SEM-EDX</b> <b>Скайнер электрон микроскоп</b>		1ш	Органик эдлэлийн материал судлал

42	<b>Plastic tapper</b> Хуванцар савнууд		60ш	Органик металл эплэлийн хадгалалт хамгаалалт
----	---	--	-----	--

2. Соёлын өвийн үндэсний төвийн хээрийн судалгаа, сэргээн засварлалтын ажилд хэрэгцээт тоноглол бүхий явуулын лаборатори

№	Автомашины марк, модель	Зураг	Тоо ширхэг	Зориулалт
1	<b>Toyota Land Cruiser 78 /long/</b>		1 ш	Хээрийн нөхцөлд судалгаа, олдворын хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалтын ажил хийх зориулалттай, хээрийн лабораторийн тоноглолтой.

-----oOo-----



Соёлын үндэсний төвийн захирлын 2019 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн А/20 дугаар тушаалаар “Соёлын өвийн Улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн үйл ажиллагааны дотоод журам”-ыг баталсан.

“Соёлын өвийн Улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн үйл ажиллагааны дотоод журам” 7 бүлэг, 40 заалт, 6 хавсралттай. Журмын дагуу СӨУНБМСан нь дараах таван хөмрөг бүрдүүлэхээр зааж, хөмрөг бүрийн хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг оруулсан. Хөмрөгт:

Хөмрөг А. “Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл”

Хөмрөг В. “Түүх, соёлын үл хөдлөх дурсгал”

Хөмрөг С. “Соёлын биет бус өв, өвлөн уламжлагч”

Хөмрөг D. “Соёлын өвийн авран хамгаалалт”

Хөмрөг E. “Соёлын биет өвийн сэргээн засварлалт”

Журмын хавсралтаар цаасан болон цахим баримтыг “Хадгаламжийн нэгж” бүрдүүлэн хадгалах, СӨУНБМСангийн баримтын ашиглалтын баримт үүсгэх чиглэлээр дараах 13 төрлийн хөтлөгдөх маягыг орууллаа. Үүнд:

СӨУНБМСМаягт №1 Хадгаламжийн нэгжийн тодорхойлолт

СӨУНБМСМаягт №2 Хадгаламжийн нэгжийн дотоод товъёг

СӨУНБМСМаягт №3 Хадгаламжийн нэгжийн баталгааны хуудас

СӨУНБМСМаягт №4 Цахим тээгчийн тодорхойлолт

СӨУНБМСМаягт №5 Цахим тээгчийн дотоод товъёг

СӨУНБМСМаягт №6 Баримт ашиглах хүсэлт

СӨУНБМСМаягт №7 Баримт түр ашиглуулах хуудас

СӨУНБМСМаягт №8 Лавлагаа олгосон хуудас

СӨУНБМСМаягт №9 Цаасан суурьтай баримтаас хуулбар авсан акт

СӨУНБМСМаягт №10 Цахим баримтаас хуулбар авсан акт

СӨУНБМСМаягт №11 Дотоод ажлын хэрэгцээнд баримт ашиглуулсан бүртгэл

СӨУНБМСМаягт№12 Цаасан суурьтай баримт хүлээн авсан бүртгэл

СӨУНБМСМаягт№13 Цахим баримт хүлээн авсан бүртгэл

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн үйл ажиллагаа, нөхөн бүрдүүлэлтийн ажилд энэхүү журам тодорхой үүрэг гүйцэтгэх дамжиггүй. Цаашдаа Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн хадгаламжийн санг өрөө тасалгааг стандарт шаардлагад нийцүүлэн тохижуулах, тоноглох, цахим баримтын хадгалалт хамгаалалтын аюулгүй байдлыг хангах зэрэг цогц үйл ажиллагаа хэрэгжүүлж боловсон хүч, техник хэрэгслийн хүчин чадлыг нэмэгдүүлэн ажиллах шаардлагатай байна.

ТАЙЛАН БИЧСЭН:

Ш.ЭНХТУЯА.СОЁЛЫН ӨВИЙН БҮРТГЭЛ,  
СУДАЛГААНЫ ГАЗАР, ЕРӨНХИЙ  
БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН САНЧ

-----oOo-----



## Соёлын өвийн Улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн цахим архивыг төгөлдөржүүлэх ажлын хүрээнд хийсэн бусад ажил

### ХӨМРӨГ-А. ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛТ ЗҮЙЛ




Журмын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд өмнө орхигдож байсан “Түүх, соёлын үл хөдлөх дурсгал”, “Соёлын биет бус өв, өвлөн уламжлагч”-ийн цаасан суурьтай баримтыг данслах ажлыг хийж үндсэндээ дууссан. Нөхөн бүрдүүлэлтийн ажлаар 96 соёлын биет бус өвийн бүртгэл хийгдээд байна. Цахим баримтжуулалтын хүрээнд Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан Соёлын биет бус 97 өв, улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх 300 дурсгалыг цаасан хэлбэрээр, түүх, соёлын үл хөдлөх дурсгалын 2015 оны үзлэгийн 8000 дурсгалт газрын мэдээллийг цахим хэлбэрээр, 2012 оны түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн 110 мянган үзмэрийн мэдээлэл цахим хэлбэрээр, түүх, соёлын хосгүй үнэт 368 дурсгалын дүрс бичлэг болон СӨУНБМСанд хадгалагдаж байсан цахим баримтын 2 tb, Мэдээллийн технологи аюулгүй байдлын газрын цахим баримтын 8.4 tb хэмжээтэй 4 суурин хард “Мастер” хувь үүсгэж, үүний 8 tb хардны “дотоод товъёг” хийгээд байна.

Цаашдаа цаасан суурьтай баримтуудыг нягтлан шалгаж “Хадгаламжийн нэгж” болгох, товъёгжуулах, “Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт”-ын дагуу “Нөхөн бүрдүүлэлт” хийх, “Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн дотоод үйл ажиллагааны журам”-д зарим нэг нэмэлт оруулах, цахим баримтуудын “мастер” хувь үүсгэх, товъёгжуулах ажлыг үргэлжлүүлэн хийх зэрэг тодорхой ажлуудыг төлөвлөөд байна.


-----oOo-----

2015 оны түүх, соёлын үл хөдлөх дурсгалын үзлэг, тооллогод хамрагдсан дурсгалын тархалтын зураг "GIS"



0 50 100 200 300 400 500 600 Kilometers

ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛЫН ҮЗЛЭГ, ТООЛЛОГОД ХАМРАГДСАН НИЙТ ДУРСГАЛЫН ТООН, ХУВИЙГ ХАРУУЛСАН БАЙДАЛ



➤ RICH 3.0 програм хангамжид нийт Улаанбаатар хотын 9 дүүрэг, 21 аймгийн 330 сумын нутаг дахь 9537 дурсгалт газрын 86157 үл хөдлөх дурсгалыг хамрагдсан.

2015 оны түүх, соёлын үл хөдлөх дурсгалын үзлэг, тооллого-**2020 он**

Материалын бүтцийн найрлага, анализ судалгааг БМСангийн бүрдэлд ашиглах

Аюуш бурханд хийсэн орц найрлагын хэмжилт

2015.7.24



Хэмжээт-1						
Element	Au	Ag	Cu	Zn	As	Pb
%	94.81	2.59	1.31	0.35	0.96	0.02
x	0.148	0.005	0.017	0.006	0.007	0.018

Хэмжээт-2								
Element	Cu	Zn	Pb	Fe	Ni	Sn	Ag	W
%	98.20	2.53	0.61	0.24	0.21	0.16	0.09	0.01
x	0.087	0.015	0.001	0.005	0.005	0.027	0.024	0.003

Хэмжээт-3							
Element	Au	Ag	Cu	Zn	Sn	As	Pb
%	95.30	2.45	1.51	0.33	0.28	0.11	0.05
x	0.153	0.056	0.038	0.008	0.008	0.008	0.026




Бүх төрлийн эд материалын найрлагыг тогтоох зориулалттай төхөөрөмж: (X-MET 7500)

Хэмжилт хийсэн хэсгийн тэмдэглэл:



havrab.1

mungun tsugts u-61-1-32  
MUTMuzel



Live time: 100 s Processing Time: P3  
XRF Dia: 100 µm X-ray tube vol: 50 kV  
Current: 1.000 mA  
X-ray Filter: Ni/Zn/Kanama Cell (Non-scattering)  
Quant. Corr.: Standard-less

Elem	Line	Mass	Zorgun	Atomic Density	
	[eV]	[g]	[g/cm³]	[g/cm³]	
64 Ni	K	5.85	0.13	1.58	2.44
29 Cu	K	47.08	0.26	10.47	1017.56
40 Zn	K	0.02	0.00	0.01	0.21
47 Ag	K	52.35	0.27	10.51	439.66

Soyolin usvin tuy 2014.12.08

## **СОЁЛЫН ӨВИЙН УЛСЫН НЭГДСЭН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН САНД ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛЫН БАРИМТЫГ ТӨГӨЛДӨРЖҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ**

*Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 29 дүгээр зүйл. Соёлын өвийн бүртгэлийн нөхөн бүрдүүлэлт.* Монгол улсын Засгийн газрын 2008 оны 175 дугаар тогтоолоор батлагдсан Улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх 452 түүх, соёлын дурсгалын бүртгэл мэдээллийг цэгцлэх ажлыг үргэлжлүүлэн Улаанбаатар хот, Говьсүмбэр, Булган, Увс, Хэнтий, Завхан, Ховд, Дархан-Уул, Орхон-Уул, Дорнод аймгуудын нутагт орших дурсгалуудын мэдээллийг цахим хэлбэрээр байршуулав. Засгийн газрын 171 дугаар тогтоол Аймаг, Нийслэлийн хамгаалалтанд оруулах урьдчилсан жагсаалт гаргах ажлын хүрээнд боловсруулах маягтын асуулгыг Соёлын өвийн бүртгэл судалгааны газрын даргыг түр орлон гүйцэтгэгч Д.Нарантуяа, СӨАХГДарга Г.Анхсанаа, СӨБСГазрын гэрээт ажилтан Б.Амгаланбат нарын хамт боловсруулав.

*Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 29 дүгээр зүйл. Соёлын өвийн судалгааны ажлын тайлан, баримтыг данслаж цэгцлэх ажлын хүрээнд.* Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 29.1. - д Соёлын өвийн судалгааны ажлын дэлгэрэнгүй тайлангийн нэг хувийг Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд шилжүүлнэ хэмээн заасан байдаг. 2017 онд мэргэжлийн байгууллагуудын хийсэн тайланг УНБМСангийн журмын дагуу 81 тайланг хавтаслан үдэж УНБМСанд цаасан хэлбэрээр байршуулав. Мөн 2018 онд хийсэн судалгааны тайлангуудыг 2019 оны 03 дугаар сарын 25 - ны өдөр БСШУС-ын яамны Шинжлэх ухаан технологийн сангийн мэргэжилтэн М.Уранзулаас авч цэгцлэн санд байршуулав.

СӨУНБМС-нд хадгалагдаж буй түүх, соёлын үл хөдлөх дурсгалын цаасан болон цахим мэдээллийн сан (дуу, дүрс бичлэг, гэрэл зураг, маягт бүхий цаасан бүртгэл, цахим бүртгэл, дагалдах хэрэглэгдэхүүн болох хэв, дардас гм) цэгцлэх мөн аймаг тус бүрээр үүсгэн Ерөнхий бүртгэл мэдээллийн санчтай хамтран ажиллан түүх соёлын 214 нэр цаасан болон цахим мэдээллийг урьдчилсан жагсаалт гаргав.

*Чулуун соёлын өвийн бүртгэлийн маягыг “RICH” програмд нэвтрүүлэх ажлыг эхлүүлэх.* 2015 оны үл хөдлөх дурсгалыг үзлэг тооллогын зарим бүртгэлийн шинэчлэлтийн хүрээнд RICH 0.2, RICH 0.3 программын асуулгыг нэгтгэх, холбогдох маягыг шинэчлэх ажлыг СӨАХГДарга Г.Анхсанаа, САЙБЕР Б.Алтансүх, БМСанч Г.Бүрэнтөгс нар хамтран боловсруулав.

БИЧСЭН:

Г.БҮРЭНТӨГС. СОЁЛЫН ӨВИЙН БҮРТГЭЛ,  
СУДАЛГААНЫ ГАЗАР, БҮРТГЭЛ,  
МЭДЭЭЛЛИЙН САНЧ

-----oOo-----

## **4.2. Соёлын биет бус өвийн үзлэгт зориулсан ICH програмын нэмэлт хөгжүүлэлт**

- ICH програмд СББӨ-ийн эрсдэлийн хүчин зүйлс, өвийн өвлөгдөл гээгдлийг тодорхойлох шинэчлэлтийг хийх,
- Тус төвөөс програм хангамжийн ажилд шаардлагатай бодлогын даалгавар, техникийн өгөгдлийг боловсруулсан.
- Монгол Улсын Засгийн хэрэгжүүлэгч агентлаг Соёл урлагийн газар боолн СӨҮТ-д 2019 онд хэрэгжүүлэх ажлын төсөв батлагдаагүйн улмаас ажил хийгдээгүй байна.

## **4.3. Соёлын өвийг гэрэл зургаар баримтжуулах онолын болон дадлага сургалт зохион**

### **“СОЁЛЫН ӨВИЙН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН САН ДАХЬ ГЭРЭЛ ЗУРАГ, САНЧИЙН ЧАДАВХИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ НЬ” СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛСАН ТУХАЙ АЖЛЫН ТАЙЛАН**

2019.11.20

Улаанбаатар хот

#### **АГУУЛГА**

- Сургалт зохион байгуулах тухай үндэсний төвийн захирлын тушаал
- “Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан дахь гэрэл зураг, санчийн чадавхийг дээшлүүлэх нь” Сургалтын хөтөлбөр
- Сургалт зохион байгуулсан тухай ажлын тайлан

Хавсралт:

- Сургалтанд оролцогч байгууллагууд
- Сургалтанд оролцогчдын бүртгэл
- Улс, аймаг орон нутгийн музейн БМСанчдын талаарх судалгааны үзүүлэлт

Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 32.1.3, 37.1 дүгээр зүйл, Соёлын өвийн үндэсний төвийн дүрмийн 2.1.1-ийн 4, 5 дугаар заалт, 2.1.4-ийн 5 дугаар заалт, Үндэсний төвийн 2019 оны үр дүнгийн гэрээний 4.3-т заалт, Үндэсний төвийн захирлын 2019 оны А/108 тоот “сургалт зохион байгуулах, зардал гаргах тухай” тушаалд заасны дагуу “Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан дахь гэрэл зураг, санчийн чадавхийг дээшлүүлэх нь” мэргэжил арга зүйн сургалт, семинарыг 2019 оны 11 дүгээр сарын 18-19 өдрүүдэд Соёлын өвийн үндэсний төвийн байр болон Уран зургийн галерейн хурлын зааланд зохион байгууллаа.

Сургалт нь: - Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд гэрэл зургийн мэдээллийн эзлэх байр суурь, бүртгэл мэдээллийн санчаас аппарат, техник хэрэгслийг ашиглаж сурах болон дурсгалын зураг авах, гэрэл зургийн зохиомж, өнгөний хослолын чанар, шинж байдлыг ялгаж сурах чадавхийг бий болгох,

- Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санчийн чадавхийг сайжруулах зорилгоор цаг үеийн асуудлаар харилцан санал солилцох, цаашдын хамтын ажиллагааг төлөвлөх зорилгод чиглэгдсэн.

Үндэсний төвийн захирлын баталсан “Сургалтын хөтөлбөр”-ийн дагуу Захиргаа, удирдлагын газрын дарга О.Мэндсайхан 2 өдрийн сургалт, хичээлийг зохион байгуулан, удирдан чиглүүлэв.

Соёлын өвийн үндэсний төвөөс бүртгэл, мэдээллийн санч нарыг уг сургалтад хамруулах тухай албан бичгийг улс, аймаг, орон нутгийн музей нийт 39 байгууллагад хүргүүлсэн ба үүнээс нийт 37 байгууллагын 41 бүртгэл, мэдээллийн санч нар хамрагдлаа. Монголын Үндэсний музей, Завхан аймгийн музей, Өмнөговь аймгийн музей, Дэлхийн өв-Орхоны хөндийн дурсгалт газрын хамгаалалтын захиргаа зэрэг байгууллагаас тус бүр сан хөмрөгч, эрдэм шинжилгээний ажилтан зэрэг 2 ажилтан оролцсон байна.

Говь-Алтай, Дорноговь аймгийн музейн бүртгэл, мэдээллийн санч нар оролцоогүй болно. /Хавсралт. Сургалтанд оролцогчдын ирцийн бүртгэл/

Үндэсний төвийн захирлын баталсан сургалтын хөтөлбөрийн дагуу 11 дүгээр сарын 18-ны өдөр “Соёлын өв, дурсгалт зүйлийн гэрэл зураг авах” онолын болон дадлага ажлын хичээлийг үндэсний төвийн байранд зохион байгуулсан. Хичээлийг мэргэжлийн гэрэл зурагчин Б. Нямгэрэл заасан.

Уг хичээлээр соёлын өв, дурсгалт зүйлийн гэрэл зураг авах, гэрэл зургийг аппарат тохиргоо, зохиомж, гэрэл сүүдрийг мэдрэх зэрэг арга зүйг зааж сургав. Дадлага хичээлийг хоёр хэмжээст уран зураг, зээгт наамал зэрэг үзмэр, гурван хэмжээст үзмэр металл зэрэг гялгар гадаргуутай эд зүйлсийг хэрхэн авах талаар явууллаа. Сургалтад оролцогчид өөрсдийн гэрэл зургийн аппараттайгаа ирсэн ба аппаратын тохиргоо, ашиглалт хэрэглээ зэрэг гарч буй асуудлаар багшаас зөвлөмж авч, гэрэл зураг авах хичээл үр дүнтэй явагдсан.

Сургалтын 2 дахь өдөр буюу 11 дүгээр сарын 19-ны Уран зургийн галерейн хурлын зааланд “Бүртгэл, мэдээллийн сан, санчийн чадавхийг сайжруулах” сэдвийн хүрээнд соёлын биет ба биет бус өвийг бүртгэн баримтжуулах, санг бүрдүүлэх мэргэжил арга зүйн хичээлүүдийг тус үндэсний төвийн мэргэжилтэнгүүд заалаа.

- Хичээлийн эхэнд бүртгэл, мэдээллийн санчийн ажлын байрны тодорхойлолт болон хийж гүйцэтгэх ажлын талаар, мөн ойрын үед бүртгэл, мэдээллийн сангийн зорилт, төлөвлөлтийн талаар дэлгэрэнгүй танилцуулга хичээлийг үндэсний төвийн захирал Г. Энхбат;





- 2018-2019 онд улсын хэмжээнд зохион байгуулсан түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн улсын тооллогын тайлан нэгтгэл, тооллогын үр дүнгийн мөрөөр хийж, хэрэгжүүлэх бүртгэлд дэс алгассан, давхардсан, өмнөх тооллогоор актлагдсан, шилжүүлсэн зэрэг эд зүйлсийг ерөнхий бүртгэлээс хасаж бүртгэлээ цэгцлэх, нэмж бүртгэх саналтай үзмэрээ бүртгэх зэрэг ажлуудаа бүрэн хийж гүйцэтгэх талаар, мөн хөдлөх дурсгалт зүйлийн хууль дүрмийн хэрэгжилтийн талаар Соёлын өвийн бүртгэл, судалгааны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Нарантуяа;





Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санг ангилан төрөлжүүлж, мэдээллийн санг төгөлдөржүүлэх асуудал, Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тоон дүнгийн нэгтгэл, судалгаа хийх тухай зөвлөмж, Музейн үзмэрийн гэрэл зургийг бүртгэн баримтжуулах “Object ID”-гийн зарчмийн талаар тус тус ерөнхий бүртгэл,



мэдээллийн санч Ш.Энхтуяа заасан ба хичээлийн үеэр тухайн байгууллагын БМСангийн соёлын өвийн бүртгэл, мэдээллүүдийн судалгааг авсан.

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэл (БСШУ-ны сайдын 2010 оны 541 дугаар тушаалаар батлагдсан бүртгэлийн маягт), Түүх, соёлын үл хөдлөх дурсгал (дурсгалт уран барилга)-ыг бүртгэн баримтжуулах “ИКИМОС”-ын зарчим, Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тоон дүнгийн нэгтгэл, судалгаа хийх тухай зөвлөмж өгч түүх, соёлын үл хөдлөх дурсгал хариуцсан бүртгэл, мэдээллийн санч Г. Бүрэнтөгс;



- Соёлын биет бус өв, түүнийг өвлөн уламжлагчийг бүртгэх, баримтжуулах бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх, холбогдох журмууд, Соёлын биет бус өвийн тоон дүнгийн нэгтгэл, судалгаа хийх тухай зөвлөмж өгч соёлын биет бус өв хариуцсан бүртгэл, мэдээллийн санч Ж. Насанжаргал, Ц. Жаргалсайхан нар;

- Түүх соёлын үл хөдлөх дурсгалын 2015 оны үзлэг тооллогын үр дүн, дүн шинжилгээний талаар Соёлын өвийг авран хамгаалах газрын дарга Г. Анхсанаа нар тус тус заасан.

Сургалтын үеэр улс, аймаг, орон нутгийн музейн бүртгэл, мэдээллийн санчдын судалгаа авсан. Нийт 30 хүн хамрагдсан байна. Судалгаагаар бүртгэл, мэдээллийн санчдийн 73% нь 30-40 насных, 20% нь 41-50 насных, 6% нь 51-ээс дээш насных ба хүйсийн 66 %-ийг эмэгтэйчүүд эзэлж байна.

Нийт БМСанчдийн 40% 1-5 жил, 20% нь 6-10 жил, 23% нь 11-15 жил, 1 хүн 20 жил ажиллаж байна. 30 хүнээс зөвхөн 6 нь магистр зэрэгтэй байгаа нь боловсрол,



эрдмийн зэргийн хувьд чамлалттай байна. БМСанчдийг тогтвор суурьшилтай ажиллуулах, мэдлэг мэргэшлийг дээшлүүлэх шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Судалгаанд оролцогчид “музейн төсөвт БМСангийн бүртгэл, баримтжуулалтыг зардлыг бий болгох, төсөв нэмэгдүүлэх тухай”, “бүртгэл, баримтжуулалтын техник тоног төхөөрөмжөөр хангах шаардлагатай тухай”, “Аймгийн БМСанд өв тус бүр хариуцсан орон тоо бий болгох, БМСанчийг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлөөр хангах тухай” саналуудыг түлхүү ирүүлсэн байна. /Хавсралт. БМСанчдийн судалгаа/

Мөн “Сургалтын үнэлэмжийн судалгаа”-г 23 оролцогчоос авсныг нэгтгэхэд:  
- “Сургалтын агуулгын оновчтой байдал” асуулгад 100% “сайн” үнэлгээ өгсөн,  
- “Сургалтын зохион байгуулалт” асуулгад 19 оролцогч “сайн”, 4 оролцогч “дунд” үнэлгээ өгсөн,

“Цаашид ямар сэдвээр сургалт, мэдээлэл авах хүсэлтэй байгаа тухай санал” асуулгад дараах санал хүсэлтүүдийг гаргасан байна. Үүнд:

- ✓ Бичиг хэрэг, архивын сургалт 2
- ✓ Бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлж буй туршлагатай танилцах -7
- ✓ Бүртгэл, мэдээллийн сангийн бүрдүүлж буй гадаад орны туршлагатай танилцах-3
- ✓ Соёлын биет бус өвийн бүртгэлийн арга зүйг боловсронгуй болгох, сургалт авах-3
- ✓ БМС бүрдүүлэлт, сан хөмрөг, эрдэм шинжилгээний ажлын чиглэлээр
- ✓ Музейн удирдлагуудын мэдлэг чадварыг сайжруулах, сургалт явуулах -3
- ✓ Бүртгэлийн программ дээр ажиллах 2
- ✓ Бүртгэн баримтжуулах, ЭШ тодорхойлолт бичих талаар сургалт авах
- ✓ Цахим баримтыг төрөлжүүлэх талаар сургалт, туршлага
- ✓ Бүртгэл, мэдээллийн сан, ЭША, сан хөмрөгч нарын ажлын байрны тодорхойлолтыг тодруулах
- ✓ Соёлын өвийг бүртгэх шалгуур үзүүлэлтийг тодруулах
- ✓ Үзмэртэй хэрхэн харьцах талаар музей ажилтнуудад сургалт явуулах
- ✓ Үзмэрийг дүрс бичлэгээр баримтжуулах тухай сургалт явуулах-2
- ✓ Бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх ажил зөвхөн БМС-ийн үүрэг гэсэн ойлголтыг өөрчлөх
- ✓ Үл хөдлөх дурсгалыг таньж тодорхойлох
- ✓ БМС-ын сургалтыг сертификат, гэрчилгээ олгодог болгох

“Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санг ангилан төрөлжүүлэх, төгөлдөржүүлэх” хичээлээр аймгийн болон байгууллагын БМСанд хадгалагдаж буй баримтуудын жагсаалт гаргах дадлага ажил явуулахад 35 оролцогч жагсаалтаа гаргаж өгсөн бөгөөд уг баримтыг музейн БМСанг төрөлжүүлэх ажилд ашиглахаар зорьж байна.

Хичээлийн төгсгөлд заасан сэдвээр хэлэлцүүлэг зохион байгуулсан ба хэлэлцүүлэгт Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газрын Соёл, соёлын өвийн газрын музей, үл хөдлөх дурсгал хариуцсан мэргэжилтэн Ч.Нацагням оролцлоо.

Хэлэлцүүлгийн үеэр Ховд аймгийн музейн Бүртгэл, мэдээллийн санч Г.Сүхбаатар, Завхан аймгийн музейн эрдэм шинжилгээний ажилтан Т.Цолмон, Дорнод аймгийн музейн Бүртгэл, мэдээллийн сан В.Нарангэрэл нарын хүмүүс аймгийн музейн БМСанч нь хуулийн дагуу тухайн аймгийнхаа БМСанг давхар хариуцан ажиллахын зэрэгцээ ихэнх аймаг, орон нутгийн музейн БМСанч байгууллагийн архив, бичиг хэргийн ажлыг давхар гүйцэтгэдэг ажлын их ачаалалтай ажилладаг. Гэтэл Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол хөдөө орон нутагт ажилласны нэмэгдэл олгодог соёлын байгууллагуудын ажилтнуудын жагсаалтад “Бүртгэл, мэдээллийн санч”-ийн албан тушаал байдаггүй тул хөдөө орон нутагт ажилласны нэмэгдэл авдаггүйг салбарын яам, соёл, урлагийн газраас анхаарч, нэмж оруулах тухай санал болон аймаг, орон нутгийн бүртгэл, мэдээллийн санчийн ажлын ачаалал их, соёлын өвийн бүртгэл баримтжуулалтын техник хэрэгсэл, орон нутагт ажиллах зардал төсөв хүрэлцдэггүй талаар голлон ярилцсан байна.

#### ДҮГНЭЛТ:

Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан дахь гэрэл зураг, санчийн чадавхийг дээшлүүлэх сургалтыг 2 өдөр амжилттай зохион байгуулан явуулж Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр бүлэг, Соёлын өвийн үндэсний төвийн 2019 оны үр дүнгийн гэрээний 4.3-т заасан ажлыг гүйцэтгэн, хэрэгжилтийг ханган ажиллалаа.

- Соёлын өв дурсгалт зүйлийг гэрэл зургаар баримтжуулахад тавигдах шаардлага, гэрэл зургийн аппарат хэрэгслийг ашиглах тухай зөвлөмжийг онол болон дадлага хослуулан явуулж,

- Бүртгэл, мэдээллийн санчдад байгууллагын түвшинд, аймгийн шатлалын түвшинд соёлын биет ба биет бус өвийг бүртгэх, мэдээллийг цуглуулах, сангийн бүрдэлтийг чадавхижуулахад мэргэжил, арга зүйгээр хангасан, үр дүнтэй сургалт боллоо.

#### Хавсралт №1

№	СУРГАЛТАНД ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГА
1	Монголын үндэсний музей
2	Байгалийн түүхийн музей
3	Богд хааны ордон музей
4	Дүрслэх урлагийн музей
5	Монголын Театрын музей
6	Монголын Уран зургийн галерей
7	Хархорум музей
8	Хөшөө цайдам музей
9	Чойжин ламын сүм музей
10	Монголын Үндэсний номын сангийн үнэт ховор номын фонд
11	ШУА-ийн Палеонтологи, геологийн хүрээлэн
12	ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн
13	Улаанбаатар хотын музей
14	Төрийн Түүхийн музей
15	Монгол цэргийн музей
16	Архангай аймгийн музей
17	Баян-Өлгийн аймгийн музей

18	Баянхонгор аймгийн түүх, угсаатны зүйн музей
19	Булган аймгийн музей
20	Говь-Алтай аймгийн музей - оролцоогүй
21	Говьсүмбэр аймгийн музей
22	Дархан-Уул аймгийн музей
23	Дорноговь аймгийн музей, сургалт сурталчилгааны төв - оролцоогүй
24	Дорнод аймгийн музей
25	Дундговь аймгийн музей
26	Завхан аймгийн музей
27	Орхон аймгийн музей
28	Өвөрхангай аймгийн музей
29	Өмнөговь аймгийн музей
30	Сүхбаатар аймгийн түүх, угсаатны зүйн музей
31	Сэлэнгэ аймгийн нэгдсэн музей
32	Төв аймгийн музей
33	Увс аймгийн музей
34	Ховд аймгийн музей
35	Хөвсгөл аймгийн Орон нутаг судлах музей
36	Хэнтий аймгийн музей
37	Эрдэнэ Зуу музей
38	Ялалт музей (Дорнод аймаг)
39	Дэлхийн өв - Орхоны хөндийн дурсгалт газрын хамгаалалтын захиргаа

## Хавсралт №2

Улс, аймгийн музейн Бүртгэл, мэдээллийн санчдийн судалгаа

Сургалтад оролцогч 39 хүнээс 30 хүн судалгаа ирүүлсэн байна

Нас	20-30 нас	31-40 нас	41-50 нас	51-60 нас
Хүний тоо	11	11	6	2

Хүйс	Эр	Эм
Хүний тоо	10	20

Боловсрол, эрдмийн зэрэг	Хүний тоо
Бакалавр	30
Магистр	Үүнээс - 6

Жил	Улсад нийт ажилласан	БМСанчаар ажиллаж буй
14 хоног-5 сар	2 хүн	4 хүн
1-5 жил	7 хүн	12 хүн
6-10 жил	7 хүн	6 хүн
11-15 жил	7 хүн	6 хүн
16-20 жил	3 хүн	2 хүн
21-25 жил	1 хүн	
25-30 жил	2 хүн	
30-аас дээш жил	1 хүн	

Ажил хавсран гүйцэтгэдэг эсэх	13 хүн /Архив, бичиг хэрэг, хүний нөөц, нярав касс- 8, эрдэм шинжилгээний ажилтан- 1, соёлын биет бус өв-2, олдворын сан хөмрөг-1, номын сан-1/ <b>Аймгийн БМСанг давхар хариуцдагаа бичээгүй?</b>
	17 хүн – үгүй

Соёлын өвийн бүртгэл, баримтжуулалтын чиглэлээр сургалтад хамрагдаж байсан	
хамрагдаж байсан	хамрагдаж байгаагүй
20 хүн	10 хүн

Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд тулгарч буй асуудлууд, түүнийг шийдвэрлэхэд таны санал
<ul style="list-style-type: none"> <li>▪ Музейн төсөвт БМСангийн бүртгэл, баримтжуулалтыг зардлыг бий болгох, төсөв нэмэгдүүлэх тухай- 7 санал</li> <li>▪ Бүртгэл, баримтжуулалтын техник тоног төхөөрөмжөөр хангах шаардлагатай- 8 санал</li> <li>▪ Аймгийн БМСанд өв тус бүр хариуцсан орон тоо бий болгох, БМСанчийг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлөөр хангах - 5 санал</li> <li>▪ RCH болон Register програмыг сайжруулах шаардлагатай – 4 санал</li> <li>▪ Хөдөө орон нутагт мэргэжлийн ажилтнуудад олгодог 10-8 хувийн нэмэгдэлд БМСанчийг нэмж оруулах, БМСанчийн цалингийн шатлал ахиулах- 3 санал</li> <li>▪ Мэргэжил арга зүйн модуль ба бүртгэл, баримтжуулалтын техник ашиглах талаар сургалт зохион байгуулах -3 санал</li> <li>▪ Сумдад бүртгэлийн програм суурилуулах тухай- 1 санал</li> <li>▪ БМСангийн журмыг шинэчлэх -1 санал</li> <li>▪ Музейг мэргэжлийн удирдлагатай болгох – 1 санал</li> <li>▪ Зураасан кодын төслийг нэгдсэн журмаар нэвтрүүлэх – 1 санал</li> <li>▪ Музейн баримт бичгийг хадгалах хугацааны үлгэрчилсэн жагсаалт гаргах -1 санал</li> <li>▪ БМСанч давхар ажил хавсрахгүй байх тухай – 1 санал</li> </ul>

ТАЙЛАН БИЧСЭН:

Д.НАРАНТУЯА. СОЁЛЫН ӨВИЙН БҮРТГЭЛ,  
СУДАЛГААНЫ ГАЗРЫН ДАРГЫН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

-----oO-----

#### **4.4. Чойжин ламын сүм музейн 3 хэмжээст бүртгэн баримтжуулалтыг ажлыг хийх**

### **ЧОЙЖИН ЛАМЫН СҮМ МУЗЕЙН 3 ХЭМЖЭЭСТ АРХИТЕКТУРЫН ЗУРАГЛАЛ, БҮРТГЭЛ БАРИМТЖУУЛАЛТЫН АЖИЛ**

Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны харьяа Соёлын өвийн үндэсний төв, БНСУ-ын Соёлын өвийн судалгааны үндэсний хүрээлэн хамтран “Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгал болох сүм хийд, уран барилга, архитектурын дурсгалыг 3D цахим хэлбэрээр баримтжуулах, техникийн зураг боловсруулах, мэргэжилтэн бэлтгэх” тухай Хамтын ажиллагааны Санамж бичгийг 2015 онд байгуулсан.

Төслийн хүрээнд 2015 онд Өөлд бэйсийн хүрээний Цогчин дуган, Жүд дацан (Архангай аймгийн Өлзийт сум), 2016 онд мөн Өөлд бэйсийн хүрээний Цамын Асар, Үнстийн хийд (Дундговь аймгийн Эрдэнэдалай сум), 2017 онд Заяын хүрээний Цогчин дуган (Архангай аймгийн Цэцэрлэг хот), 2018 онд Чойжин ламын сүм музейн Гол сүм (Улаанбаатар хот) зэрэг улс, аймгийн хамгаалалтад байх эртний уран барилга, архитектурын 6 объект дурсгалуудад уламжлалт гар хэмжилт, техникийн дэвшилтэт төхөөрөмж 3D сканер ашиглан судалгаа хийсэн ба 2019 онд Чойжин ламын сүм музейн Гол сүмийн барилгад дахин хэмжилт судалгаа үргэлжлүүлэн хийсэн.

Судалгааны багт Монгол Улсын талаас БСШУСЯамны харьяа Соёлын өвийн үндэсний төвийн Соёлын өвийн бүртгэл судалгааны газрын дарга М.Цэцэнбилэг, тус Үндэсний төвийн Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санч, археологич Г.Бүрэнтөгс, ШУТИС-ийн БАС-ийн оюутан А.Намуун, Солонгос Улсын талаас Соёлын өвийн судалгааны үндэсний хүрээлэн Бай Бйөнсөн, Хан үг, Хон Инъги, Ким Тэхён, И Минжи, Т.Эрдэнэцогт нар ажилласан.

Төслийн хүрээнд 2019 оны 08 дугаар сарын 26-ний өдрөөс 2019 оны 09 дүгээр сарын 01-ныг хүртэл 6 хоногийн хугацаанд БНСУ-ын Соёлын өвийн судалгааны үндэсний хүрээлэнгийн Барилга, архитектурын дурсгалын судалгааны хэлтсийн мэргэжилтнүүдтэй Улаанбаатар хот Чойжин ламын сүм музейн барилгын Цогчин дуганд хэмжилт судалгааг үргэлжлүүлэн хийв. Тус музейн Гол сүм (Занхан)-ийн сүмийн барилга дээр хийгдсэн ба энэ жилийн ажлын онцлог нь сүм хийдийн барилга архитектурын зураглалыг 3D лазер хэмжилтийн багаж ашиглан тухайн объектуудын хана туурга, багана, хаалга, цонх, шал зэрэг барилгын хийц бүтээцийн дээд, доод давхар, дотор, гадна талын хэмжилтүүдийг өмнөх онд хийж баримтжуулсныг бататган гар хэмжилтийг ашиглан тулгалт хийн тэмдэглэв. Гар хэмжилтийг 3D скан дата-г нөхвөрлөх шаардлагатай хэсэгт голчлон явуулав. Мөн өмнө жил хэмжсэн дээврийн дээд хэсэг сканердахад агаарын дрон ашиглан зураг авч, дээд давхрын хийц бүтээцийн хэмжилт судалгааг гар хэмжилт, фото зургийн хосолмол аргаар нөхвөрлөх хэмжилтүүдийг бататган хийсэн. Энэ ажлын хүрээнд дурсгалт барилга, архитектурын хэмжилтийг мэргэжлийн байгууллага, их дээд сургуулийн цөөн оюутнуудыг татан оролцуулан ажиллуулсан явдал байлаа.

Уран барилга архитектурын соёлын өвийг баримтжуулах ажил нь архитектурын дурсгалын анхны хэлбэр төрхийг баримтжуулан, тухайн судалгааны объект болох дурсгалт барилгын түүхэн архитектурын хийц, бүтээцийг хадгалж хамгаалах үндсэн аргын нэг бөгөөд 3D баримтжуулалтын ажлыг археологийн малтлага судалгаатай хавсарсан байдлаар явуулбал тухайн хот суурины төлөвлөлт, барилга-архитектурын бүтэц, зохион байгуулалтыг талаарх мэдээллийг бүрэн баримтжуулах боломжтой болох юм.



Зураг 1. Чойжин ламын сүм музейн 3D боловсруулалтын зураг



Судалгааны багийн бүрэлдэхүүн, Гол сүм (Занхан) сүмийн барилга дээр хийсэн гар хэмжилт - 2019




Чойжин ламын сүм музейн Цогчин дуганд хийсэн гар хэмжилт - 2019



Зураг 2. Чойжин ламын сүм музейн уламжлалт гар хэмжилтийн зураг

Судалгааны ажлын тайланд монголын сүм хийдийн барилга архитектурын үүсэл хөгжил, тухайн сүм хийдийн шашны түүхэн тойм судалгаа, хамрагдсан объектуудын 3D болон гар хэмжилийн зураг, гэрэл зураг зэргийг багтаан монгол, солонгос, англи хэлээр бэлтгэн хэвлүүлж, мэргэжлийн байгууллага, холбогдох их дээд сургууль, улсын болон 21 аймгийн номын сангуудад үнэ төлбөргүй тараан, олон нийтэд хүргэсэн. 2020 оны 1-р сард энэхүү ажлын 4 дэх цуврал болох Чойжин ламын сүм музейн тайлант ном 270 ширхэг хэвлэгдэн ирсэн.



Зураг 2. Чойжин ламын сүм музейн 3D боловсруулалтын зураг боловсруулах ажлын тайлант ном

ТАЙЛАН БИЧСЭН:  
Г.БҮРЭНТӨГС.  
СОЁЛЫН ӨВИЙН БҮРТГЭЛ, СУДАЛГААНЫ  
ГАЗАР, БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН САНЧ

-----oO-----

#### 4.5. Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг дүрс бичлэгээр бүртгэх, баримтжуулах ажил

### БОГД ХААНЫ ОРДОН МУЗЕЙН ТҮҮХ, СОЁЛЫН ХОСГҮЙ ҮНЭТ ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙГ ДҮРС БИЧЛЭГЭЭР БАРИМТЖУУЛСАН АЖЛЫН ТАЙЛАН

2019 оны 06 дугаар сарын 15

Улаанбаатар хот

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 21.1, 21.2.7, 21.3 дахь заалтуудын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд БСШУЯамны 2015 оны 7/302 тоот албан бичиг, Соёлын өвийн үндэсний төвийн 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.5-т тусгагдсаны дагуу Соёлын өвийн үндэсний төв, Богд хааны ордон музей “Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалуудыг дүрс бичлэгээр бүртгэн баримтжуулах тухай” № 03/12 тоот гэрээ байгуулан, Богд хааны ордон музейн захирлын А/21 тоот тушаал гарч тус музейд хадгалагдаж байгаа Монгол Улсын түүх, соёлын хосгүй үнэт 30 үзмэрийг дүрс бичлэгээр баримтжууллаа.

Баримтжуулах ажлыг хоёр үе шаттайгаар хэрэгжүүлсэн. Эхний ажил 2019 оны 04 дугаар сарын 25, 29, 30-ны өдрүүдэд явагдаж 21 үзмэрийг хамруулсан. Дараагийн ажил 6 сарын 12, 14-ны өдрүүдэд хийгдэж том оворын танка, зээгт наамал голдуу 9 үзмэр хамрагдсан. 6 дугаар сарын 14-ны өдөр авсан “Жамсран” зээгт наамал “Цогдогмарав” танка, “Намсрай” зээгт наамлыг захиргааны байрны зүүн талд дээврээс уяж авлаа.



Дүрс бичлэгээр баримтжуулах ажлын үеэр гурван том зээгт наамлыг гадаа авсан

Уг ажлыг Соёлын өвийн үндэсний төвөөс Ерөнхий бүртгэл, мэдээллийн санч Ш.Энхтуяа хариуцан, дүрс бичлэгийг тус төвийн зураглаач Т.Даваа-Очир хийсэн. Богд хааны ордон музейгээс ажил үүргийн хуваарийн дагуу сан хөмрөгийн эрхлэгч Д.Алтаннавч, бүртгэл, мэдээллийн санч Ж.Болортуяа нар ажилласан. Үзмэрийн



тайлбарыг унших ажил давхар хийгдсэн бөгөөд эхний 21 үзмэрийн тайлбарыг музейн нарийн бичгийн дарга, судлаач Ц.Гүнчин-Иш, дараагийн 9 үзмэрийн тайлбарыг Д.Алтаннавч, Ж.Болортуяа нар уншиж бичүүлсэн. Ажлын өдөр тутмын тэмдэглэлийг БМСанч Ж.Болортуяа бичсэн.

Д/д	Үзмэрийн нэр	Хувийн дугаар	Хэмжээ	Баримтжуу сан огноо
1	Хайстайн Лаврин. Шороон будаг	24-2-1821	4.89 gb, 31.34 min	2019-04-25
2	Өвлийн ордон /Ногоон ордон/	24-2-1822	5.57 gb, 35.37 min	2019-04-25
3	Сайн цагийн 1000 бурхан. Шороон будаг, танка	24-2-565	1.78 gb, 15.8 min	2019-04-25
4	Чойжоо. Торго, хоргой зээгт наамал	24-3-03	1.67 gb, 10.46 min	2019-04-25
5	Гомбо. Торго, хоргой зээгт наамал	24-3-12	1.93 gb, 12.26 min	2019-04-25
6	Сайн цагийн 1000 бурхан. Шороон будаг, танка	24-2-563	1.18 gb, 7.36 min	2019-04-29
7	Жигжид. Шороон будаг, танка	24-2-1604	2.20 gb, 14.09 min	2019-04-29
8	Мэгжиджанрайсэг. Шороон будаг, торго	24-2-278	1.61 gb, 10.20 min	2019-04-29
9	Очирдара. Торго, хоргой зээгт наамал	24-3-10	1.95 gb, 12.34 min	2019-04-29
10	Манал. Торго, хоргой зээгт наамал	24-3-02	1.57 gb, 10.09 min	2019-04-29
11	Бурхан багш. Торго, хоргой зээгт наамал	24-3-06	2.83 gb, 18.13 min	2019-04-29
12	Хамжаар. Булга	24-6-20/1/	1.79 gb, 11.39 min	2019-04-29
13	Хамжаар. Булга	24-6-20/2/	1.37 gb, 8.52 min	2019-04-29
14	Хантааз. Хоргой, сувд	24-6-19	12.04 gb, 13.13 min	2019-04-29
15	Хүрэм. Пүүсүү, сувд	24-6-02	2.23 gb, 14.29 min	2019-04-29
16	Дээл. Торго, пүүсүү	24-6-118	2.18 gb, 14.11 min	2019-04-29
17	Шүд. Яс	24-10-104	2.02 gb, 4.53 min	2019-04-30
18	Малгай торго,алт,сувд	24-6-71	2.41 gb, 9.10 min	2019-04-30

19	Малгай. Навч, шүр, мөнгө, мод	24-6-76	8.99 mb, 5.41 min	2019-04-30
20	Гутал. Савхи	24-6-103	1.32 gb, 8.38 min	2019-04-30
21	Дээл. Торго, хоргой	24-6-41	1.77 gb, 11.29 min	2019-04-30
22	Сайн цагийн мянган бурхан	24-2-564	00:04:55 570mb	2019-06-12
23	Дамжиндорлиг	24-3-113	00:11:36 1.46 gb	2019-06-12
24	Цамба	24-3-118	00:10:32 1.25gb	2019-06-12
25	Дойнхор	24-3-01	00:08:34 0.97gb	2019-06-12
26	Доржпагма	24-03-04	00:20:27 2.44 gb	2019-06-12
27	Гонгор	24-3-49	00:09:38 1.09 gb	2019-06-12
28	Жамсран	24-3-05	00:15:33 2.11 gb	2019-06-14
29	Цогдогмарав	24-2-595	00:14:26 1.64 gb	2019-06-14
30	Намсрай	24-3-129	00:12:38 1,72 gb	2019-06-14

Дүрс бичлэгийг зураглаач Т.Даваа-Очир Canon 200D, Sony HXR-MC2500, Sony Alpha 7 mark II камераар хийсэн ба эвлүүлгийн ажил хийгдэж байна.

-----oOo-----

**ТӨВ, СҮХБААТАР АЙМГИЙН МУЗЕЙН САН ХӨМРӨГ ДЭХ ТҮҮХ,  
СОЁЛЫН ХОСГҮЙ ҮНЭТ ДУРСГАЛТ ЗҮЙЛСИЙГ ДҮРС БИЧЛЭГЭЭР  
БАРИМТЖУУЛСАН ТУХАЙ**

Бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэлтэд үзлэг хийх, мэргэжил арга зүйгээр хангах ажлын хүрээнд Засгийн газрын тогтоолоор 2013 оны 227 дугаар тогтоолоор “Монгол Улсын түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалт”-д бүртгэгдсэн Төв аймгийн музейн 1 ширхэг хосгүй үнэт, Сүхбаатар аймгийн музейн 2 ширхэг хосгүй үнэт дурсгалуудыг нийт 01:47:02 минутын 10,63 gb хэмжээ бүхий дүрс бичлэгээр баримтжуулан бүртгэх ажлыг гүйцэтгэн, тухай байгууллагуудын БМСан болон СӨУНБМСанд архивлан хадгалах ажлыг гүйцэтгэлээ.

Ажлын хүрээнд 2019 оны 10 дугаар сарын 23-ны өдөр Төв аймгийн музейн сан хөмрөг дэх “түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалт”-д бүртгэгдсэн “Өндөр гэгээний жирав” 1 ширхэг үзмэрийн нийт 00:01:32 хугацаатай, 2,65 gb хэмжээний дүрс бичлэгээр бүртгэн баримтжуулав.

“Өндөр гэгээний жирав” хосгүй үнэт дурсгалт зүйлийн талаар тус музейн эрдэм шинжилгээний ажилтан Ц. Цэцэгжаргалын тайлбар яриаг мөн дүрсжүүлсэн.

2018 оны 10 дугаар сарын 25-ны өдөр Сүхбаатар аймгийн музейн сан хөмрөгт хадгалагдаж буй “түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалт”-д бүртгэгдсэн “Дарьганга эхнэрийн толгойн гоёл”-ыг 00:21:31 хугацаатай 3,68 gb хэмжээгээр, “Үзэмчин эхнэрийн толгойн гоёл”-ыг 01:47:02 хугацаатай 4,30 gb хэмжээгээр тус, тус дүрсжүүлсэн байна.

Тус музейн хосгүй үнэт 2 ширхэг үзмэрийн судлагдсан байдал, холбогдох мэдээллийг тайлбарлагч Д. Гансарнайгийн ярьсанаар дүрсжүүллээ.

Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлсийг дүрс бичлэгээр баримтжуулан дүрсжүүлэх ажлыг Мэдээлэл, технологийн зураглаач Т.Даваа-Очир хариуцан гүйцэтгэлээ.

Хүснэгт №1

Төв ба Сүхбаатар аймгийн музейн хосгүй үнэт үзмэрийн баримтжуулалт

№	Үйл ажиллагаа	Музей	Дүрс бичлэг хийсэн огноо	Хосгүй үнэт үзмэрийн нэр	Бичлэгийн хугацаа	Бичлэгийн хэмжээ
1	Түүх, соёлын хосгүй үнэт хөдлөх	Төв аймгийн музей	2019.10.23	Өндөр гэгээний жирав	00:01:32	2,65 gb
2	дурсгалт зүйлийн дүрс бичлэг	Сүхбаатар аймгийн музей	2019.10.25	Дарьганга эхнэрийн толгойн гоёл	00:21:31	3,68 gb
3	баримтжуулалтын ажил		2019.10.25	Үзмчин толгойн гоёл	00:24:59	4,30 gb
				Нийт	01:47:02	10,63 gb

### ТҮҮХ, СОЁЛЫН ХОСГҮЙ ҮНЭТ ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙГ ДҮРС БИЧЛЭГЭЭР БАРИМТЖУУЛСАН НИЙТ ТООН ҮЗҮҮЛЛЭЛТ

Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалыг дүрс бичлэгээр баримтжуулах ажил 2015 оноос эхлэн хэрэгжиж одоогийн байдлаар Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйл хадгалагдаж буй 27 байгууллагын 778 дурсгалт зүйлээс 15 байгууллагын 406 дурсгалыг дүрс бичлэгээр баримтжуулсан.

Үүнээс Богд хааны ордон музей, Чойжин ламын сүм музей, Монголын Үндэсний музей, Байгалийн түүхийн музей, Археологийн хүрээлэн, Эрдэнэ-Зуу музей, Хархорум музей, УБ-ын Их сургууль, Уран зургийн г

алерей, Монгол цэргийн музей, Сүхбаатар аймгийн музей, Төв аймгийн музей нийт 13 байгууллагад хадгалагдаж байгаа түүх, соёлын хосгүй үнэт дурсгал дүрс бичлэгт бүрэн хамрагдсан байна. Дүрс бичлэгээр баримтжуулсан түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн тоон үзүүллэлтийг хүснэгтээр харуулав.

## Хүснэгт №1

Д/д	Байгууллага	Нийт үзэмрийн тоо	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	Дүрс бичлэг хийгдсэн үзэмрийн тоо
1	Богд хааны ордон музей	79	21	8		20	30	<b>79</b>
2	Чойжин ламын сүм музей	38		26		12		<b>38</b>
3	Дүрслэх урлагийн музей	71	17	3	40	7		<b>67</b>
4	Монголын Үндэсний музей	27		27				<b>27</b>
5	Монголын Үндэсний номын сан	20						
6	ШУА-ын Палеонтологийн хүрээлэн	26				5		<b>5</b>
7	Байгалийн түүхийн музей	8		8				<b>8</b>
8	Монгол банкны Эрдэнэсийн сан	20						
9	ШУА-ын Археологийн хүрээлэн	6			6			<b>6</b>
10	Гандантэгчинлэн хийд	15						
11	Эрдэнэ-зуу музей	93			93			<b>93</b>
12	Шанхын Баруун хүрээ хийд	18						
13	Төвхөн хийд	1						
14	Данзанравжаагийн музей	7						
15	Монгол төрийн түүхийн музей	259						
16	Дундговь аймаг. Баруун Чойрын хийд	1						
17	Хархорум музей	63			63			<b>63</b>
18	МУИС-ийн харъяа Улаанбаатар сургууль	10			10			<b>10</b>
19	Уран зургийн галерей	5			5			<b>5</b>
20	Монгол цэргийн музей	1			1			<b>1</b>
21	Архангай аймгийн музей	1						
22	Говь-Алтай аймгийн музей	1						
23	Дорноговь аймгийн музей	3						
24	Сүхбаатар аймгийн музей	2					2	<b>2</b>
25	Төв аймгийн музей	1					1	<b>1</b>
26	Хэнтий аймгийн музей	1						
27	ШУА-ын Түүх, угсаатны зүйн хүрээлэн	1					1	<b>1</b>
	<b>Нийт</b>	<b>778</b>	38	72	218	45	34	<b>406</b>

ТАЙЛАН БИЧСЭН:  
Ш.ЭНХТУЯА.СОЁЛЫН ӨВИЙН БҮРТГЭЛ,  
СУДАЛГААНЫ ГАЗАР, ЕРӨНХИЙ  
БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН САНЧ

Д.НАРАНТУЯА. СОЁЛЫН ӨВИЙН БҮРТГЭЛ,  
СУДАЛГААНЫ ГАЗРЫН ДАРГЫН  
ҮҮРГИЙГ ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

-----oOo-----